УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

# СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ




**ТОЙМ АГУУЛГА**

◊ **Эрх зүй, төрийн байгуулал, гадаад бодлого**

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УЛААНБААТАР, 2015

“Судалгааны эмхэтгэл” (XX боть)-ийг
Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.

Хянасан: Ц.Норовдондог (Ph.D)

Эмхэтгэсэн: Г.Билгээ

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Т.Цэнд-Аюуш

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## ГАРЧИГ


**I БҮЛЭГ. ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ, ГАДААД БОДЛОГО**

**1.1. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх асуудал, Монгол Улс ба бусад орнуудын туршлага, хандлага** *(Харьцуулсан судалгаа)* ................................. 6

*Ц.Норовдондог, А.Пагма, Б.Ариунжаргал, О.Нарантуяа, Т.Мягмаржав, Р.Нургүл*

**1.2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал ба тэдгээрийн бие даасан, хараат бус байдлын талаарх харьцуулсан судалгаа** *(Харьцуулсан судалгаа)* ................................. 35

*Г.Чулуун, Д.Халиун, Д.Жигваагүнсэл*

**1.3. Төрийн албаны эрх зүйн зохицуулалтын зарим асуудлаарх бусад орны туршлага** *(Харьцуулсан судалгаа)* ................................. 62

*Г.Билгээ, Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, Р.Нургүл*

**1.4. Парламентын засаглалтай зарим оронд төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүдийг хэрхэн томилдог талаарх эрх зүйн зохицуулалт** *(Харьцуулсан судалгаа)* ................................. 86

*А.Пагма, Г.Билгээ, Д.Жигваагүнсэл, Р.Нургүл, Ө.Мөнхтунгалаг*

**1.5. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох асуудлаарх зарим орны эрх зүйн зохицуулалт** *(Харьцуулсан судалгаа)* ................................. 90

*А.Пагма, Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, Р.Нургүл*

**1.6. Монгол Улсын Үндсэн хууль (1992) ба Монгол Улсын Их цаазын төслүүдийн (1991.VI.05, X.05, XI.07) харьцуулалт** *(Харьцуулсан судалгаа)* ................................. 103

*Г.Билгээ, Д.Жигваагүнсэл*

**1.7. Монгол Улсын Үндсэн хууль (1992) ба Монгол Улсын Их цаазын төслүүдэд (1991.VI.05, X.05, XI.07) хэлэлцүүлгийн явцад орсон өөрчлөлтүүд** *(Мэдээлэл лавлагаа)* ................................. 162

*Г.Билгээ, Д.Жигваагүнсэл*


UIH.MN СУДАЛГААНЫ САН

**1.8. Дэлхийн зарим орнуудын төрийн тогтолцооны талаарх мэдээлэл лавлагаа** *(Мэдээлэл лавлагаа)* ................................. 171

*Г.Билгээ, Д.Жигваагүнсэл*

**1.9. Дэлхийн улс орнуудын хүн амын тоог парламентын гишүүдийн тоонд харьцуулсан байдал болон Холбооны улсуудын парламентын танхимын тоо** *(Харьцуулсан судалгаа)* ................................. 198

*Г.Билгээ, Б.Ариунжаргал*

**1.10. Парламентын засаглалтай орнуудын сонгуулийн тогтолцоо ба ротацийн журмаар парламентын гишүүдийг сэлгэдэг зарим орны туршлага** *(Харьцуулсан судалгаа)* ................................. 207

*А.Пагма, И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл, Р.Нургүл, Ө.Мөнхтунгалаг*

**1.11. Парламентын ээлжит бус сонгуулийг зарлах тухай зарим орны эрх зүйн зохицуулалт** *(Харьцуулсан судалгаа)* ................................. 211

*Р.Хатанбаатар, Г.Алтан-Оч, Г.Чулуун, Ч.Онончимэг, Д.Халиун, Ц.Элбэгзаяа*

**1.12. Улсын Их Хурлын гишүүдийн дээд, доод, дундаж насны судалгаа (1990-2016 оны бүрэн эрхийн хугацаагаар)** *(Мэдээлэл лавлагаа)* ................................. 218

*Э.Содбаяр, Б.Баясах, Н.Эрдэнэбаатар*

**1.13. Дэлхийн улс орнуудын ерөнхийлөгчөөр сонгогдох насны доод хязгаар** *(Харьцуулсан судалгаа)* ................................. 231

*Г.Билгээ*

**1.14. Дэлхийн улс орнуудын Засгийн газрын тэргүүн буюу Ерөнхий сайдыг томилдог ерөнхий дэг** *(Мэдээлэл лавлагаа)* ................................. 234

*Г.Алтан-Оч, Б.Ариунжаргал, Г.Билгээ, Ч.Онончимэг,Ч.Чулуун, Ц.Элбэгзаяа*

**1.15. Засгийн газрыг бүрдүүлэх асуудлаарх зарим орны эрх зүйн зохицуулалт** *(Мэдээлэл лавлагаа)* ................................. 258

*Г.Алтан-Оч, Ч.Онончимэг, Д.Халиун, Ч.Чулуун*

**1.16. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх тойм мэдээлэл /Казахстан улсын туршлага/** *(Мэдээлэл лавлагаа)* ................................. 268

*Ч.Чулуун*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# 1
# БҮЛЭГ

**ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ, ГАДААД БОДЛОГО**

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ХУВИЙН ХЭВШЛЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АСУУДАЛ, МОНГОЛ УЛС БА БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ХАНДЛАГА

*Ц.Норовдондог (PH.D), А.Пагма, Б.Ариунжаргал,*
*О.Нарантуяа, Т.Мягмаржав, Р.Нургүл*

## АГУУЛГА

Удиртгал
Судалгааны дүгнэлт

I. Улсын салбарын шинэчлэлийн зорилго, мөн чанар, хандлага
II. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх хэлбэрүүд
III. Төрийн үйлчилгээг гэрээгээр шилжүүлэн гүйцэтгүүлсэн зарим орны туршлага
 3.1. Австрали улс
 3.2. Их Британи
 3.3. Канад улс
 3.4. АНУ
 3.5. ОХУ
IV. Монгол улсын хууль эрх зүйн орчин

Ашигласан материал

## УДИРТГАЛ

### *Судалгааны зорилго*

Энэхүү судалгаа нь төрийн байгууллагуудын гүйцэтгэж байгаа зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг төрийн бус байгууллагуудад шилжүүлэх болон хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэлбэрийг тодорхойлох, зарим улс оронд энэ чиглэлээр төрийн салбарт шинэчлэл хийсэн туршлагыг харьцуулан судалж, дүгнэлт гаргахад чиглэгдсэн болно. Мөн Монгол улсын төр-хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн орчин ямар байгааг тодруулан захиалагчид мэдээлэл лавлагаа гаргаж өгөхөд чиглэгдэнэ.

### *Судалгааны зорилтууд*

- Төрийн салбарын шинэчлэлийн зорилго, мөн чанар, хандлагыг судлах;
- Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага болон хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх хэлбэрүүд, олон улсын хэмжээнд төлөвшин бий болсон арга зүйг тодруулах;
- Төрийн удирдлагын үйл явцад аутсорсингийг ашиглах аргыг судлах;
- Төрийн үйлчилгээг гэрээгээр шилжүүлэн гүйцэтгүүлсэн зарим орны туршлагыг харьцуулан судлаж дүгнэлт хийх.
- Монгол улсын төр-хувийн хэвшлэлийн түншлэлийн эрх зүйн орчныг нарийвчлан судлах

### *Судалгааны аргачлал*

- Төрийн салбарын шинэчлэлийн агуулга, мөн чанар, онцлогын харьцуулалт;
- Төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхтэй холбоотой материалыг судалж нэгтгэн дүгнэх;
- Бичиг баримтын судалгаа.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Энэ хүрээнд:

- Төрийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх асуудалтай холбоотой ном, материал, судалгааны тайлангуудад анализ хийсэн.
- Бусад орнуудын туршлага, цуглуулсан мэдээлэлд нэгдсэн боловсруулалт хийсэн.
- Судалгааны материалыг нэгтгэн дүгнэж, судалгааны тайлан бичсэн.

## СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

1. Бидний судалгаандаа авч үзсэн гадаадын улсуудад төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагад шилжүүлэн гүйцэтгүүлэх үйл явц нь гол төлөв төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд явагдсан ба Концесс, Тендер, Өөрөө өөрийгөө зохицуулах байгууллага, мэргэжлийн холбоод, аутсорсингоор гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх зэрэг олон янзын хэлбэрээр хэрэгжсэн байна. Манай улсад энэ чиглэлийн үйл ажиллагааны концесс, тендер, гэрээгээр гүйцэтгүүлэх эхлэл тавигдсан бөгөөд харин төрийн зарим чиг үүргийг шилжүүлэн гүйцэтгүүлэхэд аутсорсингийг ашиглах, өөрөө өөрийгөө зохицуулах байгууллага мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх хэлбэр төдийлэн нэвтрээгүй байна.

2. Гадаадын зарим орны туршлагаас үзэхэд, төрийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор төрийн зарим үүргийг улсын бус секторт шилжүүлэн гүйцэтгүүлэх үйл ажиллагааг олон янзын хэлбэрээр нэвтрүүлсэн нь үр дүнтэй болжээ. Үүнийг улс бүрээр нь нэгтгэн авч үзье:

   а/ Их Британи Түншлэл (Partnerships UK-PUK) байгууллага нь 51 хувь нь хувийн салбарын пүүс компанууд, үлдсэн 49 хувийн хувьцааг Сангийн Яам (HM Treasury) болон Scottish Executive эзэмшдэг ба хөрөнгөө хувь эзэмшигчдээс зээлийн хувьцаа хэлбэрээр босгож, зөвхөн шинээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг дэмжих болон төрөөс баримтлах Төр Хувийн Хэвшлийн Түншлэлийн зорилтын хүрээнд шинэ бизнес хэрэгжүүлэхэд зориулж ашигладаг, илүүдэл ашгийг буцаан хөрөнгө оруулдаг ба хувь эзэмшигч нарт олгодоггүй байна. Түүнчлэн Их Британийн Төрийн үйлчилгээний Омбудсмен ажиллуулдаг ба төрийн үйлчилгээний стандартын дагуу түүний чанар хүртээмжийг шалгадаг байна.

   б/ Австрали улсын “Partnerships Victoria” бодлогын баримт бичиг нь хамтын хэлэлцээр хийхийн өмнөх шийдвэр гаргалт, хамтын ажиллагааны гэрээ байгуулах, төслийн менежмент, мониторинг ба хяналтын хийх асуудлыг багтаасан цогц заавар журмуудыг анхлан тодорхойлжээ. Түүнээс хойш уг удирдамжийг байнга сайжруулан шинэчилж, хэрэгцээт жишээ хэв загваруудыг багтааснаараа цаг үетэйгээ нийцэж Австралийн бусад мужуудын хувьд төдийгүй олон улсын түвшинд стандарт, үлгэр дууриалал болон хэрэглэгддэг байна. Түүнчлэн Австралид төрийн зарим үүргийг гэрээгээр шилжүүлэн гүйцэтгүүлэхэд аутсорсингийг ашиглаж байна.

   в/ Канад улсын хувьд төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх эрх зүйн орчин нь нэлээн боловсронгуй ба Төрийн үйлчилгээний тухай хууль, Төрийн үйлчилгээг өөрчлөх болон үүргийг шилжүүлэх тухай акт, Зам тээвэр, дэд бүтцийн түншлэлийн акт зэрэг гол хуулиуд нь төрийн зарим үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, гэрээ байгуулахтай холбогдсон бүхий л харилцааг зохицуулж өгсөн. Мөн дэд бүтэц, нийтийн тээвэр, ус болон хог хаягдлын байгууламж, эмнэлэг, сургууль, халамжийн байгууллага, олон нийтийн амралт соёлийн төвийн үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоог өргөн ашиглаж байна.

   г/ АНУ-д дэд бүтцийг ханган нийлүүлэхэд хувийн салбарын оролцоо бусад орнуудтай харьцуулахад харьцангуй голлох байр суурь эзэлж байна. Холбооны

UIH.MN СУДАЛГААНЫ САН

мужийн болон орон нутгийн засаг захиргааны нэгжийн хэмжээнд цэвэр болон муу ус, хог хаягдлын үйлчилгээ, нийтийн аж ахуйн үйлчилгээ, барилгын засвар үйлчилгээ, хууль эрх зүйн үйлчилгээ, архитектур ба инженерингийн үйлчилгээ, түргэн тусламжийн үйлчилгээ болон барилга байгууламжийн менежментийн удирдлага, ашиглалтыг голчлон гэрээгээр гүйцэтгүүлдэг нийтлэг жишиг эртнээс тогтжээ. Түүнчлэн АНУ-д өөрөө өөрийгөө зохицуулагч байгууллагуудын хувьд Канадаас нилээд туршлага солицож эрчимтэй хөгжүүлж байгаа улсуудын нэг юм. Тухайлбал: АНУ-ын хувьд мэргэжлийн холбоод, өөрөө өөрийгөө зохицуулагч холбоодоор төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлдэг жишиг байдаг.

д/ ОХУ-д төрийн гүйцэтгэх байгууллагуудад аутсорсингийг өргөн ашиглаж, ялангуяа Холбооны субъектууд өөрийн засгийн газрын тогтоол, журмаар энэ үйл ажиллагааг зохицуулан амьдралд өргөн нэвтрүүлж байна. Бизнес холбоод, өөрөө өөрийгөө зохицуулах байгууллагуудтай хамтран ажиллаж гэрээний үндсэн дээр ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх үйл ажиллагаа үндсэндээ эрх зүйн хувьд ч, практик дээр ч төлөвших шатандаа явж байна. Мөн нийгмийн үйлчилгээний салбар тухайлбал, нийгмийн халамж, өндөр настны эмчилгээ, үйлчилгээнд хувийн хэвшлийн оролцоог өргөн ашиглаж байна.

3. Төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох нь чухал ба энэ хүрээнд төр, засгаас иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн төрийн бус байгууллага, холбоодын ажилд бодитой туслалцаа үзүүлэх, тэдгээрээс дэвшүүлсэн санал, санаачлагыг хүлээн авч дэмждэг, хэрхэн ажил хэрэг болгосноо эргэж тайлагнадаг хууль эрх зүйн орчныг мөн бүрдүүлэх шаардлагатай.

4. Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх үйл явц нь үндэслэлтэй эсэхийг тогтоох шалгуур, үзүүлэлтийг боловсруулах нь чухал бөгөөд энд зөвхөн төсвийн зардлыг багасгах явдал голлох шалгуур болж болохгүй юм. Харин төрийн зарим үүргийг төрийн бус байгууллага, хувийн секторт шилжүүлэх үйл явцын үндсэн шалгуурууд нь шилжүүлсэн үүргийг хэрэгжүүлэх үр ашиг нэмэгдэх, үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж дээшлэх зэрэг үзүүлэлтийг шалгуур болгодог ажээ.

5. Монгол Улсын хууль эрх зүйн орчныг авч үзвэл:
   - УИХ-аас ***“Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого”***-ын баримт бичиг болон ***“Концессын тухай”*** хуулийг, Засгийн газраас ***“Төрийн бус байгууллагад гэрээний үндсэн дээр хариуцуулан гүйцэтгүүлэх зөвшөөрлийн жагсаалт”***-ыг батлан гаргасан нь төр, хувийн хэвшлийн түншлэлд шинэлэг бөгөөд дэвшилттэй алхам болсон.
   - Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлснээр тэдгээрийн хооронд үүрэг, хариуцлагыг хуваах, төрийн өмч хөрөнгийг илүү үр ашигтай зарцуулах, төрийн үйлчилгээг бага зардлаар чанартай хүргэх боломж бүрдсэн. Түншлэгч талуудын нийтлэг эрх ашгийг бүрдүүлж, харилцан ашигтай хамтран ажилласнаар улс орны эдийн засаг, бизнесийн хөгжилд хувь нэмэр оруулах ач холбогдолтой.
   - Хэдийгээр хууль эрх зүйн орчин бүрдсэн ч түүний хэрэгжилт хангалтгүй, хэрэгжүүлэх механизм тодорхой бус байна. Зарим хууль тогтоомжид урамшууллын талаар оруулсан нь оновчтой алхам боловч урамшуулах арга хэлбэр, тогтолцоо нь тодорхойгүй байна.

Цаашид дээрх асуудлуудыг хууль тогтоомжид илүү тодорхой тусгах, төр-хувийн хэвшлийн түншлэлийн талаар сайтар сурталчлан таниулах шаардлагатай. Түүнчлэн төрийн бус байгууллага, хувийн хэвшлийг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах, бусад орны туршлагыг нэвтрүүлэхэд анхааран ажиллах шаардлагатай.

УИХ.MN СУДАЛГААНЫ САН

## I. УЛСЫН САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛИЙН ЗОРИЛГО, МӨН ЧАНАР, ХАНДЛАГА

XX зууны эцэс XXI зууны эхээр дэлхийн ихэнх улс оронд улсын салбарын шинэчлэл явагдаж, төрийн удирдлагыг өөрчлөн цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэ удирдлагын тогтолцоонд шилжүүлэх өргөн цар хүрээтэй үйл явц явагдсан, одоо ч үргэлжилж байна. Энэхүү өөрчлөлт шинэчлэл нь төрийн байгууллагыг тогтолцооных нь хувьд үр ашгийг нь нэмэгдүүлэх, төрийг өндөр чадавхитай, мэргэшсэн боловсон хүчин бүхий, ингэхдээ эдгээр боловсон хүчинд зарцуулж буй зардлаа хянадаг, тооцдог чадвартай хүчирхэг ажил олгогч болгох, хувийн хэвшил, ард иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх цогц зорилтуудыг шийдвэрлэх шаардлагыг дэвшүүлжээ.

Улсын салбарын шинэчлэлийн голлох салбар, чиглэл нь нийгэмд төрийн үүрэг, төрийн удирдлагын байгууллагуудын бүтэц, төрийн аппаратын үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн албаны удирдлага, санхүүгийн удирдлагын шинэчлэл, төрийн удирдлагын ил тод, тайлагнах байдал зэрэг болно.

Дэлхийн зарим улсад, тухайлбал, Австрали, Шинэ Зеланд, Их Британид улсын салбар, төрийн удирдлагыг бүхэлд нь, үндсээр нь шинэчлэх (New Public Management) байдлаар явагдсан бол Герман, Финлянд, Голланд зэрэг оронд аажмаар шинэчлэх, Канадад аль алийг нь хослуулах замаар энэ шинэчлэлийг хийж байна. Ингэхдээ энэ хоёр замын алиныг нь ч сонгосон хувийн секторын удирдлагын давуу талыг онцолж, түүний арга, загварыг хэсэгчлэн болон бүхэлд нь төрийн удирдлага, улсын салбарын удирдлагад нэвтрүүлэх, төрийн захиргааны шинэчлэл уламжлалт бюрократ тогтолцоонд бус, харин аж ахуй эрхлэх менежментэд суурилах, төрийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах, төрийн үйлчилгээг нийлүүлэхэд өрсөлдөөнийг дэмжих, гүйцэтгэлд үндэслэсэн үнэлгээ нэвтрүүлэх, төрийн зарим үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх, хувьчлах явдлыг тэргүүлэх чиглэл болгожээ.

Төрийн удирдлага, захиргааны шинэчлэлийн нэг гол чиглэл нь төр, иргэн, хуулийн этгээдийн хоорондын харилцааны нэг үндсэн хэлбэр болох төрийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх явдал бөгөөд төрийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх нэг чухал арга нь төрийн зарим чиг үүргийг улсын бус секторт шилжүүлэх үйл ажиллагаа юм.

Төрийн зарим чиг үүргийг хувийн сектор, төрийн бус байгууллагад шилжүүлэх нь ардчилсан, өндөр хөгжилтэй улс орнуудын улсын салбарын хөгжлийн орчин үеийн хандлага бөгөөд төрийн зарим үүргийг гүйцэтгэхэд “гуравдугаар сектор” оролцох нь үйлчилгээг тодорхой, шуурхай болгох, зардал хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх, захиргааны хүнд суртлыг халж, үйлчлүүлэгчдийн эрэлт, хэрэгцээг нэн тэргүүнд тавих боломжийг олгодог байна.

Төрийн үйлчилгээ нь төрийн нийтийн чиг үүрэгтэй шууд холбоотой ба төрийн байгууллагууд эдгээр үүрэг дээр үндэслэн уг үйлчилгээг үзүүлдэг. Төрийн үйлчилгээ нь төрийн чухам ямар чиг үүрэгтэй холбогдон гарч ирдэг вэ гэдэг асуудлыг тодруулах үүднээс төрийн чиг үүргийн дараах хоёр том бүлэг болгон авч үздэг. Үүнд:

1.Иргэд, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдсэн төрийн чиг үүрэг;
2.Төрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоогүй чиг үүрэг болно.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Төрийн гүйцэтгэх чиг үүргийг нарийвчлах, данслаж цэгцлэх үйл явцад (Inventory of function) эдгээр чиг үүргийг дараах 3 бүлэг болгон хуваажээ. Үүнд:

1.Хууль, хэм хэмжээ тогтоох чиг үүрэг;
2.Хууль хэрэглэх чиг үүрэг;
3.Төрийн (нийтийн) үйлчилгээ үзүүлэх ба төрийн өмчийг удирдах чиг үүрэг болно.

Төрийн зарим чиг үүргийг улсын бус салбарт шилжүүлэн гүйцэтгүүлэх асуудал нь энэ 3 дугаар бүлэг чиг үүрэг буюу төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй холбоотой гэдэг нь ойлгомжтой юм. Төрийн буюу нийтийн үйлчилгээ нь бусад үйлчилгээнээс ялгарах дараах онцлог шинжтэй байдаг. Үүнд:

- Эдгээр нь бүх нийтийг хамарсан, нийтийн ач холбогдол бүхий үйл ажиллагааг хангадаг.
- Уг үйлчилгээг хүртдэг субъект нь хязгааргүй хүрээтэй байдаг.
- Нийтийн үйлчилгээг төр ба орон нутгийн байгуулага, аль эсхүл өөр бусад субъект үзүүлдэг.
- Нийтийн үйлчилгээ нь нийтийн болон хувийн өмч дээр суурилдаг.

Төрийн зарим чиг үүргийг улсын бус секторт шилжүүлэх үйл ажиллагааг захиргааны журмаар (ихэвчлэн тусгайлан байгуулсан бүтцээр дамжуулан) ба гэрээний үндсэн дээр шилжүүлэх гэсэн замаар хэрэгжүүлдэг.

Төрийн үйлчилгээг хүргэх дэг журам, хэмжээ, нөхцөлд их, бага ямар нэгэн өөрчлөлт орох нь хэрэглэгчдэд шууд нөлөөлөх учраас нийтийн үйлчилгээг улсын бус секторт шилжүүлэх шийдвэрийг гаргахдаа нухацтай хандах, хэрэглэгчдийн хүсэл, сонирхлыг харгалзах нь чухал байдаг байна.

Түүнчлэн ийнхүү шилжүүлэх үйл явц нь үндэслэлтэй эсэхийг тогтоох шалгуур, үзүүлэлтийг боловсруулах шаардлагатай ба энд зөвхөн төсвийн зардлыг багасгах явдал голлох шалгуур болж болохгүй юм. Харин төрийн зарим үүргийг төрийн бус байгууллага, хувийн секторт шилжүүлэх үйл явцын үндсэн шалгуурууд нь шилжүүлсэн үүргийг хэрэгжүүлэх үр ашиг нэмэгдэх, үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж дээшлэх зэрэг үзүүлэлтийг шалгуур болгодог ажээ.

Төрийн үйлчилгээний чиг үүргийг улсын бус салбарт шилжүүлэхийн тулд дараах нөхцөлүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

- Нийтийн үйлчилгээг улсын бус салбарт шилжүүлэх шалгуурыг тодорхойлох;
- Нийтийн үйлчилгээг шилжүүлэн гүйцэтгэх гэж буй төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагыг тодруулах шалгуурыг тодорхойлох;
- Нийтийн үйлчилгээг дээрхи байгууллагуудаар шилжүүлэн гүйцэтгүүлэх нөхцөлийг тодорхойлох зэрэг болно.

Мөн төрийн зарим чиг үүргийг шилжүүлж байгаа тодорхой тохиолдол бүрт ямар зорилтод хүрэх гэж буй, ийнхүү шилжүүлэхийн нийгмийн ач холбогдол бүхий үр дүн, урьд нь ямар сөрөг үр дүн гарч байсан, түүнийг хэрхэн арилгах арга зам зэргийг нарийн тооцож тодруулсан байх шаардлагатай байдаг байна.

Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудад шилжүүлэх нэг чухал нөхцөл нь төрийн зүгээс эдгээр байгууллагын үзүүлж буй үйлчилгээний чанарт хяналт тавих явдал юм.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Ихэнхи улс оронд энэхүү хяналтыг “Төрийн үйлчилгээний стандарт”-ын (Public Service Standarts)[1] дагуу явуулдаг байна. Энэхүү стандартыг боловсруулахын тулд төрийн үйлчилгээний албан ёсны жагсаалтыг (The register of Public Service)[2] гаргадаг.

[1]Public Service Standards 2007-2008. www.nationalarchives.gov.uk
[2]National Register of Public Service. www.nrpsi.co.uk

## II. ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ХУВИЙН ХЭВШЛЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ХЭЛБЭРҮҮД, ТЭДГЭЭРИЙН ОНЦЛОГ

Төрийн удирдлага, захиргааны шинэчлэлийн хүрээнд төрийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагад шилжүүлэн гүйцэтгүүлэх үйл явц нь ихэвчлэн төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд явагддаг ба төрийн эрх, үүрэг, үйл ажиллагааг шилжүүлэх хэд хэдэн хэлбэрийг ангилж болохоор байна. Үүнд:

1. Концессийн гэрээ (Төрийн зүгээс хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах хэлбэр)
2. Тендерийн гэрээ (Төрийн хөрөнгөөр хувийн хэвшлээр ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх хэлбэр)
3. Өөрөө өөрийгөө зохицуулах байгууллага, мэргэжлийн холбоодоор төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх (Зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, төрийн байгууллагын зарим чиг үүргээс зах зээлийн хяналт, зохицуулалтын зарим эрх, үүргийг Мэргэжлийн холбоод, нийгэмлэгүүдэд шилжүүлсэнээр зах зээлийн өөрөө өөрийгөө зохицуулах механизмыг төлөвшүүлэх, шаталсан хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх хэлбэр)
4. Аутсорсинг (Тухайн хэрэгцээт ажил үйлчилгээг нарийн мэргэшсэн мэргэжлийн байгууллага, хувь хүмүүсээр гүйцэтгүүлэх хэлбэр) гэх мэтээр

Концесс нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн нэг хэлбэр бөгөөд төр, концесс эзэмшигчид байгалийн баялаг, газар, дэд бүтцийн объектууд, үйлдвэрийн газар бусад аж ахуйн объектууд, тоног төхөөрөмжийг гэрээний үндсэн дээр харилцан ашигтай нөхцөлөөр ашиглуулахаар шилжүүлэх хэлбэр юм. Концессийн гэрээний зүйл буюу объект нь гол төлөв нийтийн шинж чанартай объектууд байдаг, тухайлбал, нисэх буудал, төмөр зам, барилга байгууламж, дэд бүтцийн байгууламжууд мөн нийтийн тээврийн тогтолцоо, эрүүл мэнд, боловсрол, соёл, спортын объектууд зэрэг болно.

Түүнчлэн концессийн олон хэлбэр байдаг ба төсөл боловсруулах, барих ажлыг хувийн байгууллагад зөвшөөрч мөнгө, цаг хэмнэхийн зэрэгцээ гүйцэтгэлийн баталгаатай байдлыг хангах болон төслийн нэмэлт эрсдлийг хувийн хэвшилд шилжүүлэх, хувийн хэвшлийн байгууллага үндэсний болон орон нутгийн засаг захиргааны захиалгаар тодорхой нэг үйлчилгээг (барилга байгууламж, тоног төхөөрөмж, ажил үйлчилгээ) хүргэх, түүнтэй холбогдох засвар үйлчилгээ зэрэг өдөр тутмын үйл ажиллагаа, ашиглалтыг гэрээгээр гүйцэтгэн төрийн эрх бүхий байгууллага тухайн барилга байгууламж, системийг өмчилж ерөнхий удирдлагаар хангах зэрэг хэд хэдэн хэлбэртэй. Эдгээр хэлбэрүүд нь эрсдэл шилжүүлэх хэмжээ болон хувийн салбарын оролцооны хувьд харилцан адилгүй ба жишээ нь, Канад улс гэхэд урд нь төрийн хариуцаж байсан ажил үйлчилгээг хувийн хэвшилд бүхэлд нь концессоор гүйцэтгүүлэхийг түншлэлийн дээд хэлбэр гэж үздэг байна[3].

Тендер нь урьдчилсан уралдаанд шалгаруулалтын үндсэн дээр түншлэгчийг шалгаруулан гэрээ байгуулах хэлбэр юм. Тендер нь шударга, үр ашигтай байдал, өрсөлдөөний үндсэн дээр төрөөс бараа, ажил үйлчилгээ худалдан авах, гэрээт ажил, үйлчилгээ хийлгэх түншлэгчээ сонгон гэрээ байгуулах үйл явц болно.

Тендер нь нээлттэй, хаалттай, тусгай хаалттай, хоёр үе шаттай, үнэ тогтоох зэрэг төрөлтэй. Аливаа тендерийг шударга явуулах анхдагч нөхцөл нь сонирхогч талуудыг үнэн зөв, бүрэн дүүрэн мэдээллээр жигд хангаж, ил тод, нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэх явдал гэж үздэг.

[3]"Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшилд шилжүүлэх нь". Харьцуулсан судалгаа (Код: СТ-10/216). УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв. УБ., 2010, 14 дэх тал.

UIH.MN ТЭТГЭЛЭГТ САН

Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод шилжүүлэн гүйцэтгүүлэх нь иргэний нийгмийн чухал бүрэлдэхүүн хэсэг болсон төрийн бус байгуулагууд нь төсөв зардлыг хэмнэх, үйлчилгээг иргэдэд илүү ойртуулж, шуурхай үр дүнтэй хүргэх боломжтой байдгаараа давуу талтай байдаг байна. Төрийн бус байгууллагууд нь нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээ, боловсрол, нийгмийн эрүүл мэнд, байгаль орчин, нийгмийн хэв журам, хүний эрхтэй холбоотой асуудлууд, мэдээлэл, зар сурталчилгаатай холбоотой ажил, үйлчилгээг үзүүлэхэд тэргүүлэх үүрэгтэй оролцдог.

Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр болон хуулийн дагуу шилжүүлэн хэрэгжүүлэхэд мэргэжлийн холбоод, өөрөө өөрийгөө зохицуулах байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэхдээ мэргэжлийн холбоод, өөрөө өөрийгөө зохицуулах байгууллагууд нь тухайн салбарын харилцааг хянах, зохицуулах харилцааг хууль, журмын хүрээнд зохицуулахын зэрэгцээ хамгийн гол нь тухайн салбарын үйл ажиллагааны стандарт, журмыг боловсруулан тогтоох, түүний дагуу үйл ажиллагаанд нь хяналт тавих эрхийг тэдэнд хуулиар олгосон байдагт оршино. Тухайлбал, Канадын радио нэвтрүүлгийн стандартын зөвлөл **(CBSC)**-Canadian Broadcast Standards Council – Энэхүү зөвлөл нь Канадын хувийн салбарын нэвтрүүлэгчдийн өөрөө өөрийгөө зохицуулах байгууллага юм. Зөвлөл нь хэд хэдэн дүрэм журам (code)-ыг гарган мөрдүүлж байгаа бөгөөд тухайлбал: секс дүрийг дүрслэх журам (sex role portrayal code), хүчирхийллийн журам (violence code), ёс зүйн дүрэм (code of ethics), мөн радио телевизийн нэвтрүүлэгчдийн ёс зүйн дүрэм, радио телевизийн нэвтрүүлгийн программийн үнийн журам, сэтгүүлчийн ёс зүйн дүрэм гэх мэт дүрэм журмуудаар зохицуулагддаг байна.

Мөн үзэгч сонсогчдын зүгээс нэвтрүүлэгтэй холбоотой санал хүсэлт, нэвтрүүлэгчдийн талаарх гомдлоо зөвлөлд гаргах бөгөөд зөвлөл уг асуудлыг 14 хоногт хариу өгдөг байна. Энэ нь нэвтрүүлэгчдийн хариуцлагын түвшин өсөхөд ихээхэн нөлөөлж байна гэж Зөвлөлийн олон нийтийн хэлэлцүүлгийн илтгэлд дурдсан байна. Энэхүү зөвлөл нь жил бүр олон нийтэд илтгэл тайлангаа тавьж хэлэлцүүлдэг байна.

Түүнчлэн хүүхдийн нэвтрүүлгийн стандарт, бусдыг доромжилсон нэвтрүүлгийн, хүчирхийллийн гэх мэтчилэн нилээд олон стандартуудыг зөвлөлөөс батлан гаргаж мөрдүүлж байна.

**Олон улсын үнэт цаасны хороо-IOSCO:** АНУ-ын үнэт цаасны зах зээлд томоохон байр суурь эзэлдэг байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан дүрэм, журмаар зохицуулдаг байна. Олон улсын үнэт цаасны хорооноос үнэт цаасны мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаандахь хууль, журмын хэрэгжилтийг үнэлж дүгнэх аргачлал, арга зүйг баталсан бөгөөд уг дүрмийн 6-д "Өөрөө өөрийгөө зохицуулах байгууллагад хамаарах зарчим (Principles relating to Self-Regulation)-уудыг тодорхойлж зохицуулсан байна. Өөрөө өөрийгөө зохицуулагч байгууллага нь бүхий л үйл ажиллагаагаа дүрмийн хүрээнд удирдан зохион байгуулах болон хянах, зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Дэлхийн олон улс оронд явагдсан захиргааны шинэчлэлийн нэг зорилго нь төрийн байгууллагууд үйл ажиллагаандаа инновацийг нэвтрүүлэхэд бэлэн байх урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэх явдал байсан бөгөөд төрийн удирдлагын хувийн хэвшил, эдийн засгийн салбарын тэргүүлэх туршлагаас нэвтрүүлсэн шинэ технологи нь аутсорсинг билээ.

**"**Аутсорсинг" гэдэг үг нь англи хэлний **"outsourcing"** буюу гадаад орчноос нөөц эрж хайх гэсэн утгатай үг. Эдийн засгийн салбарт аутсорсинг гэдэг бол тухайн компанийн үйл ажиллагаанд хэрэгтэй ямар нэг ажлыг тухайн ажлыг хийж мэргэшсэн өөр компаниар хийлгэхийг хэлнэ.

UFIMN СУДАЛГААНЫ САН

**Сонгодог тодорхойлолтууд:**

- "Байгууллага өөрийн түргэн хугацаанд гүйцэтгэх ёстой ажлуудыг гадны гүйцэтгэгчийг ашиглан гүйцэтгүүлэх үйл явц" (Филип А. Лапланте),
- "Бүтээгдэхүүн болон үйлчилгээгээ өөрийн боломжоор хийснээс илүү чанартай, хурдан хийлгэхийн тулд гадны гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахыг хэлнэ." (Ранди Сойфер)[4].

Харин захиргаа-удирдлагын үйл явцад аутсорсинг хэрэглэх гэж төрийн үйлчилгээний тодорхой үүргийг шалгаруулалтын үндсэн дээр хувийн хэвшил, орон нутгийн байгууллага, бусад байгууллагаар гүйцэтгүүлэхийг хэлнэ[5].

Төрийн үйлчилгээнд аутсорсинг дараах үндсэн үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах, тухайлбал, мэдээллийн шинэ технологийг нэвтрүүлэх зэрэг үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх,
- Төрийн өмчийн барилга, байгууламжийн удирдлага, үйлчилгээг гүйцэтгэх,
- Боловсон хүчнийг шилж сонгох, холбооны үйлчилгээ үзүүлэх, санхүүгийн тооцоо, тооллого хийх,
- Төрийн байгууллагын үйл ажиллагааны зардал, төсвийн хөрөнгийн хэмнэлтэд хяналт тавих,
- Төрийн удирдлага, захиргааны байгууллага үндсэн үйл ажиллагаандаа гол анхаарлаа хандуулах боломж олгох зэрэг болно.

Аутсорсингийн хөгжлийн орчин үеийн хандлага нь олон улс оронд төрийн байгууллагын үйл ажиллагаанд энэ технологийг ашиглаж байгаа нь харагдаж байна[6].

Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж буй аутсорсингийн хөгжлийн дараах 4 хандлагыг онцолж болно. Үүнд:

- Төрийн үйлчилгээнд гэрээний үндсэн дээр үүрэг шилжүүлэн үйлчилгээ үзүүлэх практикийг өргөн хүрээтэй болгосон: Олон орны нийтийн үйлчилгээний[7] салбарт төрийн бус байгууллагууд зөвхөн техникийн болон тээврийн үйлчилгээ үзүүлэхэд оролцох бус харин хүн амд төрийн болон орон нутгийн үйлчилгээ, тухайлбал, татварын хуудсыг цуглуулж авах, хорих байгууллагыг удирдах, хувийн гал түймрээс хамгаалах үйлчилгээ үзүүлэх болон бусад үйлчилгээ үзүүлдэг болсон байна.
- Төрийн байгууллагын болон албан хаагчдын үйл ажиллагааны шинж чанарт өөрчлөлт орсон: Төрийн байгууллагын үйл ажиллагаанд аутсорсингийг нэвтрүүлсэнээр улсын бус салбараар шилжүүлэн гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийг төрөлжүүлэх, данслах, жагсаалт гаргах, шилжүүлэх шалгуурыг боловсруулах, зарим төрлийн үйл ажиллагааны зардлыг тооцох ил тод, тунгалаг тогтолцоог бүрдүүлэх, аутсорсингийг ашиглах, хянах, гэрээний биелэлтэд мониторинг хийх журам боловсруулах, төрийн байгууллагуудыг аутсорсинг ашиглахад түлхэц үзүүлэхүйц механизм бий болгон хэрэгжүүлэх зэрэг ажлууд хийгдсэн.
- Түншлэлийн харилцаа тогтоох: Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны нэг хэлбэр бөгөөд хувийн хэвшил нь аж ахуйн нэгж байгууллага байхаас гадна ашгийн бус байгууллага буюу төрийн бус байгууллага байж болно. Оролцогч тал бүр эзэн байх, өөрөөр хэлбэл, оролцогчид аль нэг эрх бүхий байгууллагаас үл хамааран өөрийн нэрийн өмнөөс гэрээ, хэлэлцээр хийх чадвартай байна. Түншлэл нь оролцогчдын хооронд удаан хугацаанд тогтвортой үргэлжлэх харилцааг байгуулна. Түншлэл нь үр дүн эсхүл үйл ажиллагааны төлөө хариуцлагаа хуваалцахыг илэрхийлнэ.

[4]www.biznetwork.mn
[5]Административная реформа: решения и проблемы. www.adm.yar.ru
[6]Outsourcing of Public Services in Australia. www.inst-informatica.pt
[7]Public Service.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Төрийн болон орон нутгийн чанартай гэрээний агуулга өөрчлөгдсөн: Төрийн байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагын хооронд байгуулсан гэрээнд юун түрүүнд үйлчилгээний төлбөрийн төрөл, хэмжээ, гэрээний нөхцлийг зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага зэрэг эдийн засгийн агуулга бүхий заалтуудад ач холбогдол өгч, үүнд гэрээний эрх зүй онцгой байр суурь эзлэх болсон. Түүнчлэн захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан үндсэн гэрээний хамт үйлчилгээний түвшингийн (Service Level Agreements) тухай гэрээг мөн байгуулдаг. Энэ нэмэлт гэрээнд үйлчилгээний чанарт тавигдах шаардлага, үзүүлэлтийг нарийвчлан зааж, түүнд тавих хяналтын арга хэрэгслийг тодорхойлно.

## III. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ГЭРЭЭГЭЭР ШИЛЖҮҮЛЭН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТАЛААР ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

### 3.1. АВСТРАЛИ УЛС

Австрали улс нь төрийн бүтцийн хувьд парламентын засаглалтай Холбооны Засгийн газар бүхий тогтолцоотой бөгөөд ТХХТ (Төр Хувийн Хэвшлийн Түншлэл) төсөл, хөтөлбөрүүд нь голчлон нэгдсэн Засгийн газар гэхээсээ илүү Холбооны муж улсаар дамжин, бие даан хэрэгжиж эхэлсэн.

Мужуудын засаг захиргаа нь эдийн засгийн болон нийгмийн дэд бүтцийн асуудлыг хариуцан, хүн амын хэрэгцээнд нийлүүлэх ажлын тэргүүлэх үүргийг гүйцэтгэдэг.

**Бодлого, хууль эрх зүйн орчин**

ТХХТ-ийг хэрэгжүүлэхдээ дараах бодлого, хууль эрх зүйн актын дагуу хэрэгжүүлдэг.

- **Хууль эрх зүй:** Австралийн Үндсэн хууль (Constitution), Төрийн үйлчилгээний тухай хууль (Public Service Act) 1999, Эрүүгийн хууль (Crimes Act) 1914, Хяналт шалгалтын ерөнхий хууль (Auditor-General Act) 1997, Санхүүжилтийн тухай хууль (Appropriation Acts), Иргэний түншлэлийн тухай хууль (Civil Partnership Act) 2004.
- **Бодлогын баримт бичиг:** Виктория хамтын ажиллагааны тухай (Partnerships Victoria) 2000, Нээлттэй өрсөлдөөний бодлого (Open Competition), Албан тайлангын баримтлах бодлого (Mandatory Reporting), Төрийн үйл ажиллагааны үндсэн чиглэл (Public Works).
- **Санхүүгийн менежментийн хууль зүйн орчин:** Санхүүгийн удирдлага ба хариуцлагын тухай хууль (Financial Management and Accountability Act) 1997 болон хуультай холбогдож гарсан дүрэм, журам, тогтоолууд (Orders, ), Хамтын нөхөрлөлийн орнуудын компани болон тэдгээрийн зохицуулалтын тухай хууль (Commonwealth Authorities and Companies Act) 1997, хуультай холбогдолтой гарсан тогтоолууд (Commonwealth Authorities and Companies Regulations).

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Викториа мужид хувийн хэвшил дэд бүтцийн салбарт гар бие оролцож, бүтээн байгуулах болсон үеийг цаг хугацааны хувьд 2000 оноос өмнөх болон 2000 оны дараах үе гэж ерөнхийд нь хоёр хуваан авч үздэг байна.

***1997 онд үндсэн дараах ажил үйлчилгээнд хуваагдаж байсан:***

- Замын үйлчилгээ (зам, замын хажуу, явган хүний зам, ус зайлуулах үйлчилгээ, автомашины зогсоолын үйлчилгээ, замын хажуугийн тохижилт болон тэмдгийн үйлчилгээ, гудамжны цэвэрлэгээ),
- Талбайн үйлчилгээ (задгай талбай, далайн түрэлтийн үед усанд ордог эрэг хавийн бүс болон модны үйлчилгээ, оршуулгын газар),
- Барилгын үйлчилгээ (барилгын үзлэг болон дотоод үйлчилгээ).

***2000 оноос хойш*** дараах ажил үйлчилгээ нэмэгдсэн байна:

- Замын үйлчилгээ (орон нутгийн замын энгийн техник үйлчилгээ, ус зайлуулах сувгийн засвар)
- Цэвэрлэгээ (бүх ус зайлуулах сувгийн дэд бүтэц, арилжааны болон олон нийтийн задгай талбай, ариун цэврийн газрууд /00/ зэргээс хог цуглуулах),
- Цэцэрлэгт хүрээлэн болон замын хажуугийн талбайн үйлчилгээ (бүх орон нутгийн /сүлжээ/ замын хажуу, тоглоомын талбай, амралтын бүс болон галын унтраах зэрэг үйлчилгээ),
- Тохижилт болон тэмдгийн үйлчидгээ (замын, цэцэрлэгт хүрээлэнгийн бүх тэмдэг, бүх тохижилт буюу тавилга, шат, явган хүний зам),
- Барилгын үйлчилгээ (төрийн өмчийн бүх барилгын дотоод үйлчилгээ болон цаг үеийн үйлчилгээ)[8].

2000 оноос өмнөх үеийн үйл явцын онцлог нь балансын гаднах буюу төсвийн болон татварын бус санхүүжилтийн эх үүсвэрийг хайж олох, хувийн хэвшлийн байгууллагуудын өрсөлдөөнт болон үр ашигтай ажиллах чадварын итгэлцлийг бий болгоход анхаарсан байна. 2000 оноос хойш ТХХТ-ийн үе нь олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн “мөнгөний үнэ цэнэ”-ийг бий болгох баримжаатай, эрсдлийг эрчимжүүлэн шилжүүлэх тал дээр голчлон анхаарч ирсэн байна.

2000 онд гарсан “Partnerships Victoria” бодлогын баримт бичиг нь хамтын хэлэлцээр хийхийн өмнөх шийдвэр гаргалт, хамтын ажиллагааны гэрээ байгуулах, төслийн менежмент, мониторинг ба хяналтын хийх асуудлыг багтаасан цогц заавар журмуудыг анхлан тодорхойлжээ. Түүнээс хойш уг удирдамжийг байнга сайжруулан шинэчилж, хэрэгцээт жишээ хэв загваруудыг багтааснаараа цаг үетэйгээ нийцэж Австралийн бусад мужуудын хувьд төдийгүй олон улсын түвшинд стандарт, үлгэр дууриалал болон хэрэглэгддэг байна.

Викториа мужийн Хамтын Ажиллагааны арга барилын салшгүй гол санаа нь Засгийн газар актив хөрөнгө худалдан авч байгаа бус, харин зөвшөөрөгдсөн чанартай, тоо хэмжээтэй, тогтоосон зардалтай болон заасан цаг хугацаатай ажил үйлчилгээг хувийн хэвшлээс худалдан авч байгаа явдал юм.

Уламжлалт улсын салбарын худалдан авалт ба Викториа Хамтын Ажиллагааны аргачлал хоёрын ялгаатай талыг дор харьцуулан үзүүлсэн болно.

**Уламжлалт улсын салбарын худалдан авалт ба Викториа Хамтын Ажиллагааны аргачлалын харьцуулалт**[9]

| ***Уламжлалт худалдан авалт*** | ***Викториа хамтын ажиллагаа*** |
|---|---|
| • Дэд бүтцийн барилга, байгууламжийг төр худалдан авна | • Дэд бүтцээр дамжин нийлүүлэгдэж буй үйлчилгээг төр худалдан авна |
| • Зураг төсөл, барилга байгуулалтын богино-хугацаат гэрээ (2-4 жилийн) | • Зураг төсөл, барилга байгуулалтыг бүхэлд нь хамарсан урт хугацааны гэрээ (20+жил) |
| • Орцод суурилсан ажлын жагсаалт | • Гарцад суурилсан ажлын жагсаалт |
| • Барьж байгуулах болон ашиглах хугацааны бүх эрсдлийг төр хүлээнэ | • Барьж байгуулах болон ашиглах хугацааны бүх эрсдлийг хувийн хэвшил хүлээнэ |
| • Хөрөнгө оруулалтын эхний зардал өндөр, урсгал зардал бага байхаар төлбөр хийгддэг | • Барилга байгууламж ашиглалтад ормогц төлбөр хийгдэнэ. Төлбөрийн хэмжээ урт хугацааны гэрээний туршид харьцангуй жигд байна |

[8] www.econ.mq.edu.au
[9] Partnerships Victoria. Guideline material. July 2006, Overviem, page 5.

| | |
|---|---|
| • Барьж байгуулах цаг хугацаа болон зардлын хэтрэлтийг төр үүрэхэд хүрдэг | • Хувийн гэрээлэгч барьж байгуулах цаг хугацаа болон зардлын хэтрэлтийг харуулна |
| • Барилга байгууламжийг төр хариуцан ажиллуулна | • Барилга байгууламжийг төр хариуцан ажиллуулах эсэх нь үйлчилгээний төрлөөс хамаарна |
| • Байгууламжийг барих, ашиглах хугацааны туршид төрөөс олон тооны гэрээ, хэлэцээрийг байгуулна | • Байгууламжийг барих, ашиглах хугацааны туршид төрөөс ганцхан тооны гэрээ хийдэг |
| • Үйл явц дахь ажлын гүйцэтгэлээс хамаарсан стандарт байхгүй | • Гүйцэтгэлийн стандарттай, үйлчилгээ гэрээнд заасны дагуу биелүүлээгүй нөхцөлд төлбөрийг бууруулах боломжтой |
| • Ашиглалтын хугацаа тодорхой биш | • Хүлээлгэн өгөх чанарын үзүүлэлт болон ашиглалтын хугацаа тодорхой |

Дээрх хүснэгтээс Викториа Хамтын Ажиллагааны гол элементүүд нь:

- Засгийн газар төрөөс үзүүлэх гол ажил үйлчилгээ, тухайлбал, улсын сургуулийн сургалт, улсын эмнэлгийн болон засан хүмүүжүүлэх үйлчилгээ гэх мэт хариуцлагыг өөртөө авч үлдсэн
- Хөрөнгийн хомсдол болон балансын хуудасны тоон харьцаанаас илүүтэйгээр мөнгөний үнэ цэнийг хөдөлгөгч хүчин зүйл болгосон
- Хамтын ажиллагааны төрөл бүрийн загваруудыг ашигласан
- Худалдан авалтын процессыг ил тод тендерээр явуулах зарчмыг хатуу баримталсан
- Олон нийтийн ашиг сонирхлын шалгуурыг давж байгаа эсэхийг шалгах тестыг шударга тэгш байдал, хэрэглэгчдийн эрх, олон нийтэд хүртээмжтэй байдал, аюулгүй байдал, хувийн нууцлал зэрэг шалгуураар боловсруулсан
- Өрсөлдөөнт төвийг сахисан зохицуулалтаар засгийн газрын агентлагын өөрт нь ноогдсон ерөнхий өрсөлдөөнт давуу талыг халж байгаа зэргийг дурьдаж болно.[10]

**Бараа материал, үйлчилгээ авах удирдамж**

Хамтын нөхөрлөлийн орнуудад *(*Автрали, Шинэ Зеланд, Шотланд, Их Британи гм*)* бараа материал, үйлчилгээ нийлүүлэхэд удирдах зарчим нь ижил байдаг. Сангийн яамнаас энэхүү “Бараа материал, үйлчилгээ авах удирдамж”-ийг гаргасан байна.

Удирдамжийг гарснаар Засгийн газрын бүх хэлтэс, агентлагын 1997 оны Санхүүгийн хуулиар Засгийн газрын хэлтэс, агентлагын чиг үүргийг тодорхойлж нарийвчлан зааж өгсөн байдаг.

**Хамрах хүрээ**

Удирдамжинд доорх зүйлс хамаарна. Тухайн бараа материал, ажил үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг Засгийн газрын агентлаг тодорхойлоод түүнийг сонгох, үйлчилгээг авах явцад гарах магадлалтай эрсдлийг тооцох, гэрээ байгуулах, бараа материал үйлчилгээний нийлүүлэлт, төлбөр, гэрээний явцад хяналт тавих үйл ажиллагаа хамаарна.

Энэ асуудалтай холбоотой үндсэн гурван баримт бичиг байдаг. Үүнд:

1. Сангийн яамнаас гарсан удирдамж нь тухайн бараа материал, үйлчилгээг үзүүлэх процердурыг тодорхойлох.
2. Санхүүгийн хөтөлбөр, ажил үйлчилгээ авах Засгийн газрын бодлогод өөр санхүү ба төрийн зохицуулалтын хэлтэсээс зөвлөгөө өгдөг.

[10]“Төрийн чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшилд шилжүүлэх нь”, Судалгааны тайлан. Удирдлагын академи, 2010 он.

3. Засгийн газрын бараа материал ажил үйлчилгээ авахад эдийн засгийн өсөлттэй холбогдуулан Засгийн газрын агентлагуудад дэмжлэг үзүүлэхээр гарч буй баримт бичгүүд зэрэг болно.

**Aus Tender**

Aus Tender нь Засгийн газрын агентлагуудын жил бүрийн бараа материал, үйлчилгээ худалдаж авах жагсаалтыг хэвлэн гаргах, ажил хэргийн боломжийг танилцуулах цахим хэлбэрийн системийг ашигладаг.

Aus Tender нь Австралийн Засгийн газрын өмнөөс Санхүү ба төрийн зохицуулалтын хяналтын хэлтэс удирдаж явуулдаг. Агентлаг нь цахим системээс гадна хэвлэл мэдээллийн бусад хэрэгсэл болох сонин, сэтгүүл, телевизийг ашиглаж болдог байна.

Тендерийн үр дүн гарсан тохиолдолд шалгарсан газарт мэдэгдэнэ. Агентлаг нь тухайн үүрэг гүйцэтгэхээр шалгарсан гүйцэтгэгчийг нээлттэй байлгах үүднээс хамтран гүйцэтгэгчийг тодруулна. Шалгарсан гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэгчийнхээ мэдээллийг бүрэн гүйцэд өгч ил тод болгодог.

Шууд эх үүсвэр нь тухайн тендерийн гадаад, дотоодын нийлүүлэгчид уралдаан шалгаруулалт явуулахгүйгээр авах давуу эрх олгогдохгүй. Харин дараах тохиолдолд агентлагууд шууд эх үүсвэрт шууд хандана.

1. үнийн болон чанарын санал ирээгүй
2. бичиг баримтын шаардлага хангаагүй
3. оролцогч нар нь оролцох шаардлагыг хангаагүй (агентлаг өөрийн дүрэм журмыг өөрчлөөгүй мөн тендерийн нөхцөлийг хангаж чадаагүй тохиолдолд)
4. яаралтай, хугацаа тулсан тохиолдолд
5. хязгаарлагдмал хүрээнд бараа материал, үйлчилгээ авах тохиолдолд. Үүнд зохиогчийн эрх, патент, зэрэгт хамааралтай тохиолдолд ханддаг байна.[11]

**Хугацаа**

Бараа материал, үйлчилгээ зарласан өдөр цагаас хойш 25 хоногийн дотор бичиг баримтыг өгсөн байна. Зарим тохиолдолд явуулж байгаа агентлаг нь доод талын хугацаа нь 10-аас доош хоногоор тогтоож болдог байна.

**Хариуцлага ба ил тод байдал**

Ажил үйлчилгээг авахад хамгийн эхэнд тавигддаг асуудал нь хариуцлага, ил тод байдал юм. Агентлаг болон түүний албан тушаалтнууд бараа материал үйлчилгээг авах бүх үе шатанд нээлттэй, ил тод явуулах ёстой.

*Хариуцлага гэдэг нь:* тухайн бараа материал үйлчилгээг авахад гаргаж буй, шийдвэр, үйлдлээ хариуцна.

Ил тод байдал, хариуцлага хоёрын суурь нь хууль эрх зүйн үүрэг, бодлого (баримт бичиг үнийн санал бусад зүйлийг багтаасан) юм. Агентлаг нь үйлчилгээ авах бүртээ ажлынхаа баримтуудыг тухай бүрт нь авч хадгалж байх ёстой.

Тухайн агентлаг нь өөрийн ажилтнууддаа дараах байдлыг гаргуулахгүйн тулд доорх шаардлагыг тавьдаг байна.

[11]www.australia.gov.au

UIH.MN СУДАЛГААНЫ САН

a) албан тушаалаа урвуулан ашиглахгүй байх,
b) шударга байх,
c) ямар нэгэн шударга бус байдал илэрвэл түүнийг шалгаж үзэх,
d) Австралийн засгийн газраас баримтладаг бодлогын дагуу тухайн бараа материал, үйлчилгээг авах байгууллагын зохиож буй үйл ажиллагаа, хүлээн авалт зэрэгт оролцохгүй байх шаардлагыг тавьж дээр дурьдсан үйл ажиллагаануудыг хориглодог байна.

**Үнэ ба чанар**

Бараа материал авах үед үнэ болон чанар хоёр нийцэж байгаа талаар тус бүрд нь нарийн судалж үздэг байна.
Үнэ ба чанарын хоорондын зохилдлогоонд өртөг голлох үүрэг гүйцэтгэхгүй. Харин энэ зохилдлогоонд дараах зүйлүүдийг авч үзнэ.

- тухайн бараа материал, үйлчилгээ шаардлагатай эсэх,
- тухайн бараа материал, үйлчилгээг авахад гүйцэтгэж байгаа талын чадвар, ажилласан хугацаа, туршлага
- тухайн саналын эрсдэл
- гэрээний хувилбарын дүгнэлт (гэрээний үнэлэлт хувилбаруудад үнэлэлт өгөх, өөрөөр хэлбэл, гэрээний хувилбарыг өргөтгөх, багасгах)

**Жижиг, дунд үйлдвэрлэл**

Засгийн газар бараа материал, үйлчилгээ авахдаа тухайн ажиллагааг хариуцсан хүмүүс жижиг, дунд үйлдвэрлэлүүдэд ижил тэгш эрх олгоно. Ямар нэг шалтгаанаар түрүүлж хасахгүй. Бараа материал, ажил үйлчилгээний 10-аас доошгүй хувийг (квот) жижиг, дунд үйлдвэрлэлээс авдаг байна.

## 3.2. ИХ БРИТАНИ УЛС

Их Британи улсад XVIII зуунаас анх эхлэн орон нутгийн баян хүмүүс зээлийн сан бий болгон хувийн хөрөнгө оруулагчдаас хөрөнгө мөнгө зээлж, эвдэрч муудсан зам засаж түүнийгээ ашиглуулахдаа хэрэглэгчийн хураамжийн шимтгэл авч зээлсэн өрөө буцаан төлдөг байжээ. XIX зууны дунд үед Лондон хотын гүүр барих засварлах ажлын санхүүжилтийг иймэрхүү байдлаар бүрдүүлсэн сангаас хийж байжээ. Энэ концессийн гэрээ нь цаг хугацааны хувьд хамгийн урт түүхтэй нь байсан байна.

Анх Лейборист намын засгийн газар 1997 онд иргэдэд өндөр чанартай төрийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хамтран ажиллах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх стратеги зорилт дэвшүүлэхдээ Төр Хувийн Хэвшлийн Түншлэлийг санаачилж, улмаар 2000 онд Их Британи улсын ТХХТ-ийн төв болсон Их Британи Түншлэл /Partnerships UK-PUK/ байгууллага бий болж үйл ажиллагаагаа эхэлжээ.

Хууль эрх зүй орчин - Их Британийн Төрийн үйлчилгээний тухай хууль 2009 онд шинэчлэгдсэн, Захиргааны байгууллагын шинэчлэлийн тухай хууль 2001, Төрийн зохицуулалтыг шинэчлэх болон харилцан тохиролцох гэрээ хийх тухай хууль 1994, Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль 2000, Төрийн үйлчилгээний гомдол шийдвэрлэх тухай хууль (Public Services Ombudsman /Wales/ Act) 2005, Иргэний түншлэлийн тухай хууль (Civil Partnership Act) 2004.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Бодлогын баримт бичиг - Их Британи Түншлэл (Partnerships UK-PUK) байгууллага 2000, Засгийн газар болон иргэний секторын хоорондын хамтын ажиллагааны гэрээ Их Британий дотоод хэргийн яам (Memorandum the civil partnership) 2004, Иргэний Харти (Cimizens charter) 1991.

**Public Servises Ombudsman - Төрийн үйлчилгээний Омбудсмен**

Их Британид зарим байгууллагад төрийн албаны үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор Ombudsman (гомдол шийдвэрлэх төрийн үйлчилгээний байгууллага) ажилладаг.

Төрийн албаны зарим үйлчилгээ хангалтгүй байгаагаас үйлчилгээний талаархи гомдол ирэх гол нөхцөл болдог. Их Британий Засгийн газрын ассамблей бусад холбоодууд, эрүүл мэндийн байгууллагууд, Засгийн газрын талаархи гомдлуудыг Public Servises Ombudsman шалгах эрхтэй байдаг. Ombudsman эдгээр гомдлуудыг шалгахдаа: байгууллагуудыг хэсэг тус бүрээр бүрэн шалгадаг. Хэрэв тэнд төрийн албан хаагчийн талаар гомдол байвал Ombudsman нь хамгийн түрүүнд тухайн байгууллагын бүх гомдол саналыг хүлээн авч судалж ажиглалт хийж дахин шалгана. Харин ямар нэгэн гомдол гарчихаад шийдвэрлэгдэхгүй байгаа бол Ombudsman дахин нягтлан шалгаад эцсийн шийдвэрийг гаргадаг байна. Ombudsman-ны үүрэг нь төрийн үйлчилгээний чанарын талаар гарсан санал гомдлыг дэс дараалалтайгаар дамжуулан хянаж шийдвэрлэх явдал юм.

**Их Британи Түншлэл (Partnerships UK-PUK) байгууллага**

Дээр дурьдсан PUK байгууллага нь ашгийн бус статустай бөгөөд анх тус улсын Сангийн яамны бүтцийн нэг хэсэг (Treasury Taskforse) байсан бөгөөд өнөөдөр 51 хувь нь хувийн салбарын пүүс компанууд, үлдсэн 49 хувийн хувьцааг Сангийн Яам (HM Treasury) болон Scottish Executive эзэмшдэг байна. Түүнийг Сангийн Яам болон төрийн салбарын бусад байгууллагууд бодлогын хүрээнд дэмжих үүрэгтэй ажилладаг байна.

PUK хөрөнгөө хувь эзэмшигчдээс зээлийн хувьцаа хэлбэрээр босгож, зөвхөн шинээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг дэмжих болон төрөөс баримтлах Төр Хувийн Хэвшлийн Түншлэлийн зорилтын хүрээнд шинэ бизнес хэрэгжүүлэхэд зориулж ашигладаг, илүүдэл ашгийг буцаан хөрөнгө оруулдаг ба хувь эзэмшигч нарт олгодоггүй байна.

PUK улсын салбарт гагцхүү доорх 5 үндсэн салбарт ажлаа явуулахаар тогтжээ. Үүнд:

- Цогц худалдан авалтын төслүүдийг дэмжих
- Хөрөнгө оруулалтын болон худалдан авалтын бодлогыг хөгжүүлэх
- Бие даасан дэд бүтцийн төслүүдийг боловсруулах
- Төрийн үйлчилгээ ханган нийлүүлэгчийн загварыг боловсруулах
- Төсөл болон компаниудад хөрөнгө оруулах

PUK-ын ажлын албаны баг 80 орчим хүний бүрэлдхүүнтэй бөгөөд хувийн болон төрийн байгууллагын ажилтнууд багтдаг. Хувийн салбарын хөрөнгө оруулалтыг татах зорилгоор 2003 онд анхны хөрөнгө оруулалтын сан байгуулагдсан. Мөн Төслийн мэдээллийн сан, Үйл ажиллагааны туслалцааны нэгж, (Operationa Maskforce) болон хэрэгжиж буй төслүүдийн хэрэглэгчдийг дэмжих үүрэгтэй “Мэдээллийн технологийн харилцааны туслах төв” нээгджээ.

**Эрүүл мэндийн салбарт**

Энэ салбарт хийгдсэн ТХХТ шинэчлэлийн гол хөтөлбөр нь Үндэсний Эрүүл Мэндийн Үйлчилгээ (National Nealtn Services) ба өндөр зэрэглэлийн эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхэд

UIH.MN СУДАЛГААНЫ САН

үүрэг хүлээсэн улсын байгууллага юм. Энэхүү төсөл нь зүгээр нэг санхүүгийн хөрөнгө оруулалт бус хувийн салбарын менежмент, бизнесийн болон шинийг санаачлагч ур чадварыг эрүүл мэндийн үйлчилгээнд татан оролцуулах явдал бөгөөд D-B-F-O загварыг голдуу ашигладаг байна. Ингэснээр NHS нь, 25-40 жилийн хугацааны туршид жил бүр хувийн эзэмшлийн байгууламж болон тоног төхөөрөмжийг ашигласны төлөө төлбөр төлдөг. Мөн бүх төсөл нь мөнгөний үнэ цэнийг зарлага талдаа чухалчилсан байхыг NHS журмандаа зааж өгчээ.

**Боловсролын салбарт**

Энэ салбарт хийгдсэн ТХХТ-ийн томоохон төслийн нэг болох New Deal for Schools (NDS) нь тус улсын 220 сургуулийн PFI аргачлалын дор хувийн хэвшил нь сургуулийн барилга байгууламж болон тоног төхөөрөмжийг гэрээгээр нийлүүлэн үйл ажиллагааг нь хариуцаж, бизнесийн ашиг орлого бий болгох чадвартайгаар орон нутгийн боловсролын байгууллага болон сургуультай хамтарч ажилладаг байна.

**Батлан хамгаалах салбарт**

Их Британийн ТХХТ-ийн түүхэн дэх хамгийн том төсөлд тус улсын Батлан Хамгаалах яамны захиалгаар ундны усны хангамж, хөрсний ус болон муу ус цэвэршүүлэх байгууламжийн актив хөрөнгийн ашиглалт, үйл ажиллагааг 25 жилийн хугацаатай хэрэгжүүлэх хувийн хэвшлийн 3 ханган нийлүүлэгчийн хамтарсан нэгдлээр гүйцэтгүүлэх хоёр тэрбум фунт стерлингийн өртөг бүхий Акватрины төсөл тооцогдож байгаа юм. Ингэснээр Батлан хамгаалах яам стратегийн бус үйл ажиллагааг аутсорсинг хийснээр зөвхөн үр ашигтай хэрэглээ, бага зардалтай худалдан авалт болон мөнгөний үнэ цэнийг бий болгож, хүрээлэн буй орчны зорилт, тулгамдсан асуудлыг давхар шийдсэн байна.

**Төрийн үйлчилгээний стандарт (Public Service Standards) 2007-2008**

Энэ стандартын гол зорилго нь хэрэглэгчдэд чанартай сайн үйлчилгээ хүргэх болон гүйцэтгэлийг нарийн тогтоох, зорилтот бүлэг болон стандартын дагуу байгаа эсэхэд хяналт тавьж, үйл ажиллагааг зохицуулдаг.

Түүнчлэн 2007-2008 онд хувь хүний зорилтот бүлэг нь ажлын хүрээнээс ангид тусад нь байлгах ба үндсэн бүрдүүлэгч гол ажлаас салангид авч үздэг. Хэрэглэгч дөрвөн долоо хоногоос багагүй хугацаанд түр зогсоох мэдээллийг өгч болно. Мэдээллийн Эрх чөлөөний тухай болон Мэдээлэл Хамгаалах эсвэл Мэдээллийн Зохицуулалтын тухай хуулиудын дагуу нууц биш бол 98,5 хувь нь захидал бичиж бичгээр хариуг ажлын 10 хоногийн дотор өгнө.

Хуулиудын дагуу дараах хэлбэрээр хариуг өгч болно. Үүнд:

- Утсаар хариу өгөх: Шаардлагатай тохиолдолд нийт хэрэглэгчдийн 85 хувь нь 20 секундын дотор холбогдох албан тушаалтантай холбогдож мэдээлэх боломжийг бүрдүүлэх;
- Хэрэглэгчийн сэтгэл хангамж: Хэрэглэгчийн сэтгэл хангамж нь 90 хувь дээр нь нэмэх ба утасны үйлчилгээнд 80 хувь дээр нь нэмэх байна;
- Үйлчилгээний ашигтай үйлчилгээ: Ажлын өдөр үйлчилгээний хугацаанд бизнес систем нь 99 хувь ашигтай гол түлхүүр бөгөөд онлайны түлхүүр үйлчилгээ нь 99 хувь нь ашигтай байдаг;
- Уншлагын танхимд хэрэглэгчдэд зориулсан бичлэг үзүүлэх ба цаг гаргах: Хэрэглэгчдэд зориулсан уншлагын танхимд 35 минут бичлэг үзүүлэх;
- Бичлэгийн хуулбар хийх хурд болон чанар: Тусгайлсан зорилтот бүлэгт захиалгын дагуу бичлэгийг хуулан нийлүүлэх хувь 98,5 байдаг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Үүнд дараах стандартыг дагаж мөрдөнө.

- Хар болон цагаанаар хуулах фото хуулбар:
  - *200 хувь байвал ажлын 9 өдөрт;*
  - *201-500 хувь бол ажлын 14 өдөрт;*
- Хэвлэх болон микрофильм эсвэл цахим шууданг орлуулагч:
  - *200 хувь бол ажлын 7 өдөрт;*
  - *201-500 хувь бол ажлын 14 өдөрт;*
- Дижитал скайнераас хар, цагаан болон өнгөт хэвлэл хийх:
  - *20 хувь б*ол ажлын 14 өдөрт Электрон хувь*;*
  - файл нь 20 хүртэл электрон шуудангаар ажлын 14 хоногт мөн нэмж 1 өдөрт нь *CD-ROM-д бичнэ;*
  - Файлуудыг дижиталаар бол ажлын 1 өдөрт*;*
- Микрофильм буюу бичлэг хийх эсвэл хуулбар хийх:
  - бичлэг болон хуулбар хийхэд хэрвээ 1,000 метр урттай бичлэг эсвэл 100 хуулбар ажлын 15 өдөрт*;*
  - гэрчилгээ хувилах бол ажлын 2 өдөрт багтаан хийх.

Үндэсний Архивт хэрэглэгчид шинэ, нээлттэй цаг гаргах ба түүний тодорхойлолт, ангилал гаргуулах эрх авах 2000 оны Мэдээллийн Эрх Чөлөөний хуулийн дор санал гаргасны дагуу үр дүнг шалгах ба олон нийтэд нээлттэй байх Үндэсний Архивын газарт нэмэлт хийх

- Өөрийнх нь хүсэлт ёсоор Хувь хүний тухай мэдээллийг Мэдээллийн Эрх чөлөөний хуулийн дагуу 30 хоногийн дотор 100 хувь гаргаж өгөх;
- Үндэсний Архивын шилжүүлэг нээлттэй бол хувь хүний мэдээллийг хүсэлт хүлээж авснаас хойш ажлын 15 өдөрт гаргаж өгнө;
- Үндэсний Архивт шилжүүлсэн баримт бичиг хуулбараас тэмдэглэлийн 80 хувийг ажлын 60 хоногт гаргаж өгнө.

Үндэсний Архивын газар нь хүртээмжтэй үйлчлэх ба Мэдээллийн Эрх чөлөөний дагуу нээлттэй, чөлөөтэй байх нь 2007 оны 5 дугаар сараас хэрэгжсэн байна.

Энэ бүхнээс дүгнэж үзэхэд:

1. Их Британи улс нь төр хувийн хэвшлийн харилцааг XYIII зууны үеэс янз бүрийн хэлбэрээр хэрэгжүүлж ирсэн түүхтэй. 51 хувь нь хувийн салбарын пүүс компанууд, үлдсэн 49 хувийн хувьцааг Сангийн Яам (HM Treasury) болон Scottish Executive эзэмшдэг байна.
   - Цогц худалдан авалтын төслүүдийг дэмжих;
   - Хөрөнгө оруулалтын болон худалдан авалтын бодлогыг хөгжүүлэх;
   - Бие даасан дэд бүтцийн төслүүдийг боловсруулах;
   - Төрийн үйлчилгээ ханган нийлүүлэгчийн загварыг боловсруулах;
   - Төсөл болон компануудад хөрөнгө оруулах зэрэг;

2. Их Британи Түншлэл (Partnerships UK-PUK) байгууллага нь улсын салбарт гагцхүү дээрх 5 үндсэн салбарт ажлаа явуулдаг байна.
3. Эрүүл мэндийн, Боловсролын, Батлан хамгаалахын салбаруудад тоног төхөөрөмжүүдийг гэрээгээр нийлүүлэн үйл ажиллагааг нь хариуцах болон D-B-F-O загварыг голдуу ашиглан 25-40 жилийн хугацааны туршид жил бүр хувийн эзэмшлийг ашигласны төлөө төлбөр төлдөг байсан төдийгүй аутсорсинг хийснээр үр ашигтай хэрэглээ, бага зардалтай худалдан авалт болон мөнгөний үнэ цэнийг бий болгож тулгамдсан асуудлыг давхар шийдсэн.

4. Төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилготой **Public Servises Ombudsman** байгууллагыг ажиллуулдаг төдийгүй мөн хэрэглэгчдэд чанартай түргэн шуурхай сайн үйлчилгээ үзүүлэхийн тулд тодорхой стандартуудыг мөрддөг.

### 3.3. КАНАД УЛС

Канад нь арван муж, гурван нутаг дэвсгэрээс тогтсон холбооны улс бөгөөд парламентын засаглалтай ардчилсан, үндсэн хуульт хаант улс юм. Төрийн тэргүүн нь Хатан хаан II Элизабет. Англи, Франц гэсэн албан ёсны хоёр хэлтэй бөгөөд олон үндэстэн угсаатан амьдардаг. Канад нь технологийн хувьд хөгжсөн, аж үйлдвэржсэн орон бөгөөд байгалийн баялаг, нарийн төвөгтэй харилцаатай орон болох АНУ-тай хийдэг худалдаан дээрээ тулгуурласан эдийн засагтай.

Канад улс нь Төр хувийн хэвшлийн түншлэлийг 1988 оноос эхлэн өнөөг хүртэл амжилттай хэрэгжүүлж байгаа орны нэг юм. 2000 оноос эхлэн ТХХТ-ийн үйл ажиллагаа өргөн далайцтай эрчимтэйгээр хөгжиж, орон нутгийн шинж чанартай хөтөлбөрүүд нь ихэнх тохиолдолд Барих-санхүүжүүлэх болон Төсөл санаачлах-барих-санхүүжүүлэх-ажиллуулах загвараар хэрэгжиж байна.

Канадын ТХХТ-ийн Үндэсний зөвлөл (1998) ТХХТ-ийг төрийн болон хувийн хэвшлийн хооронд бие биенийхээ экспертиз дээр суурилсан, нөөцийн, эрсдэлийн ба ашгийн зохистой хуваарилалтаар дамжуулан олон нийтийн хэрэгцээг хамгийн сайнаар хангах хамтарсан нэгдэл гэж тодорхойлдог байна. Үндэсний зөвлөл нь гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг жинхэнэ ТХХТ гэж үздэггүй. Канад улсад ТХХТ нь амжилттайгаар хэрэгжиж буй үндсэн хүчин зүйл нь:

- Олон улсын сонирхогч талыг татан оролцуулсан;
- Хувийн салбарын хөрөнгө босгох бололцоо өндөр (тэтгэврийн сан, даатгалын сан, хувийн хөрөнгө);
- Засгийн газрын (нам бус) болон олон нийтийн дэмжлэг нэн өсч буй;
- Төрийн салбар дахь холбоодын эерэг хандлага, эсэргүүцэл багассан байдал;
- Дээд түвшний улс төрийн хатуу манлайлал зэрэг байна.

ТХХТ дэд бүтцийг шинэчлэхэд нэн хэрэгцээтэй арга болох хувийн хэвшлийн оролцоог Канадын иргэдийн дунд явуулсан судалгаагаар 88 хувь нь дэмжиж, дэд бүтцийн салбарын эрэлт хэрэгцээг Засгийн газар дангаараа хангаж гүйцэтгэх чадвар дутмаг байгааг дүгнэж, мөн 63 хувь нь хувийн хэвшил бүрэн байдлаар оролцох цаг нь болсон гэсэн дүгнэлт гарчээ. Үүний үндсэн дээр Канадын засгийн газар ТХХТ-ийг идэвхтэйгээр дэмжин ажиллаж байна. Энэхүү дэмжлэг нь дараах үр дүнд хүрээд байна:

- дэд бүтцийн салбарын хөгжлийн зогсонги байдлыг шийдвэрлэсэн;
- төсөл, хөтөлбөрүүд гэрээнд заасан цаг хугацаа болон тогтоосон төсөвтөө багтан хийгддэг болсон;
- эрсдлийг үлэмж хэмжээгээр хувийн хэвшилд шилжүүлсэн;
- байгууламжийн ашиглалын хугацааны зардал төсөвдөө багтдаг болсон;
- удаан хугацааны гүйцэтгэлийн чиг баримжаатай ажиллах болсон;
- хөрөнгө ашиглалтын болон үнэ цэнийг дээшлүүлсэн;
- засгийн газар өөрийн үндсэн чиг үүрэгтээ анхаарах боломж илүү болсон зэрэг юм.

Канадын Төр хувийн хэвшлийн түншлэлийн үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа нь дараах салбаруудад хуваагдан үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлж байна.

- эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээ;
- сургууль;
- тээврийн харилцаа;
- цэвэр болон бохир ус гэсэн салбаруудад хувийн салбарын оролцоо хамгийн их

UIH.MN СУДАЛГААНЫ САН

байдаг байна. Өөрөөр хэлбэл төрийн зарим чиг үүргийг хувийн салбарын холбоо, нэгдлүүдээр гүйцэтгүүлж байна.

Канад улсад хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн хугацааг харахад урт хугацаатай байдаг бөгөөд хамгийн багадаа 25 жил болон түүнээс дээш хугацаатайгаар хэрэгжсэн байна. Үүнийг салбараар нь авч үзвэл:

- Эмнэлэгийн салбар-30 жил
- Сургууль-30 жил
- Зам байгуулах-30 жилийн хугацаатай төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

**Хууль эрх зүйн орчин**

Хууль эрх зүйн хувьд Канадын холбооны хууль болон мужийн хуулиудаар зохицуулагддаг. Голлох хуулиудад:

1. Канадын стратегийн дэд бүтцийн санхүүгийн тухай хууль (Canada Strategic Infrastructure Fund Act, 2002)-д стратегийн дэд бүтцийг тодорхойлж өгсөн. Үүнд:
    - авто зам болон төмөр зам;
    - орон нутгийн тээврийн харилцаа;
    - аялал жуулчлал болон хотын хөгжил;
    - бохир ус цэвэршүүлэх;
    - цэвэр ус салбарыг хуульчилсан байна.

   Энэхүү хуулиар хувийн хэвшлийг хэрхэн оролцуулах болон гэрээ байгуулах талаар хуульчилсан байна. Төсөл хөтөлбөрийг шалгаруулах болон гэрээ байгуулах асуудлыг Канадын хатан хааны хувийн зөвлөлийн гишүүн сайд хариуцдаг.
2. Төрийн үйлчилгээг өөрчлөх болон үүргийг шилжүүлэх тухай акт (Public service rearrangement and transfer of duties act) нь 1985 онд батлагдсан. Хуулийн P-34 дугаар бүлэгт Холбооны төрийн захиргааны байгууллагын сайд нь өөр сайдад, нэг хэлтсээс нөгөө хэлтэст, төрийн захиргааны байгууллагаас нөгөөд гүйцэтгэх үүрэг, удирдлага, хяналтын үүргээ бүрэн шилжүүлэх мөн нэг сайд болон шадар сайдад хамаарах 2 болон түүнээс дээш хэлтсийн үүргийг нэгдэл холбоонд шилжүүлэх тухай зохицуулсан байна.
3. Зам тээвэр, дэд бүтцийн түншлэлийн акт (Act respecting transport infrastructure partnerships) – Хуулиар гэрээ байгуулахтай холбогдсон бүхий л харилцааг зохицуулж өгсөн бөгөөд гэрээг дараах байдлаар тодорхойлсон байна. Түншлэлийн гэрээ гэж барилга байгууламж болон дэд бүтэц, зам тээврийн ажил болон завсар үйлчилгээ үзүүлэх зорилгоор Засгийн газар болон хувийн хэвшлийн хооронд түншлэлийн урт хугацааны хүсэлт гаргахыг хэлнэ. Гэрээнд оролцогч нь Засгийн газар болон сайд, эсвэл хотын захиргаа байж болно гэж заасан байна. Мөн түүнчлэн хуулинд төсөл хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт болон гэрээнд өөрчлөлт оруулах, эзэмшил, хариуцлагын талаар зохицуулсан байна.
    - Төрийн үйлчилгээний тухай хууль (Public service act, 1996);
    - Усны тухай хууль (Canadian Water law);
    - Тээврийн тухай хууль (Canadian transportation act, 1996);
    - Зам тээврийн хөрөнгө оруулалтын тухай хууль (Transportation investment act-British Columbia, 1996);
    - **Авто замын хууль** (Highway Act, 1998)

   Канад нь гадаадын хөрөнгө оруулагчидтай зарим томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ Концессийн гэрээ байгуулан ажилладаг байна. Дэ Чо гүүрийг концессийн гэрээ байгуулсан байна.

Канад улсад төрийн зарим чиг үүргийг гэрээгээр болон хуулийн дагуу шилжүүлэн хэрэгжүүлдэг мэргэжлийн холбоод байдаг бөгөөд тэдгээр холбоод нь тухай салбарын харилцааг удирдах, зохицуулах, хяналт тавих бүхий л харилцааг хууль болон дүрэм, журмаар зохицуулдаг байна.

Канадын Үндсэн хуулийн эрх, эрх чөлөөний тунхаглал, радио нэвтрүүлгийн тухай хууль, Радиогийн журам, Телевиз радиогийн журам зэрэг эрх зүйн баримт бичгүүдээр зохицуулдаг байна.

Канадын радио нэвтрүүлгийн стандартын зөвлөл (Canadian Broadcast Standards Council, CBSC) нь Канадын хувийн салбарын нэвтрүүлэгчдийн өөрөө өөрийгөө зохицуулах байгууллага юм. Тус зөвлөл нь 1990 онд байгуулагдсан. Зөвлөл нь Канадын 730 радио телевизийн станц болон 2 телевизийн сүлжээг багтаасан байгууллага юм. Программ нь англи, франц болон гуравдагч хэл дээр нэвтрүүлдэг ба Канадын нэвтрүүлэгчдийн холбооны гишүүн нэвтрүүлэгч 96 хувь байдаг.

Зөвлөл нь хэд хэдэн дүрэм журам (code)-ыг гарган мөрдүүлж байгаа бөгөөд тухайлбал: секс дүрийг дүрслэх журам (sex role portrayal code), хүчирхийлэлийн журам (violence code), ёс зүйн дүрэм (code of ethics), мөн радио телевизийн нэвтрүүлэгчдийн ёс зүйн дүрэм, радио телевизийн нэвтрүүлгийн программийн үнийн журам, сэтгүүлчийн ёс зүйн дүрэм гэх мэт дүрэм журмуудаар зохицуулагддаг байна.

Мөн үзэгч сонсогчдийн зүгээс нэвтрүүлэгтэй холбоотой санал хүсэлт, нэвтрүүлэгчдийн талаарх гомдолоо зөвлөлд гаргах бөгөөд зөвлөл уг асуудлыг 14 хоногт хариу өгдөг байна. Энэ нь нэврүүлэгчдийн хариуцлагын түвшин өсөхөд ихээхэн нөлөөлж байна гэж Зөвлөлийн олон нийтийн хэлэлцүүлгийн илтгэлд дурдсан байна. Энэхүү зөвлөл нь жил бүр олон нийтэд илтгэл тайлангаа тавьж хэлэлцүүлдэг байна.

Мөн түүнчлэн хүүхдийн нэвтрүүлгийн стандарт, бусдыг доромжилсон нэвтрүүлгийн, хүчирхийлэлийн гэх мэтчилсэн нилээд олон стандартуудыг зөвлөлөөс батлан гаргаж мөрдүүлж байна.

### 3.4. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

АНУ нь дэлхийн хамгийн том, технологийн хувьд хөгжсөн хүчирхэг эдийн засагтай орон юм. Тус улсын зах зээлийн эдийн засгийн тогтолцооны дагуу хувийн бизнес давамгайлах үүрэгтэй бөгөөд холбооны болон төрийн байгууллагууд шаардлагатай бараа, үйлчилгээг эдгээр хувийн үйлдвэрлэгчээс худалдан авдаг системтэй байна. Баруун Европ, Японы аж үйлдвэрлэгчидтэй харьцуулбал америкийн бизнес эрхлэгчид нь капитал болон үйл ажиллагааны хэмжээг өргөжүүлэх, ажиллах хүч нэмэгдүүлэх, шинэ бараа бүтээгдэхүүн боловсруулахад давуу талтай байна. АНУ-ын компаниуд нь компьютер, анагаах ухаан, сансар судлал, батлан хамгаалах зэрэг салбарын тоног төхөөрөмж боловсруулалтаараа дэлхийд тэргүүлдэг байна.

АНУ-д дэд бүтцийг ханган нийлүүлэхэд хувийн салбарын оролцоо бусад орнуудтай харьцуулахад харьцангуй голлох байр суурь эзэлж байна. Холбооны мужийн болон орон нутгийн засаг захиргааны нэгжийн хэмжээнд дараах ажил үүргүүдийг гэрээгээр гүйцэтгүүлдэг байна. Тухайлбал:

1. цэвэр болон бохир ус;
2. хог хаягдалын үйлчилгээ;
3. нийтийн аж ахуйн үйлчилгээ;

4. барилгын засвар үйлчилгээ;
5. хууль эрх зүйн зөвлөгөө;
6. архитектур ба инженерийн үйлчилгээ;
7. түргэн тусламжийн үйлчилгээ;
8. барилга, байгууламжийн менежментийн удирдлага ба ашиглалт гэх мэт

Мөн хувийн хэвшил дангаараа эсхүл улсын салбартай хамтарсан хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн төлбөрт авто замын барилгын ажлууд орно. Хувийн салбарын пүүс компаниуд бас нийгмийн салбар болох сургууль, халамжийн үйлчилгэний хөтөлбөр, хотын дотоод хөгжлийн дахин сайжруулалт болон төрийн барилга байшин барих зэрэг ажил үүргийг Төр хувийн хэвшлийн түншлэлийн зохицуулалтаар хийдэг. Төрөөс нийгмийн өмнө хүлээх хариуцлагаа биелүүлэх, түүнийг хэрэгжүүлэхэд хэдэн зуун мянган улсын орон сууцыг ч мөн ТХХТ-ийн санхүүжилтээр барьжээ.

АНУ-д ТХХТ-ийн нэгдсэн бодлого зохицуулалтыг хангах үүрэг бүхий төрийн байгууллага байдаггүй хэдий ч, төр хувийн хэвшлийн салбарын хамтын ажиллгааг дэмжих зорилго бүхий Үндэсний ТХХТ-ийн зөвлөл хэмээх ашгийн бөгөөд нам бус байгууллага 1985 онд байгуулагдсанаар түншлэлийн хүрээнд шинэлэг санаа дэвшүүлэх, түүнийгээ бодит ажил хэрэг болгоход чиглэсэн хувийн болон улсын салбарын гишүүнчлэлтэйгээр үйл ажиллагаа явуулдаг. Үндэсний зөвлөл нь дэргэдээ Эрчим хүчний институт, Олон улсын институт, Үл хөдлөх хөрөнгийн институт, Тээврийн институт болон Усны институтай.

**Хууль, эрх зүйн орчин**

АНУ-ын хувьд Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн үйлчилгээний тухай хууль болон бусад салбарын хуулиудаар зохицуулагддаг байна.
Харин өөрөө өөрийгөө зохицуулагч байгууллагуудын хувьд Канадаас нилээд туршлага солилцож эрчимтэй хөгжүүлж байгаа улсуудын нэг юм. Тухайлбал: АНУ-ын хувьд мэргэжлийн томоохон холбоо, нэгдлүүдээр болон өөрөө өөрийгөө зохицуулагч холбоодоор энэхүү үүргийг гүйцэтгүүлдэг жишиг байдаг байна.

**Олон улсын үнэт цаасны хороо – IOSCO**

Олон улсын үнэт цаасны хороо нь АНУ-ын үнэт цаасны зах зээлд томоохон байр эзэлдэг байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан дүрэм, журмаар зохицуулдаг байна. Олон улсын үнэт цаасны хорооны үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлж дүгнэх аргачлал, арга зүйг баталсан бөгөөд уг дүрмийн 6-д “Өөрөө өөрийгөө зохицуулахад хамаарах зарчим (Principles relating to Self-Regulation)-уудыг тодорхойлж зохицуулсан байна. Өөрөө өөрийгөө зохицуулагч энэхүү байгууллага нь бүхий л үйл ажиллагаагаа дүрмийн хүрээнд удирдан зохион байгуулах болон хянах, зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Энэхүү дүрмээр хороо нь хууль болон дүрмэнд заасны дагуу төрийн зарим чиг үүргийг шилжүүлэх талаар нарийн зааж өгсөн байдаг байна.

Өөрөө өөрийгөө зохицуулах байгууллага нь дараах ач холбогдолтой:

- Өөрөө өөрийгөө зохицуулах байгууллага нь төрийн хууль тогтоомж болон өөрөө өөрийгөө зохицуулах байгууллагын дүрэм журмыг хэрэгжүүлэхэд болон хууль, болон бусад эрх зүйн актын зорилгуудыг биелүүлэх
- Тохируулагчийн алдаа гаргах боломжийг багасгадаг
- Зохицуулах харилцаануудын бүхэлд нь хамарч чаддаг байна.

UIT.MN СУДАЛГААНЫ САН

Өөрөө өөрийгөө зохицуулагч байгууллага нь:

- Хууль тогтоомж болон өөрөө өөрийгөө зохицуулагч байгууллагын дүрэм журмыг холбоо, түүний гишүүд биелүүлэх чадвартай байх
- Өөрөө өөрийгөө зохицуулагч байгууллагын гишүүд болон гишүүнээр элсэхээр өргөдөл гаргагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах чадвартай байх
- Төслийн хөрөнгө оруулагчийн болон гишүүдийн баримтлах стандарт, журмуудыг боловсруулах
- Зохицуулагч нь өөрөө өөрийгөө зохицуулагч байгууллагын журам, бодлогын зааврууд болон хамтран ажиллагчийн дүрмэнд захирагдах ёстой.
- Дүрэм зөрчигчид хариуцлага хүлээлгэх
- Удирдах албан тушаалтан болон удирдах зөвлөлийг сонгоход гишүүдийн төлөөллийг тэгш оролцуулах зэрэг шалгуур үзүүлэлтийг хангасан байх ёстой.

## 3.5. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

ОХУ-д төрийн захиргааны шинэчлэлийг улсынхаа нийгэм эдийн засгийн хөгжлийг шинэ шатанд гаргах чухал нөхцлүүдийн нэг гэж үздэг. Энэ шинэчлэл хэд хэдэн үе шаттайгаар явагдаж байна. Үүнд, нэгдүгээр үе – 1992-1993 он, хоёрдугаар үе – 1996-1998, гуравдугаар үе – 1999-2000, дөрөвдүгээр үе – 2001-2003, тавдугаар үе – 2005 оноос эхлэсэн.

### Бодлого, хууль эрх зүйн орчин

- Хууль эрх зүй: “Оросын Холбооны Улсын Үндсэн хууль” (1993), “Оросын Холбооны Улсын субъектүүдийн төрийн хууль тогтоох болон гүйцэтгэх байгууллагуудын зохион байгуулалтын үндсэн зарчмуудын тухай” (1999), “Оросын Холбооны Улсын нутгийн өөрөө удирдах байгууллагуудын зохион байгуулалтын үндсэн зарчмуудын тухай” (2004), “Өөрөө өөрийгөө зохицуулах байгууллагын тухай” (2007), “Төрийн үйлчилгээний стандартын тухай” хуулийн төсөл ” (2007).
- Бодлогын баримт бичиг: “Захиргааны шинэчлэл 2005-2010” Үндэсний Хөтөлбөр“, “Оросын Холбооны Улсын төрийн албаны шинэчлэл” Холбооны хөтөлбөр (2003-2005), “Оросын Холбооны Улсын төрийн албаны шинэчлэл ба хөгжил” Холбооны хөтөлбөрт (2009-2013).

2003-2005 онуудад ОХУ-ын захиргааны шинэчлэлийг эрчимтэй хэрэгжүүлэх чухал шийдвэрүүд гарсан байна. ОХУ-ын Ерөнхийлөгчийн ОХУ-ын Холбооны Хуралд явуулсан 2003 оны Илгээлтэд улс орны эдийн засгийн шинэчлэл, өөрчлөлтөнд саад болж буй хүчин зүйлүүдийн нэг нь төрийн аппаратын үйл ажиллагааны үр ашиг хангалтгүй байгаа болон эрх мэдлийн хэмжээндээ чанар нь хүрэхгүй байгаа байдал гэж тодорхойлжээ[12].

ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2003 оны 7 дугаар сарын 23-ны N 824 **“2003-2004 онуудад захиргааны шинэчлэл хийх арга хэмжээний тухай”** зарлигт захиргааны шинэчлэлийн тэргүүлэх чиглэлүүдийг заасан. Үүнд:

- Үйлдвэрлэл эрхлэгч субъектүүдийн эдийн засгийн үйл ажиллагаанд төрийн оролцоог хязгаарлах, түүний дотор төрийн илүүдсэн зохицуулалтыг багасгах;
- Холбооны гүйцэтгэх байгууллагуудын давхардсан үүрэг, эрх мэдлийг хасах;
- Эдийн засгийн салбарт өөрөө өөрийгөө зохицуулагч байгууллагуудын тогтолцоог хөгжүүлэх;
- Эдийн засгийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, төрийн өмчийг удирдах, иргэд, хуулийн этгээдэд төрийн байгууллагаас үйлчилгээ үзүүлэх үүргийг зохион байгуулалтын хувьд хуваах, цэгцлэх зэрэг болно.

[12]Послание Президента Федеральному Собранию Российской Федерации 2003. www.kremlin.ru

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Эдгээр зорилтыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах үүргийг захиргааны шинэчлэлийг хэрэгжүүлэх Засгийн газрын Комисс хүлээжээ.

Түүнчлэн 2005-2010 онд хэрэгжүүлэх **“Захиргааны шинэчлэл”**-ийн зорилтот хөтөлбөрийн үзэл баримтлал батлагдан гарч, түүнийг хэрэгжүүлж эхэлсэн нь улсын салбарын шинэчлэлийг эрчимжүүлэхэд их түлхэц болжээ.

“Захиргааны шинэчлэл”-ийн үзэл баримтлалд төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд гүйцэтгэлд үндэслэсэн үнэлгээ, төрийн болон орон нутгийн үйлчилгээний стандартыг нэвтрүүлэх, захиргааны болон электрон захиргааны журмыг боловсруулж, нэвтрүүлэх, төрийн болон орон нутгийн хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тогтолцооны үр ашгийг дээшлүүлэх, авилгын эрсдэл бүхий салбарын удирдлагыг боловсронгуй болгох онцгой механизмыг бий болгож, хэрэгжүүлэх, захиргааны хэргийн шүүх, эрх зүйн механизмыг боловсронгуй болгох, гүйцэтгэх засаглалын эрх мэдэл, чиг үүргийн давхардлыг арилгах үйл ажиллагааг дуусгах, захиргаа-удирдлагын үйл явцад аутсорсингийн тогтолцоог хөгжүүлэх, төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагын харилцааны үр дүн, тунгалаг байдлыг хангах зэрэг цогц арга хэмжээг тодорхойлсон байна.

Захиргааны шинэчлэлийн явцад хийгдсэн нэг чухал арга хэмжээ бол захиргааны байгууллагын хэрэгжүүлж буй чиг үүргийг шинжилж, ангилах ажил байжээ. Энэ үйл ажиллагааны дүнд агуулгыг нь шинээр тодорхойлох, аль эсхүл бүр мөсөн хүчингүй болгох, эсхүл өөрөө өөрийгөө зохицуулах байгууллагад шилжүүлэх шаардлагатай бүлэг чиг үүргийг тодруулсан байна. Засгийн газрын комиссоос захиргааны шинэчлэлийг хэрэгжүүлсэн ажлын хүрээнд нийт 5634 чиг үүргийг шинжилж дүгнэлт хийснээс 1468 нь илүүдэл, 263 нь давхардсан, 868 нь өөрчлөх чиг үүрэг байжээ[13].

Мөн 2002 онд ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан “Оросын Холбооны Улсын төрийн албаны шинэчлэл” Холбооны хөтөлбөрт (2003-2005) дэвшүүлсэн төрийн албаны шинэчлэлийн нэг чухал чиглэл нь дэлхийн стандартад нийцсэн төрийн цогц үйлчилгээг бий болгох явдал юм. Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр төрийн албан хаагчид албан үүргээ чанартай сайн гүйцэтгэж иргэд, байгууллагт үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлсэн үр дүн гарна гэдгийг тодорхойлжээ[14].

ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2009 оны № 261 зарлигаар батлагдсан **“Оросын Холбооны Улсын төрийн албаны шинэчлэл ба хөгжил”** Холбооны хөтөлбөрт (2009-2013) төрийн албаны шинэчлэлийг хэрэгжүүлж дуусган, ОХУ-ын төрийн албаны нэгдсэн тогтолцоог бий болгон, төрийн албаны өндөр мэргэшсэн боловсон хүчнийг бүрдүүлж, төрийн удирдлагын үр ашиг, инновацит эдийн засаг, иргэний нийгмийн хөгжлийг хангах зорилго дэвшүүлжээ[15].

Түүнчлэн ОХУ-ын төрийн захиргааны шинэчлэлийн хүрээнд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, зарим чиг үүргийг төрийн бус салбарт шилжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгдсэн зарим хууль батлагдаж, зарим хуулийн төслүүд боловсруулагдсан байна. Тухайлбал, 2007 онд **“Өөрөө өөрийгөө зохицуулах байгууллагын тухай”** (Федеральный закон “О саморегулируемых организациях”) Холбооны хууль батлагдсан, гүйцэтгэх засаглалын байгууллагын захиргааны журмын тухай, төрийн үйлчилгээний стандартын тухай, санхүүгийн аудит болон үнэлгээний салбарын төрийн үйл ажиллагааг өөрийгөө зохицуулах байгууллагуудад шилжүүлэх тухай холбооны хуулиудын төсөл боловсруулагдаж, холбооны түвшний төрийн үйлчилгээний жагсаалт, стандартыг боловсруулах ажил хийгдэж байгаа юм.

[13]Концепции административной реформы в РФ в 2006-2010 годах. www.adm.yar.ru
[14]Федеральная программа “Реформирование государственной службы службы Российской Федерации”. www.uk.mos.ru
[15]Федеральная программа “Реформирование и развитие государственной службы службы Российской Федерации”. www.rg.ru

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Дээрх бодлогын баримт бичгүүдэд тодорхойлогдсон төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилтын хүрээнд ОХУ-ын субъектүүдэд төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, тухайлбал, төрийн үйлчилгээг аутсорсингоор гүйцэтгүүлэх хэлбэр амжилттай хэрэгжиж, энэ асуудалд онцгой анхаарал хандуулж байна.

Жишээ нь, ОХУ-ын Пенза мужийн Засгийн газар 2008 онд **“Пенза мужийн төрийн гүйцэтгэх байгууллагууд аутсорсингийг хэрэглэх тухай”**[16] № 274 **дугаар тогтоолыг баталсан ба түүнд** аль нэг чиг үүргийг шилжүүлэн аутсорсингоор гүйцэтгүүлэх нь оновчтой эсэхийг эрх бүхий албан тушаалтан тодорхойлох (тухайлбал, Пенза мужийн Засгийн газрын орлогч дарга) ба аутсорсингоор гүйцэтгүүлэх үйл ажиллагааны жагсаалт гаргах, төрийн гүйцэтгэх байгууллагын зарим үүргийг аутсорсингоор гүйцэтгүүлэх дүрэм боловсруулж батлуулахыг заажээ.

Түүнчлэн энэ ажлын хүрээнд төрийн байгууллагын чиг үүргийн байдалд анализ (аудит) хийх, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагааны төрөлд анализ хийх, тодорхой шалгуурын дагуу аутсорсингоор хийлгэх үйл ажиллагааны төрөл, хугацааг тодорхойлох шаардлагатай байдаг.

ОХУ-ын субъектуудын төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага аутсорсингоор зарим чиг үүргийг гүйцэтгүүлэхдээ дараах үндсэн хүчин зүйлүүдийг тооцож оноогоор үнэлдэг байна. Үүнд:

- Тухайн чиг үүргийн аль ангилалд хамаарч буй байдал (үндсэн эсхүл туслах) 1-5 оноо;
- Нөөцийн хүчин зүйл (боловсон хүчний болон санхүүгийн) 1-5 оноо;
- Үнэ, өртөгийн хүчин зүйл (тухайн үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгө, санхүүгийн тооцоо) 1-3-5 оноо;
- Цаг хугацааны хүчин зүйл;
- Чанарын асуудал, 1-3 оноо;
- Хязгаарлалтын хүчин зүйл (тухайн чиг үүргийг гүйцэтгэх эрх зүйн зохицуулатыг харгалзах) 1-5 оноо, зэрэг болно.

Дээрхи хүчин зүйл бүрийг оноогоор тооцон 6 хүчин зүйлээр нийт 18 онооноос доош үнэлгээ авсан тохиолдолд тухайн чиг үүргийг аутсорсингоор гүйцэтгүүлэхээр шилжүүлдэг байна.

Ийнхүү ОХУ-д захиргааны шинэчлэлийн хүрээнд төрийн үйлчилгээний үр ашиг, хүртээмжийг дээшлүүлэх, төрийн үйлчилгээний стандартыг нэвтрүүлэх, төр иргэний нийгмийн харилцааг шинэ түвшинд гаргах үйл ажиллагаа амжилттай хийгдэж байна.

## IV. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсад 1992 онд шинэ Үндсэн хууль батлагдснаар засгийн бүх эрх ард түмний мэдэлд байхыг, мөн хүний эрх, эрх чөлөөг хуульчлан баталгаажуулсан билээ. Энэ нь төр болон иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллага хоорондын түншлэл хэрэгжих эхлэл болсон юм.

Манай улсад сүүлийн 20 жилийн хугацаанд иргэний нийгмийн байгууллагуудын хөгжил, төлөвшил улам сайжирч байгаа нь хөгжлийн чухал алхам юм. Төр нь иргэдийнхээ санал санаачлагыг бодлого, шийдвэрт тусгахыг чухалчилж, иргэний нийгэм төлөвшүүлэхийн төлөө анхааран ажиллаж байна.

[16]Постановление Правительства Пензенской обл.от 04.05.2008. №274 “Об использовании аутсорсинга исполнительными органами государственной власти Пензенской области”. www.regionz.ru

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Иймээс төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэд, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог хангах хууль эрх зүйн орчин хэр зэрэг бүрдсэн бэ гэдэг асуулт зайлшгүй гарч ирнэ.

УИХ-аас 2009 онд “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын баримт бичгийг, 2010 онд уг баримт бичгийн хүрээнд “Концессын тухай” хуулийг, мөн 2010 онд Засгийн газрын 352 дугаар тогтоолоор “Төрийн бус байгууллагад гэрээний үндсэн дээр хариуцуулан гүйцэтгүүлэх зөвшөөрлийн жагсаалт”-ыг батлан гаргажээ. Концессын тухай хууль гарснаар Монгол Улсын хэмжээнд төр ба хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх эрх зүйн суурь орчин бүрдсэн байна.

Иргэд, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоог бусад салбарын хууль тогтоомжид хэрхэн тусгасан талаар үзье.

**Эдийн засаг, төсвийн хүрээнд**

Сүүлийн жилүүдэд төсвийн шинэчлэлийн хүрээнд төсвийн харилцааг зохицуулдаг хуулиудад чухал өөрчлөлтүүд хийгдэж байна. Тухайлбал, Төсвийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Концессын тухай хуулиудад холбогдох журам, заавруудыг боловсруулан хэрэгжүүлж эхэлснээр төсвийн үйл явцад иргэд, олон нийтийн оролцоог хангах эрх зүйн зохицуулалт улам сайжирсан.

***Төсвийн тухай*** хуулийн 30 дугаар зүйлд төр ба хувийн хэвшлийн түншлэлийн талаар тусгайлан заасан байдаг. Хуулинд түншлэлийн дараах хэлбэрүүдийг тодорхойлжээ. Үүнд:
- төрийн үйлчилгээг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;
- концессын гэрээгээр гүйцэтгүүлэх.

Түншлэлийг дараах тохиолдолд хэрэгжүүлнэ:
- хувийн хэвшлийн эзэмшиж буй техник, технологи, үр ашигтай удирдлагын арга барилыг төрийн үйлчилгээнд нэвтрүүлэх;
- хувийн хэвшил дангаараа хэрэгжүүлэх боломжгүй, төрийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай төсөл, арга хэмжээг;
- төсөл, арга хэмжээ нь эдийн засгийн хувьд үр ашигтай нь техник, эдийн засгийн үндэслэлээр нотлогдсон байх.

Харин төсвийн санхүүжилтийн дутагдлыг нөхөх, төсвөөс төлөх төлбөрийг хойшлуулах зорилгоор түншлэлийг хэрэгжүүлэхийг хориглосон байна.

***Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай*** хуулинд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулах эрх зүйн цоо шинэ зохицуулалтыг оруулсан. Түүнчлэн өртөг нь 20 сая хүртэлх төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг иргэд, төрийн бус байгууллагын оролцоотойгоор зохион байгуулахаар хуульчилсан байна. Худалдан авах ажиллагаанд иргэдийн төлөөллийг оролцуулан сонгон шалгаруулалт явуулах бөгөөд тухайн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд иргэдийг өргөнөөр оролцуулах зарчмыг баримтлах болсон[17.]

[17]Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7› дугаар зүйл.

Худалдан авах ажиллагаатай холбоотой бусад журам, заавар, жишиг баримт бичгийг Сангийн Яамнаас батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 3 хууль, 13 журам заавар, 12 жишиг баримт бичгийг даган мөрдөж байна[18].

Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хороонд мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллийг заавал оролцуулах эрх зүйн нөхцөлийг бүрдүүлжээ. Мөн хувийн хэвшил болон мэргэжлийн төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах замаар захиалагчийн зүгээс явуулж буй худалдан авах ажиллагаа, гэрээний хэрэгжилт, чанарыг хянах, аудит хийлгэх зэрэг ажлыг гүйцэтгүүлэх боломжтой болсон.

***Барилгын тухай*** хуулийн 8 дугаар зүйлд барилгын тухай хууль тогтоомж, дүрэм, стандарт, эрх зүйн бусад баримт бичгийг боловсронгуй болгох, төрөөс үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх ажлыг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх зохицуулалт оруулсан байна.

Түүнчлэн, Засгийн газраас 2014 оны 8 сард барилга, хот байгуулалтын салбарын зарим ажлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх тухай асуудлыг хэлэлцэж тогтоол гаргахаар болжээ. Үүнд хот байгуулалтын баримт бичиг, зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох чиг үүргүүд орох юм[19].

**Нийгэм хамгаалал, эрүүл мэнд, боловсролын салбарт**

***Нийгмийн халамжийн тухай*** хуулийн 18 дугаар зүйлд олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээг сонгон шалгаруулж гэрээ хийсний үндсэн дээр иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага хүргэхээр хуульчилсан байна. Үүнд дараах үйлчилгээнүүдийг хамруулжээ:

- амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох авъяасыг дэмжих сургалт зохион байгуулах;
- зөвлөгөө өгөх;
- сэргээн засах үйлчилгээнд хамруулах;
- түр байрлуулан асрамжлах;
- өдрийн үйлчилгээнд хамруулах;
- гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах;
- иргэн түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх;
- гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;
- нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах.

Төрийн захиргааны байгууллага нь олон нийт болон төрийн бус байгууллагыг мэргэжил, арга зүйн туслалцаагаар хангах, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй[20].

ШИН MN СУДАЛГААНЫ САН

[18]http://www.e-procurement.mn/?lid=175&f=newpage&id=2&t=legis
[19]http://zasag.mn/news/view/6335
[20]Нийгмийн халамжийн тухай хууль, 25 дугаар зүйл

Түүнээс гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах болон ахмадуудын санаачлагын байгууллагуудад тодорхой ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх, санхүүжүүлэх боломжийг бүрдүүлэх талаар ***Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай, Ахмад настны нийгэм хамгааллын тухай*** хуулиудад тодорхой тусгажээ[21].

***Эрүүл мэндийн тухай*** хуулийн 4 дүгээр зүйлд өрхийн эмнэлэгийн үйлчилгээг гэрээгээр хүргүүлэх талаар, 13 дугаар зүйлд эрүүл мэндийн байгууллага нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дангаараа болон бусад аж ахуйн нэгж, байгууллага, олон нийт, иргэдтэй хамтран явуулах талаар тус тус хуульчилсан. Мөн эрүүл мэндийг хамгаалах, дэмжихэд төрийн бус байгууллагын оролцоог хангах талаар хуулийн 45 дугаар зүйлд тусгасан байна.

***Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай*** хуулийн 5, 6 дугаар зүйлд Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (*Эрүүл мэндийн яам*) нь эх нялхсын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран ажиллах талаар, мөн тэдгээр байгууллага болон эрүүл мэндийн ажилтан хүүхдийн хоол тэжээлийн талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах талаар хуульчилжээ.

Боловсролын салбарын ***Боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай*** хуулиудад төр, төрийн бус байгууллагын түншлэлийн талаар тодорхой зохицуулалтууд байхгүй. Харин боловсролын зарим баримт бичгүүдэд зарим нэг заалтуудыг оруулсан байна. Тухайлбал, БСШУЯамнаас (одоогийн БШУЯам) 2007 онд гаргасан ***"Бага насны хүүхдийн хөгжилд эцэг, эх, гэр бүл, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх талаар сургуулийн өмнөх боловсролын байгууллагаас баримтлах чиглэл"*** баримт бичигт эцэг эх, олон нийтийн байгууллагын оролцоог хангах олон асуудлыг тусгажээ.

***Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай*** хуулийн 6 дугаар зүйлд мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал хариуцсан байгууллага Үндэсний зөвлөлтөй байх талаар заасан байна. Зөвлөл нь төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд төр ба хувийн хэвшлийн тэнцүү оролцоог хангаж, тогтвортой ажиллах баталгааг бүрдүүлэх юм. Хуулийн 13 дугаар зүйлд яам болон холбогдох бусад байгууллагын хамтарсан шийдвэрээр үйлдвэр, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагыг сургалт-үйлдвэрлэл, дадлагын түшиц газар болгон ажиллуулж болох талаар тусгасан.

Түүнчлэн хуулийн 20 дугаар зүйлд мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн байгууллагын ажил олгогч, ажилтан, үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоо, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах чиглэлийг тодорхойлсон байна. Үүнд:

- мэргэжлийн боловсрол, сургалтын талаар төрийн бодлого боловсруулахад оролцох;
- сургалтын орчин, нөхцөлийг сайжруулах;
- мэргэжлийн хяналт шинжилгээний тогтолцоог бүрдүүлэх, сургалтын агуулга, стандарт боловсруулахад оролцох;
- үйлдвэрлэлийн сургалт, дадлагыг хамтран байгуулах;
- багш нарын мэргэжил дээшлүүлэх;
- мэргэжлийн шалгалт хамтран авах;
- төгсөгчийг ажлын байраар хангах;
- багш, инженер-техникийн ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх;
- үйлдвэрлэлийн техник, технологийг шинэчлэх, судалгаа, туршилт хамтран явуулах;
- бусад.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[21]Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хууль 6 дугаар зүйл, Ахмад настны нийгэм хамгааллын тухай хууль, 9 дүгээр зүйл.

**Байгаль орчин, уул уурхайн салбарт**

Байгаль орчны салбарын суурь хуулиуд 1990-ээд оны дундуур батлагдсан бөгөөд хуулиар байгаль орчныг хамгаалах бүх үүрэг, хариуцлагыг дан ганц төр хариуцдаг байв.

Уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж байгаа нь эдийн засгийг тэлж, улс орны хөгжилд хувь нэмрээ оруулж байгаа боловч хүрээлэн буй орчны байгаль сүйдэж, бохирдон доройтох сөрөг үр дагаврыг дагуулж байна. Нэгдүгээрт, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалах, байгаль орчныг хамгаалах асуудал хурцаар тавигдах болсон. Хоёрдугаарт, төрөөс бодлого боловсруулах, шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянах явцад иргэдээ оролцуулах, иргэдийн оролцоог хангах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай болсон.

Иймд 2008 оноос иргэдийн оролцоо, хяналтад тулгуурласан байгаль хамгааллыг хөгжүүлэх зорилгоор байгаль орчны салбарын хуулиудыг багцаар нь шинэчлэх ажлыг хийж эхэлсэн. Энэ ажлын хүрээнд 2012 онд байгаль орчны салбарт мөрдөж ирсэн 18 хуулийг илүү боловсронгуй 8 хууль болгон нэгтгэж, шинээр хоёр хууль нэмж баталсан юм. Эдгээр багц хуулийг баталснаар байгаль хамгаалах ажил цоо шинэ шатанд гарсан бөгөөд иргэд, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, байгаль орчны стратегийн үнэлгээ болон аудитын тогтолцоог шинээр нэвтрүүлэх, ногоон эдийн засгийн хөгжлийн үндсийг тавьсан эрх зүйн орчин бүрдсэн байна.

Байгаль хамгаалах асуудал дан ганц төрийн үүрэг бус орон нутгийн засаг захиргаа, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад ч хамаатай. Байгаль орчны багц хуулийн хүрээнд шат шатны төрийн байгууллага, удирдлагын үүрэг, хариуцлагыг илүү нарийн тодорхойлж чангатгаснаас гадна иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг, оролцоо, хүлээх хариуцлагыг тодорхой болгосон. Хамгаалахын зэрэгцээ байгалийн баялаг, хүрээлэн буй орчныг зүй зохистой ашиглах, бохирдуулахгүй байх, нөхөн сэргээх талаар хуульчилсан байна.

***Байгаль орчныг хамгаалах тухай*** хуульд орсон гол нэмэлт нь иргэд оршин суугаа газар нутгийнхаа байгалийн баялгийг тодорхой нөхцөлтэйгөөр хариуцан хамгаалахад чиглэсэн. Байгаль орчныг бохирдуулж доройтуулсан, хууль бус ашигласан тохиолдолд иргэд, төрийн бус байгууллагаас шүүхэд хандах эрх нь нээгдсэн. Орон нутгийн иргэд сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтанд орох буюу нөхөрлөл байгуулж газар нутгаа хариуцан хамгаалах боломжийг илүү бүрдүүлсэн байна[22]. Жишээ нь, иргэдэд оршин суугаа нутгийн байгалийн нөөц баялаг бүрийг тоолж хүлээлгэн өгөх ба байгалийн баялагийг хууль бусаар ашиглаж, байгаль орчныг бохирдуулан доройтуулж, түймэр гаргаж болохгүй гэсэн хариуцлагыг гэрээгээр хүлээлгэх болсон. Ийнхүү байгаль орчноо хамгаалснаар иргэдэд амьдрах нөхцөлийн давуу боломжууд болон байгалийн баялгаа зүй зохистой ашиглах бололцоо олгогдох юм. Байгалийн баялаг нь төрийн халдашгүй өмч бөгөөд түүнийг хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлж байгаа нь манайх шиг өргөн уудам нутагтай, цөөн хүн амтай оронд тохирсон сайн арга болох талтай.

Байгаль орчны багц хуулийн хүрээнд ***Усны тухай*** хуулийг шинэчлэн найруулсан юм. Хуулинд усны сав газрын захиргаадыг шинээр байгуулахаар тусгасан бөгөөд засаг захиргааны нэгжээс ангид байгуулагдах, мөн удирдлага, хяналтад төрийн болон төрийн бус байгууллагууд тэгш эрхтэйгээр харилцан хамааралтай ажиллахаар болсон[23].

[22]Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 4 дүгээр зүйл, 31, 32 дугаар зүйл.
[23]Усны тухай хууль, 20, 23 дугаар зүйл.

***Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай*** хуулинд олон нийтийн оролцоо, ялангуяа нутгийн иргэдийн оролцоог хангах харилцааг зохицуулах тусгай бүлэг оруулсан. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний явцыг олон нийтэд мэдээлэх, олон нийтийн саналыг авах, хэрэгжилтэд хяналт тавих, хянан магадлагаа хийх зэргээр олон нийтийн оролцоог хангасан байна[24].

***Агаарын тухай*** хуульд агаарын бохирдлыг бууруулахад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлж, урамшуулах, тэдэнд төр болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн[25].

***Ойн тухай*** хуулинд ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж, ойг өөрийн зардлаар арчлан хамгаалах, ашиглахаар тусгасан байна[26].

***Амьтны тухай*** хуулинд иргэн, нөхөрлөл, төрийн бус байгууллагуудыг ан амьтны нөөцийг хамгаалахад оролцуулах талаар хуульчилсан[27].

Байгаль орчны хуулиудад Байгаль хамгаалах нөхөрлөл, Ойн нөхөрлөл, Сав газрын зөвлөл, Орчны бүсийн зөвлөл зэрэг байгаль хамгаалахад иргэдийн оролцоог хангах бүтэц, зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлсон байна.

***Ашигт малтмалын тухай*** хуулинд иргэд, олон нийтийн оролцоог хангасан чухал заалтуудыг оруулжээ. Хуулийн 42 дугаар зүйлд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавих бие төлөөлөгчийг иргэдийн дундаас сонгон ажиллуулж, ИНХ-аар тайланг сонсох талаар тусгасан байна. Энэ нь уул уурхайн компаниудын байгаль, хүрээлэн буй орчныг хамгаалах хариуцлагыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Иргэний хөдөлгөөнүүдийн идэвх санаачлагаар 2007 онд “урт нэртэй хууль” буюу ***Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглах, хориглох*** тухай хууль батлагдсан юм. Хуулийн 5 дугаар зүйлд байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг орон нутгийн удирдлага болон иргэд, олон нийтийн хяналт дор 2 хүртэл жилийн хугацаанд хийж дуусгах ба хяналтыг ИТХ-ын шийдвэрээр байгаль орчныг хамгаалах зорилго чиглэл бүхий төрийн бус байгууллагуудад гэрээгээр хариуцуулж болохоор зохицуулсан байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[24]Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 18 дугаар зүйл.
[25]Агаарын тухай хууль, 13, 14 дүгээр зүйл.
[26]Ойн тухай хууль, 20, 21, 25, 26, 27, 28, 30, 31, 34, 37, 39 дүгээр зүйл.
[27]Амьтны тухай хууль, 14, 21, 22, 33, 38 дугаар зүйл.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ


- Төрийн чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшилд шилжүүлэх нь. Судалгааны тайлан. Удирдлагын академи., 2010 он.
- Civil Partnership Act. 2004. www.partnershipsuk.org.uk
- Civil Servise Act 2005. www.parliament.uk
- National Register of Public Service. www.nrpsi.co.uk
- Outsourcing of public services in Australia: seven case stadies. www.econ.mq.edu.au
- Partnerships Victoria. Guideline material. July 2006, Overviem, page 5. www.australia.gov.au
- Public Service Standards 2007-2008. www.nationalarchives.gov.uk
- Административная реформа: решения и проблемы. www.adm.yar.ru
- Концепции административной реформы в РФ в 2006-2010 годах. www.adm.yar.ru
- Послание Президента Федеральному Собранию Российской Федерации 2003. www.kremlin.ru
- Постановление Правительства Пензенской обл.от 04.05.2008. №274 “Об использовании аутсорсинга исполнительными органами государственной власти Пензенской области”. www.regionz.ru
- Федеральная программа “Реформирование государственной службы службы Российской Федерации”. www.uk.mos.ru
- Федеральная программа “Реформирование и развитие государственной службы службы Российской Федерации”. www.rg.ru
- И.Н.Барциц, Публичные услуги и административный регламент их оказания. М., 2008 г.
- http://laws-lois.justice.gc.ca/eng/index.html
- http://zasag.mn/news/view/6335
- www.cbsc.ca/english/faqs/standards.php#con
- www.e-procurement.mn/?lid=175&f=newpage&id=2&t=legis
- www.legalinfo.mn/


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ ТЭДГЭЭРИЙН БИЕ ДААСАН, ХАРААТ БУС БАЙДЛЫН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

*Г.Чулуун, Д.Халиун, Д.Жигваагүнсэл*

## АГУУЛГА

Судалгааны дүгнэлт

Нэг. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн орчин, бие даасан байдлын талаарх гадаадын зарим орны туршлага

Хоёр. Монгол Улсын нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн орчин, тэдгээрийн бие даасан, хараат бус байдлын өнөөгийн байдал

Ашигласан материал

Хавсралт

## СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Судалгааны явцад Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн орчныг тодорхойлсон байдлыг гадаадын зарим орны Үндсэн хуулийн тодорхойлолтуудтай харьцуулан судалснаас гадна Европын холбооны зарим орнууд болон БНСУ-ын нутгийн удирдлагын эрх зүйн орчин, бие даасан хараат бус байдлыг дэлгэрэнгүй байдлаар судалж мэдээлэл бэлтгэв.

Нутгийн удирдлагын зарчим, хараат бус байдлыг судлахын тулд юуны өмнө нутгийн удирдлагын тухай ойлголт болон нутгийн өөрөө удирдах байгууллагын статусыг тодорхой болгох нь чухал юм. “Нутгийн өөрөө удирдах ёс” гэдэг нь нутаг дэвсгэрийн тухайлсан нэгжид оршин суугч иргэд өөртөө хамаарах асуудлыг ардчилсан сонгуулиар байгуулсан төлөөллийн байгууллагаараа дамжуулан, өөрсдийн ашиг сонирхолд нийцүүлэн, боломжит хөрөнгө мөнгөнийхөө хэрээр, үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн зохицуулах эрх мэдлийг хэлдэг байна.

Нутгийн Өөрөө Удирдах Ёсны Олон Улсын Тунхагт *(*Харти – *European Charter on Local Self-Government* “, …Нийтэд хамаарах үүрэг хариуцлагыг иргэдэд хамгийн ойр байгаа нутаг дэвсгэрийн байгууллага эдэлбэл зохино” гэж заасан. Нутгийн өөрөө удирдах ёсыг тунхагласан эл баримт бичиг нь бүхэлдээ нутгийн удирдлагын асуудалд зориулагдсан тул “нутаг дэвсгэрийн байгууллага” гэдэг нь чухамдаа бүх шатны иргэдийн төлөөллийн байгууллага болох нийслэл, дүүрэг, аймаг, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлыг хэлсэн гэж ойлгож болно.

Олон улсад мөрдөж буй зарчмаар бол Хурлын эрх мэдэл нь Засаг даргынхаас дутуу байж болохгүй гэж үздэг. Нутгийн өөрөө удирдах ёсны Европын Хартид “нутгийн өөрийн удирдлагын тогтолцоог хамгаалж, бэхжүүлэх нь эрх мэдлийн төвлөрлийг сааруулж, улмаар Нэгдсэн Европыг байгуулахад чухал нөлөөтэй”-г онцлон тэмдэглэсэн байна.

Европын Холбооны гишүүн орнуудын нутгийн удирдлагын асуудлаарх нийтлэг чиг хандлагыг тоймлон авч үзвэл: 2001 оноос хойш ихэнх улс орнууд нь (ЕХ-ны гишүүн орноос 16 нь) орон нутгийн удирдлагын асуудлаар эрх зүйн шинэтгэлийг амжилттай явуулсан байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Судлагдсан орнуудын авч хэрэгжүүлсэн өөрчлөлтүүд нь хэмжээ, цар хүрээний хувьд ихээхэн ялгаатай байх ба нутгийн удирдлагын тогтолцоонд харилцан адилгүй нөлөө үзүүлэхээр харагдаж байна. *(*Хавсралт 1, Хүснэгт 1-ээс дэлгэрэнгүй харж болно*)*.

Өөрчлөлт, шинэтгэлийн цар хүрээ, хэмжээ томрох тусам, түүнийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил зэрэг хүндрэл тулгарах нь нэмэгдэж байгааг Австрийн жишээн дээр харж болох юм. Австрийн Конвенц *(Austrian Convention)* нь Холбооны засгийн газар болон Ландер *(Lander)-ийн* эрх мэдэл, санхүүжилтийн хуваарилалтыг оновчтой болгох асуудлаар санал нэгдэж чадаагүй юм. Түүнчлэн эрх мэдэл болон санхүүжилтийн хуваарилалтаас гадна газар нутаг, засаг захиргааны нэгжийн хүрээнд томоохон хэмжээний шинэтгэлийг амжилттай хэрэгжүүлсэн орнууд олон байна. (Тухайлбал, Дани улс).

Улс орнуудын төрийн байгууламжийн хэлбэрээс үл хамааран нутгийн өөрөө удирдах байгууллага бие даан оршин тогтнох чадамжтай байх нь тухайн орны хөгжлийн үндэс суурь болдог бол нутгийн удирдлагын байгууллагын бие даасан, хараат бус байдлын гол цөм нь санхүүгийн бие даасан байдал юм. Тиймээс хэрэгжүүлж буй шинэтгэлийн гол зорилго нь нутгийн удирдлагын байгууллагуудын эрх мэдэл, чиг үүргийг нэмэгдүүлэхэд түлхүү чиглэгдэж байна.

Ихэнх улс оронд нутгийн өөрөө удирдах байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эрх хэмжээ, бие даасан байдлыг Үндсэн хуулиараа зохицуулсан байх бөгөөд Нутгийн удирдлагын тухай хууль, түүний санхүүгийн бие даасан байдлын тухай хуулиудыг батлан гаргасан байх боловч тэдгээрийн хоорондын зөрчилтэй байдал, Иргэдийн сонгуульт төлөөллийн эрх ашгийн сонирхлын нөлөөлөл зэргээс хамаарч бодит амьдрал дээр төдийлөн үр дүнтэй хэрэгждэггүй тал хандлага бий гэж судлаачид үзсэн байна. (Тухайлбал БНСУ)

Судалгааны явцад нутгийн удирдлагын эрх зүйн орчин, тэдгээрийн бие даасан, хараат бус байдлын үнэлгээний талаар гадаадын болон дотоодын судалгааны байгууллагуудад хийгдсэн судалгааны тайлангууд олдсон боловч ихэнх нь хуучирсан мэдээлэлтэй байна. *(*Хавсралт 2*.)*

## НЭГ. НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, БИЕ ДААСАН БАЙДЛЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНУУДЫН ТУРШЛАГА

Европын Холбооны орнууд болон Солонгос Улсын нутгийн удирдлагын байгууллагын тогтолцоо, бүтэц, эрх зүйн орчны өнөөгийн байдал, тэдгээрийн бие даасан, хараат бус байдлын талаарх асуудлуудыг энэхүү бүлэгт авч үзэв.

### 1.1. Европын холбооны орнууд

#### *1.1.1 Нутгийн удирдлагын эрх зүйн орчин:*

Европын орнууд дахь нутгийн өөрөө удирдах ёсыг Европын Зөвлөлөөс 1985 онд баталсан Европын нутгийн өөрийн удирдлагын Харти *(European Charter on Local Self-Government)*[28]-р зохицуулсан байдаг. Тус Харти нь 30 зүйлээс бүрдэх ба, Европын Холбооны гишүүн орнууд нь доод тал нь 10 зүйлийг баталсан байхыг шаарддаг байна.

Нутгийн өөрөө удирдах ёсыг тус баримт бичгийн 3.1-т дараах байдлаар тодорхойлжээ: Тухайлбал, "*Нутгийн өөрөө удирдах ёс гэдэг нь орон нутгийн эрх барих байгууллагаас төрийн хэргийн үлэмж хэсгийг хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд, өөрийн*

[28]http://conventions.coe.int/Treaty/en/Treaties/Html/122.htm

*хариуцлага дор, орон нутгийн хүн амын ашиг сонирхолд нийцүүлэн зохицуулах болон удирдах эрх, чадварыг илэрхийлнэ." гэжээ.*

Европын Харти-д нутгийн өөрөө удирдах ёсны дараах гол зарчмуудыг тусгасан байна: Үүнд:

- нутгийн өөрөө удирдах ёсны зарчим нь дотоодын эрх зүйн хэм хэмжээ, шаардлагатай гэж үзвэл үндсэн хуулиар баталгаажсан байх;
- хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд өөрийн эрх мэдэлд хамаарах асуудлыг бие даан шийдвэрлэх;
- нутгийн өөрөө удирдах ёсны үйл ажиллагаа хэрэгжиж байгаа нутаг дэвсгэрийн хилийн цэсэд өөрчлөлт оруулахаар бол нутгийн иргэдийн саналыг урьдчилан авах буюу санал хураалт явуулдаг байх;
- нутгийн өөрөө удирдах байгууллагуудын үйл ажиллагаанд тавих захиргааны хяналтын зөвхөн үндсэн хууль буюу холбогдох хуульд заасан тохиолдолд хэрэгждэг байх;
- нутгийн өөрөө удирдах ёсны сонгуульт төлөөлөгчдийн эрх зүйн байдал нь өөрийн албан үүргээ саадгүй биелүүлэх баталгаа болох ёстой;
- нутгийн өөрөө удирдах байгууллага бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд үндэсний эдийн засгийн бодлогын хүрээнд чөлөөтэй зарцуулах өөрийн гэсэн зохих хэмжээний хөрөнгөтэй байх;
- эрхээ чөлөөтэй хэрэгжүүлэхийн тулд шаардлага гарвал шүүхэд хандах;
- нутгийн өөрөө удирдах байгууллагын гаргасан шийдвэр нь хэрэгжих бүрэн үндэстэй байх.

Европын орнуудын нутгийн удирдлагын эрх зүйн үндсийг бүрдүүлж буй гол хуулиуд, тухайн орнуудын нутгийн удирдлагын асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, эрх зүйн шинэтгэлийн талаарх товч мэдээллийг дараах хүснэгтээс үзнэ үү.

***(Хүснэгт 1.)***

| ***Улсын нэр*** | ***Товч мэдээлэл*** |
|---|---|
| **Австри** | Австрийн Үндсэн хуулийг 1920 онд, 1945 онд дахин шинэчлэн баталсан байна. 1929 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр нутгийн өөрөө удирдах ёсны үзэл баримтлалыг *Үндсэн хуулийн 116 дугаар зүйлд* тусгасан. 1962 онд нутгийн өөрийн удирдлагыг хөгжүүлэх, өргөжүүлэх Үндсэн хуулийн шинэтгэл явагдсан. Холбооны системийг шинэчлэх өөрчлөлтүүд 1974, 1983 болон 1988 онуудад тус тус орсон байна. |
| **Бельги** | Бельгийн Вант Улс нь 1830 онд нэгдмэл төрийн байгууламжтай байгуулагдсан байна. Фламандчууд болон Франц угсаатнуудын хоорондын харьцаа таагүй хөгжиж ирсний үр дүнд 20 дугаар зууны дунд үеэс Фламанд болон Валони бүс нутгууд нь эдийн засгийн хувьд ихээхэн ялгавартай хөгжсөн. Нийслэл Брюссель нь Фламандаар хүрээлүүлсэн бөгөөд, албан ёсны хоёр хэлтэй. Үндсэн хуулийн шинэтгэл нь энэхүү асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн анхаарч 1970, 1980, 1988-1989, 1993 болон 2001 онуудад бүс нутгуудын эрх мэдлийг нэмэгдүүлэх асуудлаар томоохон хэмжээний шинэтгэл явуулсан. 1993 онд Бельги Улс нь Холбооны төрийн байгууламжтай болсон. |
| **Болгар** | 1991 онд батлагдсан *Үндсэн хуулийн 135-146 дугаар зүйлд* заасны дагуу "нутгийн өөрийн удирдлага бүхий нэгдмэл улс" Болгар улс нь парламентын засаглалтай Бүгд Найрамдах Улс юм. Үндсэн хуулийн 2 дугаар заалтад заасны дагуу автономит эрхийг хүлээн зөвшөөрдөггүй. Ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш 1991 онд Нутгийн өөрийн удирдлагын тухай хуулийг баталж, 1995, 1999 болон 2003 онд нэмэлт, өөрчлөлтүүд орсон байна. 2002 онд нутгийн өөрийн удирдлагын санхүүгийн хараат бус байдлыг нэмэгдүүлэх хуулийн төслийг өргөн барьсан. |

| | |
|---|---|
| **Чех** | Бүгд Найрамдах Чех Улс нь 1993 онд тусгаар тогтносон. Бүс нутгийн болон нутгийн өөрийн удирдлагыг 1992 онд батлагдсан Ү*ндсэн хуулийн 8 болон 101 дүгээр зүйлээр* баталгаажуулсан. |
| **Дани** | Дани Улс нь Үндсэн хуульт хаант засаглалтай улс бөгөөд нутгийн өөрийн удирдлагыг 1953 онд батлагдсан *Үндсэн хуулийн 82 дугаар зүйлээр* зохицуулсан. Нутгийн удирдлагын анхны эрх зүйн зохицуулалт 1849 онд баталсан хуулиас эхтэй гэж үздэг. 1948 болон 1985 онуудад Фарое Арал *(Faroe Island)* болон Гренландын тусгаар тогтнолыг тус тус хүлээн зөвшөөрсөн. 1970 онд батлагдсан Нутгийн удирдлагын тухай хууль нь нутгийн удирдлагын байгууллагын чадавхыг бэхжүүлсэн. 2005 онд явагдсан орон нутгийн томоохон шинэтгэлийн хүрээнд хотын тоог цөөлөх буюу засаг захиргааны нэгжийг томсгож, бүс нутгуудыг байгуулсан. |
| **Финланд** | Бүгд Найрамдах Финланд Улс нь 1917 онд тусгаар тогтносон. 2000 онд Үндсэн хуулиа шинэчлэн баталсан ба хотын, орон нутгийн өөрийн удирдлагын асуудлын *Үндсэн хуулийн 121 дүгээр зүйлээр* баталгаажуулсан. Хэдийгээр Финланд дахь нутгийн удирдлага 19 дүгээр зуунд үүссэн гэж үздэг боловч 1919 онд холбогдох хуулийг баталсан. Швед олонхтой Аландын *(Aland Islands)* Арал нь 1921 оноос Олон улсын хууль болон Үндсэн хуулийн 75 дугаар заалтад заасны дагуу тусгай автономит статустай. 1949 болон 1977 онд батлагдсан Орон нутгийн засгийн газрын тухай хууль нь хот, хөдөөгийн ялгааг арилгасан. 1989 онд орон нутгийн засгийн газруудын эрх мэдлийг нэмэгдүүлэх зорилго бүхий туршилтын Чөлөөт Хот *(Free Municipality)* хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. 1995 онд шинэчлэн батлагдсан Орон нутгийн засгийн газрын тухай хуулиар орон нутгуудын эрх мэдлийг нэмэгдүүлсэн. |
| **Франц** | Франц Улс нь Францын хувьсгалаар /1789-199/ хоёр түвшний нутгийн удирдлагын байгууллагын тогтолцоотой болсон. Бүс болон орон нутгийн өөрөө удирдах ёсыг *Үндсэн хуулийн 72 болон 34 дүгээр зүйлээр* баталгаажуулсан. Коммунууд нь 1834 оноос зөвлөлийг сонгож эхэлсэн, 1884 оноос өөрийн газар нутагт эрх мэдлээ хэрэгжүүлэх эрхтэй, хотын зөвлөл - (*conseil municipal)* -с сонгогдох хотын захирагчтай болсон байна. 1791 онд Департаментуудыг байгуулсан, 1806 оноос засаг төрийн төлөөлөгч болох Префект-д дэмжлэг үзүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх Ерөнхий зөвлөлийг сонгож эхэлсэн.<br><br>Франц улс нь төвлөрлийг сааруулах 2 үе шат бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлж буй. Эхний үе шат 1982-1983 онд Парламенты тухай хуулиар, хоёр дахь үе шат нь 2003 онд Үндсэн хууль нэмэлт өөрчлөлт оруулснаар тус тус хэрэгжиж эхэлсэн байна. Тус хөтөлбөрөөр бүс нутаг, департамент, коммун болон орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлсэн. Сүүлийн шинэтгэлээр Парламентын тухай хуульд заасны дагуу, орон нутгийн дэд байгууллагууд *(sub-state unit)* нь орон нутгийн эрх мэдлийг хязгаарласан хязгаарлалтыг туршилтын журмаар тодорхой нөхцөл болон тодорхой хугацааны хүрээнд мөрдөхгүй байх эрхтэй болсон. |
| **Герман** | Герман нь 1871 онд нэгдсэнээр Холбооны Бүгд Найрамдах Улс болсон. *Үндсэн хуулийн 20 дугаар зүйлээр холбооны улсын зарчим, 28 дугаар зүйлээр* нутгийн өөрийн удирдлагыг тус тус хуульчлан тогтоосон. 1990 онд хоёр Герман нэгдэхэд Зүүнд Ландерийг дахин сэргээж хүчин төгөлдөр Үндсэн хуульд нийцүүлсэн байна. 2006 онд холбооны тогтолцооны, 2 түвшний орон нутгийн засаг захиргааны байгууллагууд хоорондын чиг үүрэг, санхүүжилтийн хуваарилалтыг оновчтой болгох эрх зүйн томоохон шинэтгэл явагдсан. |
| **Унгар** | 1949 онд батлагдсан Үндсэн хуулийн дагуу Бүгд Найрамдах Улс юм. 1989 онд ардчилсан тогтолцоонд шилжсэн. *Үндсэн хуулийн 44 дүгээр зүйлийн А-заалтад* заасны дагуу нутгийн удирдлагын тухай хуулийг Парламентын олонх буюу 2/3 саналаар батлах ба мөн хэмжээний саналаар нутгийн удирдлагын эрхийг хязгаарласан хууль, эрх зүйн хэм хэмжээг тогтооно гэж заасан. 1994 онд баталсан хуулийн дагуу хотын дарга нарыг шууд сонгох зарчмыг нэвтрүүлсэн. 1999 оны хуулиар тойрог (*county)* нь хөгжлийн бүс байгуулах ёстой гэж заасан. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | |
|---|---|
| **Ирланд** | Бүгд Найрамдах Ирланд Улс нь 1921 онд Британийн Эзэнт Гүрний бүрэлдэхүүнээс гарч, тусгаар тогтносон. 1937 онд батлагдсан Үндсэн хуулийн дагуу Ирландын газар нутаг нь арлыг бүхэлд нь хамрах байсан боловч 1998 онд явагдсан ард нийтийн санал асуулгаар "гагцхүү арлын хоёр хэсгийн ард иргэдийн зөвшөөрснөөр нэгдэнэ гэж тогтоожээ. Орон нутгийн удирдлагыг 1898 оноос буюу Их Британийн харьяа байх үеэс тогтсон гэж үздэг. Орон нутгийн дүүргүүдийн 1925 онд татан буулгасан, 1941 болон 1946 онд орон нутгийн төвлөрсөн удирдлагыг чангатгасан байна. Орон нутгийн Газруудыг *(Regional Authorities)* 1994 онд, Орон нутгийн Чуулганыг (Regional Assembly) 1999 онд тус тус байгуулсан. 1999 онд явагдсан ард нийтийн санал асуулгаар нутгийн өөрөө удирдах ёсны зарчмыг албан ёсоор хүлээн зөвшөөрч холбогдох өөрчлөлтийг Үндсэн хуульд оруулсан. 2001 оны шинэтгэлээр хотын дүүрэг, хотын комиссар/даргын зөвлөлийг хотын зөвлөлөөр сольсон бөгөөд хотын даргыг шууд сонгох зарчмыг нэвтрүүлсэн байна. 2003 оны хуулиар хотын даргын сонгуулийн шууд зарчмыг болиулсан ч, Парламентын гишүүн зөвлөлийн гишүүнээр ажиллахыг хориглож, давхар суудлын асуудлыг шийдсэн байна. |
| **Итали** | 1948 онд батлагдсан Үндсэн хуулийн дагуу Итали нь нэгдмэл тогтолцоотой Бүгд Найрамдах Улс ба *Үндсэн хуулийн 5 болон 114 дүгээр зүйлээр* нутгийн хараат бус байдлыг хуульчилсан. 1948 онд тусгай статустай 4 бүс нутгийн байгуулсан, 1963 онд нэг бүс нутаг нэмэгдсэн байна. Ердийн статустай бус нутгуудыг 1970 он хүртэл байгуулаагүй ба тэдгээр нь 1976 он хүртэл эрх мэдэлгүй байсан. 1997 онд батлагдсан "Бассанини"-гийн гэх 2 хуулийн хүрээнд бүс болон орон нутгуудын эрх мэдлийг нэмэгдүүлэхтэй холбоотой томоохон хэмжээний шинэтгэлийг явуулсан. 1999 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу бүс нутгийн ерөнхийлөгчдийг шууд сонгох, 2001 онд бүс нутгийн хууль тогтоох эрхийг нэмэгдүүлсэн. Бассанинигийн хууль болон 2001 оны Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь төрийн чиг үүргийг хуваарилахдаа аль болох иргэдэд хамгийн ойр дөт захиргааны түвшинд тухайн чиг үүргийг ногдуулж байх нийцүүлэх зарчмыг нэвтрүүлсэн. |
| **Латви** | 1922 онд батлагдсан Үндсэн хуулийн дагуу Латви Улс нь парламентын засаглалтай Бүгд Найрамдах Улс бөгөөд Зөвлөл Холбоот Улсаас 1990 онд тусгаар тогтносон. Нутгийн өөрөө удирдах ёсыг тодорхой байдлаар Үндсэн хуулиар баталгаажуулаагүй. Нутгийн өөрөө удирдах байгууллагын тухай хуулийг 1994 онд баталсан. Нутаг дэвсгэрийг нэгжийн санхүүжилтийн тухай хуулийг 1995, 1998 онд тус тус баталсан. 1998 оны Засаг захиргааны нэгжийн захиргааны шинэтгэлийн тухай хуулиар хотуудыг нэгтгэсэн байна. 1998 онд орон нутгийн удирдлагууд нь сайн дурын үндсэн дээр төлөвлөлтийн бүсүүдийг байгуулж, 2002 оны Бүс нутгийн хөгжлийн тухай хууль нь төлөвлөлтийн бүсийн эрх зүйн үндсийг бий болгосон байна. |
| **Литва** | Литва Улс нь 1990 онд тусгаар тогтносон бөгөөд 1992 онд батлагдсан *Үндсэн хуулийн 119-124 дүгээр зүйлээр* нутгийн удирдлагыг зохицуулсан. Нутгийн өөрийн удирдлагын тухай хуулийг 1994, 1995 онд Нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж болон тэдгээрийн хилийн цэсийн тухай хуулийн, 1994 онд Мужийн захиргааны тухай хуулийг тус тус баталсан байна. |
| **Нидерланд** | 1815 оны Үндсэн хуулийн дагуу Нидерланд Улс нь Үндсэн хууль хаант засаглалтай, 1983 онд Үндсэн хуулиа бүрэн шинэчилсэн ба нутгийн өөрөө удирдах ёсны зарчмыг *124 дүгээр зүйлээр* баталгаажуулсан. 1994 онд нутгийн удирдлагын тухай хуулийг шинэчлэн найруулсан. 2002-2003 онд явагдсан нутгийн өөрийн удирдлагын шинэтгэлээр орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, хотын тоог цөөлөх, бүс нутгийн түвшнийг нэвтрүүлэх асуудлаар томоохон хөдөлгөөнүүд өрнөсөн. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | |
|---|---|
| **Португали** | 1976 онд батлагдсан Үндсэн хуулийн дагуу Португали нь Бүгд Найрамдах Улс бөгөөд нутгийн өөрөө удирдах ёсны зарчмыг *Үндсэн хуулийн 235-243 дугаар зүйлээр* баталгаажуулсан. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд уламжлалт төвлөрсөн тогтолцоотой улс. 1989 онд Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу /бүс байгуулагдахаас өмнө/ засаг захиргааны үндсэн нэгж нь дүүрэг байна гэж заасан байна. *Үндсэн хуулийн 225-234 дүгээр зүйлд* заасны дагуу Мадейра *(Madeira)* болон Азорын Арал *(Azores)* бүхий 2 автономит бүстэй. |
| **Испани** | 1978 онд батлагдсан Үндсэн хуулийн дагуу Испани нь Үндсэн хуульт хаант засаглалтай. 1870 онд хотын зөвлөлийг сонгох тухай заалт орж байсан ч энэ нь диктатурын үед хэрэгжээгүй ба 1978 онд ардчилсан тогтолцоонд шилжсэнээр, бүс нутгийн өөртөө засах байгуулалттай (*Estado de las autonomnas)* болсон. Тус зарчмыг *Үндсэн хуулийн 2 болон 137 дугаар зүйлээр* баталгаажуулсан. Хотын удирдлагын асуудлыг Үндсэн хуулийн 140 дүгээр заалтад тусгасан. |
| **Их Британи** | Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс нь Үндсэн хуульт хаант засаглалтай улс бөгөөд Англи, Шотланд, Уэльс, Умард Ирланд гэсэн 4 улсаас бүрдэнэ. Тойргийн зөвлөлүүд нь 19 дүгээр зуунд үүссэн бөгөөд Англи, Уэльс болон Шотландад 1974-1975 онд нутгийн удирдлагын шинэтгэл явагдаж хоёр түвшний нутгийн өөрийн удирдлагын байгууллагын тогтолцоотой болсон. 1980, 1990 онд нутгийн удирдлагын шинэтгэл явагдаж нэг түвшинтэй тогтолцоонд эргэн шилжсэн. 1997 оноос хойш батлагдсан ИБУИНВУ-ын төрийн тогтолцоон нөлөөлөхүйц хууль, эрх зүйн жагсаалт:<br><br>• Шотландын тухай хууль 1998, Шотландын Парламентыг хуульчлан тогтоосон;<br>• Уэльсийн Засгийн Газрын тухай хууль 1998, Уэльсийн Үндэсний Чуулганы үндсийг бий болгосон;<br>• Умард Ирландын тухай хууль 1998, Умард Ирландын Чуулганы үндсийг бий болгосон;<br>• Их Лондоны Удирдлагын тухай хууль 1999, Их Лондоны Удирдлага болон Лондон хотын захирагчийн шууд сонгуулийн эрх зүйн хэм хэмжээг тогтоосон;<br>• Бүс Нутгийн Хөгжлийн Агентлагийн тухай хууль 1998, Бүс нутгийн хөгжлийн агентлаг болон чуулганы эрх зүйн хэм хэмжээг тогтоосон;<br>• Нутгийн Удирдлагын тухай хууль 2000, нутгийн удирдлагын тогтолцооны гүйцэтгэх удирдлагыг бэхжүүлсэн;<br>• Уэльсийн Засаглалын тухай хууль 2006, Уэльсийн Үндэсний Чуулганы эрх мэдлийг нэмэгдүүлсэн; |

Европын Холбооны гишүүн улс орнуудыг нутгийн удирдлагын тогтолцооны хувьд дараах байдлаар 6 хуваасан байна. /Хүснэгт 2-оос үзнэ үү/

***(Хүснэгт 2)***[29]

| ***№*** | ***Тодорхойлолт*** | ***Улс орон*** |
|---|---|---|
| 1 | Бүс нутгууд нь өөрийн эрх мэдэлдээ хамаарах асуудлаар хууль батлах эрх нь Үндсэн хууль (Холбооны гэрээ)-р баталгаажсан | Австри, Бельги, Финланд (Аланд - *Aland)*, Герман, Итали (тусгай статус бүхий бүс нутаг), Орос, Словак, Испани, Швейцар |
| 2 | Бүс нутгууд нь өөрийн эрх мэдэлдээ хамаарах асуудлаар хууль батлах эрх нь Үндсэн хуулиар баталгаажаагүй | Их Британи (Шотланд болон Умард Ирланд) |
| 3 | Бүс нутгууд нь үндэсний хууль тогтоомжийн хүрээнд (үзэл баримтлал, ерөнхий нөхцөл гм.) өөрийн эрх мэдэлдээ хамаарах асуудлаар хууль батлах эрх нь Үндсэн хуулиар баталгаажсан | Чех, Унгар, Итали (ердийн бүсүүд), Нидерланд |

[29]www.migm.gov.tr/AvrupaKonseyi/Ek39.pdf , p.156.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| 4 | Бүс нутгууд нь үндэсний хууль тогтоомжийн хүрээнд (үзэл баримтлал, ерөнхий нөхцөл гм.) өөрийн эрх мэдэлдээ хамаарах асуудлаар хууль болон/эсхүл холбогдох эрх зүйн акт батлах эрх нь Үндсэн хуулиар баталгаажаагүй | Их Британи (Уэльс), Польш |
| 5 | Бүс нутгууд нь шийдвэр гаргах эрхтэй (хууль тогтоох эрх эдлэхгүй) ба зөвлөл *(council)* нь иргэдээс шууд сонгогдоно | Хорват, Дани, Финланд (Кайнуу - *Kainuu*), Франц, Норвеги, Швед, Турк, Украин, Их Британи - Их Лондон (*Greater London*) |
| 6 | Бүс нутгууд нь шийдвэр гаргах эрхтэй (хууль тогтоох эрх эдлэхгүй) ба зөвлөлийг нутгийн удирдлагын холбогдох байгууллагууд сонгоно | Албани, Финланд (бусад бүсүүд), Латви, Румынь |

Европын Холбооны гишүүн орнуудын нутгийн удирдлагын асуудлаарх нийтлэг чиг хандлагыг тоймловол[30]:

- Европын Холбооны гишүүн орнууд нутгийн удирдлагын асуудлаар их болон бага хэмжээгээр өөрчлөлт, шинэчлэлт хийж байна. 2001 оноос хойш ихэнх улс орнууд нь (ЕХ-ны гишүүн орноос 16 нь) орон нутгийн удирдлагын асуудлаар эрх зүйн шинэтгэлийг амжилттай явуулсан байна.
- Тусгагдсан өөрчлөлтүүд нь нутгийн удирдлагын байгууллагын бүтэц, зохион байгуулалт болон үйл ажиллагаанд чиглэгдсэн байна. Зарим бүтцийн өөрчлөлтүүд нь нутгийн удирдлагын өдөр тутмын үйл ажиллагаанд шууд мэдрэгдэхгүй ч үр дүн нь урт хугацаанд илрэх юм. Тухайлбал, Чехийн бүс нутгуудыг Үндсэн хуульд нутаг дэвсгэрийн дээд нэгж хэмээн тодорхойлсон зэргийг дурдаж болох юм. Бусад төрлийн өөрчлөлтүүд нь нутгийн удирдлагын өдөр тутмын үйл ажиллагаанд шууд нөлөөлөх өөрчлөлтүүд байх ба тухайлбал, Бельгийн Үндсэн хуульд Герман иргэд оршин суудаг засаг захиргааны нэгжүүдэд нэмэлт эрх мэдэл олгохоор тусгасан явдлыг нэрлэж болно.
- Судлагдсан орнуудын авч хэрэгжүүлсэн өөрчлөлтүүд нь хэмжээ, цар хүрээний хувьд ихээхэн ялгаатай байх ба нутгийн удирдлагын тогтолцоонд харилцан адилгүй нөлөө үзүүлэхээр харагдаж байна. Судлагдсан Европын Холбооны гишүүн нийт 7 орон бүтэц, зохион байгуулалтын тодорхой шат дараалалтайгаар томоохон хэмжээний өөрчлөлт хийхээр төлөвлөсөн, буюу хийж байна. Улс орнуудын оруулсан өөрчлөлтийг Хавсралт 1 болон Хүснэгт 1-с дэлгэрэнгүй харж болно. Өөрчлөлт, шинэтгэлийн цар хүрээ, хэмжээ томрох тусам, түүнийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил зэрэг хүндрэл тулгарах нь нэмэгдэж байгааг Австрийн жишээн дээр харж болох юм. Австрийн Конвенц *(Austrian Convention)* нь Холбооны засгийн газар болон Ландер *(Lander)-ийн* эрх мэдэл, санхүүжилтийн хуваарилалтыг оновчтой болгох асуудлаар санал нэгдэж чадаагүй юм. Өөр нэг амжилтгүй болсон томоохон хэмжээний шинэтгэлийн оролдлого нь 2006 онд Италийн Бүгд Найрамдах Улсын Холбооны Сенатыг *(Federal Senate of Republic)* байгуулах асуудал нь ард нийтийн санал асуулгаар дэмжигдээгүй байна. Томоохон хэмжээний шинэтгэлийг амжилттай хэрэгжүүлсэн туршлагаас дурдвал, Дани Улс нь 5 бүс/регион шинээр байгуулж 13 тойргийг (нутгийн удирдлагын байгууллагын 2-р түвшин) татан буулгасан байна.
- Хэрэгжүүлж буй шинэтгэлүүд ихэвчлэн нь нутгийн удирдлагын байгууллагуудын эрх мэдэл, чиг үүргийг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байна. Энэхүү хандлагыг санаачлагчийн хувьд авч үзвэл зарим тохиолдолд төв засгийн газар нь төвлөрлийг сааруулах зорилгоор орон нутагт зарим эрх мэдлээ шилжүүлж байгаа бол нөгөө талаас санаачилга нь орон нутгийн зүгээс гарч байна.
- Түүнчлэн, эрх мэдэл, санхүүжилтийн хуваарилалтаас гадна газар нутаг, засаг захиргааны нэгжийн хүрээнд томоохон өөрчлөлтүүд гарч байгаа ба үүний нэг жишээ нь Дани Улс юм. Мөн өөрчлөлтийг Нидерланд болон Норвеги Улсууд хэрэгжүүлэхээр хэлэлцэж байна. Нөгөөтээгүүр орон нутгийн удирдлага Засгийн газрын шийдвэр гаргахад оролцох оролцоо нэмэгдэж байгааг Испани Улсын жишээн дээр харж болох юм. (Автономит нэгдлүүдийн ЕХ-ны Сайд нарын зөвлөлд оролцох оролцоо гм.)

[30]Орсон өөрчлөлтүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийн Хавсралт 1-ээс үзнэ үү.

### *1.1.2 Нутгийн удирдлагын хараат бус байдал*

Улс орнуудын нутгийн удирдлагын байгууллагуудын санхүүгийн хараат бус байдлыг орон нутгийн өөрийн орлого бүрдүүлэлт болон орон нутгийн төсвийн зарлагын хэмжээ гэсэн 2 үзүүлэлтүүдийг харьцуулан, дараах 4 ангилалд хуваав:

1. *Орон нутгийн өөрийн орлого болон орон нутгийн төсвийн зарлагын хэмжээ нь өндөр;* Энэ нь орон нутгийн захиргаа нь нутгийн иргэдийн хэрэгцээ, шаардлагыг хангалттай хангахуйц хэмжээний санхүүгийн чадавх бүхий тогтолцоотой учир нутгийн удирдлагын байгууллагууд нь хүчтэй байдаг. (АНУ)*Орон нутгийн өөрийн орлогын хэмжээ нь өндөр, орон нутгийн төсвийн зарлагын хэмжээ нь бага;* Энэ нь санхүүгийн хараат бус байдал нь өндөр хэдий ч, орон нутгийн үзүүлэх үйлчилгээ, хариуцлага нь бага байдаг. Харин захиргааны хувьд бие даасан, хараат бус байдал нь сул, орон нутгийн үзүүлэх үйлчилгээ, хариуцлага нь бага, төв Засгийн газраас хамаарал ихтэй. (Франц, Польш)*Орон нутгийн өөрийн орлогын хэмжээ нь бага, орон нутгийн төсвийн зарлагын хэмжээ нь өндөр;* Энэ нь орон нутгийн үйлчилгээ, хариуцлага өндөр, санхүүгийн хараат бус байдал нь сул тогтолцоо юм. Эдгээр нь орон нутгийн удирдлага нь сул ба төв Засгийн газраас хараат орон нутгийн үйлчилгээ үзүүлнэ. Захиргааны хараат бус байдал сул. (Их Британи)*Орон нутгийн өөрийн орлогын хэмжээ болон орон нутгийн төсвийн зарлагын хэмжээ нь бага;* Санхүүгийн болон захиргааны бие даасан, хараат бус байдал нь сул байна. (Турк, Унгар, Словени)Дараах хүснэгтэд Европын зарим орон болон АНУ-ын орон нутгийн санхүүгийн хараат бус байдлыг тоймлон харуулав:

**(Хүснэгт 4)**[31]

| | **Бага** | **Өндөр** | |
|---|---|---|---|
| **Орон нутгийн орлого** | Франц, Польш | АНУ | **Өндөр** |
| | Словени, Унгар, Турк | Их Британи | **Бага** |
| | **Орон нутгийн төсвийн зарлага** | | |

**Орон нутгийн төсвийн орлого /дэмжлэг/, төсвийн зарлага**
**(Хүснэгт 5)**

| | ***Төвлөрсөн төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг, хувиар*** | ***Орон нутгийн татвар, хураамж, хувиар*** | ***(Харьцаа) Орон нутгийн төсөв/ төвлөрсөн төсөв*** | ***Орон нутгийн төсвийн зарлага (ДНБ, хувиар)*** | ***Төвлөрсөн төсвийн зарлага (ДНБ, хувиар)*** |
|---|---|---|---|---|---|
| Унгар | 68.00 | 19.00 | - | - | - |
| Польш | 45.00 | 44.00 | 15/85 | - | - |
| Франц | - | - | 18/82 | 8.00 | 48.00 |
| АНУ | 20.50 | - | 23/77 | 9.00 | 37.00 |
| Их Британи | 48.00 | 31.00 | 28/72 | 13.00 | 46.00 |
| Словени | 79.30 | 20.70 | 12/01/00 | 5.00 | 43.00 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[31]Comparative analysis of recent trends concerning the efficiency of the local self government. http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/iias/unpan011168.pdf

### 1.2 БНСУ /Өмнөд Солонгос/[32]

Солонгост орон нутгийн өөрөө удирдах засаглалын тогтолцоо нь 1948 онд Бүгд найрамдах Солонгос Улсыг байгуулснаас 4 жилийн дараа буюу 1952 оноос эхлэн хэрэгжижээ. Гэвч энэ нь Ли Сунгмэний (Lee Syngman) засаг барьж байх үед ердөө 9 жил хэрэгжсэн. Тодорхой хэлбэл Пак Чун Хэ-гийн цэргийн дарангуйлал бүхий дэглэмийн үед орон нутгийн сонгуульгүй болж, Үндсэн хууль нь орон нутгийн бие даасан удирдлагыг хэрэгжүүлэх үйл явцыг ирээдүйд Солонгосын хойг нэгдэхийг хүртэл буюу тодорхой бус хугацаагаар хойшлуулсан байна.

1979 онд Тавдугаар Бүгд Найрамдах засаглал нь орон нутгийн бие даасан, өөрөө удирдах засаглалын Үндсэн хуулийн үндэслэлийг дахин батлан гаргасан байдаг.

#### *1.2.1 Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн өнөөгийн байдал*

Тус улсад орон нутгийн удирдлага, түүний үйл ажиллагаа, эрх хэмжээ, бие даасан байдлын талаар Үндсэн хууль, Орон нутгийн бие даасан байдлын тухай хууль, Орон нутгийн санхүүгийн тухай хуулиудаар тус тус зохицуулдаг.

Тавдугаар Бүгд найрамдах засаглалын Үндсэн хуулийн[33] 118-р зүйлд заасанчлан, орон нутгийн удирдлагын засаглах хүрээ нь оршин суугчдынхаа сайн сайхан, эд хөрөнгийн менежмент, орон нутгийн хуулийн зохицуулалт зэргийг хамааран тэлсэн байна. Мөн 19-р зүйлд орон нутгийн хурал буюу Зөвлөлүүдийн тухай тодорхойлж өгсөн байдаг. Тэдгээрийг дахин сэргээх явдалтай холбогдуулан Үндсэн хуулийн нэмэлт 10-р зүйлд заахдаа, “*Орон нутгийн зөвлөлүүдийг нэн яаралтайгаар орон нутгийн захиргааг санхүүгийн хувьд бие даасан байдалд хүрэхүйц түвшинд сэргээн байгуулах ёстой*” гэжээ. Харин Орон нутгийн бие даасан, өөрөө удирдах засаглалын тогтолцооны тухайд удаан хугацаанд маргалдан мэтгэлцэж, “Орон Нутгийн Бие Даасан байдлын тухай хууль”-д[34] (Local Autonomy Act (LAA)) хэд хэдэн нэмэлт өөрчлөлтийг хийснээс хойш 1991 онд орон нутгийн зөвлөлүүдийн сонгууль болж, түүнээс 4 жилийн дараа орон нутаг бүрэн өөрийгөө удирдах орон нутгийн бүрэн хэмжээний сонгууль болжээ. Түүнээс хойш одоог хүртэл ийм орон нутгийн сонгууль дөрвөн удаа болсон байна.

*Орон нутгийн өөрөө удирдах байгуулагын тогтолцоо ба бүтэц*

Солонгос нь хоёр түвшин бүхий орон нутгийн засаглалын тогтолцоог хэрэгжүүлсэн байдаг. **Дээд түвшний** (бүс нутгийн түвшний) орон нутгийн засгийн газрууд нь муж (До-Do 道) болон метродолитан хотоос (Квангуёк-си - Kwangyeok-si 廣域市) бүрдэнэ. Харин **доод түвшний** (хотын түвшин) орон нутгийн захиргаанд хөдөөний сум (Гүн - Gun 道), хот (Си - Si 市) ба дүүрэг (Гү - Gu 區) багтана.

Хөдөө болон хот хоорондоо ихээр нэгдэн шингэж байгаа ба, бас хотууд хоорондоо нэгдэж байгаагаас шалтгаалан 1995 оноос хойш орон нутгийн өөрөө удирдах байгууллагын тоо буурч, 2012 оны 7-р сарын 1-ний байдлаар гэхэд 244 болжээ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Үүнд 17 нь бүс нутгийн засгийн газрууд, 227 нь хотын засгийн газрууд байна. Бүс нутгийн захиргаадад, Сөүл метрополитан хот, Сежонг хот, 6 метрополитан хотууд (Бусан, Инчеон, Даегу, Гвангжу, Даежеон, Улсан) ба 8 муж (Жуеонгги, Гангвон, Чунгнам, Чунгбук, Жеоннам, Жеонбук, Гуеонгги, Гуеонгбук) орно. Тэдгээрийн дотор Сөүл нь Солонгос улсын нийслэл учраас тусгай метрополитан хот болдог. Төв Засгийн Газрын 9 яам, холбогдох засгийн

[32]Local Government and Public Administration in Korea, 2013. https://hufsiss.files.wordpress.com/
[33]Constitution of the Republic of Korea.
[34]Local Autonomy Act (LAA). http://elaw.klri.re.kr/eng_mobile/

газрын агентлагууд, улсын судалгааны институтууд байрлах Сежонг хотыг тусгай бие даасан хот хэмээн нэрлэнэ. Түүний хууль зүйн байр суурь нь АНУ-ын Вашингтонтой төстэй. Чэжү муж нь олон улсын хөрөнгө оруулалтын таатай нутаг болж хөгжих үүднээс эдийн засгийн асуудлаар харьцангуй бие даасан, тусгай бие даасан муж болдог. Чэжү мужийн харьяалалд бие даасан бус хоёр захиргааны хотууд багтана. Эдгээр хотуудын засаг даргыг Чэжү мужийн засаг дарга томилно.

Доод түвшний орон нутгийн захиргаадад, 80 сум, 73 хот, 69 бие даасан өөрийн удирдлага бүхий дүүрэг багтана. Тэдгээрийн доторх бүх бие даасан, өөрийн удирдлага бүхий дүүрэг ба хотууд нь тус тусын харьяа метродолитан хотууд ба мужуудад харьяалагдана. 80 сумын 75 нь мужийн харьяаны захиргаад байхад, үлдсэн 5 нь метрополитан хотуудад харьяалагддаг байна. Эдгээр 5 сумд нь өдөр тутмын амьдрал ба оршин суугчдын нь эдийн засгийн үйл ажиллагааны хувьд метрополитан хотуудынхтай ойролцоо учраас тэдгээрийг метрополитан хотуудын салбар дагавар болгон харьяалуулдаг байна.

Бүх 244 орон нутгийн захиргааг өөрийн гэсэн сонгогдсон Зөвлөл ба гүйцэтгэх захиргаа бүхий бие даасан өөрийн удирдлагатай хэмээн ангилж үзнэ. Доод түвшний орон нутгийн засгийн газар нь хөдөөний нутаг дэвсгэрт бол Еуп ба Муеон, харин хотын нутаг дэвсгэрт Донг хэмээх захиргааны дагалдах түвшинтэй байна.

Орон нутгийн засгийн газар бүр өөрийн хууль ёсны статусыг «Орон нутгийн бие даасан байдлын тухай хууль»-д тодорхойлсон нөхцөлүүдийг хангасан тохиолдолд өөрчилж болно.

Солонгосын одоогийн мужуудын нутаг дэвсгэрийн харьяаллын тогтолцоо нь бараг зуу илүү жил болсон ба, 6 том метрополитан хотуудыг тус тусын мужуудаас нь салган бие даалгасныг эс тооцвол томоохон өөрчлөлт огт гараагүй юм. Үүнээс үүдэлтэйгээр одоогийн орон нутгийн захиргаадын нутаг дэвсгэрийн хуваарилалтад зарим асуудлууд байдаг. Нэгдүгээрт, Солонгос нь 1970-аад оноос хойш хотжилт, нийгмийн дэд бүтцийн модернизац ба тээвэр, холбоо харилцааны технологийн хөгжилт тэргүүтэн нийгэм-эдийн засгийн хувьд асар хурдацтай хөгжсөн байтал энэ бүхэн нь орон нутгийн одоогийн нутаг дэвсгэрийн хуваарилалтад бараг тусгагдаагүй хэвээр буй. Хоёрдугаарт, нутаг дэвсгэр ба хүн амын хэмжээний ялгаа нь орон нутгийн захиргаадын, тэр бүү хэл ижил зэрэглэл түвшний захиргаадын хооронд хүртэл санхүүгийн чадавхын тэнцвэргүй байдлыг үүсгэж байдаг юм. Тиймээс энэхүү санхүүгийн тэнцвэргүй байдал нь орон нутгийн захиргаадын хоорондох зай цоорхойг улам бүр нэмэн тэлэх шалтгаан болж байдаг.

Европ болон Америк тивийн улс орнуудад хэд хэдэн хэлбэрийн орон нутгийн засгийн газар, захиргаад байдаг байхад Солонгосынх АНУ-ын хотын мээр ба консул буюу Зөвлөл гэсэн бүтэцтэй адил нэг л бүтэцтэй байдаг. Мээр-Зөвлөл хэмээх орон нутгийн засгийн газрын хэлбэр нь гүйцэтгэх захирал (мужийн хувьд засаг дарга, метрополитан хот, хот, сум, дүүргийн хувьд мээр) ба орон нутгийн Зөвлөл (хурал) -өөс бүрдэнэ. Дээд ба доод түвшний орон нутгийн засгийн газрын аль алиных нь засаг дарга ба мээр нь 4 жил тутам болдог нийтийн сонгуулиар шууд сонгогдоно. Дээд ба доод түвшний орон нутгийн захиргааны зөвлөлийн гишүүдийн 11-ийн 10 нь нийтийн сонгуулиар сонгогдож үлдсэн суудалд нь порпорцианаль төлөөлөгчид сууна.

Мэр болон засаг дарга бол орон нутгийн засгийн газрын тэргүүн байна. Тухайн орон нутгийн тэргүүний хувиар тэрээр өдөр тутмын захиргааны ажил хэрэг, дээд албан тушаалтнуудыг томилох, төсөв бэлтгэх зэрэг үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тэрээр Зөвлөлийн үйл ажиллагаанд хориг тавих эрхтэй байна.

UILI.MN СУДАЛГААНЫ САН

Орон нутгийн зөвлөлүүд нь оршин суугчдын эрх ашгийг төлөөлж хууль гаргагч этгээд ба, онолын хувьд орон нутгийн өөрөө удирдах засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, тэнцвэржүүлэх эрхтэй.

### *1.2.2 Орон нутгийн засгийн газрын үйл ажиллагаа, бие даасан байдал*

Орон нутгийн бие даасан байдлын тухай хуулиар Солонгосын орон нутгийн засгийн газрууд нь засаг захиргааны үйл ажиллагааны хувьд маш өргөн цар хүрээтэй эрх мэдэл, бие даасан байдлыг эдэлдэг. Тус хуулийн 9-р зүйлд: “... орон нутгийн засгийн газар нь уг чанараараа орон нутгийн ба төв засгийн газраас төлөөлүүлсэн үүрэг үйл ажиллагааг явуулна”[35] гэжээ. Мөн орон нутгийн засгийн газрын үүрэг, үйл ажиллагааны 6 категорийг тодорхойлсон байдаг. Тухайлбал,

- Нутаг дэвсгэрийн харьяалал, орон нутгийн засгийн газруудын байгууллагын болон менежментийн талын үүрэг, үйл ажиллагаа
- Орон нутгийн оршин суугчдын ерөнхий сайн сайхан байдлыг сурталчлан дэмжих үүрэг, үйл ажиллагаа
- Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, худалдаа, аж үйлдвэрлэл гэх зэрэг аж үйлдвэрлэлийг сурталчлан дэмжихтэй холбоотой үүрэг, үйл ажиллагаа
- Бүс нутгийн хөгжил, барилгажилт, хүрээлэн буй орчны тохижилтын менежменттэй холбоотой үүрэг, үйл ажиллагаа
- Боловсрол, биеийн тамирын ажил, соёл, урлагийг дэмжин сурталчлах үүрэг, үйл ажиллагаа
- Иргэний хамгаалалт ба гал сөнөөхтэй холбоотой үүрэг, үйл ажиллагаа

Гэхдээ бодит амьдрал дээр, орон нутгийн засгийн газруудын үүрэг, үйл ажиллагааны хүрээ харьцангуй хязгаарлагдмал байдаг байна. Тус хуулийн 9-р зүйлийн нөхцөлт буюу болзолт үг өгүүлбэрүүд нь үндсэндээ орон нутгийн засгийн газруудынхаа эрх мэдлийг хязгаарласан байдаг. Тухайлбал, «*Энэ хуульд заасан үүрэг, үйл ажиллагаануудыг үл харгалзан Төв Засгийн газар /хэрвээ өөр бусад хуулиудад төв засгийн газрын үүрэг, үйл ажиллагаа гэж заасан бол/ аливаа үүрэг, үйл ажиллагаанд өөрийн эрх мэдэл ба хяналтыг хэрэгжүүлж болно*” гэжээ. Одоогийн байдлаар дээр дурдсан үүрэг, үйл ажиллагааг төв засгийн газрынх гэж заасан олон тооны хууль байдаг байна. Энэ нь орон нутгийн эрх мэдэл ба бие даасан байдлыг ноцтой сулруулдаг аж.

Ерөнхийлөгчийн дэргэдэх Төвлөрлийг Бууруулах Комиссоос 2009 онд гаргасан мэдээллээр бол засгийн газрын нийт 42,320 үүрэг, үйл ажиллагаа байдаг байна. Эдгээрээс төв засгийн газар нь гуравны хоёрыг нь (71.4 хувь буюу 29,980) эцэслэн шийдвэрлэдэг бол орон нутгийн засгийн газрууд гуравны нэг ч (27.9 хувь буюу 11,817) хүрэхгүйг нь шийдвэрлэдэг ба, төв засгийн газраас орон нутгийн засгийн газруудад төлөөлүүлэн дамжуулдаг нь 3.6 хувь (1,523) байжээ.

*Өөр өөр түвшний засгийн газруудын үүрэг үйл ажиллагааны давхардлууд*

Үүрэг, үйл ажиллагааны давхардал нь өнөөгийн Солонгосын өөр өөр түвшний орон нутгийн засгийн газруудын үүрэг, үйл ажиллагааны ангилалтай холбоотой нэгэн зүйл маш илэрхий шинж чанар байдаг. Хэдийгээр «*Орон нутгийн захиргааны бие даасан байдлын тухай хууль*”-д дээд түвшний орон нутгийн засгийн газрууд ба доод түвшний орон нутгийн засгийн газруудын хоорондох үүрэг, үйл ажиллагааны ангиллыг заасан байдаг боловч энэ хоёр түвшний үүрэг хариуцлагын цар хүрээ нь маш тодорхойгүй бөгөөд адармаатай байдаг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[35]Local autonomy act. http://elaw.klri.re.kr/eng_mobile/

"*Орон нутгийн захиргааны бие даасан байдлын тухай хууль*"-д дараах үүрэг, үйл ажиллагааг дээд түвшний засгийн газруудад (Муж ба Метрополитан хотуудад) хамаатуулсан байна.

1. Хоёр буюу түүнээс дээш тооны доод түвшний орон нутгийн засгийн газруудад нөлөөлөхүйц өргөн салбар хүрээний захиргааны ажил хэргүүд
2. Нэгэн ижил дээд түвшний орон нутгийн засгийн газарт харьяалагддаг доод түвшний орон нутгийн засгийн газруудад хэрэглэж болохуйц нэгэн ижил стандартуудын дагуу менежмент хийх шаардлагатай ажил хэргүүд
3. Нэгэн дээд түвшний засгийн газруудад харьяалагдаж буй бүх орон нутгуудад нэгдсэн нэг арга хэлбэрээр хэрэгжүүлэх шаардлагатай ажил хэргүүд
4. Улс үндэстний засгийн газар ба доод түвшний засгийн газруудын хооронд харилцах, хамтран ажиллах шаардлагатай ажил хэргүүд
5. Хоёр буюу түүнээс дээш тооны доод түвшний орон нутгийн засгийн газрууд нэгдсэн хэлбэрээр тоноглох ба менежментийг нь хийх хэмжээний тоног төхөөрөмж, тохижилт гэх зэрэгтэй холбоотой ажил хэргүүд

Нөгөө талд, тус хуулинд "*дээд түвшний орон нутгийн засгийн газруудад хамааралгүй ажил хэргүүд нь доод түвшний орон нутгийн засгийн газруудын үүрэг, үйл ажиллагааны салбар хүрээ мөн"* гэж заажээ. Мөн "... 500,000-аас дээш хүн амтай доод түвшний засгийн газрууд нь дээд түвшний орон нутгийн засгийн газруудаас авч хэрэгжүүлдэг ажил хэргүүдтэй холбоотой илүү үүрэг хариуцлагыг үүрч болно" гэсэн байна.

*Төвлөрлийг сааруулах бодлого*

Төв Засгийн газрын зүгээс эрх мэдлийг доод түвшний засгийн газруудад шилжүүлэн төлөөлүүлэх төдий л сонирхолгүй байгааг орон нутгийн засгийн газрын төрийн албаныхан ба эрдэмтэд шүүмжлэн үзэх болсон тул төв засгийн газраас 1999 онд «Засгийн Газрын Ажил Хэргийг Шилжүүлэн Өгөх Тусгай Хороо»-г байгуулсан ба, энэ нь 2004 онд Төвлөрлийг Сааруулахыг Дэмжих тухай тусгай хууль (Special Act on the Promotion of Decentralization) батлагдсанаар «Ерөнхийлөгчийн дэргэдэх Төвлөрлийг Сааруулах Комисс» хэмээн нэрээ сольсон байдаг. Тэрхүү хуулиар төвлөрлийг сааруулахын хэрэгцээ шаардлагыг тунхаглаж, төвлөрлийг сааруулах арга, зарчмуудыг тодорхойлсон байна. Энэхүү хуульд үндэслэн байгуулагдсан Комиссын үүрэг роль бол эрх мэдлийг шилжүүлэх, тухайлбал, засгийн газрын ажил хэргийг төв болон орон нутгийн засгийн газруудад учир үндэслэлтэй бөгөөд системтэй хуваарилахыг дэмжин нөхцөлдүүлэх явдал байжээ.

Энэхүү комисс байгуулагдсанаас хойш тухайлбал 2011 оны 12-р сарын байдлаар авч үзэхэд, нийт 3023 үүрэг, үйл ажиллагааг шилжүүлж төвлөрлийг сааруулна хэмээн сонгосноос 1709-ийг нь хэдийнээ шилжүүлж, 1314 нь шилжүүлэхээр ажиллаж байгаа юм байна.

Солонгосын орон нутгийн бие даасан удирдлагын ёс 1980-аад оны үеийн ардчиллын хөдөлгөөний үр дүнд дахин сэргэж, 1990-ээд оны эхэн үеэс эхлэн хөгжиж эхэлсэн байдаг. Тухайлбал, 1991 онд орон нутгийн Зөвлөлийн хурлын сонгууль болж, 1995 онд орон нутгийн анхны ерөнхий сонгууль зохион байгуулагдсан байдаг байна. Хэдий тийм боловч, эрх мэдэл ба ажил хэргийн төвлөрлийг сааруулах явц их удаан байгаа тул үүнийг дэмжигчид нь өнөөгийн байдлаа «**30 хувь орон нутгийн бие даасан байдал**" хэмээн тодорхойлж байна.

Төв Засгийн Газрын яамд ба агентлагууд нь, «орон нутгийнхан эхлээд төвлөрлийг бууруулан ажил хэргийг шилжүүлснээр өөрсдөд дээрээ тохоогдох хэцүү үүргийг гүйцэтгэн биелүүлэх чадвартай болох ёстой» гэж мэтгэлцдэг аж. Үүнээс эсрэгээр, орон нутгийн

UIH.MN СУДАЛГААНЫ САН

засгийн газрууд нь, «төв засгийн газрынхан орон нутаг дахь өөрсдийн эрх мэдэл ба нөлөөг алдчих вий гэсэндээ өөрсдийн ажил үүргийг бидэнд шилжүүлэн өгөхийг хүсэхгүй байгаа юм» гэцгээнэ. Аль аль нь үндэслэл муутай аргументууд мөн. Учир нь нэг нь нөгөөгөө харилцан бэхжүүлдэг тул орон нутгийн засгийн газруудын чадамжийг сайжруулан дээшлүүлэх ба төвлөрлийг бууруулах ажлыг нэгэн зэрэг хийх ёстой билээ.

“Орон нутгийн бие даасан байдлын тухай хууль”-д орон нутгийн засгийн газруудын хоорондох зөрчлийг шийдвэрлэх арга замуудыг үндэслэн зааж өгсөн байдаг. Нэгэнт орон нутгийн бие даасан байдал сэргэсэн тул орон нутгийн засгийн газрууд хоорондоо тодорхой хэмжээгээр зөрчилдөх нь байвч тэр хэрээр зөрчлийг шийдвэрлэх чадамж нь сайжирч байгаа билээ.

*Орон нутгийн санхүү, Төсөв ба нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо*

Солонгосын орон нутгийн засгийн газрууд нь жил тутмын төсвийн санхүүжилтээр хийж буй үр ашигтай төслийн ажлуудаараа оршин суугчдынхаа амьжиргааг дээшлүүлэхэд чухал хувь нэмрийг оруулж байгаа юм. Солонгосын орон нутгийн засгийн газруудын төсвийг гүйцэтгэх алба нь бэлтгэж, хууль гаргагчид нь тодорхойлдог.

Орон нутгийн засгийн газрын төсөв нь ерөнхий ба тусгай гэсэн хоёр төрлийн данстай. Орон нутгийн засгийн газруудын ерөнхий үүрэг, үйл ажиллагаа төсвийн ерөнхий дансанд багтана. Тиймээс, орон нутгийн засгийн газрын ихэнх үйл ажиллагаа **ерөнхий дансан дахь орлогоос санхүүжнэ**. Гэтэл зарим тодорхой үүрэг, үйл ажиллагааны тогтмол мөнгө санхүү болон тодорхой орлогын эх үүсвэрээс санхүүжүүлэх шаардлагатай байх тул түүний орлого ба зардлыг **тусгай дансанд** оруулдаг. Тэгэхээр зөвхөн нэг ерөнхий данс байдаг байхад орон нутгийн засгийн газруудын бусад төслүүдийг санхүүжүүлэх тухайд олон тооны тусгай данснууд байдаг байна. Солонгосын орон нутгийн засгийн газрууд нь удаан хугацааны туршид нягтлан бодох бүртгэлийн нэг оролт бүхий тогтолцоо ба бэлэн мөнгө суурьтай тогтолцоотой явж ирсэн байдаг. Ингээд 2000 оны орчимд орлого ба зардлыг илүү нарийн сайн тооцох үүднээс нягтлан бодох бүртгэлийн **давхар оролт бүхий тогтолцоо** болон аккруэл суурьтай нягтлан бодохын тогтолцоонд шилжсэн байна.

*Орон нутгийн төсвийн хувь хэмжээ, хуваарилалт*

Солонгос нь нэг нэгдмэл төртэй улс тул 1948 онд тусгаар тогтносон Солонгосын Засгийн Газрыг байгуулсан цагаасаа хойш орон нутгийн бие даасан байдлын түвшин нэлээдгүй дор байсаар ирсэн.
Орон нутгийн санхүү нь нэгдсэн схемээс харахад нийт улс үндэстний санхүүд төв засгийн газраас том биш байдаг. **Улсын төсөв нь төв засгийн газар, орон нутгийн засгийн газрууд ба орон нутгийн боловсрол гэсэн гурван хэсэгтэй.** Төсвийн хуваарилалтыг 2011 оны байдлаар үзвэл, төв засгийн газарт 56.0 хувь байгаа нь эдгээр гурав дотроо хамгийн том нь байгаа юм. Гэтэл орон нутгийн засгийн газруудад төсвөөс ногдох нь мөн 2011 оны байдлаар 33.5 хувь байгаа нь хоёрдугаарт орж байна. Харин орон нутгийн боловсролын төсөв нь тэргүүнүүд нь мээрээс ангид байдлаар сонгогддог сургуулийн дүүргүүдэд ногдоно. Гэхдээ төв засгийн газрын зардлыг үзэхэд мөн оны байдлаар дөнгөж 42.8 хувь ба, сүүлийн гурван жилийн хугацааны орон нутгийн засгийн газар ба орон нутгийн боловсролын төсвийн нэгдсэн дүнгээс улам бүр бага болсоор байгаа. Энэ нь төв засгийн газраас ихээхэн хэмжээний улсын орлогыг орон нутгийн засгийн газрууд болон боловсролын дүүргүүдэд орлогын хуваарилалт ба төсөлд суурилсан тэтгэмж хэлбэрээр шилжүүлсэнтэй холбоотой байдаг байна. Үүний үр дүнд орон нутгийн засгийн газрууд болон сургуулийн дүүргүүдийн төсвийн хувь хэмжээ нэмэгдэж, харин төв засгийн газрынх 2011 оны байдлаар 56.0 хувиас 42.8 хувь болж буурсан байна.

*Орлого ба зардал*

Орон нутгийн засгийн газрын **орлого нь** өөрийн эх үүсвэр бүхий ба төвөөс хамааралтай орлого гэсэн үндсэн хоёр эх үүсвэртэй. **Өөрийн эх үүсвэрийн орлогод нь орон нутгийн татвар ба татварын бус орлогууд ордог** бол т**өвөөс хамааралтайд нь орлогын хуваарилалт ба категорийн тэтгэлэг** зэрэг ордог юм.

Орон нутгийн засгийн газрууд нь өөрсдийн орон нутгийн татварын ба татварын бус орлогыг хүссэнээрээ захиран зарцуулна. Орон нутгийн засгийн газрууд орон нутгийн татвар ногдуулах эрх мэдэл бүхий байна. Энэ нь тэдний орлогын үндсэн эх үүсвэр юм. Татварын бус орлогод нь үйлчилгээний төлбөр гэх тэргүүтэн олон зүйлийн эх үүсвэр бүхий орлогууд багтана. Орлогын хуваарилалт гэдэг нь тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд захиргааны хэрэг явуулахад хэдий хэмжээний илүү орлогын хэрэгцээ байна вэ гэдгээр тооцож төв засгийн газраас хуваарилан өгч буй орлого юм.

Хэрэглээний хувьд ямарваа хориг байдаггүй тул энэхүү орлогын хуваарилалт нь орон нутгийн засгийн газруудын хувьд хамгийн таатай засгийн газар хоорондын орлогын төрөл зүйл байдаг байна. Үүний эсрэгээр категорийн тэтгэлгийг ямагт тодорхой нөхцөлүүд дагалдах ба, тэдгээрийг төв засгийн газар нь орлого хуваарилахад багтаадаг байна. 2011 оны байдлаар орон нутгийн орлогуудын нийт дүн нь 141 триллион (сая тэрбум) вон болж байлаа. Олон жилийн туршид орон нутгийн татвар нь орлогын хамгийн том эх үүсвэр болсоор ирэв. Хэрвээ орлогын хуваарилалт ба категорийн тэтгэлгийг төв засгаас хамааралтай орлогод оруулан үзвээс, тэдгээр нийтдээ бүх орлогын 40 хувь буюу орон нутгийн татварын орлогоос их болж байгаа юм.

2011 оны байдлаар, орон нутгийн татварын орлого нь бүх орлогын 35,3 хувь байсан бол орлогын хуваарилалт ба тэтгэлэг нь нийлээд 41,1 хувь болж байв. Үүнд их тодорхой ажиглагдаж байгаа зүйл бол категорийн тэтгэлгийн хувь хэмжээ жил ирэх тусам өсөж байгаа явдал юм. Энэ үзэгдлээс үүдэн орон нутгийн бие даасан байдлыг дэмжигчид орон нутгийн засгийн газруудад категорийн тэтгэлгийг хүссэнээрээ хэрэглэх эрх мэдэл өгөхгүй байна гэх болжээ. Үүнээс гадна төв засгийн газраас хатуу хянадаг тул орон нутгийн өрийг их бага хэмжээтэй барьж байдаг байна. Солонгосын орон нутгийн засгийн газрууд нь оршин суугчдадаа олон талын үйлчилгээг үзүүлдэг. Орон нутгийн бие даасан байдлын тухай хуульд зааснаар, орон нутгийн засгийн газрууд нь төсөв ба зардлын тэнцэтгэлийг сайтар хадгалах ёстой бөгөөд 2011 онд Солонгосын орон нутгийн засгийн газруудын төслийн орлого тогтмол 141 триллион вон байжээ.

Солонгосын орон нутгийн засгийн газруудын хамгийн том зардал бол нийгмийн хөгжилд зарцуулагддаг байна. Угтаа нийгмийн хөгжлийн зардлууд 2008- 2011 онд 2,9 хувиар өсөж нийт 28 триллион вон болсон нь 2011 оны нийт зардлын тавны нэг болсон юм. Харин тээвэр (замын хөдөлгөөн ба газар нутгийн) бүс нутгийн хөгжлийн зардал сүүлийн жилүүдэд 10,7 хувь, 8,3 хувь болтлоо буурсан байдаг. Дөрөвхөн жилийн өмнө эдгээр нь нийт зардлын 13,05 ба 10,3 хувь байсан юм.

*Орон нутгийн санхүүгийн бие даасан байдал*

Солонгос бол Японы колончлолоос чөлөөлөгдсөнөөсөө хойш Пруссын хууль зүйн уламжлалыг баримталдаг төвлөрсөн засаглал бүхий орон юм. Хэдийгээр орон нутгийн төлөөлөгчид сонгогдон гарч эхэлсэн 1991 оноос хойш төвлөрлийн хувь хэмжээ багассан боловч Солонгосын орон нутгийн засгийн газрууд төр захиргааны бүх тал дээр өнөө хэр нь маш хязгаарлагдмал бие даасан байдал бүхий хэвээр байна. Тэгэхээр орон нутгийн санхүүгийн хувьд мөн л ялгаагүй хэрэг. Орон нутгийн татварын орлого нь нийт улс болон

UILI.MN СУДАЛГААНЫ САН

орон нутгийн засгийн газруудын хураан төвлөрүүлдэг орлогын ердөө тавны нэг нь байдаг байна. Тийм ч учраас, Солонгосын орон нутгийн бие даасан байдлыг «тавны нэг» гэж нэрлэдэг аж. Тэдгээрийн өөрийн эх үүсвэрийн орлого нь 60 хувиас бага тул улсын засгийн газраасаа санхүүгийн хувьд ихээхэн хамааралтай. Бас категорийн тэтгэлгийн хувь хэмжээ жил ирэх тусам өсөж байгаа нь орон нутгийн засгийн газруудын санхүүгийн бие даасан байдлыг тэр хэрээр багасгаж байгаа юм.

Солонгос улсын Үндсэн хуульд "т***атвар болон үнэ ханшийг Үндэстний Асамблей буюу хурлаас батлан гаргасан хуулиар тогтооно***" хэмээн маш тодорхой заасан байдаг байна. Тэгэхээр орон нутгийн засгийн газрууд нь өөрсдийн санхүүгийн хэрэгцээнд тохируулан татварын орлогыг нэмэгдүүлэх эрх мэдэл багатай байдаг ажээ. Энэ нь орон нутгийн Зөвлөл, хурал нь татварын тогтолцоонд ямар ч шинэ татварыг нэвтрүүлэхгүй, бас орон нутгийн татварын хэмжээг өөрчлөхгүй, тийм эрх зүйн чадамжгүй гэсэн үг болно. Тодорхой хэлбэл, тэдгээр нь төв засгийн газрын бодлогын өөрчлөлтөөс ихээхэн хамааралтай ба, гол төлөв орон нутгийн орлогыг бууруулах үр дагавартай байдаг байна. Жишээлэхэд, Солонгосын үндэстний засгийн газар нь 2008 оны дэлхийн санхүүгийн хямралаас үүдэлтэй бууралтыг даван туулах үүднээс орлогын татварыг бууруулах шийдвэр гаргасан байдаг. Энэ нь зөвхөн нэг орон нутгийн засгийн газруудын төвийн орлогын татварын 1/10 болдог оршин суугчийн татварын орлогыг бууруулаад зогсохгүй, бас үндэстний дотоод татварын 19,24 хувь болдог орлогын хуваарилалтыг нь хүртэл бууруулсан юм.

Төв засгийн газар нь орон нутгийн засгийн газруудынхаа жилийн төсөв бэлтгэх гарын авлагыг гаргадаг. Хэдийгээр энэ нь 20 жилийн тэртээ орон нутгийн бие даасан байдлыг дөнгөж эхлүүлж байсан үеийнх шиг хэт дэлгэрэнгүй биш боловч, зардлын хяналт нь өнөө хэр идэвхтэй байдаг. Ялангуяа, орон нутгийн улс төрчдийн ёс суртахууны аюул эрсдэл өндөр үед бүр ч чанга хяналт тавьдаг байна. Мээр болон Зөвлөлийн гишүүдийн зардлууд, орон нутгийн иргэдийн бүлгүүдийг дэмжих гэх мэт олон зардлын нэгж үнийг төв засгийн газраас захирамжлан тогтоодог байна.

## ХОЁР. НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ХҮРЭЭНД ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

### 2.1 Нутгийн өөрөө удирдах ёсны үзэл санаа, тодорхойлолт

"Нутаг дэвсгэрийн тухайлсан нэгжид оршин суугч иргэд өөртөө хамаарах асуудлыг ардчилсан сонгуулиар байгуулсан төлөөллийн байгууллагаараа дамжуулан, өөрсдийн ашиг сонирхолд нийцүүлэн, байгаа хөрөнгө мөнгөнийхөө хэрээр, үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн зохицуулах эрхтэй. Энэ эрх мэдлийг "нутгийн өөрөө удирдах ёс" гэнэ.[36]

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Энэхүү ойлголтыг тодорхойлсон байдлыг авч үзье. Жишээлбэл:

– «Нутгийн өөрөө удирдах ёс нь тухайлсан удирдлагатай, нутаг дэвсгэртэй коммуны зүгээс хариуцлагыг бүрэн үүрч, төрийн хэргийн үлэмж хэсгийг тухайн нэгжид суугаа иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн хуулийн хүрээнд шийдвэрлэн хэрэгжүүлэх эрх–чадамж мөн» гэж "Нутгийн өөрөө удирдах ёсны Европын Харти"[37] –д өгүүлжээ.

[36]Б.Баттүвшин, Нутгийн удирдлагын практик асуудал, Konrad Adenauer Stiftung, УБ, 1999.
[37]1985.10.15 –нд Страсбургт баталсан (бүс нутгийн чанартай) эл баримт бичигт Европын Холбооны гишүүн орнууд нэгджээ.

- Торонто -гийн тунхаглалд[38] "нутаг дэвсгэрийн нэгжүүд өөрт хамаарах асуудлыг бүрэн хариуцаж, тухайн нутгийн оршин суугчдын эрх ашгийн үүднээс зохицуулан хянах эрх, үүргийг Нутгийн өөрөө удирдах ёс гэнэ" гэжээ.
- ХБНГУ –ын Үндсэн хуульд "нутаг дэвсгэрийн нэгж нь өөрийн газар нутаг дээрх бүх асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд бие даан шийдэх эрхтэй, үүрэгтэй" гэж заажээ. Энэ нь, засаг захиргааны нэгжийн удирдлага тухайн нэгжийн харъяа дэвсгэр нутаг дээр (төвөөс хараат бус) нутгийн өөрөө удирдах ёс зарчимд нийцүүлэн, хуулиар тодорхойлсон зааг дотор, өөрсдийн асуудлаа бие даан шийдэх эрх, үүрэгтэй" –г хэлж байна.
- ОХУ –ын хууль тогтоомжид тодорхойлсноор, "нутгийн өөрөө удирдах ёс (самоуправление)" гэдэг нь,
    - «орон нутгийн удирдлагын бие даан шийдэж байх асуудлын хүрээг конституц ба бусад хуулиар тодотгож олгосон эрх мэдэл[39];
    - нутгийн удирдлагын зүгээс өөрөө удирдах , ёс зарчмын дагуу хуулиар олгогдсон эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа[40];
    - ардчилсан ёс, зарчмын дагуу сонгогдож солигддог, нутгийн иргэдэд тайлагнаж, тэдний санал санаачилгыг үндэслэж ажилладаг, (засаг захиргааны нэгж дэх) төрийн ба нутгийн удирдлагын байнга хэрэгжүүлэх захиргаа, аж ахуй, боловсон хүчний болон бусад асуудалтай холбогдол бүхий шийдвэр гаргах практик үйлдэл[41]; юм.

Дээр дурдсан болон төсөөтэй тодорхойлолтууд цөөн бус. Товчдоо, өөрөө удирдах ёс гэдэг нь нутгийн удирдлага үйл ажиллагааныхаа чиг зорилгод хүрэх арга замыг төрийн ба нутгийн удирдлагын хамтын ажиллагааны арга механизмаар өөрөө бие даан тодорхойлдог, зарим тохиолдолд нийгмийн зөвшилцлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын баримтлах гол зарчим юм.

Нутгийн өөрөө удирдах ёс зарчмыг зөв зохистой төлөвшүүлэхгүй бол нийгмийн бүлэглэлүүдийн хэтийдсэн сонирхол, дур зоргыг өөгшүүлэх, улмаар төрийн байгууллын нэгдмэл чанарт гажилт үүсгэх, төрийн бүрэн эрх[42] үгүйсгэгдэх зэрэг зарим ноцтой сөрөг үр дагавар илрэх сөрөг үр дагавартай.

Нутгийн өөрөө удирдах ёс нь иргэдийн тулд, иргэдийн өргөн хэмжээний шийдвэрлэх оролцоотойгоор төр, нийгмийн үйл хэргийг удирдах (шийдэх) ардчилсан арга систем[43] мөн. Энд, нутгийн өөрөө удирдах ёсны мөн чанарыг тодорхойлохдоо "тухайн засаг захиргааны нэгж дэх ард иргэдийн хүсэл зоригийг нэгтгэн тодорхойлж, тэднийг нийгэм – улстөрийн амьдрал, улс хийгээд орон нутгийн аливаа асуудалд шийдвэрлэх нөлөөтэй оролцуулах боломжийг хангадаг улс төрийн системийн салшгүй хэсэг" гэж үзсэн байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[38]Канадын Торонто хотноо 1993.6.13 – 17 –нд хуралдсан Нутаг дэвсгэрийн нэгжийн олон улсын Холбооны дэлхийн XXXI Бага хурлаас батлан гаргасан "Нутгийн өөрөө удирдах ёсны олон улсын тунхаг" бичиг;

[39]Предоставленное Конституцией или иными государственными актами право местных органов власти самостоятельно решать круг вопросов, отнесенных к их компотенции;

[40]Деятельность местных органов власти по реализации предоставленных им полномочии самоуправления;

[41]Практика решения текуших административных, хозяйственных, кадровых иных вопросов государственными и общественными организациями, опирающаяся на демократические принципы выборности и сменяемости руководства на основе выборов, его подотчетности членом коллектива и по его инациативе;

[42]"Төрийн бүрэн эрх" ухагдахуун нь төрд ард түмнээс олгогдсон эрх мэдлийн тухай өгүүлдэг "төрийн эрх мэдэл" гэдгээс ойлголтоос зарчмын ялгаатай хэллэг юм.

[43]Г.Маналжав, "Хурал, өөрөө удирдах ёс", УБ, 2000.

### 2.2 Монгол Улсын Үндсэн хуульд засаг захиргааны нэгж, түүний удирдлагын талаар тусгасан байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн агуулгад нилээн дэлгэрэнгүй туссан конституцийн бүтэн нэг бүлгийг[44] дагнан ээлсэн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай асуудалд анхаарал хандуулъя.

Үндсэн хуулийн 2 дугаар зүйлд “Монгол улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана, Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна” гэж заасан. Төрийн байгууламж “нэгдмэл” байх нөхцөлд төрийн эрх барих дээд байгууллагын шийдвэр улс даяар шууд хэрэгждэг учраас улсын нутаг дэвсгэрийг зөвхөн засаг захиргааны нэгжид хувааж байгаа хэрэг. Энд туссан “зөвхөн” гэсэн тодотгол нь улсын хэмжээнд засаг захиргааны “өөр нэрийн нэгж байж болохгүй” –г хэлж буй хэрэг юм. Гэтэл засаг захиргааны тухайлсан нэгжийн харьяа нутаг дэвсгэр дээр тухайн орон нутагт хэрэг дээрээ захирагдахгүй өөр нэрийн бүтэц үүсэх, үүсгэх хэрэгцээ шаардлага тулгардаг, үүнийг тусгай хуулиар зохицуулж шийдээд явдаг. Үүнийг Үндсэн хуулийн зохицуулалттай холбож тайлбарлах шаардлагатай ч манай сэдвийн хүрээнд үл хамаарах асуудал гэж үзэв.

<u>Чөлөөт бүсийн тухай хуулиас ...</u>

- Чөлөөт бүсийн тухай Монгол Улсын хуульд тодорхойлсноор “чөлөөт бүс» нь тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн [нэг] хэсэг юм. Чөлөөт бүс нь улсын онцгой объектод хамаарна.
- Чөлөөт бүсийн захирагчийг эдийн засгийн хөгжлийн сайд томилж, чөлөөлнө. Чөлөөт бүсийн захирагч нь чөлөөт бүсэд төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн. Чөлөөт бүс бие даасан төсөвтэй, чөлөөт бүсийн захирагч ажлын албатай байна. Чөлөөт бүсийн төсвийн ерөнхийлөн захирагч нь чөлөөт бүсийн захирагч байна.
- Чөлөөт бүсийн захирагч нь тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь бүх талын дэмжлэг, үзүүлж хамтран ажиллана.

Үндсэн хуулийн 57 дугаар зүйлд:

- Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана;
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно;
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэж заасан.

“Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж” хэмээх ойлголтын талаар хуульчид, эрдэмтэд өөр өөрөөр тайлбарласан нь бий. Тухайлбал:

а) Үндсэн хуульд зааснаар, улсын нутаг дэвсгэр нь засаг захиргааны нэгжид хуваагдах тул

> “Улс орны нутаг дэвсгэрийг орон нутгийн удирдлагын зохион байгуулалтад тулгуурлан нэгж болгон хуваахыг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж гэнэ” хэмээсэн тодорхойлолтыг судлаач Д.Оюунтуяа “Нутгийн удирдлагын онол, практикийн асуудалд” өгүүлэлдээ томъёолсон. [“Нутгийн удирдлага” сэтгүүл, 2000, №1];

[44]Монгол Улсын Үндсэн хуулийн IV бүлэг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

b) Засаг захиргааны нэгж дэх өөрийн удирдлага бүхий зарим төвлөрсөн суурин газрыг аль болохоор нийгэм – эдийн засгийн цогцолбор байлгах талаас нь тусгайлан авч үзэх шаардлагын үүднээс хот, тосгоны эрх зүйн асуудал хөндөгддөг. Гэвч Үндсэн хуульд “зааснаар”, жишээ нь, 15000 –аас доошгүй оршин суугчтай засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж буюу эдийн засаг, нийгмийн нэн чухал холбогдолтой хотыг засаг захиргааны нэгж гэж үздэггүй нь зарим талаар ойлгомжгүй байдал үүсгэсээр ирсэнийг цаашид залруулбал зохих зохицуулалтын нэг юм.

> Нутгийн өөрөө удирдах ёсны үзэл санааны хөгжлийн түүхнээ, жишээ нь, Прусст 1808 онд гаргаж хэрэгжүүлсэн “Хотуудын үлгэрчилсэн дүрэм” –ээр “хот” –ыг (одоогийнхоор бол) засаг захиргааны нэгж гэж үзсэн байдаг.

c) Үндсэн хуулийн 58 дугаар зүйлийн 1 –т “Аймаг, нийслэл, сум дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн” гэсэн.

Эндээс харвал, “аймаг, нийслэл, сум, дүүрэг нь цогцолбор”, харин “баг, хороо нь засаг захиргааны нэгж” гэж ойлгогдохоор байна.”
Засаг даргатай, иргэдийн Нийтийн хуралтай засаг захиргааны нэгж – баг, хороо нь засаг захиргааны нэгж юм бол тэдгээрт заавал нутаг дэвсгэр (нутгийн хилтэй) байх ёстой гэсэн асуудлыг дэвшүүлж болох юм. Хорооны нутаг дэвсгэрийн хил хязгаарыг нийслэлийн дүүргүүд түүгээрээ шийдээд яваад байдаг, харин багийн нутаг дэвсгэрийн тухайд байдал бүрхэг талдаа байна.

Засгийн газрын ХЭГ –ын зарим мэргэжилтний өгүүлж байснаар, “засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж” л зөвхөн хилийн цэстэй байна, (зүгээр) “засаг захиргааны нэгж” –ийн тухайд хилийн цэс гэж ярих нь зөв биш гэх. Энд ойлголтын зөрүү илэрч байна [45] гэдгийг анзаарч болно. Үндсэн хуулийн 58 дугаар зүйлийн 2 –т, “аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална “ гэж заасан.

d) Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 1–т, “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ” гэжээ.

> “Дорнод Европын орнууд, хуучин ЗХУ –ын задралаас үүссэн шинээр тусгаар тогтносон Бүгд Найрамдах Улсууд болон Монгол дахь нийгмийн ардчилсан байгууллыг дэмжих Европын Холбооны санаачилга” – “Tasis” хөтөлбөр, Конрад Аденаурын Сангийн санхүүжилттэйгээр 1996 оноос монголд “Нутгийн өөрөө удирдах ёсны хөгжил” Дэд төсөл хэрэгжсэн. Төслийн эмхтгэлд, зохиогч Б. Баттүвшин Үндсэн хуулийн дээрх заалтыг “тунхаглал” гэж тэмдэглээд, энд , “төрийн удирдлага” гэж чухам юу болох, нутгийн өөрөө удирдах ёс гэж чухам юуг нэрлээд байгааг тодруулаагүй, хамгийн гол нь, тэдгээрийг хэрхэн хослуулах талаар үндсэн хууль тогтоогчид хэлэлгүй орхисон” гэж онцолжээ.

Засаглалын хамгийн зохистой хэлбэр “өөрөө удирдах ёс” –онд тулгуулана гэж үздэг. Удирдлагын “зэрэгцээ орших” субъектүүд, тэдгээрийн эрхийн ерөнхий тэнцвэрийг сайн хангаж өгөх шаардлага үүсдэг. Эсрэг тохиолд нэг нь нөгөөгөө үгүйсгээд байх боломж бий.

[45] Г.Чулуун – УИХ-ын Тамгын газрын референт

Нутгийн өөрөө удирдах ёсны олон улсын Тунхагт, “ нийтэд хамаарах үүрэг хариуцлагыг иргэдэд хамгийн ойр байгаа нутаг дэвсгэрийн байгууллага эдэлбэл зохино” гэсэн нь бий. Нутгийн өөрөө удирдах ёсыг тунхагласан эл баримт бичиг нь бүхэлдээ “нутгийн удирдлагын асуудал” –д зориулагдсан тул, “нутаг дэвсгэрийн байгууллага” гэдэг нь чухамдаа (манай) Хурлуудыг хэлсэн гэж үзэх үндэстэй юм. Олон улсад мөрдөж буй зарчмаар бол Хурлын эрх мэдэл Засаг даргынхаас дутуу байж болохгүй нь. Нутгийн өөрөө удирдах ёсны Европын Хартид “нутгийн өөрийн удирдлагын тогтолцоог хамгаалж, бэхжүүлэх нь эрх мэдлийн төвлөрөлийг сааруулж, улмаар Нэгдсэн Европыг байгуулахад чухал нөлөөтэйг онцлон тэмдэглэсэн байна.

“Сайн засаглал” –ыг нөхцөлдүүлэгч 9 гол шинжийн I –т “засаглалын үйл ажиллагаанд иргэдийн оролцоо идэвхтэй байх нь өөрөө удирдах ёсны байгууллагаар дамжуулан, иргэд нийгэм – эдийн засгийн үйл ажиллагаанд хамрагдах өргөн боломжтой байх” явдал юм” гэдгийг НҮБ –ын баримт бичгүүдэд дурдсан байдаг. “Сайн засаглал” бол “ардчилсан засаглал” мөн. Тиймээс, хаана өөрөө удирдах ёс жинхэнэ ёсоор хөгжинө, тэнд ардчилал тэр хэмжээгээр хөгжинө гэж хэлж бүрнээ болох юм.

е) Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 2 –т “Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн” гэж, 60 дугаар зүйлийн 1 –т, “Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ” гэж тус тус заажээ.

Үндсэн хуулийн 59 –ийн 2, 60 –ын 1 дэх заалтууд нь засаг захиргааны алив нэгжид «нутгийн удирдлага» (local governance), «төрийн удирдлага» гэсэн хосмол гэхээсээ илүү зэрэгцээ функциональ үүрэгтэй 2 байгууллага заавал оршин ажиллах ёстойг хэлжээ. Бодлого зөв байх, бодлогын нэр санаа зөв байхын ач холбогдлын жишээл болгож, төрийн бодлого тодорхойлогч байгууллагаас 2000.10.01–нд аймаг нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга нарыг хүлээн авч уулзахад яригдсан зарим зүйлээс эш татъя. Тэнд, “аймаг, сум, нийслэл, дүүрэг нь зөвхөн төрийн удирдлагын объект биш, тусгайлсан чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий эдийн засаг, нийгмийн цогцолбор, өөрөөр хэлбэл төр нийгмийн харилцааны бие даасан субъект болж өөрийгөө авч явах учиртай”гэж онцлон тэмдэглэсэн байна.

> Манайд, нутгийн удирдлагын чиг үүрэг, эрх мэдлийг тогтоосон агуулгатай нийт 80 гаруй хууль тогтоомж үйлчилдгийн дотор Хурлын болон Засаг даргын эрх хэмжээтэй холбогдсон заалт 2000 хол давжээ. Тэдгээрт, тухайлбал, аймаг нийслэл сум дүүргийн засаг дарга, ИТХ –д давхардуулан хамаатуулсан заалт их байдаг. (Удирдахуйн ухааны магистр Б. Шарбанди)

Засаг захиргааны нэгж дэх төрийн удирдлага нь хэрэгжүүлэлтийн аргын хувьд төв засгийн газраас (дээрээс) гарсан шийдийг доош доош нь шатлан проекцлох босоо хэв маягтай байдаг.
Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 1 –т “Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ; гэж заасан. Дээрх заалтаас, бүх шатны засаг дарга нар бол засаг захиргааны нэгжийн удирдлагын (зөвхөн) “төрийн

UIH.MN СУДАЛГААНЫ САН

удирдлага" талын төлөөлөгч гэдэг нь тодорхой байна. Үүнийг, Засаг дарга нь төрийн удирдлага талын хүмүүс болохоор засгаас, "дээд шатнаас" томилж байгаа хэрэг гэж үзэж болох ч, засаг захиргааны нэгж дэх төрийн ба нутгийн удирдлагын хүчний харьцааг "иргэдийн хуралд ашиггүйгээр" эвдсэн агуулгатай болсных нь хувьд буруушаах үндэслэлүүдийг гаргаж болдог.

> Үндэсний статистикийн газраас Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр 2000 онд "Иргэдийн амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх" чиглэлээр 7 аймаг, мөн Улаанбаатарыг хамруулж дэлгэрэнгүй судалгаа хийжээ. Тэнд "тухайн засаг захиргааны нэгж дэх хамгийн чухал албан газар" –ыг иргэдээр өөрсдөөр нь тодорхойлуулжээ. Хамгийн ач холбогдолгүй албан газраар Улаанбаатарт НИТХ –ыг нэрлэсэн байв. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг аймаг, нийслэл, сум, дүүргийн аль ч түвшинд "хамгийн хүртээмжтэй 5 байгууллага" –ын тоонд ер оруулаагүй нь анхаарал татахуйц байдлын тод жишээ юм. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хүртээмжийг иргэн бүр мэдэрдэг, үгүйлдэг болгох нь Засаг төрийн зүгээс явуулж буй төвлөрлийг сааруулах бодлогын үндсэн зорилт болж тавигдах учиртай.

Нутгийн өөрөө удирдах ёсны Европын Хартийн §3 –т, "сонгуулийн дүнд байгуулагдсан зөвлөл буюу хурал нь өөрт тайлагнадаг гүйцэтгэх байгууллагатай" байх тухай санаа туссан. Гэтэл манайд, "Монгол Улс дээрээ парламентын засаглалтай, доороо буюу орон нутагтаа Засаг дарга–ын засаглалтай" гэмээр байдалд явсаар байгааг иргэд шүүмжилдэг. Иргэдийн Нийтийн хурлаас сонгогдсон Хорооны Засаг даргыг дээд шатны засаг дарга нь хүлээж авахгүй байх тогтолцооны эх үндэс Үндсэн хууль руу явж очдог.

> АНУ –ын Үндсэн хуульд Холбооны Засгийн газарт олгогдоогүй ч муж улсуудад хориглодоггүй эрх мэдлийн тухай өгүүлсэн нь бий бөгөөд тэнд "… муж улс бүр Бүгд найрамдах засаглалтай …, Үндсэн хуулийн агуулгын нэг ч заалтыг муж улсын эрх ашигт хохирол учруулах байдлаар тайлбарлаж болохгүй" гэхчилэнгээр тодотгож өгсөн байдаг.

f) Үндсэн хуулийн 61 дүгээр зүйлийн 4 –т: Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь (түүний) Тамгын газар мөн. Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газар нэг маягаар тогтооно; гэжээ. Засаг захиргааны нэгж дэх нутгийн удирдлагын буюу Хурлын ажлын албаны талаар Үндсэн хуульд тусгаагүй бөгөөд Засаг даргын ажлын алба нь үндсэн хуулийн хуулийн статустай байхад, хурал талдаа эсрэгээр байж таарамгүй.

Үндсэн хуулийн 62 дугаар зүйлд,

- Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна;
- Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно; гэсэн.

Засаг захиргааны нэгж дэх Хурлууд нь Улсын Их Хурлын орон нутаг дахь "хөл" биш юм. Тэрээр өөрөө хуулийн хүрээнд "дээд эрх мэдэлтэй" байгууллага мөн. Хурал өөрт нь "шилжсэн үүргийг" (хэрэв шаардлагатай гэж үзвэл) шилжүүлэгч талын саналыг тооцолгүйгээр хэрэгжүүлэх эрхтэй байгууллага. Хурал эрх мэдлийнхээ

UIH.MN СУДАЛГААНЫ САН

хүрээнд шийдвэр гарган хэрэгжүүлэхдээ дээд газрын даалгаварыг биелүүлэгч зохион байгуулагчийн байр сууринд очиж болохгүй. Энэ нь шат шатны Засаг дарга, түүний ажлын албаныханд илүү хамаатай ажил юм.

**2.3 Засаг захиргааны нэгж дэх нутгийн удирдлагыг боловсронгуй болгох талаар гарсан зарим санал**

1998 оны намар «Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгоё» сэдэвт улсын зөвлөлгөөн Улаанбаатарт болсон. Зөвлөлгөөнөөс, засаг захиргааны нэгж дэх нутгийн удирдлагын талаархи хууль, тогтоомжийг яаж боловсронгуй болгох, орон нутгийн Хурлын эрх хэмжээг хэрхэн өргөтгөвөл зохилтойг тоймлож нэгтгэсэн дэлгэрэнгүй санал–зөвлөмж боловсруулан Улсын Их Хурал, Засгийн газарт уламжилсан байдаг. Тэнд,

1) Иргэдийн төлөөлөгчдийн хурлын байгууллагыг сонгох зарчмыг шинэтгэн өөрчлөх;
2) Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдла-гын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа, ИТХ –д холбогдох бүлэг асуудлыг тусад нь хууль болгон салгах талаар судалж үзэх;
3) Хурлын байгууллагад эдийн засаг, санхүүгийн үзэгдэхүйц эрх мэдэл олгож, орон нутгийн төсвийг ёс төдий хэлэлцэн баталдаг одоогийн (өнгөц) хэлбэр төдий эрхийг халж шинэчлэх; (Төсөв, татварын хуулиар орон нутгийн Хуралд олгосон чиг үүргийг өсгөн нэмэгдүүлж, орон нутгийн өмчийг захиран зарцуулах эрх хэмжээгээр хангах; г. м.)
4) Засаг захиргааны нэгж дэх төрийн удирдлагын ажлын алба, түүний дэргэдэх тохируулагч ба хэрэгжүүлэгч агентлагийн бүтэц, чиг үүрэг, ажиллах орон тоог Засгийн газраас тогтоосон чиглэлийн дагуу, тухайн орон нутгийн хэрэгцээ шаардлагыг тусгасан Засаг даргын саналыг тухайн шатны Хуралд оруулж шийддэг байхаар хуульчлан зохицуулах;
5) Орон нутаг дахь хүний нөөцийн менежментийн болон засаг захиргааны тухайн нэгжийн удирдлагын эрхлэх чиг үүргийн хүрээнд боловсон хүчнийг зохистой зөв байршуулахад шаардагдах эрх мэдлийг Хурлын байгууллагуудад олгох;
6) Хяналт, шалгалтын бүх шатны байгууллагыг Хурлын мэдэлд харъяалуулж, нутгийн удирдлагын хяналтын чиг үүргийг бэхжүүлж, өргөтгөх;
7) Ардчилал хөгжсөн улс орнуудын нийтлэг жишгийг харгалзан, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын нэгдмэл сонирхлыг төлөөлөн илэрхийлж ажилладаг Монголын нутгийн удирдлагын холбоог бэхжүүлэх эрх зүйн зохицуулалт хийх, орон нутгийн удирдлагын чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн онол – арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх зарим тодорхой чиг үүргийг Төрийн бус байгууллагын хуулийн дагуу Нутгийн удирдлагын хол-боогоор гэрээлэн гүйцэтгүүлэх замаар үйл ажиллагааг санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх;
8) Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хандалт (санал хүсэлт) –ыг шуурхай авч үзэж, цаг алдалгүй шийдэж хариу өгч байх, Хурлуудаас хуулийн хүрээнд гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх (өөрөө удирдах ёсны байгууллагын шийдвэр тэр бүр хэрэгжих баталгаагаар хангагдаагүй байдлыг арилгах) –д дэмжлэг үзүүлэх, Хурлын байгууллагуудын ажилтнуудыг гадаад, дотоодод давтан сургаж дахин бэлтгэх ажлыг байнгын болгож сайжруулах; г.м. –ээр дурдсан нь олон зүйлс одоо ч ач холбогдолтой хэвээр байна.

Засаг захиргааны нэгж дэх нутгийн удирдлагын эзлэх байр суурь төрийн удирдлагатай “зэрэгцэн хутгалдах” хэлбэрээр бус, харин, хуулийн хүрээнд түүнтэй нэг чигт бүтээлчээр хамтран ажиллах замаар бэхжих учиртай. Ингэхийн тулд, засаг захиргааны нэгжийн нутгийн удирдлага талд “үзэгдэхүйц эрх мэдэл”, “үйл ажиллагааны өөрийн талбар” бий болгох хэрэгтэй.

IIHE.MN СУДАЛГААНЫ САН

Засаг захиргааны нэгжийн удирдлагын “өнөөдрийн” хэлбэрийг практик талаас нь харвал “засаг даргын эрх мэдэл зонхилсон” байдал харагддаг. Орон нутагт төрийн удирдлага илт давамгайлаад, “нутгийн удирдлага” байр сууриа зохих ёсоор бэхжүүлж чадахгүй байна.

Монголын төрийн байгууламж нэгдмэл тул “орон нутгийн төр” гэж ярих бичих боломгүй. Орон нутагт “тэндэхийн төр” үгүй тул хэлбэрийн хувьд “төрийн эрх барих байгууллага” –ыг дуурайсан үнэмлэхүй эрхтэй “орон нутгийн парламент” бас зонхилох байдалд оршиж болохгүй. Ингээд, засаг захиргааны нэгжийн удирлагын чиг үүрэг “хуваагдмал мөртөө нэгдмэл” байх тийм арга механизмын эрэл хайгуулыг заавал хийх болдог. Үүнийг Үндсэн хуулийн агуулгын хүрээнд боловсронгуй болгож шийдэх хэрэгцээ тулгамдсан байдалтай оршиж байна.

Нутгийн удирдлагын “талынхан” өөрийнхөө ажлын талбарыг ажиглалт туршлагын үндсэн дээр олж таньж мэдээд, бодит үйл ажиллагааг хэрэгжүүлэх “тодорхой бүрэн эрхийн хойноос эрчимтэй хөөцөлдөж” байгааг шийдвэр гаргагч нарын зүгээс анхаарч үзэх нь зөв болов уу. Тэд тухайн асуудлын өрнөлтийн хэв төлөвийг шинжихдээ “бодлого зөв ч, хэрэгжилт нь хэвшихгүй байна” хэмээн зовинож, эцсийн эцэст “төвлөрөл саарах биш гаарах вий” хэмээн болгоомжилдог байна.

**2.4 Нутгийн удирдлагын байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаар**

Засаг захиргааны нэгжийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэгч үндсэн 2 субъект болох төрийн ба нутгийн удирдлагын талуудын хариуцах ажил үйл хоорондоо тов тодорхой заагтай, тэд бие биенээ нөхдөггүй, орлон ажилладаггүй байх учиртай юм.

Төрийн удирдлага талын эрхлэх ажлын удирдамж ерөнхийдөө төв засгийн газраас буюу “дээрээс бэлнээр зааварчлан өгөгддөг”, тодорхой байдаг тул түүнийг үл өгүүлэн, харин, нутгийн өөрөө удирдах зарчмын дагуу гарсан “доороос эхтэй” иргэдийн хандалтын санааг Хурлын байгууллагууд хэрхэн зангидаж, бүлэглэн нэгтгэж үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд холбогдох зарим асуудлаас дурдъя.

Орон нутагт ч өөрийн гэсэн хэм хэмжүүртэй “улстөр” бийг судлаачид нотолсон нь олонтаа. Орон нутгийн “улстөр”–ийн өрнөх талбар нь чухамдаа Иргэдийн төлөөлөгчдийн хурлууд юм. Орон нутгийн хурлын байгууллагуудыг “захиргаа” –ны буюу түүнтэй ижилтгэсэн үүрэг функцтэй байх мэтээр ташаа ойлгох нь уг чанартаа орон нутгийн улстөрийг үгүйсгэсэн, ардчилсан ёс зарчимд харш үйлдэл байх болно.

Орон нутагт “улстөр” оршин байдаг нь маргаангүй тул тэнд нутгийн хэмжээний “улстөрийн бодлого” явагддаг байж таарах нь. Чухам ямар ямар чиглэлээр гэхээр, тэдгээр нь, улс үндэстний түвшинд дээр орших “нэгдмэл төр” –ийн бодлоготой зарчмын хувьд ижил төс бүхий бүрдэл хэсэгтэй байна. Жишээ нь,

- засаг захиргааны нэгжийн хөгжил – төлөвлөлтийн (эдийн засгийн) бодлого;
- хүн ам зүйн бодлого;
- нийгэм – соёлын бодлого;
- хүний нөөцийн удирдлага, зохицуулалтын бодлого;
- санхүү, төсвийн бодлого г.м.

Нутгийн өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааны дотоод бүтэц дээр дурдсантай төсөөтэй салбар чиглэлээр хуваагдах бололцоотой бөгөөд Хурлуудын дотоод зохион байгуулалтын бүтэц ч эндээс тодорхойлогдохоор байна. Нийгмийн ардчилсан тогтолцоотой улс орон бүр “нутгийн өөрөө удирдах ёсыг заавал хөгжүүлэх үүрэг” –тэй болдгийн учир нь,

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- хүний эрх, эрх чөлөөг хамгаалах буюу тухайн нутагт иргэд амар амгалан аж төрөх, аж ахуй эрхлэх тааламжтай нөхцөлөө өөрсдөө бүрдүүлэх боломжийг нээж өгөх;
- төр, засгийн зүгээс авч хэрэгжүүлэх нийгэм эдийн засгийн (болзошгүй зарим) алдаатай бодлогын золиос болох заналаас ард иргэд өөрсдийгөө хамгаалах чадамжтай байх нөхцлийг хангах; явдалд оршино.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ, ЭХ СУРВАЛЖ


- Монгол Улсын Үндсэн хууль.
- Б.Баттүвшин, Нутгийн удирдлагын практик асуудал, Konrad Adenauer Stiftung, УБ, 1999. Г.Маналжав, “Хурал, өөрөө удирдах ёс”, УБ, 2000.
- Канадын Торонто хотноо 1993.6.13 – 17 –нд хуралдсан Нутаг дэвсгэрийн нэгжийн олон улсын Холбооны дэлхийн XXXI Бага хурлаас батлан гаргасан “Нутгийн өөрөө удирдах ёсны олон улсын тунхаг” бичигв“Төрийн бүрэн эрх” ухагдахуун нь төрд ард түмнээс олгогдсон эрх мэдлийн тухай өгүүлдэг “төрийн эрх мэдэл” гэдгээс ойлголтоос зарчмын ялгаатай хэллэг юм.
- Constitution of the Republic of Korea
- A Comparative Analysis of Recent Trends Concerning the Efficiency of Local Self-Government, International Association of Schools and Institutes of Administration. http://unpan1.un.org/
- Division of Power Between National, Regional and Local Authorities: Government and Electoral System – Introduction. http://www.cesifo-group.de/
- European Charter on Local Self-government, 1985. http://conventions.coe.int/
- Report on European Practice and Recent Developments in the Field of Regional Self-government, Council of Europe, http://www.migm.gov.tr/AvrupaKonseyi/Ek39.pdf
- Local Government and Public Administration in Korea. https://hufsiss.files.wordpress.com/
- Local autonomy act. http://elaw.klri.re.kr/eng_mobile/


UIH.MN СУДАЛГААНЫ САН

ХАВСРАЛТ 1.

**2001 оноос хойш Европын зарим гишүүн орнуудын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль эрх зүйн зохицуулалтад нутгийн удирдлагын асуудлаар орсон өөрчлөлтүүд[46]**

| ***Улс орны нэр*** | ***Шинэтгэлийн явц – үе шат*** | ***Төв болон орон нутгийн засгийн газрын хоорондын харилцаанд нөлөөлөхүйц Үндсэн хуулийн өөрчлөлтүүд*** | ***Нутгийн удирдлагын байгууллагуудын асуудлаар Үндсэн хууль, тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлт орсон эсэх*** | ***Нутгийн удирдлагатай холбоотой эрх зүйн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт орсон эсэх*** | ***Нутгийн удирдлагатай холбоотой томоохон өөрчлөлт, шинэтгэл*** |
|---|---|---|---|---|---|
| **Австри** | Амжилттай хэрэгжиж дууссан | | Тироль болон Зальцбургийн Ландер *(Lander)*-ийн Үндсэн хуульд Ландерийн холбогдох парламентын засгийн газрын сонгуулийн тогтолцоог өөрчлөх өөрчлөлт оруулсан (пропорциональ тогтолцооноос мажоритари тогтолцоонд шилжих) | | |
| | Амжилтгүй болсон | Австрийн Конвенц *(Austrian Convention)* төв болон орон нутгийн санхүүжилтын харилцаа болон удирдлагыг томилох асуудал | | | |
| **Бельги** | Амжилттай хэрэгжиж дууссан | Өмнө нь холбооны түвшинд харьяалагддаг байсан эрх мэдлийг орон нутгуудад шилжүүлэх | Германчууд олноор оршин суудаг газар нутгийн нутгийн удирдлагын эрх мэдлийг нэмэгдүүлэх | | |
| **Болгар** | Амжилттай хэрэгжиж дууссан | | | 2005 оноос хойш Болгарын 6 төлөвлөлтийн бүс нутгийн *(planning region)* дүүргийн удирдлагын бүтцэд Техникийн туслалцаа, бүс нутгийн төлөвлөгөө болон хөтөлбөрийг зохион байгуулах болон удирдах Директорат *(Directorate)* байгуулагдсан. | |

[46] www.migm.gov.tr/AvrupaKonseyi/Ek39.pdf . pp.126-149.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Хэлэлцэж байгаа | (Тодорхой бус) Болгарын нутгийн удирдлагын бүх түвшнийг шинэчлэх | | | |
| **Чех** | Амжилттай хэрэгжиж дууссан | Чехийн бүс нутгуудыг Үндсэн хуульд нутаг дэвсгэрийн дээд нэгж хэмээн тодорхойлсон | Бүсийн Зөвлөлүүд нь өөрсдийн нэрийг өөрчлөх эрхтэй болсон | | |
| | Одоо явагдаж байгаа | | | Хяналт, мониторингийн системийг шинэчлэх | |
| **Дани** | Амжилттай хэрэгжиж дууссан | | | 2007 онд нутгийн болон бүсийн удирдлагын шинэтгэл | |
| **Финланд** | Одоо явагдаж байгаа | | | | Каинуу бүсэд ердийн зөвшөөрөгдсөн эрхээс илүү эрхийг олгох туршилтын хуулийн төсөл |
| **Франц** | Амжилттай хэрэгжиж дууссан | | Бүс нутгуудын эрхийг үндсэн хуулиар баталгаажуулсан, Гадаад дахь бүс нутгуудад өөрийн хууль тогтоох эрх олгосон | Төвөөс бүс нутагт дараах эрхийг шилжүүлсэн. Үүнд: эдийн засгийн хөгжил, төлөвлөлт, боловсрол болон соёл зэрэг асуудлаар. Бүсүүд нь Европын эрсдэл бууруулах сан /European structural fund/-ийн зарцуулах эрхтэй болсон | |
| **Герман** | Амжилттай хэрэгжиж дууссан | Холбооны засгийн газар болон Ландерийн эрх мэдлийг хуваарилах үндсэн хуулийн шинэчлэл 2006 онд амжилттай хэрэгжиж дууссан | | | |
| **Унгар** | Амжилтгүй болсон | | Тодорхой бус | Холбогдох хууль эрх зүйн зохицуулалтад нэмэлт өөрчлөлтөөр бүсийн засаг захиргааг байгуулах асуудал Парламентын олонхын санал авч чадаагүй (2/3) | |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Литва** | Амжилттай хэрэгжиж дууссан | | | | Нутгийн болон бүсийн удирдлагын томилох асуудал шийдэгдсэн |
| **Нидерланд** | Амжилттай хэрэгжиж дуссан | | | 2003 онд орон нутгийн удирдлагын "дуализаци"-ийн хууль хэрэгжиж эхэлсэн | |
| **Португали** | Одоо явагдаж байгаа | | | | Бүс, орон нутгийн санхүүжилтийн тухай хууль |
| | Хэлэлцэж байгаа | Төв болон орон нутгийн удирдлагын техник болон санхүүгийн хамтын ажиллагааны шинэ тогтолцоо | Хотын бүс *(metropolitan area)* -ийн эрх үүргийг тодорхойлж, тогтоосон шинэ загвар | Төв засгийн газраас орон нутгийн засгийн газарт эрх мэдэл шилжүүлэх эрх зүйн актын төсөл | |
| **Испани** | Амжилттай хэрэгжиж дууссан | | Валенсия-гийн автономит статус тогтоох асуудлыг шийдвэрлэсэн | | Ерөнхийлөгчдийн Бага хурал /Засгийн газар болон Автономит Холбоод/-ыг хамтын ажиллагааны дээд байгууллагаар тогтоосон. Автономит Холбоод нь ЕХ-ын Сайд нарын зөвлөл болон тэдгээрийн ажлын хэсгийн уулзалтад оролцох эрхтэй болсон |
| | Амжилтгүй болсон | | Баск тойргийн автономит статус | | |
| **Их Британи** | Амжилттай хэрэгжиж дууссан | Уэльсийн засгийн газрын тухай хууль *(Government of Wales Act)* хууль тогтоох эрх нэмэгдсэн | Уэльсийн засгийн газрын тухай хууль *(Government of Wales Act)* хууль тогтоох эрх нэмэгдсэн | Уэльсийн засгийн газрын тухай хууль *(Government of Wales Act)* хууль тогтоох эрх нэмэгдсэн | |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХАВСРАЛТ 2.

**Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн өнөөгийн байдал, бие даасан, хараат бус байдлын үнэлгээний асуудлаар өнгөрсөн хугацаанд дотоод болон гадаадын судалгааны байгууллагуудын хийж гүйцэтгэсэн зарим судалгааны жагсаалт**

| | ***Судалгааны нэр*** | ***Гүйцэтгэсэн байгууллага, он*** | ***Цахим эх сурвалж*** |
|---|---|---|---|
| 1 | Хариуцлагатай төр: Санхүүгийн төвлөрөл, нутгийн өөрөө удирдах ёс – Форумын эмхтгэл | Нээлттэй нийгэм форум, 2008 | |
| 2 | Local Governance in Developing Countries | World Bank, 2006 | http://elibrary.worldbank.org/doi/book/10.1596/978-0-8213-6565-6 |
| 3 | Local Governance in Industrial Countries | World Bank, 2006 | http://siteresources.worldbank.org/PSGLP/Resources/LocalGovernanceinIndustrial.pdf |
| 4 | Үндэсний ба нутгийн удирдлагын чиг үүргийн зохистой хуваарилалт -Бодлогын судалгаа | Нээлттэй нийгэм форум, 2005 | http://www.forum.mn/res_mat/chig_yyreg_maket.pdf |
| 5 | Монголын нутгийн удирдлагын өнөөгийн төлөв байдал – Судалгааны тайлан | Нээлттэй нийгэм форум, 2003 | http://www.forum.mn/res_mat/Local_Authority.pdf |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ТӨРИЙН АЛБАНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

*Г.Билгээ, Д.Жигваагүнсэл,*
*Ө.Мөнхтунгалаг, Р.Нургүл*

## ОРШИЛ

Судалгаанд захиалагчийн хүсэлтийн дагуу Австрали, Азербайжан, Герман болон Франц зэрэг улсуудын төрийн албаны эрх зүйн зохицуулалттай холбоотой дараах асуудлуудыг хамруулав. Үүнд:

- Төрийн албаны харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн орчин,
- Төрийн албаны төв байгууллага, түүний бүтэц, орон тоо, харьяалал,
- Төрийн албаны дарга, орон тооны гишүүдийг санал болгодог субъект,
- Төрийн албаны зэрэг дэв, сонгон шалгаруулалт,
- Төрийн албаны тангараг,
- Төрийн албан хаагчийг ажлаас халах үндэслэл,
- Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм.

### *Судлагдсан байдал*

Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтсээс Монгол Улсын болон гадаадын зарим орны төрийн албатай холбоотой хэд хэдэн судалгаанууд хийсэн байна. Үүнд:

| № | Судалгааны ажлын нэр | Код | “Судалгааны эмхэтгэл” цуврал ботийн дугаар |
|---|---|---|---|
| 1 | Төрийн албан хаагчдын ёс зүйн асуудлаарх хэвлэлийн нийтлэлийн контент-анализ | СТ-09/307 | **1** |
| 2. | Төрийн албан тушаалд тавих шаардлага, болзолын тухай | СТ-09/302 | 2 |
| 3. | Авилга, төрийн албаны хүнд суртал, төрийн албан хаагчийн ашиг сонирхолын зөрчлийн асуудлаар Монгол Улсад 2005-2009 онуудад хийгдсэн судалгааны тойм | СТ-09/306 | 2 |
| 4. | Төрийн албан хаагчийн ангилалын тухай | СТ-09/417 | 4 |
| 5. | Улс төрийн сонгуулийн нөлөөгөөр төрийн албан хаагчийг өөрчлөх, чөлөөлөх асуудал, төлөв байдал | СТ-10/208 | 5 |
| 6. | Төрийн албаны үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд нийгмийн аудитын үүрэг | СТ-10/214 | 5 |
| 7. | Төрийн албаны тогтолцоо, шинэтгэлийн талаарх бусад орнуудын туршлага ба Монгол Улсын нөхцөл байдал | СТ-12/220 | 14 |
| 8. | Төрийн албан хаагчдын цалин, хөлс, нийгмийн баталгааны талаарх гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт, туршлага | СТ-14/204 | 17 |
| 9. | Төрийн албан хаагчийн баталгааг хангах чиглэлд үйлчилж буй хууль эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилтийн байдал | СТ-14/405 | 17 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## 1. АВСТРАЛИ УЛС

Австралийн төрийн алба гэдэгт 1999 оны “Төрийн албаны тухай хууль” (Public service Act 1999[47])-ийн дагуу ажилд орсон бүх хүнийг хэлдэг.

### 1.1. Төрийн албаны төв байгууллагын бүтэц, орон тоо, зохион байгуулалт, хаана харьяалагддаг талаар[48]

Австралийн төрийн албаны төв байгууллага нь Австралийн төрийн албаны комисс (APSC) байдаг бөгөөд энэ нь **Ерөнхий сайд ба түүний кабинетын бүрэлдэхүүнд** багтдаг төв агентлаг юм. Комисс нь дараах эрхэм зорилгын хүрээнд төрийн албаны үнэ цэнийг эрхэмлэн Австралийн төрийн албыг нэгдсэн бөгөөд өндөр түвшинд удирдан, ажилладаг байна.

*Эрхэм зорилго*Төрийн албаны комиссын эрхэм зорилго нь Австралийн төрийн албыг нэгдсэн бөгөөд өндөр түвшинд удирдан, хэлбэржүүлэхэд оршино. Үүний тулд Төрийн Албаны хуульд тодорхойлсон эрхэм зорилго ба дараах зорилтуудыг дэмжин биелүүлэхэд чиглэнэ:

- Австралийн төрийн албаны үнэ цэнийг агентлагууд хэдий хэмжээгээр баримтлан нийцэж буйг үнэлж цэгнэх;
- Австралийн төрийн албаны ёс зүйн дүрмийн биелүүлэлтийг баталгаажуулахын тухайд агентлагуудын тогтолцоо ба үйл ажиллагааны чадавхыг үнэлэх;
- Австралийн төрийн албаны үнэ цэнэ ба ёс зүйн дүрмийг сурталчлах;
- Австралийн төрийн албаны ажил эрхлэлтийн бодлого ба практикийг хөгжүүлэх, сурталчлах, нягтлах, үнэлэн дүгнэх;
- Нийт төрийн албаны боловсон хүчний менежментийг байнга сайжруулж байх нөхцөлийг бүрэлдүүлэх;
- Австралийн төрийн албаны сургалт ба карьерын хөгжлийг зохицуулан дэмжих;
- Австралийн төрийн албанд манлайллыг хөгжүүлэх ба хувь нэмэр оруулах, хүссэн үед нь агентлагуудад төрийн албаны асуудлаар зөвлөх ба туслах;
- Үнэ цэнийг хамгаалах комиссарт бие даасан, хөндлөнгийн үнэлгээ дүгнэлт хийх үйл ажиллагааг нь хангах юм.

*Бүтэц*

Австралийн Төрийн албаны тухай хуульд /Public service Act 1999/ “Австралийн төрийн алба нь агентлагийн дарга ба ажиллагсдаас бүрдэнэ” гэж ерөнхий заасан. Энэ нь холбооны бүх яам, шүүх, зарим Засгийн газрын агентлагт ажиллагсдыг оруулж байна. Энэ хуульд зөвхөн төрийн захиргааны байгууллагуудад ажиллагсдын асуудлыг тусгасан бөгөөд улс төрийн болон үйлчилгээний албаны талаар тусгаагүй.

2009-2010 оны санхүүгийн жилд 164,596 төрийн албан хаагч дээрх хуулийн хүрээнд ажиллаж байна. Эдгээрийн 150,871 нь байнгын, 13,725 нь гэрээт ажилтан байна. Хамгийн том агентлаг нь 27,312 хүнтэй Centrelink буюу хөдөлмөр, халамжийн агентлаг, Австралийн татварын алба 24,070, Батлан хамгаалах яам 21,458 хүнтэй байна.

Австралийн яамдын тэргүүн нь Төрийн нарийн бичгийн дарга – хувийн сектор дахь гүйцэтгэх захиралтай адил юм. Төрийн нарийн бичгийн дарга нар нь Засгийн газрын бодлогын талаар Сайдад зөвлөгөө өгдөг үндсэн зөвлөх бөгөөд яамны гүйцэтгэх аппаратыг тэргүүлнэ.

[47]www.comlaw.gov.au/Series/C2004A00538
[48]www.apsc.gov.au/about-the-apsc/the-public-service-commissioner

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Төрийн нарийн бичгийн даргын орлогч, Төрийн нарийн бичгийн даргын тэргүүн туслахууд, Төрийн нарийн бичгийн даргын туслахууд, захирлууд, туслах захирлууд, мэргэжилтнүүд гэж байна.

Засгийн газраас Ерөнхий сайдад төрийн албаны талаар туслах Сайдыг томилдог. Төрийн албаны комиссыг Комиссар толгойлох бөгөөд энэ алба нь дээр дурдсанчлан Австралийн төрийн албаны үнэт зүйлсийг сурталчилж, үйлчилгээний гүйцэтгэл, хэрэгжилтэд үнэлгээ хийх, үйлчилгээний чадавхыг сайжруулахад тусалж ажиллах үүрэгтэй.

Комиссар нь Төрийн албаны тухай хуульд /Public service act 1999/ заасан эрх мэдэл эдлэхээс гадна Бодлогын чиглэлийн үүргийг мөн хүлээдэг байна. Засгийн газар мөн яамдын төрийн нарийн бичгийн дарга нар Австралийн нийтийн /төрийн/ албаны манлайлалд чухал үүрэг гүйцэтгэдгийг Засгийн газар хүлээн зөвшөөрдөг**.** Тухайн байгууллага дахь хүний нөөцийг хариуцсан ажилтан нь яамдад Төрийн нарийн бичгийн дарга, бие даасан агентлагуудад тусгай томилогдсон дарга нар байдаг.

Тэдний үүрэг, үйл ажиллагааны талаар Төрийн Албаны Хууль 1999 (the PS Act) -ийн 41 (1) ба 50 (1) хэсгүүдэд тус тус заасан байдаг.

*Төрийн албаны комиссын бүтэц:*

Австралийн Төрийн албаны комиссыг Төрийн Албаны комиссар, Төрийн Албаны Орлогч комиссар, Үнэ Цэнэ Хамгаалах комиссар, Ажил Эрхлэлтийн Ерөнхий Менежер гэсэн 4 гүйцэтгэх албаны хүмүүс удирдах бөгөөд гүйцэтгэх бүлэг нь тус байгууллагыг стратегийн удирдлага ба чиглэлээр хангана.

Гүйцэтгэх бүлгийн харьяанд тус тусын менежерийн удирдлагад ажилладаг 8 бүлэг байх ба, тэдгээр нь комиссын үүрэг, үйл ажиллагааг дэмжиж, Гүйцэтгэх бүлэгтээ тайлагнана.

Дараах бүдүүвчээр комиссын байгууллагын бүтцийг харуулсан болно.

**Бүдүүвч 1. Төрийн албаны комиссын бүтэц**




UIH.MN СУДАЛГААНЫ САН

Эдгээр 8 бүтцийн нэгж нь  нь дараах үүрэгтэй байдаг байна. Үүнд:

***1. Үйлчлүүлэгчтэй уулзах бүлэг (Client Engagement):*** Энэ бүлэг нь комиссын зүгээс үйлчлүүлэгчидтэй уулзаж харилцах стратегийг удирдан чиглүүлэх бөгөөд үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлон, түүнд тохирсон менежментийг хийх үүрэгтэй. Тус бүлэг нь комиссыг Канберрагаас гадна төлөөлөх ажлын менежментийг хийж, комиссын Удирдах бүлгийн хамтаар Австралийн төрийн албадуудын хоорондох харилцааг хангахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Тус бүлэг комиссын гадаад харилцааны, тухайлан Ази Номхон далайн орнуудтай харилцах харилцааг хариуцна. Энэ нь ажил олголтыг өөрчлөх, сайжруулах, менежментийн гүйцэтгэл, шинээр эхлүүлэх ба өөрчлөх үйл явцууд ба тэдгээрийн практик зэрэгтэй холбоотой стратегийг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй.

***2. Үйл ажиллагааны бүлэг (Corporate Group):*** Энэ бүлэг нь комиссын хүний капиталын менежментийн ба ажиллах хүчний хөгжлийг баталгаажуулах ба удирдлагаар хангах, төсөв ба санхүүгийн менежмент, эд хөрөнгийн үйлчилгээ, бичиг хэрэг хөтлөлтийн менежмент, яамд болон парламентын үйлчилгээ, мэдээлэл -харилцааны технологи ба төслийн менежмент зэрэг үйл ажиллагаануудыг дэмжин ажиллана. Энэ нь бас Нарийн Бичгийн Дарга нарын УЗ-ийг дэмжих тусгайлсан үүрэгтэй ба, APS 200 ба бүхэл шинэтгэлийн мэдээллийн үүрэг бүхий байна.

***3. Ажил эрхлэлтийн бодлогын бүлэг:*** Ажил эрхлэлтийн бодлого ба оролцооны бүлэг нь Австралийн төрийн албаны гүйцэтгэх ажилтнууд болон бусад бүх ажлуудыг оролцуулан ажил эрхлэлтийн хууль зүй ба бодлогын хүрээнд зөвлөх үүрэгтэй. Энэ бүлэг нь уугуул иргэдийн ажил эрхлэлтийн хөтөлбөрүүд, Австралийн төрийн албаны комиссын бүс нутгийн төлөөлөгчдийн сүлжээ, Австралийн засгийн газрын манлайлан удирдах сүлжээ ба NSW, Vic, Tas, Өмнөд Австрали ба Баруун Австрали дахь Хүний менежментийн сүлжээ зэргийг хариуцна.

***4. Ёс зүйн бүлэг:*** Энэ бүлэг нь Австралийн төрийн албаны ёс зүй ба үнэнч шударга байдлын тал дээр зөвлөх ба Австралийн төрийн албаны үнэ цэнэ ба ёс зүйн дүрмийг нээлттэй, ил тод бөгөөд агентлагийн шийдвэрийг шуурхай байлгах тал дээр дэмжин урамшуулна. Бас Төрийн албаны комиссарын ба Үнэ цэнийн комиссарын бүлгүүдийн үйл ажиллагааг нягтлах ба лавлах ажлыг хийж дэмжинэ. Энэ бүлэг бүхэл төрийн албаны Ёс зүйн Зөвлөлийн албыг хангах ба одоогоор Австралийн төрийн албаны үнэ цэнийг сайжруулах төсөл дээр ажиллаж байна.

***5. Хүний капиталын судалгаа ба үнэлгээний бүлэг:*** Энэ нь комиссын Австралийн төрийн албаны шинэтгэлийг удирдах, хэлбэржүүлэх байр суурийг хадгалах үүднээс баримтад суурилсан хүний нөөцийн удирдлагын сэтгэлгээнд голчлон анхаарах явдлыг ханган биелүүлнэ. Хүний нөөцийг стратеги хараатайгаар төлөвлөх, хүний нөөцийн оюун ухаан ба зөн хараа, хүний нөөцийн хэмжүүр ба стандарт, Австралийн төрийн албаны ажиллах хүчний төлөвлөлт, судалгаа, үнэлгээ зэргийн чадавхыг сайжруулах ба хөгжүүлэх ажлыг хариуцна.

***6.Цалин урамшууллыг шийдвэрлэх тамгын газар (Remuneration Tribunal Secretariat):*** Энэ нь Цалин урамшуулал шийдвэрлэх албаны Ерөнхийлөгч ба гишүүдийг нарийн бичгийн үйлчилгээгээр хангана.

UILI.MN СУДАЛГААНЫ САН

***7. Манлайлал, сургалт, хөгжлийн стратегийн төв:*** Энэ бүлгийг 2010 оны 7-р сард Австралийн төрийн албыг сургалт, хөгжил, манлайллын хөгжил ба авьяасын менежмент зэргийг орчин цаг үетэйгээ хөл нийлсэн системтэй арга хандлага бүхий байх явдлыг баталгаажуулах үүднээс Австралийн төрийн албаны комиссын бүрэлдэхүүн дотор үүсгэн байгуулсан. 2013 оны 3-р сараас эхлэн энэхүү Стратегийн төв нь Австралийн уугуул иргэдийн ажил эрхлэлт ба ур чадварын стратегийн ажлыг хариуцах болжээ.

Австралийн төрийн албаны ажлын байрны ур чадвар ба олон талт байдлыг хэлбэржүүлэн туслах үүднээс Стратегийн төв нь:

- Жил тутмын Австралийн төрийн албаны Манлайлал ба Ур чадварын стратегийн үндэслэн одоогийн болон ирээдүйн чадварын шаардлагуудыг тодорхойлох
- авьяасын менежмент, сургалтын хөтөлбөрүүд, зөвлөгөө ба дэмжлэгээр дамжуулан манлайллыг сайжруулах
- Австралийн төрийн албаны сургалт ба хөгжлийн зөвлөгөө ба үйлчилгээг санал болгох
- Австралийн төрийн албаны өмнөөс уугуул иргэдийн төлөөллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажил эрхлэлтийн үйлчилгээний цар хүрээг удирдан чиглүүлнэ.

***8. Ажлын газрын оролцооны бүлэг:*** Энэ бүлэг нь Австралийн төрийн албаны ажиллах хүчний оролцооны стратегийг Австралийн төрийн албаны эрэлт хэрэгцээ ба засгийн газрын ажлын байрны өргөн цар хүрээ бүхий зорилтуудтай нийцүүлэн удирдах үүрэгтэй. Үүнд бас ажил эрхлэх эрх тэгш боломж; гэрээ байгуулах, цалин хөлс ба ажлын нөхцөл зэргийг удирдан зохион байгуулах хариуцлага багтана.

### 1.2. Төрийн албаны зэрэг, дэв, сонгон шалгаруулалт

Төрийн албаны сонгон шалгаруулалтыг төрийн албаны комиссоос явуулах ба Агентлаг нь харилцан адилгүй өөр ангилал шатлалын, аль эсвэл нэгэн ангиллын олон ажлын байранд сурталчилгаа хийж сонгон шалгаруулж авах ажлыг нэгэн удаагийн сонгон шалгаруулалтаар хийж болно. Үүнийг гагцхүү сонгон шалгаруулах шалгуур нь ижил төстэй тохиолдолд зохион байгуулна. Өөрөөр хэлбэл, хэдийгээр өөр өөр салбарын ажил боловч гүйцэтгэх үүрэг хариуцлага нь ижил ур чадвар шаардаж байх гэсэн үг юм.

Хэрвээ сонгогдсон цөөн тооны өргөдөл гаргагчид нь хоёр түвшний аль алинд нь эсвэл бүх түвшинд өргөдөл гаргаагүй бол түүнийг зөвхөн өөрийн нь өргөдөл гаргасан шатлалын ажил албанд хамаатуулан сонгон шалгаруулна.

Агентлагууд нь доод шаталбарт өргөдөл гаргагчийг дээд шаталбарын шалгуурт оролцуулан үнэлэн дүгнэхээс зайлсхийх ёстой.

Хэрвээ өргөдөл гаргагч нь дээд шатны ангилалд өргөдөл гаргаагүй бол тэрээр түүнд оролцож болохгүй. Ямарваа үнэлгээ шалгаруулалтыг хийхийн өмнө өргөдөл гаргагчдаас бүх шатны сонгон шалгаруулалтад хамрагдах уу, үгүй юу гэдгийг нь асууж болох юм. Гэхдээ энэ нь ямар нэг байдлаар дэмжиж байгаа эсвэл таатай нөхцөлөөр хангаж байгаа хэрэг биш юм. Учир нь өргөдөл гаргагчдад адил боломжтой байх ба хэнийг нь ч бусдаас нь онцгойлон үзэж үнэлэхгүй бөгөөд бүх хүсэлт ба хариултыг бичгээр баримтжуулна.

*Ерөнхий сонгон шалгаруулалт (Generic selection criteria)*

Аливаа агентлаг нь өөрийн тухайлсан ажил үүрэгтэй хамааралтай ажлын байранд ерөнхий сонгон шалгаруулалтын шаардлагуудыг боловсруулан үйлдэж болно. Тухайлсан нэг ажил үүрэг эсвэл ажлын байрны шаардлагыг тусгайлан боловсруулж болох юм.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Тэгэхээр өргөдөл гаргагчид тэрхүү агентлагийн тухайлсан ажил үүрэгтэй холбоотой тусгай шалгуурт сонгон шалгаруулалтад бас оролцох юм. Үүнд өргөдөл гаргах хоёр нийтлэг арга зам бий. Тухайлбал, сонгон шалгаруулалтын үед өргөдөл гаргагчид ерөнхий болон тусгайлсан бүх шалгуурт тэнцэх ёстой.

Ажлын байр бүрийн ерөнхий ба тусгайлсан шалгууруудтай харгалзуулан үнэлэх замаар үнэ цэнийн ангиллыг боловсруулсан байна. Жишээлэхэд, хүний нөөцийн үнэ цэнийн ангилал, Санхүүгийн үнэ цэнийн ангилал, Бодлогын үнэ цэнийн ангилал гэх мэт. Ингээд өргөдөл гаргагчдыг тэдгээрийн тохирч буй эсэхээр сонгон шалгаруулна. Мөн шалгаруулалтаас хойш 12 сарын хугацааны дотор ижил төстэй ажлын боломж гарвал зохилдох ажлын салбарын үнэ цэнийн ангиллаас сонгож болно.

Ерөнхий сонгон шалгаруулалтын шалгуураар урьдчилан сонгох ажлыг хийж, үүний үр дүнгээр өргөдөл гаргагчдыг ангилан зэрэглэнэ. Жишээлэхэд, «онцгой сайн», «сайн тохирч байгаа», «тохирч байгаа» гэхчлэн ангилна. Хэрвээ боломж гарваас, өргөдөл гаргагчдыг ерөнхий болон тусгай шаардлагууд, бас боловсруулагдсан үнэ цэнийн ангиллын дагуу үнэлэн шалгаруулна.

### 1.3. Төрийн албаны комиссын дарга, орон тооны гишүүдийг хэн санал болгодог

Төрийн албаны комиссын дарга буюу комиссарыг Засгийн газрын тэргүүн томилох бөгөөд 5 жилийн бүрэн эрхийн хугацаатай томилдог. Комиссар нь Ерөнхий сайдын санал болгосноор, комиссын гишүүнд туслах нэг буюу хэд хэдэн тусгай Комиссарыг томилж болно.

### 1.4. Төрийн албаны тангараг, ямар албан хаагч өргөдөг

Австралид төрийн албанд ажиллагсад тангараг өргөдөггүй харин төрийн албаны үнэ цэнийг заавал эрхэмлэн биелүүлэх шаардлага тавьдаг.

***Австралийн төрийн албаны үнэ цэнэ:***

- Улс төрөөс хараат бусаар өөрсдийн чиг үүргээ мэргэжлийн түвшинд биелүүлэх,
- Энэ нь нийтийн алба бөгөөд ажилд авахдаа мерит тогтолцоонд үндэслэнэ,
- Ялгаварлан гадуурхахаас ангид ажлын байр бөгөөд Австралийн нийгмийг олон үндэстний гэдгийг хүлээн зөвшөөрнө,
- Хамгийн өндөр ёс суртахууны стандарттай байна,
- Засгийн газар, Парламент, Австралийн олон нийтэд Сайдын хариуцлагын хүрээнд өөрсдийн үйл ажиллагаанд ил тод байна,
- Засгийн газарт ил тод, үнэн бодит, дэлгэрэнгүй, иж бүрэн, нарийн, цаг үедээ нийцсэн зөвлөгөө бэлтгэж өгөх, Засгийн газрын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй,
- Австралийн олон нийтэд шударга, үр ашигтай, бүрэн үйлчилгээг хүргэнэ,
- Чанарын өндөр манлайлалтай байх, Үүнд:
    - Харилцах, зөвлөлдөх, хамтран ажиллах гэсэн ажлын байрны харилцааг үүсгэх бөгөөд ажилтнуудаас тэдний ажиллах нөхцлийн талаарх саналыг хүлээн авна,
    - Шударга, уян хатан, аюулгүй, үр ашигтай ажлын байрыг бэлтгэж өгнө,
    - Үр дүнд хүрэхэд төвлөрөх бөгөөд хэрэгжилтийг удирдана,
    - Ажилд авахад тэгш боломжийг дэмжинэ,
    - Австралийн нийтийн албанд ажилд орох өргөдөл гаргахад нийгмийн бүхий л гишүүдэд харьцангүй бүх боломжийг бий болгох,
    - Австралийн Засгийн газрын ардчилсан тогтолцооны үр ашгийг дэмжих зорилгоор карьерт суурилсан нийтийн алба байна.

UIII.MN СУДАЛГААНЫ САН

### 1.5. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм (Code of Conduct)[49]

Австралийн төрийн албан хаагчийн баримтлах ёстой ёс зүйн дүрэм нь:

- Австралийн төрийн албанд үнэнч шударга зүтгэнэ;
- Австралийн төрийн албыг анхаарал сэрэмжтэй бөгөөд хянамгай сайн гүйцэлдүүлнэ;
- Австралийн төрийн албыг эрхлэхдээ хэнийг ч үл тоож болохгүй, хүн бүртэй хүндэтгэлтэй, эелдэг сайхан харилцана;
- Австралийн төрийн албаны аливаа ажил эрхлэлтийн үйл хэргийг Австралийн хууль эрх зүйд нийцүүлэн явуулна;
- Алба хашиж буй агентлагийн албан тушаалтны өгсөн хууль зүйтэй нийцсэн бөгөөд учир үндэслэл бүхий тушаал захирамжийг даган биелүүлэх;
- Сайд эсвэл Сайдын ажлын хэсгийн гишүүнтэй холбогдсон аливаа үйл хэргийг зохистой нууцлалыг хадгалах;
- Ямарваа ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх алхмуудыг авч хэрэгжүүлэх ба, өөрийн төрийн албыг хашихдаа хувийн ямарваа материаллаг сонирхлыг таягдан хаяна.
- Зөв зорилгын тухайд Хамтын нийгэмлэгийн орнуудын эх сурвалжийг зөв хэлбэрээр ашиглах;
- Австралийн төрийн албаны ажил хэрэгтэй холбоотойгоор мэдээлэл хүссэн тохиолдолд буруу эсвэл төөрөгдүүлэх мэдээллийг өгөхгүй байх;
- Өөрийн ажил албыг эрхлэх явц, байр суурь, эрх мэдлийн хүрээний дотоод мэдээллийг буруу ашиглахгүй байх:
    - өөртөө болон өөр бусад хэн нэгэнд ашиг тус эсвэл давуу талыг олох буюу олгох, эсвэл завдах;
    - өөрийн ажиллаж буй агентлаг, Commonwealth эсвэл хэн нэгнийг хохироох шалтгаан болох эсвэл завдах.
- Аль ч цаг үед Австралийн төрийн албаны үнэ цэнэ ба Ажил эрхлэлтийн зарчмуудыг баримталж, өөрийн ажиллаж буй агентлаг ба Австралийн төрийн албаны нэр хүндийг өндөрт өргөн ажиллана;
- гадаадад алба хаших үедээ, ямагт Австралийн сайн нэр хүндийг өргөхүйцээр биеэ авч явах;
- тэрчлэн хууль дүрэмд заасан ёс зүйн холбогдол бүхий бусад шаардлагуудыг даган биелүүлэх зэрэг болно.

### 1.6. Төрийн албан хаагчийг ажлаас халах үндэслэл, хариуцлага

Төрийн албан хаагчийг ажлаас халах үндэслэл, хариуцлагын талаар Төрийн албаны тухай хууль (Public service act, 1999)-ийн 5.47, 6.54-т тус тус заасан байна. Тухайлбал, 6.54-д:

- комиссарыг сэтгэцийн чадваргүй (ground of misbehaviour or physical or mental incapacity) гэдэг нь тогтоогдвол,
- тэтгэврийн насанд хүрсэн бол,
- өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх өргөдлөө өгсөн тохиолдолд ажлаас чөлөөлнө.

Дараах тохиолдолд ажлаас халана. Үүнд:

- дампуурагч болох нь тогтоогдвол,
- төлбөрийн чадваргүй зээлдэгч зээлээ төлөхийн тулд хууль бус үйл ажиллагаа хийсэн;
- түүний хамтран зээлдэгч бол,
- төрийн албаны ёс зүйн дүрэм ноцтой зөрчсөн нь тогтоогдсон бол, зэрэг болно.

[49]Regulations available on the Com Law. www.apsc.gov.au/aps-employment-policy-and-advice/aps-values-and-code-of-conduct/code-of-conduct

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## 2. АЗЕРБАЙЖАН УЛС

Азербайжаны ***Төрийн албаны хууль***[50] төр, төрийн албан хаагчийн хоорондох харилцаа болон төрийн албан хаагчийн эрх зүйн асуудлыг зохицуулна.

### *2.1. Хуулийн хамрах хүрээ*

Энэ хууль нь гүйцэтгэх, хуулийн, шүүх байгууллагын албан хаагчдад хамаарна. Прокурорын байгууллага, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, онцгой байдал, хилийн алба, цагаачлалын алба, дотоод хэрэг, гааль, татвар, гадаад хэрэг болон *field-chasseur*-ийн алба, Үндэсний банк зэрэг нь төрийн онцгой албанд хамаардаг тул өөр хуулиар зохицуулагдана. Харин эдгээр байгууллагад *(Үндэсний банк орохгүй)* ажилладаг, цэргийн болон бусад тусгай зэрэг цолгүй, мэргэжлийн зэрэг дэвгүй үйлчлэгч, цэвэрлэгч, цэцэрлэгч, манаач, харуул зэрэг ажилтнуудад энэ хууль хамааралтай.

Азербайжан Улсын Ерөнхийлөгч, Мили Межлис буюу парламентын гишүүд, Ерөнхий сайд, түүний орлогч, шүүхийн шүүгчид, Хүний эрх буюу Омбудсмены бүрэн эрхт төлөөлөгч *(Attorney of the Republic of Azerbaijan for Human Rights)*, гүйцэтгэх засаглалын төв байгууллагын тэргүүн болон дэд тэргүүн, Сонгуулийн төв хорооны дарга, орлогч, нарийн бичгийн дарга, Санхүү бүртгэлийн танхимын *(Chamber of Accounts)* аудиторууд, орон нутгийн гүйцэтгэх байгууллагын тэргүүнүүд, Нахчываны Автономит Бүгд Найрамдах Улсын Дээд Межлисын гишүүд, Нахчываны Автономит Бүгд Найрамдах Улсын Ерөнхий сайд, түүний орлогч, Нахчываны Автономит Бүгд Найрамдах Улсын гүйцэтгэх засаглалын төв байгууллагын тэргүүнүүд, түүнчлэн цэргийн албан хаагчдад энэ хууль хамаарахгүй.

Мөн улсын үйлдвэрийн ажилтнуудад хамаарахгүй *(Хөдөлмөрийн хуулиар зохицуулна).*

### *2.2. Төрийн албаны төв байгууллагын бүтэц, орон тоо, зохион байгуулалт, хаана харъяалагддаг талаар*

Төрийн албаны төв байгууллага нь Ерөнхийлөгчийн дэргэдэх ***Төрийн албаны комисс*** (*Civil Service Commission)* юм. Төрийн албаны комисс нь Ерөнхийлөгчид шууд харъяалагддаг бөгөөд комиссын даргыг Ерөнхийлөгч томилдог. Комисс нь дарга, орлогч дарга, тамгын газрын дарга, нарийн бичгийн дарга гэсэн удирдлагын бүрэлдэхүүнтэй. Хүний нөөцийн хэлтэс, мэдээлэл технологи ба программ хангамжийн хэлтэс, хуулийн хэлтэс, гадаад харилцааны хэлтэс, санхүү эдийн засгийн хэлтэстэй.

Түүнээс гадна ***Төрийн албаны удирдлагын зөвлөл*** *(Civil Service Management Board)* ажилладаг бөгөөд 18 гишүүнтэй, Ерөнхийлөгчөөс 6, Мили Межлисээс (*парламент*) 6, Үндсэн хуулийн цэцээс 6 гишүүнийг тус тус томилдог. Зөвлөл нь төрийн бус байгууллага бөгөөд өндөр түвшиний зөвлөх байгууллага юм. Түүний гол зорилго *Төрийн албаны тухай* хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох хууль эрх зүйн акт болон төрийн албаны арга зүйн удирдамж боловсруулах явдал юм. Зөвлөлийн эрх, үүргийг журмаар зохицуулна *(хуулийн 5 дугаар зүйл)*.

### *2.3. Төрийн албаны сонгон шалгаруулалт*

Төрийн албыг захиргааны болон туслах алба гэж ангилна. Захиргааны албанд 5-р зэрэглэлийн төрийн дээд байгууллага болон тэдгээрийн хэлтэс албадын дарга, орлогч нар, түүнчлэн төрийн албаны сонгон шалгаруулалтаар орсон мэргэжилтнүүд зэрэг албан тушаал хамаарна. Харин эдгээр байгууллагын техник үйлчилгээний ажлыг эрхэлдэг бичиг

[50]Law of the Republic of Azerbaijan on Civil Service.

UUL.MN СУДАЛГААНЫ САН

хэргийн ажилтан, бичээч, архивийн ажилтан, жолооч зэрэг ажилтнууд төрийн туслах албанд хамаарна *(хуулийн 10 дугаар зүйл)*.

Төрийн албанд болзол, шаардлага хангасан 16 ба түүнээс дээш насны, Азербайжан хэлийг төгс эзэмшсэн Азербайжаны иргэн орох эрхтэй. Үндэс угсаа, шашин шүтлэг, хэл, соёл, хүйс, олон нийтийн байгууллагын гишүүнчлэл, нийгмийн гарал үүсэл, итгэл үнэмшил зэргээр нь ялгаврлан гадуурхахыг хуулиар хориглосон.

Төрийн албанд сонгон шалгаруулалтаар орох ба өрсөлдөх зарчмаар явагдана. Сонгон шалгаруулалтыг хэрхэн явуулдаг талаар үзье *(хуулийн 28 дугаар зүйл)*.

- Төрийн албаны комисс төрийн захиргааны 5-7 дугаар ангиллын албан тушаалд сонгон шалгаруулалт зарлана. Хуулинд өөрөөр заагаагүй бол хүйс заахыг хориглоно.
- Сонирхсон иргэн сонгон шалгаруулалт зарлагдснаас хойш 30 хоногийн дотор материалаа ирүүлэх бөгөөд цахимаар, цаасан хэлбэрээр байж болно.
- Шалгалт тест, ярилцлага гэсэн 2 шаттай явагдана. Тестийн шалгалтын хариу ажлын 10 хоногт гарах ба амжилттай өгсөн хүн дараагийн шат буюу ярилцлагад орно.
- Хуулинд өөрөөр заагаагүй бол, нэгдсэн дүн гарсны дараа ажлын 5 хоногт шалгарсан хүмүүсийн материалыг төрийн байгууллагын удирдлагад танилцуулна.
- Байгууллагын удирдлага материал хүлээн авснаас хойш ажлын 10 хоногт шийдвэр гаргах ба шалгарсан хүмүүсээс сонголт хийж, тухайн албан тушаалд 1 жилийн хугацаатай дадлагажигчаар ажиллуулна. Энэ талаар Төрийн албаны комисст эргээд хариу мэдэгдэнэ.
- Удирдлагын шийдвэрээр дадлагжигчийг байгууллагын нэг ажилтанд даалган ажиллуулах ба дадлагажих хугацааны туршид дадлагажигчийн ажлыг удирдан чиглүүлж, хяналт тавьж ажиллана. Хугацаа дуусахад түүний ажлыг үнэлж, цаашид ажиллах эсэхийг шийдэх ба хангалттай үнэлгээ авсан тохиолдолд, хуулинд өөрөөр заагаагүй бол, гэрээ байгуулж 6 сар туршилтын журмаар ажиллуулна. Гэрээнд туршилтын хугацаанд ажиллах нөхцөлийг тодорхой заана.
- Туршилтын хугацаанд гэрээ зөрчихгүй, сайн ажиллавал байгууллагын удирдлага тушаал гаргаж байнгын ажилтнаар авах ба түүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулна. Төрийн албанд ажиллах болсныг баталгаажуулж байгууллагаас үнэмлэх олгоно.

Төрийн албаны төв байгууллагын 5-7 дугаар ангиллын захиргааны албан тушаалд анх орж байгаа хүнд дадлагжих болон туршилтын хугацаа мөн адил хамааралтай.

Хэрэв дадлагажигч дадлагажих хугацаанд дахин төрийн албаны шалгалтанд орж тэнцээд, шинэ ажилд томилогдвол өмнөх дадлагажсан хугацааг хэвээр тооцож дадлагажих хугацааг үргэлжлүүлнэ. Туршилтын хугацаанд дахин төрийн албаны шалгалт өгч тэнцээд, шинэ ажилд томилогдсон бол мөн адил буюу өмнөх туршилтын хугацааг тооцож үргэлжлүүлнэ.

Төрийн албанд ажиллаж байгаа хүнийг шинэ албан тушаалд, мөн төрийн албанаас чөлөөлөгдсөн хүнийг эргээд төрийн албанд томилоход дадлагажих болон туршилтын хугацаа хамаарахгүй.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

“Залуусыг 2007-2015 онуудад гадаадад сургаж, боловсрол эзэмшүүлэх хөтөлбөр”-т хамрагдсан хүнийг нөөцөд шууд бүртгэнэ. Сонгон шалгаруулалт явагдах үеэр тэдний материалыг төрийн байгууллагад танилцуулж санал болгодог.

### *2.4. Төрийн албан хаагчийн мэргэжлийн зэрэг дэв*

Төрийн захиргааны албыг дотор нь 8, туслах албыг 4 ангиллалд хуваах *(хуулийн 11 дүгээр зүйл)* ба уг ангиллын дагуу албан тушаалын мэргэжлийн зэрэг дэвийг ангилдаг.

Захиргааны албан тушаалын мэргэжлийн зэрэг дэвийг дараах байдлаар ангилна *(хуулийн 16 дугаар зүйл)*:

**Хүснэгт 1 . Захиргааны албан тушаалын мэргэжлийн зэрэг дэвийн ангилал**

| № | *Захиргааны албан тушаалын ангилал* | *Мэргэжлийн зэрэг дэв* |
|---|---|---|
| 1. | Захиргааны дээд зэрэглэл | төрийн жинхэнэ зөвлөх *(actual state counselor)* |
| | | 1-р зэргийн төрийн зөвлөх |
| | | 2-р зэргийн төрийн зөвлөх |
| 2. | Захиргааны I | 1-р зэргийн төрийн зөвлөх |
| | | 2-р зэргийн төрийн зөвлөх |
| | | 3-р зэргийн төрийн зөвлөх |
| 3. | Захиргааны II | 2-р зэргийн төрийн зөвлөх |
| | | 3-р зэргийн төрийн зөвлөх |
| | | төрийн албаны тэргүүн зөвлөх |
| 4. | Захиргааны III | төрийн албаны тэргүүн зөвлөх |
| | | төрийн албаны зөвлөх |
| | | төрийн албаны бага зөвлөх *(junior civil service counselor)* |
| 5. | Захиргааны IV | төрийн албаны зөвлөх |
| | | төрийн албаны бага зөвлөх *(junior civil service counselor)* |
| | | 1-р зэргийн төрийн албан хаагч |
| 6. | Захиргааны V | төрийн албаны бага зөвлөх *(junior civil service counselor)* |
| | | 1-р зэргийн төрийн албан хаагч |
| | | 2-р зэргийн төрийн албан хаагч |
| 7. | Захиргааны VI | 1-р зэргийн төрийн албан хаагч |
| | | 2-р зэргийн төрийн албан хаагч |
| | | 3-р зэргийн төрийн албан хаагч |
| 8. | Захиргааны VII | 2-р зэргийн төрийн албан хаагч |
| | | 3-р зэргийн төрийн албан хаагч |
| | | бага төрийн албан хаагч *(junior civil servant)* |

Төрийн туслах албаны мэргэжлийн зэрэг дэв дараах байдлаар ангилагдана *(хуулийн 16 дугаар зүйл)*:

**Хүснэгт 2. Туслах албан тушаалын мэргэжлийн зэрэг дэвийн ангилал**

| № | *Туслах албан тушаалын ангилал* | *Мэргэжлийн зэрэг дэв* |
|---|---|---|
| 1. | Туслах алба I зэрэглэл | төрийн албаны тэргүүн референт |
| | | төрийн албаны ахлах референт |
| | | 1-р зэргийн төрийн албаны референт |
| 2. | Туслах алба II | төрийн албаны ахлах референт |
| | | 1-р зэргийн төрийн албаны референт |
| | | 2-р зэргийн төрийн албаны референт |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| 3. | Туслах алба III | 1-р зэргийн төрийн албаны референт |
| | | 2-р зэргийн төрийн албаны референт |
| | | 3-р зэргийн төрийн албаны референт |
| 4. | Туслах алба IV | 2-р зэргийн төрийн албаны референт |
| | | 3-р зэргийн төрийн албаны референт |
| | | төрийн албаны бага референт *(junior civil service referent)* |

Төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдэл болон бусад шагнал урамшуулал, тэтгэлэг тэтгэмжийн хэмжээ албан тушаалын мэргэжлийн зэрэг дэвээс хамаардаг.

### *2.5. Төрийн албаны тангараг*

Төрийн албанд орохдоо: *"Бүгд Найрамдах Азербайжан Улсын төлөө үнэнч байж, Үндсэн хуулийг эргэж буцалтгүй даган мөрдөж, төрийн болон албаны нууцыг чанд хадгалж, төрийн албаны эрх үүргээ зөвхөн хуулийн дагуу, шударгаар, итгэл дүүрэн, бүх хүч чадлаа дайчлан биелүүлж, эх орныхоо эрх ашгийн төлөө ажиллахаа тангараглаж байна"* хэмээн тангараг өргөдөг *(хуулийн 15 дугаар зүйлд)*.

Тангаргыг Азербайжан Улсын далбаан дор, Үндсэн хуулин дээр гараа тавиад ёслол төгөлдөр өргөнө. Зөвхөн захиргааны албан хаагч өргөх бөгөөд нэг л удаа өргөнө. Харин төрийн туслах албанд ороход тангараг өргөхгүй. Төрийн албан хаагч нь бичмэл тангарагт гарын үсэг зурах ба түүнийг хувийн хэрэгтэй нь хамт хадгална.

Тангараг нь төрийн албаны онцлогоос хамааран өөр байж болох ба түүнийг хуулиар зохицуулдаг.

### *2.6. Төрийн албан хаагчийг ажлаас халах үндэслэл, хариуцлагын талаар*

Төрийн албан хаагч нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсвэл эрхээ хэтрүүлэн хэрэглэж хууль зөрчсөн бөгөөд энэ талаар хуулинд өөрөөр заагаагүй бол сахилгын хариуцлага хүлээнэ *(Хуулийн 25 дугаар зүйл)*. Сахилгын хариуцлага хүлээлгэхэд дараах арга хэмжээг авна. Үүнд:

- сануулах;
- цалинг 1 жилийн хугацаатай 5-30 хувь хүртэл бууруулах;
- ижил ангиллын, бага цалинтай албан тушаалд шилжүүлэх;
- албан тушаал бууруулах;
- мэргэжлийн зэрэг дэвийг бууруулах;
- төрийн албанаас халах.

Хэрэв төрийн албан хаагчид сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл байгаа бол байгууллагын даргын шийдвэрээр шалгах бөгөөд төрийн албан хаагч бичгээр тайлбар өгнө. Шаардлагатай гэж үзвэл байгууллагын дарга шийдвэр гарган, шалгалт хийх баг томилж ажиллуулна. Төрийн албан хаагч тайлбар бичихээс татгалзсан тохиолдолд татгалзсан тухай тэмдэглэх ба энэ нь сахилгын шийтгэл хүлээлгэхэд саад болохгүй. Үндэслэл, шалтгааныг тогтоосноос хойш сарын дотор төрийн албан хаагчид сахилгын арга хэмжээ авна. Сахилгын арга хэмжээг байгууллагын удирдлага ногдуулах ба зөвхөн сануулах арга хэмжээг л удирдлагаас эрх олгосон ажилтан авч болно.

Шийтгэлтэй байх хугацаанд ажлын шугамаар гадаад явах, ээлжийн амралт, хөдөлмөрийн чадвараа түр алдах, мөрдөн байцаалтад байх хугацаа зэргийг сахилгын шийтгэлийн хугацаанд оруулахгүй.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Төрийн албанд хориглосон үйлдлүүд буюу хуулийн 20 дугаар зүйлд заасныг зөрчсөн, мөн албан үүргээ удаа дараа биелүүлээгүй, ноцтой алдаа гаргасан тохиолдолд ажлаас халах арга хэмжээ авна.

Хэрэв төрийн албан хаагч нь сахилгын хариуцлага хүлээлгэх тухай шийдвэрт гомдолтой байвал шийдвэр гарснаас хойш ажлын 7 хоног дотор зохих хууль журмын дагуу байгууллагын удирдлагад гомдол гаргана. Удирдлага ажлын 10 хоног дотор гомдлыг авч үзээд, шийдвэрийг хүчингүй болгоно, эсвэл хэвээр үлдээнэ.

Төрийн албан хаагчийн хууль зөрчсөн үйлдлээс үүдэлтэй материаллаг хохирлыг хуулийн дагуу өөрөөр нь төлүүлж барагдуулна.

Төрийн албан хаагч нь "*Авлигын эсрэг хууль*"-ийн 5.1 дүгээр заалтыг, мөн "*Төрийн албаны хууль*"-ийн 9 дүгээр зүйлийг зөрчсөн бөгөөд энэ нь захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол сахилгын хариуцлага хүлээнэ.

Хэрэв төрийн албан хаагчийн гаргасан зөрчил сахилгын хариуцлагаас хэтэрсэн, илүү ноцтой бол хуулийн дагуу захиргааны, эсвэл эрүүгийн хариуцлага хүлээнэ.

### *2.7. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм*

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг тусдаа хуулиар зохицуулдаг бөгөөд ***Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн тухай хуулийг*** 2007 онд батлан гаргажээ. Энэ хууль нь ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэх баталгаа юм.

Хуулинд тодорхойлсноор төрийн албан хаагч бүр хууль дээдлэх, хүний эрхийг эрхэмлэх, ардчилсан зарчим, ёс зүйн өндөр хэм хэмжээ болон энэ хуулийг баримтлан ажиллана.

Хуулийн зорилт*:*

- төрийн алба болон төрийн байгууллагын нэр хүндийг нэмэгдүүлэх;
- төрийн байгууллага, төрийн албан хаагчид хандах иргэдийн итгэлийг бэхжүүлэх;
- төрийн байгууллага, төрийн албан хаагчийг авлига, ашиг сонирхлын зөрчилд орохоос урьдчилан сэргийлэх;
- төрийн байгууллага, төрийн албан хаагчийн ажлын үр ашиг, ил тод байдлыг нэмэгдүүлэх;
- төрийн албан хаагчийн мөрдөх ёс зүйн талаар иргэдэд мэдээлэл, ойлголт өгөх;
- төрийн байгууллага, төрийн албан хаагчийн ажлыг үнэлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

Энэ хууль нь дараах харилцааг зохицуулдаг. Үүнд:

- Төрийн албан хаагч болон төрийн байгууллага хоорондын харилцаа;
- Удирдлага болон ажилтан хоорондын харилцаа (Захирах, захирагдах ёс);
- Төрийн албан хаагчдын өөр хоорондын харилцаа;
- Төрийн албан хаагчийн бусадтай харилцах харилцааг зохицуулна.

Төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ дараах ёс зүйн хэм хэмжээ, зарчимыг баримтлан ажиллана:

- Үнэнч байх. Төрийн албан хаагч нь бүх хүний өмнө үнэнч шударга, үлгэр жишээ байх үүрэгтэй.
- Мэргэжлийн ур чадвар болон хувийн үүрэг, хариуцлагаа нэмэгдүүлэх. Төрийн албан заагч эрх, үүргээ хуулийн хүрээнд, мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх ба өөрийн мэдлэг боловсрол, харилцааны соёлоо дээшлүүлэхэд байнга анхаарч ажиллана.
- Олон нийтийн итгэлийг хүлээх. Төрийн албан хаагч нь улс орон, төрийн

UIH.MN СУДАЛГААНЫ САН

байгууллага, төрийн алба болон өөрийн нэр хүндийг эрхэмлэн ажиллах үүрэгтэй. Төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангахад анхаарч ажиллана. Хэрэв төрийн албан хаагчийн алдаа дутагдлаас болж олон нийтийн итгэлийг алдахад хүрвэл засч залруулах арга авч, анхааран ажиллана.

- Соёлтой зан харьцаа. Төрийн албан хаагч нь бүх хүнтэй эелдэг найрсаг харьцаж, аливаад нягт нямбай, анхааралтай, тэвчээртэй хандах үүрэгтэй.
- Үүрэг даалгаврыг бүрэн гүйцэд биелүүлэх. Төрийн албан хаагч үүрэг даалгаврыг цаг хугацаанд бүрэн гүйцэд биелүүлэх үүрэгтэй бөгөөд хэрэв биелүүлэхгүй бол хариуцлага хүлээнэ.
- Ялгаварлахгүй харьцах. Төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ хэнийг ч арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэг, хэл, хүйс, нийгмийн гарал, эд хөрөнгө, албан тушаал, итгэл үнэмшил, олон нийтийн байгууллагын гишүүнчлэлээр нь ялгаварлан гадуурхахгүй, хэн нэгэнд давуу байдал олгохгүй. Улс төрийн хувьд төвийг сахисан байр суурьтай байна. Албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн ашиг сонирхлын үүднээс хандаж болохгүй.
- Авлигаас урьдчилан сэргийлэх. Материаллаг болон материаллаг бус бэлэг авах, эрх ямба, найр тавих зэрэг хууль бус үйлдлээс татгалзана.
- Бэлэг авахаас татгалзах. Төрийн албан хаагч нь зөвшөөрөгдсөн хэмжээ болон Авлигын эсрэг хуулинд зөвшөөрснөөс бусад тохиолдолд бэлэг сэлт авч болохгүй.
- Ашиг сонирхлын зөрчилд орохгүй байх. Төрийн албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхлын зөрчилгүй байх ёстой ба бүрэн эрхээ хэтрүүлэн хэрэглэж хууль бус үйлдэл хийж болохгүй. Төрийн албан хаагч төрийн албанд анх орохдоо, мөн ажиллаж байх хугацаандаа хувийн ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол хуулийн дагуу мэдээлэх үүрэгтэй. Шинэ албан тушаалд томилогдох тохиолдолд ашиг сонирхлын зөрчил үүсэхээр байвал байгууллагын удирдлагад мэдэгдэнэ.
- Мэдээлэл ашиглах. Байгууллага нь төрийн албан хаагчийг албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллээр хангана. Төрийн албан хаагч мэдээлэл авах болон түүнийг хэрэглэхэд зохих журмыг баримтална. Мэдээллийг хувийн ашиг сонирхлын дагуу ашиглаж болохгүй.
- Эд хөрөнгө ашиглах. Албан хэрэгцээний эд хогшил, компьютер, техник төхөөрөмж, харилцаа холбооны хэрэгслүүд болон бусад эд хөрөнгийг зүй зохистой, гамтай хэрэглэнэ.
- Олон нийтийн болон улс төрийн идэвх. Хуулинд өөрөөр заагаагүй бол, төрийн албан хаагч нь олон нийтийн болон улс төрийн холбооны гишүүн байх эрхтэй. Энэ нь албан үүргээ хараат бус, шударгаар бүрэн гүйцэд биелүүлэхэд нөлөөлөх ёсгүй. Төрийн албан хаагч нь албан тушаалаа ашиглан бусад төрийн албан хаагчийг улс төрийн намын, олон нийтийн болон шашины үйл ажиллагаанд татан оролцуулж болохгүй. Улс төрийн болон олон нийтийн холбоо, шашины байгууллагын салбар нэгж байгуулах, мөн тэдгээрийг байгуулахад тусламж үзүүлэхийг хориглоно. Түүнчлэн сонгуулийн үед албан тушаал болон эрх үүргээ нэр дэвшигч, нам, эвслийн төлөө ашиглаж болохгүй.

Төрийн байгууллагын удирдлага, дарга нар нь ажилтнууд ёс зүйн дүрмийг хэр биелүүлж байгаад байнгын хяналт тавин ажиллахаас гадна дүн шинжилгээ хийнэ. Түүнчлэн *Төрийн албаны комисс* ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй. Хяналт тавихад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хууль зөрчсөн талаар төрийн албан хаагч, бусад хүмүүсээс мэдээлэл, өргөдөл, гомдол хүлээн авах;
- Хүлээн авсан мэдээлэл, өргөдөл, гомдлыг шийдвэрлэхээс гадна шийдвэрлэх талаар санал, зөвлөмж, дүгнэлт гаргах;
- Ёс зүйн талаар тайлан бэлтгэх;
- Төрийн албан хаагчийн ёс зүйн холбогдолтой хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал гаргах;

- Ёс зүйн асуудлаар бие даасан шинжээч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.

Хэрэв төрийн албан хаагч хуулинд заасныг биелүүлэхгүй бол сахилгын хариуцлага хүлээнэ.

***2.8. Судалгааны хүрээнд Азербайжаны төрийн албаны хуулийн Монголын хуулиас ялгаатай талуудыг дурьдвал***

- Төрийн албаны төв байгууллага буюу Төрийн албаны комисс нь Ерөнхийлөгчид шууд харъяалагддаг бөгөөд комиссын даргыг Ерөнхийлөгч томилно. Түүнээс гадна Төрийн албаны удирдлагын зөвлөл ажилладаг ба зөвлөл нь 18 гишүүнтэй, Ерөнхийлөгч 6, Мили Межлис (парламент) 6, Үндсэн хуулийн цэсээс 6 гишүүнийг тус тус томилдог. Зөвлөл нь төрийн бус байгууллага бөгөөд өндөр түвшиний зөвлөх байгууллага юм.
- Төрийн албаны сонгон шалгаруулалтын нэгдсэн дүн гарсны дараа шалгарсан хүмүүсийн материалыг төрийн байгууллагын удирдлагад танилцуулах ба байгууллагын удирдлага шалгарсан хүмүүсээс сонголт хийж, тухайн албан тушаалд 1 жилийн хугацаатай дадлагажигчаар ажиллуулна.
- Байгууллагын удирдлагын шийдвэрээр дадлагжигчийг нэг ажилтан хариуцан ажиллах ба дадлагажих хугацааны туршид дадлагажигчийн ажлыг удирдан чиглүүлж, хяналт тавьж ажиллана.
- Гадаадад боловсрол эзэмшсэн, өндөр мэдлэг боловсролтой залуусыг дэмжиж, төрийн албанд ажиллах боломж бүрдүүлсэн. “Залуусыг 2007-2015 онуудад гадаадад сургаж, боловсрол эзэмшүүлэх хөтөлбөр”-т хамрагдсан хүнийг нөөцөд шууд бүртгэх ба сонгон шалгаруулалтын үеэр төрийн байгууллагад санал болгодог.
- Сахилгын хариуцлага хүлээлгэхэд сануулах, цалинг тодорхой хугацаанд тодорхой хувиар бууруулахаас гадна ижил ангиллын, бага цалинтай албан тушаалд шилжүүлэх, албан тушаал бууруулах, мэргэжлийн зэрэг дэвийг бууруулах, төрийн албанаас халах арга хэмжээнүүдийг авдаг.
- Төрийн албан хаагч нь олон нийтийн болон улс төрийн холбооны гишүүн байх эрхтэй талаар Төрийн албаны ёс зүйн дүрмийн тухай хуулинд тусгасан байна (хуулинд өөрөөр заагаагүй тохиолдолд).
- Төрийн албаны ангилал, албан тушаалын мэргэжлийн зэрэг дэв нь монголынхоос өөр бүтэцтэй, ялгаатай байна.

**3. ХБНГУ**

**3.1. Эрх зүйн орчин**

ХБНГУ-ын Үндсэн хууль (Basic Law for the Federal Republic of Germany, 1949), Холбооны Төрийн албаны тухай хууль (Bundesbeamtengesetz – BBG, 2009), Холбооны төрийн албан хаагчдын цалингийн тухай хууль (Federal Civil Service Remuneration Act Germany), Холбооны тэгш эрхийн тухай хууль (Bundesgleichstellungsgesetzes, 2005), Ёс зүйн зөвлөлийн хууль (Ethics Council Act, 2007) зэрэг хуулиудаас судалгааны мэдээлэл бэлтгэв.

Тус улс нь төрийн иргэний албаны “хаалттай” загвартай улс орны нэг юм. Энэхүү загварыг Европын эх газрын олонх улс орнуудын төрийн албанд хэрэгжүүлдэг бөгөөд дараах нийтлэг шинжтэй байна:
- Төрийн албаны түвшин тус бүрт зориулсан дүрэмтэй, захирч захирагдах дэглэм илүү ноёрхсон төрийн албаны тогтолцоотой байх;
- Төрийн албанд боловсон хүчнийг шилж сонгох хаалттай систем үйлчлэх;
- Төрийн албан хаагчдын эрх зүй, нийгмийн баталгаа сайтай байхын зэрэгцээ албан

UIH.MN СУДАЛГААНЫ САН

тушаал дэвших, цалин хөлс, хөнгөлөлтийн өсөлт нь ажилласан жилээс ихэвчлэн хамаарах;
- Төрийн иргэний албан хаагчийг ажлаас халах журам процедурын хувьд олон шат дамжлагатай байх.

Германы төрийн албаны орчин үеийн загварын хамгийн гол онцлог нь боловсон хүчний асуудалд улс төрийн намын оролцоо, улс төрийн томилгоог өргөжүүлсэн байна. Нэг үгээр хэлбэл намын ивээл, хамгаалалтын зарчим үйлчилдэг. Төрийн иргэний албаны тогтолцоонд улс төрийн хүчин зүйлийн оролцоо өндөр байна. Төрийн иргэний албаны байгууллагуудыг удирдлагын түвшингээр эрх хэмжээг нь ялгаж өгсөн. Төрийн албаны боловсон хүчнийг хамгийн тэргүүний дээд боловсролын байгуулллагаас шилж сонгох олон шаттай системтэй. Төрийн иргэний албан хаагчид өндөр түвшний нийгмийн эрх хэмжээтэй, хүндэт түшмэдийн институци байдаг. Албан хаагчийн насан туршийн томилгооны зарчим болон эрх зүй, нийгмийн хамгааллын баталгааны төгс тогтолцоотой.

Дэлхийн хоёрдугаар дайны дараа Герман улсад төрийн алба (*Staatdienst*) гэсэн ойлголт нь нийтийн алба (*offentliehes Dienst*) гэсэн ойлголтоор солигдсон. Орчин үед нийтийн албыг чиг үүргийн талаас нь нийт улсын хэмжээний удирдлагын зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тогтоцын талаас нь нийтийн албаны чиг үүргээ хэрэгжүүлэх нь үйл ажиллагааных нь агуулга болох албан тушаалтан, хүмүүсийн тодорхой хүрээ гэж ойлгоно.[51]

Германд холбооны болон муж улсын төрийн байгууллагуудад ажиллаж буй төрийн иргэний албан хаагчид нь: төрийн аппаратын албан тушаалтнууд, шүүгчид, дээд сургуулийн багш нар, багш, эмч, шуудан, төмөр замын ажилтнууд, төрийн банкнуудын ажилтнууд зэрэг болно. Германы хууль тогтоомжоор төрийн албан хаагчдыг албан тушаалтнууд (*Beamte*) болон хөлсний хөдөлмөр эрхлэгч албан хаагч, ажилтнууд (*Arbeiter, Angestellte*) гэсэн хоёр том бүлэгт хуваана.

Энэ хоёр бүлгийн гол ялгаа нь:
- Албан тушаалтнуудын алба хаах нөхцөл нь томилолтоороо тодорхойлогдох бол төрийн албаны албан хаагчид, ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл нь хувийн эрх зүйн гэрээнд үндэслэнэ.
- Албан тушаалтны эрх, үүрэг нь Төрийн албаны тухай хуулиар зохицуулагдана. Албан хаагчид, ажилтнуудын цалин, хөдөлмөрийн хөлс болон хөдөлмөрийн бусад нөхцөл нь тарифийн гэрээгээр зохицуулагдана.
- Албан тушаалтны үндсэн цалин нь тэдний албан тушаал, ажилласан жилээс хамааран тодорхойлогдоно. Хөлсний хөдөлмөр эрхлэгч албан хаагчид, ажилтнуудын хөдөлмөрийн хөлс нь тэдний гүйцэтгэж буй ажлын онцлог, насны байдлаас шалтгаалан тарифаар тогтоогдоно.
- Албан тушаалтан бүх насаараа томилогдоно. Хөлсний хөдөлмөр эрхлэгч албан хаагчид, ажилтныг халж болно.
- Албан тушаалтнаас ялгаатай нь хөлсний хөдөлмөр эрхлэгч албан хаагчид, ажилтанд сахилгын хариуцлага ноогдуулахгүй, захиргааны ерөнхий эрх зүйн дагуу асуудлыг шийднэ.
- Албан тушаалтан ажил хаялтанд оролцож болохгүй бол хөлсний хөдөлмөр эрхлэгч албан хаагчид, ажилтны хувьд энэ эрх нь нээлттэй.
- Албан тушаалтны ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой бүх зардлыг улсаас даадаг. Тэд тусгай тэтгэвэр авна. Хөлсний хөдөлмөр эрхлэгч албан хаагч, ажилтан нийтийн адилаар тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[51]"Төрийн албан хаагчдын цалин, хөлс, нийгмийн баталгааны талаарх гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт. Харьцуулсан судалгаа (Код: СТ-14/204). УИХ ын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтэс, 2014 он.

ХБНГУ-ын Төрийн албан тухай ерөнхий хуулиар төрийн албан хаагчдыг дөрвөн ангилалд хуваана:

- Албаны доод түвшин (энгийн алба)
- Албаны дунд түвшин (дунд алба)
- Албаны ахисан түвшин (хариуцлагатай алба)
- Албаны дээд түвшин (дээд алба).

Ангилал тус бүрийн хүрээнд төрийн албан хаагчид ранг тогтооно. Нийт 16 рангтай:

- А1-А5 доод ранг (туслах, техникийн ажилтнууд)
- А6-А9 дунд ранг (засгийн газрын нарийн бичгийн дарга нар)
- А10-А13 нэгдүгээр шатны дээд ранг (засгийн газрын инспекторууд)
- А14-А16 хоёрдугаар шатны дээд ранг (засгийн газрын ахлах зөвлөхүүд).

Мөн аль холбооны, муж улсын, тойргийн албан хаагчид гэж хуваана. Тухайн албан тушаалд ажилласан жилээр нь ангилна. Бас туршилтын хугацаагаар томилогдсон, тодорхойгүй хугацаагаар томилогдсон, түр томилогдсон, насаараа томилогдсон гэсэн дөрвөн бүлэгт хуваана.

### 3.2. Холбооны иргэний нийтийн албаны үйлчилгээ[52]

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 33 зүйлийн 1-т зааснаар *“...Герман улсын иргэн бүр өөрийн авьяас, мэргэжлийн ур чадвараар нийтийн аливаа албанд адил тэгш орох боломжтой...”* хэмээн зааснаар Холбооны канцлерийн, Дотоод хэргийн сайд, сангийн сайд, хүний нөөцийн асуудал хариуцсан сайд, төрийн захиргааны шинэтгэлийн асуудал хариуцсан сайдын эрхлэх хүрээнд Холбооны нийтийн албаны үйлчилгээ багтдаг байна. Төрийн албаны төв болон яам агентлагийн салбар алба ажилдгаас гадна мужийн болон орон нутгийн нэгжийн түвшний төрийн албаны нэгж (ажилтан)-тэй байна.

Герман улс холбооны хэмжээндээ төрийн албаны шалгаруулалт хариуцсан нэгж байдаггүй, шалгаруулалтыг тухайн субъект өөрөө хариуцна. Дотоод яам нь төрийн албаны хууль эрх зүй, нийтийн албаны үйлчилгээний асуудлыг ерөнхийд нь л хариуцдаг.

Холбооны Төрийн албаны тухай хуулийн 116, 118 дугаар зүйлээр Төрийн албан хаагчид нь үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоодод нэгдэх эрхтэй мэргэжлийн холбоод дээд шатны байгууллагад иргэний үйлчилгээний нөхцлийн ерөнхий журам боловсруулахад оролцдог.

Тус хуулийн 8 дугаар бүлгийн 119-124 зүйлд Холбооны нийтийн албаны ажилтны хорооны эрх зүйн байдлын талаарх зохицуулалтыг авч үзье.

*120 дугаар зүйл. Холбооны иргэний нийтийн албаны ажилтны хорооны гишүүд*

1. Холбооны нийтийн албаны ажилтны хороо байнгын найман гишүүдээс бүрдэнэ.
2. *Байнгын гишүүд* Холбооны шүүхийн Ерөнхийлөгч, эсвэл дарга, үйлчилгээний эрх зүйн газрын дарга, эсвэл Дотоод хэргийн яамны Хууль эрх зүйн газрын дарга, *Түр бүрэн гишүүд* аж ахуйн нэгжийн газар, өөр хоёр холбооны дээд болон бусад дөрвөн албан тушаалтан дарга, *Орлогч гишүүд* нь Холбооны мужийн төлөөлөөл бүрийн нэгжийн төлөөлөл 1, аж ахуйн хэлтэс, өөр хоёр холбооны дээд болон бусад дөрвөн албан тушаалтан буюу холбооны засгийн газрын албан тушаалтнууд аж ахуйн газрын дарга нар байдаг.

[52]www.bundestag.de/htdocs_e/bundestag/

3. Байнгын гишүүдийг дээд шатны байгууллага нь тодорхойлж дөрвөн жилийн хугацаанд Дотоод хэргийн Холбооны сайдын саналыг үндэслэн Холбооны Ерөнхийлөгч томилно.
4. Холбооны нийтийн албаны ажилтны хороо Дотоод хэргийн яамны харъяа үйл ажиллагаа явуулна.

*122 дугаар зүйл. Дэг*

Холбооны нийтийн албаны ажилтны хороо нь өөрийн үйл ажиллагааны дүрмийг батална.

*123 дугаар зүйл. Хорооны хурал, шийдвэр*

Холбооны нийтийн албаны ажилтны хорооны хуралд дээд шатны эрх бүхий байгууллагын төлөөлөл, гуравдагч этгээдийн эрх бүхий төлөөлөл хуралдаанд байлцахыг зөвшөөрч болно.

Холбооны нийтийн албаны хорооны хуралд хорооны дарга, түүний эзгүйд орлогч дарга дарга. гишүүд байлцах бөгөөд шийдвэрийг олонхын саналаар гаргана. Санал тэнцсэн тохиолдолд хорооны дарга шийдвэрлэх бөгөөд Холбооны нийтийн албаны ажилтны хорооны дүрмээр зохицуулна.

**3.3. Холбооны иргэний нийтийн албаны сонгон шалгаруулалт, тангараг өргөх**

Холбооны нийтийн албаны сонгон шалгаруулалт ***Холбооны Төрийн албаны тухай хуулийн 7, 8, 9 10, 17 дугаар зүйлээр*** нийтийн албанд тавигдах шаардлага, төрийн албаны сул орон тоог зарлах, томилох асуудлуудыг дараах байдлаар зохицуулжээ. Нийтийн албаны сул орон тоог Холбооны Засгийн газрын захирамжаар гаргах бөгөөд олон нйитэд нээлттэй мэдээлнэ. Холбооны тэгш эрхийн тухай хууль, 2005 /*Bundes-gleichstellungsgesetzes*/ 6-д заасны дагуу эрх мэдлийг зохицуулдаг.

Төрийн албанд тавигдах үндсэн шаардлын хувьд тус хуулийн ХБНГУ-ын Үндсэн хуулийн 116 зүйлийн утга агуулгын хүрээнд иргэний харъяаллыг тогтоохоос гадна Европын холбооны өөр гишүүн улс гэрээний өөр нэг Хэлэлцэн тохирогч улсын, Европын холбоо гэрээгээр, мэргэжлийн ур чадвар хүлээн зөвшөөрөгдсөн бол харгалзан үздэг. *(Дотоод хэргийн яам ажилтан, албан тушаалтныг томилох яаралтай мэргэжлийн шалтгаан байгаа тохиолдолд) 9 дүгээр зүйл.* **Сонгон шалгаруулах шалгуур** Төрийн албанд нэр дэвшигчийг сонгон шалгаруулахад хүйс, арьсны өнгө, гарал үүсэл, хөгжлийн бэрхшээл, шашин шүтлэг, улс төрийн итгэл үнэмшил, бэлгийн баримжаа харгалзахгүйгээр мэргэжлийн ур чадвар дээр суурилсан байна.

*10, 12 дугаар зүйл.* **Байнгын** *(Хугацаагүйгээр томилогдсон)* төрийн албан хаагчийг хуульд өөрөөр заагаагүй бол Холбооны Төрийн албаны тухай хуулийн 7-д заасан шалгуур хангасан туршилтын 3 жилийн хугацаа нь дуусгавар болсон албан тушаалтныг Холбооны Ерөнхийлөгч томилно. Туршилтын 3 жилийн хугацаанд тухайн албан хаагч чөлөө авсан бол чөлөөлөгдсөн хугацаагаар хойшлуулна.

Төрийн албан хаагчдын тасралтгүй сургалтад хамруулах тогтолцоотой бөгөөд их дээд сургуулийн төгсөлтийн шалгалт адил хатуу чанга шалгуураар тарийн албаны сонгон шалгаруулалтыг явуулна.

“Төрөөс төрийн албан хаагчийн амьдрах боломжийн цалин хангамж эдлүүлнэ” гэсэн тодорхой хуультай учир тэр эрхээ төрийн албан хаагч насан туршдаа эдэлнэ. Төрийн

UIH.MN СУДАЛГААНЫ САН

албан хаагчаар томилогдсон л бол тэтгэвэрт гартлаа хууль зөрчсөн, ёс зүйн алдаа гаргахгүй бол энэ статусаа хадгална.

Сонгон шалгаруулалтын улсын тусгай комисс авч тэнцсэн албан хаагчдад батламж олгох бөгөөд тухайн албан хаагч урьд нь өөр байгууллагад ажиллаж байсан бол байгууллагын даргын тодорхойлолт болон хамт олны зөвлөлийн тодорхойлолтыг нарийвчлан судлана. Төрийн албаны сонгон шалгаруулалтанд хууль зүйн мэдлэгийг голчлон анхаарна. Тус улсад удирдах албан тушаалд ажиллаж байгаа төрийн бүх албан хаагчдын 60 хувь нь хууль зүйн, 14 хувь нь эдийн засгийн боловсролтой, үүний дотор төрийн нарийн бичгийн дарга нарын 31 хувь нь хууль зүйн боловсрол эзэмшсэн байдаг байна.

Герман төрийн албан хаагч намын гишүүн байж болох бөгөөд улс төрийн үзэл бодлоо даруу илэрхийлэх, аль нам гэдгээ ил тод байлгах хэрэгтэй гэж үздэг. Германчууд намын харъяалалыг нууцлах нь сөрөг нөлөөтэй гэж үзнэ.

Германд төрийн албан хаагч хэдэн насандаа ямар албан тушаалд хүрэхээ төсөөлсөн байдаг. Жишээлбэл, хэд хэдэн хэлтэст ажиллах замаар салбарынхаа түвшинд универсаль мэргэжилтэн болж, хэлтсийн орлогч даргаар ажиллах шалгуур давдаг байна. Энэ зарчим л бүх албан тушаалд томилоход баримтлагдана. 40-45 насандаа дарга болохоо төрийн албан хаагч ажилд орсон өдрөө л мэдэж байдаг. Ийм улсад төрийн албан хаагч 50 нас хүрсэн бол яамны газрын даргын зиндаанд хүрлээ гэж үзнэ. Тэгээд тийм цалин хангамж олгоно, албанд нь томилно.

Германд холбооны болон муж улсын төрийн байгууллагуудад ажиллаж буй төрийн иргэний албан хаагчид нь: төрийн аппаратын албан тушаалтнууд төрийн албанд туршилтын хугацаа нь дуусгавар болж орохдоо дараах тангараг өргөнө. Холбооны төрийн албаны тухай хуулийн 64 дүгээр зүйлд заасны дагуу дараах тангараг *"Үндсэн хууль болон Холбооны хууль тогтоомжийг дээдлэн сахиж өөрийн албан үүргээ шударгаар биелүүлэхээ тангараглая. Бурхан намайг ивээх болтугай».*

### 3.4. Төрийн иргэний нийтийн албаны ёс зүйн дүрэм

Холбооны Төрийн албаны тухай хуулиар төрийн иргэний нийтийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг зохицуулсан заалт байхгүй бөгөөд Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны талаарх дараах хуулийн зохицуулалтыг авч үзье.

**Төрийн албаны хаагчийн ёс зүйн зөвлөл байгуулах тухай хууль**[53]*(2007, Ethics Council Act)*- иар Германы ёс зүйн зөвлөлийн чиг үүрэг, гишүүдийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа зэргийг дараах байдлаар зохицуулсан байна. Ёс зүйн зөвлөл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, технологи, философи, ёс зүйн, нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн асуудалд мэргэшсэн 26 гишүүнээс бүрдэнэ. Эдгээр 26 гишүүний 13-ыг Бундестагийн Ерөнхийлөгч Холбооны Засгийн газрын саналыг үндэслэн томилно. Гишүүд нь 4 жилийн хугацаагаар томилох бөгөөд 1 удаа улируулан томилж болно. Ёс зүйн зөвлөл нь дөрвөн жилийн хугацаагаар нууц санал хураалтаар гишүүдийн дотроос нь дарга, дэд дарга сонгох бөгөөд үйл ажиллагааны журмыг батална.

Германы Ёс зүйн зөвлөлийн гишүүд нь нууцын зэрэглэлтэй мэдээ, материал үйл ажиллагаандаа ашиглах эрхтэй бөгөөд хаалттай хуралдаан болон баримт бичгийн хэлэлцүүлгийн талаарх мэдээллийг задруулахыг хориглоно. Хаалттай хуралдаан болон хэлэлцүүлгийн үр дүнг хэвлэн нийтлэнэ. Ёс зүйн зөвлөл нь төрийн албаны ёс зүйн

[53]www.ethikrat.org/about-us/ethics-council-act

асуудлаар олон нийтийн байгууллагуудын дунд хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, бусад улс орнуудын ижил төстэй байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх чиг үүрэгтэй.

Ёс зүйн зөвлөлийн гишүүдийн аялал жуулчлалын зардал, тэтгэмж, нөхөн олговрыг Германы Бундестагийн Ерөнхийлөгч тогтооно. Германы Ёс зүйн зөвлөл болон түүний засаг захиргааны албан зардал Холбооны Засгийн газар хариуцна.

Тус зөвлөл нь Бундестаг, Холбооны Засгийн газрын хүсэлтээр чиг үүргийн хүрээнд төрийн албаны ёс зүйн асуудлаар санал, зөвлөмж хүргүүлэх үүрэгтэй бөгөөд Зөвлөл нь өөрийн үйл ажиллагааны талаар жил бүрийн эцэст үйл ажиллагааныхаа тайланг Бундестаг болон Холбооны Засгийн газарт бичгээр хүргүүлнэ.

**3.5. Төрийн албан хаагчийг ажлаас халах үндэслэл, хариуцлага**

Холбооны төрийн албаны тухай хуулийн 32, 38 дүгээр зүйлд захиргааны санаачилгаар төрийн албан хаагчийг ажлаас дараах үндэслэлээр халина. ХБНГУ-ын Үндсэн хуулийн 116 зүйлийн утга агуулгын хүрээнд иргэний харъяалал нь өөрчлөгдсөн, төрийн албан хаагч туршилтын хугацаанд тухайн албан үүргээ гүйцэтгэх чадваргүй нь тогтоогдсон, тэтгэвэрт гарах нас хүрсэн бол хуульд өөрөөр заагаагүй бол тухайн захиргааны байгууллага халах, томилох эрхтэй.

ХБНГУ-ын Үндсэн хууль, 1949 (Basic Law for the Federal Republic of Germany) 132 дугаар зүйлд

Төрийн албан хаагчийн эрхийг түр хүчингүй болгох - Хугацаагүйгээр томилогдсон төрийн албан хаагч, шүүгчдийг Бундестагийн анхдугаар чуулганаас хойш 6 сарын дотор хувийн болон мэргэжлийн хандлагаар тухайн албан тушаалын шаардлага хангахгүй байвал албан тушаалаас нь бүрэн буюу түр хугацаагаар чөлөөлөх эсхүл доогуур цалинтай албан тушаалд шилжүүлж болно. Энэхүү заалтыг мөн төрийн албан хаагч болон шүүгчдээс бусад байнга ажиллахаар томилогдсон нийтийн байгууллагад ажиллагсдад жишиж хэрэглэнэ. Харин нийтийн байгууллагад ажиллагсад байнгын хугацаатайгаар томилогдоогүй тохиолдолд хамтын гэрээнд заасан нөхөн төлбөр олгохыг хүчингүй болгож болох бөгөөд харин 6 сарын дотор дээд гатны байгууллагад гомдол гаргах эрхтэй байна.

ХБНГУ-ын Үндсэн хууль (Basic Law for the Federal Republic of Germany, 1949)-ийн 132 дугаар зүйлд Үүрэгт ажилдаа хайнга хандсаны төлөөх хүлээх хариуцлага - Нийтийн алба хашиж буй хэн ч гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн албан ажилдаа хайнга хандсаны төлөөх хариуцлагыг зарчмын хувьд төр буюу тухайн хүнийг ажиллуулж буй байгууллага хүлээнэ. Санаатай буюу үлэмж хайхрамжгүй хандсанаас улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаарх нэхэмжлэлийн шаардлагаар ердийн шүүхийн журмаар шийдвэрлэнэ.

Холбооны төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлд Ажлаас халагдах үр дагавар Ажлаас халалдсаны дараа хуулийн дагуу өөрөөр заагаагүй, цалин, тэтгэмж авах эрхтэй байдаг.

Төрийн албан хаагчийг ажлаас нь халах ажиллагаа хэн эрх барьж байгаагаас их хамаарах бөгөөд удирдах алба хашиж байгаа буюу яамны төрийн нарийн бичгийн дарга, газар, хэлтсийн дарга нар ихэвчлэн халагддаг. Халагдсан албан хаагчид төрөөс цалингийн 72 хувьтай тэнцэх тэтгэмж сар бүр өгөхөөс гадна тэтгэврийн санд төрөөс 100 хувь шимтгэл төлнө. Насан туршийн төрийн албан хаагчийн баталгаа нь энэ юм. Халагдсан төрийн албан хаагчийн оронд ажиллах хүн тангараг өргөсөн төрийн албан хаагч л байна. Төрийн

УИХ-ЫН СУДАЛГААНЫ САН

албан хаагч намын гишүүн байж болно. Нам нь ялж түүний эгүүлэн томилох хүртэл авч байсан цалингийнхаа 72 хувьтай тэнцэх тэтгэлгээ аваад өөр ажил эрхэлж болно, намынхаа төрийн албан хаагчийн нөөцөд орно.[54]

## 4. ФРАНЦ УЛС

### 4.1. Эрх зүйн орчин

Францад төрийн албаны үндсэн зарчмыг тус улсын Үндсэн хууль (1958), Хүний болон иргэний эрх, эрх чөлөөний тунхаглал (1789), Үндсэн хуулийн оршил (1946) зэрэгт тусгасан байна. Тухайлбал, Үндсэн хуулийн 34-д "нийтийн албаны ангилал тогтоох" болон "төрийн иргэний болон цэргийн албан хаагчдын үндсэн баталгаа"-г, Хүний болон иргэний эрх, эрх чөлөөний тунхаглалын 6-д "иргэд нийтийн албанд эрх тэгш орох боломж"-ийг, Үндсэн хуулийн оршилд "хөдөлмөрийн нөхцөлийг чөлөөтэй тогтоох"-ыг тус тус тусгасан байна.

Тус улсад 1980-аад оны эхэн үеэс төрийн албаны шинэтгэл хийх шийдвэр гарснаар олон хууль, дүрэм, журам батлагдсан байна. Тухайлбал, төрийн албатай холбоотой харилцааг зохицуулах ерөнхий хууль бол 1983 оны 6 дугаар сарын 13-нд батлагдсан Түшмэлийн эрх, үүргийн тухай хууль[55] юм. Энэхүү хуулийн дагуу францын нийтийн албыг улсын, орон нутгийн болон эмнэлгийн хэмээн ангилж тус бүрдээ бие даасан хуулиар зохицуулна. Үүнд:

- Төрийн нийтийн албаны эрх зүйн байдлын тухай хууль, 1984 оны 1 дүгээр сарын 14-нд батлагдсан,
- Орон нутгийн нийтийн албаны эрх зүйн байдлын тухай хууль, 1984 оны 1 дүгээр сарын 26-нд батлагдсан,
- Төрийн эмнэлгийн албаны эрх зүйн байдлын тухай хууль, 1986 оны 1 дүгээр сарын 6-нд батлагдсан.

Эдгээрээс гадна төрийн албаны тусгайлсан харилцааг, тухайлбал, цэрэг, цагдаа, шүүхийн албан хаагчдын эрх зүйн байдлыг зохицуулсан хуулиуд байна.

Тодруулага: Францын төрийн албан хаагчдийн өргөх тангараг болон мөрдөх ёс зүйн дүрмийн талаар мэдээлэл олдсонгүй.

### 4.2. Төрийн албаны төв байгууллага, түүний харьяалал

1984 оны 1 дүгээр сарын 14-нд батлагдсан Төрийн нийтийн албаны эрх зүйн байдлын тухай хуулийн 13-д зааснаар төрийн албаны ерөнхий удирдлага нь тус улсын Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд багтана. Түүнчлэн тус улсын Ерөнхийлөгч, Засгийн газар болон Танхимын гишүүд өөрсдийн эрхлэх ажлын хүрээнд зарим эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Тухайлбал, Францын Үндсэн хуулийн 13-д зааснаар Ерөнхийлөгч нь Төрийн зөвлөлийн гишүүн, элчин сайд, дээд шүүхийн түшмэл, их сургуулийн профессор зэрэг иргэний болон цэргийн өндөр албан тушаалтнуудыг томилох эрхтэй.

Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан Төрийн албаны дээд зөвлөл нь 38 гишүүнтэй хамтын байгууллага юм. Гишүүдийн 19 нь удирдлагыг, 19 нь албан хаагчдыг (үйлдвэрчний эвлэлээс сонгоно) тус тус төлөөлүүлж Сайд нарын зөвлөлийн шийдвэрээр 3 жилийн хугацаатай томилно. Энэхүү байгууллага нь төрийн албатай холбоотой нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд оролцох ба хуулийн төсөлд зөвлөмж боловсруулах зэрэг зөвлөх үндсэн үүрэгтэй. Зөвлөл нь төрийн, орон нутгийн болон эмнэлгийн албанд тус тус салбар зөвлөлтэй.

[54] Ц.Ганхуяг, Төрийн алба, Герман соёл тэмдэглэл сургамж.

[55] Loi n° 83-634 du 13 juillet 1983 portant droits et obligations des fonctionnaires. Loi dite loi Le Pors.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Төрийн албаны удирдлага нь тусгайлан Төрийн алба, төрийн шинэчлэл, төвлөрлийг сааруулах яаманд хамаарах ба түүний бүтцэд Захиргаа, нийтийн албаны ерөнхий газар багтана. Төрийн албаны төв байгууллага нь анх 1945 онд "Нийтийн албаны газар" нэртэйгээр "Захиргааны үндэсний сургууль"-тай хамт байгуулагдаж, 1959 онд Захиргаа, нийтийн албаны ерөнхий газар (Direction gйnйral de l'administration et de la fonction publique, DGAFP) болж шинэчлэгдсэн байна. Төрийн албаны эрх зүйн шинжилгээ хийх, төрийн албан дахь нийгмийн асуудлаар зөвлөх, хүний нөөцийн бодлогын удирдлагын хангах гэсэн үндсэн 3 чиг үүрэгтэй.

### 4.3. DGAFP-ны бүтэц зохион байгуулалт, орон тоо

2014 оны байдлаар Захиргаа, нийтийн албаны ерөнхий газар нь нийт 154 албан хаагчидтай үйл ажиллагаа явуулж байна. Жилийн нийт төсөв нь 205 сая евро.

**Бүдүүвч 2. Захиргаа, төрийн албаны ерөнхий газрын бүтэц**



Судалгаа шинжилгээний хэлтсийн гүйцэтгэсэн өмнөх судалгаанаас үзэхэд Ботсвана улсын төрийн албаны загвар нь эх газрын Францын загварыг өөрийн орны нөхцөлд тохируулан буулгасан хувилбар аж.[56]

## 4.4. Төрийн албаны ангилал

1983 оны 6 дугаар сарын 13-нд батлагдсан Түшмэлийн эрх, үүргийн тухай хуулиар францын нийтийн албыг улсын, орон нутгийн болон эмнэлгийн хэмээн ангилж тус бүрдээ бие даасан хуулиар зохицуулагдана.

2011 оны сүүлээр нийт 5,4 сая төрийн албан хаагчид ажиллаж байсан бөгөөд үүнээс 2,4 сая буюу 44.8 хувь нь төрийн нийтийн албанд, 1,8 сая буюу 34.1 хувь нь орон нутгийн нийтийн албанд (орон нутгийн захиргаанд), 1,1 сая буюу 21.1 хувь нь төрийн эмнэлгийн албанд ажиллаж байна.[57]

Төрийн нийтийн албанд төв засгийн газар болон түүний орон нутгийн нэгжид ажиллаж байгаа албан хаагчид хамаарна. Харин орон утгийн нийтийн албанд нутгийн өөрөө удирдах байгууллагад ажиллаж байгаа албан хаагчид хамаарах бол төрийн эмнэлгийн албанд эмч, биологч, эмийн санч зэрэг хүмүүс хамаарна.

Үүнээс гадна тухайн ажилд шаардагдах мэргэжлийн түвшний дагуу А, В, С гэсэн шаталсан ангилалд хуваагдана. А ангилалд удирдах албан тушаалтан хамаарах ба боловсролын хувьд дээд боловсролтой байх шаардлагатай, В ангилалд гүйцэтгэх албан тушаалтан хамаарах ба бакалавр, түүнтэй дүйцэх дипломтой байх шаардлагатай, харин С ангилалд үйлчилгээний ажилтан байх ба дунд мэргэжилтэй байна.

Гурван үндсэн ангилалыг тухайн байгууллага, ажлын байрнаас хамаарч А+ (ахлах), А захиргааны, А техникийн, В захиргааны, В үйл ажиллагааны, В техникийн, С захиргааны, С үйл ажиллагааны, С техникийн гэж дэд ангилалаар ялгана. Хүснэгт 3-т Францын төрийн албан хаагчдын 2002 оны хүний нөөцийн үзүүлэлтийг 2012 оныхтой харьцуулсан байна.

**Хүснэгт 3. Төрийн албан дахь хүний нөөцийн үзүүлэлт*(2002, 2012 он, саяар)***

| | *А ангилал* | | *В ангилал* | | *С ангилал* | |
|---|---|---|---|---|---|---|
| | ***2002*** | ***2012*** | ***2002*** | ***2012*** | ***2002*** | ***2012*** |
| Төрийн нийтийн алба | 44,3 | 54,6 | 24,5 | 25,2 | 31,2 | 20,1 |
| Орон нутгийн нийтийн алба | 7,8 | 9,2 | 13,6 | 13,6 | 78,7 | 77,1 |
| Эмнэлгийн нийтийн алба | 13,7 | 30,2 | 36,9 | 20,4 | 49,4 | 49,4 |

## 4.5. Сонгон шалгаруулалт

Албан хаагчдын төрийн албанд сонгон шалгаруулалтаар авах ба гурван төрлийн шалгаруулалт байдаг: гадаад, дотоод болон гурав дахь сонгон шалгаруулалт.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[56]"Төрийн албаны тогтолцоо, шинэтгэлийн талаарх бусад орнуудын туршлага ба Монгол Улсын нөхцөл байдал". Харьцуулсан судалгаа (Код: СТ-12/220). Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төв, 2012 он.

[57]www.fonction-publique.gouv.fr/

Тавигдах үндсэн шаардлага бол харьялал бөгөөд Франц улсын иргэдээс гадна Европын холбооны гишүүн улсын иргэд сонгон шалгаруулалтанд орж болно. Түүнчлэн Франц улсын харилцан чөлөөтэй зорчих гэрээ байгуулсан Швейцарь[58], Монакко[59], Андорра[60] зэрэг гурван улсын иргэд зарим ажлын байранд орох шалгаруулалтанд өрсөлдөх боломжтой. Эрдэм шинжилгээний, дээд боловсролын болон эмнэлгийн байгууллагуудад аль ч орны иргэн өрсөлдөх боломжтой.

Тухайн ажлын байранд шаардлагатай зэрэг, боловсролын түвшин нь тухайн байгууллага, ажлын зэрэг шатлалын дагуу харилцан адилгүй байна. Төрийн албаны гадаад сонгон шалгаруулалт боловсролын буюу дипломын түвшингээс хамаарч дараах байдлаар оролцуулна. Үүнд:

- А ангилалын сонгон шалгаруулалт: дээд боловсролын дипломтой байх (бакалаврын дипломын сургалт төгссөнөөс хойш 5 жилийн дараа лиценз, эсхүл дипломын сургалтанд дахин хамрагдсан),
- В ангилалын сонгон шалгаруулалт: бакалаврын диплом, эсхүл бакалаврын сургалтын дараа мэргэжлийн дипломтой байх (тухайлбал, сувилагч, нийгмийн ажилтан, захиргааны нарийн бичгийн даргын мэргэшлийн үнэмлэх),
- С ангилалын сонгон шалгаруулалт: зарим ажлын байрны сонгон шалгаруулалтанд зайлшгүй дипломтой байх ба бусад тохиолдолд үндэсний сертификат, эсхүл мэргэжлийн сертификаттай байх.

Дотоод сонгон шалгаруулалтын оролцогчид Засгийн газрын нөөцийн жагсаалтад орно. Шалгаруулалт нээлттэй явагдах ба шалгаруулагчдад тавигдах шаардлага нь тухайн ажлын байрнаас хамаарч өөр өөр байна.

Гурав дахь сонгон шалгаруулалтанд төрийн албанаас гадуур ажил эрхлэж байсан иргэдийг оролцуулна, тухайлбал, хувийн байгууллагад ажиллаж байсан эрх зүйч, чөлөөт уран бүтээлч, нийгэмлэг болон орон нутгийн хариуцлагатай гишүүн зэрэг байна.

Сонгон шалгаруулалт нь бичгээр (сорил буюу хариу сонгох тест байж болно), эсхүл ярилцлага авах хэлбэрээр явагдана.

Сонгон шалгаруулалтад шалгарсан этгээд, ялангуяа А ангилалын ажлын байранд шалгарсан этгээд шаардагдах нэмэлт мэдлэг чадварыг олж авахын тулд Захиргааны үндэсний сургууль, Орон нутгийн захиргааны институт зэрэгт захиргааны сургалтанд хамрагдах ёстой. Сургалт нь ажлын байрнаас хамаарч янз бүр байна, тухайлбал, эмнэлгийн албаны сургалт ажлын байрнаасаа хамаарч 12-27 сар үргэжилнэ. Зарим ажлын байранд туршилтын хугацаагаар ажиллах шаардлагатай ба энэ хугацаанд дадлага туршлага олж авах ёстой аж.

#### 4.6. Төрийн албанаас халах

Тухайн албан хаагч нь хариуцсан үүрэг даалгавараа биелүүлээгүй, эсхүл ноцтой үйлдэл гарсан тохиолдолд байгууллагын Сахилгын зөвлөлийн шийдвэрээр ажлаас нь халнa. Онц ноцтой үйлдэлээс болж халагдсан тохиолдолд тэтгэвэр авах эрхээ хасуулна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[58]La loi n° 2001-1117 du 28 novembre 2001.

[59]La loi n° 2008-572 du 19 juin 2008.

[60]La loi n° 94-628 du 25 juillet 1994

АШИГЛАСАН МАТЕРИАЛ


- Ц.Ганхуяг, Төрийн алба, Герман соёл тэмдэглэл сургамж.
- “Төрийн албан хаагчдын цалин, хөлс, нийгмийн баталгааны талаарх гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт”. Харьцуулсан судалгаа (Код: СТ-14/204). УИХ ын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтэс, 2014 он.
- “Төрийн албаны тогтолцоо, шинэтгэлийн талаарх бусад орнуудын туршлага ба Монгол Улсын нөхцөл байдал”. Харьцуулсан судалгаа (Код: СТ-12/220). УИХ ын Тамгын газрын Судалгааны төв, 2012 он.
- ХБНГУ-ын Ёс зүйн зөвлөл. www.ethikrat.org/about-us/ethics-council-act
- Холбооны Засгийн газар. www.bundestag.de/htdocs_e/bundestag/
- Public service act 1999. www.comlaw.gov.au/Series/C2004A00538
- www.apsc.gov.au/
- http://www.stat.gov.az/
- http://www.csc.gov.az/
- Loi n° 83-634 du 13 juillet 1983 portant droits et obligations des fonctionnaires. Loi dite loi Le Pors.
- La loi n° 2001-1117 du 28 novembre 2001.
- La loi n° 2008-572 du 19 juin 2008.
- La loi n° 94-628 du 25 juillet 1994.
- http://www.fonction-publique.gouv.fr/


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛТАЙ ЗАРИМ ОРОНД ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙГ ХЭРХЭН ТОМИЛДОГ ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

*А.Пагма, Г.Билгээ, Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, Р.Нургүл*

Судалгаанд парламентын засаглалтай 18 орны Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүдийг хэрхэн томилдог талаарх эрх зүйн зохицуулалтыг харьцуулан авч үзлээ. Эдгээр орнуудад уг асуудлыг хэрхэн зохицуулдаг болохыг үзэхэд Энэтхэг, Польш, Сингапур, ӨАБНУ зэрэг 7 улсад Төрийн албаны зөвлөлийн гишүүдийг улсын Ерөнхийлөгч, Серби, Босни Герцоговин, Хорват зэрэг 4 улсад Засгийн газар, 1 улсад Парламент, Кыргыз, Япон, Словени зэрэг 3 улсад Ерөнхийлөгч, Засгийн газар, Дээд шүүх нь тус тус тодорхой тооны гишүүдийг томилдог байна. Үүнийг дэлгэрүүлэн доорх хүснэгтээр үзүүлэв.

| ***Улс,<br>Эх сурвалж*** | ***Төрийн албаны удирдах байгууллагын дарга, гишүүдийг хэрхэн томилох талаарх эрх зүйн зохицуулалт*** |
|---|---|
| **1. Кыргыз,**<br><br>Закон “О государственной службе”. www.jogorku.sot.kg | Төрийн албаны зөвлөл нь дарга, 6 гишүүнтэй ба даргыг нь Жогорку Кенешийн зөвшөөрснөөр Кыргыз Улсын Ерөнхийлөгч томилдог. Гишүүдийн тухайд Кыргыз Улсын Ерөнхийлөгч 1, Парламент 2, Засгийн газар 2, Дээд шүүх 1 гишүүнийг тус тус нэг жилийн хугацаатай томилдог. |
| **2. Серби,**<br><br>Law on civil servants. www.track.unodc.org/<br>LegalLibrary | Нийтийн албаны Зөвлөл нь 9 гишүүнтэй, тэдгээрийг засгийн газраас нь 6 жилийн хугацаатай томилдог. 4 гишүүнийг нь Засгийн газрын тэргүүний санал болгосноор төрийн захиргааны эксперт хүмүүсийг томилдог. Бусад 5 гишүүнийг Хүний нөөцийн удирдлагын албаны даргын санал болгосноор төрийн албан хаагчдаас томилдог. Нийтийн албаны Зөвлөлийн даргыг тус Зөвлөлийн гишүүдийн дундаас нууц санал хураалтаар сонгоно. Төрийн байгууллагын албан тушаалтан Нийтийн албаны зөвлөлийн гишүүнээр ажиллахыг хориглосон. Нэг хүн тус Зөвлөлийн гишүүнээр дээд тал нь 2 удаа томилогдож болно. |
| 3. **Македони,**<br><br>Law on civil servants. http://unpan1.un.org | Нийтийн албаны Агентлагын дарга, түүний орлогчийг 6 жилийн хугацаатай Засгийн газрын саналаар Македон улсын Парламент тус тус ажилд томилж, чөлөөлнө. |
| **4. Бангладеш,**<br><br>**-**The Constitution of the people’s republic of Bangladesh, Chapter II,<br>-Public service commissions. http://bdlaws.minlaw.gov.bd | Нийтийн албаны комиссын дарга, гишүүдийг Ерөнхийлөгч 5 жилийн хугацаатай томилдог. |
| **5. Босни Герцоговин,**<br><br>Law on Civil Service in the Institutions of Bosnia and Herzegovina. www.track.unodc.org/<br>LegalLibrary | Сайд нарын Зөвлөлөөс томилсон Хараат бус хорооноос Нийтийн албаны зөвлөлийн 3 гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр тэдний мэргэжил туршлагыг харгалзан шалгаруулж, шалгарсан хүмүүсийг Сайд нарын Зөвлөл 4 жил хүртэлх хугацаагаар томилно. |

UIH.MN

| | |
|---|---|
| **6. Өмнөд Африкийн БНУ,**<br><br>The Constitution of the Republic of South Africa, 1996.<br>www.thehda.co.za | Төрийн албаны зөвлөлийн 14 комиссарыг Ерөнхийлөгч томилох ба тэдний 5-ийг (дарга, 5 комиссар) нь Үндэсний ассамблей зөвшөөрнө, бусад 9 комиссарыг муж тус бүрийн ерөнхий сайд (засаг дарга) нар нэр дэвшүүлнэ. (196.7)<br><br>Үндэсний ассамблейн зөвшөөрсөн Төрийн албаны зөвлөлийн 5 комиссарыг Үндэсний ассамблей хороо санал болгох ба ассамблейд суудалтай бүх намуудын төлөөлөгчдөөс пропорциональ байдалтай оролцуулан олонхын санаар сонгоно. (196.8)<br><br>9 мужийн ерөнхий сайд нарын нэр дэвшүүлсэн Төрийн албаны зөвлөлийн 9 комиссарыг мужийн хууль тогтоох байгууллагаас санал болгох ба мужийн хууль тогтоох байгууллагад суудалтай бүх намуудын төлөөлөгчдөөс пропорциональ байдалтай оролцуулан олонхын санаар сонгоно. (196.8)<br><br>Комиссаруудыг 5 жилийн хугацаатай томилох ба зөвхөн нэг удаа улируулан томилж болно. (196.10) |
| **7. Словени,**<br><br>Civil servants act.<br>http://www.akos-rs.si | А Албаны зөвлөл нь 12 гишүүнтэй. Эдгээрээс улсын салбарын мэргэжилтэн 3 хүнийг Ерөнхийлөгч томилдог, 3 хүнийг нийтийн албаны ахлах нарийн бичгийн дарга хийж байсан хүмүүсээс сонгодог, 2 хүнийг үйлдвэрчний эвлэлийн идэвхтэн, ажилтнуудаас өөрсдөөр нь сонгуульдаг, 4 гишүүнийг захиргааны асуудал эрхэлсэн сайдын саналаар Засгийн газар томилно. Зөвлөлийн гишүүд олонхын саналаар Зөвлөлийн даргыг сонгоно. |
| **8. Шинэ Зеланд,**<br><br>State services commission<br>State Sector Amendment Act 2013.<br>www.legislation.govt.nz | Төрийн албаны зөвлөлийн комиссар болон орлогч комиссарыг Ерөнхий сайдын саналаар Амбан захирагч томилно. (14.1) |
| 9**. Энэтхэг,**<br><br>The Constitution of India, 2008,<br>Union Public Service Commission (Members) Regulations, 1969 | Үндсэн хууль:<br>Нийтийн албаны нэгдсэн зөвлөлийн дарга, гишүүдийг Ерөнхийлөгч томилох бол Нийтийн албаны мужийн зөвлөлийн дарга, гишүүдийг мужийн захирагч томилох ба 6 жилийн хугацаатай томилогдоно. (316.)<br><br>Төрийн албаны нэгдсэн зөвлөлийн журам:<br>Нийтийн албаны нэгдсэн зөвлөл нь даргыг оролцуулаад 10-аас илүүгүй тооны гишүүнтэй байна. (3.) Нийтийн албаны нэгдсэн зөвлөлийн даргыг Ерөнхийлөгч томилно. (2.) |
| **10. Япон,**<br><br>National personnel authority,<br>Засгийн газрын дэргэдэх Боловсон хүчний зөвлөл[61]<br>National Public Service Act, 1947.<br>www.ssl.jinji.go.jp/en/recomme/rl_npsa.pdf | Боловсон хүчний зөвлөл 3 гишүүнээс бүрдэнэ. (4.1) Тэдний нэгийг нь Ерөнхийлөгч томилно. (4.2) Гишүүдийг Парламентын 2 танхимын зөвшөөрснөөр Засгийн газар томилох ба (5.1) Япон улсын Эзэн хаан батална. (5.2) |
| **11. Канад Улс,**<br><br>Нийтийн албаны хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль (Public Service Employment Act) http://laws-lois.justice.gc.ca/ | Нийтийн албаны комисс (Public Service Commission) нь Ерөнхийлөгч, 2 ба түүнээс дээш тооны гишүүнтэй байна. Ерөнхийлөгч болон гишүүдийг Амбан захирагч томилж, чөлөөлдөг. Ерөнхийлөгчийн томилгоог Сенат болон Нийтийн танхимаас баталж шийдвэр гарсны дараа хийдэг.<br><br>*Жич: Албан ёсоор Их Британий хатан хаан Канад Улсын тэргүүн бөгөөд Амбан захирагч нь хатан хааны бие төлөөлөгч юм.* |

[61]http://ssl.jinji.go.jp/en/

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | |
|---|---|
| **12. БНПольш Улс,**<br><br>Нийтийн албаны тухай хууль (Act of 21 November 2008 on Civil Service)<br>http://dsc.kprm.gov.pl/en/civil-service-system-in-poland | Нийтийн албаны зөвлөл (Civil Service Council) нь 15 гишүүнтэй бөгөөд 8 гишүүнийг Ерөнхий сайд томилдог. Үлдсэн 7 гишүүнийг парламент дахь намын бүлгүүдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Ерөнхий сайд томилох бөгөөд парламентын гишүүн, сенатор, парламентын гишүүн бус хүн ч байж болно. Зөвлөлийн гишүүд хуулинд заасан нөхцөл шаардлагыг хангасан байх ёстой.<br><br>Зөвлөлийн Ерөнхийлөгчийг зөвлөлийн гишүүд дундаас Ерөнхий сайд томилно. Зөвлөл нь Ерөнхийлөгчийн хүсэлтээр гишүүд дундаас дэд Ерөнхийлөгч сонгож болно. |
| **13. БНХорват Улс,**<br><br>Нийтийн албан хаагчийн тухай хууль<br>(Civil servants act)<br>http://www.vsrh.hr/ | Нийтийн албаны зөвлөл (Civil Service Board) нь дарга, 10-аас багагүй тооны гишүүнтэй байх ба Засгийн газраас 5 жилийн хугацаатай томилогддог. Зөвлөлийн гишүүд хуулийн зэрэг цолтой байна. Дарга нь хуулийн практик ур чадварын шалгалт өгсөн байх шаардлагатай. |
| **14. Сингапур Улс,**<br><br>Үндсэн хууль. 9-р хэсэг. (Constitution of the Republic of Singapore. Part IX The Public Service)<br>http://statutes.agc.gov.sg/aol/ | Төрийн албаны зөвлөл (Public Service Commission) нь дарга болон 5-14 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба Ерөнхий сайдтай зөвшилцсөнөөр Ерөнхийлөгч томилно. |
| **15. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс,**<br><br>Үндсэн хуулийн шинэтгэл ба Засаглалын тухай хууль. (Constitutional Reform and Governance Act 2010. Schedule 1. Section 2. The Civil Service Commission)<br>http://civilservicecommission.independent.gov.uk/ | Нийтийн албаны комисс (Civil Service Commission) нь 7-оос багагүй тооны гишүүнтэй байна. Комиссын тэргүүнийг Нийтийн албаны сайд буюу Ерөнхий сайдын санал болгосноор Хатан хаан 5 жилийн хугацаатай томилдог. Тэргүүнийг томилохоос өмнө ил тод, шударга өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулна. Сонгон шалгаруулалтын дараа Ерөнхий сайд Шотланд, Уэльсийн тэргүүн сайд болон бусад холбогдох хүмүүстэй зөвшилцөх ёстой.<br><br>Бусад гишүүдийг мөн адил өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулж, Ерөнхий сайдын санал болгосноор Хатан хаан 5 жилийн хугацаатай томилно. Гишүүдийн томилгоог хийхдээ комиссын тэргүүний саналыг заавал харгалзах бөгөөд зөвшөөрөөгүй тохиолдолд тухайн хүнийг томилохгүй. Комиссын тэргүүн болон гишүүнээр томилогдсон хүнийг тухайн албанд дахин сонгохгүй. |
| **16. Австрали,**<br><br>Public service Act 1999, Division 2, 45, Commissioner's appointment, conditions etc.<br>www.comlaw.gov.au/ | Австралийн төрийн албаны комисс (APSC) нь Ерөнхий сайд ба түүний кабинетын бүрэлдэхүүнд багтдаг төв агентлаг юм. Төрийн албаны комиссын дарга буюу комиссарыг Засгийн газрын тэргүүн томилох бөгөөд 5 жилийн хугацаатай томилдог. Комиссар нь Ерөнхий сайдын санал болгосноор, комиссын гишүүнд туслах нэг буюу хэд хэдэн тусгай Комиссарыг томилж болно. |
| **17. Мальт,**<br><br>Constitution of malta chapter The Public Service<br>http://justiceservices.gov.mt | Төрийн албаны комисс нь (Public Service Commission for Malta) Төрийн албаны комиссын дарга, орлогч дарга, орон тооны 3 гишүүнтэй байна. Комиссын даргыг Ерөнхий сайдын сайдын санал болгосноор Ерөнхийлөгч 3 жилийн хугацаатай томилно. |
| **18. ХБНГУ,**<br><br>Холбооны Нийтийн албаны тухай хууль, 2009, 119-124 зүйл, /Bundesbeamtengesetz (BBG)/<br>www.gesetze-im-internet.de/ | Холбооны Нийтийн албаны Хороо нь байнгын 8 гишүүн, орлогч 8 гишүүнтэй.<br><br>Байнгын гишүүдэд Холбооны Аудит, Шүүх, Дотоод хэргийн яамны Хүний нөөц, Хууль зүйн хэлтсээс гишүүн орно. Орлогч 8 гишүүдэд байнгын гишүүдийг томилсон байгууллагаас 2 ажилтан, төрийн бусад байгууллагаас 6 хүнийг томилно.<br><br>Байнгын гишүүдийг дээд шатны байгууллагын санал болгосноор Холбооны Дотоод хэргийн сайдын саналыг үндэслэн Холбооны Ерөнхийлөгч 4 жилийн хугацаатай томилно. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

АШИГЛАСАН МАТЕРИАЛ


- Law on civil servants. Republic of Serbia. www.track.unodc.org/LegalLibrary
- Macedonian Law on civil servants.http://unpan1.un.org
- The Constitution of the people's republic of Bangladesh. http://bdlaws.minlaw.gov.bd
- Law on Civil Service in the Institutions of Bosnia and Herzegovina www.track.unodc.org/LegalLibrary
- The Constitution of the Republic of South Africa, 1996. www.thehda.co.za
- Civil servants act. Republic of Slovenia. http://www.akos-rs.si
- State Sector Amendment Act 2013. www.legislation.govt.nz
- The Constitution of India, 2008. www.prsindia.org/.
- National Public Service Act, 1947. ssl.jinji.go.jp/en/recomme/rl_npsa.pdf
- Public Service Employment Act) http://laws-lois.justice.gc.ca/
- Act of 21 November 2008 on Civil Service) http://dsc.kprm.gov.pl/en/civil-service-system-in-poland
- Civil servants act. http://www.vsrh.hr/EasyWeb.asp?pcpid=286
- Constitution of the Republic of Singapore. Part IX The Public Service. http://statutes.agc.gov.sg/aol/
- Constitutional Reform and Governance Act 2010. Schedule 1. Section 2. The Civil Service Commission.http://civilservicecommission.independent.gov.uk/
- Public service Act 1999, http://www.comlaw.gov.au/Details/C2014C00511
- Constitution of Malta, http://justiceservices.gov.mt/DownloadDocument.
- Bundesbeamtengesetz (BBG) http://www.gesetze-im-internet.de/bundesrecht/bbg_2009/gesamt.pdf
- Закон "О государственной службе". www.jogorku.sot.kg


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДСЭН ИРГЭДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АСУУДЛААРХ ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

*А.Пагма, Д.Жигваагүнсэл,*
*Ө.Мөнхтунгалаг, Р.Нургүл*

## УДИРТГАЛ

Судалгаанд улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох асуудлын эрх зүйн зохицуулалт, нөхөн олговор авах эрх бүхий этгээдийг тогтоох, ямар хэмжээний олговрыг хэрхэн олгодог талаар тодруулахыг зорив. Эдгээр асуудлаар Монгол Улс болон ОХУ, Казахстан, Болгар, Польш зэрэг орнуудын эрх зүйн зохицуулалтын хүрээнд судаллаа.

## СУДАЛГААНЫ ТОВЧ ДҮГНЭЛТ

Судалгаанд хамрагдсан орнуудад улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршгийг арилгах, хэлмэгдүүлэлтийн золиос болсон иргэдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох асуудлыг бие даасан хууль, журмаар зохицуулж байна.

Коммунист тогтолцооны үед улс төрийн зорилгоор үй олноороо хоморголон устгагдсан, тамлагдан зовсон, хоригдсон, эрүүдэн шүүгдсэн, цөлөгдсөн хүмүүсийг цагаатгуулах нэхэмжлэлийг хэлмэгдэгчийн шийтгүүлсэн байдлаас шалтгаалан харьяалах шатны шүүхэд гаргах ба нэхэмжлэл гаргах субъектүүд нь улс орнуудад ихэвчлэн адилхан байна. Тухайлбал ОХУ-д Цагаатгуулах тухай өргөдлийг хэлмэгдэгчид өөрсдөө болон тэдний өмнөөс ямар ч хүн, олон нийтийн байгууллага гаргаж болох ба хэргийн хамаарлаас шалтгаалан[62] Дотоод хэргийн Яамны болон прокурорын байгууллагад гаргаж байна.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдэд амь нас болон сэтгэл санааны, бие махбодын, эд материалын зэрэг ноцтой хохирол учруулсныхаа төлөө нөхөн төлбөр олгох ба нөхөн төлбөрийг тухайн улсын төсвөөс бүрэн гаргахаар байна. Хэлмэгдэгчдэд нөхөн олговрыг олгохдоо ихэвчлэн мөнгөн хэлбэрээр нэг удаа эсхүл сар бүр тэтгэмж олгох ба хэлмэгдлийн хор уршгийг арилгах зорилгоор амьжиргаанд нь олон талын хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх, нэр төр, эрхийг сэргээх зэргээр зохицуулж байна.

## УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДСЭН ИРГЭДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТАЛААРХ ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

### 1. МОНГОЛ УЛС

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох, хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгах ажлыг 1998 оны 01 дүгээр сарын 02-нд батлагдсан "*Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай*" хууль[63] /цаашид "Цагаатгалын хууль" гэх/-аар зохицуулж байна. Энэхүү ажлыг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс хариуцан ажилладаг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[62]Хэлмэгдүүлэлт шүүхийн ба шүүхийн бус байгууллагын шийдвэрийн дагуу явагдсан бол прокурорын байгууллагад, харин захиргааны байгууллагын шийдвэрийн дагуу явагдсан бол Дотоод хэргийн яамны байгууллагад өргөдлийг гаргана.
[63]Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай Монгол улсын хууль. УБ. 2000 он.

Цагаатгалын хуулийн 4-р зүйлд “энэ хууль 1922 оноос “БНМАУ-ын шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах журмын тухай хууль” хүчин төгөлдөр болсон өдөр хүртэлх хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хамаарна”[64] гэж зааснаас үзэхэд 1922 оноос эхлэн 1990 оны 03 сарын 23-ны өдрийг хүртэлх хугацаанд Цагаатгалын хуулийн 5-р зүйлд заасан ял шийтгэлээр шийтгүүлсэн хүмүүсийг улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгч гэж үзэж байна.

Цагаатгалын хуулийн 5-р зүйлд зааснаар дараах ял шийтгэлээр шийтгэгдсэн хүмүүсийг улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгч гэж тооцно. Үүнд:

1. Шүүх, шүүхийг орлон ажилласан тусгай комисс, онцгой бүрэн эрхт комиссын шийдвэрээр Монгол Улсын Эрүүгийн хуулийн дор дурдсан зүйл ангид заасан гэмт хэрэгт хилсээр ял шийтгүүлсэн нь шүүхийн журмаар тогтоогдсон; /Улсын дээд шүүх/
   - а/ 1922-1926 он /”Шүүх цаазын бичиг” гарах хүртэл хугацаа/-д эрүүгийн ял шийтгэлийг шинэчлэн тогтоосон болон хэрэглэсэн Ардын Засгийн газрын тогтоолууд;
   - б/ 1926 оны “Шүүх цаазын бичиг” /1929 онд нэмэн найруулсан/-ийн 7-р бүлгийн 42-49-р зүйл; 8-р бүлгийн 50-52-р зүйл;
   - в/ 1934 оны “Шүүх цаазын бичиг”-ийн тусгай ангийн 1-р бүлгийн 42-50-р зүйл; БНМАУ-ын Ардын СнЗ-ийн 1938 онд 1-р бүлэгт оруулсан нэмэлт, өөрчлөлт;
   - г/ 1942 оны “Эрүүгийн хууль” -ийн 55-69, 137-р зүйл;
   - д/ 1961 оны “Эрүүгийн хууль”-ийн тусгай ангийн 1-р бүлгийн 45-52, 53-55, 57-р зүйл
2. Ял шийтгүүлээгүй боловч дээрх хуулийн зүйл ангиудад заасан хэрэгт хилсээр холбогдон баривчлагдаж мөрдөгдсөн нь прокурорын тогтоолоор нотлогдсон; /УЕПГ/
3. Шүүх, тусгай болон онцгой бүрэн эрхт комиссоор хэлэлцэн шийдвэрлээгүй боловч улс төр, үзэл суртлын шалтгаанаар тухайн үеийн нам, төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр ажил, албан тушаалаасаа хууль бусаар халагдсан нь шүүхийн журмаар тогтоогдсон /Анхан шатны шүүхүүд/ зэрэг хамаардаг байна.

***Цагаатгал[65] :***

Улс төрийн хэлмэгдүүлэлтэд 36 мянга орчим хүнийг хэлмэгдүүлсэн гэсэн албан бус тоо байдаг бөгөөд 1937-1939 оны үед оргил үедээ хүрч 26211 хүнийг буюу нийт хэлмэгдэгчдийн дийлэнх хувийг хэлмэгдүүлсэн байдаг байна.

МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 15-р тогтоол гарч ДЯЯ-аас ард иргэдийг хувьсгалын эсэргүү хэрэгт холбогдуулан бөөнөөр нь баривчлах ажиллагаагаа зогсоож, мөрдөн байцаалтад байгаа хүмүүсийг суллах, 1937-1939 онд улс төрийн хилс хэрэгт холбогдон хорих ял шийтгүүлсэн хүмүүсийн хэргийг дахин шалгах болсны дагуу 1939-1955 оны хооронд ДЯЯ-ны дэргэдэх Тусгай комисс 1256 хүний хэргийг шалгаж, суллан тогтоол гаргасан үеэс цагаатгалын ажлыг эхэлсэн гэж үздэг. Одоогийн байдлаар 1939-2014 оны дуусталх хугацаанд 31215 хүнийг цагаатгасан байна.[66]

[64]Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай Монгол улсын хууль. УБ. 2000 он.
[65]Мөн тэнд.
[66]М.Ринчин. Цагаатгал ба хэлмэгдүүлэлт. УБ. 2005 он

UIH.MN СУДАЛГААНЫ ГАЗАР

Цагаатгуулах тухай гомдлыг **хэлмэгдэгч өөрөө буюу түүний гэр бүлийн аль нэг гишүүн, хууль ёсны төлөөлөгч,** түүнчлэн **ЦАУЗБУК, түүний орон нутгийн салбар** гаргах эрхтэй байдаг. Хуулийн 8-р зүйлд заасны дагуу тухайн хэлмэгдэгчдийн шийтгэгдсэн байдлаас нь шалтгаалан Улсын Дээд Шүүх, Улсын Ерөнхий Прокурорын Газар, Анхан шатны шүүхүүд цагаатгах эсэхийг эцэслэн шийдвэрлэдэг.

***Нөхөх олговор олгох[67] :***

Цагаатгалын хууль ёсоор улс төрийн хэрэгт хэлмэгдэгч мөн болох нь хууль ёсоор тогтоогдсон этгээдэд учирсан хохирол /*эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус амины эрх зөрчсөнөөс*/-ыг хуулийн дагуу нөхөн олговор олгох хэлбэрээр нөхөн төлөхөөр заажээ.

Нөхөх олговрыг нэг удаа олгох ба нөхөн олговрын хэмжээ нь 500.000-1000000 төгрөг байна. Тухайлбал,

a) 1 000 000 сая төгрөгийн нөхөн олговрыг- хилс хэрэгт холбогдуулан цаазаар авах ял шийтгүүлсэн болон хорих ялаар шийтгүүлсэн, баривчлагдан мөрдөгдөж байхдаа нас барсан, мөн хэлмэгдсэн нь тогтоогдоод нөхөх олговроо авч амжилгүй нас барсан хэлмэгдэгч */ямар шийдвэрээр байх нь хамаагүй*/-д,

b) 500.000 төгрөгийн нөхөх олговрыг- хилсээр баривчлагдан мөрдөгдөж байгаад суллагдсан, захиргааны шийдвэрээр шийтгэгдсэн амьд байгаа нэхэмжлэгчид тус тус хуулийн 12-р зүйлд заасан бүрдүүлбэрээр олгоно.

Нөхөн олговрыг шүүхийн шийдвэрийг үндэслэн харьяалах сум, дүүргийн санхүүгийн хэлтсээр дамжуулан улсын төсвөөс олгох ба ямар нэгэн татвар хураамж авахгүй.

Хууль батлагдсанаас хойш 17584 иргэнд 16 тэрбум 326 сая төгрөгийн нөхөн олговрыг нэг удаа олгосон байна.

Хууль ёсоор Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчид олгох нөхөн олговрыг хэлмэгдэгч өөрөө, хэлмэгдэгч нас барсан бол түүний эхнэр буюу нөхөр, төрсөн болон үрчилж авсан, нас барснаас хойш 10 сарын дотор төрсөн хүүхэд, эдгээр хүмүүс байхгүй бол хэлмэгдэгчийн төрсөн эцэг, эх, ах, эгч, дүү, ач, зээ нар нэхэмжлэх эрхтэй.

Мөн хэлмэгдүүлэлтийн үр дагаврыг арилгах зорилгоор хэлмэгдэгчийг цагаатгасан тухай олон түмэнд мэдээлэх, нэр төрийг сэргээх, цол шагналыг буцаан олгох, орон сууц олгох зэрэг арга хэмжээг хуулиар зохицуулсан байна. Тухайлбал, Цагаатгалын хуулийн 23-р зүйлд зааснаар амьд сэрүүн байгаа хэлмэгдэгч болон нас барсан хэлмэгдэгчийн эхнэр, нөхөр /амьд байгаа/-т хэлмэгдүүлэлтийн улмаас эзэмшиж байсан гэр, орон сууцаа хураалгаж одоо хүртэл орон сууцгүй байгаа бол орон сууц буюу өөрөө хүсвэл түүнтэй дүйцэх 30 сая төгрөгийг нэг удаа олгодог байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## 2. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

Тус улсад улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох асуудлыг 1991 онд батлагдсан "Улс төрийн хэлмэгдүүлэлтэд хохирогсдыг цагаатгах тухай" хууль[68] ,ОХУ-ын Засгийн газрын "Улс төрийн хэлмэгдүүлэлтийн явцад иргэдээс хууль бусаар хураасан болон өөр замаар тэдний өмчлөлөөс гаргасан хөрөнгийг буцаан

[67]Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай Монгол улсын хууль. УБ. 2000 он.
[68]ФЗ "О реабилитации жертв политических репрессий". http://base.garant.ru

олгох, үнийг нөхөн төлөх, мөнгөн төлбөр төлөх журам”[69] болон бусад хууль, эрх зүйн актаар[70] зохицуулдаг.

“Улс төрийн хэлмэгдүүлэлтэд хохирогчдыг цагаатгах тухай” хуулиар 1917 оны 10 дугаар сарын 25-ны (11 дүгээр сарын 7) өдрөөс эхлэн ОХУ-ын нутаг дэвсгэр дээр улс төрийн хэлмэгдүүлэлтэд хохирогсдыг цагаатгах, тэдний иргэний эрхийг сэргээх, бусад сөрөг үр дагаврыг арилгах, эд материалын хохирлыг тухайн үеийн боломжийн хэрээр нөхөн төлөх зорилтыг тодорхойлсон.

Тус хуулийн дагуу улс төрийн хэлмэгдүүлэлтэд шууд өртөж хохирогчдоос гадна тэдэнтэй хамт шорон, цөллөгт байсан тэдний хүүхдүүд, хэлмэгдүүлэлтийн улмаас бага насандаа эцэг, эхгүй өссөн хүүхдүүд, улс төрийн хэлмэгдүүлэлтэд хохирсон ОХУ-ын иргэдээс гадна хуучин ЗХУ-ын Бүгд Найрамдах Улсуудын иргэд, гадаадын иргэд, харьяалалгүй иргэдийг хэлмэгдүүлэлтэд өртсөнд тооцож, цагаатгахаар заасан.

Мөн буудуулсан, шоронд нас барсан, нөхөн цагаатгагдсан иргэдийн эхнэр (нөхөр), хүүхдүүд, эцэг, эх нь улс төрийн хэлмэгдүүлэлтэд хохирсонд тооцогдоно.

“Улс төрийн хэлмэгдүүлэлтэд хохирогчдыг цагаатгах тухай” хуульд улс төрийн хэлмэгдүүлэлтэд хохирсон иргэдийг цагаатгах журмыг хуульчилсан. Цагаатгуулах тухай өргөдлийг хэлмэгдэгсэд өөрсдөө болон тэдний өмнөөс ямар ч хүн, олон нийтийн байгууллага гаргаж болох ба хэргийн хамаарлаас шалтгаалан[71] Дотоод хэргийн Яамны болон прокурорын байгууллагад гаргана. Цагаатгуулах тухай өргөдлийг 3 сарын дотор хянан үзэж хариу өгөх ёстой.

Иргэд, байгууллагын өргөдлийн дагуу хэргийг хянан үзэж тухайн иргэнийг цөлсөн, албадан нүүлгэсэн, тусгай лагерьт явуулсан, эрх чөлөөг нь хязгаарлан албадан хөдөлмөрлүүлсэн захиргааны хэргийг Дотоод хэргийн Яам, эрүүгийн хэрэг үүсгэн ялласан хэргийг хянан үзэж прокурорын байгууллага цагаатгасан тухай тодорхойлолт, эсхүл ийм тодорхойлолт олгохыг татгалзсан хариу өгнө.

Улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртөж цагаатгагдсан тухай, эсхүл улс төрийн хэлмэгдүүлэлтийн хохирогч болсон тухай тодорхойлолт олгохыг татгалзсан зохих байгууллагын шийдвэрийг эсэргүүцэн хуулийн дагуу[72] шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

Тус хуулийн дагуу цагаатгагдсан иргэдийн нийгэм-улс төр, иргэний эрх, цэргийн, тусгай цолыг сэргээж, төр, засгийн шагналуудыг нь буцаан олгож, нийгмийн тусламж, дэмжлэг үзүүлж, нөхөн олговор олгоно.

Цагаатгагдсан иргэд, тэдний өв залгамжлагчдад олгох хэлмэгдүүлэлтийн явцад учруулсан эд материалын нөхөн олговрыг холбооны төсвөөс санхүүжүүлнэ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[69]“Положение о порядке возврата гражданам незаконно конфискованного, изьятого или вышедшего иным путем из владения в связи с политическими репрессиями имущества, возмещения его стоимости или выплаты денежной компенсации.” http://www.zakonprost.ru

[70]Указ Президента РФ от 8 июня 1996 г. N 858 «О дополнительных мерах по реабилитации лиц, репрессированных в связи с участием в событиях в г. Новочеркасске в июне 1962 г.», Об организации деятельности органов прокуратуры по исполнению и надзору за исполнением настоящего Закона см. приказ Генеральной прокуратуры РФ от 5 февраля 2008 г. N 21. http://base.garant.ru

[71]Хэлмэгдүүлэлт шүүхийн ба шүүхийн бус байгууллагын шийдвэрийн дагуу явагдсан бол прокурорын байгууллагт, харин захиргааны байгууллагын шийдвэрийн дагуу явагдсан бол Дотоод хэргийн яамны байгууллагад өргөдлийг гаргана.

[72]ФЗ “Об обжаловании в суд действий и решений, нарушающих права и свободы граждан”. http://base.garant.ru

Цагаатгагдсан иргэдийн хэлмэгдүүлэлтийн явцад алдсан орон байрны ба урд нь амьдарч байсан нутаг орондоо буцан ирэх эрхийг сэргээж, буцан ирсэн тохиолдолд гэр бүлийнх нь хамт иргэний бүртгэлийг хийж, ОХУ-ын субъектийн хуулийн дагуу орон байраар хангана.

Шоронд хоригдсон, сэтгэл мэдрэлийн эмнэлэгт албадан эмчлэгдэж байсан цагаатгагдсан иргэдэд цагаатгалын баримт бичгийг үндэслэн орон нутгийн нийгмийн хамгааллын байгууллагаас шорон, сэтгэл мэдрэлийн эмнэлэгт өнгөрөөсөн сар тутамд 75 рублиэр тооцон нэг удаа мөнгөн нөхөн төлбөр олгоно. Нөхөн төлбөрийн хэмжээ 10 000 рублиэс илүүгүй байна.

Энэхүү нөхөн төлбөрийг шилжүүлсэн боловч цагаатгагдсан иргэн өөрөө авч амжаагүй тохиолдолд л түүний өв залгамжлагчдад олгоно.

"Улс төрийн хэлмэгдүүлэлтэд хохирогчдыг цагаатгах тухай" хуулийн 16.1 дэх хэсэгт улс төрийн хэлмэгдүүлэлтийн явцад иргэдээс хууль бусаар хураасан болон өөр замаар тэдний өмчлөлөөс гаргасан хөрөнгийг буцаан олгох, үнийг нөхөн төлөх, эсвэл мөнгөн нөхөн төлбөр төлөх тухай хуульчилсан.

Төрийн ба олон нийтийн байгууллагууд өөрийн эзэмшилд байгаа дээр дурдагдсан хөрөнгийн элэгдэл, хорогдол, уг хөрөнгийг хадгалан хамгаалж байсны зардлыг нэхэмжлэлгүйгээр зохих эзэнд нь буцаан өгнө.

Хэрэв цагаатгагдсан иргэдэд хадгалагдан үлдсэн хөрөнгийг нь буцаан өгөх боломжгүй бол тогтоосон Журмын[73] дагуу үнэлгээ хийж орон байр, сууцыг оруулалгүйгээр 4000 рублиэс илүүгүй нөхөн төлбөр, орон байр, сууцыг оруулбал 10 000 рублийн нөхөн төлбөр олгоно. Хадгалагдан үлдээгүй эд хөрөнгийн нөхөн төлбөрийг мөн ийм журмаар олгохоор заажээ.

Цагаатгагдсан иргэн нас барсан тохиолдолд хууль бусаар хураасан болон өөр замаар тэдний өмчлөлөөс гаргасан хөрөнгийг буцаан олгох, үнийг нөхөн төлөх, мөнгөн төлбөрийг нь түүний нэгдүгээр ээлжийн өв залгамжлагчид буюу хүүхдүүд (үрчилж авсан хүүхдүүд мөн адил), эхнэр (нөхөр), эх, эцэг (үрчилж авсан эх, эцэг мөн адил), түүнчлэн нас барсных нь дараа төрсөн хүүхдэд тэгш хуваан олгоно.

Улс төрийн хэлмэгдүүлэлтийн явцад иргэдээс хууль бусаар хураасан болон өөр замаар тэдний өмчлөлөөс гаргасан хөрөнгийг буцаан олгох, үнийг нөхөн төлөх, мөнгөн төлбөр төлөх талаарх өргөдлийг иргэн "Улс төрийн хэлмэгдүүлэлтэд хохирогчдыг цагаатгах тухай" хууль хүчин төгөлдөр болсноос хойш 3 жилийн хугацаанд гаргана, хугацааны хувьд хожуу цагаатгагдсан тохиолдолд цагаатгалын баримт бичгийг хүлээн авснаас хойш 3 жилийн хугацаанд уг өргөдлийг гаргана.

Улс төрийн хэлмэгдүүлэлтийн явцад иргэдээс хууль бусаар хураасан болон өөр замаар тэдний өмчлөлөөс гаргасан хөрөнгийг буцаан олгох, үнийг нөхөн төлөх, мөнгөн төлбөр төлөх талаарх шийдвэрийг ОХУ-ын субъектүүдийн гүйцэтгэх засаглалын байгууллага, нутгийн удирдлагын байгууллага нь Улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртөж цагаатгагдсан иргэдийн эрхийг сэргээх комиссын дүгнэлтийг үндэслэн гаргана.

[73]"Положение о порядке возврата гражданам незаконно конфискованного, изьятого или вышедшего иным путем из владения в связи с политическими репрессиями имущества, возмещения его стоимости или выплаты денежной компенсации." http://www.zakonprost.ru

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртөж цагаатгагдсан иргэдийн эрхийг сэргээх комисс[74] шаардлагатай бол мэргэжилтнүүдийг татан оролцуулж хураагдсан хөрөнгийн үнэлгээг тодорхой баримт, материалыг үндэслэн тогтооно.

Хөрөнгийг буцаан олгох тухай шийдвэрийг хэрэгжүүлэх хугацаа 1 жилээс илүү байж үл болно.

Хөрөнгийг буцаан олгох, үнийг нөхөн төлөх, мөнгөн төлбөр төлөх талаарх маргааныг шүүхээр хянан үзнэ.

Хуулийн дагуу дараах өмч хөрөнгийг буцаан олгохгүй, үнийг нөхөн төлөхгүй, мөнгөн төлбөр төлөхгүй. Үүнд:

a) Тухайн үед үйлчилж байсан хуулийн дагуу нийгэмчилсэн өмч, хөрөнгө (түүний дотор орон сууцны байшин),
b) Иргэний ба Эх орны дайны үед болон байгалийн гамшигт сүйтгэгдсэн, устсан хөрөнгө,
c) Газар, жимс, үр тарианы суулгац, хураагаагүй тариалан зэрэг болно.

Цагаатгагдсан иргэд, тэдний өв залгамжлагчдад олгох хэлмэгдүүлэлтийн явцад учруулсан эд материалын мөнгөн төлбөрийг холбооны төсвөөс санхүүжүүлнэ.

**3. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС**

Казахстан Улс нь улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох асуудлыг зохицуулах хүрээнд 1993 онд “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах тухай хууль”[75] ,2003 онд “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдэд мөнгөн төлбөр олгох тухай журам”[76] тус тус гаргасан байна.

Энэ хууль нь хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан аль ч улс оронд хилс хэргээр ял шийтгэл хүлээсэн бөгөөд одоо Казахстан Улсын иргэний харьяалалд байгаа иргэдийн хувьд мөн адил үйлчилнэ.

Эдгээр хууль эрхзүйн зохицуулалтаар улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, хэлмэгдсэн иргэд, тэдний гэр бүлд учруулсан сэтгэл зүйн болон материаллаг хохирлыг нөхөн төлөх арга хэмжээ авч, тэдний хязгаарлагдсан эрхийг буцаан сэргээсэн юм. Энэ хүрээнд хуульд дараах зохицуулалтуудыг оруулсан байна.

***Хэлмэгдсэн иргэний хязгаарлагдсан эрхийг сэргээх. Үүнд:***

1) Иргэнийг зохих журмын дагуу цагаатгасны дараа түүний хязгаарлагдсан эрх, гавьяа шагнал, цэргийн болон бусад цол хэргэмийг сэргээх. Хэрэв иргэний хэрэг бүхэлдээ биш, зөвхөн нэг хэсэг нь цагаатгагдсан бол түүнтэй холбоо бүхий хязгаарлагдсан эрхүүдийг сэргээнэ[77] .

[74]Тус Комисс нь ОХУ-ын Ерөнхийлөгчийн Зарлигаар ОХУ-ын Ерөнхийлөгчийн дэргэд 2004 онд байгуулагдсан. 2010 оны 2 дугаар сарын 17-ны өдрөөс ОХУ-ын Ерөнхийлөгчийн иргэд, байгууллагын өргөдөл, хүсэлтийг хүлээн авах Алба болсон. http://state.kremlin.ru/commission/25/statute
[75]О реабилитации жертв массовых политических репрессий (Закон Республики Казахстан от 14 апреля 1993 года) http://adilet.zan.kz/rus/docs/Z930002200.
[76]Об утверждении Правил выплаты денежных компенсаций жертвам массовых политических репрессий (Постановление Правительства Республики Казахстан от 23 января 2003 года N 82)-http://adilet.zan.kz/rus/docs/P030000082.
[77]О реабилитации жертв массовых политических репрессий (Закон Республики Казахстан от 14 апреля 1993 года). Статья 19. http://adilet.zan.kz/rus/docs/Z930002200.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

2) Иргэнийг амьдарч байсан газраас өөр газар нутагт албадан шилжүүлсэн, цөллөгт явуулсан бөгөөд үүнд тухайн үед түүнтэй хамт амьдарч байсан гэр бүлийн гишүүд, хамаатан садан мөн адил өртсөн бол хэлмэгдсэн иргэн болон түүнтэй хамаарал бүхий эдгээр хүмүүсийн өмнө амьдарч байсан газар нутаг руу буцах эрхийг сэргээх[78].
3) Иргэн байх эрх нь хасагдсан хүний харьяатын эрхийг сэргээх зэрэг орно.

***Нөхөн олговор олгох***

Улс төрийн хилс хэргээр баривчлах, эрх чөлөөг нь хязгаарлах, сэтгэл мэдрэлийн эмнэлэгт албадан эмчлүүлэх, цөллөгт явуулах, эрх чөлөөг нь хязгаарлаж албадан ажил хийлгэх зэргээр ял шийтгэл эдэлсэн иргэнийг хуулийн дагуу цагаатгаж мөнгөн төлбөр олгоно. Тухайн иргэнтэй цуг ял шийтгэлд өртсөн үр хүүхэд нь мөн адил мөнгөн төлбөр авна. Тухайн иргэний ял шийтгэл эдэлж байсан тухай баримт материалыг үндэслэн ял эдэлсэн сарын тоог тухайн иргэн нийгэм хамгааллын байгууллагад хандан хүсэлт гаргасан үеийн “сарын тооцооллын индекц”-ийн ¾-аар үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн төлбөр олгоно[79] .

*Жич: Сарын тооцооллын индекс* гэдэг нь хууль тогтоомжийн дагуу олгогдох халамжийн мөнгө, хуулийн дагуу төлөгдөх мөнгөн хэлбэрийн торгууль, татвар болон бусад мөнгөн төлбөрийг тооцоолоходхэрэглэх нэгж бөгөөд одоогийн байдлаар 1 852 тенгетэй тэнцүү байна[80].

Хэлмэгдсэн иргэн мөнгөн төлбөрийг заавал өөрөө авах ёстой. Хэрэв өөрөө нас барсан бол үр хүүхэд нь авах эрхтэй.

Иргэний мөнгөн төлбөр авах эрхийг түүнийг хуулийн дагуу цагаатгасан шүүх байгууллага тогтоодог.

Эрх бүхий иргэн хүсэлтээ харьяа нутаг дэвсгэрийн мөнгөн төлбөр олгох асуудлыг хариуцах байгууллагад гаргах бөгөөд холбогдох материалуудыг бүрдүүлж өгнө. Уг байгууллага нь материалыг холбогдох байгууллагуудаас лавлагаа аван хянаж үзээд, холбогдох дээд шатны байгууллагад шилжүүлнэ.

Мөнгөн төлбөрийг Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам, уг яамны харьяа Тэтгэврийн асуудал хариуцах төрийн төв байгууллага, банк болон түүнтэй адилтгах эрх бүхий байгууллага нь хуулийн дагуу өөр өөрийн хариуцах хүрээнд зохицуулан олгодог.

***Бусад хөнгөлөлт***

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэж, хуулийн дагуу цагаатгагдсан иргэн дараах хөнгөлөлтүүдийг эдлэх эрхтэй. Үүнд:
1. Тухайн иргэний хилс хэргээр хоригдож байсан, цөллөгт байсан, тусгай газар эрх чөлөөг нь хязгаарлаж албадан ажил хийлгэсэн, сэтгэл мэдрэлийн эмнэлэгт хүчээр эмчилгээнд байлгасан хугацааг өндөр насны тэтгэвэрт гарахад ажилласан жилд оруулах бөгөөд 3 дахин нэмэгдүүлж тооцох;

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[78]О реабилитации жертв массовых политических репрессий (Закон Республики Казахстан от 14 апреля 1993 года). Статья 20. http://adilet.zan.kz/rus/docs/Z930002200.
[79]О реабилитации жертв массовых политических репрессий (Закон Республики Казахстан от 14 апреля 1993 года). Статья 22. http://adilet.zan.kz/rus/docs/Z930002200.
[80]О республиканском бюджете на 2014 - 2016 годы. Закон Республики Казахстан от 3 декабря 2013 года № 148-V ЗРК. http://adilet.zan.kz/kaz/docs/Z1300000148/compare

2. Ажил хөдөлмөр эрхэлдэг бол ээлжийн амралтаа авах хугацааг өөрөө сонгох эрхтэй;
3. Амьдарч буй орон байраа үнэгүй хувьчилж авах;
4. Суурин утас эхний ээлжинд тавиулах;
5. Байр авахад дараалал харгалзахгүй эхний ээлжинд орох;
6. Өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан асрамжийн газарт эхний ээлжинд орох бөгөөд хуулийн дагуу хангамж эдлэх;
7. Протез болон ортопедийн хэрэгслийг хөнгөлөлттэй авах;
8. Цагаатгах асуудлаар өмгөөлөгчөөс үнэ төлбөргүй зөвлөгөө авах;
9. Байр, цахилгаан, халаалт, унааны зардалд зориулан жилд 1 удаа төрөөс тусгай тэтгэмж авах (1.07 “сарын тооцооллын индекц”-тэй тэнцэх хэмжээний[81]) зэрэг хөнгөлөлтийг эдэлнэ.

Эдгээр хөнгөлөлтийг хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд хамаарах бусад улс оронд хилс хэргээр ял шийтгэл эдэлж байсан бөгөөд одоо Казахстан Улсад байнга оршин суугаа тус улсын иргэн мөн адил эдэлнэ.

## 4. БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛС

Польшид улс төрийн хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор тухай асуудлыг «Төрийн хариуцлагын тухай хууль» /1956/ (*ustawa o odpowiedzialności Państwa za szkody wyrządzone przez funkcjonariuszyw państwowych*), “Польшийн иргэний хууль”/1964/-ийн 415-р зүйлийн “et” хэсэг, Польшийн Үндсэн Хууль”/1997/-ийн 77-р бүлгийн 1-р зүйл, “Ахмад дайчид болон Польшийн тусгаар тогтнолын төлөө үйл ажиллагааныхаа улмаас хилсээр буруутгагдан шийтгэгдсэн хүмүүсийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль” 1991 (*Ustawa o **uznaniu** za nieważne orzeczeń wydanych wobec osyb represjonowanych za działalność na rzecz niepodległego bytu Państwa Polskiego*) зэрэг хуулиудаар зохицуулж ирсэн байна.

1956 оны 11-р сарын 15-ны өдөр батлагдсан “Төрийн хариуцлагын тухай хууль[82]”-аар тухайн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн нэг жилийн хугацаанд Сталины дарангуйллын үед хэлмэгдэн баривчлагдсан, мөрдөгдсөн, нийгмээс тусгаарлагдсан, ял шийтгэл эдэлсний улмаас үүдсэн хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг иргэний шүүхэд гаргах эрхийг олгосон ч энэ нь хугацаа богино, нийгмийн хаалттай байдал зэргээс шалтгаалан төдий л үр дүнгээ өгөөгүй. Түүнээс хойш 1964 оны «Польшийн иргэний хууль»[83] -ийн 417-р зүйлд иргэний эрхийг зөрчсөнтэй холбогдох төрийн зохицуулалтыг зааж өгснөөс өөрөөр улс төрийн хэлмэгдэгчдийн эрхийг зохицуулсан хууль байсангүй.
Харин 1991 оны 2-р сарын 23-нд “Ахмад дайчид болон Польшийн тусгаар тогтнолын төлөө үйл ажиллагааныхаа улмаас хилсээр буруутгагдан шийтгэгдсэн хүмүүсийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль» батлагдсан. Уг хуулиар 1944 оны 1-р сарын 1-нээс 1956 оны 12-р сарын 31-нийг хүртэлх хугацаанд тодорхой улс төрийн зорилгоор буруутгагдсан хүмүүсийн хэргийг цагаатган гэм буруугүйд тооцох хуулийн үндэслэлүүдийг зааж, мөн тэдгээрт төрөөс хүлээх үүрэг хариуцлагыг зааж өгсөн байдаг.
Мөн 1997 оны «Польшийн Үндсэн Хууль[84] “-ийн 77 § 1-р зүйлд: *“Аливаа төрийн захиргааны байгууллагын хууль зөрчсөн аливаа үйлдлээс шалтгаалан ямар нэг хор хохирол амссан хэн болович түүнийг барагдуулах үүднээс нөхөх олговрыг авах эрхтэй.” гэж баталгаажуулсан байна.*

[81]О специальном государственном пособии в Республике Казахстан(Закон Республики Казахстан от 5 апреля 1999 года N 365). Статья 7.19. http://adilet.zan.kz/kaz/docs/Z990000365_#z9
[82]Ustawa o odpowiedzialności Państwa za szkody wyrządzone przez funkcjonariuszyw państwowych www.udskior.gov.pl/
[83]Мөн тэнд.
[84]Мөн тэнд.

Цагаатгал[85] **:** Ахмад дайчид болон Польшийн тусгаар тогтнолын төлөө үйл ажиллагааныхаа улмаас хилсээр буруутгагдан шийтгэгдсэн хүмүүсийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 1-р хэсгийн 1-р догол мөрд: "*1944 оны 1-р сарын 1-ээс 1956 оны 12-р сарын 31-нийг хүртэлх хугацаанд Польшийн шүүх, прокурор эсвэл дээд шүүхийн байгууллагуудаас хэрвээ хэн нэгнийг Польшийн тусгаар тогтнолын төлөөх үйл ажиллагаанд холбогдсон гэж буруутгасан эсвэл тэр мэт үйл ажиллагаанд оролцсон гэх үндэслэлээр шүүн тасалсан бүхий л шийдвэрийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж байна.*" хэмээн заажээ.

Хууль ёсоор дээрх заалтад хамаарах этгээдийг цагаатгуулах нэхэмжлэлийг Омбудсман, Хууль зүйн яам, прокурор, хэлмэгдэгч өөрөө, хууль ёсны төлөөлөгч, хэлмэгдсэн хүн нь нас барсан, гадаад оронд байгаа эсхүл сэтгэцийн өвчтэй бол түүний ойрын хамаатнууд, үрчилж авсан эцэг эх ба үрчилсэн хүүхэд, төрсөн ах дүү ба хань ижил, үр хүүхэд нь, мөн тусгаар тогтносон Польш улсын төлөөх үйл ажиллагааныхаа төлөө хэлмэгдсэн хүмүүсийн байгууллага нь Шүүхэд гаргаснаар хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгадаг байна.

Шүүхээс тухайн хэргийг шүүн тасалсан захиргааны баримт бичгүүдийг үндэслэн шийдвэрлэх ба, шаардлагатай тохиолдолд, цаашид нотлох баримтыг мөрдөн байцаах эрхтэй бөгөөд *1944 оны 1-р сарын 1-ээс 1989 оны 12-р сарын 31-нийг хүртэл хугацаанд цөлөгдсөн эсвэл тусгаар тогтносон Польш улсын төлөө хөдөлгөөнд холбогдсон ба тэрхүү хөдөлгөөний улмаас шийтгэгдсэн, мөн энэчлэн хөдөө аж ахуйн газар болон тариалан зэргийг албан ёсоор улсад тушаан хураалгах хэргийг эсэргүүцсэний төлөө яллагдсан* бүхий л хэргүүдийг бүрэн цагаатгаж ёстой хэмээн хуульчилсан байдаг байна.

Мөн хуулиар цэргийн хээрийн шүүх байсан дүүргийн эсхүл цэргийн дүүргийн шүүхийн шийдвэрүүдийг үндэслэлгүй гэж үзсэн бөгөөд ийнхүү шийдвэрийг хэрэгсэхгүй болгож буй нь суллан чөлөөлөхтэй адил гэж үзжээ. Энэ мэт ялыг цагаатгаваас хилсээр хэлмэгдсэн тухайн хүн энэ хуулийн 8-р хэсгийн 1-р догол мөрийг үндэс болгон Улсын сангаас нөхөх олговор нэхэмжлэх эрхтэй болсон байна.

**Нөхөх олговор:**[86]

Дээрх хуулиар улс төрийн хэлмэгдэгсдийг дайны ахмад дайчидтай адилтган үзэж, тэдгээртэй адил нөхөх олговор /санхүүгийн тэтгэлэг/, хөнгөлөлтүүдийг олгосон байдаг. Нөхөх олговор олгох болон хөнгөлөлт эдлүүлэхтэй холбогдох бүхий л зардлыг Улсын сангаас гаргахаар хуульчилсан байна.

Польшийн тусгаар тогтнолын төлөөх тэмцэлд оролцсон ахмад дайчид болон хэлмэгдэгч нь нөхөх олговрын нэхэмжлэлээ дүүргийн эсвэл цэргийн дүүргийн шүүхэд цагаатгах тогтоол гарснаас хойш 1 жилийн дотор гаргана. Ахмад дайчид болон хэлмэгдэгч нь нас барсан бол хань ижил, үр хүүхэд, түүний төрсөн эцэг эх нь нэхэмжлэл гаргах эрхтэй.

***Ахмад дайчдад олгох тэтгэмж, хөнгөлөлтүүд:***

Энэ нь 1914-1956 оны хооронд Польшийн тусгаар тогтнол ба төрийн төлөө тэмцэлд идэвхтэй оролцсон эсхүл холбоотны цэргийн ангиудад (ердийн ба нууц) хүмүүс юм. Үүнээс гадна Дэлхийн II дайны үеийн цэргийн албатай дүйцүүлэн адилд тооцох өөр бусад үйл ажиллагаанууд байдаг нь: Польшийн төрийн иргэний нууц засаг захиргаа, нууцаар ажиллаж байсан боловсролын үйл ажиллагаанд оролцсон багш нар, цаазын ял авах хүмүүсийг (жишээлэхэд, еврей удмын хүмүүсийг) нуун далдалж байсан хүмүүс зэрэг болно. Энэхүү тэтгэмж авах эрхтэй бүлэгт бас 1970 оны коммунист дэглэмийн эсрэг бослого тэмцэлд оролцогсдыг оруулах болжээ.

[85]Мөн тэнд.
[86]Мөн тэнд.

Эдгээр ахмад дайчдад дараах хөнгөлөлт, санхүүгийн тэтгэлгүүдийг олгоно. Үүнд:

a) ажилласан жил дээр нь нэмж тусгаар тогтнолын хөдөлгөөнд оролцсон хугацааг нь хоёроор өсгөн оруулж тооцох
b) жилд нэмэлт ажлын 10 өдрийн амралт эдлүүлэх,
c) сар бүр Польшийн мөнгөн нэгжээр 403 (97 евро орчим) тэтгэмж олгох,
d) хотын тээврийн хэрэгслээр зорчих үнэ тарифыг 50% бууруулж үйлчлэх,
e) дотоодын галт тэрэг ба автобусаар зорчих үнэ тарифыг 51% бууруулж үйлчлэх зэрэг байна.

Мөн ахмад дайчдад аливаа нийгмийн халамжийн үйлчилгээ ба ахмад настнуудад байр орон сууц олгох зэрэгт түрүүлж хамрагдах боломжийг олгодог. Санхүүгийн хүндрэл бэрхшээлтэй байгаа хүмүүст зохих хэмжээний санхүүгийн тусламж олгох нь хуулиар нээлттэй байдаг байна.
Ахмад дайчны эрхийг Польшийн иргэдэд эс бөгөөс тусгаар тогтнолын төлөө тэмцэлд орж байх үедээ эсхүл хавчигдан мөрдөгдөж байх үедээ Польшийн иргэн байсан хүмүүст олгоно.

***Улс төрийн дарамт шахалтын улмаас хэлмэгдэгчдэд олгох тэтгэлгүүд:***

Энэ нь 1939-1945 оны нацист дэглэм, 1939-1956 оны Зөвлөлтийн, 1944-1956 оны Польшийн коммунист дэглэмийн гэх зэрэг захиргаадалтын дэглэмийн хамгийн харгис хатуу улс төр, яс үндэс ба арьс өнгөний учир шалтгаанаар мөрдөгдөн хавчигдаж, яллагдсан хүмүүсийг хамааруулж байна. Үүнд шорон гяндан, хорих ангиуд, бөөнөөр хорих лагерь, бас энэчлэн ЗХУ-ын гүн рүү ачигдан хоригдож байсан хүмүүс багтана. Мөн алж устгах эсхүл Германчлах зорилгоор эцэг эхээсээ хүчээр булаагдан явсан хүүхдүүдийг хамруулан ойлгоно.
Эдгээр мөрдлөг хавчлагын золиос бологсдод мөн дараах хөнгөлөлт, санхүүгийн тэтгэлгүүдийг олгоно. Үүнд:

a) ажилласан жил дээр нь нэмж тусгаар тогтнолын хөдөлгөөнд оролцсон хугацааг нь хоёроор өсгөн оруулж тооцох
b) жилд нэмэлт ажлын 10 өдрийн амралт эдлүүлэх,
c) сар бүр Польшийн мөнгөн нэгжээр 403 (97 евро орчим) тэтгэмж олгох,
d) хотын тээврийн хэрэгслээр зорчих үнэ тарифыг 50% бууруулж үйлчлэх,
e) дотоодын галт тэрэг ба автобусаар зорчих үнэ тарифыг 51% бууруулж үйлчлэх зэрэг байна.

Мөн эдгээр хүмүүст ахмад дайчдад олгодог аливаа нийгмийн халамжийн үйлчилгээ ба байр орон сууц олгох зэрэгт түрүүлж хамрагдах боломжийг олгодог. Санхүүгийн хүндрэл бэрхшээлтэй байгаа хүмүүст зохих хэмжээний санхүүгийн тусламж олгох асуудал мөн хуулиар нээлттэй байдаг.

Дэлхийн II дайны үед цөлөгдөж хүчээр албадан хөдөлмөр эрхэлж байсан ба одоо Польшид оршин суугч Польш иргэд Гуравдугаар Рейх ба Зөвлөлт Социалист Холбоот Улсын хөдөлмөрийн лагериудад цөлөгдөн хоригдож албадан хөдөлмөр эрхэлж байсан хүмүүст мөнгөн тэтгэлэг болгох тухай 1996 оны 5-р сарын 31-ны хуульд заасан эрхүүдийг эдэлдэг. Эдгээрт дараах хүмүүс орно. Эдгээр хүмүүс сар бүр хэдий хугацаагаар цөлөгдсөн эсхүл хорих лагерьт хөдөлмөр эрхэлсэнээс шалтгаалан өөр өөр дүн хэмжээ бүхий мөнгөн тэтгэмж авна. Одоогийн байдлаар хамгийн ихдээ 206,76 Польшийн мөнгөн дэвсгэрт (50 евро орчим) байна.

Нас барсан ахмад дайчны болон мөрдлөг хавчлагын золиос болсон хэлмэгдэгчдийн ар гэрийнхэнд олгох хөнгөлөлт, санхүүгийн дэмжлэг:

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Өндөр насны тэтгэвэрт гарсан эсхүл тахир дутуугийн тэтгэмж авдаг, ахмад дайчин эсхүл мөрдлөг хавчлагын золиос бологсдын ар гэрийн хүнд Польшийн мөнгөний нэгжээр 196 (47 евро орчим) мөнгөн тэтгэмж өгөх ба, дотоодын галт тэрэг ба хот хоорондын үйлчилгээний автобусны үнэ тарифыг 51% бууруулж үйлчлэх эрх эдэлнэ.

Харин нас барсан ахмад дайчны ар гэрийн хүн гадаадад амьдардаг тохиолдолд Польшийн өндөр насны тэтгэвэр эсхүл тахир дутуугийн, эсхүл Европын Холбооны улсуудын лугаа адил хэмжээний тэтгэвэр олгоно.

## 5. БҮГД НАЙРАМДАХ БОЛГАР УЛС

Болгар улсад улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох асуудлыг 1991 онд батлагдсан Улс төрийн хэрэгт хэлмэгдсэн иргэнийг цагаатгах тухай /Political and Civil Vindication Act for individuals who have undergone Repressive action/[87] хуулиар зохицуулсан байна.

Тус хуулиар улс төрийн хэрэгт нийгмийн гарал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан нийгэмд аюултай этгээд гэж тооцож улс төрийн хилс хэрэгт 1944 оны 09 дүгээр сарын 12-ноос 1989 оны 11 дүгээр сарын 10-ныг хүртэлх хугацаанд хууль бусаар холбогдуулж хэлмэгдсэн иргэдийг цагаатгаж нэр төрийг нь сэргээх, нэг удаагийн нөхөн олговор олгох харилцааг зохицуулжээ.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгч гэж дор дурдсан хүмүүс хамаарна:

1. 1944-1945 онд Ардын шүүхээс эрүүгийн гэмт хэрэгт хилсээр ял шийтгүүлсэн болон цаазлагдсан;
2. Ял шийтгүүлээгүй боловч хууль бусаар хилс хэргээр холбогдон баривчлагдаж хөдөлмөрийн лагерь бусад газар хоригдсон;
3. Тухайн үеийн захиргааны шийдвэрээр нутаг заагдсан, эд хөрөнгөө хураалгасан;
4. Ажил албан тушаал, дунд сургууль болон их, дээд сургуулиас хөөгдсөн;
5. Хэлмэгдэгчтэй хамаарал бүхий этгээд гэж хүчээр тулгасан;
6. Баривчлагдаж сураггүй алга болсон.

***Улс төрийн хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, нөхөн олговор олгох***

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн цагаатгах улсын төв комисс */Central Commission on Political and Civil Vindication/* нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд зөвлөлийн тэргүүнээр Сайд нарын зөвлөлийн гишүүн байна. Комиссын бүрэлдэхүүнд хөдөлмөр, нийгмийн хамгаалал, сангийн яамны сайд, хэлмэгдсэн иргэдийн төлөөлөл 5 гишүүнээс бүрдэнэ.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн гэж үзэж байгаа этгээд өөрөө буюу гэр бүлийн аль нэг гишүүн, хууль ёсны төлөөлөгч, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах улсын төв комисс, түүний орон нутгийн салбарт гаргана.

Цагаатгах, нөхөн олговор олгох тухай гомдлыг сайд нарын зөвлөлөөс гомдол, саналыг үндэслэн журмын дагуу холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгах эсхүл ял шийтгүүлсэн нь тогтоогдоогүй бол гомдлыг хэрэгсэхгүй болгох шийдвэрийг аль нэгийг гаргана.

[87] Political and Civil Vindication Act for individuals who have undergone Repressive action. www.proyectos.cchs.csic.es/

*Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдэд олгох нөхөн олговрыг дор дурдсан этгээд нэхэмжлэх эрхтэй. Тухайлбал,*

1944-1945 онд Ардын шүүхээс эрүүгийн гэмт хэрэгт хилсээр ял шийтгүүлсэн болон цаазлагдсан, ял шийтгүүлээгүй боловч хууль бусаар хилс хэргээр холбогдон баривчлагдаж хөдөлмөрийн лагерь бусад газар хоригдсон, тухайн үеийн захиргааны шийдвэрээр нутаг заагдсан, эд хөрөнгөө хураалгасан, ажил албан тушаал, дунд сургууль болон их, дээд сургуулиас хөөгдсөн; баривчлагдаж сураггүй алга болсон хэлмэгдэгч өөрөө эсхүл өөрөө нас барсан бол түүний эхнэр нөхөр, хууль ёсны асран хамгаалагч, хэлмэгдэгсдийн төрсөн эцэг, эх , ах, эгч, дүү, ач, зээд нэг удаа нөхөн олговор олгоно.

1944-1945 онд Ардын шүүхээс эрүүгийн гэмт хэрэгт хилсээр ял шийтгүүлж цаазын ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгчдийн гэр бүлийн гишүүдэд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгах тухай тогтоол гаргаж, нэг удаа 60 мянган левийн нөхөн олговор олгоно.

Ял шийтгүүлээгүй боловч хууль бусаар хилс хэргээр холбогдон баривчлагдаж хөдөлмөрийн лагерь бусад газар хоригдсон хэлмэгдэгчид, хэрэв хэлмэгдэгч нас барсан бол түүний гэр бүлийн гишүүдэд сар бүр 1500 лев олгох бөгөөд нөхөн олговрын хэмжээ 50 мянган левээс хэтрэхгүй,

Тухайн үеийн захиргааны шийдвэрээр нутаг заагдсан, эд хөрөнгөө хураалгасан нэхэмжлэлийн бүрдүүлбэрээ хангасан хэлмэгдэгсдэд сар бүр 800 лев олгох бөгөөд нөхөн олговрын хэмжээ 20 мянган левээс хэтрэхгүй,

Ажил албан тушаал, сургууль болон их, дээд сургуулиас хөөгдсөн нэхэмжлэлийн бүрдүүлбэрээ хангасан хэлмэгдэгсдэд 10 мянган левийн нөхөн олговор нэг удаа олгоно.

Нэхэмжлэлийг бичгээр гаргах бөгөөд улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгч мөн болох нь хууль ёсоор тооцогдсон эрх бүхий байгууллагын шийдвэр, цагаатгагдсан үнэмлэх, нөхөн олговрыг авах эрхтэй бусад гэр бүлийн гишүүдийн бичиг баримт, нөхөн олговрыг ямар хэлбэрээр авах тухай харилцан тохиролцсоныг батлах баримтыг тус тус хавсаргана.

Нөхөн олговрыг олгох тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн дотор бэлэн мөнгөөр олгох бөгөөд Сангийн яамны сайд тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд багтаан тухай бүр нөхөн олговор олгох хэмжээг тогтооно.

* * *

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АШИГЛАСАН МАТЕРИАЛ


- М.Ринчин. Цагаатгал ба хэлмэгдүүлэлт. УБ. 2005 он.
- Улс төрийн талаар хэлмэгдэгчдийг цагаатгах тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль. 1998 он.
- Repression of the communist regime in Poland. www.slideshare.net/OWTF/repression-of-the-communist-regime-in-poland
- The rights and privileges of Veterans and Victims of Oppression have been defined in the Act of January 24th, 1991 on war veterans and victims of war and postwar oppression, the major act serving as the base of Polish veteran law. www.udskior.gov.pl/
- Об утверждении Правил выплаты денежных компенсаций жертвам массовых политических репрессий. http://adilet.zan.kz/rus/docs/P030000082
- О реабилитации жертв массовых политических репрессий. http://adilet.zan.kz/rus/docs/Z930002200
- Political and Civil Vindication Act for individuals who have undergone Repressive action. www.proyectos.cchs.csic.es/
- ФЗ ”О реабилитации жертв политических репрессий”. http://base.garant.ru
- ФЗ “Об обжаловании в суд действий и решений, нарушающих права и свободы граждан”. http://base.garant.ru
- “Положение о порядке возврата гражданам незаконно конфискованного, изьятого или вышедшего иным путем из владения в связи с политическими репрессиями имущества, возмещения его стоимости или выплаты денежной компенсации. www.zakonprost.ru
- Указ Президента РФ от 8 июня 1996 г. N 858 “О дополнительных мерах по реабилитации лиц, репрессированных в связи с участием в событиях в г. Новочеркасске в июне 1962 г.”, Об организации деятельности органов прокуратуры по исполнению и надзору за исполнением настоящего Закона см. приказ Генеральной прокуратуры РФ от 5 февраля 2008 г. N 21. http://base.garant.ru


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ (1992) БА МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗЫН ТӨСЛҮҮДИЙН (1991.VI.05, X.05, XI.07) ХАРЬЦУУЛАЛТ

*Г.Билгээ, Д.Жигваагүнсэл*

**ТАЙЛБАР:** -үг, өгүүлбэр шинээр нэмэгдсэнийг **тод хараар** (“**bold**”),
-үг, өгүүлбэрийг өөрчлөн найруулсныг доогуур зураасаар (“underline”),
-үг, өгүүлбэр хасагдсаныг ~~дундуур зураасаар~~ (“~~strikethrough~~”),
-зарчмын зөрүүтэй санал орхигдсон, өөрчлөлт орсон зэргийг тодруулав (“highlighting”) тус тус тэмдэглэв.

| **МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ** [88] **(ҮНДСЭН ХУУЛЬ)**<br><br>*(Улсын Бага Хуралд өргөн барьсан хувь)*<br>1991.04.19 | **МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ** [89] **(Үндсэн хууль)**<br><br>*(Ард түмнээр хэлэлцүүлсэн хувь)*<br>1991.06.05 | **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ**[90] **(ИХ ЦААЗ)**<br><br>*(Улсын Бага Хуралд өргөн барьсан хувь)*<br>1991.10.05 | **МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ** [91]<br><br>*(Улсын Бага Хурлаас Ардын Их Хуралд өргөн барьсан хувь)*<br>1991.11.07 | **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ** [92]<br><br>*(Батлагдсан хувь)*<br>1992.01.13 |
|---|---|---|---|---|
| **1-р төсөл** | **2-р төсөл** | **3-р төсөл** | **4-р төсөл** | **Үндсэн хууль** |
| Монголын ард түмэн:<br>– ~~үндэстнийхээ~~ төрт ёс, түүх, соёлын уламжлалыг нандигнан дээдэлж,<br>– эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган мандуулж,<br>– эрх, эрх чөлөө, ~~энэрэнгүй ёс~~, эв нэгдлийг эрхэмлэн сахиж,<br>– хүн төрөлхтений соёл иргэншлийг хүндэтгэн,<br>– ~~энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулахаа нотлон илэрхийлж~~,<br>– ~~улмаар~~ Монгол нутагт хүнлэг, иргэний ардчилсан нийгмийн ~~тогтолцоог~~ цогцлон хөгжүүлэх зорилгоор төрийн ~~Үндсэн хууль болсон~~ Улсын Их | Монголын ард түмэн **бид**:<br>– **хүний эрх, эрх чөлөө, шударга ес, үндэснийхээ** эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,<br>– төрт ес, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан залгамжилж,<br>– улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлнэ,<br>– хүн төрөлхтений соёл, иргэншлийг хүндэтгэн,<br>– эх орондоо хүнлэг, ардчилсан нийгмийг цогцлон хөгжүүлэх зорилгоор **Монгол** Улсын Их цаазыг даяар олонд зарлан тунхаглаж байна. | Монголын ард түмэн бид:<br>– Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,<br>– хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,<br>– төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан залгамжилж,<br>– хүн төрөлхтөний соёл иргэншлийн **ололтыг** хүндэтгэн ~~**харгалзаж**~~,<br>– эх орондоо иргэний ардчилсан нийгмийг цогцлон хөгжүүлэх зорилгоор Монгол Улсын үндсэн хуулийг даяар олонд зарлан тунхаглаж байна. | Монголын ард түмэн бид:<br>– улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,<br>– хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,<br>– төр ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,<br>– хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн **үзэж**,<br>– эх орондоо иргэний ардчилсан нийгмийг цогцлон хөгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их цаазыг даяар олноо зарлан тунхаглаж байна. | Монголын ард түмэн бид:<br>– улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,<br>– хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,<br>– төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,<br>– хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,<br>– эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан |

[88]УИХ, УИХТГ-ын архив, данс №1-91, х167-190.
[89]“Ардын эрх” сонин, 1991.06.05, №86 /158/.
[90]УИХ, УИХТГ-ын архив, данс №1-92, х165-199.
[91]УИХ, УИХТГ-ын архив, данс №1-92, х200-234.
[92]“Ардын эрх” сонин, 1992.01.14, №9 /313/.

| | | | | |
|---|---|---|---|---|
| цаазыг даяар олонд зарлан тунхаглаж байна. | | | | тунхаглаж байна. |
| **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ** | **Нэгдүгээр бүлэг.** | **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ** | **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ** | **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ** |
| **Монгол улсын бүрэн эрхт байдлыг илтгэн тунхаглах нь** | **Монгол улсын бүрэн эрхт байдлыг ~~илтгэн тунхаглах нь~~** | **МОНГОЛ УЛСЫН БҮРЭН ЭРХТ БАЙДАЛ** | **МОНГОЛ УЛСЫН БҮРЭН ЭРХТ БАЙДАЛ** | **МОНГОЛ УЛСЫН БҮРЭН ЭРХТ БАЙДАЛ** |
| **1 дүгээр зүйл** | **НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ** | **Нэгдүгээр зүйл** | **Нэгдүгээр зүйл** | **Нэгдүгээр зүйл** |
| 1. Монгол Улс ~~бол хөдөлмөрт үндэслэсэн хүнлэг, ардчилсан, шударга ёсыг эрхэмлэн дээдэлсэн~~, бүрэн эрхт, тусгаар тогтносон, хууль цаазат Улс мөн. | Монгол улс бүрэн эрхт, тусгаар тогтносон, хууль цаазат **ардчилсан** улс мөн. | 1. Монгол Улс **бол** тусгаар тогтносон, бүрэн эрхт, бүгд найрамдах улс мөн. | 1. Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, бүгд найрамдах улс мөн. | 1. Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн. |
| | | 2. Хуулийг дээдлэн ~~сахих~~, ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах нь төрийн эрхэм дээд зарчим мөн. | 2. Хууль дээдлэх, ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн. | 2. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн. |
| **2 дугаар зүйл** | **ХОЁРДУГААР ЗҮЙЛ** | **Хоёрдугаар зүйл** | **Хоёрдугаар зүйл** | **Хоёрдугаар зүйл** |
| Монгол улс нь төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна. | 1. Монгол улс нь төрийн байгууламжийн хувьд нэгдмэл ~~улс~~ байна. | 1. Монгол улс нь төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна. | 1. Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна. | 1. Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна. |
| ~~Түүний~~ нутаг дэвсгэр засаг захиргааны нэгжид хуваагдана. | 2. **Монгол улсын** нутаг дэвсгэр засаг захиргааны нэгжид хуваагдана. | 2. Монгол улсын нутаг дэвсгэр **зөвхөн** засаг захиргааны нэгжид хуваагдана. | 2. Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана. | 2. Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана. |
| **3 дугаар зүйл** | **ГУРАВДУГААР ЗҮЙЛ** | **Гуравдугаар зүйл** | **Гуравдугаар зүйл** | **Гуравдугаар зүйл** |
| Монгол улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн энэхүү эрхээ төрийн үйл хэрэгт шууд оролцож болон өөрсдөө сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаар уламжлан хэрэгжүүлнэ. | 1. Монгол улсад **төрийн** эрх **мэдэл** ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн энэхүү эрхээ төрийн үйл хэрэгт ~~**эрх тэгш**~~, шууд **оролцох** ~~**замаар**~~ болон өөрсдөө сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаар уламжлан хэрэгжүүлнэ. | 1. Монгол улсад **засгийн бүх** эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн энэхүү эрхээ төрийн үйл хэрэгт шууд оролцож болон өөрсдөө сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаар уламжлан хэрэгжүүлнэ. | 1. Монгол Улсад засгийн бүх эрхийг ард түмэн мэднэ. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцох ~~болон өөрсдөө~~ сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаар**аа** уламжлан **энэхүү** эрхээ эдэлнэ. | 1. Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, **мөн** сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ. |
| | 2. Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг цээрлэнэ. | 2. Төрийн засаг /эрх мэдэл/-ийг хууль бусаар авах, авахаар завдахыг төр, ард түмний эсрэг хүнд гэмт хэрэгт тооцно**.** | 2. Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно. | 2. Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно. |
| **4 дүгээр зүйл** | **ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ** | **Дөрөвдүгээр зүйл** | **Дөрөвдүгээр зүйл** | **Дөрөвдүгээр зүйл** |
| Монгол улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан | 1. Монгол улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил халдашгүй дархан байна. | 1. Монгол улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, **улсын** хил халдашгүй дархан | 1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан | 1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан |

| | | | | |
|---|---|---|---|---|
| байна. | | байна. | байна. | байна. |
| Монгол улсын торгон хилийг хуулиар бататган бэхжүүлнэ. | 2. Монгол улсын ~~**торгон**~~ хилийг ~~**хөрш улстай байгуулсан гэрээг үндэслэн**~~ хуулиар батална. | 2. Монгол улсын хилийг хуулиар бататгана. | 2. Монгол Улсын хилийг хуулиар бататгана. | 2. Монгол Улсын хилийг хуулиар бататгана. |
| Монгол Улсын Их Хурл<u>ын</u> баталсан хуульгүйгээр Монгол улсын торгон хилийг өөрчлөх, гадаадын цэргийн ~~хүчийг~~ Монголын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэхээр улсын хил нэвтрүүлэхийг хориглоно. | 3. Монгол Улсын ~~**Их Хурл**~~<u>**аас**</u> ~~**баталсан**~~ хуульгүйгээр Монгол улсын торгон хилийг өөрчлөх, гадаадын цэргийг Монголын нутаг дэвсгэрт байрлуулах буюу дамжин өнгөрүүлэхээр улсын хил нэвтрүүлэхийг хориглоно. | 3. ~~**Монгол улсын**~~ хуульгүйгээр ~~Монгол улсын торгон хилийг өөрчлөх~~, гадаадын цэргийн **хүчийг** Монголын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэхээр улсын хил нэвтрүүлэхийг хориглоно. | 3. Хуульгүйгээр гадаадын цэргийн хүчийг өөрийн нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэхээр улсын хил нэвтрүүлэхийг хориглоно. | 3. Хууль гаргахгүйгээр гадаадын цэргийн хүчнийг **Монгол Улсын** нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэхээр улсын хил нэвтрүүлэхийг хориглоно. |
| Монгол улс нэлттэй далай, тэнгис, сансрын уудмыг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчим, Монгол улсын олон улсын гэрээний дагуу эзэмших, ашиглах явдлыг өөрийн бүрэн эрхэнд хадгална. | 4. Монгол улс нэлттэй, далай, ~~тэнгис~~, сансрын уудмыг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчим, Монгол улсын олон улсын гэрээний дагуу эзэмших, ашиглах явдлыг өөрийн бүрэн эрхэд хадгална. | 4. Монгол улс нэлттэй далай, сансрын уудмыг олон улсын **Эрх зүйн** нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчим, Монгол улсын олон улсын гэрээний дагуу эзэмших, ашиглах явдлыг өөрийн бүрэн эрхэд хадгална. | | |
| **Тавдугаар зүйл** | **ТАВДУГААР ЗҮЙЛ** | **Тавдугаар зүйл** | **Тавдугаар зүйл** | **Тавдугаар зүйл** |
| Монгол улс эдийн засгийн түгээмэл харилцаанд үндэслэсэн, өөрийн орны уламжлал, онцлогийг харгалзсан эдийн засгийн бие даасан бодлого явуулна. | 1. Монгол улс эдийн засгийн түгээмэл ~~харилцаанд үндэслэсэн~~, өөрийн орны уламжлал, онцлогийг харгалзсан эдийн засгийн бие даасан бодлого явуулна. | 1. Монгол улс ~~**нь**~~ **дэлхийн** эдийн засгийн **хөгжлийн** түгээмэл <u>хандлага</u>, <u>өөрийн орны өвөрмөц нөхцөлийг харгалзсан олон хэвшил бүхий эдийн засагтай байна.</u> | 1. Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц ~~нөхцлийг харгалзсан~~ олон хэвшил бүхий эдийн засагтай байна. | 1. Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц <u>онцлогт нийцсэн</u> олон хэвшил бүхий эдийн засагтай байна. |
| Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, тэдгээрийн эрх тэгш, халдашгүй байдлыг хуулиар хамгаална. | 2. Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, ~~тэдгээрийн эрх тэгш~~, ~~халдашгүй байдлыг~~ хуулиар хамгаална. | 2. Төр ~~нь нийтийн болон хувийн~~ өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, **өмчлөгчийн эрхийг** хуулиар хамгаална. | 2. Төр өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална. | 2. Төр **нь нийтийн болон хувийн** өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална. |
| Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. | 3. ~~Өмчлөгчийн~~ эрхийг гагцхүү хуул<u>иар</u> хязгаарлаж болно. | 3. Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуул<u>ьд</u> **заасан үндэслэл, журмаар** хязгаарлаж болно. | 3. Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэл ~~журмаар~~ хязгаарлаж болно. | 3. Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэл**ээр** хязгаарлаж болно. |
| | | 4. Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, эдийн засгийн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн улс орныхоо эдийн засгийг зохицуулна. | 4. Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, ~~эдийн засгийн~~ бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн ~~улс орныхоо~~ эдийн засгийг зохицуулна. | 4. Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, **аж ахуйн** бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна. |
| | | 5. Эдийн засгийн аливаа хэвшлийн хөгжил нь хүний эрх болон үндэсний эдийн засгийн | | |

EKH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | аюулгүй байдлын ашиг сонирхолд нийцэж байвал зохино. | | |
| | | | | 5. Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна. |
| **6 дугаар зүйл** | **ЗУРГАДУГААР ЗҮЙЛ** | **Зургадугаар зүйл** | **Зургадугаар зүйл** | **Зургадугаар зүйл** |
| Монгол улсад газар, түүний хэвлий, ус, ой, ан амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна. | 1. Монгол улсад газар, түүний хэвлий, ус, ой, ан амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна. | 1. Монгол улсад газар, түүний хэвлий, ус, ой, ан амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна. | 1. Монгол Улсад газар, түүний хэвлий, ус, ой, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна. | 1. Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна. |
| | | 2. Ус, ойн сан, ан амьтан, байгалийн бусад баялаг бол төрийн өмч мөн. | 2. ~~Ус~~, ой, амьтан, байгалийн бусад баялаг бол төрийн өмч мөн. | 2. **Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн** газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн. |
| Төрөөс газрыг Монгол улсын иргэдэд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй. | 2. Төрөөс газрыг Монгол улсын иргэдэд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй. | 3. ~~Төрөөс~~ **бэлчээр, нийтийн эдэлбэрийн болон улсын тусгай хэрэгцээнийхээс бусад** газрыг **зөвхөн** Монгол улсын иргэдэд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй. | 3. Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй. | 3. Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй.<br><br>**Иргэд хувийн өмчийнхөө газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэх, түүнчлэн төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно.** |
| | | 4. Төр нь газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг сольж буюу эргүүлэн авах, хэрэв уул газрыг байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно. | 4. Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уул газрыг байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно. | 4. Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг **хүн амын эрүүл мэнд**, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно. |
| | | 5. Төрийн өмчийн газрыг | 5. ~~Төрийн өмчийн газрыг~~ | 5. **Төрөөс** гадаадын иргэн, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Монгол улсын болон гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүст түрээсээр, түүнчлэн хуульд заасан бусад болзол, хэлбэрээр эзэмшүүлэн, эдлүүлж болно. | ~~Монгол улсын болон~~ гадаадын иргэн, харьяалалгүй хүнд ~~түрээсээр, түүнчлэн~~ хуульд заасан бусад болзол, хэлбэрээр эзэмшүүлэн эдлүүлж болно. | хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг **төлбөр, хугацаатайгаар** болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно. |
| **7 дугаар зүйл** | **ДОЛДУГААР ЗҮЙЛ** | **Долдугаар зүйл** | **Долдугаар зүйл** | **Долдугаар зүйл** |
| Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйлс, шинжлэх ухаан, оюуны өв сан төрийн хамгаалалтад байна. | 1. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйлс, шинжлэх ухаан, оюуны өв сан төрийн хамгаалалтад байна. | 1. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйлс, шинжлэх ухаан, оюуны өв сан төрийн хамгаалалтад байна. | 1. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна. | 1. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна. |
| Оюуны үнэт зүйлс бол Монгол улсын нийгмийн баялаг мөн. | 2. Оюуны өмч бол Монгол улсын ~~нийгмийн~~ баялаг мөн. | 2. Иргэдийн туурвисан оюуны үнэт зүйлс бол **түүнийг зохиогчийн өмч**, Монгол улсын үндэсний баялаг мөн. | 2. Иргэдийн туурвисан оюуны үнэт зүйл бол түүнийг зохиогчийн өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн. | 2. Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн. |
| **8 дугаар зүйл** | **НАЙМДУГААР ЗҮЙЛ** | **Наймдугаар зүйл** | **Наймдугаар зүйл** | **Наймдугаар зүйл** |
| Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн. | 1. Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн. | 1. Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн. | 1. Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн. | 1. Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн. |
| Энэ нь бусад үндэстэн эх хэлээрээ суралцах, ажил хэргээ явуулах эрхээ эдлэхэд саад болохгүй. | 2. **Монгол хэлийг төрийн албан ёсны хэл болгон хэрэглэх нь** бусад үндэстэн эх хэлээрээ суралцах, ажил хэргээ явуулах эрхээ эдлэхэд саад болохгүй. | 2. Энэ зүйлийн 1-д заасан үндэслэл нь хүн амын өөр хэл бүхий хэсэг эх хэлээрээ суралцах, **харилцах**, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа эрхлэхэд саад болохгүй. | 2. Энэ зүйлийн 1-д заасан үндэслэл нь хүн амын өөр хэл бүхий **үндэстний цөөнх** эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа эрхлэхэд саад болохгүй. | 2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө. |
| **9 дүгээр зүйл** | **ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ** | **Ес дүгээр зүйл** | **Есдүгээр зүйл** | **Есдүгээр зүйл** |
| Монгол улсад сүм хийд, төрөөс, сургууль шашнаас тусгаар байна. | 1. Монгол улсад сүм хийд, төрөөс, сургууль шашнаас тусгаар байна. | 1. Монгол улсад сүм хийд төрөөс, иргэний боловсрол шашнаас, тусгаар байна. **Шашны боловсролыг шашны сургуулиар олгоно.** | 1. Монгол Улсад сүм хийд, төрөөс, иргэний боловсрол шашнаас тусгаар байна. Шашны боловсролыг шашны сургалтаар олгоно. | 1. Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ. |
| Сүм хийдээс улс төрийн үйл ажиллагаа явуулахыг үл зөвшөөрнө. | 2. Сүм хийдээс улс төрийн үйл ажиллагаа явуулахыг үл зөвшөөрнө. | Төрийн байгууллага нь шашны үйл ажиллагаа, сүм хийд, ~~шашны бусад байгууллага нь~~ улс төрийн үйл ажиллагаа эрхлэн явуулж болохгүй. | Төрийн байгууллага шашны ~~үйл ажиллагаа,~~ сүм хийд, улс төрийн үйл ажиллагаа эрхлэн явуулж болохгүй. | 2. Төрийн байгууллага шашны, сүм хийд улс төрийн үйл ажиллагаа эрхлэн явуулж болохгүй. |
| | | 2. Төр ~~нь хүний шашин шүтэх эрх чөлөөг хангах зарчимд нийцүүлэн төр,~~ түүний байгууллагуудаас сүм хийд, ~~шашны бусад байгууллагатай~~ харилцах ~~талаархи~~ үйл ажиллагааг хуулиар зохицуулан ~~хамгаална~~. | 2. Төр, түүний байгууллагаас сүм хийдтэй харилцах үйл ажиллагааг **шашин шүтэх эрх чөлөөг хангах зарчимд нийцүүлэн** хуулиар зохицуулна. | 3. Төр, сүм хийдийн хоорондын харилцааг хуулиар зохицуулна. |
| **10 дугаар зүйл** | **АРАВДУГААР ЗҮЙЛ** | **Аравдугаар зүйл** | **Аравдугаар зүйл** | **Аравдугаар зүйл** |
| Монгол улс олон улсын | 1. Монгол улс олон улсын | 1. Монгол улс олон улсын | 1. Монгол Улс олон улсын **эрх** | 1. Монгол Улс олон улсын эрх |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудыг ~~түүштэй~~ баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна.<br><br>Монгол улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахиж биелүүлнэ. | нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна. | нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчм~~уу~~дыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна. | **зүйн** нийтээр хүлээн зөвшөөрсөн **хэм хэмжээ**, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна. | зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна. |
| | 2. Монгол улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахиж биелүүлнэ. | 2. Монгол улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. | 2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. | 2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. |
| | | **3.** ~~Монгол улсын хууль тогтоомж нь олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээтэй уялдсан байвал зохино.~~<br>Монгол улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хүчин төгөлдөр ~~байна.~~ | 3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил **үйлчилнэ.** | 3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. |
| Монгол улсын бүрэн эрх, тусгаар тогтнол, ард түмний эрх ашигт харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг Монгол улс дагаж мөрдөхгүй. | 3. ~~Монгол улсын бүрэн эрх, тусгаар тогтнол, ард түмний эрх ашигт~~ харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг Монгол улс дагаж мөрдөхгүй. | 4. **Үндсэн хуульд** харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг Монгол улс дагаж мөрдөхгүй. | 4. Монгол улс Их цаасдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй. | 4. Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй. |
| | | **Арван нэгдүгээр зүйл** | **Арван нэгдүгээр зүйл** | **Арван нэгдүгээр зүйл** |
| | | 1. Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдлыг хангах нь төрийн үүрэг мөн. | 1. Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдлыг хангах нь төрийн үүрэг мөн. | 1. Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн. |
| | | 2. Монгол улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний зохион байгуулалт, түүнд албан хаах журмыг хуулиар тогтооно. | 2. Монгол улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно. | 2. Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний **бүтэц,** зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно. |
| **11 дүгээр зүйл**<br>Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, далбаа, дуулал мөн. | **АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ**<br>1. Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь төрийн сүлд, далбаа, дуулал мөн. | **Арван хоёрдугаар зүйл**<br>1. Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, туг, **тамга**, дуулал мөн. | **Арван хоёрдугаар зүйл**<br>1. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, туг, тамга, дуулал мөн. | **Арван хоёрдугаар зүйл**<br>1. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, туг, **далбаа,** тамга, дуулал мөн. |
| Төрийн сүлд, далбаа, дуулал нь монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, суу хийморийг илэрхийлэнэ. | 2. Төрийн сүлд, далбаа, дуулал нь монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлэнэ. | 2. Төрийн сүлд, туг, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ. | 2. Төрийн сүлд, туг, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ. | 2. Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ. |

| | | | |
|---|---|---|---|
| **АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ** | | | |
| 1. ~~Монгол улсын~~ Төрийн сүлд нь ариун цагаан цэцэг дээр суурилуулсан "Алтан соёмбо" байна. | 3. Төрийн сүлд нь ариун цагаан цэцэг дээр суурилуулсан "Алтан соёнбо" байна. | 3. Төрийн сүлд нь цагаан улаан хосолсон тасман хөвөөтэй хөх цэнхэр тойрог дотор элгэндээ дөрвөлжин хөх дэвсгэр дээр нар, сар, гал гурвыг мандуулж, эв эеийг илтгэх багц таван сумыг атгасан шонхор шувууг дүрсэлсэн байна. Сүлдний дээд хэсгээр бидний улс юу санасан есөн хүсэл бүтэхийн их бэлгэдэл есөн цагаан одыг зэллүүлэн зурсан байна. | 3. Төрийн сүлд нь ариун цагаан өнгийн бадам цэцэг суурьтай, төгсгөлгүй үргэлжлэн дэлгэрэх түмэн насан хээгээр хөвөөлсөн, мөнх тэнгэрийг бэлгэдсэн дугариг хөх дэвсгэртэй байна. Сүлдний төв хэсэгт Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, цог хиймориг илтгэсэн алтан соёмбо, эрдэнийн хүлгийг хослуулан дүрсэлсэн байна. Сүлдний хүрээний магнайн хэсэгт эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийг бэлгэдсэн хүслийг хангагч чандмань эрдэнэ, доод хэсэгт эх газрыг төлөөлсөн ногоон өнгийн уулан хээ, ашид дэвжихийн өлзий хутаг оршсон хүрдийг тус тус дүрсэлнэ. Хүрдийг хадгаар дээдлэн сүлжсэн байна. |
| **АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ** | | | |
| 1. Монгол улсын Төрийн далбааг үйлдэхдээ Төрийн сүлдийг үндэс болгоно. | | | |
| | | | 4. Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан туг нь Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл мөн. |
| 2. Төрийн далбааны дунд хэсэг нь тэнгэрийн хөх цэнхэр өнгөтэй, хоёр хажуу нь улаан өнгөтэй байх бөгөөд ишин талын улаан дэвсгэрийн дунд "Алтан соёмбо" дүрсэлсэн байна. | 4. Төрийн тугны дунд хэсэг нь тэнгэрийн хөх цэнхэр өнгөтэй, хоёр хажуу нь улаан өнгөтэй байх бөгөөд ишин талын улаан дэвсгэрийн дунд "Алтан соёнбо" дүрсэлсэн байна. | 4. Төрийн тугийн дунд хэсэг нь **мөнх** хөх тэнгэрийн өнгөтэй **зөв тэгш өнцөгт,** 2 хажуу нь цагаан зурвасан дэвсгэрийг голлосон босоо улаан тасам байна. Цагаан зурвасуудын гадна талд хөх өнгийн босоо тэгш өнцөгт байна. Дунд талын дөрвөлжин хөх дэвсгэрийн төвд цагаан лянхуан дээр суурилсан "Алтан соёмбо" байна. | 5. Монгол Улсын төрийн далбаа нь улаан, хөх, улаан хосолсон өнгөтэй байна. Далбааны гурав хуваасны нэгийн хэмжээтэй дундах хэсэг нь мөнх тэнгэрийн хөх, түүний хоёр тал нь мандан бадрахын бэлгэдэл улаан өнгөтэй байна. Далбааны ишин талын улаан дэвсгэрийн төв хэсэгт алтан соёмбо байрлуулна. |
| 3. Төрийн далбааны өргөн, урт нь 1:2-ын харьцаатай байна. | Төрийн тугны өргөн, урт нь 1:2-ын харьцаатай байна. | ~~Төрийн тугийн~~ өргөн, урт нь 1:2-ын харьцаатай байна. | Далбааны өргөн, урт нь 1:2-ын харьцаатай байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 5. Төрийн тамга нь цагаан шонхрын дүрс бүхий бариултай, дөрвөлжин хэлбэртэй, ~~түүний~~ голд Монгол улсын сүлдийг дүрсэлсэн, сүлдний хоёр талаар Монгол улс гэсэн үсэг ~~бүхий байх ба түүнийг Улсын~~ Ерөнхийлөгч барина. | 5. Төрийн тамга ~~шонхрын дүрс бүхий бариултай,~~ дөрвөлжин хэлбэртэй, голд**оо** Монгол улсын сүлдтэй, сүлдний 2 талаар Монгол улс гэсэн үсэгтэй байна.<br>6. **Төрийн тамгыг** Ерөнхийлөгч барина. | 6. Төрийн тамга дөрвөлжин хэлбэртэй, голдоо төрийн сүлдтэй, сүлдний хоёр талаар Монгол Улс гэсэн бичээстэй, арслангийн дүрс бүхий бариултай байна.<br><br>Төрийн тамгыг **Монгол Улсын** Ерөнхийлөгч барина. |
| | **АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ** | | | |
| ~~Төрийн сүлд, далбааны бүрдэл, хэв маяг,~~ дууллын үг, ая болон төрийн бэлэг тэмдгүүдийг дээдлэн хэрэглэх журмыг хуулиар батлатган ~~тогтооно~~. | 1. ~~Монгол улсын~~ төрийн бэлгэ тэмдгүүдийг дээдлэн хэрэглэх журам, төрийн дууллын үг, аяыг хуулиар батлатгана. | 6.Төрийн бэлгэ тэмдгийг дээдлэн хэрэглэх журам, төрийн дууллын үг, аяыг хуулиар батлатгана. | 7.Төрийн бэлгэ тэмдгийг дээдлэн хэрэглэх журам, төрийн дууллын үг, аяыг хуулиар батлатгана. | 7.Төрийн бэлгэ тэмдгийг дээдлэн хэрэглэх журам, төрийн дууллын үг, аяыг хуулиар батлатгана. |
| Монгол улсын төрийн байгууллагуудын тамга дөрвөлжин хэлбэртэй, өр дунд нь төрийн сүлд, түүний хоёр талаар тухайн байгууллагын нэрийг сийлсэн байна. | | | | |
| Төрийн тамгыг үйлдэх, хэрэглэх, залах, хадгалах журмыг Улсын Их Хурал тогтооно. | | | | |
| **12 дугаар зүйл** | **АРВАН ТАВ ДУГААР ЗҮЙЛ.** | **Арван гуравдугаар зүйл** | **Арван гуравдугаар зүйл** | **Арван гуравдугаар зүйл** |
| Монгол улсын төрийн дээд байгууллагууд байнга орших хотыг Улсын нийслэл тооцож түүний онцгой байр суурийг хуулиар батлатгана. | 1. Монгол улсын Төрийн дээд байгууллагууд байнга орших хотыг Улсын нийслэл ~~гэж тооцож түүний онцгой байр суурийг хуулиар батлатгана.~~ | 1. Монгол улсын төрийн дээд байгууллагууд байнга орших хотыг Улсын нийслэл гэнэ. | 1. Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга орших хотыг Улсын нийслэл гэнэ. | 1. Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. |
| Монгол улсын нийслэл бол Улаанбаатар хот мөн. | 2. Монгол улсын нийслэл ~~бол~~ Улаанбаатар хот мөн. | | | Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн. |
| | | 2. Монгол Улсын нийслэлийн нэр, орших газар, эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. | 2. Монгол Улсын нийслэлийн ~~нэр, орших газар,~~ эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. | 2. Монгол Улсын нийслэлийн эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. |
| **ХОЁРДУГААР БҮЛЭГ** | **Хоёрдугаар бүлэг** | **ХОЁРДУГААР БҮЛЭГ** | **ХОЁРДУГААР БҮЛЭГ** | **ХОЁРДУГААР БҮЛЭГ** |
| **ХҮНИЙ ЭРХ ЭРХ ЧӨЛӨӨГ ИЛТГЭН ТУНХАГЛАХ НЬ** | **ХҮНИЙ ЭРХ ЭРХ ЧӨЛӨӨГ ИЛТГЭН ТУНХАГЛАХ НЬ** | **ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ** | **ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ** | **ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ** |
| **13 дугаар зүйл** | **АРВАН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ** | **Арван дөрөвдүгээр зүйл** | **Арван дөрөвдүгээр зүйл** | **Арван дөрөвдүгээр зүйл** |
| ***Хуулийн төслийн 16-р зүйлийн 13-т тусгагдсан байна:***<br><br>иргэн бүр хууль ба шүүхийн | ***Хуулийн төслийн 19-р зүйлийн 14-т тусгагдсан байна:***<br><br>иргэн бүр хууль ба шүүхийн | 1. **Монгол улсад хууль ёсоор оршин суугаа хүн** бүр хууль ба шүүхийн өмнө эрх тэгш байна. | 1. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. | 1. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| өмнө эрх тэгш байна. | өмнө эрх тэгш байна. | | | |
| Монгол улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн болон эд хөрөнг~~ийн байдал~~, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад нөхцөл байдлаар ялгаваргүй эрх тэгш байна. | ~~Монгол улсад хүн бүр~~ үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, эд хөрөнгө, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ~~болон бусад нөхцөл~~ байдлаар ялгаваргүй эрх тэгш байна. | 2. **Хүнийг** үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, эд хөрөнгө, эрхэлсэн ажип, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролын байдлаар ялгаварлан гадуурхаж болохгүй. **Хүн бүрийн эрх зүйн ~~харилцаанд~~ субъект байх эрхийг хуулиар хамгаална.** | 2. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, эд хөрөнгө, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж болохгүй. Хүн бүр эрх зүйн субъект байх эрхтэй. | 2. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө **чинээ,** эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна. |
| **14 дүгээр зүйл** | **АРВАН ДОЛДУГААР ЗҮЙЛ** | **Арван тавдугаар зүйл** | **Арван тавдугаар зүйл** | **Арван тавдугаар зүйл** |
| Монгол улсын иргэд Улсын Их цаазад заасан эрхийг эдэлж, үүргийг төрийн өмнө хариуцан гүйцэтгэнэ. | 1. Монгол улсын иргэд Улсын Их цаазад заасан эрхийг эдэлж, үүргийг төрийн өмнө хариуцан биелүүлнэ. | | | |
| Монгол улсын иргэний харьяалал хийгээд харьяат болох, харьяатаас гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтооно. | 2. Монгол улсын иргэний харьяалал хийгээд харьяат болох, харьяатаас гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтооно. | 1. Монгол улсын иргэний харьяалал хийгээд харьяат болох, харьяатаас гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтооно. | 1. Монгол Улсын иргэний харьяалал хийгээд харьяат болох, харьяатаас гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтооно. | 1. Монгол Улсын иргэний харьяалал хийгээд харьяат болох, харьяатаас гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтооно. |
| | 3. Монгол улсын иргэнийг харьяатаас хасаж болохгүй. | 2. Монгол улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно. | 2. Монгол Улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно. | 2. Монгол Улсын иргэнийг харьяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно. |
| **15 дугаар зүйл** | **АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ** | **Арван зургадугаар зүйл** | **Арван зургадугаар зүйл** | |
| Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэдийн эрх, үүргийг Монгол улсын хууль болон уул иргэнийг харьялах улстай байгуулсан гэрээгээр, | 1. Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэдийн эрх, үүргийг Монгол улсын хууль болон уул иргэнийг харьялах улстай байгуулсан гэрээгээр **тогтооно.** | 1. Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэдийн эрх, үүргийг Монгол улсын хууль болон уул иргэнийг харьялах улстай байгуулсан гэрээгээр тогтооно. | 1. Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол улсын хууль, уул иргэнийг харьялах улстай байгуулсан гэрээгээр тогтооно. | ***Үндсэн хуулийн төслийн 18-р зүйлийн 1-т тусгагдсан байна:*** Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, уул иргэнийг харьялсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно. |
| | | 2. Монгол улс олон улсын гэрээгээр гадаадын иргэдийн эрх, үүргийг тодорхойлохдоо уул иргэнийг харьялсан улстай энэ талаар харилцан адил байх зарчмыг баримтална. | 2. Монгол улс олон улсын гэрээгээр гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо уул иргэнийг харьялсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримтална. | ***Үндсэн хуулийн төслийн 18-р зүйлийн 2-т тусгагдсан байна:*** Монгол Улс олон улсын гэрээгээр гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо уул иргэнийг харьялсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримтална. |
| харьяалалгүй хүмүүсийн эрх, үүргийг Монгол улсын хуулиар | 2. **Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа** харьяалалгүй | 3. Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа харьяалалгүй | 3. Монгол улс нутаг дэвсгэртээ байгаа харьяалалгүй хүний эрх, | ***Үндсэн хуулийн төслийн 18-р зүйлийн 3-т тусгагдсан*** |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| тус тус тогтооно. | хүмүүсийн эрх, үүргийг Монгол улсын хуулиар тогтооно. | хүмүүсийн эрх, үүргийг Монгол улсын хуулиар тогтооно. | үүргийг өөрийн хуулиар тогтооно. | ***байна:***<br><br>Монгол Улс нутаг дэвсгэртээ байгаа харьяалалгүй хүний эрх, үүргийг өөрийн хуулиар тогтооно. |
| | | 4. Үзэл бодол, улс төрийн <u>болон</u> шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан, мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслал бүхий хүсэлт гаргавал Монгол улсад орогнох эрх олгож болно. | 4. Үзэл бодол, улс төрийн <u>хийгээд</u> шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан, мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол улсад орогнох эрх олгож болно. | ***Үндсэн хуулийн төслийн 18-р зүйлийн 4-т тусгагдсан байна:***<br><br>Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол Улсад орогнох эрх олгож болно. |
| **16 дугаар зүйл** | **АРВАН ЕС ДҮГЭЭР ЗҮЙЛ** | **Арван долдугаар зүйл** | **Арван долдугаар зүйл** | **Арван зургадугаар зүйл** |
| Монгол улсын иргэд дараах үндсэн эрхийг баталгаатай эдэлнэ. | Монгол улсын иргэд дараах үндсэн эрхийг баталгаатай эдэлнэ. | Монгол улсын иргэд дараах үндсэн эрхийг баталгаатай эдэлнэ: | Монгол Улсын иргэн дараах үндсэн эрхийг баталгаатай эдэлнэ: | Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: |
| 1) иргэн бүр амьдрах, эрүүл саруул орчинд аж төрөх эрхтэй. Хүний амь насыг дур зоргоор бусниулахыг хатуу цээрлэнэ; | 1) иргэн бүр амьдрах, эрүүл саруул орчинд аж төрөх эрхтэй. Хүний амь насыг зоргоор бусниулахыг хатуу цээрлэнэ; | 1/ <u>амьдрах эрхтэй. Монгол улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь насыг бусниулахыг хатуу хориглоно</u>. ~~**Гэмт хэрэг үйлдэхийн өмнө 18 нас хүрээгүй байсан этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд, 60-аас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй;**~~ | 1/ амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно; | 1/ амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно; |
| | | 2/ эрүүл, аюулгүй орчинд амьдарч, аж төрөх, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалагдах эрхтэй; | 2/ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй; | 2/ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй; |
| 2) иргэн бүр хувийн халдашгүй эрхтэй. Хуульд заасан бусад тохиолдолд хэнийг ч нэгжих, баривчилж, хорьж үл болно.<br>Хэнд боловч эрүү шүүлт | 2) иргэн бүр хувийн халдашгүй эрхтэй. Хуульд заасан бусад тохиолдолд хэнийг ч нэгжих, баривчилж, хорьж үл болно. Хэнд боловч эрүү шүүлт <u>тулгаж</u> | ***Хуулийн төслийн 17-р зүйлийн 13-т тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 17-р зүйлийн 13-т тусгагдсан байна.*** | ***Үндсэн хуулийн 16-р зүйлийн 13-т тусгагдсан байна.*** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| тулгахыг цээрлэнэ. Иргэдийн хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон сууц халдашгүй байна; | болохгүй. Иргэдийн хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон сууц халдашгүй байна; | | | |
| 3) иргэд хувийн өмчтэй байх, түүнийгээ өвлүүлэх, аж ахуй эрхлэн хөтлөх эрхтэй. | 3) иргэд хувийн өмчтэй байх, түүнийгээ өвлүүлэх, аж ахуй эрхлэн хөтлөх эрхтэй. Иргэний хувийн өмчийг хууль бусаар хураан авах, төр, түүний байгууллага хариу төлбөргүйгээр дайчлан авахыг хориглоно; | 3/ хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Иргэний хувийн өмчийг хууль бусаар хураан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг нөхөх олговортойгоор дайчлан авч болох бөгөөд үнийг шударгаар төлөх үүрэгтэй; | 3/ хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг ~~нөхөх олговортойгоор~~ дайчлан авбал үнийг төлөх ~~үүрэгтэй;~~ | 3/ хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө; |
| 4) иргэн бүр хөдөлмөрлөх, амрах, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийнхөө хэр хэмжээнд тохирсон цалин хөлс авах, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах эрхтэй. Хуульд зааснаас бусад тохиолдолд хэнийг ч албадан хөдөлмөрлүүлж болохгүй; | 4) ~~иргэн бүр~~ хөдөлмөрлөх, амрах, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийнхөө хэр хэмжээнд тохирсон цалин хөлс авах, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах эрхтэй. Хуульд зааснаас бусад тохиолдолд хэнийг ч албадан хөдөлмөрлүүлж болохгүй; | 4/ хөдөлмөрлөх, амрах, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ~~хөдөлмөрийнхөө хэр хэмжээнд тохирсон~~ цалин хөлс авах, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, **хувийн аж ахуй эрхлэх** эрхтэй. ~~**Монгол улсын олон улсын гэрээ,** хуульд зааснаас бусад тохиолдолд~~ хэнийг ч албадан хөдөлмөрлүүлж болохгүй; | 4/ ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, **амрах**, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч **хууль бусаар** албадан хөдөлмөрлүүлж болохгүй; | 4/ ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй; |
| 5) иргэд өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа болон тэжээгчээ алдах, ажилгүйдэхэд улсаас хуульд зааснаар эдийн тусламж авах эрхтэй; | 5) ~~иргэд~~ өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа болон тэжээгчээ алдах, ~~ажилгүйдэхэд улсаас~~ хуульд зааснаар эдийн тусламж авах эрхтэй; | 5/ ~~өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа болон тэжээгчээ алдахад~~ хуульд зааснаар эдийн тусламж авах эрхтэй; | 5/ Хуульд заасны **дагуу** төрөөс эдийн тусламж авах эрхтэй. | 5/ өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, **хүүхэд төрүүлэх, асрах** болон хуульд заасан **бусад тохиолдолд** эд, **мөнгөний** тусламж авах эрхтэй; |
| 6) иргэн бүр эмнэлгийн тусламж авах эрхтэй. Төрөөс иргэдэд эмнэлгийн үнэ төлбөргүй тусламж үзүүлэх нөхцөл, журмыг хуулиар тогтооно; | 6) ~~иргэн бүр~~ эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн үнэ төлбөргүй тусламж үзүүлэх нөхцөл, журмыг хуулиар тогтооно; | 6/ **эрүүл мэндээ хамгаалуулах,** эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн үнэ төлбөргүй тусламж үзүүлэх нөхцөл, журмыг хуулиар тогтооно; | 6/ эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно; | 6/ эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно; |
| 7) иргэд сурч боловсрох мэдлэг мэргэшлээ дээшлүүлэх эрхтэй ~~бөгөөд бүх шатны сургуульд сурч боловсрох явдал иргэн бүрт нээлттэй.~~ Төрийн сургуульд бүх нийтийн суурь боловсролыг үнэ төлбөргүй олгоно. | 7) ~~иргэд~~ сурч боловсрох ~~мэдлэг мэргэшлээ дээшлүү~~лэх эрхтэй. Төрийн сургуульд бүх нийтийн суурь ~~(ерөнхий)~~ боловсролыг үнэ төлбөргүй олгоно. Иргэд их сургуулиас бусад хувийн сургууль байгуулж болно. Хувийн сургуулийн | 7/ сурч боловсрох эрхтэй. Төрийн сургуульд бүх нийтийн суурь /ерөнхий/ боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн сургалт бүхий хувийн сургууль байгуулан ажиллуулж болно; | 7/ сурч боловсрох эрхтэй. Төрийн сургуульд бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно; | 7/ сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно; |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Иргэд их сургуулиас бусад хувийн сургууль байгуулж болно. Хувийн сургуулийн сургалт нь төрөөс тавих шаардлагад бүрэн нийцсэн байвал зохино.<br>Бүх сургууль төрийн хяналтад байна; | сургалт нь төрөөс тавих шаардлагад бүрэн нийцсэн байвал зохино.<br>~~Бүх сургууль төрийн хяналтад байна;~~ | | | |
| 8) иргэд соёл, шинжлэх ухааны амьдралд чөлөөтэй оролцох, соёл урлагийн бүтээл, шинжилгээ судалгааны үр дүнг ашиглах, өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийн үр шимийг хүртэх, зохиогчийн эрх, ашиг сонирхолоо хамгаалуулах эрхтэй; | 8) иргэд соёл, шинжлэх ухааны амьдралд чөлөөтэй оролцох, соёл урлагийн бүтээл, шинжилгээ судалгааны үр дүнг ашиглах, өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийн үр шимийг хүртэх, зохиогчийн эрх, ашиг сонирхолоо хамгаалуулах эрхтэй; | 8/ соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, түүний үр шимийг хүртэх эрхтэй. Зохиогч~~ийн~~ ~~болон~~ шинэ бүтээл~~ийн эрх,~~ нээлтийн ~~онц~~ эрхийг хуулиар хамгаална; | 8/ соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална; | 8/ соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална; |
| 9) эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй. ~~Монгол улсад~~ гэрлэлт, гэр бүл, эх нялхас төрийн онцгой анхааралд байна; | 9) эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй. Гэрлэлт, гэр бүл, эх нялхас төрийн онцгой анхааралд байна; | ***Хуулийн төслийн 17-р зүйлийн 11-т тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 17-р зүйлийн 11-т тусгагдсан байна.*** | ***Үндсэн хуулийн 16-р зүйлийн 11-т тусгагдсан байна.*** |
| ***Хуулийн төслийн 16-р зүйлийн 12-т тусгагдсан байна:***<br><br>иргэд шууд буюу төлөөлсөн байгууллагаараа уламжлан нийгэм, төрийг удирдах хэрэгт чөлөөтэй оролцох эрхтэй.<br>Хуулиар тогтоосон насанд хүрсэн иргэн төрийн байгууллагад сонгох, сонгогдох, | ***Хуулийн төслийн 19-р зүйлийн 12-т тусгагдсан байна*:**<br><br>~~иргэд~~ шууд буюу төлөөлсөн байгууллагаараа уламжлан ~~нийгэм,~~ төрийг удирдах хэрэгт чөлөөтэй оролцох эрхтэй. Хуулиар тогтоосон насанд хүрсэн иргэн төрийн байгууллагад сонгох, сонгогдох **эрхтэй**; | 9/ шууд буюу төлөөлсөн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт ~~чөлөөтэй~~ оролцох эрхтэй. ~~Хуулиар тогтоосон насанд хүрсэн иргэн~~ төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. **Сонгох эрхийг 18 наснаас эдлэх ~~бөгөөд~~ сонгогдож болох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавигдах шаардлагыг харгалзан хуулиар тогтооно;** | 9/ шууд буюу төлөөлсөн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй.<br><br>Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг 18 наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно; | 9/ шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй.<br><br>Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно; |
| | ***Хуулийн төслийн 19-р зүйлийн 11-т тусгагдсан байна:***<br><br>иргэд нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам олон нийтийн бүх байгууллага нийгэм, төрийн | 10/ нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдал, ~~хүн амын эрүүл энх, зан суртахууныг эрхэмлэн~~ сахиж хуулийг дээдлэн биелүүлнэ; | 10/ нийгмийн болоод өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. | 10/ нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. **Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | аюулгүй байдал, хүн амын эрүүл энх, зан суртахууныг эрхэмлэн сахиж, ~~Улсын Их цаазын хүрээнд улс төрийн аргаар үйл ажиллагаа явуулж~~ хуулийг дээдлэн биелүүлнэ; | | | **нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно;** |
| ***Хуулийн төслийн 16-р зүйлийн 9-д тусгагдсан байна:*** эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй. ~~Монгол улсад~~ гэрлэлт, гэр бүл, эх нялхас төрийн онцгой анхааралд байна; | ***Хуулийн төслийн 19-р зүйлийн 9-д тусгагдсан байна:*** эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй. Гэрлэлт, гэр бүл, эх нялхас төрийн онцгой анхааралд байна; | 11/ эрэгтэй, эмэгтэйчүүд **улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын салбар, гэр бүлийн харилцаанд** тэгш **эрх**, эрх **чөлөө**тэй. **Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ.** Гэр бүл, эх нялхас, хүүхдийн эрх ашгийг төр анхааран хамгаална; | 11/ эрэгтэй, эмэгтэй улс төр, эдийн засаг, нийгэм-соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр анхааран хамгаална; | 11/ улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална; |
| 10) иргэд төрийн нууцад хамаарахаас бусад асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Төрийн нууцыг хуулиар тогтоож хамгаална; | 10) иргэд төрийн нууцад хамаарахаас бусад асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Төрийн нууцыг хуулиар тогтоож хамгаална; | ***Хуулийн төслийн 17-р зүйлийн 17-д тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 17-р зүйлийн 17-д тусгагдсан байна.*** | ***Үндсэн хуулийн 16-р зүйлийн 17-т тусгагдсан байна.*** |
| 11) иргэд нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын~~хөө~~ үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам олон нийтийн бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдал, хүн амын эрүүл энх, зан суртахууныг эрхэмлэн сахиж, Улсын Их цаазын хүрээнд улс төрийн аргаар үйл ажиллагаа явуулж хуулийг дээдлэн биелүүлнэ; | 11) иргэд нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам олон нийтийн бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдал, хүн амын эрүүл энх, зан суртахууныг эрхэмлэн сахиж, Улсын Их цаазын хүрээнд улс төрийн аргаар үйл ажиллагаа явуулж хуулийг дээдлэн биелүүлнэ; | ***Хуулийн төслийн 17-р зүйлийн 10-т тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 17-р зүйлийн 10-т тусгагдсан байна.*** | ***Үндсэн хуулийн 16-р зүйлийн 10-т тусгагдсан байна.*** |
| 12) иргэд шууд буюу төлөөлсөн байгууллагаараа уламжлан нийгэм, төрийг удирдах хэрэгт чөлөөтэй оролцох эрхтэй. Хуулиар тогтоосон насанд хүрсэн иргэн төрийн байгууллагад сонгох, сонгогдох, | 12) иргэд шууд буюу төлөөлсөн байгууллагаараа уламжлан нийгэм, төрийг удирдах хэрэгт чөлөөтэй оролцох эрхтэй. Хуулиар тогтоосон насанд хүрсэн иргэн төрийн байгууллагад сонгох, сонгогдох **эрхтэй;** | ***Хуулийн төслийн 17-р зүйлийн 9-т тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 17-р зүйлийн 9-т тусгагдсан байна.*** | ***Үндсэн хуулийн 16-р зүйлийн 9-т тусгагдсан байна.*** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| өргөдөл, гомдлоо гаргаж хуулийн дагуу шийдвэрлүүлэх эрхтэй; | 13) **иргэд төрийн байгууллага, албан тушаалтанд** өргөдөл, гомдлоо гаргаж хуулийн дагуу шийдвэрлүүлэх эрхтэй; | 12/ төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. **Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй;** | 12/ төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй; | 12/ төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй; |
| ***Хуулийн төслийн 16-р зүйлийн 2-т тусгагдсан байна:*** <br><br> иргэн бүр хувийн халдашгүй эрхтэй. Хуульд заасан бусад тохиолдолд хэнийг ч нэгжих, баривчилж, хорьж үл болно. <br> Хэнд боловч эрүү шүүлт тулгахыг цээрлэнэ. <br> Иргэдийн хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон сууц халдашгүй байна; | ***Хуулийн төслийн 19-р зүйлийн 2-т тусгагдсан байна:*** <br><br> ~~иргэн бүр~~ хувийн халдашгүй эрхтэй. Хуульд заасан бусад тохиолдолд хэнийг ч нэгжих, баривчилж, хорьж үл болно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж болохгүй. Иргэдийн хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон сууц халдашгүй байна; | 13/ хувийн халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Дур зоргоор, хуульд заасан үндэслэл журмаас гадуур хэнийг ч нэгжиж, баривчилж хорьж, эрх чөлөөг нь хязгаарлаж үл болно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Хэргийн учир баривчлагдсан хүнд болон түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь баривчилсан шалтгаан, үндэслэлийг хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэдийн хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон сууцны халдашгүй байдлыг хуулиар хамгаална; | 13/ халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур зоргоор хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, **мөрдөн мөшгих**, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Хэргийн учир баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь баривчилсан шалтгаан, үндэслэлийг хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална: | 13/ халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална; |
| 13) иргэн бүр хууль ба шүүхийн өмнө эрх тэгш байна**.** <br><br> Гэм буруутай болох нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. <br> Хэргийн учир баривчлагдсан хүнд болон түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид баривчилсан шалтгаан, хууль зүйн үндэслэлийг хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ; | 14) иргэн бүр хууль ба шүүхийн өмнө эрх тэгш байна**.** <br><br> Гэм буруутай болох нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Хэргийн учир баривчлагдсан хүнд болон түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид баривчилсан шалтгаан, хууль зүйн үндэслэлийг хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ; | ***Хуулийн төслийн 14-р зүйлийн 1 дэх хэсэгт тусгагдсан байна.*** <br> 14/ Монгол улсын хууль болон олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөөгөө зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулах, сэргээн тогтоолгох, хэрэгжүүлэхээр шүүхэд гомдол гаргах, өөрийн болон гэр бүлийнхээ гишүүд, төрөл садныхаа эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүгдэх, өөрийн хэргийг шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. | ***Хуулийн төслийн 14-р зүйлийн 1 дэх хэсэгт тусгагдсан байна.*** <br> 14/ Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, өөрийн болон гэр бүлийн гишүүд, төрөл садныхаа эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүгдэх, өөрийн хэргийг шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Хэнийг ч өөрийн эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг | ***Үндсэн хуулийн 14-р зүйлийн 1 дэх хэсэгт тусгагдсан байна.*** <br> 14/ Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Хэнийг ч өөрийн эсрэг мэдүүлэхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай болох нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно; | гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай болох нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. | Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно; |
| 14) иргэд шашин шүтэх эс шүтэх эрх чөлөөтэй; | 15) ~~иргэд~~ шашин шүтэх эс шүтэх эрх чөлөөтэй; | 15/ сүсэг бишрэлтэй байх, шашин чөлөөтэй шүтэх эрхтэй; | 15/ шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй; | 15/ шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй; |
| 16) иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, цуглаан хийх, тайвнаар жагсаал үйлдэх эрх чөлөөтэй. Цуглаан хийх, жагсаал үйлдэх журмыг хуулиар тогтоон ~~зохицуулна;~~ | 16) иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайвнаар жагсаал үйлдэх, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал үйлдэх, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно; | 16/ итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайвнаар жагсаал үйлдэх, цуглаан хийх эрх чөлөөтэй. Хэвлэн нийтлэх, жагсаал үйлдэх, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно; | 16/ итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. ~~Хэвлэн нийтлэх~~ жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно; | 16/ итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно; |
| ***Хуулийн төслийн 16-р зүйлийн 10-т тусгагдсан байна:***<br><br>иргэд төрийн нууцад хамаарахаас бусад асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.<br>Төрийн нууцыг хуулиар тогтоож хамгаална; | ***Хуулийн төслийн 19-р зүйлийн 10-т тусгагдсан байна:***<br><br>иргэд төрийн нууцад хамаарахаас бусад асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.<br>Төрийн нууцыг хуулиар тогтоож хамгаална. | 17/ төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журлыг хангах зорилгоор төр, түүний байгууллагаас задруулж үл болох төрийн болон хувь хүн, байгууллага нууцыг хууль тогтоомжоор тодорхойлно; | 17/ төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хууль тогтоомжоор тодорхойлно. | 17/ төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална; |
| 16) иргэд тус улсын нутаг дэвсгэр дээр оршин суух газраа чөлөөтэй сонгох, дотоод гадаадад зорчих, эх орондоо буцаж ирэх эрхтэй; | 17) ~~иргэд~~ тус улсын нутаг дэвсгэр дээр оршин суух газраа чөлөөтэй сонгох, дотоод гадаадад зорчих, **цагаачлах**, эх орондоо буцаж ирэх эрхтэй; | 18/ тус улсын нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох, гадаадад зорчих, **хувийн журмаар оршин суух**, эх орондоо буцаж ирэх эрхтэй. **Эдгээр эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж** | 18/ улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, хувийн журмаар оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, ~~хувийн журмаар~~ оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв | 18/ улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | **болно**. | журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно. | хуулиар хязгаарлаж болно. |
| **17 дугаар зүйл** | **ХОРЬДУГААР ЗҮЙЛ** | **Арван наймдугаар зүйл** | **Арван наймдугаар зүйл** | **Арван долдугаар зүйл** |
| Монгол улсын иргэд шударга, хүнлэг ёсыг дээдэлж дараах үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ: | Монгол улсын иргэд шударга, хүнлэг ёсыг дээдэлж дараах үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ: | Монгол Улсын иргэд шударга, хүнлэг ёсыг дээдэлж дараах үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ: | 1. Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг дээдэлж дараах үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ: | 1. Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараах үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ: |
| 1) Улсын Их цааз, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх; | 1) Улсын Их цааз, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх; | 1/ Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх; | 1/ Их Цааз, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх; | 1/ Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх; |
| 2) бусад хүний нэр төр, алдар хүнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг эрхэмлэн хүндэтгэх; | 2) бусад хүний нэр төр, алдар хүнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг эрхэмлэн хүндэтгэх; | 2/ бусад хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг ~~эрхэмлэн~~ хүндэтгэх; | 2/ Бусад хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх; | 2/ хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх; |
| 3) улс үндэстнийхээ эв нэгдлийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах; | 3) улс үндэстнийхээ эв нэгдлийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах; | | | |
| 4) эх орныхоо хөгжил дэвшилтийн төлөө шударгаар хөдөлмөрлөх; | 4) эх орныхоо хөгжил дэвшилтийн төлөө шударгаар хөдөлмөрлөх; | ***Хуулийн төслийн 18-р зүйлийн 2 дахь хэсэгт тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 18-р зүйлийн 2 дахь хэсэгт тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 17-р зүйлийн 2 дахь хэсэгт тусгагдсан байна.*** |
| 5) хуулиар тогтоосон албан татвар төлөх замаар улсын мөнгөн хөрөнгийн төвлөрсөн санд хувь нэмэр оруулах; | 5) хуулиар тогтоосон албан татвар төлөх ~~замаар улсын мөнгөн хөрөнгийн төвлөрсөн санд хувь нэмэр оруулах~~; | 3/ хуулиар тогтоосон албан татвар төлөх; | 3/ хуулиар оногдуулсан албан татвар төлөх; | 3/ хуулиар ногдуулсан албан татвар төлөх; |
| 6) нийгмийн баялгийг хайрлан хамгаалж арвижуулах; | 6) нийгмийн баялгийг хайрлан хамгаалж арвижуулах; | | | |
| 7) байгаль орчноо хамгаалах, түүний баялгийг хайрлан ариг гамтай эдэлж, хойч үедээ өвлүүлэхийг ариун журам болгон сахих; | 7) байгаль орчноо хамгаалах, түүний баялгийг хайрлан ариг гамтай эдэлж, хойч үедээ өвлүүлэхийг ариун журам болгон сахих; | 4/ байгаль орчноо хамгаалах, түүний баялгийг хайрлан ариг гамтай эдэлж, хойч үедээ өвлүүлэхийг ариун журам болгон сахих; | ***Хуулийн төслийн 18-р зүйлийн 2 дахь хэсэгт тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 17-р зүйлийн 2 дахь хэсэгт тусгагдсан байна.*** |
| 8) эх орноо хамгаалахад бэлэн байж, хууль ёсоор тохоогдсон үед цэргийн албан хаах; | 8) ~~эх орноо хамгаалахад бэлэн байж~~, хууль ёсоор ~~тохоогдсон үед~~ цэргийн албан хаах; | 5/хууль ёсоор цэргийн албан хаах. | 4/ хуулийн дагуу цэргийн алба хаах. | 4/ **эх орноо хамгаалах,** хуулийн дагуу цэргийн алба хаах. |
| 9) төрийн нууцыг чанд хамгаалах; | 9) төрийн нууцыг чанд хамгаалах; | | | |
| 10) эцэг, эх нь үр хүүхдээ, үр хүүхэд нь эцэг эхээ асран хамгаалах; | 10) эцэг, эх нь үр хүүхдээ, үр хүүхэд нь эцэг эхээ асран хамгаалах; | | | |
| 11) бусад үндэстэн, ард түмний бүрэн эрх, нэр төр, зан заншлыг хүндэтгэх. | 11) бусад үндэстэн, ард түмний бүрэн эрх, нэр төр, зан заншлыг хүндэтгэх. | | | |
| ***Хуулийн төслийн 17-р зүйлийн 4-т тусгагдсан байна:*** | ***Хуулийн төслийн 20-р зүйлийн 4-т тусгагдсан байна:*** | 2. Эх орноо хамгаалах, ~~шударгаар хөдөлмөрлөх~~ нь иргэн бүрийн ~~ариун~~ журамт | 2. Эх орон, **байгаль орчныг** хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн. | 2. **Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх**, байгаль |

| | | | | |
|---|---|---|---|---|
| эх орныхоо хөгжил дэвшилтийн төлөө шударгаар хөдөлмөрлөх; | эх орныхоо ~~хөгжил дэвшилтийн төлөө~~ шударгаар хөдөлмөрлөх; | үүрэг мөн. | | орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн. |
| | | | | **Арван наймдугаар зүйл** |
| ***Хуулийн төслийн 15-р зүйлд тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 18-р зүйлийн 1-т тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 16-р зүйлийн 1-т тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 16-р зүйлийн 1-т тусгагдсан байна.*** | 1. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, уул иргэнийг харьялсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно. |
| | | ***Хуулийн төслийн 16-р зүйлийн 2-т тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 16-р зүйлийн 2-т тусгагдсан байна.*** | 2. Монгол Улс олон улсын гэрээгээр гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо уул иргэнийг харьялсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримтална. |
| ***Хуулийн төслийн 15-р зүйлд тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 18-р зүйлийн 2-т тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 16-р зүйлийн 3-т тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 16-р зүйлийн 3-т тусгагдсан байна.*** | 3.Монгол Улс нутаг дэвсгэртээ байгаа харьяалалгүй хүний эрх, үүргийг өөрийн хуулиар тогтооно. |
| | | ***Хуулийн төслийн 16-р зүйлийн 4-т тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 16-р зүйлийн 4-т тусгагдсан байна.*** | 4. Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол Улсад орогнох эрх олгож болно. |
| | | | | 5. Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлал тогтоож болно. |
| **18 дугаар зүйл** | **ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ** | **Арван есдүгээр зүйл** | **Арван есдүгээр зүйл** | **Арван есдүгээр зүйл** |
| Төр нь иргэдийн үндсэн эрх, эрх чөлөө, нэр төрийг эрхэмлэн | Төр нь иргэдийн үндсэн эрх, эрх чөлөө, нэр төрийг эрхэмлэн | 1. Төр нь хүний эрх, эрх чөлөөг хангах эдийн засаг, нийгэм, | 1. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, | 1. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| хамгаалж, иргэн бүр чөлөөтэй хөгжих эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэдийн өмнө хүлээнэ. | хамгаалж, иргэн бүр чөлөөтэй хөгжих эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэдийн өмнө хүлээнэ. | хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, тэдний эрх, эрх чөлөөг зөрчих явдалтай тэмцэх, зөрчигдсөн эрхийг сэргээн хангах үүргийг иргэдийн өмнө хариуцна. | хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэдийн өмнө хариуцна. | хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна. |
| | | 2. Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг дайны болон онц байдал зарласан, Үндсэн хуулийн дэг журмын эсрэг тэмцэлд ашигласан нөхцөлд гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарлах тухай хууль нь хувь хүн, ганц тохиолдлыг хамарсан бус, нийтлэг чанартай байвал зохино. | 2. Дайны болон онц байдал зарласан, Их цаазын журмыг урвуулан ашигласан үед Их цааз, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хувь хүн, нэжгээд тохиолдлыг үл хамаарна. | 2. Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө. |
| | | 3. Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэх явдал үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, бусад хүний эрх, эрх чөлөөг хохируулахад хүргэж болохгүй. | 3. Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй. | 3. Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй. |
| **ГУРАВДУГААР БҮЛЭГ** | **Гуравдугаар бүлэг** | **ГУРАВДУГААР БҮЛЭГ** | **ГУРАВДУГААР БҮЛЭГ** | **ГУРАВДУГААР БҮЛЭГ** |
| **МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛТ. ТӨРИЙН ЭРХ МЭДЛИЙГ ХУВААРИЛАХ НЬ** | **МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛЛЫГ ~~БАТАТГАН БЭХЖҮҮЛЭХ НЬ~~** | **МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛ** | **МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛ** | **МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛ** |
| **19 дүгээр зүйл** | | | | |
| Монгол Улсад төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл болгон хуваарилж, хоорондын уялдаа, зохицлыг хуулиар баталгаажуулан хангана. | | | | |
| **I. Хууль тогтоох эрх мэдэл. Монгол Улсын Их хурал** | **НЭГ. Монгол Улсын Их хурал** | **НЭГ. Монгол Улсын Их Хурал** | **НЭГ. Монгол Улсын Их Хурал** | **НЭГ. Монгол Улсын Их Хурал** |
| **20 дугаар зүйл** | **ХОРИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ** | **Хорьдугаар зүйл** | **Хорьдугаар зүйл** | **Хорьдугаар зүйл** |
| Монгол улсын төрийн дээд эрх мэдлийг Улсын Их Хуралд хадгална. | 1. Монгол улсын төрийн дээд эрх мэдлийг Улсын Их Хуралд хадгална. | ***Хуулийн 3-р төслийн 20-р зүйлийн 2 дахь хэсэгт тусгагдсан байна:***<br><br>Монгол улсад хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хурал хэрэгжүүлнэ. | 1.Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална. | Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Монгол Улсын Их Хурал бол монголын ард түмний бүрэн эрхийг илэрхийлсэн, хууль тогтоох, хянан шалгах төлөөлөгчдийн дээд байгууллага мөн. | 2. Монгол Улсын Их Хурал бол ~~монголын ард түмний бүрэн эрхийг илэрхийлсэн, хууль тогтоох, хянан шалгах~~ төлөөлөгчдийн дээд байгууллага мөн. | 1. Монгол Улсын Их Хурал бол **төрийн засаг /эрх/-ийг барих** төлөөлөгчдийн дээд байгууллага мөн. | | |
| ***Хуулийн төслийн 20-р зүйлд тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 20-р зүйлийн 2 дахь хэсэгт тусгагдсан байна.*** | 2. Монгол улсад хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хурал хэрэгжүүлнэ. | ***Хуулийн төслийн 20-р зүйлд тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 20-р зүйлд тусгагдсан байна.*** |
| | | | Монгол улс бол Парламентын бүгд найрамдах улс мөн. | |
| **21 дүгээр зүйл** | **ХОРИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ** | **Хорин нэгдүгээр зүйл** | **Хорин нэгдүгээр зүйл** | **Хорин нэгдүгээр зүйл** |
| Монгол Улсын Их Хурал нь нэг танхимтай байнгын ажиллагаатай байх бөгөөд 75 гишүүнээс бүрдэнэ. | 1. ~~Монгол~~ Улсын Их Хурал нь ~~**нэг танхимтай байнгын ажиллагаатай** байх бөгөөд~~ 75 гишүүнээс бүрдэнэ. | Улсын Их Хурал **75** гишүүнээс бүрдэнэ. | 1. Улсын Их Хурал **76** гишүүнээс бүрдэнэ. | 1. Улсын Их Хурал **нэг танхимтай**, далан зургаан гишүүнтэй байна. |
| | | *А хувилбар:* 2. Улсын Их Хурлын гишүүнийг Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэд бүх нийтийн, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж 4 жилийн хугацаагаар сонгоно. | | 2. Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. |
| Монгол Улсын Их Хурлын гишүүнийг Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэд саналаа нууцаар гаргаж 6 жилийн хугацаагаар сонгоно. | 2. Монгол Улсын Их Хурлын гишүүнийг Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэд ~~нийтээрээ тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр~~ саналаа нууцаар гаргаж 6 жилийн хугацаагаар сонгоно. | *Б хувилбар:* 2. ~~Монгол~~ Улсын Их Хурлын гишүүнийг ~~Монгол улсын~~ сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж 6 жилийн хугацаагаар сонгоно. | 2. Улсын Их Хурлын гишүүнийг сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, шууд сонгох эрхтэй оролцож саналаа нууцаар гаргаж, 6 жилийн хугацаагаар сонгоно. | |
| Монгол Улсын Их Хурлын ~~Тэргүүн~~ даргаас бусад гишүүний хоёрны нэгийг гурван жил тутам шинэчлэн сонгож сэлбэнэ. | 3. Монгол Улсын Их Хурлын даргаас бусад гишүүний хоёрны нэгийг гурван жил тутам шинэчлэн сонгож сэлбэнэ. | ~~Монгол~~ Улсын Их Хурлын ~~даргаас бусад~~ гишүүний хоёрны нэгийг гурван жил тутам шинэчлэн сонгож сэлбэнэ. | Улсын Их Хурлын нийт гишүүний хоёрны нэгийг 3 жил тутам шинэчилэн сонгож сэлбэнэ. | |
| Монгол Улсын Их Хурлын гишүүнээр Монгол улсын 25 нас хүрсэн Монгол улсын иргэнийг сонгоно. | 4. Монгол Улсын Их Хурлын гишүүнээр Монгол улсын 30 нас хүрсэн иргэнийг сонгож **болно.** | 3. Улсын Их Хурлын гишүүнээр Монгол улсын 30 нас хүрсэн иргэнийг сонгож болно. | 3. Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын 25 нас хүрсэн иргэнийг сонгоно. | 3. Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын 25 нас хүрсэн, **сонгуулийн эрх бүхий** иргэнийг сонгоно. |
| Монгол Улсын Их Хурлын гишүүний сонгуулийн зарчим, журмыг хуулиар тогтооно. | 5. Монгол Улсын Их Хурлын гишүүний сонгуулийн зарчим, журмыг хуулиар тогтооно. | 4. Улсын Их Хурлын ~~гишүүний~~ сонгуулийн ~~зохион байгуулалт~~, журмыг хуулиар тогтооно. | 4. Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. | 4. Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. |
| **22 дугаар зүйл** | **ХОРИН ДӨРӨВ ДҮГЭЭР ЗҮЙЛ** | **Хорин хоёрдугаар зүйл** | **Хорин хоёрдугаар зүйл** | **Хорин хоёрдугаар зүйл** |
| Онцгой нөхцөл байдлын улмаас Монгол Улсын Их Хурлын гишүүний ээлжит сонгууль | 1. Онцгой нөхцөл байдлын улмаас ~~Монгол Улсын~~ Их Хурлын гишүүний ээлжит | 1. Улсын бүх нутаг дэвсгэр буюу түүний ихэнхийг хамарсан гэнэтийн аюул тохиолдсон, | 1. Улсын нийт нутаг дэвсгэр буюу зарим хэсгийг хамарсан гэнэтийн аюул тохиолдсон, | 1. Улсын нийт нутаг дэвсгэр буюу зарим хэсгийг нь хамарсан гэнэтийн аюул тохиолдсон, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| явуулах боломжгүй бол мөнхүү нөхцөл байдал арилж, шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ эдэлнэ. | сонгууль явуулах боломжгүй бол мөнхүү нөхцөл байдал арилж, Улсын Их Хурлын шинээр сонгогдсон гишүүд тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ хадгална. | дайны болон нийтийн эмх замбараагүй байдал бий болсон зэрэг онцгой нөхцөл байдлын улмаас Улсын Их Хурлын гишүүний ээлжит сонгууль явуулах боломжгүй бол мөнхүү нөхцөл байдал арилж, Улсын Их Хурлын шинээр сонгогдсон гишүүд тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлнэ. | дайны болон нийтийн эмх замбараагүй байдал үүссэн зэрэг онцгой нөхцөлийн улмаас Улсын Их Хурлын гишүүний ээлжит сонгууль явуулах боломжгүй бол мөнхүү нөхцөл арилж, Улсын Их Хурлын шинээр сонгогдсон гишүүд тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлнэ. | дайны ба нийтийн эмх замбараагүй байдал үүссэн зэрэг онцгой нөхцөлийн улмаас ээлжит сонгууль явуулах боломжгүй бол мөнхүү нөхцөл арилж, шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлнэ. |
| Монгол Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзвэл өөрөө тарах тухай шийдвэр гаргаж болох боловч ээлжит бус сонгуулиар шинэ сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд тангараг өргөтөл бүрэн эрхээ хадгална. | 2. ~~Монгол~~ Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр **буюу Ерөнхийлөгчийн санал болгосноор** өөрөө тарах тухай шийдвэр гаргаж болох боловч ээлжит бус сонгуулиар шинэ сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд тангараг өргөтөл бүрэн эрхээ хадгална. | 2. Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу Ерөнхийлөгчийн санал болгосноор өөрөө тарах тухай шийдвэр гаргаж болох боловч ээлжит бус сонгуулиар шинэ сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд тангараг өргөтөл бүрэн эрхээ хэрэгжүүлнэ. | 2. Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу Ерөнхийлөгчийн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болох **боловч** ~~ээлжит бус~~ сонгуулиар шинэ сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд тангараг өргөтөл бүрэн эрхээ эдэлнэ. | 2. Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу **эсхүл мөнхүү шалтгаанаар** Ерөнхийлөгч **Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн** санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно. Ийнхүү тарах шийдвэр гаргасан бол шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ эдэлнэ. |
| **23 дугаар зүйл** | **ХОРИН ТАВ ДУГААР ЗҮЙЛ** | **Хорин гуравдугаар зүйл** | **Хорин гуравдугаар зүйл** | **Хорин гуравдугаар зүйл** |
| Монгол Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд | ~~Монгол~~ Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд | 1. Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд **нийт иргэн, улсын ашиг сонирхлыг баримтлан ажиллана.** | 1. Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална. | 1. Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална. |
| түүний бүрэн эрх нь төрийн сүлднээ тангараг өргөснөөр эхэлж, шинэ сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн тангараг өргөснөөр дуусгавар болно. | ~~түүний~~ бүрэн эрх нь төрийн сүлднээ тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын шинэ сонгогдсон гишүүн тангараг өргөснөөр дуусгавар болно. | 2. **Улсын Их Хурлын гишүүний** бүрэн эрх нь төрийн сүлднээ тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын шинэ сонгогдсон гишүүн тангараг өргөснөөр дуусгавар болно. | 2. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь Төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын **дараагийн сонгуулиар** шинэ сонгогдсон гишүүн тангараг өргөснөөр дуусгавар болно. | 2. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь Төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно. |
| **24 дүгээр зүйл** | **ХОРИН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ** | **Хорин дөрөвдүгээр зүйл** | **Хорин дөрөвдүгээр зүйл** | **Хорин дөрөвдүгээр зүйл** |
| Монгол Улсын Их Хурлын ~~Тэргүүн~~ дарга, Дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос саналаа нууцаар гаргаж чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар сонгоно. | 1. ~~Монгол~~ Улсын Их Хурлын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос ~~нэр дэвшүүлэн~~ саналаа нууцаар гаргаж чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар сонгоно. | 1. Улсын Их Хурлын дарга, дэд дарга, ~~**нарийн бичгийн даргыг**~~ Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа нууцаар гаргаж чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар сонгоно. | 1. Улсын Их Хурлын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа нууцаар гаргаж чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар сонгоно. | 1. Улсын Их Хурлын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа нууцаар гаргаж сонгоно. |
| Монгол Улсын Их Хурлын | 2. ~~Монгол~~ Улсын Их Хурлын | 2. Улсын Их Хурлын дарга, **дэд** | 2. Улсын Их Хурлын дарга, дэд | 2. Улсын Их Хурлын дарга, дэд |

СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| ~~Тэргүүн~~ даргын бүрэн эрхийн хугацаа 6 жил байна. | даргын бүрэн эрхийн хугацаа 6 жил байна. | **дарга,** ~~нарийн бичгийн даргын~~ бүрэн эрхийн хугацаа 4 жил байх **бөгөөд** ~~тэдний~~ **хуульд заасан үндэслэлээр хугацааны нь өмнө чөлөөлж, огцруулж болно.** | даргын бүрэн эрхийн хугацаа 3 жил байх хийгээд хуульд заасан үндэслэлээр хугацаанаас нь өмнө чөлөөлж, огцруулж болно. | даргын бүрэн эрхийн хугацаа 4 жил байх бөгөөд хуульд заасан үндэслэлээр хугацаанаас нь өмнө чөлөөлж, огцруулж болно. |
| **25 дугаар зүйл** | **ХОРИН ДОЛДУГААР ЗҮЙЛ** | **Хорин тавдугаар зүйл** | **Хорин тавдугаар зүйл** | **Хорин тавдугаар зүйл** |
| Монгол улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын ~~үндсийг тодорхойлж~~, дор дурдсан асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэнд хадгалж шийдвэрлэнэ: | 1. ~~Монгол~~ улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын **ямар ч асуудлыг санаачилгаараа хэлэлцэж болох бөгөөд** дор дурдсан асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: | 1. Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын ямар ч асуудлыг санаачилгаараа хэлэлцэж болох бөгөөд дор дурдсан асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: | 1. Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: | 1. Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: |
| 1) Улсын Их цааз болон бусад хууль батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах; | 1) ~~Улсын Их цааз болон бусад~~ хууль батлах, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах; | 1/ хууль батлах, ~~тэдгээрт~~ нэмэлт өөрчлөлт оруулах; | 1/ хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах; | 1/ хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах; |
| | | **2/ төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох;** | 2/ төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох; | 2/ төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох; |
| 2) Ерөнхийлөгчийн сонгуулийг товлон зарлах; | 2) Ерөнхийлөгчийн **болон Улсын Их Хурлын гишүүний** сонгуулийг товлон зарлах; | 3/ Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын гишүүний сонгуулийг товлон зарлах; | 3/ Ерөнхийлөгчийн ба Улсын Их Хурлын гишүүний сонгуулийг товлон зарлах; | 3/ Ерөнхийлөгчийн ба Улсын Их Хурал, **түүний** гишүүний сонгуулийг товлон зарлах; |
| 3) Улсын Их Хурлын байнгын хороо, Засгийн газар, түүнчлэн хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүтэц, бүрэлдэхүүний тоог тогтоох, өөрчлөх; | 3) Улсын Их Хурлын байнгын хороо, Засгийн газар, түүнчлэн хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүтэц, бүрэлдэхүүний тоог тогтоох, өөрчлөх; | 4/ Улсын Их Хурлын байнгын хороо, Засгийн газар, түүнчлэн хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүтэц, бүрэлдэхүүний тоог тогтоох, өөрчлөх; | 4/ Улсын Их Хурлын Байнгын хороо, Засгийн газар, ~~түүнчлэн~~ хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоох, өөрчлөх; | 4/ Улсын Их Хурлын Байнгын хороо, Засгийн газар, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоох, өөрчлөх; |
| 4) Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын байнгын хорооны бүрэлдэхүүнийг сонгох, чөлөөлөх, огцруулах,<br>Засгийн газрын гишүүдийг болон хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх огцруулах; | 4) Ерөнхийлөгч, ~~Улсын Их Хурлын байнгын хорооны бүрэлдэхүүнийг~~ сонгох, чөлөөлөх, огцруулах,<br>~~Ерөнхий сайд~~, Засгийн газрын гишүүдийг болон бусад хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх огцруулах; | 5/ Ерөнхийлөгчийг сонгох, чөлөөлөх, огцруулах,<br>Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг болон хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах; | 5/ Ерөнхийлөгчийг сонгох, чөлөөлөх, огцруулах,<br>Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, мөн хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах; | 5/ Ерөнхийлөгчийг сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргах, чөлөөлөх, огцруулах;<br>6/ Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах; |
| 5) төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг | 5) төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг | 6/ төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг | 6/ төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг | 7/ төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын ~~нэгдсэн~~ төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах; | тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах; | тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах; | тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, гүйцэтгэлийн тайланг батлах; | тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах; |
| 6) Улсын Их цааз, хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах; | 6) ~~Улсын Их цааз~~, хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах; | 7/ хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах; | 7/ хуулийн болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах; | 8/ хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах; |
| | | | 8/ улсын хил тогтоох; | 9/ улсын хил тогтоох; |
| | | | 9/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт, бүрэн эрхийг тогтоох; | 10/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрхийг тогтоох; |
| 7) Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол улсын засаг захиргаа-нутаг дэвсгэрийн хуваарийг батлах, өөрчлөх; | 7) Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол улсын засаг захиргаа-нутаг дэвсгэрийн хуваарийг батлах, өөрчлөх; | 8/ Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын засаг захиргаа-нутаг дэвсгэрийн хуваарийг батлах, өөрчлөх; | 10/ Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын засаг захиргаа-нутаг дэвсгэрийн хуваарийг батлах, өөрчлөх; | 11/ Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг батлах, өөрчлөх; |
| Нутгийн эрх барих байгууллагын бүтцийг тогтоож, үйл ажиллагааг чиглүүлэх; | 8) нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох; | 9/ нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох; | 11/ нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох; | 12/ нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох; |
| | **9) улсын цол, одон, медаль, цэргийн дээд цол бий болгох**; | 10/ улсын цол, одон, медаль, цэргийн дээд цол бий болгох, **төрийн албаны зарим тусгай салбарын албан тушаалын зэрэг дэвийг тогтоох;** | 12/ улсын цол, одон, медаль, цэргийн дээд цол бий болгох, төрийн албаны зарим тусгай салбарын албан тушаалын зэрэг дэвийг тогтоох; | 13/ улсын цол, одон, медаль, цэргийн дээд цол бий болгох, төрийн албаны зарим тусгай салбарын албан тушаалын зэрэг дэвийг тогтоох; |
| | **10) өршөөл үзүүлэх тухай шийдвэр гаргах;** | 11/ өршөөл үзүүлэх тухай шийдвэр гаргах; | 13/ өршөөл үзүүлэх шийдвэр гаргах; | 14/ өршөөл үзүүлэх шийдвэр гаргах; |
| 9) Монгол улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах; | 11) Монгол улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах; | 12/ **Засгийн газрын өргөн мэдүүлснээр** Монгол улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах; | 14/ Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах; | 15/ Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах; |
| 10) ~~Ерөнхийлөгчийн санаачилснаар~~ гадаад улстай дипломат харилцаа тогтоох, таслах; | 12) ~~**Засгийн газрын өргөн мэдүүлснээр**~~ гадаад улстай дипломат харилцаа тогтоох, таслах; | | | |
| 11) ард нийтийн санал хураалт явуулах; | 13) ард нийтийн санал хураалт явуулах; | 13/ ард нийтийн санал хураалт явуулах; ~~**Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол**~~ **сонгуулийн эрх бүхий иргэдийн ~~дийлэнх~~ олонх нь оролцсон ард нийтийн санал хураалтыг хүчинтэйд тооцож,** | 15/ ард нийтийн санал асуулга явуулах. Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонхи нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож, олонхийн санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзнэ; | 16/ ард нийтийн санал асуулга явуулах. Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонхи нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож, олонхийн санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзнэ; |

UNMN СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | **~~тэдний~~ олонхийн санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэнд тооцно.** | | |
| 12) Монгол улсын бүрэн эрх, тусгаар тогтнолд аюул занал учирвал дайн бүхий байдал зарлах, энх тайван тогтоох. | 14) Монгол улсын бүрэн эрх, тусгаар тогтнолд аюул занал учирвал дайн бүхий байдал зарлах, энх тайван тогтоох. | 14/ бусад улсаас Монгол улсын бүрэн эрх, тусгаар тогтнолд аюул занал учруулж зэвсэглэн халдвал дайн бүхий байдал зарлах, цуцлах; | 16/ Бусад улсаас Монгол Улсын бүрэн эрх, тусгаар тогтнолд аюул занал учруулж, зэвсэглэн халдвал дайн бүхий байдал зарлах, цуцлах; | 17/ Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд бусад улсаас аюул занал учруулж, зэвсэглэн халдвал дайн бүхий байдал зарлах, цуцлах; |
| | | 15/ энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөлд улсын хэмжээнд буюу түүний нутаг дэвсгэрийн зарим хэсэгт онц байдал, ~~түүнчлэн~~ дайны байдал зарлах, эсвэл эдгээр асуудлаар гаргасан Ерөнхийлөгчийн зарлигийг батлах, хүчингүй болгох. | 17/ энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөлд улс даяар буюу нутаг дэвсгэрийн зарим хэсэгт онц болон дайны байдал зарлах, эсвэл энэ тухай гаргасан Ерөнхийлөгчийн зарлигийг батлах, хүчингүй болгох. | 18/ энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөлд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, **эсхүл** энэ тухай гаргасан Ерөнхийлөгчийн зарлигийг батлах, хүчингүй болгох. |
| | | 2. Онц байдлыг дор дурдсан онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд түүний үр дагаврыг арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн байдалд оруулахын тулд зарлаж болно: | 2. дараах онцгой нөхцөл бий болсон үед үр дагаврыг нь арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд онц байдал зарлаж болно: | 2. дараах онцгой нөхцөл бий болсон үед үр дагаврыг нь арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд онц байдал зарлаж болно: |
| | | 1/ нийт нутаг дэвсгэрт буюу түүний тодорхой хэсэгт оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул ~~учруулсан буюу~~ учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул бий болсон; | 1/ нийт нутаг дэвсгэр буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон; | 1/ улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон; |
| | | 2/ Үндсэн хуулийн ардчилсан дэг журам, нийгмийн хууль ёсны зохион байгуулалт оршин тогтноход заналхийлсэн ямар нэгэн байгууллага, ~~хэсэг~~ бүлэг хүмүүсийн зохион байгуулалттай, хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас бий болсон ~~олон~~ нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэглэсээр зохицуулах | 2/ Их цаазын журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон. | 2/ Үндсэн хуулийн **дэг** журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус **үйл** ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | боломжгүй болсон. | | |
| | | 3. Дайны байдлыг улсын хэмжээнд буюу ~~түүний~~ нутаг дэвсгэрийн зарим хэсэгт олон түмний эмх замбараагүй байдал бий болж зэвсэгт мөргөлдөөнд хүрсэн буюу тийм мөргөлдөөн гарах бодит аюул бий болсон, мөн бусад улсаас цэргийн хүчээр түрэмгийлэн халдсан ~~буюу~~ тийнхүү халдах нь бодитой болсон тохиолдолд зарлаж болно. | 3. Улс даяар буюу нутаг дэвсгэрийн зарим хэсэгт нийтийн эмх замбараагүй байдал үүсч, зэвсэгт мөргөлдөөнд хүрсэн ~~буюу~~ тийм мөргөлдөөн гарах бодит аюул бий болсон, ~~мөн~~ бусад улсаас цэргийн хүчээр түрэмгийлэн халдсан, тийнхүү халдах нь бодитой болсон үед дайны байдал зарлаж болно. | 3. Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт **нь** нийтийн эмх замбараагүй байдал үүсч, зэвсэгт мөргөлдөөнд хүрсэн, тийм мөргөлдөөн гарах бодит аюул бий болсон, бусад улсаас цэргийн хүчээр түрэмгийлэн халдсан, эсхүл тийнхүү халдах нь бодитой болсон үед дайны байдал зарлаж болно. |
| Монгол Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. | 2. ~~Монгол~~ Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. | 4. Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. | 4. Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. | 4. Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. |
| **26 дугаар зүйл** | **ХОРИН НАЙМДУГААР ЗҮЙЛ** | **Хорин зургадугаар зүйл** | **Хорин зургадугаар зүйл** | **Хорин зургадугаар зүйл** |
| Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар, ~~Дээд шүүх~~ хууль санаачлах эрх эдэлнэ. | 1. ~~Монгол Улсын~~ Ерөнхийлөгч, ~~Улсын Их Хурлын байнгын хороо~~, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ. | 1. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ. | 1. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ. | 1. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ. |
| Бусад байгууллага, иргэд хуулийн төсвийн саналаа хууль санаачлагчид уламжилна. | 2. Бусад байгууллага, иргэд хуулийн төсвийн саналаа хууль санаачлагчид уламжилна. | 2. ~~**Хууль ёсоор бүртгэгдсэн**~~ бусад байгууллага, **түүнчлэн** иргэд хуулийн төслийн саналаа хууль санаачлагчид уламжилна. | 2. Бусад байгууллага, ~~түүнчилэн~~ иргэд хуулийн төслийн **тухай** саналаа хууль санаачлагчид уламжилна. | 2. Иргэд, бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна. |
| | | | **3. Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсны ~~хэвлэлд~~ нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол иййнхүү нийтэлснээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.** | 3. Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёс**оор** нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол иййнхүү нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно. |
| **27 дугаар зүйл** | **ХОРИН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ** | **Хорин долдугаар зүйл** | **Хорин долдугаар зүйл** | **Хорин долдугаар зүйл** |
| Монгол Улсын Их Хурал бүрэн эрхээ өөрийн чуулган, байнгын хороо болон бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ. | 1. ~~Монгол~~ Улсын Их Хурал бүрэн эрхээ өөрийн чуулган, байнгын хороо болон бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ. | 1. Улсын Их Хурал бүрэн эрхээ өөрийн чуулган, ~~Байнгын хороо болон~~ **зохион байгуулалтын** бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ. | 1. Улсын Их Хурал бүрэн эрхээ ~~өөрийн~~ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ. | 1. Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ. |
| Ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тус бүр ажлын 75 хүртэл хоног чуулна. | 2. **Улсын Их Хурлын** ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тус бүр ~~ажлын~~ 75 ~~хүртэл хоног~~ чуулна. | 2. Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тус бүр 75**-аас доошгүй ажлын өдөр** чуулна. | 2. Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа далан таваас доошгүй ажлын өдөр чуулна. | 2. Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа далан таваас доошгүй ажлын өдөр чуулна. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| Улсын Их Хурлын гишүүдийн олонхийн шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын ~~Тэргүүн~~ даргын санаачилгаар ээлжит бус чуулган хийж болно.<br>Улсын Их Хурал анхдугаар чуулганыг Ерөнхийлөгч, бусад чуулганыг Улсын Их Хурлын ~~Тэргүүн~~ дарга товлон зарлана. | 3. Улсын Их Хурлын гишүүдийн олонхийн шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын даргын санаачилгаар ээлжит бус чуулган хийж болно. | 3. Улсын Их Хурлын гишүүдийн <u>олонхийн</u> шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын даргын санаачилгаар ээлжит бус чуулган хийж болно. | 3. Улсын Их Хурлын гишүүдийн <u>гуравны нэгээс дээшхийн</u> шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргын санаачилгаар ээлжит бус чуулган хийж болно. | 3. Улсын Их Хурлын гишүүдийн гуравны нэгээс дээшхийн шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргын санаачилгаар ээлжит бус чуулган чуулж болно. |
| | 4. Улсын Их Хурал анхдугаар чуулганыг Ерөнхийлөгч, бусад чуулганыг Улсын Их Хурлын дарга товлон зарлана. | 4. Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг Ерөнхийлөгч, бусад чуулганыг Улсын Их Хурлын дарга товлон зарлана. | 4. Улсын Их Хурал анхдугаар чуулганыг Ерөнхийлөгч **30 хоногийн дотор**, бусад чуулганыг Улсын Их Хурлын дарга товлон зарлана. | 4. Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг **сонгууль явуулсан өдрөөс хойш** гуч хоногийн дотор Ерөнхийлөгч, бусад чуулганыг Улсын Их Хурлын дарга товлон зарлана. |
| | | 5. Улсын Их Хурал онцгой чуулганыг ~~энэхүү~~ <u>Үндсэн хуулийн</u> гучин гуравдугаар зүйлийн I дэх хэсгийн 13-д зааснаар дайны болон онц байдал зарласан ~~тохиолдолд тийнхүү зарласнаас~~ хойш 72 цагийн дотор тусгайлан <u>зарлахгүйгээр</u> хийнэ. | 5. Улсын Их Хурал онцгой чуулганыг <u>Их цаазын</u> ~~гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12-т зааснаар~~[93] дайны болон онц байдал <u>зарлавал түүнээс</u> хойш 72 цагийн дотор тусгайлан <u>товлохгүйгээр</u> хийнэ. | 5. **Ерөнхийлөгч** онц болон дайны байдал зарлавал түүнээс хойш далан хоёр цагийн дотор Улсын Их Хурал онцгой чуулганаа тусгайлан товлохгүйгээр чуулна. |
| Улсын Их Хурлын нийт гишүүний 75 хувиас доошгүй нь хүрэлцэн ирсэн бол чуулганыг хүчинтэйд тооцож, асуудлыг чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ. | 5. Улсын Их Хурлын нийт гишүүний ~~75 хувиас доошгүй~~ нь хүрэлцэн ирсэн бол чуулганыг хүчинтэйд тооцож, ~~**Улсын Их цаазад нэмэлт, өөрчлөлт оруулахаас бусад**~~ асуудлыг чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ. | 6. Улсын Их Хурлын нийт гишүүний **дийлэнх олонхи** нь хүрэлцэн ирсэн бол чуулганыг хүчинтэйд <u>тооцож</u>, ~~асуудлыг~~ <u>Үндсэн хуульд</u> **<u>өөрөөр заагаагүй бол</u>** чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ. | 6. Улсын Их Хурлын нийт гишүүний ~~олонхи~~ нь хүрэлцэн ирсэн бол чуулганыг хүчинтэйд <u>үзэж</u>, ~~<u>Их цаазад</u> өөрөөр заагаагүй бол~~ чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. | 6. Үндсэн хууль, бусад хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нийт гишүүний <u>дийлэнх</u> олонхи нь хүрэлцэн <u>ирснээр</u> чуулганыг хүчинтэйд үзэж, чуулганд оролцсон нийт гишүү**дийн** олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. |
| **28 дугаар зүйл** | **ГУЧДУГААР ЗҮЙЛ** | **Хорин наймдугаар зүйл** | **Хорин наймдугаар зүйл** | **Хорин наймдугаар зүйл** |
| Монгол Улсын Их Хурал үйл ажиллагаанныхаа зохих салбарын асуудал эрхэлсэн байнгын хороодтой байна. | 1. ~~Монгол~~ Улсын Их Хурал үйл ажиллагаанныхаа зохих ~~салбарын асуудал эрхэлсэн~~ байнгын хороодтой байна. | 1. Улсын Их Хурал үйл ажиллагаанныхаа зохих салбар, **чиглэлээр** байнгын хороодтой байна. | 1. Улсын Их Хурал үйл ажиллагаанныхаа зохих салбар, чиглэлээр Байнгын хороодтой байна. | 1. Улсын Их Хурал үйл ажиллагаанныхаа зохих салбар, чиглэлээр Байнгын хороодтой байна. |
| Байнгын хороо нь Улсын Их Хурлын ажлын байгууллага мөн бөгөөд хуулийн болон бусад асуудлаар төсөл боловсруулах, санал дүгнэлт гаргах, тус тусын эрхлэх асуудлын хүрээнд Улсын Их Хурлын хянан шалгах үүргийг хэрэгжүүлэх бүрэн | | | | |

[93]3-р төслийн "гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12" гэсэн заалт огт байхгүй байна.

| | | | | |
|---|---|---|---|---|
| эрхтэй. | | | | |
| Байнгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Улсын Их Хурал тогтооно. | 2. Байнгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Улсын Их Хурал тогтооно. | 2. Байнгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Улсын Их Хурал тогтооно. | 2. Байнгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Улсын Их Хурал тогтооно. | 2. Байнгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Улсын Их Хурал тогтооно. |
| **29 дүгээр зүйл** | **ГУЧИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ** | **Хорин ес дүгээр зүйл** | **Хорин есдүгээр зүйл** | **Хорин есдүгээр зүйл** |
| | ***Хуулийн төслийн 32-р зүйлд тусгагдсан байна:***<br><br>~~Монгол~~ Улсын Их хурлын гишүүн нь Ерөнхийлөгч, Засгийн Газрын гишүүний болон хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад албан тушаал хавсран ~~эрхэлж~~ болохгүй. | 1. Улсын Их Хурлын гишүүн нь **бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин харамж хүртэх бөгөөд** Ерөнхийлөгч, **Ерөнхий сайд,** Засгийн газрын гишүүний болон хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ~~бусад~~ ажил, албан тушаал хавсарч болохгүй. | 1. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин ~~хангамж хүртэх бөгөөд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний болоод~~ хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй. | 1. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин **авна. Улсын Их Хурлын гишүүн нь** хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах **бусад** ажил, албан тушаал хавсарч болохгүй. |
| Монгол Улсын Их хурлын гишүүнийг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр (гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд) эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, түүний бие, гэр орон, албан тасалгаа, унаанд халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно. | 1. ~~Монгол~~ Улсын Их хурлын гишүүнийг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр (гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд) эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, түүнд шүүхийн журмаар ~~захиргааны~~ шийтгэл оногдуулах, түүний бие, гэр орон, албан тасалгаа, **эд хөрөнгө**, унаанд халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно. | 2. Улсын Их Хурлын гишүүнийг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр /гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд/ эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, түүнд шүүхийн журлаар шийтгэл оногдуулах, **түүнчлэн албан үйл ажиллагаатай нь холбогдуулж** түүний бие, гэр орон, албан тасалгаа, эд хөрөнгө, унаанд халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно. | 2. Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална. | 2. Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална. |
| Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэн тухай асуудал гарвал түүнийг гагцхүү Улсын Их Хурлын чуулганаар шүүн хэлэлцэн чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ.<br>Улсын Их Хурал уг гишүүнийг гэмт хэрэг үйлдсэн гэх үндэслэл тогтоовол огцруулж, Улсын-дээд шүүхэд шилжүүлнэ. | 2. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэн тухай асуудал гарвал түүнийг гагцхүү Улсын Их Хурлын чуулганаар ~~шүүн~~ хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ.<br>3. Улсын Их Хурал уг гишүүнийг гэмт хэрэг үйлдсэн гэх үндэслэл тогтоовол эгүүлэн татаж ~~Улсын Дээд~~ шүүхэд шилжүүлнэ. | 3. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг, **зөрчил** ~~үйлдсэн~~ тухай ~~асуудал гарвал түүнийг~~ гагцхүү Улсын Их Хурлын чуулганаар **хянан** хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэж ~~уул гишүүнийг~~ гэмт хэрэг үйлдсэн гэх үндэслэл тогтоовол эгүүлэн татаж шүүхэд шилжүүлнэ. | 3. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг~~, зөрчилд~~ холбогдсон тухайд ~~гагцхүү~~ Улсын Их Хурлын чуулганаар ~~хянан~~ хэлэлцэж~~, чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар~~ шийдвэрлэж~~,~~ гэмт хэрэг үйлдсэн гэх үндэслэл тогтоовол эгүүлэн тат~~аж шүүхэд шилжүүлнэ~~. | 3. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг**т** холбогдсон тухай **асуудлыг** Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, **бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг** шийдвэрлэнэ. **Уул гишүүн** гэмт хэрэг үйлдсэн гэж **шүүх** тогтоовол **Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь** эгүүлэн татна. |
| **30 дугаар зүйл** | **ГУЧИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ** | | | |
| Монгол Улсын Их хурлын гишүүн нь Ерөнхийлөгч, Засгийн | ~~Монгол~~ Улсын Их хурлын гишүүн нь Ерөнхийлөгч, Засгийн | ***Хуулийн төслийн 29-р зүйлийн 1 дэх хэсэгт*** | ***Хуулийн төслийн 29-р зүйлийн 1 дэх хэсэгт*** | ***Үндсэн хуулийн 29-р зүйлийн 1 дэх хэсэгт тусгагдсан*** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Газрын гишүүний болон хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад албан тушаал хавсран эрхэлж болохгүй. | Газрын гишүүний болон хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад албан тушаал хавсра~~н~~ ~~эрхэлж~~ болохгүй. | ***тусгагдсан байна.*** | ***тусгагдсан байна.*** | ***байна.*** |
| **II. Монгол улсын Ерөнхийлөгч** | **ХОЁР. Монгол улсын Ерөнхийлөгч** | **ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** | **ХОЁР. Монгол Улсын Ерөнхийлөгч** | **ХОЁР. Монгол Улсын Ерөнхийлөгч** |
| **31 дүгээр зүйл** | **ГУЧИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ** | **Гучдугаар зүйл** | **Гучдугаар зүйл** | **Гучдугаар зүйл** |
| Монгол улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийн бэлгэдэл мөн. | 1. Монгол улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийн бэлгэдэл мөн. | 1. Монгол улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийн бэлгэдэл мөн. | 1. Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийн бэлгэдэл мөн. | 1. Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн. |
| Ерөнхийлөгчөөр 40 нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол улсын гурван үе дамжсан уугуул иргэнийг 4 жилийн хугацаагаар сонгоно.<br><br>***Хуулийн төслийн 31-р зүйлд тусгагдсан байна.*** | 2. Ерөнхийлөгчөөр 40 нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, гурван үе залгамжилсан, Монгол улсын ~~түүх~~ уугуул иргэнийг 4 жилийн хугацаагаар сонгоно.<br>3. Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно. | 2. Ерөнхийлөгчөөр 40 нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол улсын ~~гурваас доошгүй үеийн~~ уугуул иргэнийг 4 жилийн хугацаагаар сонгоно.<br>***Хуулийн төслийн 31-р зүйлийн 7 дахь хэсэгт тусгагдсан байна.*** | 2. Ерөнхийлөгчөөр 50 нас хүрсэн, сүүлийн 5-аас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг 4 жилийн хугацаагаар сонгоно.<br>***Хуулийн төслийн 31-р зүйлийн 7 дахь хэсэгт тусгагдсан байна.*** | 2. Ерөнхийлөгчөөр 45 нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг 4 жилийн хугацаагаар сонгоно.<br>***Үндсэн хуулийн 31-р зүйлийн 7 дахь хэсэгт тусгагдсан байна.*** |
| | **ГУЧИН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ** | **Гучин нэгдүгээр зүйл** | **Гучин нэгдүгээр зүйл** | **Гучин нэгдүгээр зүйл** |
| Ерөнхийлөгчийн сонгууль 2 үе шаттай байна. | 1. ~~Монгол улсын~~ Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байна. | 1. Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байна. | 1. Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байна. | 1. Ерөнхийлөгчийн сонгууль 2 шаттай байна. |
| ~~Нийт сонгогчийн таван хувиас доошгүйн санал авсан~~ нам дангаар буюу хамтран Ерөнхийлөгчид нэгэн хүний нэр дэвшүүлнэ. | 2. **~~Монгол~~ Улсын Их Хуралд суудал ~~авсан~~** нам дангаар буюу хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлж ~~болно.~~ | 2. Улсын Их Хуралд суудал **бүхий** нам дангаар буюу хамтран Ерөнхийлөгчид ~~тус бүр нэг~~ хүний нэр дэвшүүлнэ. | 2. Улсын Их Хуралд суудал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид нэжгээд хүний нэр дэвшүүлнэ. | 2. Улсын Их Хуралд суудал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлнэ. |
| Анхан шатны сонгуульд Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээр, шууд сонгох эрхийн үндсэн дээр оролцож, Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн төлөө саналаа нууцаар гаргана. | 3. Анхан шатны сонгуульд Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээр, ~~тэгш,~~ шууд сонгох эрхийн үндсэн дээр оролцож, Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн төлөө саналаа нууцаар гаргана. | 3. Анхан шатны сонгуульд Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээр**ээ, чөлөөтэй,** шууд сонгох Эрхийн үндсэн дээр оролцож Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн төлөө саналаа нууцаар гаргана. | 3. Анхан шатны сонгуульд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхтэй оролцож, Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн төлөө саналаа нууцаар гаргана. | 3. Анхан шатны сонгуульд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхтэй оролцож, Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн талаар саналаа нууцаар гаргана. |
| | | 4. Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсонд тооцож түүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн хууль гаргана. | 4. Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана. | 4. Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Анхан шатны сонгуулиар нийт сонгогчийн тэн хагасаас доошгүй нь оролцож, ~~хамгийн олон тэгэхдээ~~ санал хураалтад оролцсон сонгогчдын ~~гучаас доошгүй хувийн~~ санал авсан хоёр хүнийг Улсын Их Хуралд хэлэлцэж санал хураалтанд оруулна. | 4. ~~Анхан шатны сонгуулиар нийт сонгогчийн тэн хагасаас доошгүй нь оролцож, санал хураалтад оролцсон~~ сонгогчдын **хамгийн олон** санал авсан хоёр хүнийг Улсын Их Хуралд хэлэлцэж санал хураалтад оруулна. | 5. **Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү** сонгогчдын **олонхийн санал аваагүй бол** хамгийн олон санал авсан хоёр хүнийг **хоёр дахь шатны сонгууль буюу** Улсын Их Хуралд **оруулан** хэлэлцэж **чуулганд оролцсон гишүүдийн** саналыг **нууцаар** хураана. | 5. Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү сонгогчдын олонхийн санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр хүнийг ~~2 дахь шатны сонгууль буюу Улсын Их Хуралд оруулан хэлэлцэж чуулганд оролцсон гишүүдийн саналыг нууцаар хураана~~. | 5. Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү сонгогчдын олонхийн санал аваагүй бол **анхны санал хураалтад оролцсон нийт сонгогчийн** хамгийн олон санал авсан хоёр хүнийг **дахин санал хураалтад оруулна**. |
| Улсын Их хурлын нийт гишүүний олонхийн санал авсан нэр дэвшигчийг Монгол улсын Ерөнхийлөгчөөр сонгосонд тооцно. | 5. Улсын Их хурлын нийт гишүүний олонхийн санал авсан нэр дэвшигчийг ~~Монгол улсын~~ Ерөнхийлөгчөөр сонгосонд тооцно. | 6. Улсын Их Хурлын **чуулганд оролцсон** нийт гишүүний олонхийн санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсонд-тооцно. | 6. ~~Улсын Их Хурлын чуулганд~~ оролцсон нийт гишүүний олонхийн санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон хэмээн үзнэ. | **Дахин санал хураалтаар сонгуульд** оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг **Улсын Их Хурал** Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж **бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана.** |
| Хэрэв Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч олонхийн санал аваагүй бол Улсын Их хурлын гишүүдийн олонхийн саналаар дахин нэг удаа санал хураалт явуулж болно. | 6. Хэрэв Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч олонхийн санал авахгүй бол Улсын Их Хурлын гишүүдийн олонхийн саналаар дахин санал хураалт явуулж болно. | ~~Хэрэв~~ Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч олонхийн санал аваагүй бол ~~Улсын Их Хурлын чуулганд **оролцсон нийт** гишүүний олонхийн саналаар~~ дахин **нэг удаа** санал хураалт**~~ад оруулж болох бөгөөд энэхүү~~ санал хураалтаар хэн нь ч олонхийн санал аваагүй бол Ерөнхийлөгчийн сонгуулийг эхнээс нь** явуулна. | Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч олонхийн санал аваагүй бол дахин ~~1 удаа санал хураана. Санал хураалтаар хэн нь ч олонхын санал аваагүй бол Ерөнхийлөгчийн~~ сонгуулий~~г эхнээс нь~~ явуулна. | 6. **Хэрэв хоёр дахь санал хураалтаар** Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч **ийнхүү сонгогчдын** олонхийн санал аваагүй бол дахин сонгууль явуулна. |
| | 7. Ерөнхийлөгчийг сонгох журмыг хуулиар тогтооно. | | | |
| Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно. | ***Хуулийн төслийн 33-р зүйлийн 3 дахь хэсэгт тусгагдсан байна:***<br><br>Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно. | 7. Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно. | 7. Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно. | 7. Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно. |
| **32 дугаар зүйл** | **ГУЧИН ТАВДУГААР ЗҮЙЛ** | | | |
| Монгол Улсын Ерөнхийлөгч нь Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад албан тушаалыг хавсарч болохгүй.<br>Хэрэв Ерөнхийлөгч өөр албан | 1. ~~Монгол Улсын~~ Ерөнхийлөгч нь Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад албан тушаалыг хавсарч болохгүй.<br>2. Хэрэв Ерөнхийлөгч өөр албан | 8. Ерөнхийлөгч нь Улсын Их Хурлын ~~болон~~ Засгийн газрын гишүүн, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад албан тушаалыг хавсарч болохгүй.<br>Хэрэв Ерөнхийлөгч өөр албан | 8. Ерөнхийлөгч нь **Ерөнхий сайд,** Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад **ажил,** албан тушаал хавсарч болохгүй.<br>Хэрэв Ерөнхийлөгч өөр **ажил,** | 8. Ерөнхийлөгч нь Ерөнхий сайд, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй.<br>Хэрэв Ерөнхийлөгч өөр ажил, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| тушаал эрхэлж, сонгууль хүлээж байгаа бол тангараг өргөсөн өдрөөс эхлэн уул үүргээсээ чөлөөлөгдөнө. | тушаал эрхэлж сонгууль хүлээж байгаа бол тангараг өргөсөн өдрөөс эхлэн уул үүргээсээ чөлөөлөгдөнө. | тушаал эрхэлж, сонгууль хүлээж байгаа бол тангараг өргөсөн өдрөөс эхлэн уул үүргээсээ чөлөөлөгдөнө. | албан тушаал, сонгуульт эрхэлж байгаа бол тангараг өргөсөн өдрөөс эхлэн уул үүргээс чөлөөлөгдөнө. | албан тушаал эрхэлж байгаа бол тангараг өргөсөн өдрөөсөө эхлэн уул үүргээс чөлөөлөгдөнө. |
| | | **Гучин хоёдугаар зүйл** | **Гучин хоёрдугаар зүйл** | **Гучин хоёрдугаар зүйл** |
| ***Хуулийн төслийн 33-р зүйлд тусгагдсан байна:*** <br><br> Ерөнхийлөгчийн бүрэн эрх тангараг өргөснөөр эхлэж, шинэ сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөмөгц дуусгавар болно. | ***Хуулийн төслийн 36-р зүйлийн 2 дахь хэсэгт тусгагдсан байна:*** <br><br> Ерөнхийлөгчийн бүрэн эрх тангараг өргөснөөр эхлэж, шинэ сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөснөөр дуусгавар болно. | 1. Ерөнхийлөгчийн бүрэн эрх тангараг өргөснөөр эхлэж, шинэ сонгогдсон Ерөнхнийлөгч тангараг өргөснөөр дуусгавар болно. | 1. Ерөнхийлөгчийн бүрэн эрх тангараг өргөснөөр эхлэж, шинэ сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөснөөр дуусгавар болно. | 1. Ерөнхийлөгчийн бүрэн эрх тангараг өргөснөөр эхлэж, шинэ сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөснөөр дуусгавар болно. |
| **33 дугаар зүйл** | **ГУЧИН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ** | | | |
| Монгол улсын Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш 30 хоногийн дотор “Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн хамгаалж, Монгол Улсын Их цаазыг дээдлэн сахиж Ерөнхийлөгчийн үүргийг шударгаар биелүүлэхээ батлан тангараглая” хэмээн Улсын Их Хуралд тангараг өргөнө. | 1. ~~Монгол улсын~~ Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш 30 хоногийн дотор “Монгол улсын тусгаар тогтнол бүрэн эрхт байдал ард түмнийхээ эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн хамгаалж, Монгол Улсын Их цаазыг дээдлэн сахиж Ерөнхийлөгчийн үүргийг шударгаар биелүүлэхээ батлан тангараглая” хэмээн Улсын Их Хуралд тангараг өргөнө. | 2. Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш 30 хоногийн дотор “Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард тумнийхээ эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн хамгаалж, ~~Монгол Улсын~~ Үндсэн хуулийг дээдлэн сахиж, Ерөнхийлөгчийн үүргийг шударгаар биелүүлэхээ батлан тангараглая" хэмээн Улсын Их Хуралд тангараг өргөнө. | 2. Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш гуч хоногийн дотор “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн хамгаалж, Их цаазаа дээдлэн сахиж, Ерөнхийлөгчийн үүргийг шударгаар биелүүлэхээ батлан тангараглая” хэмээн Улсын Их Хуралд тангараг өргөнө. | 2. Ерөнхийлөгч сонгогдсоноосоо хойш гуч хоногийн дотор “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн хамгаалж, Үндсэн хуулийг дээдлэн сахиж, Ерөнхийлөгчийн үүргийг шударгаар биелүүлэхээ батлан тангараглая” хэмээн Улсын Их Хуралд тангараг өргөнө. |
| Ерөнхийлөгчийн бүрэн эрх тангараг өргөснөөр эхлэж, шинэ сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөмөгц дуусгавар болно. | 2. Ерөнхийлөгчийн бүрэн эрх тангараг өргөснөөр эхлэж, шинэ сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөснөөр дуусгавар болно. | ***Хуулийн төслийн 32-р зүйлийн 1 дэх хэсэгт тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 32-р зүйлийн 1 дэх хэсэгт тусгагдсан байна.*** | ***Үндсэн хуулийн 32-р зүйлийн 1 дэх хэсэгт тусгагдсан байна.*** |
| **34 дүгээр зүйл** | **ГУЧИН ДОЛДУГААР ЗҮЙЛ** | **Гучин гуравдугаар зүйл** | **Гучин гуравдугаар зүйл** | **Гучин гуравдугаар зүйл** |
| Монгол улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг Улсын Их цааз, бусад хуулиар тодорхойлно. | 1. Монгол улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг Улсын Их цааз, бусад хуулиар тодорхойлно. | | | |
| Ерөнхийлөгч дор дурдсан онцгой бүрэн эрх эдэлнэ: | 2.Ерөнхийлөгч дор дурдсан ~~онцгой~~ бүрэн эрх эдэлнэ: | 1. Ерөнхийлөгч дор дурдсан бүрэн эрх эдэлнэ: | 1. Ерөнхийлөгч дараах **үндсэн** бүрэн эрх хэрэгжүүлнэ: | 1. Ерөнхийлөгч дараах үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: |
| 1) Улсын Их Хурлын гишүүний сонгуулийг товлон зарлана; | | | | |
| 2) Улсын Их Хурлын хэлэлцэж баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт хориг тавина. | 1) Улсын Их Хурлын хэлэлцэж баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт хориг тавина. | 1/ Улсын Их Хурлын ~~хэлэлцэж~~ баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт хориг тавина. | 1/ Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт хориг тавина. Ерөнхийлөгчийн | 1/ Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих. Ерөнхийлөгчийн тавьсан |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёрын саналаар хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэрийг хүчин төгөлдөр болсонд тооцно; | Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёрын саналаар хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэрийг хүчин төгөлдөр болсонд тооцно; | Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр~~ын~~ ~~саналаар~~ хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэрийг хүчин төгөлдөр болсонд тооцно; | тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр **нь** хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэри~~йг~~ хүчин төгөлдөр болсонд тооцно. | хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ; |
| 3) Улсын Их хурал илтгээлт явуулж, чуулганд өөрийн үзэмжээр оролцож улс орны дотоод, гадаад амьдралын нэн чухал асуудлаар тогтмол мэдээлж, саналаа оруулна; | 2) Улсын Их хурал илтгээлт ~~явуулж~~, чуулганд өөрийн үзэмжээр оролцож улс орны дотоод, гадаад амьдралын нэн чухал асуудлаар тогтмол мэдээлж, саналаа оруулна; | ***Хуулийн төслийн 33-р зүйлийн 2 дахь хэсэгт тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 33-р зүйлийн 3 дахь хэсэгт тусгагдсан байна.*** | ***Үндсэн хуулийн 33-р зүйлийн 3 дахь хэсэгт тусгагдсан байна.*** |
| ***Хуулийн төслийн 34-р 5-т тусгагдсан байна:***<br><br>Улсын Их хуралд хамгийн олон суудал авсан намаас нэр дэвшүүлсэн хүнийг Монгол улсын Ерөнхий сайдаар томилох санал, түүнчлэн үндэслэлтэй гэж үзвэл Засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулна; | ***Хуулийн төслийн 37-р зүйлийн 2 дахь хэсгийн 4-т тусгагдсан байна:***<br><br>Улсын Их хуралд хамгийн олон суудал авсан намаас нэр дэвшүүлсэн хүнийг Монгол улсын Ерөнхий сайдаар томилох санал, түүнчлэн үндэслэлтэй гэж үзвэл Засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулна; | 2/ Улсын Их Хуралд хамгийн олон суудал авсан намаас нэр дэвшүүлсэн хүнийг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох санал, түүнчлэн ~~үндэслэлтэй гэж үзвэл~~ Засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулна; | 2/ Улсын Их Хуралд олонхи суудал авсан намтай, ~~эсхүл~~ **аль ч нам олонхийн суудал аваагүй бол Улсын Их Хуралд суудал авсан намуудтай зөвшилцөн** нэр дэвшүүлсэн хүнийг ~~Монгол улсын~~ Ерөнхий сайдаар томилох санал, түүнчлэн Засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулах; | ***2/ Улсын Их Хуралд олонхи суудал авсан намтай, аль ч нам олонхийн суудал аваагүй бол Улсын Их Хуралд суудал авсан намуудтай зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох санал, түүнчлэн Засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулах;*** |
| 4) өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн Газарт чиглэл өгнө; | 3) өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн Газарт чиглэл өгнө; | ~~3/ өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгнө.~~ ~~**Энэ талаар Ерөнхийлөгч зарлиг гаргавал түүнд Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно;**~~ | | 3/ өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх. Энэ талаар Ерөнхийлөгч зарлиг гаргавал түүнд Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно; |
| 5) Улсын Их хуралд хамгийн олон суудал авсан намаас нэр дэвшүүлсэн хүнийг Монгол улсын Ерөнхий сайдаар томилох санал, түүнчлэн үндэслэлтэй гэж үзвэл Засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулна; | 4) Улсын Их хуралд хамгийн олон суудал авсан намаас нэр дэвшүүлсэн хүнийг Монгол улсын Ерөнхий сайдаар томилох санал, түүнчлэн үндэслэлтэй гэж үзвэл Засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулна; | ***Хуулийн төслийн 33-р зүйлийн 1 дэх хэсгийн 2-т тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 33-р зүйлийн 1 дэх хэсгийн 2-т тусгагдсан байна.*** | ***Үндсэн хуулийн 33-р зүйлийн 1 дэх хэсгийн 2-т тусгагдсан байна.*** |
| 6) Монгол улсыг гадаад харилцаанд бүрэн эрхтэй төлөөлж, Монгол улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулна; | 5) ~~Монгол улсыг~~ гадаад харилцаанд бүрэн эрхтэй төлөөлж, Монгол улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулна; | 4/ гадаад харилцаанд **улсаа** бүрэн эрхтэй төлөөлж, **Улсын Их Хуралтай зөвшөөрөлцөн** Монгол улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулна; | 3/ гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж, Улсын Их Хуралтай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах; | 4/ гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж, Улсын Их Хуралтай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах; |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 7) Монгол улсаас гадаад улс ~~болон олон улсын байгууллага~~д суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшөөрөлцөн томилох буюу эгүүлэн татна; | 6) Монгол улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшөөрөлцөн томилох буюу эгүүлэн татна; | 5/ Монгол улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшөөрөлцөн томилох буюу эгүүлэн татна; | 4/ Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох буюу эгүүлэн татах; | 5/ Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох буюу эгүүлэн татах; |
| 8) Монгол улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авна; | 7) Монгол улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авна; | 6/ Монгол улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авна; | 5/ Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах; | 6/ Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах; |
| 9) улсын ~~цол, одон, медаль,~~ цэргийн дээд ~~цол бий болгож үүл~~ цолыг хүртээж одон медалиар шагнана; | 8) улсын **болон** цэргийн дээд цол хүртээж, одон, медалиар шагнана; | 7/ Улсын **цол** ~~болон~~ цэргийн дээд цол хүртээж, одон, медалиар шагнана; | 6/ улсын цол, цэргийн дээд цол хүртээж, одон, медалиар шагнах; | 7/ улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах; |
| 10) Монгол улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийг тэргүүлнэ; | | | | |
| 11) уучлал үзүүлнэ; | 9) уучлал үзүүлнэ; | 8/ уучлал үзүүлнэ; | 7/ уучлал үзүүлэх; | 8/ уучлал үзүүлэх; |
| 12) Монгол улсын харьяат болгох, харьяатаас гарах болон Монгол Улсад орогнох эрх олгох асуудлыг шийдвэрлэнэ; | 10) Монгол улсын харьяат болгох, харьяатаас гарах болон Монгол Улсад орогнох эрх олгох асуудлыг шийдвэрлэнэ; | 9/ Монгол улсын харьяат болгох, харьяатаас гарах ~~болон~~ монгол улсад орогнох эрх олгох асуудлыг шийдвэрлэнэ; | 8/ Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах**,** тус улсад орогнох эрх олгох асуудлыг шийдвэрлэх; | 9/ Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, тус улсад орогнох эрх олгох асуудлыг шийдвэрлэх; |
| | **11) Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлнэ;** | 10/ Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлнэ; | 9/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх; | 10/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх; |
| 13) Монгол улсын зэвсэгт хүчний дээд командлагч байна; | 12) Монгол улсын зэвсэгт хүчний дээд командлагч байна; | 11/ Монгол улсын зэвсэгт хүчний ерөнхий жанжин байна; | ***Хуулийн төслийн 33-р зүйлийн 2 дахь хэсэгт тусгагдсан байна:***<br><br>**Ерөнхийлөгч** Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. | ***Үндсэн хуулийн 33-р зүйлийн 2 дахь хэсэгт тусгагдсан байна:***<br><br>Ерөнхийлөгч Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна |
| 14) улсын хэмжээнд, эсхүл нутаг дэвсгэрийн зарим хэсгийг дайны байдалд оруулж, нийгмийн дэг журам сахиулах онцгой журам тогтооно; | 13) улсын хэмжээнд, эсхүл нутаг дэвсгэрийн зарим хэсгийг дайны байдалд ~~оруулж, нийгмийн дэг журам сахиулах онцгой журам тогтооно~~; | ***Хуулийн төслийн 33-р зүйлийн 1 дэх хэсгийн 13-т тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 33-р зүйлийн 1 дэх хэсгийн 11-т тусгагдсан байна.*** | ***Үндсэн хуулийн 33-р зүйлийн 1 дэх хэсгийн 12-т тусгагдсан байна.*** |
| 15) бүх нийтийн буюу хэсэгчилэн цэргийн дайчилгаа зарлана. | 14) бүх нийтийн буюу хэсэгчилэн цэргийн дайчилгаа зарлана. | 12/ бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлана; | 10/ бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах; | 11/ бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах; |
| ***Хуулийн төслийн 34-р зүйлийн 14-т тусгагдсан байна:***<br><br>улсын хэмжээнд, эсхүл нутаг | ***Хуулийн төслийн 37-р зүйлийн 2 дахь хэсгийн 13-т тусгагдсан байна:***<br><br>улсын хэмжээнд, эсхүл нутаг | 13/ **энэхүү Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт** | 11/ Их цаазын хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт**,** хойшлуулшгүй | 12/ Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| дэвсгэрийн зарим хэсгийг дайны байдалд оруулж, нийгмийн дэг журам сахиулах онцгой журам тогтооно; | дэвсгэрийн зарим хэсгийг дайны байдал~~д оруулж, нийгмийн дэг журам сахиулах онцгой журам тогтооно~~; | ~~**буюу**~~ **хойшлуулшгүй тохиолдолд** улсын хэмжээнд <u>эсхүл</u> ~~нутаг дэвсгэрийн~~ зарим хэсэгт **онц** ~~байдал, **мөн**~~ дайны байдал **зарлах, түүнчлэн** ~~**цэргийн ажиллагаа эхлэх**~~ **захирамж өг<u>нө</u>.** **Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал 7 хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болго<u>х</u>** ~~**бөгөөд**~~ **хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно.** | тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт <u>буюу</u> зарим хэсэгт **нь** онц **болон** дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг **хөдөлгөх** захирамж өг<u>өх</u>. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал **уул зарлиг гарснаас хойш** 7 хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болго<u>но.</u> Хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно. | хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгөх. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно. |
| ***Хуулийн төслийн 34-р зүйлийн 13-т тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 37-р зүйлийн 2 дахь хэсгийн 12-т тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 33-р зүйлийн 1 дэх хэсгийн 11-т тусгагдсан байна.*** | 2. Ерөнхийлөгч Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий <u>командлагч</u> байна. | 2. Ерөнхийлөгч Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. |
| ***Хуулийн төслийн 34-р зүйлийн 3-т тусгагдсан байна:*** <br><br> Улсын Их хуралд илтгэлт явуулж, чуулганд өөрийн үзэмжээр оролцож улс орны дотоод, гадаад амьдралын нэн чухал асуудлаар тогтмол мэдээлж, саналаа оруулна; | ***Хуулийн төслийн 37-р зүйлийн 2 дахь хэсгийн 2-т тусгагдсан байна:*** <br><br> Улсын Их хуралд илтгэлт <u>явуулж</u>, чуулганд өөрийн үзэмжээр оролцож улс орны дотоод, гадаад амьдралын нэн чухал асуудлаар ~~тогтмол~~ мэдээлж, саналаа оруул<u>на</u>; | 2. **Ерөнхийлөгч** Улсын Их Хуралд **болон ард түмэндээ хандан** илгээлт <u>гаргаж</u>, чуулганд өөрийн үзэмжээр оролцож улс орны дотоод, гадаад амьдралын нэн чухал асуудлаар мэдээлж, саналаа оруул<u>ж болно</u>. | 3. Ерөнхийлөгч Улсын Их Хуралд болон ард түмэндээ хандан илгээлт гаргаж, чуулганд өөрийн таалаар оролцон улс орны дотоод, гадаад амьдралын нэн чухал асуудлаар мэдээлж, саналаа оруулж болно. | 3. Ерөнхийлөгч Улсын Их Хуралд болон ард түмэндээ хандан илгээлт гаргаж, чуулганд өөрийн таалаар оролцон улс орны дотоод, гадаад байдлын нэн чухал асуудлаар мэдээлж, саналаа оруулж болно. |
| <u>Монгол улсын хуулиар</u> Ерөнхийлөгчид өөр тодорхой бүрэн эрхийг олгож болно. | 3. Ерөнхийлөгчид өөр тодорхой бүрэн эрхийг <u>зөвхөн хуулиар</u> олгож болно. | 3. Ерөнхийлөгчид өөр тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно. | 4. Ерөнхийлөгчид бусад тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно. | 4. Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно. |
| **35 дугаар зүйл** | **ГУЧИН НАЙМДУГААР ЗҮЙЛ** | **Гучин Дөрөвдүгээр зүйл** | **Гучин дөрөвдүгээр зүйл** | **Гучин дөрөвдүгээр зүйл** |
| Монгол улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ дагуу Улсын Их цааз, бусад хуульд нийцүүлэн зарлиг гаргана. | 1. ~~Монгол улсын~~ Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ ~~дагуу Улсын Их цааз, бусад~~ хуульд нийцүүлэн зарлиг гаргана. | 1. Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ **хүрээнд** хуульд нийцүүлэн зарлиг гаргана. | 1. Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд хуульд нийцүүлэн зарлиг гаргана. | 1. Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд хуульд нийцүүлэн зарлиг гаргана. |
| | | 2. Ерөнхийлөгчийн зарлиг хуульд нийцээгүй бол Ерөнхийлөгч өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно. | 2. Ерөнхийлөгчийн зарлиг хуульд нийцээгүй бол Ерөнхийлөгч өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно. | 2. Ерөнхийлөгчийн зарлиг хуульд нийцээгүй бол Ерөнхийлөгч өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно. |
| <u>Түүнийг</u> Монгол улс даяар дагаж мөрдөнө. | 2. <u>Ерөнхийлөгчийн зарлигийг</u> Монгол улс даяар дагаж мөрдөнө. | | | |
| **36 дугаар зүйл** | **ГУЧИН ЁСДҮГЭЭР ЗҮЙЛ** | **Гучин тавдугаар зүйл** | **Гучин тавдугаар зүйл** | **Гучин тавдугаар зүйл** |
| Монгол улсын Ерөнхийлөгч | 1. ~~Монгол улсын~~ Ерөнхийлөгч | 1. Ерөнхийлөгч Улсын Их | 1. Ерөнхийлөгч Улсын Их | 1. Ерөнхийлөгч Улсын Их |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Улсын Их хуралд ажлаа хариуцан тайлагнана. | Улсын Их хуралд ажлаа хариуцан тайлагнана. | Хуралд ажлаа хариуцан тайлагнана. | Хуралд ажлаа хариуцан ~~тайлагнана~~. | Хуралд ажлаа хариуцна. |
| Ерөнхийлөгч өргөсөн тангарагаасаа няцаж Улсын Их цааз, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Улсын Их цаазын цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурал шүүн хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар түүнийг огцруулж болно. | 2. Ерөнхийлөгч өргөсөн тангарагаасаа няцаж Улсын Их цааз, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Улсын Их цаазын цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурал ~~шүүн~~ хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний ~~гуравны хоёроос доошгүйн~~ саналаар түүнийг огцруулж болно. | 2. Ерөнхийлөгч ~~өргөсөн~~ тангарагаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн шүүхийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурал хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний **дийлэнх олонхийн** саналаар ~~түүнийг~~ огцруулж ~~болно~~. | 2. Ерөнхийлөгч тангарагаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна. | 2. Ерөнхийлөгч тангарагаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна. |
| Ерөнхийлөгч гэмт хэрэг үйлдсэний улмаас огцорвол хэргийг зөвхөн Улсын Дээд шүүхэд шилжүүлнэ. | 3. Ерөнхийлөгч гэмт хэрэг үйлдсэний улмаас огцорвол хэргийг зөвхөн Улсын Дээд шүүхэд шилжүүлнэ. | | | |
| **37 дугаар зүйл** | **ДӨЧДҮГЭЭР ЗҮЙЛ** | **Гучин зургадугаар зүйл** | **Гучин зургадугаар зүйл** | **Гучин зургадугаар зүйл** |
| Монгол улсын Ерөнхийлөгчийн бие, нэр төр, алдар хүнд, өргөө, унаа халдашгүй дархан байна. | 1. ~~Монгол улсын~~ Ерөнхийлөгчийн бие, нэр төр, алдар хүнд, өргөө, унаа халдашгүй дархан байна. | 1. Ерөнхийлөгчийн бие, өргөө, унаа халдашгүй дархан байна. | 1. Ерөнхийлөгчийн бие, өргөө, унаа халдашгүй дархан байна. | 1. Ерөнхийлөгчийн бие, өргөө, унаа халдашгүй дархан байна. |
| | | 2. Ерөнхийлөгчийн нэр төр, ~~алдар хүндийг~~ **хуулиар хамгаална**. | 2. Ерөнхийлөгчийн нэр төрийг хуулиар хамгаална. | 2. Ерөнхийлөгчийн нэр төр, |
| Хуульд зааснаас бусад тохиолдолд Ерөнхийлөгчийг эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, түүний бие, өргөө, албан тасалгаа, эд хөрөнгө, унаанд халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно. | 2. ~~Хуульд зааснаас бусад тохиолдолд~~ Ерөнхийлөгчийг эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, түүний бие, өргөө, албан тасалгаа, эд хөрөнгө, унаанд халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно. | 3. ~~**Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр**~~ Ерөнхийлөгчийг ~~эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, түүний бие, өргөө, албан тасалгаа, эд хөрөнгө, унаанд халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.~~ | 3. Ерөнхийлөгчийн халдашгүй байдлыг хуулиар тогтооно. | халдашгүй байдлыг хуулиар хамгаална. |
| **38 дугаар зүйл** | **ДӨЧИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ** | **Гучин долдугаар зүйл** | **Гучин долдугаар зүйл** | **Гучин долдугаар зүйл** |
| Монгол улсын Ерөнхийлөгчийг түр эзгүйд түүний бүрэн эрхийг Улсын Их Хурлын ~~Тэргүүн~~ дарга хэрэгжүүлнэ. | 1. ~~Монгол улсын~~ Ерөнхийлөгчийг түр эзгүйд түүний бүрэн эрхийг Улсын Их Хурлын дарга хэрэгжүүлнэ. | 1. Ерөнхийлөгчийг түр эзгүйд ~~түүний~~ бүрэн эрхийг Улсын Их Хурлын дарга ~~хэрэгжүүлнэ~~. | 1. Ерөнхийлөгчийг түр эзгүйд бүрэн эрхийг нь Улсын Их Хурлын дарга ~~эдэлнэ~~. | 1. Ерөнхийлөгчийг түр эзгүйд бүрэн эрхийг нь Улсын Их Хурлын дарга хэрэгжүүлнэ. |
| Ерөнхийлөгч таалал төгссөн, хүсэлтээрээ чөлөөлөгдсөн, огцорсон бол түүний бүрэн эрхийг Ерөнхийлөгч шинээр сонгогдож тангараг өргөтөл нь Улсын Их Хурлын ~~Тэргүүн~~ дарга эдэлнэ. Энэ тохиолдолд Улсын | 2. Ерөнхийлөгч таалал төгссөн, хүсэлтээрээ чөлөөлөгдсөн, огцорсон бол Ерөнхийлөгч шинээр сонгогдож тангараг өргөх хүртэл **хугацаанд түүний бүрэн эрхийг** Улсын Их Хурлын дарга эдэлнэ. Энэ тохиолдолд | 2. Ерөнхийлөгч таалал төгссөн, хүсэлтээрээ чөлөөлөгдсөн, огцорсон бол Ерөнхийлөгч шинээр сонгогдож тангараг өргөх хүртэл ~~хугацаанд түүний~~ бүрэн эрхийг Улсын Их Хурлын дарга эдэлнэ. Энэ тохиолдолд | 2. Ерөнхийлөгч хүсэлтээрээ чөлөөлөгдсөн, огцорсон, нас нөгчсөн бол Ерөнхийлөгч шинээр сонгогдож тангараг өргөх хүртэл бүрэн эрхийг **нь** Улсын Их Хурлын дарга эдэлнэ. Энэ тохиолдолд Улсын Их | 2. Ерөнхийлөгч огцорсон, нас нөгчсөн, хүсэлтээрээ чөлөөлөгдсөн бол Ерөнхийлөгч шинээр сонгогдож тангараг өргөх хүртэл бүрэн эрхийг нь Улсын Их Хурлын дарга хэрэгжүүлнэ. Энэ тохиолдолд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Их Хурал Ерөнхийлөгчийн сонгуулийг дөрвөн сарын дотор зарлан явуулна. | Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн сонгуулийг дөрвөн сарын дотор зарлан явуулна. | Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн сонгуулийг дөрвөн сарын дотор зарлан явуулна. | Хурал Ерөнхийлөгчийн сонгуулийг 4 сарын дотор зарлан явуулна. | Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн сонгуулийг дөрвөн сарын дотор зарлан явуулна. |
| | | 3. Улсын Их Хурлын дарга нь энэ зүйлийн 2-т заасан үндэслэлээр Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэх хугацаанд Улсын Их Хурлын гишүүний~~хээ~~ бүрэн эрхийг түдгэлзүүлэн ~~зогсооно~~. | 3. Улсын Их Хурлын дарга энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэх хугацаандаа Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхээсээ түдгэлзэнэ. | |
| | | | | 3. Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэх журмыг хуулиар тогтооно. |
| **III. ~~Гүйцэтгэх эрх мэдэл.~~ Монгол улсын Засгийн газар** | **ГУРАВ. Монгол улсын Засгийн газар** | **ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР** | **ГУРАВ. Монгол Улсын Засгийн газар** | **ГУРАВ. Монгол Улсын Засгийн газар** |
| **39 дүгээр зүйл** | **ДӨЧИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ** | **Гучин наймдугаар зүйл** | **Гучин наймдугаар зүйл** | **Гучин наймдугаар зүйл** |
| Монгол улсын төрийн гүйцэтгэх эрх мэдлийг Засгийн газар хадгалан хэрэгжүүлнэ. | 1. Монгол улсын төрийн гүйцэтгэх эрх мэдлийг Засгийн газар хадгалан хэрэгжүүлнэ. | | | |
| Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн. | 2. **Монгол улсын** Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн. | 1. Монгол улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн. | 1. Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн. | 1. Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн. |
| **40 дүгээр зүйл** | **ДӨЧИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ** | | | |
| Монгол улсын Засгийн газар нь Улсын Их цааз, бусад хуулийг биелүүлэх үндсэн дээр аж ахуй, нийгэм, соёлын байгуулалт, захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг удирдана. | 1. ~~Монгол улсын~~ Засгийн газар нь Улсын Их цааз, ~~бусад~~ хуулийг биелүүлэх үндсэн дээр аж ахуй, нийгэм, соёлын байгуулалт, ~~захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг~~ удирдана. | 2. Засгийн газар ~~нь~~ **төрийн** хуулийг биелүүл~~эх үндсэн дээр~~ аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах түгээмэл чиг үүргийн зэрэгцээ **дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:** | 2. Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн зэрэгцээ дараах **үндсэн** бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: | 2. Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараах үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: |
| | | 1/ Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улсын хэмжээнд зохион байгуулж хангах; | 1/ Их цааз, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах; | 1/ Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах; |
| | | 2/ Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд оруулах, ~~энэ талаар~~ гарсан шийдвэрийг биелүүлэх; | 2/ улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх; | 2/ шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх; |
| | | 3/ шинжлэх ухаан-техникийн нэгдсэн бодлого, улсын ~~хэмжээний~~ болон салбар хоорондын, түүнчлэн бүс | 3/ шинжлэх ухаан-техникийн нэгдсэн бодлого, улсын ~~хийгээд салбар хоорондын, түүнчлэн бүс нутгийн хөгжлийн асуудлаар~~ | |



UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | нутгийн хөгжлийн ~~чухал~~ асуудлаар ~~цогцолбор~~ арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх; | ~~арга хэмжээ~~ боловсруулж хэрэгжүүлэх; | |
| | | | | 3/ салбарын ба салбар хоорондын, түүнчлэн бүс нутгийн хөгжлийн асуудлаар арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх; |
| | | 4/ байгаль, орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах ~~цогцолбор~~ арга хэмжээ авах; | 4/ байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах арга хэмжээ авах; | 4/ хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах**, нөхөн сэргээх** арга хэмжээ авах; |
| | | 5/ яам, улсын хороо, тусгай газрын ~~үйл ажиллагааг~~ шуурхай удирдаж, нутгийн захиргааны байгууллагын үйлурхай удирдаж, нутгийн | 5/ яам, улсын хороо, тусгай газрыг шуурхай удирдаж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг **удирдан** чиглүүлэх; | 5/ төрийн захиргааны төв байгууллагыг шуурхай удирдаж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх; |
| | | 6/ улсыг батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах ~~арга хэмжээ авах~~; | 6/ улсыг батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах; | 6/ улсыг батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах; |
| | | 7/ хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, түүнийг зөрчих явдалтай тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх; | 7/ хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, ~~түүнийг зөрчихтэй~~ тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх; | 7/ хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, **гэмт хэрэгтэй** тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх; |
| | | 8/ төрийн гадаад бодлого хэрэгжүүлэх ~~арга хэмжээ авах~~; | 8/ төрийн гадаад бодлого хэрэгжүүлэх; | 8/ төрийн гадаад бодлого хэрэгжүүлэх; |
| | | 9/ Улсын Их Хурал~~д~~ дараа соёрхон батлуулахаар Монгол улсын олон улсын гэрээ байгуулах, ~~түүнийг~~ хэрэгжүүлэх, түүнчлэн Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, цуцлах. | 9/ Улсын Их Хурал**тай зөвшилцөж** дараа соёрхон батлуулахаар Монгол улсын олон улсын гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, түүнчлэн Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, цуцлах. | 9/ Улсын Их Хуралтай зөвшилцөж дараа соёрхон батлуулахаар Монгол Улсын олон улсын гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, түүнчлэн Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, цуцлах. |
| Улс орны амьдралын салбараар Засгийн газрын эдлэх бүрэн эрх, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. | 2. ~~Улс орны амьдралын салбараар~~ Засгийн газрын ~~эдлэх~~ бүрэн эрх, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. | 3. Засгийн газрын **тодорхой** бүрэн эрх, **зохион байгуулалт**, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. | 3. Засгийн газрын тодорхой бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. | 3. Засгийн газрын тодорхой бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. |
| **41 дүгээр зүйл** | **ДӨЧИН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ** | **Гучин есдүгээр зүйл** | **Гучин есдүгээр зүйл** | **Гучин есдүгээр зүйл** |
| Монгол улсын Засгийн газар нь Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. | 1. ~~Монгол улсын~~ Засгийн газар нь Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. | 1. Засгийн газар нь ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. | 1. Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. | 1. Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тоог Улсын Их хурал тогтооно. | | | | |
| **42 дугаар зүйл** | | | | |
| Монгол улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их хуралд өргөн мэдүүлнэ. | 2. Монгол улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их хуралд өргөн мэдүүлнэ. | 2. Монгол улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай **болон түүнд өөрчлөлт оруулах** саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. | 2. Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. | 2. Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. |
| Ерөнхий сайдын өргөн мэдүүлсэн нэр дэвшигчдийг Улсын Их Хурал хүн бүрээр хэлэлцэж чуулганд оролцсон гишүүний олонхийн санал авсан хүнийг Засгийн газрын гишүүнээр томилогдсонд тооцно. | 3. Ерөнхий сайдын өргөн мэдүүлсэн нэр дэвшигчдийг Улсын Их Хурал хүн бүрээр хэлэлцэж чуулганд оролцсон гишүүний олонхийн санал авсан хүнийг Засгийн газрын гишүүнээр томилогдсонд тооцно. | 3. Засгийн газрын гишүүнийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хүн бүрээр хэлэлцэж чуулганд оролцсон гишүүний олонхийн саналаар томилно. | 3. Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хүн бүрээр хэлэлцэж ~~чуулганд оролцсон гишүүний олонхийн саналаар~~ томилно. | 3. Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хүн бүрээр хэлэлцэж томилно. |
| **43 дугаар зүйл** | **ДӨЧИН ТАВДУГААР ЗҮЙЛ** | **Дөчдүгээр зүйл** | **Дөчдүгээр зүйл** | **Дөчдүгээр зүйл** |
| 1. Монгол улсын Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байх бөгөөд | 1. ~~Монгол улсын~~ Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа 4 жил байх ~~бөгөөд~~ | 1. Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа 4 жил байна. | 1. Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа 6 жил байна. ~~**Улсын Их Хурлын гишүүдийг шинэчилэн сонгож сэлбэсний дараа Засгийн газарт итгэх эсэхийг тухай бүр хэлэлцэж шийдвэрлэнэ.**~~ | 1. Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа 4 жил байна. |
| Ерөнхий сайд Улсын Их хуралд тангараг өргөсөн өдрөөс эхэлж, шинэ Ерөнхий сайд тангараг өргөснөөр дуусгавар болно. | Ерөнхий сайд Улсын Их хуралд тангараг өргөсөн өдрөөс эхэлж, шинэ Ерөнхий сайд тангараг өргөснөөр дуусгавар болно. | 2. **Засгийн газрын бүрэн эрх** Ерөнхий сайд Улсын Их Хуралд тангараг өргөсөн өдрөөс эхэлж, шинэ Ерөнхий сайд тангараг өргөснөөр дуусгавар болно. | 2. Засгийн газрын бүрэн эрх Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилсноор эхэлж, шинэ Ерөнхий сайдыг томилсноор дуусгавар болно. | 2. Засгийн газрын бүрэн эрх Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилсноор эхэлж, шинэ Ерөнхий сайдыг томилсноор дуусгавар болно. |
| **44 дүгээр зүйл** | **ДӨЧИН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ** | **Дөчин нэгдүгээр зүйл** | **Дөчин нэгдүгээр зүйл** | **Дөчин нэгдүгээр зүйл** |
| Монгол улсын Ерөнхий сайд Засгийн газрын ~~бодлого,~~ үйл ажиллагаар удирдах бөгөөд түүний үйл ажиллагааны хөтөлбөрийг Улсын Их Хуралд оруулан батлуулж, үр дүнг нь хариуцна. | 1. ~~Монгол улсын~~ Ерөнхий сайд Засгийн газрын үйл ажиллагааг удирдах бөгөөд ~~түүний үйл ажиллагааны хөтөлбөрийг Улсын Их Хуралд оруулан батлуулж, үр дүнг нь~~ хариуцна. | 1. Ерөнхий сайд Засгийн газрын ~~үйл ажиллагааг~~ удирдах бөгөөд **төрийн хуулийг биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө** хариуцна. | 1. Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцан ~~**тайлагнана**~~. | 1. Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна. |
| Засгийн газар үйл ажиллагааныхаа талаар Улсын Их Хурлын өмнө хамтын хариуцлага хүлээнэ. | 2. Засгийн газар үйл ажиллагааны~~хаа талаар~~ Улсын Их Хурлын ~~өмнө хамтын хариуцлага хүлээнэ~~. | 2. Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд хариуцна. | 2. Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд хариуцна. | 2. Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана. |
| ~~Харин~~ Засгийн газрын гишүүн | 3. Засгийн газрын гишүүн бүр | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| бүр үйл ажиллагаагаа Ерөнхий сайдын өмнө хариуцна. | үйл ажиллагаагаа Ерөнхий сайдын өмнө хариуцна. | | | |
| Засгийн газар Ерөнхийлөгчийн шийдвэрийг хэрэгжүүлэх талаар явуулсан үйл ажиллагааныхаа тухай Ерөнхийлөгчид тайлагнаж байна. | 4. Засгийн газар Ерөнхийлөгчийн шийдвэрийг хэрэгжүүлэх талаар явуулсан үйл ажиллагааныхаа тухай Ерөнхийлөгчид тайлагнаж байна | 3. Засгийн газар Ерөнхийлөгчийн шийдвэрийг хэрэгжүүлэх талаар явуулсан үйл ажиллагааныхаа тухай Ерөнхийлөгчид тайлагнаж байна. | | |
| **45 дугаар зүйл** | **ДӨЧИН ДОЛДУГААР ЗҮЙЛ** | **Дөчин хоёрдугаар зүйл** | **Дөчин хоёрдугаар зүйл** | **Дөчин хоёрдугаар зүйл** |
| | | 1. Ерөнхий сайдын халдашгүй байдлыг хуулиар хамгаална. | Ерөнхий сайд, **Засгийн газрын гишүүний** халдашгүй байдлыг хуулиар хамгаална. | Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална. |
| Монгол Улсын Ерөнхий сайдыг Улсын Их хурлын зөвшөөрөлгүйгээр, Засгийн газрын гишүүнийг Ерөнхий сайдын зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах, цагдан хорих, шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулахыг хориглоно. ~~Энэ нь шүүхийн хариуцлага хүлээлгэх бүрэн эрхийг хөндөхгүй.~~ | ~~Монгол Улсын~~ Ерөнхий сайдыг Улсын Их хурлын зөвшөөрөлгүйгээр, Засгийн газрын гишүүнийг Ерөнхий сайдын зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах, цагдан хорих, шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулахыг хориглоно | 2. Ерөнхий сайдыг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр, Засгийн газрын гишүүнийг Ерөнхий сайдын зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах **/хэргийн газар дээр баривчилсан, саатуулснаас бусад тохиолдолд/, албан үүрэгтэй нь холбогдуулан** баривчлах, албадан саатуулах, цагдан хорих, **нэгжих,** шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулахыг хориглоно. | | |
| **46 дугаар зүйл** | **ДӨЧИН НАЙМДУГААР ЗҮЙЛ** | **Дөчин гуравдугаар зүйл** | **Дөчин гуравдугаар зүйл** | **Дөчин гуравдугаар зүйл** |
| Монгол улсын Ерөнхий сайд нь Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл хугацаа дуусахаас өмнө огцрох тухайгаа Улсын Их хуралд өргөн мэдүүлж болно. | 1. ~~Монгол улсын~~ Ерөнхий сайд нь Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл хугацаа дуусахаас өмнө огцрох тухайгаа Улсын Их хуралд өргөн мэдүүлж болно | 1. Ерөнхий сайд нь Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл хугацаа дуусахаас өмнө огцрох тухайгаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. | 1. Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл хугацаа дуусахаас өмнө огцрох тухайгаа Ерөнхий сайд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. | 1. Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл хугацаа дуусахаас өмнө огцрох тухайгаа Ерөнхий сайд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. |
| Ерөнхий сайд, түүнчлэн Засгийн газрын гишүүдийн гуравны нэг нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно. | 2. Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн гуравны нэг нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно | 2. Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно. | 2. Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно. | 2. Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно. |
| **47 дугаар зүйл** | **ДӨЧИН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ** | **Дөчин дөрөвдүгээр зүйл** | | |
| Монгол Улсын Их Хурал нь Засгийн газрыг огцруулах тухай Ерөнхийлөгчийн санал, Ерөнхий сайдын мэдэгдлийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор Засгийн газрыг огцруулах эсэх тухай асуудлыг хэлэлцэн | 1. Монгол Улсын Их Хурал нь Засгийн газрыг огцруулах тухай Ерөнхийлөгчийн санал, Ерөнхий сайдын мэдэгдлийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор Засгийн газрыг огцруулах эсэх тухай асуудлыг хэлэлцэн | 1. Улсын Их Хурал нь Засгийн газрыг огцруулах тухай **өөрийн санаачилга болон** Ерөнхийлөгчийн санал, Ерөнхий сайдын мэдэгдлийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор Засгийн газрыг огцруулах | 3. Улсын Их Хурал Засгийн газрыг огцруулах тухай өөрөө санаачилсан болон Ерөнхийлөгчийн санал, Ерөнхий сайдын мэдэгдлийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор Засгийн газрыг огцруулах | 3. Улсын Их Хурал Засгийн газрыг огцруулах тухай өөрөө санаачилсан болон Ерөнхийлөгчийн санал, Ерөнхий сайдын мэдэгдлийг хүлээн авснаас хойш арван тав хоногийн дотор Засгийн газрыг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар шийдвэрлэнэ. | чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар шийдвэрлэнэ | эсэх тухай асуудлыг хэлэлцэн чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ. | эсэхийг хэлэлцэн ~~чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар~~ шийдвэрлэнэ. | огцруулах эсэхийг хэлэлцэн шийдвэрлэнэ. |
| | | | **Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрыг огцруулах тухай санал гаргавал Улсын Их Хурал ~~санаачилгаараа~~ хэлэлцэж ~~болно~~.** | 4. Улсын Их Хурлын гишүүдийн **дөрөвний нэгээс доошгүй нь** Засгийн газрыг огцруулах тухай саналыг **албан ёсоор тавьбал** Улсын Их Хурал хэлэлцэн **шийдвэрлэнэ**. |
| | | | **Дөчин дөрөвдүгээр зүйл** | **Дөчин дөрөвдүгээр зүйл** |
| ~~Хэрэв~~ Засгийн газар итгэл хүлээж байгаа эсэхээ илэрхийлж өгөхийг Улсын Их Хурлаас хүссэн бол Улсын Их хурал энэ тухай шийдвэрийг дээр заасан журмаар гаргана. | 2. Засгийн газар итгэл хүлээж байгаа эсэхээ илэрхийлж өгөхийг Улсын Их Хурлаас хүссэн бол Улсын Их хурал энэ тухай шийдвэрийг дээр заасан журмаар гаргана. | 2. Засгийн газар итгэл хүлээж байгаа эсэхээ илэрхийлж өгөхийг хүссэн тогтоолын төслийг Улсын Их Хуралд оруулсан бол Улсын Их Хурал уул асуудлыг энэ зүйлийн I дэх хэсэгт заасан журмаар шийдвэрлэнэ. | ~~Улсын Их Хурал~~ өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг хүсч Засгийн газар тогтоолын төсөл оруулбал Улсын Их Хурал уул асуудлыг 43 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмаар шийдвэрлэнэ. | Өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг хүсч Засгийн газар тогтоолын төсөл оруулбал Улсын Их Хурал уул асуудлыг дөчин гуравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмаар шийдвэрлэнэ. |
| **48 дугаар зүйл** | **ТАВЬДУГААР ЗҮЙЛ.** | **Дөчин тавдугаар зүйл** | **Дөчин тавдугаар зүйл** | **Дөчин тавдугаар зүйл** |
| Засгийн газар шийдвэрлэсэн асуудлаараа хууль тогтоомжид нийцүүлэн тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд тухайн асуудал эрхэлсэн сайд болон Ерөнхий сайд гарын үсэг зурна. | 1. Засгийн газар ~~шийдвэрлэсэн асуудлаараа~~ хууль тогтоомжид нийцүүлэн тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд болон тухайн асуудал эрхэлсэн сайд гарын үсэг зурна. | 1. Засгийн газар **~~хуулиар олгосон~~ бүрэн эрхийнхээ дотор** хууль тогтоомж, **~~Ерөнхийлөгчийн зарлигт~~** нийцүүлэн тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд болон тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцвал зохих сайд гарын үсэг зурна. | 1. Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд болон тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна. | 1. Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна. |
| | 2. Засгийн газрын тогтоол, захирамж нь улсын хэмжээнд хүчин төгөлдөр байна. | | | |
| | | 2. Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль, тогтоомж, ~~Ерөнхийлөгчийн зарлигт~~ нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал, ~~мөн Ерөнхийлөгч~~ хүчингүй болгоно. | 2. Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно. | 2. Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно. |
| **49 дүгээр зүйл** | **ТАВИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ** | **Дөчин зургадугаар зүйл** | **Дөчин зургадугаар зүйл** | **Дөчин зургадугаар зүйл** |
| Монгол Улсын яам, төрийн бусад албан газар нь хууль болон дүрмийнхээ дагуу зохион байгуулагдана. | 1. Монгол Улсын яам, төрийн бусад албан газар нь хууль болон дүрмийнхээ дагуу зохион байгуулагдана | 1. Монгол улсын яам, төрийн бусад албан газар нь хууль ~~болон дүрмийнхээ~~ дагуу байгуулагдана. | 1. Монгол Улсын яам, төрийн бусад албан газрыг хуулийн дагуу байгуулна. | 1. Монгол Улсын яам, төрийн бусад албан газрыг хуулийн дагуу байгуулна. |
| Төрийн албан газрын дүрэмд | 2. Төрийн албан газрын дүрэмд | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| түүний чиг үүрэг, эрх хэмжээ, удирдах албан тушаалтны хариуцлагыг тодорхойлсон байвал зохино. | түүний чиг үүрэг, эрх хэмжээ, удирдах албан тушаалтны хариуцлагыг тодорхойлсон байвал зохино. | | | |
| Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч нь Монгол Улсын харьяат иргэн байх бөгөөд Улсын Их цааз, бусад хуулийг чанд баримтлан ард түмнийхээ тусын тулд, иргэний байр суурьнаас төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана. | 3. Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч нь Монгол Улсын харъяат иргэн байх бөгөөд Улсын Их цааз, бусад хуулийг чанд баримтлан ард түмнийхээ тусын тулд, иргэний байр сууриас төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана. | 2. Монгол улсын төрийн жинхэнэ албан хаагч ~~нь~~ Монгол улсын ~~харьяат~~ иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чанд баримтлан ард түмнийхээ тусын тулд, иргэний байр сууриас төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана. | 2. Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд Их цааз, бусад хуулийг чанд баримтлан ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана. | 2. Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана. |
| | | 3. Зэвсэгт хүчин, улсын аюулгүй байдлыг хангах болон цагдаагийн байгууллагын ажилтан зэрэг төрийн зарим ~~төрлийн~~ албан хаагч намын гишүүн байх ~~явдл~~ыг хуулиар хязгаарлаж болно. | 3. Зэвсэгт хүчин, улсын аюулгүй байдлыг хангах болон цагдаагийн байгууллагын ажилтан зэрэг төрийн зарим албан хаагч намын гишүүн байхыг хуулиар хязгаарлаж болно. | |
| Шүүгч, цэргийн жинхэнэ албанд байгаа мэргэшсэн албан хаагч, цагдаагийн болон дипломат ажилтан зэрэг төрийн зарим төрлийн албан хаагч намын гишүүн байх явдлыг хуулиар хязгаарлаж болно. | 4. Шүүгч, цэргийн жинхэнэ албанд байгаа мэргэшсэн албан хаагч, цагдаагийн болон дипломат ажилтан зэрэг төрийн зарим төрлийн албан хаагч намын гишүүн байх явдлыг хуулиар хязгаарлаж болно. | | | |
| Төрийн албан газрын /эрдэм шинжилгээний болон гүйцэтгэх, туслах зэрэг хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаас бусад/ албан тушаалд алба хашигчдыг мэргэшил дадлагын талаар шалгаруулах журмаар хугацаагүй авч ажиллуулах бөгөөд уул албан тушаалд авах, үргэлжлэн ажиллах нөхцөл, баталгаар ~~Төрийн албан хаагчийн тухай~~ хуулиар тогтооно. | 5. Төрийн албан газрын албан тушаалд /эрдэм шинжилгээний болон гүйцэтгэх, туслах зэрэг хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаас бусад/ алба хашигчдыг мэргэшил дадлагын талаар шалгаруулах журмаар хугацаагүй авч ажиллуулах бөгөөд уул албан тушаалд авах, үргэлжлэн ажиллах нөхцөл, баталгаар хуулиар тогтооно. | 4. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно. | 4. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно. | 3. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно. |
| **IV. Шүүх эрх мэдэл** | **ДӨРӨВ. Шүүх эрх мэдэл** | **ДӨРӨВ.ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ /ЗАСАГ/** | **ДӨРӨВ. Шүүх эрх мэдэл** | **ДӨРӨВ. Шүүх эрх мэдэл** |
| **50 дугаар зүйл** | **ТАВИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ** | **Дөчин долдугаар зүйл** | **Дөчин долдугаар зүйл** | **Дөчин долдугаар зүйл** |
| Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ. | 1. Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх~~, Их цаазын холбогдолтой~~ | 1. Монгол улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ. | 1. Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ. | 1. Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | ~~маргааныг хянан шийдвэрлэх эрхийг Их цаазын цэц тус тус~~ хэрэгжүүлнэ. | | | |
| Шүүхийг зөвхөн хуулийн дагуу байгуулна. | ***Хуулийн төслийн 54-р зүйлийн 1 дэх хэсэгт тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 47-р зүйлийн 3 дахь хэсэгт тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 47-р зүйлийн 3 дахь хэсэгт тусгагдсан байна.*** | ***Үндсэн хуулийн төслийн 47-р зүйлийн 3 дахь хэсэгт тусгагдсан байна.*** |
| Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах хийгээд шүүх эрх мэдлийг шүүхээс өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно. | 2. Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах хийгээд шүүх эрх мэдлийг шүүхээс өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно. | 2. ~~Ямар ч нөхцөлд~~ хуулиас гадуур шүүх байгуулах хийгээд шүүх эрх мэдлийг шүүхээс өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно. | 2. Хуулиас гадуур шүүх байгуулах хийгээд шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно. | 2. Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно. |
| ***Хуулийн төслийн 50-р зүйлийн 2 дахь өгүүлбэрт тусгагдсан байна:***<br><br>Шүүхийг зөвхөн хуулийн дагуу байгуулна | ***Хуулийн төслийн 54-р зүйлийн 1 дэх хэсэгт тусгагдсан байна:***<br><br>Шүүхийг зөвхөн хуулийн дагуу байгуулна | 3. Шүүхийг зөвхөн **Үндсэн хууль, бусад** хуулийн дагуу байгуулна. | 3. Шүүхийг зөвхөн Их цааз, бусад хуулийн дагуу байгуулна. | 3. Шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулна. |
| **51 дүгээр зүйл** | **ТАВИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ** | **Дөчин наймдугаар зүйл** | **Дөчин наймдугаар зүйл** | **Дөчин наймдугаар зүйл** |
| Монгол улсын Шүүхийн тогтолцоо нь Улсын Дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, хошууны шүүхээс бүрдэнэ.<br><br>***Хуулийн төслийн 51-р зүйлийн 3 дахь өгүүлбэрт тусгагдсан байна:***<br><br>~~Түүнчлэн~~ шүүхийг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. | 1. ~~Монгол улсын~~ Шүүхийн **үндсэн** тогтолцоо нь Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, хошууны шүүхээс бүрдэх **бөгөөд**<br><br>шүүхийг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. | 1. Шүүхийн үндсэн тогтолцоо нь **Монгол улсын Үндсэн хуулийн шүүх**, ~~Монгол улсын~~ Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, хошуу, хорооны шүүхээс бүрдэх бөгөөд ~~шүүхийг~~ **эрүү, иргэн, захиргааны зэрэг** шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. **~~Ийнхүү~~ дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж болохгүй.** | 1. Шүүхийн үндсэн тогтолцоо ~~Их цаазын цэц~~, Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, хошуу, хорооны шүүхээс бүрдэх бөгөөд<br><br>эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж болохгүй. | 1. Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд<br><br>эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно. |
| Шүүхийн анхан шатны байгууллагыг аймаг, нийслэлд бүс нутгаар зохион байгуулж болно. | 2. Шүүхийн анхан шатны байгууллагыг аймаг, нийслэлд бүс нутгаар зохион байгуулж болно. | 2. Орон нутаг дахь шүүхийг бүс нутгаар зохион байгуулж болно. | 2. Орон нутаг дахь шүүхийг бүсчилэн байгуулж болно. | |
| ~~Түүнчлэн~~ шүүхийг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. | ***Хуулийн төслийн 53-р зүйлийн 1 дэх хэсэгт тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 48-р зүйлийн 1 дэх хэсэгт тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 48-р зүйлийн 1 дэх хэсэгт тусгагдсан байна.*** | ***Үндсэн хуулийн 48-р зүйлийн 1 дэх хэсэгт тусгагдсан байна.*** |
| | **ТАВИН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ** | | | |
| ***Хуулийн төслийн 50-р зүйлийн 2 дахь өгүүлбэрт тусгагдсан байна.*** | 1. Шүүхийг зөвхөн хуулийн дагуу байгуулна. | ***Хуулийн төслийн 47-р зүйлийн 3 дахь хэсэгт тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 47-р зүйлийн 3 дахь хэсэгт тусгагдсан байна.*** | ***Үндсэн хуулийн 47-р зүйлийн 3 дахь хэсэгт тусгагдсан байна.*** |
| ~~Шүүхийн тогтолцоо,~~ шүүхүүдийн | 2. Шүүхүүдийн зохион | 3. Шүүхүүдийн зохион | 3. Шүүхийн зохион байгуулалт, | 2. Шүүхийн зохион байгуулалт, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтоож ~~зохицуулна.~~ | байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. | байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. | үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. | үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. |
| | | 4. Шүүхүүд улсын төсвөөс санхүүжнэ. Шүүхийн төсвийн хэмжээг өмнөх төсвийн жилийнхээс нь бууруулж болохгүй. | 4. Шүүх улсын төсвөөс санхүүжинэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана. | 3. Шүүх улсын төсвөөс санхүүжинэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана. |
| **52 дугаар зүйл** | **ТАВИН ТАВДУГААР ЗҮЙЛ** | **Дөчин есдүгээр зүйл** | **Дөчин есдүгээр зүйл** | **Дөчин есдүгээр зүйл** |
| Шүүгч хараат биш байж, гагцхүү хуульд захирагдана. | 1. Шүүгч хараат биш байж, гагцхүү хуульд захирагдана. | 1. Шүүгч хараат биш байж, гагцхүү хуульд захирагдана. | 1. Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана. | 1. Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана. |
| | | 2. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн байгууллагын ямар ч албан тушаалтан, бусад хүн хэн боловч шүүгчдээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэх ~~үйл ажиллагаанд~~ хөндлөнгөөс оролцож болохгүй. | 2. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй. | 2. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй. |
| ~~Шүүгчдийн хараат биш байх баталгаа бол Улсын Ерөнхийлөгч мөн.~~<br>Шүүгчдийн хараат биш, бие даасан байдлыг ~~хамгаалан~~ хангах зорилгоор ~~Ерөнхийлөгчийн дэргэд~~ Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана. | 2. Шүүгчдийн хараат биш, бие даасан байдлыг хангах~~, **хууль хамгаалах байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах**~~ зорилгоор Шүүхийн Ерөнхий зөвлөл ажиллана. | 3. Шүүгчдийн хараат биш байдал, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана. | 3. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана. | 3. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана. |
| | | 4. Шүүхийн ерөнхий зөвлөл ~~нь~~ шүүх, шүүгчдийн шүүн таслах үйл ажиллагаанд оролцож болохгүй бөгөөд гагцхүү шүүгчдийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах, шүүхийн бие даан ажиллах ~~хөрөнгө, санхүүгийн болон~~ шаардлагатай бусад нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ. | 4. Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах **зэрэг** шүүх бие даан ажиллах ~~шаардлагатай **бүх**~~ нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ. | 4. Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ. |
| Шүүхийн ерөнхий зөвлөлийг Улсын Ерөнхийлөгч тэргүүлнэ. | 3. Шүүхийн ерөнхий зөвлөлийг Их цаазын цэцийн Ерөнхий цэц тэргүүлнэ. | | | |
| | | 5. Шүүхийн Ерөнхий зөвлөл нь Үндсэн хуулийн шүүхийн ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | ерөнхий прокурор, Улсын Их Хурлын хууль зүйн асуудал эрхэлсэн хорооны нэг гишүүн, Хууль зүйн сайд, Сангийн сайд, Ерөнхийлөгчийн хуулийн зөвлөх, хуульчдын байгууллагаас нэр дэвшүүлж илгээсэн хоёр шүүгч, хоёр хуульчаас бүрэлдэнэ. Ерөнхий зөвлөлийн дарга нь Үндсэн хуулийн шүүхийн ерөнхий шүүгч, орлогч дарга нь Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч буюу Улсын ерөнхий прокурор байна. Бүрэлдэхүүнийг Ерөнхийлөгч батална. | | |
| Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх, үүргийг хуулиар тогтооно. | 4. Шүүхийн ерөнхий зөвлөлийн <u>эрх, үүргийг</u> хуулиар тогтооно | 6. Шүүхийн ерөнхий зөвлөлийн <u>зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг</u> ~~**Үндсэн хуульд нийцүүлэн**~~ хуулиар тогтооно. | 5. Шүүхийн ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. | 5. Шүүхийн ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. |
| | | | **2. Монгол улсын Дээд шүүх** | |
| | | **Тавин дөрөвдүгээр зүйл** | **Тавин дөрөвдүгээр зүйл** | **Тавьдугаар зүйл** |
| | | 1. Улсын Дээд шүүх нь шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд <u>дор дурдсан</u> бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: | 1. **Монгол** Улсын дээд шүүх шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: | 1. Монгол Улсын дээд шүүх **бол** шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: |
| | | 1/ хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэг, иргэний маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх; | 1/ хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэг, иргэний маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх; | 1/ хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэг, эрх зүйн маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх; |
| | | 2/ доод шатны шүүхүүдийн шийдвэрийг давж заалдах болон хяналтын журмаар хянан шийдвэрлэх; | 2/ <u>доод шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах болон хяналтын журмаар хянан шийдвэрлэх</u>; | 2/ <u>давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх</u>; |
| | | 3/ хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар <u>Үндсэн хуулийн шүүх болон</u> Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх; | 3/ хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар <u>Их цаазын цэц,</u> Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх; | 3/ хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар <u>Үндсэн хуулийн</u> цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх; |
| | | 4/ хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх; | 4/ хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх | 5/ хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх. |
| | | 5/ <u>Үндсэн хуулиас</u> бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны | 5/ <u>Их цаазаас</u> бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны | 4/ <u>Үндсэн хуулиас</u> бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | тайлбар, удирдамж гаргах. | тайлбар~~, удирдамж~~ гаргах; | тайлбар гаргах; |
| | | 2. Улсын дээд шүүхийн шийдвэр ~~нь~~ шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын Дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ. | 2. Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ. | 2. Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв **Улсын** дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг **Улсын** дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ. |
| | | 3. Дээд шүүх болон бусад шүүх Үндсэн хуульд нийцээгүй хуулийг хэрэглэх эрхгүй. | 3. Дээд шүүх, бусад шүүх **нь** Их цаазад нийцээгүй **буюу нийтлээгүй** хуулийг хэрэглэх эрхгүй. | 3. **Улсын** дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, **албан ёсоор** нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй. |
| **53 дугаар зүйл** | **ТАВИН ЗУРГААДУГААР ЗҮЙЛ** | **Тавин тавдугаар зүйл** | **Тавин тавдугаар зүйл** | **Тавин нэгдүгээр зүйл** |
| Улсын дээд шүүх нь Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ. | 1. Улсын дээд шүүх нь Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ | 1. Улсын дээд шүүх ~~нь~~ Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ. | 1. Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ. | 1. Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ. |
| Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч болон шүүгчийг Улсын Их Хурал танилцуулан зөвшөөрөлцсөнөөр ~~Улсын~~ Ерөнхийлөгч хугацаагүй томилно. | 2. Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч болон шүүгчдийг Улсын Их Хурал танилцуулан зөвшөөрөлцсөнөөр Ерөнхийлөгч ~~12 жилийн хугацаагаар~~ томилно. | 2. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон шүүгчдийг **Шүүхийн ерөнхий зөвлөлөөс** Улсын Их Хуралд танилцуулан зөвшөөрөлцсөнөөр, **бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус** Ерөнхийлөгч томилно. | 2. Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн ~~ерөнхий шүүгч болон~~ шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулан зөвшөөрөлцсөнөөр, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. | 2. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. **Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно.** |
| | 3. Улсын Дээд шүүхийн шүүгчээр хууль зүйн дээд боловсролтой, шүүн таслах ажлын дадлага бүхий 30 нас хүрсэн, Монгол Улсын иргэнийг томилж болно. | 3. Улсын Дээд Шүүхийн шүүгчээр хууль зүйн дээд боловсролтой, **10-аас доошгүй жил** ~~шүүн таслах ажил эрхэлсэн~~, 35 нас хүрсэн, **бусад шүүхийн шүүгчээр хууль зүйн боловсролтой, 3-аас доошгүй жил** ~~хууль хамгаалах байгууллагад~~ **мэргэжлээрээ ажилласан, 25 нас хүрсэн,** Монгол улсын иргэнийг томилж болно. | 3. Хууль зүйн дээд боловсролтой, **мэргэжлээрээ** арваас доошгүй жил ажилласан, **Монгол Улсын** 35 нас хүрсэн ~~Монгол улсын~~ иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн **дээд** боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, 25 нас хүрсэн Монгол Улсын иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно. | 3. Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, Монгол Улсын 25 нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно. |
| | | 4. Үндсэн хууль ~~болон~~ шүүхийн | 4. Их цааз, шүүхийн тухай | 4. Үндсэн хууль, шүүхийн тухай |

UILMN СУДАЛГААНЫ САН

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | тухай хуульд заасан үндэслэлээр болон шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу Ерөнхийлөгч огцруулах, хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулах, өөрийн нь зөвшөөрөлгүйгээр өөр ажилд шилжүүлэх, тогтоосон цалинг нь бууруулахыг хориглоно. | хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу ~~Ерөнхийлөгч~~ огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулах, ~~өөрийн зөвшөөрөлгүйгээр өөр ажилд шилжүүлэх, тогтоосон цалинг бууруулахыг~~ хориглоно. | хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно. |
| Аймаг, нийслэл, хошууны болон нутгийн бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөр хянан хэлэлцэж шалгаруулан санал болгосноор Ерөнхийлөгч 10 жилийн хугацаагаар томилно. | 4. Аймаг, нийслэл, хошууны болон нутгийн бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөр хянан хэлэлцэж шалгаруулан санал болгосноор Ерөнхийлөгч 10 жилийн хугацаагаар томилно. | | | |
| Эдгээр шүүгчийн үйл ажиллагаа, мэргэжлийн түвшинг Шүүхийн ерөнхий зөвлөл 5 жилд нэг удаа хүн бүр дээр хэлэлцэж үргэлжлүүлэн ажиллах эсэх талаар дүгнэлт гаргана. | 5. **Улсын дээд шүүхийн шүүгчдээс бусад** шүүгчийн үйл ажиллагаа, мэргэжлийн түвшинг Шүүхийн ерөнхий зөвлөл 5 жилд нэг удаа хүн бүр дээр хэлэлцэж үргэлжлүүлэн ажиллах эсэх талаар дүгнэлт гаргана. | | | |
| **54 дүгээр зүйл** | **ТАВИН ДОЛДУГААР ЗҮЙЛ** | **Тавин зургадугаар зүйл** | **Тавин зургаадугаар зүйл** | **Тавин хоёрдугаар зүйл** |
| Бүх шатны шүүхэд хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ. | 1. Бүх шатны шүүхэд хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ. | 1. Бүх шатны шүүхэд хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ. | 1. Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ. | 1. Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ. |
| Хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхэд иргэдийн төлөөлөгчдийг таслах эрхтэйгээр оролцуулна. Тэдгээрийг хувийн зан байдал, боловсрол, мэргэжлээр нь шалгаруулан хуульд заасан журмаар баталсан нэрийн жагсаалт~~, ээлжийг баримтлан шүүхэд ажиллуулна.~~ | 2. **Шүүхэд** хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхэд **иргэдийн** Төлөөлөгчдийг тэдний хувийн зан байдал, боловсрол, мэргэжлээр нь шалгаруулан хуульд заасан журмаар баталсан нэрийн жагсаалт**ын дагуу** таслах эрхтэйгээр оролцуулна. | 2. **Анхан шатны** шүүхэд хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг ~~тэдний~~ хувийн зан байдал, боловсрол, мэргэжлээр нь шалгаруулан хуульд заасан журмаар баталсан нэрийн жагсаалтын дагуу таслах эрхтэйгээр оролцуулна. | 2. Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн Төлөөлөгчдийг ~~хувийн зан байдал, боловсрол, мэргэжлээр нь шалгаруулан~~ хуульд заасан журмаар ~~баталсан нэрийн жагсаалтын дагуу таслах эрхтэйгээр~~ оролцоно. | 2. Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна. |
| Хуульд тусгайлан зүйлчилж заасан зарим хэргийг шүүгч дангаар хянан шийдвэрлэж болно. | 3. Хуульд тусгайлан зүйлчилж заасан зарим хэргийг шүүгч дангаар хянан шийдвэрлэж болно. | 3. Хуульд тусгайлан зүйлчилж заасан зарим хэргийг шүүгч дангаар хянан шийдвэрлэж болно. | 3. Хуульд тусгайлан зүйлчилж заасан зарим хэргийг шүүгч дангаар хянан шийдвэрлэж болно. | 3. Хуульд тусгайлан зүйлчилж заасан зарим хэргийг шүүгч дангаар хянан шийдвэрлэж болно. |
| **55 дугаар зүйл** | **ТАВИН НАЙМДУГААР ЗҮЙЛ** | **Тавин долдугаар зүйл** | **Тавин долдугаар зүйл** | **Тавин гуравдугаар зүйл** |
| Шүүн таслах ажиллагааг монгол | 1. Шүүн таслах ажиллагааг | 1. Шүүн таслах ажиллагааг | 1. Шүүн таслах ажиллагааг | 1. Шүүн таслах ажиллагааг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| хэлээр явуулна. | монгол хэлээр явуулна. | монгол хэлээр явуулна. | монгол хэлээр явуулна. | монгол хэлээр явуулна. |
| Монгол хэл мэдэхгүй хүнд хэргийн баримт сэлтийг хэлмэрчлүүлэн бүрэн танилцуулах бөгөөд бас шүүн таслах хурал дээр эх хэлээр нь үг хэлэх эрх олгоно. | 2. Монгол хэл мэдэхгүй хүнд хэргийн баримт сэлтийг хэлмэрчлүүлэн бүрэн танилцуулах бөгөөд бас шүүн таслах хурал дээр эх хэлээр нь үг хэлэх эрх олгоно. | 2. Монгол хэл мэдэхгүй хүнд хэргийн баримт сэлтийг хэлмэрчлүүлэн бүрэн танилцуулах бөгөөд бас шүүн таслах хурал дээр эх хэлээр нь үг хэлэх эрх олгоно. | 2. Монгол хэл мэдэхгүй хүнд хэргийн баримт сэлтийг хэлмэрчлүүлэн бүрэн танилцуулах, шүүн таслах хурал дээр эх хэлээр нь үг хэлэх эрх олгоно. | 2. Монгол хэл мэдэхгүй хүнд хэргийн баримт сэлтийг хэлмэрчлүүлэн бүрэн танилцуулах бөгөөд шүүх хуралдаан дээр эх хэлээр нь үг хэлэх эрх олгоно. |
| **56 дугаар зүйл** | **ТАВИН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ** | **Тавин наймдугаар зүйл** | **Тавин наймдугаар зүйл** | **Тавин дөрөвдүгээр зүйл** |
| Шүүх хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хэргийг ил таслан шийдвэрлэнэ. | 1. Шүүх хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд ~~шүүх~~ хэргийг ил таслан шийдвэрлэнэ. | 1. Шүүх хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хэргийг ил таслан шийдвэрлэнэ. | Шүүх хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хэргийг ил таслан шийдвэрлэнэ. | Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүх хэргийг ил таслан шийдвэрлэнэ. |
| | | 2. Улсын аюулгүй байдалд хор хохирол учруулах, хуулиар хамгаалсан нууц задруулах, иргэдийн зан суртахуунд ноцтой харшлах зэрэг зарим хэргийг хаалттай таслахаар хуульд зааж болох боловч үндсэн хуулийн болон хүний салшгүй эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийг заавал нээлттэй тасална. | | |
| **57 дугаар зүйл** | **ЖАР ДУГААР ЗҮЙЛ** | **Тавин ес дүгээр зүйл** | **Тавин есдүгээр зүйл** | **Тавин тавдугаар зүйл** |
| Хэрэгтэн өөрийгөө өмгөөлөх эрхтэй бөгөөд<br>энэ эрхээ эдлэхэд нь хэрэгтэний хүсэлтээр буюу хуульд тусгайлан зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа заавал үзүүлнэ. | 1. Хэрэгтэн өөрийгөө өмгөөлөх эрхтэй ~~бөгөөд~~<br>энэ эрхээ эдлэхэд нь хэрэгтэний хүсэлтээр буюу хуульд тусгайлан зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ. | 1. Хэрэгтэн өөрийгөө өмгөөлөх эрхтэй.<br>2. Хэрэгтэнд энэ эрхээ эдлэхэд нь түүний хүсэлтээр буюу хуульд тусгайлан зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ. | 1. Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй.<br>2. Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд ~~нь түүний~~ хүсэлтээр буюу хуульд тусгайлан зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ. | 1. Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй.<br>2. Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр **нь** буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ. |
| **58 дугаар зүйл** | **ЖАРАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ** | **Жардугаар зүйл** | **Жардугаар зүйл** | **Тавин зургадугаар зүйл** |
| Хууль сахиулагч нь хэргийг мөрдөн байцаах, ял эдлүүлэх үйл ажиллагаанд болон нийгэм, иргэдийн эрх, ашиг сонирхлыг зөрчихөөс сэргийлэн хамгаалах зорилгоор хуулийг нэг мөр сахин биелүүлж байгаад төрийн хяналт тавина. | 1. Хууль сахиулагч нь ~~хэргийг мөрдөн байцаах, ял эдлүүлэх үйл ажиллагаанд болон~~ нийгэм, иргэдийн эрх, ашиг сонирхлыг зөрчихөөс сэргийлэн хамгаалах зорилгоор хуулийг нэг мөр сахин биелүүлж байгаад төрийн хяналт тавина. | 1. ~~**Монгол улсын**~~ прокурорын байгууллага нь нийгэм, иргэдийн эрх, **хууль ёсны** ашиг сонирхлыг зөрчихөөс сэргийлэн хамгаалах зорилгоор хуулийг нэг мөр хэрэглэж байгаад хяналт тавих төрийн байгууллага мөн. | | |
| Хууль сахиулагч нь шүүх хуралд төрийн өмнөөс яллах үүргийг гүйцэтгэнэ. | 2. Хууль сахиулагч нь шүүх хуралд төрийн өмнөөс яллах үүргийг гүйцэтгэнэ. | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 2. **Монгол улсын** прокурорын байгууллага хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралд оролцон төрийн нэрийн өмнөөс ялын шүүмжлэл явуулж дүгнэлт гаргана. | 1. Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно. | 1. Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно. |
| | | 3. Монгол улсын прокурорын байгууллага нь хяналтын үүргээ хэрэгжүүлэхдээ хууль ёсыг чанд сахих, хараат биш байх, зохион байгуулалтын хувьд нэгдмэл байх, зөвхөн дээд шатныхаа прокурорт захирагдах зарчмыг баримтална. | | |
| Улсын Ерөнхий хууль сахиулагчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн зөвшөөрснөөр Ерөнхийлөгч томилно. | 3. Улсын Ерөнхий хууль сахиулагчийг **Монгол улсын** Ерөнхийлөгч, Шүүхийн ерөнхий зөвлөлтэй зөвшилцсөнөөр **6 жилийн хугацаатайгаар** томилно. | 4. Прокурорын байгууллагыг Улсын Ерөнхий прокурор тэргүүлэх бөгөөд түүнийг Ерөнхийлөгчийн саналаар Улсын Их Хурал, Ерөнхий прокурорын орлогч нарыг түүний саналаар Ерөнхийлөгч, доод шатны прокурорыг Улсын Ерөнхий прокурор тус тус 6 жилийн хугацаагаар томилно. | 2. Улсын Ерөнхий прокурорыг Ерөнхийлөгчийн санал болгосноор Улсын Их Хурал, Ерөнхий прокурорын орлогч нарыг түүний саналаар Ерөнхийлөгч, ~~доод шатны прокурорыг Улсын Ерөнхий прокурор тус тус~~ 6 жилийн хугацаагаар томилно. | 2. Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч 6 жилийн хугацаагаар томилно. |
| Хууль сахиулах газрын зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим, журмыг хуулиар тогтооно. | 4. Хууль сахиулах газрын зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим, журмыг хуулиар тогтооно. | 5. Монгол улсын прокурорын **байгууллагын тогтолцоо**, ~~зохион байгуулалт~~, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. | 3. Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. | 3. Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо, **зохион байгуулалт**, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. |
| **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ** | **Дөрөвдүгээр бүлэг** | **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ** | **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ** | **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ** |
| **МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА** | **МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА** | **МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ ТҮҮНИЙ УДИРДЛАГА** | **МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА** | **МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА** |
| **59 дүгээр зүйл** | **ЖАРАН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ** | **Жаран нэгдүгээр зүйл** | **Жаран нэгдүгээр зүйл** | **Тавин долдугаар зүйл** |
| Монгол Улсын нутаг дэвсгэр нь засаг захиргааны талаар ~~Алтай хан, Баруун Алтай, Богд хан, Хан хөхий, Хан Хэнтий, Сэлэнгэ, Цэцэрлэг мандал~~ аймаг, нийслэлд; аймаг нь хошуудад, хошуу нь багт, нийслэл нь хороодод хуваагдана. | 1. Монгол Улсын нутаг дэвсгэр нь засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд; аймаг нь хошуудад, хошуу нь багт, нийслэл нь хороодод хуваагдана. | 1. Монгол улсын нутаг дэвсгэр ~~нь~~ засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь хошууда~~д~~, хошуу нь багт, нийслэл нь хороод~~од~~, хороод нь хоринд хуваагдана. | 1. Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь хошуунд, хошуу нь багт, нийслэл нь хороонд, хороод нь хоринд хуваагдана. | 1. Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана. |
| | | 2. Засаг захиргааны нэгжийн | 2. Засаг захиргааны нэгжийн | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | нутаг дэвсгэр дэх хот, тосгоны тухайн нэгжийн төв буюу эсвэл хүн амын төвлөрсөн суурин гэж тооцно. | нутаг дэвсгэр дэх хот, тосгоны тухайн нэгжийн төв буюу эсхүл хүн амын төвлөрсөн суурин гэж үзнэ. | |
| | | | | 2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. |
| | | | | 3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ. |
| **60 дугаар зүйл** | **ЖАРАН ДОЛДУГААР ЗҮЙЛ** | **Жаран хоёрдугаар зүйл** | **Жаран хоёрдугаар зүйл** | **Тавин наймдугаар зүйл** |
| Аймаг, нийслэл, хошуу, хороо бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, эдийн засаг, нийгмийн цогцолбор зохион байгуулалт мөн. | 1. Аймаг, нийслэл, хошуу, хороо бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага ~~бүхий~~ засаг захиргаа, эдийн засаг, нийгмийн цогцолбор зохион байгуулалт мөн. | 1. Аймаг, нийслэл, хошуу, хороо бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага, засаг захиргаа бүхий **нутаг дэвсгэр**-эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн. | 1. Аймаг, нийслэл, хошуу, хороо бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага, засаг захиргаа бүхий нутаг дэвсгэр-эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн. | 1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн. |
| Аймаг, нийслэл, хошуу, хороо бүр хилийн цэсээр тодорхойлсон нутаг дэвсгэр, бие даасан төсөв, өөрийн мэдлийн үйлдвэрийн газар, хүн амын ахуй, нийгэм, соёлын үйлчилгээний байгууллага, нэгжүүд, засаг захиргааны албан газруудтай байна. | 2. Аймаг, нийслэл, хошуу, хороо бүр хилийн цэсээр тодорхойлсон нутаг дэвсгэр, бие даасан төсөв, өөрийн мэдлийн үйлдвэрийн газар, хүн амын ахуй, нийгэм, соёлын үйлчилгээний байгууллага, нэгжүүд, засаг захиргааны албан газруудтай байна. | 2. Аймаг, нийслэл, хошуу, хороо бүр хилийн цэсээр тодорхойлсон нутаг дэвсгэр, бие даасан төсөв, өөрийн мэдлийн үйлдвэрийн газар, хүн амын ахуй, нийгэм, соёлын үйлчилгээний байгууллага, нэгжүүд, засаг захиргааны албан газруудтай байна. | | |
| Аймаг, нийслэл, хошууны хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал, хорооны хилийн цэсийг нийслэлийн Хурлын саналаар Засгийн газар, багийн хилийн цэсийг хошууны Хурлын саналаар аймгийн Хурал тус тус батална. | 3. Аймаг, нийслэл, хошууны хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал, ~~хорооны~~ хилийн цэсийг ~~нийслэлийн Хурлын саналаар Засгийн газар, багийн хилийн цэсийг хошууны Хурлын саналаар~~ аймгийн Хурал тус тус батална. | 3. Аймаг, нийслэл, хошуу, **хороо**ны хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал, **баг, хорины** хилийн цэсийг аймаг, **нийслэлийн** Хурал тус тус батална. | 2. Аймаг, нийслэл, хошуу, хорооны хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал, ~~баг, хорины хилийн цэсийг аймаг, нийслэлийн Хурал тус тус~~ батална. | 2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална. |
| **61 дүгээр зүйл** | **ЖАРАН НАЙМДУГААР ЗҮЙЛ** | **Жаран гуравдугаар зүйл** | **Жаран гуравдугаар зүйл** | **Тавин есдүгээр зүйл** |
| Монгол улсын засаг захиргаа-нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн | 1. Монгол улсын засаг захиргаа-нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн | 1. Монгол улсын засаг захиргаа-нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн | 1. Монгол Улсын засаг захиргаа-нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн | 1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| дээр зохион байгуулагдана. | дээр зохион байгуулагдана. | дээр зохион байгуулагдана. | дээр хэрэгжинэ. | дээр хэрэгжинэ. |
| | | 2. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, хошуу, хороонд тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хоринд ~~тэдгээрийн~~ иргэдийн Нийтийн хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид байна. **Эдгээрийг цаашид нутгийн өөрөө удирдах байгууллага гэнэ.** | 2. Нутгийн өөрөө удирдах байгууллага аймаг, нийслэл, хошуу, хороонд тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хоринд иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид ~~байна. Эдгээрийг цаашид нутгийн өөрөө удирдах байгууллага гэнэ.~~ | 2. Нутгийн өөрөө удирдах байгууллага **бол** аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид **мөн**. |
| ***Хуулийн төслийн 63-р зүйлийн 3 дахь өгүүлбэрт тусгагдсан байна:***<br><br>Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох, журмыг хуулиар тогтооно. | ***Хуулийн төслийн 70-р зүйлийн 2 дахь хэсэгт тусгагдсан байна:***<br><br>Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох, журмыг хуулиар тогтооно. | 3. Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно. | 3. Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно. | 3. **Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Эдгээр Хурлын болон сум, дүүргийн** Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно. |
| | | 4. Аймаг, нийслэл, хошуу, хороо, баг, хорины хурлын хуралдааны чөлөө цагт ~~тэдгээрийн~~ эрх, үүргийг тухайн хурлаас сонгосон тэргүүлэгчид хэрэгжүүлнэ. Тэргүүлэгчид нь аймаг, нийслэлд дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс, хошуу, хороо, баг хоринд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ. | 4. Аймаг, нийслэл, хошуу, хороо, баг, хорины Хурлын хуралдааны чөлөө цагт эрх, үүргийг **нь** тухайн Хурлаас сонгогдсон тэргүүлэгчид хэрэгжүүлнэ. Тэргүүлэгчид нь аймаг, нийслэлд дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс, хошуу, хороо, баг, хоринд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрэлдэнэ. | |
| **62 дугаар зүйл** | **ЖАРАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ** | | | |
| Аймаг, нийслэл, хошуу, хорооны өөрөө удирдах байгууллага нь тухайн аймаг, нийслэл, хошуу, хорооны Хурал байна. | 1. Аймаг, нийслэл, хошуу, хорооны өөрөө удирдах байгууллага нь тухайн аймаг, нийслэл, хошуу, хорооны Хурал байна. | | | |
| **63 дугаар зүйл** | **ДАЛ ДУГААР ЗҮЙЛ** | | | |
| Аймаг, нийслэл, хошуу, хорооны Хурал нь гишүүдээс бүрдэнэ. | 1. Аймаг, нийслэл, хошуу, хорооны Хурал нь төлөөлөгчдөөс бүрдэнэ. | | | |
| Хурлын гишүүнийг тухайн аймаг, нийслэл, хошуу, хорооны нутаг дэвсгэрт оршин суугаа сонгуулийн эрх бүхий иргэд нийтээр, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| гаргаж 4 жилийн хугацаагаар сонгоно. | | | | |
| Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох, журмыг хуулиар тогтооно. | 2. Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох, журмыг хуулиар тогтооно. | ***Хуулийн төслийн 63-р зүйлийн 3 дахь хэсэгт тусгагдсан байна.*** | ***Хуулийн төслийн 63-р зүйлийн 3 дахь хэсэгт тусгагдсан байна.*** | ***Үндсэн хуулийн 59-р зүйлийн 3 дахь хэсэгт тусгагдсан байна.*** |
| **64 дүгээр зүйл** | **ДАЛАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ** | **Жаран дөрөвдүгээр зүйл** | **Жаран дөрөвдүгээр зүйл** | **Жардугаар зүйл** |
| Нутаг дэвсгэрийн төрийн удирдлагын буюу гүйцэтгэх эрх мэдлийг тухайн аймаг, нийслэл, хошуу, хорооны Засаг дарга барьж хэрэгжүүлнэ. | 1. ~~Нутаг дэвсгэрийн төрийн удирдлагын буюу гүйцэтгэх эрх мэдлийг~~ тухайн аймаг, нийслэл, хошуу, хорооны Засаг дарга ~~барьж~~ хэрэгжүүлнэ. | 1. **Аймаг, нийслэл, хошуу, хороо, баг, хорины нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг** тухайн аймаг, нийслэл, хошуу, хороо, **баг, хорины** Засаг дарга хэрэгжүүлнэ. | 1. Аймаг, нийслэл, хошуу, хороо, баг, хорины нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, хошуу, хороо, баг, хорины Засаг дарга хэрэгжүүлнэ. | 1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ. |
| Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, хошуу, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, ~~олонхийн саналаар шалгаруулан улмаар~~ аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд, харин хошуу, хорооны Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус батална. | 2. Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, хошуу, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд, ~~харин~~ хошуу, хорооны Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга ~~тус тус~~ томилно. | 2. Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, хошуу, хороо, **баг, хорины** Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд, хошуу, хорооны Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга, **баг, хорины Засаг даргыг харьяалах хошуу, хорооны** Засаг дарга тус тус 4 жилийг хугацаагаар томилно. | 2. Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, хошуу, хороо, баг, хорины Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; хошуу, хорооны Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорины Засаг даргыг харьяалах хошуу, хорооны Засаг дарга тус тус 3 жилийн хугацаагаар томилно. | 2. Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно. |
| Засаг даргын бүрэн эрх ийнхүү батлагдсанаар эхлэх бөгөөд 4 жилийн хугацаатай байна. | 3. Засаг даргын бүрэн эрх томилогдсоноор эхлэх бөгөөд 4 жилийн хугацаатай байна. | | | |
| Харин Ерөнхий сайд буюу аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн нэгжийн Засаг дарга нь тухайн нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг ёсоор болгон батлахаас татгалзвал дээр заасан журмаар дахин нэр дэвшүүлж шалгаруулан батлана. Энэ хугацаанд аймаг, нийслэлийн Засаг даргын үүргийг Ерөнхий сайдын томилсон төлөөний сайд, хошуу, хорооны Засаг даргыг зохих аймаг, нийслэлийн Засаг даргын томилсон төлөөний түшмэл гүйцэтгэнэ. | 4. Ерөнхий сайд буюу ~~аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн~~ нэгжийн Засаг дарга нь тухайн нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг ёсоор болгон томилохоос татгалзвал дээр заасан журмаар дахин нэр дэвшүүлж томилох бөгөөд энэ хугацаанд ~~аймаг, нийслэлийн Засаг даргын үүргийг Ерөнхий сайдын томилсон төлөөний сайд, хошуу, хорооны Засаг даргыг зохих аймаг, нийслэлийн Засаг даргын томилсон төлөөний түшмэл гүйцэтгэнэ~~. | 3. Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн Засаг дарга ~~нь~~ тухай нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг ~~ёсоор болгон~~ томилохоос татгалзвал ~~дээр~~ заасан журмаар дахин нэр дэвшүүлж томилох ~~бөгөөд энэ хугацаанд~~ өмнө нь томилогдсон Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хэрэгжүүлнэ. | 3. Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн Засаг дарга ~~тухайн~~ нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлийн ~~2-т~~ заасан журмаар дахин нэр дэвшүүлж томилтол өмнөх Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална. | 3. Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн Засаг дарга доод шатныхаа нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар дахин нэр дэвшүүлж томилтол өмнөх Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална. |
| **65 дугаар зүйл** | **ДАЛАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ** | **Жаран тавдугаар зүйл** | **Жаран тавдугаар зүйл** | **Жаран нэгдүгээр зүйл** |
| Засаг дарга нь өөрийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг даргын төлөөлөгчийн хувьд нутаг дэвсгэрийн | 1. Засаг дарга нь ~~өөрийн~~ Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгчийн хувьд | 1. Засаг дарга ~~нь~~ **тухайн** Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгчийн хувьд | 1. Засаг дарга тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ | 1. Засаг дарга тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| ~~хэмжээнд~~ төрийн хууль, Засгийн газрын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг зохион байгуулж, ажлаа тухайн Хурал болон Засгийн газар, харьяалах дээд шатны Засаг даргын өмнө хариуцан тайлагнана. | **харьяа** нутаг дэвсгэрийн төрийн хууль, Засгийн газрын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг ~~зохион байгуулж, ажлаа тухайн Хурал болон~~ Засгийн газар, харъяалах дээд шатны Засаг даргын өмнө хариуцан тайлагнана. | нутаг дэвсгэрийн хэмжээнд төрийн хууль, Засгийн газар, **харьяалах дээд шатныхаа захиргааны** шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, харьяалах дээд шатны Засаг даргын өмнө хариуцан тайлагнана. | ~~төрийн~~ хууль, Засгийн газар, харьяалах дээд шатныхаа захиргааны шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, ~~харьяалах~~ дээд шатны Засаг даргын өмнө хариуцан ~~тайлагнана~~. | хууль **тогтоомж**, Засгийн газар, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, дээд шатны Засаг даргын өмнө хариуцна. |
| Засаг дарга нь тухайн аймаг, нийслэл, хошуу, хорооны Хурлын шийдвэрт хориг тавих эрхтэй. | 2. Засаг дарга нь тухайн аймаг, нийслэл, хошуу, хороо~~ныхоо~~ Хурлын шийдвэрт хориг тавих эрхтэй. | 2. Засаг дарга нь тухайн аймаг, нийслэл, хошуу, хороо, **баг, хорины** Хурлын шийдвэрт хориг тавих эрхтэй. | 2. Засаг дарга тухайн аймаг, нийслэл, хошуу, хороо, баг, хорины Хурлын шийдвэрт хориг тавих эрхтэй. | 2. Засаг дарга тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлын шийдвэрт хориг тавих эрхтэй. |
| Хоригийг Хурал гишүүдийнхээ олонхийн саналаар няцаавал уул шийдвэр хүчин төгөлдөр болох боловч Засаг дарга түүнийг биелүүлэх боломжгүй гэж үзвэл огцрох хүсэлтээ Ерөнхий сайд буюу харьяалах аймгийн Засаг даргад гаргаж болно. | 3. **Засаг даргын тавьсан** хоригийг Хурал төлөөлөгчдийн олонхийн саналаар няцаавал уул шийдвэр хүчин төгөлдөр болох боловч Засаг дарга түүнийг биелүүлэх боломжгүй гэж үзвэл огцрох хүсэлтээ Ерөнхий сайд буюу харьяалах **аймаг, нийслэлийн** Засаг даргад гаргаж болно. | 3. Засаг даргын тавьсан хоригийг Хурал төлөөлөгчдийн олонхийн саналаар няца~~авал уул шийдвэр хүчин төгөлдөр болох боловч~~ засаг дарга түүнийг биелүүлэх боломжгүй гэж үзвэл огцрох хүсэлтээ Ерөнхий сайд буюу харьяалах дээд шатны Засаг даргад гаргаж болно. | 3. ~~Засаг даргын~~ тавьсан хоригийг Хурал **өөрийн** төлөөлөгчдийн олонхийн саналаар няца**асан нөхцөлд** Засаг дарга ~~түүнийг~~ биелүүлэх боломжгүй гэж үзвэл огцрох хүсэлтээ зохих **Хурал**, Ерөнхий сайд буюу харьялах дээд шатны Засаг даргад гаргаж болно. | 3. Тавьсан хоригийг **нь** Хурал өөрийн төлөөлөгчдийн олонхийн саналаар няцаасан нөхцөлд Засаг дарга **уул шийдвэрийг** биелүүлэх боломжгүй гэж үзвэл огцрох хүсэлтээ зохих Хурал, Ерөнхий сайд буюу харьялах дээд шатны Засаг даргад гаргаж болно. |
| | | 4. Аймаг, нийслэл, хошуу, хорооны Засаг, даргын ажлын алба нь Тамгын газар мөн. Түүний бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газар нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтооно. | 4. Аймаг, нийслэл, хошуу хорооны Засаг даргын албан ажлаа хөтлөн явуулах байгууллага нь Тамгын газар мөн. Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газар нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтооно. | 4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар мөн. Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газар нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтооно. |
| **66 дугаар зүйл** | **ДАЛАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ** | **Жаран зургадугаар зүйл** | **Жаран зургадугаар зүйл** | **Жаран хоёрдугаар зүйл** |
| Аймаг, нийслэл, хошуу, хорооны Хурал нь нутаг дэвсгэрийнхээ амьдралын бүх асуудлыг бие дааж шийдвэрлэхийн дотор дурдсан асуудлыг өөрийн онцгой эрхэнд хадгалж шийдвэрлэнэ: | 1. Аймаг, нийслэл, хошуу, хорооны Хурал нь нутаг дэвсгэрийнхээ амьдралын ~~бүх~~ асуудлыг биеэ дааж шийдвэрлэхийн дотор ~~дурдсан асуудлыг өөрийн онцгой эрхэд хадгалж~~ шийдвэрлэнэ: | 1. Нутгийн өөрөө удирдах байгууллагууд тухайн аймаг, нийслэл, хошуу, хороо, баг, хорины эдийн засаг, нийгмийн дотоод амьдралын буюу нутаг дэвсгэрийнхээ **хэмжээний** асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт **улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна.** | 1. Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, хошуу, хороо, баг, хорины эдийн засаг, нийгмийн дотоод амьдралын ~~буюу нутаг дэвсгэрийнхээ хэмжээний~~ асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна. | 1. Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны **нутаг дэвсгэрийн хэмжээний** эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна. |
| 1) тухайн аймаг, нийслэл, хошуу, хорооны эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиглэл, | 1) тухайн аймаг, нийслэл, хошуу, хорооны эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиглэл, | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батална; | төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батална; | | | |
| 2) төрийн өмчид үндэслэн шууд харьяа үйлдвэрийн газар, байгууллагын үйл ажиллагааг удирдана; | 2) төрийн өмчид үндэслэн шууд харъяа үйлдвэрийн газар, байгууллагын үйл ажиллагааг чиглүүлнэ; | | | |
| 3) дээд шатны байгууллагын харьяа болон улсын чанартай үйлдвэрийн газар, байгууллага хууль хэрхэн биелүүлж байгааг харьяалал харгалзахгүйгээр хяналт ~~тавьж~~ шалгана; | 3) дээд шатны байгууллагын харъяа болон улсын чанартай үйлдвэрийн газар, байгууллага хууль хэрхэн биелүүлж байгааг харьяалал харгалзахгүйгээр хянан шалгана; | | | |
| 4) тухайн нутаг дэвсгэр дэх иргэдийн хоршоолол, олон нийтийн байгууллагын үйл ажиллагааг хуулийн хүрээнд зохицуулна. | 4) тухайн нутаг дэвсгэр дэх иргэдийн хоршоолол, олон нийтийн байгууллагын үйл ажиллагааг хуулийн хүрээнд зохицуулна. | | | |
| 5) өөрийн харьяа захиргааны байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавьж, тэдгээрийн тайланг хянан хэлэлцэнэ. | | | | |
| | | 2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээг хуулиар тогтоох бөгөөд түүнд хамаарах асуудлыг дээд шатны нь байгууллага шийдвэрлэж болохгүй. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно. | 2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээг ~~хуулиар тогтоох бөгөөд түүнд хамаарах~~ асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж болохгүй. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Их цаазад нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно. | 2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж ул болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно. |
| | | 3. ~~Монгол Улсын~~ Их Хурал, Засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад шилжүүлж болно. | 3. Улсын Их Хурал, Засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад шилжүүлж болно. | 3. Улсын Их Хурал, Засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад шилжүүлж болно. |
| | | 4. ~~Монгол улсын~~ засаг захиргааны нэгж, түүний | 4. Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын эрх хэмжээ, | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | удирдлагын эрх хэмжээ, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. | зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. | |
| **67 дугаар зүйл** | **ДАЛАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ** | **Жаран долдугаар зүйл** | **Жаран долдугаар зүйл** | **Жаран гуравдугаар зүйл** |
| Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хошуу, хорооны Хурал эрх хэмжээнийхээ дотор тогтоол, Засаг дарга, багийн захирагч нь захирамж гаргана. | 1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хошуу, хорооны Хурал эрх хэмжээнийхээ дотор тогтоол, Засаг дарга захирамж гаргана. | 1. Аймаг, нийслэл, хошуу, хороо, баг, хорины Хурал **нь** эрх хэмжээнийхээ дотор тогтоол, засаг дарга **нь** захирамж гаргана. | 1. Аймаг, нийслэл, хошуу, хороо, баг, хорины Хурал эрх хэмжээнийхээ дотор тогтоол, Засаг дарга захирамж гаргана. | 1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурал эрх хэмжээнийхээ дотор тогтоол, Засаг дарга захирамж гаргана. |
| Эдгээр тогтоол, захирамж нь хуульд нийцсэн байх бөгөөд тус улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр ~~дагаж мөрдөгдөнө~~. | 2. Хурлын тогтоол, Засаг даргын захирамж нь хуульд нийцсэн байх бөгөөд тус улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр ~~байна~~. | 2. Хурлын тогтоол, Засаг даргын захирамж нь хууль, **Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон өөрийн дээд шатны байгууллага, албан тушаалтны шийдвэрт** нийцсэн байх бөгөөд **түүнийг** тус тусын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр **дагаж мөрдөнө**. | 2. Хурлын тогтоол, Засаг даргын захирамж нь хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн ~~газрын болон~~ өөрийн дээд шатны байгууллага, ~~албан тушаалтны~~ шийдвэрт нийцсэн байх бөгөөд түүнийг тус тусын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөнө. | 2. Хурлын тогтоол, Засаг даргын захирамж нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн байх бөгөөд түүнийг тус тусын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөнө. |
| ~~Хэрэв уул~~ тогтоол, захирамж хуульд харшилбал, Хурал, Засаг дарга, ~~багийн захирагч~~ өөрөө буюу дээд шатны байгууллага, албан тушаалтан хүчингүй болгоно. | 3. **Хурлын** тогтоол, **Засаг даргын** захирамж хуульд харшилбал, Хурал, Засаг дарга өөрөө буюу дээд шатны байгууллага, албан тушаалтан хүчингүй болгоно. | | | |
| | | | | 3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын эрх хэмжээ, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно. |
| **68 дугаар зүйл** | **ДАЛАН ТАВДУГААР ЗҮЙЛ** | | | |
| Аймаг, нийслэл, хошуу, хорооны засаг даргын ажлын алба нь тамгын газар мөн. | Аймаг, нийслэл, хошуу, хорооны Засаг даргын ажлын алба нь тамгын газар мөн. | | | |
| **69 дүгээр зүйл** | **ДАЛАН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ** | | | |
| Монгол Улсын Их хурал, Засгийн газраас шаардлагатай хэмжээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэнд хамаарах зарим асуудлыг аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад гүйцэтгүүлэхээр шилжүүлж болно. | Монголын Улсын Их хурал, Засгийн газраас шаардлагатай хэмжээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэнд хамаарах зарим асуудлыг аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад гүйцэтгүүлэхээр шилжүүлж болно. | | | |
| **70 дугаар зүйл** | **ДАЛАН ДОЛДУГААР ЗҮЙЛ** | | | |
| Багийн өөрөө удирдах байгууллага бол тухайн багийн | 1. Багийн өөрөө удирдах байгууллага бол тухайн багийн | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| иргэдийн нийтийн хурал мөн. Иргэдийн Хурал тухайн багийн амьдралын чухал асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. | Иргэдийн Хурал мөн. Иргэдийн Хурал тухайн багийн амьдралын чухал асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. | | | |
| Багийн өдөр тутмын ажлыг багийн захирагч удирдана. Түүнийг тухайн багийн Иргэдийн нийтийн хурлаас нэр дэвшүүлж хошууны Засаг дарга 4 жилийн хугацаагаар томилно. | 2. Багийн өдөр тутмын ажлыг багийн Засаг дарга удирдана. Түүнийг тухайн багийн Иргэдийн хурлаас нэр дэвшүүлж хошууны Засаг дарга 4 жилийн хугацаагаар томилно. | | | |
| **71 дүгээр зүйл** | **ДАЛАН НАЙМДУГААР ЗҮЙЛ** | | | |
| Монгол улсын засаг захиргааны нэгж, түүний удирдлагын бүрэн эрх, чиг үүрэг, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Монгол улсын нутгийн захиргааны хуулиар тогтооно. | 1. Монгол улсын засаг захиргааны нэгж, түүний удирдлагын бүрэн эрх, чиг үүрэг, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Монгол улсын нутгийн захиргааны хуулиар тогтооно. | | | |
| **ТАВДУГААР БҮЛЭГ** | | | | **ТАВДУГААР БҮЛЭГ** |
| **~~Монгол улсын Их цаазыг баталгаажуулах, өөрчлөх нь~~** | | | **1. Монгол Улсын Их цаазын цэц** | **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ** |
| **72 дугаар зүйл** | **ЖАРАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ** | **Тавьдугаар зүйл** | **Тавьдугаар зүйл** | **Жаран дөрөвдүгээр зүйл** |
| Монгол улсын Их цаазыг чандлан сахиулах баталгаа нь Монгол улсын Их цаазын цэц мөн. | 1. Монгол улсын Их цаазын цэц бол Монгол улсын Их цаазыг чандлан сахиулах баталгаа мөн. | 1. Үндсэн хуулийн шүүх бол **Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх, Үндсэн хуулийн заалтыг хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах бүрэн эрх бүхий байгууллага**, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн. | 1. Их цаазын цэц бол Их цаазын биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай маргааныг магадлан шийдвэрлэх, Их цаазын заалтыг хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах бүрэн эрх бүхий байгууллага, Их цаазыг чандлан сахиулах баталгаа мөн. | 1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн. |
| | | 2. Үндсэн хуулийн шүүх, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан бусад хүмүүсээс хараат бус байна. | 2. Их цаазын цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Их цаазад захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна. | 2. Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна. |
| | | 3. Үндсэн хуулийн шүүхийн гишүүн нь ~~шүүгчийн~~ хараат бус байдлыг ~~хангах талаар~~ Үндсэн хууль болон бусад хуулиар тогтоосон баталгаагаар нэгэн адил хангагдана. | 3. Их цаазын цэцийн гишүүний хараат бус байдал Их цааз, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана. | 3. Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана. |



UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | Тавин нэгдүгээр зүйл | Тавин нэгдүгээр зүйл | Жаран тавдугаар зүйл |
|---|---|---|---|---|
| Монгол улсын Их цаазын цэц 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Их цаазын цэцийн 3 гишүүнийг Улсын Их Хурал, 3 гишүүнийг Ерөнхийлөгч, 1 гишүүнийг Улсын дээд шүүх тус тус томилно. ~~Улсын Их цаазын цэцийн гишүүдийн~~ бүрэн эрхийн хугацаа 9 жил байна. | 2. Монгол улсын Их цаазын цэц 6 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Их цаазын цэцийн 2 гишүүнийг Улсын Их Хурал, 2 гишүүнийг Ерөнхийлөгч, 2 гишүүнийг Улсын дээд шүүх тус тус 9 жилийн хугацаагаар томилно. | 1. Үндсэн хуулийн шүүх нь 9 гишүүнээс бүрэлдэнэ.<br>2. Үндсэн хуулийн шүүхийн ~~3 гишүүнийг~~ Улсын Их Хурал, ~~3 гишүүнийг Ерөнхийлөгч 3 гишүүнийг Улсын дээд шүүх тус тус~~ 9 жилийн хугацаагаар томилно. ~~**Үндсэн хуулийн шүүхийн гишүүдийн гуравны нэгийг 3 жил тутамд энэ зүйлд заасан журмаар шинэчилнэ.**~~ | 1. Их цаазын цэц есөн гишүүнээс бүрдэнэ.<br>2. Их цаазын цэцийн 9 гишүүнийг Улсын Их Хурал 9 жилийн хугацаагаар томилно. | 1. Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ.<br>Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно. |
| | 3. Их цаазын цэцийн гишүүнээр Монгол Улсын 40 нас хүрсэн иргэнийг томилж болно. | 3. Үндсэн хуулийн шүүхийн гишүүнээр Монгол улсын ~~**харьяат**~~**, хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан,** 40 нас хүрсэн иргэнийг томилж болно. | 3. Их цаазын цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, 40 нас хүрсэн Монгол Улсын иргэнийг томилно. | 2. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол Улсын дөчин нас хүрсэн иргэнийг томилно. |
| Эдгээр 7 гишүүний аль нэгийг Монгол улсын Их цаазын ерөнхий цэцээр 3 жилийн хугацаагаар цэцийн гишүүд ~~өөрсдөө~~ сонгоно. | 4. ~~Монгол улсын~~ Их цаазын Ерөнхий цэцээр 6 гишүүний аль нэгийг 3 жилийн хугацаагаар ~~цэцийн~~ **гишүүдийн олонхийн саналаар** сонгоно. | 4. Үндсэн хуулийн шүүхийн даргаар 9 гишүүний аль нэгийг 3 жилийн хугацаагаар гишүүдийн олонхийн саналаар сонгоно. | 4. Үндсэн хуулийн цэцийн даргаар 9 гишүүний аль нэгийг 3 жилийн хугацаагаар гишүүдийн олонхийн саналаар сонгоно. | 3. Үндсэн хуулийн цэцийн даргаар есөн гишүүний аль нэгийг гурван жилийн хугацаагаар гишүүдийн олонхийн саналаар сонгоно. |
| Ерөнхий цэцийг нэг удаа улируулан сонгож болно. | 5. Ерөнхий цэцийг нэг удаа улируулан сонгож болно. | Түүнийг нэг удаа улируулан сонгож болно. | Түүнийг нэг удаа улируулан сонгож болно. | Түүнийг нэг удаа улируулан сонгож болно. |
| | | | | 4. Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн хууль зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно. |
| Монгол улсын Ерөнхийлөгч байсан хүн хэрэв хэрэгт холбогдон огцроогүй бол 65 нас хүртэл Улсын их цаазын цэцийн гишүүн байж болно. | 6. Монгол улсын Ерөнхийлөгч байсан хүн хэрэв хэрэгт холбогдон огцроогүй бол 65 нас хүртэл Улсын их цаазын цэцийн гишүүн байж болно. | | | |
| **73 дугаар зүйл** | **ЖАРАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ** | | | |
| Монгол улсын Их цаазын цэцийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхийлөгч, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч орж болохгүй. | 1. ~~Монгол улсын~~ Их цаазын цэцийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхийлөгч, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч орж болохгүй. | 5. Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, **Ерөнхий сайд**, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч орж болохгүй. | 5. Их цаазын цэцийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч байж болохгүй. | 5. Үндсэн хуулийн цэцийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч орж үл болно. |

| 74 дүгээр зүйл | ЖАРАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ | Тавин хоёрдугаар зүйл | Тавин хоёрдугаар зүйл | Жаран зургадугаар зүйл |
|---|---|---|---|---|
| | | 1. Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, түүний ~~10-аас доошгүй~~ гишүүн, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ. | 1. Их цаазын цэц нь Их цаазыг зөрчсөн тухай маргааныг өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, ~~түүний гишүүн,~~ Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ. | 1. Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг **иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу** өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ. |
| Монгол улсын Их цаазын цэц нь дор дурдсан маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна: | 1. ~~Монгол улсын~~ Их цаазын цэц нь дор дурдсан маргаантай **асуудлаар** дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна: | 2. Үндсэн хуулийн шүүх нь **энэ зүйлийн I дэх хэсэгт заасан үндэслэлээр** дор дурдсан маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна: | 2. Их цаазын цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараах маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна: | 2. Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараах маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна: |
| 1) хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын бусад улстай байгуулсан гэрээ нь Улсын Их цаазад нийцэж байгаа эсэх; | 1) хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын бусад улстай байгуулсан гэрээ нь Улсын Их цаазад нийцэж байгаа эсэх; | 1/ хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол улсын бусад улстай байгуулсан гэрээ нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх; | 1/ хууль, ~~Ерөнхийлөгчийн~~ зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын бусад улстай байгуулсан гэрээ Их цаазад нийцэж байгаа эсэх; | 1/ хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх; |
| 2) ард нийтийн санал хураалт, Улсын Их Хурлын гишүүдийн болон Ерөнхийлөгчийн сонгуулийн асуудлаар сонгуулийн төв комиссын гаргасан шийдвэр хуульд нийцэж байгаа эсэх; | 2) ард нийтийн санал хураалт, Улсын Их Хурлын гишүүдийн болон Ерөнхийлөгчийн сонгуулийн асуудлаар сонгуулийн төв комиссын гаргасан шийдвэр Их цаазад нийцэж байгаа эсэх; | 2/ ард нийтийн санал хураалт, Улсын Их Хурлын гишүүдийн болон Ерөнхийлөгчийн сонгуулийн асуудлаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх; | 2/ ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурлын гишүүдийн болон Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх; | 2/ ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх; |
| 3) Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн тангаргаа няцаж, хууль зөрчсөн эсэх; | 3) Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын **дарга**, гишүүн ~~тангаргаа няцаж~~, хууль зөрчсөн эсэх; | 3/ Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн хууль зөрчсөн эсэх; | 3/ Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, **Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн дарга, Ерөнхий прокурор** хууль зөрчсөн эсэх; | 3/ Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, **Улсын** ерөнхий прокурор **Үндсэн** хууль зөрчсөн эсэх; |
| | 4) Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Засгийн газрыг огцруулах, Улсын Их хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх. | 4/ Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Засгийн газрыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх. | 4/ Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх. | 4/ Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх. |
| | 2. Улсын Их цааз зөрчсөн тухай асуудлаар гаргаж оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол | 3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг **нь** Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол | 3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Их | 3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Улсын Их цаазын цэц уул асуудлыг дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргана. | Үндсэн хуулийн шүүх ~~уул асуудлыг~~ дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргана. | цаазын цэц дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргана. | Үндсэн хуулийн цэц дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргана. |
| Монгол улсын Их цаазын цэц нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрын хоорондын эрх хэмжээний талаар гарсан маргааныг хянан шийдвэрлэнэ. | 3. Монгол улсын Их цаазын цэц нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрын хоорондын эрх хэмжээний талаар гарсан маргааныг хянан шийдвэрлэнэ. | | | |
| | 4. Улсын Их цаазын цэцээс хууль, зарлиг болон Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Улсын Их цаазад нийцээгүй гэж тогтоон шийдвэр гаргасан бол холбогдох хууль, зарлиг, шийдвэрийг хүчингүйд тооцно. | 4. Үндсэн хуулийн шүүхээс хууль, зарлиг ~~болон~~ Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, **Монгол улсын олон улсын гэрээ** Үндсэн хуульд нийцээгүй гэж ~~тогтоон~~ ~~**зохих**~~ шийдвэр гаргасан бол холбогдох хууль, зарлиг, **батламж,** шийдвэр~~ийг~~ хүчингүйд тооцно. | 4. Хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ **нь** Их цаазад нийцээгүй гэж Их цаазын цэц шийдвэр гаргавал зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно. | 4. Хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй гэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргавал зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно. |
| ~~Түүнчлэн~~ Их цаазын цэц төрийн дээд байгууллагууд, дээд албан тушаалтны үйл ажиллагаанд холбогдсон бусад асуудлыг Улсын Их хурал, Ерөнхийлөгчийн хүсэлтээр хянан үзэж дүгнэлт гаргаж болно. | 5. Их цаазын цэц төрийн дээд байгууллагууд, дээд албан тушаалтны үйл ажиллагаанд холбогдсон бусад асуудлыг Улсын Их хурал, Ерөнхийлөгчийн хүсэлтээр хянан үзэж дүгнэлт гаргаж болно. | | | |
| **75 дугаар зүйл** | **ЖАРАН ТАВДУГААР ЗҮЙЛ** | | | |
| Монгол улсын Их цаазын цэц нь эрх хэмжээнийхээ асуудлыг гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэх бөгөөд уул шийдвэрлэнэ. Улсын Их цаазын цэцийн шийдвэрийг зөвхөн цэц өөрөө буюу ард нийтийн санал хураалтаар хүчингүй болгож болно. | ~~Монгол улсын~~ Их цаазын цэц ~~нь~~ эрх хэмжээнийхээ асуудлыг гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэ~~х бөгөөд уул шийдвэрийг зөвхөн цэц өөрөө буюу ард нийтийн санал хураалтаар хүчингүй болгож болно~~. | 5. Үндсэн хуулийн шүүх эрх хэмжээнийхээ асуудлыг **тavaас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэж, хуралдаанд оролцсон** гишүүдийн **дийлэнх** олонхийн саналаар шийдвэрлэнэ. | | |
| | | **Тавин гуравдугаар зүйл** | **Тавин гуравдугаар зүйл** | **Жаран долдугаар зүйл** |
| | | 1. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр, тайлбар гармагц хүчин төгөлдөр болно. ~~Тэдгээрийг төр, нам, олон нийтийн бүх байгууллага, албан тушаалтан хүн бүр дагаж биелүүлэх үүрэгтэй.~~ | Их цаазын цэцийн шийдвэр гармагц хүчин төгөлдөр болно. | 1. Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагц**аа** хүчин төгөлдөр болно. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 2. Үндсэн хуулийн шүүхээс Үндсэн хуулийн талаар гаргасан тайлбар уул хуулийнхаа нэгэн адил хүчинтэй бөгөөд хэрэв Улсын Их Хурлын болон Үндсэн хуулийн шүүхийн тайлбар хоорондоо зөрчилдвөл Үндсэн хуулийн шүүхийн тайлбарыг дагаж мөрдөнө. | | |
| | **Тавдугаар бүлэг** | **ТАВДУГААР БҮЛЭГ** | **ТАВДУГААР БҮЛЭГ** | **ЗУРГАДУГААР БҮЛЭГ** |
| | **МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗЫГ БАТЛАХ, ӨӨРЧЛӨХ НЬ** | **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ** | **МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ** | **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ** |
| **76 дугаар зүйл** | **ДАЛАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ** | **Жаран наймдугаар зүйл** | **Жаран наймдугаар зүйл** | **Жаран наймдугаар зүйл** |
| Монгол Улсын Их цаазад нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан, саналыг Улсын Их цаазын цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. | 1. Монгол Улсын Их цаазад нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан, саналыг Улсын Их цаазын цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. | 1. ~~Монгол Улсын~~ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан, саналыг Үндсэн хуулийн шүүх Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. | 1. Их цаазад нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан **гаргах бөгөөд** саналыг Их цаазын цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. | 1. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. |
| Улсын Их цаазад нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар Улсын их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал хураалт явуулж болно. | 2. Улсын Их цаазад нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар Улсын их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал хураалт явуулж болно. | 2. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал хураалт явуулж болно. **Санал хураалтыг энэхүү Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13-т заасан үндэслэлийн дагуу явуулна.** | 2. Их цаазад нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулга явуулж болно. Санал асуулгыг Их цаазын 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15-д заасан үндэслэлийн дагуу явуулна. | 2. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулга явуулж болно. Санал асуулгыг Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16-д заасан үндэслэлийн дагуу явуулна. |
| **77 дугаар зүйл** | **НАЯДУГААР ЗҮЙЛ** | **Жаран есдүгээр зүйл** | **Жаран есдүгээр зүйл** | **Жаран есдүгээр зүйл** |
| Монгол Улсын Их цаазад оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын чуулганд оролцсон нийт гишүүний наяас доошгүй хувийн саналаар батална. | 1. Монгол Улсын Их цаазад оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын чуулганд оролцсон нийт гишүүний наяас доошгүй хувийн саналаар батална. | 1. ~~Монгол улсын~~ Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын чуулганд оролцсон нийт гишүүний наяас доошгүй хувийн саналаар батална. | 1. Их цаазад оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын ~~чуулганд оролцсон~~ нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар батална. | 1. Үндсэн хууль**, түүнд** оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар батална. |
| Улсын Их цаазад оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хуралд хоёр удаа авч хэлэлцэхэд ийнхүү наян хувийн санал авч эс чадваас уг төслийг Улсын Их Хурлын гишүүдийг нөхөн сэлбэх ээлжит сонгууль дуустал дахин авч хэлэлцэхгүй. | 2. Улсын Их цаазад оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хуралд хоёр удаа авч хэлэлцэхэд ийнхүү наян хувийн санал авч эс чадвал уг төслийг Улсын Их Хурлын гишүүдийг нөхөн сэлбэх ээлжит сонгууль дуустал дахин авч хэлэлцэхгүй. | 2. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хуралд хоёр удаа авч хэлэлцэхэд ийнхүү наян хувийн санал авч эс чадвал уг төслийг ээлжит сонгуулиар сонгогдсон шинэ Улсын Их Хурлын бүрэлдэхүүн ажлаа эхэлтэл | 2. Их цаазад оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хуралд хоёр удаа авч хэлэлцэхэд ийнхүү дөрөвний гурваас доошгүйн санал авч эс чадвал уул төслийг ээлжит сонгуулиар сонгогдсон Улсын Их Хурлын шинэ бүрэлдэхүүн ажлаа | 2. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хуралд хоёр удаа авч хэлэлцэхэд ийнхүү **нийт гишүүний** дөрөвний гурваас доошгүйн санал авч эс чадвал уул төслийг ээлжит сонгуулиар сонгогдсон Улсын Их Хурлын |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | дахин авч хэлэлцэхгүй. | эхэлтэл дахин авч хэлэлцэхгүй. | шинэ бүрэлдэхүүн ажлаа эхэлтэл дахин авч хэлэлцэхгүй. |
| | | | 3. Улсын Их Хурал ~~гишүүдийнхээ~~ ээлжит сонгууль явуулахын өмнөх 6 сарын дотор Их цаазад нэмэлт, өөрчлөлт оруулж үл болохгүй. | 3. Улсын Их Хурал ээлжит сонгууль явуулахын өмнөх зургаан сарын дотор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болно. |
| Улсын Их цаазад оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Улсын Их цаазын адил хүчинтэй байна. | 3. Улсын Их цаазад оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Улсын Их цаазын адил хүчинтэй байна. | 3. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь үндсэн хуулийн нэгэн адил хүчинтэй байна. | 4. Их цаазад оруулсан нэмэлт, өөрчлөлт Их цаазын нэгэн адил хүчинтэй байна. | 4. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн нэгэн адил хүчинтэй байна. |
| **78 дугаар зүйл** | **НАЯН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ** | **Далдугаар зүйл** | **Далдугаар зүйл** | **Далдугаар зүйл** |
| Монгол Улсын Их цаазад хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр бүрнээ нийцсэн байвал зохино. | 1. Монгол Улсын Их цаазад хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр бүрнээ нийцсэн байвал зохино. | 1. Монгол Улсын Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, **нийт байгууллага, иргэдийн үйл ажиллагаа** бүрнээ нийцсэн байвал зохино. | 1. Их цаазад хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино. | 1. Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино. |
| Монгол Улсын Их цаазад харшилсан аливаа хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр хүчин төгөлдөр биш байна. | 2. Монгол Улсын Их цаазад харшилсан аливаа хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр хүчин төгөлдөр биш байна. | 2. ~~Монгол Улсын~~ Үндсэн хуульд харшилсан аливаа хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр хүчин төгөлдөр биш байна. | 2. Их цаазад харшилсан аливаа хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр хүчин төгөлдөр бус байна. | |
| | | | | 2. Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 оны хоёрдугаар сарын 12-ны өдрийн 12 цаг буюу арван долдугаар жарны усан бичин жилийн хаврын тэргүүн хар барс сарын шинийн есний идрийн барилдлагаатай өлзийт сайн шар морин өдрийн морин цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө. |
| | | | | Мэдэгтүн, сахигтун! |



UIH.MN СУДАЛГААНЫ САН

ХАВСРАЛТ.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ (1992) БА МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗЫН ТӨСЛҮҮДИЙН (1991.06.05, 10.05, 11.07) ХАРЬЦУУЛАЛТ

### ЕРӨНХИЙ БҮТЭЦ

| **МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ (ҮНДСЭН ХУУЛЬ)** *(Улсын Бага Хуралд өргөн барьсан хувь)* 1991.04.19 | **МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ (Үндсэн хууль)** *(Ард түмнээр хэлэлцүүлсэн хувь)* 1991.06.05 | **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ (ИХ ЦААЗ)** *(Улсын Бага Хуралд өргөн барьсан хувь)* 1991.10.05 | **МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗ** *(Улсын Бага Хурлаас Ардын Их Хуралд өргөн барьсан хувь)* 1991.11.07 | **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ** *(Батлагдсан хувь)* 1992.01.13 |
|---|---|---|---|---|
| **1-р төсөл** | **2-р төсөл** | **3-р төсөл** | **4-р төсөл** | **Үндсэн хууль** |
| I бүлэг<br>Монгол Улсын бүрэн эрхт байдлыг илтгэн тунхаглах нь | I бүлэг.<br>Монгол Улсын бүрэн эрхт байдл~~ыг илтгэн тунхаглах нь~~ | I бүлэг<br>Монгол Улсын бүрэн эрхт байдал | I бүлэг<br>Монгол Улсын бүрэн эрхт байдал | I бүлэг<br>Монгол Улсын бүрэн эрхт байдал |
| II бүлэг<br>Хүний эрх эрх чөлөөг илтгэн тунхаглах нь | II бүлэг<br>Хүний эрх эрх чөлөөг илтгэн тунхаглах нь | II бүлэг<br>Хүний эрх, эрх чөлөө | II бүлэг<br>Хүний эрх, эрх чөлөө | II бүлэг<br>Хүний эрх, эрх чөлөө |
| III бүлэг<br>Монгол Улсын төрийн байгуулалт. Төрийн эрх мэдлийг хуваарилах нь | III бүлэг<br>Монгол Улсын төрийн байгууллыг ~~бататган бэхжүүлэх нь~~ | III бүлэг<br>Монгол Улсын төрийн байгуулал | III бүлэг<br>Монгол Улсын төрийн байгуулал | III бүлэг<br>Монгол Улсын төрийн байгуулал |
| *I. Хууль тогтоох эрх мэдэл. Монгол Улсын Их хурал* | *I. Монгол Улсын Их хурал* | *I.Монгол Улсын Их Хурал* | *I. Монгол Улсын Их Хурал* | *I. Монгол Улсын Их Хурал* |
| *II. Монгол Улсын Ерөнхийлөгч* | *II. Монгол Улсын Ерөнхийлөгч* | *II. Монгол Улсын ерөнхийлөгч* | *II. Монгол Улсын Ерөнхийлөгч* | *II. Монгол Улсын Ерөнхийлөгч* |
| *III. ~~Гүйцэтгэх эрх мэдэл.~~ Монгол Улсын Засгийн газар* | *III. Монгол Улсын Засгийн газар* | *III. Монгол Улсын засгийн газар* | *III. Монгол Улсын Засгийн газар* | *III. Монгол Улсын Засгийн газар* |
| *IV. Шүүх эрх мэдэл* | *IV. Шүүх эрх мэдэл* | *IV. Шүүх эрх мэдэл /Засаг/* | *IV. Шүүх эрх мэдэл* | *IV. Шүүх эрх мэдэл* |
| | | | *V. Монгол Улсын Дээд шүүх* | |
| IV бүлэг<br>Монгол Улсын засаг захиргааны нэгж, түүний удирдлага | IV бүлэг<br>Монгол Улсын засаг захиргааны нэгж, түүний удирдлага | IV бүлэг<br>Монгол Улсын засаг захиргааны нэгж түүний удирдлага | IV бүлэг<br>Монгол улсын засаг захиргаа~~ны~~ нэгж, түүний удирдлага | IV бүлэг<br>Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага |
| | | | 1. Монгол Улсын Их цаазын цэц | V бүлэг<br>Монгол Улсын Үндсэн хуулийн цэц |
| V бүлэг<br>~~Монгол Улсын Их цаазыг баталгаажуулах, өөрчлөх нь~~ | V бүлэг<br>Монгол Улсын Их цаазыг батлах, өөрчлөх нь | V бүлэг<br>Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах | V бүлэг<br>Монгол Улсын Их цаазад нэмэлт, өөрчлөлт оруулах | VI бүлэг<br>Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ (1992) БОЛОН МОНГОЛ УЛСЫН ИХ ЦААЗЫН ТӨСЛҮҮДЭД (1991.VI.05, X.05, XI.07) ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЯВЦАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД

*Г.Билгээ, Д.Жигваагүнсэл*

**ТАЙЛБАР:**

| | |
|---|---|
| 1-р төсөл | - Монгол улсын их цааз[94] (Үндсэн хууль), Улсын Бага Хуралд өргөн барьсан хувь, 1991.04.19. |
| 2-р төсөл | - Монгол улсын Их цааз[95] (Үндсэн хууль), Ард түмнээр хэлэлцүүлсэн хувь, 1991.06.05. |
| 3-р төсөл | - Монгол улсын Үндсэн хууль[96] (Их цааз), Улсын Бага Хуралд өргөн барьсан хувь, 1991.10.05. |
| 4-р төсөл | - Монгол улсын Их цааз[97] , Улсын Бага Хурлаас Ардын Их Хуралд өргөн барьсан хувь, 1991.11.07. |
| Үндсэн хууль | - Монгол Улсын Үндсэн хууль[98] ,Батлагдсан хувь, 1992.01.13. |

ЖИЧ: Бүлэг тус бүрийг ангилахдаа Үндсэн хуулийн (1992) бүтцийг баримтлав.

## 1. ХАСАГДСАН ХЭСГҮҮД

### I БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН БҮРЭН ЭРХТ БАЙДАЛ

- ~~Монгол улсын~~ хуульгүйгээр ~~Монгол улсын торгон хилийг өөрчлөх~~, гадаадын цэргийн хүчийг Монголын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэхээр улсын хил нэвтрүүлэхийг хориглоно. /3-р төслийн 4.3-аас/
- ~~Монгол улс нээлттэй далай, сансрын уудмыг олон улсын Эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчим, Монгол улсын олон улсын гэрээний дагуу эзэмших, ашиглах явдлыг өөрийн бүрэн эрхэд хадгална.~~ /3-р төслийн 4.4-өөс/
- ~~Монгол Улсад сүм хийд, төрөөс, иргэний боловсрол шашнаас тусгаар байна. Шашны боловсролыг шашны сургалтаар олгоно.~~ /4-р төслийн 9.1-ээс/
- ~~Монгол улсын Төрийн дээд байгууллагууд байнга орших хотыг Улсын нийслэл гэж тооцож түүний онцгой байр суурийг хуулиар бататгана. /2-р төслийн 15.1-ээс/~~

### II БҮЛЭГ. ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

- амьдрах эрхтэй. Монгол улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь насыг бусниулахыг хатуу хориглоно. ~~Гэмт хэрэг үйлдэхийн өмнө **18 нас хүрээгүй байсан этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд, 60**-аас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй~~; /3-р төслийн 17.1-ээс/
- иргэд сурч боловсрох мэдлэг мэргэшлээ дээшлүүлэх эрхтэй ~~бөгөөд бүх шатны сургуульд сурч боловсрох явдал иргэн бүрт нээлттэй~~. /1-р төслийн 16.7-оос/

[94] УИХ, УИХТГ-ын архив, данс №1-91, х167-190.
[95] "Ардын эрх" сонин, 1991.06.05, №86 /158/.
[96] УИХ, УИХТГ-ын архив, данс №1-92, х165-199.
[97] УИХ, УИХТГ-ын архив, данс №1-92, х200-234.
[98] "Ардын эрх" сонин, 1992.01.14, №9 /313/.

- иргэд сурч боловсрох мэдлэг мэргэшлээ дээшлүүлэх эрхтэй. Төрийн сургуульд бүх нийтийн суурь ~~(ерөнхий)~~ боловсролыг үнэ төлбөргүй олгоно. Иргэд их сургуулиас бусад хувийн сургууль байгуулж болно. Хувийн сургуулийн сургалт нь төрөөс тавих шаардлагад бүрэн нийцсэн байвал зохино. ~~Бүх сургууль төрийн хяналтад байна~~; /2-р төслийн 19.7-оос/
- иргэд тус улсын нутаг дэвсгэр дээр оршин суух газраа чөлөөтэй сонгох, дотоод гадаадад зорчих, ~~цагаачлах~~, эх орондоо буцаж ирэх эрхтэй; /2-р төслийн 19.17-оос/
- ~~улс үндэстнийхээ эв нэгдлийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах~~**;** /2-р төслийн 20.3-аас/
- ~~нийгмийн баялгийг хайрлан хамгаалж арвижуулах~~**;** /2-р төслийн 20.6-аас/
- ~~төрийн нууцыг чанд хамгаалах~~**;** /2-р төслийн 20.9-өөс/
- эцэг, эх нь үр хүүхдээ, ~~үр хүүхэд нь эцэг эхээ асран хамгаалах~~; /2-р төслийн 20.10-аас/
- ~~бусад үндэстэн, ард түмний бүрэн эрх, нэр төр, зан заншлыг хүндэтгэх~~**.** /2-р төслийн 20.11-ээс/
- Дайны болон онц байдал зарласан, ~~Их цаазын журмыг урвуулан ашигласан үед~~ Их цааз, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хувь хүн, нэжгээд тохиолдлыг үл хамаарна. /4-р төслийн 19.2-оос/

## III БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛ

- ~~Монгол Улсад төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл болгон хуваарилж, хоорондын уялдаа, зохицлыг хуулиар баталгаажуулан хангана~~**.** /1-р төслийн 19-өөс/

### НЭГ. Монгол Улсын Их Хурал

- ~~Монгол Улсын Их Хурал бол төрийн засаг /эрх/-ийг барих төлөөлөгчдийн дээд байгууллага мөн~~**.** /3-р төслийн 20.1-ээс/
- ~~Монгол улс бол Парламентын бүгд найрамдах улс мөн~~**.** /4-р төслийн 20-оос/
- Улсын Их Хурлын гишүүнийг сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, шууд сонгох эрхтэй оролцож саналаа нууцаар гаргаж, ~~**6 жилийн**~~ хугацаагаар сонгоно. ~~Улсын Их Хурлын нийт гишүүний хоёрны нэгийг 3 жил тутам шинэчилэн сонгож сэлбэнэ~~**.** /4-р төслийн 21.2-оос/
- ~~Улсын Их цааз,~~ хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах; /2-р төслийн 27.1.6-аас/
- ~~Ерөнхийлөгчийн санаачилснаар~~ гадаад улстай дипломат харилцаа тогтоох, таслах; /1-р төслийн 25.10/ → ~~Засгийн газрын өргөн мэдүүлснээр~~ гадаад улстай дипломат харилцаа тогтоох, таслах; /2-р төслийн 27.12-оос/
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар, ~~Дээд шүүх~~ хууль санаачлах эрх эдэлнэ. /1-р төслийн 26/ → ~~Монгол Улсын~~ Ерөнхийлөгч, ~~Улсын Их Хурлын байнгын хороо~~, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ. /2-р төслийн 28.1-ээс/
- Улсын Их Хурлын нийт гишүүний 75 хувиас доошгүй нь хүрэлцэн ирсэн бол чуулганыг хүчинтэйд тооцож, ~~Улсын Их цаазад нэмэлт, өөрчлөлт оруулахаас бусад~~ асуудлыг чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ. /2-р төслийн 29.5-аас/

*Дараагийн төсөлд шилжсэнийг тэмдэглэв.

- ~~Байнгын хороо нь Улсын Их Хурлын ажлын байгууллага мөн бөгөөд хуулийн болон бусад асуудлаар төсөл боловсруулах, санал дүгнэлт гаргах, тус тусын эрхлэх асуудлын хүрээнд Улсын Их Хурлын хянан шалгах үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй~~. /1-р төслийн 28-аас/
- Улсын Их Хурал уг гишүүнийг гэмт хэрэг үйлдсэн гэх үндэслэл тогтоовол эгүүлэн татаж ~~Улсын Дээд шүүхэд~~ шилжүүлнэ. /2-р төслийн 31.3-аас/

ХОЁР. Монгол Улсын Ерөнхийлөгч

- Ерөнхийлөгчөөр 40 нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол улсын ~~гурваас доошгүй үеийн~~ уугуул иргэнийг 4 жилийн хугацаагаар сонгоно. /3-р төслийн 33.2-оос/
- ~~Монгол улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг Улсын Их цааз, бусад хуулиар тодорхойлно.~~ /2-р төслийн 37.1-ээс/
- ~~Улсын Их Хурлын гишүүний сонгуулийг товлон зарлана;~~ /1-р төслийн 34.1-ээс/
- ~~Монгол улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийг тэргүүлнэ;~~/1-р төслийн 34.10-аас/
- ...улсын хэмжээнд, эсхүл нутаг дэвсгэрийн зарим хэсгийг дайны байдалд оруулж, ~~нийгмийн дэг журам сахиулах онцгой журам тогтооно;~~ /2-р төслийн 37.2.13-аас/
- ~~Ерөнхийлөгчийн зарлигийг Монгол улс даяар дагаж мөрдөнө.~~ /2-р төслийн 38.2-оос/
- ~~Ерөнхийлөгч гэмт хэрэг үйлдсэний улмаас огцорвол хэргийг зөвхөн Улсын Дээд шүүхэд шилжүүлнэ.~~ /1-р төслийн 28-аас/
- ~~Улсын Их Хурлын дарга энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэх хугацаандаа Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхээсээ түдгэлзэнэ.~~ /4-р төслийн 37.3-аас/

ГУРАВ. Монгол Улсын Засгийн газар

- Монгол улсын Засгийн газар нь Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. ~~Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тоог Улсын Их хурал тогтооно.~~ /1-р төслийн 41-ээс/
- ... ~~Улсын Их Хурлын гишүүдийг шинэчилэн сонгож сэлбэсний дараа Засгийн газарт итгэх эсэхийг тухай бүр хэлэлцэж шийдвэрлэнэ.~~ /4-р төслийн 40.1-ээс/
- ~~Засгийн газрын гишүүн бүр үйл ажиллагаагаа Ерөнхий сайдын өмнө хариуцна.~~ /2-р төслийн 46.3-аас/
- ~~Засгийн газар Ерөнхийлөгчийн шийдвэрийг хэрэгжүүлэх талаар явуулсан үйл ажиллагааныхаа тухай Ерөнхийлөгчид тайлагнаж байна.~~ /3-р төслийн 41.3-аас/
- ~~Ерөнхий сайдыг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр, Засгийн газрын гишүүнийг Ерөнхий сайдын зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах /хэргийн газар дээр баривчилсан, саатуулснаас бусад тохиолдолд/, албан үүрэгтэй нь холбогдуулан баривчлах, албадан саатуулах, цагдан хорих, нэгжих, шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулахыг хориглоно.~~ /3-р төслийн 42.3-аас/
- Улсын Их Хурал Засгийн газрыг огцруулах тухай өөрөө санаачилсан болон Ерөнхийлөгчийн санал, Ерөнхий сайдын мэдэгдлийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор Засгийн газрыг огцруулах эсэхийг хэлэлцэн ~~чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар~~ шийдвэрлэнэ. /4-р төслийн 43.3-аас/
- ~~Засгийн газрын тогтоол, захирамж нь улсын хэмжээнд хүчин төгөлдөр байна.~~ /2-р төслийн 50.2-оос/
- ~~Төрийн албан газрын дүрэмд түүний чиг үүрэг, эрх хэмжээ, удирдах албан тушаалтны хариуцлагыг тодорхойлсон байвал зохино.~~ /2-р төслийн 51.2-оос/
- ~~Зэвсэгт хүчин, улсын аюулгүй байдлыг хангах болон цагдаагийн байгууллагын ажилтан зэрэг төрийн зарим албан хаагч намын гишүүн байхыг хуулиар хязгаарлаж болно.~~ /4-р төслийн 46.3-аас/
- ~~Шүүгч, цэргийн жинхэнэ албанд байгаа мэргэшсэн албан хаагч, цагдаагийн болон~~

~~дипломат ажилтан зэрэг төрийн зарим төрлийн албан хаагч намын гишүүн байх явдлыг хуулиар хязгаарлаж болно.~~ /2-р төслийн 51.4-оос/

ДӨРӨВ. Шүүх эрх мэдэл

- ~~Шүүгчдийн хараат биш байх баталгаа бол Улсын Ерөнхийлөгч мөн~~... /1-р төслийн 52-оос/
- ... ~~Шүүхийн ерөнхий зөвлөлийг Улсын Ерөнхийлөгч тэргүүлнэ.~~ /1-р төслийн 52-оос/ → ~~Шүүхийн ерөнхий зөвлөлийг Их цаазын цэцийн Ерөнхий цэц тэргүүлнэ.~~ /2-р төслийн 55.3-аас/
- ~~Шүүхийн Ерөнхий зөвлөл нь Үндсэн хуулийн шүүхийн ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хурлын хууль зүйн асуудал эрхэлсэн хорооны нэг гишүүн, Хууль зүйн сайд, Сангийн сайд, Ерөнхийлөгчийн хуулийн зөвлөх, хуульчдын байгууллагаас нэр дэвшүүлж илгээсэн хоёр шүүгч, хоёр хуульчаас бүрэлдэнэ. Ерөнхий зөвлөлийн дарга нь Үндсэн хуулийн шүүхийн ерөнхий шүүгч, орлогч дарга нь Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч буюу Улсын ерөнхий прокурор байна. Бүрэлдэхүүнийг Ерөнхийлөгч батална.~~ /3-р төслийн 49.5-аас/
- Их цааз, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу ~~Ерөнхийлөгч~~ огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулах, ~~өөрийн зөвшөөрөлгүйгээр өөр ажилд шилжүүлэх, тогтоосон цалинг бууруулахыг~~ хориглоно. /4-р төслийн 55.4-оос/
- ~~Аймаг, нийслэл, хошууны болон нутгийн бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөр хянан хэлэлцэж шалгаруулан санал болгосноор Ерөнхийлөгч 10 жилийн хугацаагаар томилно.~~ /2-р төслийн 56.4-өөс/
- ~~Улсын дээд шүүхийн шүүгчдээс бусад шүүгчийн үйл ажиллагаа, мэргэжлийн түвшинг Шүүхийн ерөнхий зөвлөл 5 жилд нэг удаа хүн бүр дээр хэлэлцэж үргэлжлүүлэн ажиллах эсэх талаар дүгнэлт гаргана.~~ /2-р төслийн 56.5-аас/
- Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн Төлөөлөгчдийг ~~хувийн зан байдал, боловсрол, мэргэжлээр нь шалгаруулан хуульд заасан журмаар баталсан нэрийн жагсаалтын дагуу таслах эрхтэйгээр оролцоно~~. /4-р төслийн 56.2-оос/
- ~~Улсын аюулгүй байдалд хор хохирол учруулах, хуулиар хамгаалсан нууц задруулах, иргэдийн зан суртахуунд ноцтой харшлах зэрэг зарим хэргийг хаалттай таслахаар хуульд зааж болох боловч үндсэн хуулийн болон хүний салшгүй эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийг заавал нээлттэй тасална.~~ /3-р төслийн 58.2-оос/
- ~~Монгол улсын прокурорын байгууллага нь нийгэм, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихөөс сэргийлэн хамгаалах зорилгоор хуулийг нэг мөр хэрэглэж байгаад хяналт тавих төрийн байгууллага мөн.~~ /3-р төслийн 60.1-ээс/
- ~~Хууль сахиулагч нь шүүх хуралд төрийн өмнөөс яллах үүргийг гүйцэтгэнэ.~~ /2-р төслийн 61.2-оос/
- ~~Монгол улсын прокурорын байгууллага нь хяналтын үүргээ хэрэгжүүлэхдээ хууль ёсыг чанд сахих, хараат биш байх, зохион байгуулалтын хувьд нэгдмэл байх, зөвхөн дээд шатныхаа прокурорт захирагдах зарчмыг баримтална.~~ /3-р төслийн 60.3-аас/

## IV БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА

- ~~Засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэр дэх хот, тосгоныг тухайн нэгжийн төв буюу эсхүл хүн амын төвлөрсөн суурин гэж үзнэ.~~ /4-р төслийн 61.2-оос/

- ~~Аймаг, нийслэл, хошуу, хороо бүр хилийн цэсээр тодорхойлсон нутаг дэвсгэр, бие даасан төсөв, өөрийн мэдлийн үйлдвэрийн газар, хүн амын ахуй, нийгэм, соёлын үйлчилгээний байгууллага, нэгжүүд, засаг захиргааны албан газруудтай байна~~. /3-р төслийн 62.2-оос/
- Аймаг, нийслэл, хошуу, хорооны хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал, ~~баг, хорины хилийн цэсийг аймаг, нийслэлийн Хурал тус тус~~ батална. /4-р төслийн 62.2-оос/
- ~~Аймаг, нийслэл, хошуу, хороо, баг, хорины Хурлын хуралдааны чөлөө цагт эрх, үүргийг нь тухайн Хурлаас сонгогдсон тэргүүлэгчид хэрэгжүүлнэ. Тэргүүлэгчид нь аймаг, нийслэлд дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс, хошуу, хороо, баг, хоринд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрэлдэнэ~~. /4-р төслийн 63.4-өөс/
- ~~Аймаг, нийслэл, хошуу, хорооны өөрөө удирдах байгууллага нь тухайн аймаг, нийслэл, хошуу, хорооны Хурал байна~~. /2-р төслийн 69.1-ээс/
- ~~Аймаг, нийслэл, хошуу, хорооны Хурал нь төлөөлөгчдөөс бүрдэнэ~~. /2-р төслийн 70.1-ээс/
- ... ~~Хурлын гишүүнийг тухайн аймаг, нийслэл, хошуу, хорооны нутаг дэвсгэрт оршин суугаа сонгуулийн эрх бүхий иргэд нийтээр, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж 4 жилийн хугацаагаар сонгоно~~. /1-р төслийн 63-аас/
- ~~тухайн аймаг, нийслэл, хошуу, хорооны эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиглэл, төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батална~~; /2-р төслийн 73.1.1-ээс/
- ~~төрийн өмчид үндэслэн шууд харъяа үйлдвэрийн газар, байгууллагын үйл ажиллагааг чиглүүлнэ~~; /2-р төслийн 73.1.2-ээс/
- ~~дээд шатны байгууллагын харъяа болон улсын чанартай үйлдвэрийн газар, байгууллага хууль хэрхэн биелүүлж байгааг харьяалал харгалзахгүйгээр хянан шалгана~~; /2-р төслийн 73.1.3-аас/
- ~~тухайн нутаг дэвсгэр дэх иргэдийн хоршоолол, олон нийтийн байгууллагын үйл ажиллагааг хуулийн хүрээнд зохицуулна~~. /2-р төслийн 73.1.4-өөс/
- ~~өөрийн харьяа захиргааны байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавьж, тэдгээрийн тайланг хянан хэлэлцэнэ~~. /1-р төслийн 66.5-аас/
- ~~Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын эрх хэмжээ, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно~~. /4-р төслийн 66.4-өөс/
- ~~Хурлын тогтоол, Засаг даргын захирамж хуульд харшилбал, Хурал, Засаг дарга өөрөө буюу дээд шатны байгууллага, албан тушаалтан хүчингүй болгоно~~. /2-р төслийн 74.3-аас/
- ~~Аймаг, нийслэл, хошуу, хорооны Засаг даргын ажлын алба нь тамгын газар мөн~~. /2-р төслийн 75-аас/
- ~~Монголын Улсын Их хурал, Засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэнд хамаарах зарим асуудлыг аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад гүйцэтгүүлэхээр шилжүүлж болно~~. /2-р төслийн 76-аас/
- ~~Багийн өөрөө удирдах байгууллага бол тухайн багийн Иргэдийн Хурал мөн. Иргэдийн Хурал тухайн багийн амьдралын чухал асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ~~. /2-р төслийн 77.1-ээс/
- ~~Багийн өдөр тутмын ажлыг багийн Засаг дарга удирдана. Түүнийг тухайн багийн Иргэдийн хурлаас нэр дэвшүүлж хошууны Засаг дарга 4 жилийн хугацаагаар томилно~~. /2-р төслийн 77.2-оос/
- ~~Монгол улсын засаг захиргааны нэгж, түүний удирдлагын бүрэн эрх, чиг үүрэг, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Монгол улсын нутгийн захиргааны хуулиар тогтооно~~. /2-р төслийн 78.1-ээс/

UIH.MN СУДАЛГААНЫ САН

### V БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

- ~~Үндсэн хуулийн шүүхийн гишүүдийн гуравны нэгийг 3 жил тутамд энэ зүйлд заасан журмаар шинэчилнэ.~~ /3-р төслийн 51.2-оос/
- ~~Монгол улсын Ерөнхийлөгч байсан хүн хэрэв хэрэгт холбогдон огцроогүй бол 65 нас хүртэл Улсын их цаазын цэцийн гишүүн байж болно.~~ /2-р төслийн 63.6-аас/
- ~~Монгол улсын Их цаазын цэц нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрын хоорондын эрх хэмжээний талаар гарсан маргааныг хянан шийдвэрлэнэ.~~ /2-р төслийн 64.3-аас/
- ~~Их цаазын цэц төрийн дээд байгууллагууд, дээд албан тушаалтны үйл ажиллагаанд холбогдсон бусад асуудлыг Улсын Их хурал, Ерөнхийлөгчийн хүсэлтээр хянан үзэж дүгнэлт гаргаж болно.~~ /2-р төслийн 64.5-аас/
- ~~Үндсэн хуулийн шүүх эрх хэмжээнийхээ асуудлыг таваас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.~~ /3-р төслийн 52.5-аас/
- **...** ~~Тэдгээрийг төр, нам, олон нийтийн бүх байгууллага, албан тушаалтан хүн бүр дагаж биелүүлэх үүрэгтэй.~~ /3-р төслийн 53.1-ээс/
- ~~Үндсэн хуулийн шүүхээс Үндсэн хуулийн талаар гаргасан тайлбар уул хуулийнхаа нэгэн адил хүчинтэй бөгөөд хэрэв Улсын Их Хурлын болон Үндсэн хуулийн шүүхийн тайлбар хоорондоо зөрчилдвөл Үндсэн хуулийн шүүхийн тайлбарыг дагаж мөрдөнө.~~ /3-р төслийн 53.2-оос/

## 2. ӨӨРЧЛӨГДСӨН ХЭСГҮҮД

| ***Үндсэн хуулийн төслүүд*** | ***Үндсэн хууль*** |
|---|---|
| II БҮЛЭГ. ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ | |
| иргэн бүр хууль ба шүүхийн өмнө эрх тэгш байна. /2-р төслийн 19.14/ | Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. /Үндсэн хуулийн 14./ |
| III БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛ | |
| НЭГ. Монгол Улсын Их Хурал | |
| Монгол Улсын Их Хурал нь нэг танхимтай байнгын ажиллагаатай байх бөгөөд **75** гишүүнээс бүрдэнэ. /2-р төслийн 23.1/ | Улсын Их Хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна. /Үндсэн хуулийн 21.1/ |
| Улсын Их Хурлын гишүүнээр Монгол улсын **30 нас** хүрсэн иргэнийг сонгож болно. /3-р төслийн 21.3/ | Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын **25** нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно. /Үндсэн хуулийн 21.3/ |
| Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу Ерөнхийлөгчийн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болох боловч ээлжит бус сонгуулиар шинэ сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд тангараг өргөтөл бүрэн эрхээ эдэлнэ. /4-р төслийн 22.2/ | Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно. Ийнхүү тарах шийдвэр гаргасан бол шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ эдэлнэ. /Үндсэн хуулийн 22.2/ |
| • ~~Монгол~~ Улсын Их Хурлын даргын бүрэн эрхийн хугацаа **6 жил** байна. /2-р төслийн 26.2/<br>• Улсын Их Хурлын дарга, дэд дарга, ~~нарийн бичгийн даргын~~ бүрэн эрхийн хугацаа **4 жил** байх бөгөөд тэднийг хуульд заасан үндэслэлээр хугацааны нь өмнө чөлөөлж, огцруулж болно. /3-р төслийн 24.2/<br>• Улсын Их Хурлын дарга, дэд даргын бүрэн эрхийн хугацаа **3 жил** байх хийгээд хуульд заасан үндэслэлээр хугацаанаас нь өмнө чөлөөлж, огцруулж болно. /4-р төслийн 24.2/ | 2. Улсын Их Хурлын дарга, дэд даргын бүрэн эрхийн хугацаа **4** жил байх бөгөөд хуульд заасан үндэслэлээр хугацаанаас нь өмнө чөлөөлж, огцруулж болно. /Үндсэн хуулийн 24.2/ |

| | |
|---|---|
| Улсын Их Хурлын гишүүдийн олонхийн шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын даргын санаачилгаар ээлжит бус чуулган хийж болно./3-р төслийн 27.3/ | Улсын Их Хурлын гишүүдийн гуравны нэгээс дээшхийн шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргын санаачилгаар ээлжит бус чуулган чуулж болно. /Үндсэн хуулийн 27.3/ |
| Улсын Их Хурлын нийт гишүүний **75 хувиас доошгүй** нь хүрэлцэн ирсэн бол чуулганы хүчинтэйд тооцож, ~~Улсын Их цаазад нэмэлт, өөрчлөлт оруулахаас бусад~~ асуудлыг чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ. /2-р төслийн 29.5/ | Үндсэн хууль, бусад хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нийт гишүүний дийлэнх олонхи нь хүрэлцэн ирснээр чуулганы хүчинтэйд үзэж, чуулганд оролцсон нийт гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. /Үндсэн хуулийн 27.6/ |
| ХОЁР. Монгол Улсын Ерөнхийлөгч | |
| • Ерөнхийлөгчөөр **40 нас** хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол улсын ~~гурваас доошгүй үеийн~~ уугуул иргэнийг 4 жилийн хугацаагаар сонгоно./3-р төслийн 30.2/<br>• Ерөнхийлөгчөөр **50 нас** хүрсэн, сүүлийн 5-аас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг 4 жилийн хугацаагаар сонгоно. /4-р төслийн 30.2/ | Ерөнхийлөгчөөр **45** нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг 4 жилийн хугацаагаар сонгоно. /Үндсэн хуулийн 30.2/ |
| Улсын Их Хуралд суудал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид нэжгээд хүний нэр дэвшүүлнэ /4-р төслийн 31.2/ | Улсын Их Хуралд суудал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлнэ. /Үндсэн хуулийн 31.2/ |
| Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү сонгогчдын олонхийн санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр хүнийг **2 дахь шатны сонгууль буюу Улсын Их Хуралд оруулан хэлэлцэж чуулганд оролцсон гишүүдийн саналыг нууцаар хураана**. /4-р төслийн 31.5/ | Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү сонгогчдын олонхийн санал аваагүй бол анхны санал хураалтад оролцсон нийт сонгогчийн хамгийн олон санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулна. /Үндсэн хуулийн 31.5/ |
| Улсын Их Хурлын чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон хэмээн үзнэ. /4-р төслийн 31.6/ | Дахин санал хураалтаар сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана. /Үндсэн хуулийн 31.6/ |
| Ерөнхийлөгч өргөсөн тангаргаасаа няцаж Улсын Их цааз, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Улсын Их цаазын цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурал шүүн хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар түүнийг огцруулж болно /2-р төслийн 39.2/ | Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна. /Үндсэн хуулийн 35.2/ |
| ГУРАВ. Монгол Улсын Засгийн газар | |
| Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа **6 жил** байна. /4-р төслийн 40.1/ | Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа **4** жил байна. /Үндсэн хуулийн 40.1/ |
| Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн гуравны нэг нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно /2-р төслийн 48.2/ | Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно./Үндсэн хуулийн 43.2/ |
| Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрыг огцруулах тухай санал гаргавал Улсын Их Хурал санаачилгаараа хэлэлцэж болно. /4-р төслийн 43.3/ | Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Засгийн газрыг огцруулах тухай саналыг албан ёсоор тавьбал Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ. /Үндсэн хуулийн 43.4/ |

| ДӨРӨВ. Шүүх эрх мэдэл | |
|---|---|
| Шүүхийн үндсэн тогтолцоо Их цаазын цэц, Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, хошуу, хорооны шүүхээс бүрдэх... /4-р төслийн 48.1/ | Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх... /Үндсэн хуулийн 48.1/ |
| • Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч болон шүүгчийг Улсын Их Хурал танилцуулан зөвшөөрөлцсөнөөр Улсын Ерөнхийлөгч хугацаагүй томилно /1-р төслийн 53/<br>• Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч болон шүүгчдийг Улсын Их Хурал танилцуулан зөвшөөрөлцсөнөөр Ерөнхийлөгч 12 жилийн хугацаагаар томилно. /2-р төслийн 56.2/<br>• Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын Их Хуралд танилцуулан зөвшөөрөлцсөнөөр, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. /2-р төслийн 55.2/ | Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно**.** / Үндсэн хуулийн 51.2/ |
| • Улсын Дээд шүүхийн шүүгчээр хууль зүйн дээд боловсролтой, шүүн таслах ажлын дадлага бүхий **30 нас** хүрсэн, Монгол Улсын иргэнийг томилж болно /2-р төслийн 56.3/<br>• Улсын Дээд Шүүхийн шүүгчээр хууль зүйн дээд боловсролтой, **10**-аас доошгүй жил шүүн таслах ажил эрхэлсэн, **35 нас** хүрсэн, бусад шүүхийн шүүгчээр хууль зүйн боловсролтой, 3-аас доошгүй жил хууль хамгаалах байгууллагад мэргэжлээрээ ажилласан, 25 нас хүрсэн, Монгол улсын иргэнийг томилж болно. /3-р төслийн 55.3/ | Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр;<br><br>хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, Монгол Улсын 25 нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно. /Үндсэн хуулийн 51.3/ |
| • Улсын Ерөнхий хууль сахиулагчийг Монгол улсын Ерөнхийлөгч, Шүүхийн ерөнхий зөвлөлтэй зөвшилцсөнөөр 6 жилийн хугацаатайгаар томилно. /2-р төслийн 61.3/<br>• Прокурорын байгууллагыг Улсын Ерөнхий прокурор тэргүүлэх бөгөөд түүнийг Ерөнхийлөгчийн саналаар Улсын Их Хурал, Ерөнхий прокурорын орлогч нарыг түүний саналаар Ерөнхийлөгч, ~~доод шатны прокурорыг Улсын Ерөнхий прокуро~~р тус тус 6 жилийн хугацаагаар томилно. /3-р төслийн 60.4/ | Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч 6 жилийн хугацаагаар томилно. /Үндсэн хуулийн 56.2/ |
| IV БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА,<br>НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА | |
| Монгол улсын нутаг дэвсгэр ~~нь~~ засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь хошууд~~ад~~**, хошуу нь багт, нийслэл нь хороод**~~од~~**,** хороод нь хоринд хуваагдана./3-р төслийн 61.1/ | Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд**,** сум нь багт, нийслэл нь дүүрэгт**,** дүүрэг нь хороонд хуваагдана./Үндсэн хуулийн 57.1/ |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | |
|---|---|
| Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, хошуу, хороо, баг, хорины Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; хошуу, хорооны Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорины Засаг даргыг харьяалах хошуу, хорооны Засаг дарга тус тус **3 жилийн хугацаагаар** томилно./4-р төслийн 64.2/ | Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно. /Үндсэн хуулийн 60.2/ |
| Ерөнхий сайд буюу ~~аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн~~ нэгжийн Засаг дарга нь тухайн нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг ёсоор болгон томилохоос татгалзвал дээр заасан журмаар дахин нэр дэвшүүлж томилох бөгөөд энэ хугацаанд ~~аймаг, нийслэлийн~~ Засаг дарг~~ын үүргийг~~ Ерөнхий сайдын томилсон төлөөний сайд, хошуу, хорооны Засаг даргыг зохих аймаг, нийслэлийн Засаг даргын томилсон төлөөний түшмэл гүйцэтгэнэ. /2-р төслийн 71.4/ | Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн Засаг дарга доод шатныхаа нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар дахин нэр дэвшүүлж томилтол өмнөх Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална. /Үндсэн хуулийн 60.3/ |
| V БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ | |
| • Монгол улсын Их цаазын цэц **7 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Их цаазын цэцийн 3 гишүүнийг Улсын Их Хурал, 3 гишүүнийг Ерөнхийлөгч, 1 гишүүнийг Улсын дээд шүүх тус тус** томилно. Улсын Их цаазын цэцийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 9 жил байна. /1-р төслийн 72/<br>• Монгол улсын Их цаазын цэц **6 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Их цаазын цэцийн 2 гишүүнийг Улсын Их Хурал, 2 гишүүнийг Ерөнхийлөгч, 2 гишүүнийг Улсын дээд шүүх тус тус** 9 жилийн хугацаагаар томилно. /2-р төслийн 62.2/<br>• Үндсэн хуулийн шүүх нь 9 гишүүнээс бүрэлдэнэ. Үндсэн хуулийн шүүхийн 3 гишүүнийг Улсын Их Хурал, 3 гишүүнийг Ерөнхийлөгч 3 гишүүнийг Улсын дээд шүүх тус тус 9 жилийн хугацаагаар томилно. /3-р төслийн 50.1,2/ | Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно. /Үндсэн хуулийн 65.1/ |
| VI БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ | |
| ~~Монгол улсын~~ Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын чуулганд оролцсон нийт гишүүний наяас доошгүй хувийн саналаар батална. /3-р төслийн 69.1/ | Үндсэн хууль**,** түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар батална. /Үндсэн хуулийн 69.1/ |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

# ДЭЛХИЙН ЗАРИМ ОРНУУДЫН ТӨРИЙН ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА

*Г.Билгээ, Д.Жигваагүнсэл*

## УДИРТГАЛ

Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу дэлхийд Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий хэмжээгээр тэргүүлэгч 15 орон болон нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээгээр тэргүүлэгч 10 орны төрийн байгуулал, гүйцэтгэх засаглал, шүүх засаглалын талаарх мэдээлэл, эрх зүйн системийн аль бүлд хамаардаг тухай мэдээлэл лавлагаа бэлтгэв.

Судалгаанд төрийн байгууллын хувьд Үндсэн хуульт хаант засаглалтай-12 орон, Үндсэн хуульт парламентын засаглалтай-8 орон, Ерөнхийлөгчийн засаглалтай-5 орныг хамруулав.

**ДНБ-ийн хэмжээгээр тэргүүлэгч улсууд:**

| | | |
|---|---|---|
| 1. | Америк | Холбооны бүгд найрамдах, үндсэн хуульт ерөнхийлөгчийн засаглалтай улс |
| 2. | Хятад | Нэг намын тогтолцоотой, парламентын бүгд найрамдах улс |
| 3. | Япон | Парламентын засаглалтай үндсэн хуульт хаант улс |
| 4. | Герман | Парламентын засаглалтай холбооны улс |
| 5. | Франц | Үндсэн хуульт хагас ерөнхийлөгчийн засаглалтай бүгд найрамдах улс |
| 6. | Их Британи | Парламентын засаглалтай үндсэн хуульт хаант улс |
| 7. | Бразил | Ерөнхийлөгчийн засаглалтай холбооны бүгд найрамдах улс |
| 8. | Итали | Парламентын ардчилсан бүгд найрамдах улс |
| 9. | Орос | Хагас ерөнхийлөгчийн засаглалтай үндсэн хуульт холбооны улс |
| 10. | Энэтхэг | Парламентын бүгд найрамдах холбооны улс |
| 11. | Канад | Парламентын засаглалтай үндсэн хуульт хаант улс |
| 12. | Австрали | Үндсэн хуульт хаант засагтай, парламентын холбооны улс |
| 13. | Испани | Парламентын ардчилсан үндсэн хуульт хаант засаглалтай нэгдмэл улс |
| 14. | Өмнөд Солонгос | Парламентын бүгд найрамдах улс |
| 15. | Мексик | Ерөнхийлөгчийн засаглалтай холбооны бүгд найрамдах улс |

**Нэг хүнд ногдох ДНБ-ийн хэмжээгээр тэргүүлэгч улсууд:**

| | | |
|---|---|---|
| 16. | Катар | Үндсэн хуульт хэмжээгүй эрхт хаант засагтай улс |
| 17. | Люксембург | Үндсэн хуульт эзэн хаант парламентын ардчилсан улс |
| 18. | Сингапур | Парламентын бүгд найрамдах нэгдмэл улс |
| 19. | Бруней | Үндсэн хуульт хаант улс |
| 20. | Кувейт | Үндсэн хуульт хаант улс |
| 21. | Норвеги | Үндсэн хуульт хаант засаглалтай нэгдмэл улс |
| 22. | Арабын НЭУ | Үндсэн хуульт хаант улс |
| 23. | Сан Марино | Парламентын засаглалтай бүгд найрамдах улс |
| 24. | Швейцарь | Парламентын засаглалтай холбооны улс |
| 25. | Саудын Араб | Үндсэн хуульт хаант улс |

Эрх зүйн бүлийн хувьд судалгаанд хамрагдсан 25 орны дийлэнх нь буюу 11 орон Ром-Германы эрх зүйн бүлд, 6 орон Англи-Саксоны эрх зүйн бүлд, 3 орон Исламын Шариатын эрх зүйн бүлд хамаарах ба бусад нь холимог эрх зүйн системтэй, социалист, Скандинавын эрх зүйн бүлд тус тус хамаарч байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | |
|---|---|
| Ром-Германы эрх зүйн бүлд: | Герман, Франц, Бразил, Итали, ОХУ, Испани, Өмнөд Солонгос, Мексик, Люксембург, Швейцарь |
| Англи-Саксоны эрх зүйн бүлд: | АНУ, Англи, Энэтхэг, Канад, Австрали, Сингапур |
| Исламын Шариатын эрх зүйд тулгуурласан: | Катар, Кувейт, Саудын Араб |
| Холимог эрх зүйн системтэй: | Япон, Бруней |
| Социалист: | БНХАУ |
| Скандинавын эрх зүйн бүлд: | Норвеги |

Судалгааны мэдээллийг бэлтгэхдээ С.Нарангэрэлийн "Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо"[99] ,Д.Баярсайханы "Эрх зүйн онол"[100] ,УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргасан "Дэлхийн улс орнуудын парламент"[101] энциклопеди ном болон дэлхийн улс төрийн тогтолцооны гарын авлага "Төр улсуудын засгийн газар"[102] зэрэг эх сурвалжуудыг голлон ашиглав.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

99Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001.
100Баярсайхан Д. Эрх зүйн онол. УБ., 2006.
101Дэлхийн улс орнуудын парламент. УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргасан. УБ., 2010 он.
102Төр улсуудын засгийн газар (Дэлхийн улс төрийн тогтолцооны гарын авлага). Монсудар хэвлэлийн газар. 2011.

## 1. АМЕРИК

| | |
|---|---|
| Албан ёсны нэр: | Америкийн Нэгдсэн Улс |
| Хүн ам: | 281,4 сая |
| Нийслэл: | Вашингтон |
| Нутаг дэвсгэр: | 9,626,091 $км^2$ |
| Тусгаар тогтносон он: | 1776 |
| Үндсэн хууль баталсан он: | 1787 |
| Засаг захиргааны нэгж: | 50 муж улс, Колумбын холбооны тойрог |
| Харьяа газар нутаг: | Самао, Бэйкэр арал, Гуам, Ховландын арал, Жарвисын арал, Жонстон Атол, Кингман Рийф, Мидвэй арлууд, Навассын арлууд, хойд Марианы арлууд, Палмира атол, Пуэрто Рико, Виржиний арлууд, Вэйк арал |
| Эрх зүйн бүл: | Англи-Саксоны[103] |

### ТӨРИЙН ТОГТОЛЦОО

| ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ | ШҮҮХ ЗАСАГЛАЛ |
|---|---|---|
| **Конгресс**<br>Хоёр танхимтай.<br><br>➢ **Сенат**<br>Дээд танхим нь бүх нийтийн сонгуулиар 6 жилийн хугацаагаар сонгогдсон 100 гишүүнтэй. Муж улс бүрээс 2 гишүүн сонгогддог ба 2 жил тутам 1/3 нь шинээр сонгогдоно. 16 байнгын хороотой.<br><br>➢ **Төлөөлөгчдийн танхим**<br>Доод танхимын 435 гишүүдийг 2 жилийн хугацаатайгаар бүх нийтийн сонгуулиар сонгоно. Танхим 21 мэргэжсэн байнгын хороотой.<br><br>**Муж улсуудын засаг захиргаа**<br>50 муж улс, 1 холбооны тойрог, хилийн чанад дахь 14 газар нутагтай. Хууль тогтоох хоёр танхимын гишүүдийг бүх нийтийн сонгуулиар сонгоно. Муж улсуудын гүйцэтгэх засаглалыг захирагчид захирна. | **Ерөнхийлөгч**<br>Муж улс болгоноос шууд сонгогдсон сонгогчдоос бүрдсэн Сонгогчдын коллегийн саналаар 4 жилийн хугацаатай сонгогдох бөгөөд нэг удаа улиран сонгогдох эрхтэй. Тэрээр төр, засгийн тэргүүн бөгөөд зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.<br><br>➢ **Дэд Ерөнхийлөгч**<br>Ерөнхийлөгчийн адил жишгээр 4 жилийн хугацаатай сонгогдох ба тэрээр гүйцэтгэх засаглалын бодлогыг хэрэгжүүлэхэд Ерөнхийлөгчид тусална.<br><br>➢ **Сайд нарын танхим**<br>Танхимын 15 гишүүнийг Ерөнхийлөгч томилж, Сенат батална.<br><br>➢ **Гүйцэтгэх агентлагууд**<br>Гүйцэтгэх засаглалын хамгийн чухал салбар бөгөөд Конгрессоос эрх, үүргийг тодорхойлдог. | **Дээд шүүх**<br>9 гишүүнийг бүх насаар нь Ерөнхийлөгч томилж, Сенат батална. Дээд шүүх нь холбооны ба муж улсуудын хууль, шүүхэд хяналт тавих, шүүхийн эцсийн шатны шийдвэрийг гаргах шүүхийн дээд байгууллага. Түүнчлэн бодлого боловсруулагчид, тодорхой зэрэг дэвт хамааралтай аливаа асуудлыг хуулийн үүднээс хянан шалгах үүрэгтэй.<br><br>➢ **Нэгдсэн улсын давж заалдах шүүх**<br>Муж улс бүрт байх ба холбооны шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.<br><br>➢ **Нэгдсэн улсын тойргийн шүүх**<br>Холбооны анхан шатны шүүхүүд хамаарна.<br><br>➢ **Муж улсын шүүх**<br>Муж улсуудын Үндсэн хуулийн дагуу мужийн шүүгчид удирдана.<br><br>➢ **Анхан шатны шүүх**<br>Тойргийн шүүхийг удирдана. |

[103]Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 227 дахь тал.

## 2. ХЯТАД

| | |
|---|---|
| Албан ёсны нэр: | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| Хүн ам: | 1,29 тэрбум |
| Нийслэл: | Бээжин |
| Нутаг дэвсгэр: | 9,596,960 км$^2$ |
| Тусгаар тогтносон он: | МЭӨ 221 |
| Үндсэн хууль баталсан он: | 1982 |
| Засаг захиргааны нэгж: | 23 муж, 5 автономит улс, 4 бие даасан хот |
| Харьяа газар нутаг: | Байхгүй |
| Эрх зүйн бүл: | Социалист[104] |

### ТӨРИЙН ТОГТОЛЦОО

| ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ | ШҮҮХ ЗАСАГЛАЛ |
|---|---|---|
| **Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал**<br><br>Нэг танхимтай. ХКН[105]-ын төлөвлөгөөг хэлэлцэнэ. 5 жил тутамд бүх Хятад, АЧА[106]-аас сонгогдсон 2,900-гаад гишүүдтэй, саяханаас илүү бие даах болсон. Төрийн бодлого боловсруулах, төсөв батлах, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, өндөр тушаалын түшмэдийг томилно. Ихэнх нь ХКН-ын гишүүд байна.<br><br>➢ **Байнгын хороо**<br><br>160-аад гишүүдтэй. Тогтмол хуралдана. Хууль санаачлах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулдаг ч голдуу намын боловсруулсан хуулийн төслийг баталдаг. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах эрхтэй.<br><br>**Муж, орон нутгийн засаг захиргаа**<br><br>• Муж, хот, жижиг хотын АИХ[107]-ын төлөөлөгчдийг түүнээс доод шатны АИХ-ын сонгуулиар сонгох ба Төв Засгийн газраас шууд хамааралтай.<br>• Сонгогдсон дарга, захирагч нар хотыг захирна. | **БНХАУ-ын дарга** буюу төрийн тэргүүнийг ХКН-аас нэр дэвшүүлж, БХАТИХ-аар батлан 5 жилийн хугацаатай томилдог бөгөөд нэг л удаа улируулан сонгодог. Тэрээр ХКН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, ХКН-ын Цэргийн зөвлөлийн даргын үүргийг гүйцэтгэх ба өршөөлийн зарлиг гаргах, дайн зарлах болон Ерөнхий сайдыг томилох эрхтэй.<br><br>➢ **Орлогч дарга**<br><br>➢ **Ерөнхий сайд** нь Төрийн зөвлөл буюу Засгийн газрын тэргүүн бөгөөд БХАТИХ-аас томилогдоно.<br><br>➢ **Төрийн зөвлөл** нь БХАТИХ-аас сонгон томилсон Ерөнхий сайд, Орлогч дарга, Төрийн зөвлөхүүд, яамдын сайд нар, зөвлөлийн тэргүүн нар, Ерөнхий аудитор, Ерөнхий нарийн бичгийн дарга зэрэг хариуцлагатай албан тушаалтнуудаас бүрдэнэ. | **Ардын дээд шүүхийн** ерөнхий шүүгчийг БХАТИХ-аас томилдог ба нэг л удаа улируулан томилно. Бусад шүүгчдийг БХАТИХ-ын Байнгын хороо томилно. Энэ бол давж заалдах шатны эцсийн шүүх байгууллага. Нам төрийн зорилгод хамааралтай байж, дотроо гэмт хэрэг, иргэний хэрэг, эдийн засгийн хэргийн салбаруудтай.<br><br>➢ **Ардын дээд прокурорын газар** нь шүүх ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэхийг хянах үүрэгтэй.<br><br>➢ **Ардын доод шатны шүүх** нь Ардын дээд шүүх, Ардын дунд шүүх, Ардын үндсэн шүүхээс бүрддэг ба доод шатны прокурорын газар нь дотроо иргэний, гэмт хэргийн, засаг захиргааны, эдийн засгийн салбаруудтай.<br><br>➢ **Ардын тусгай шүүх буюу Цэргийн шүүх** нь цэргийн гэмт хэрэг шийдвэрлэнэ. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[104] Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 302 дахь тал.
[105] ХКН – Хятадын коммунист нам
[106] АЧА – Ардын чөлөөлөх арми
[107] АИХ – Ардын их хурал

## 3. ЯПОН

| | |
|---|---|
| Албан ёсны нэр: | Япон |
| Хүн ам: | 127,3 сая |
| Нийслэл: | Токио |
| Нутаг дэвсгэр: | 377,835 км$^2$ |
| Тусгаар тогтносон он: | МЭӨ 660 |
| Үндсэн хууль баталсан он: | 1947 |
| Засаг захиргааны нэгж: | 47 муж |
| Харьяа газар нутаг: | Байхгүй |
| Эрх зүйн бүл: | Холимог (Япон, Филиппиний)[108] |

## ТӨРИЙН ТОГТОЛЦОО

| ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ | ШҮҮХ ЗАСАГЛАЛ |
|---|---|---|
| **Үндэсний зөвлөл (**парламент**)**<br><br>нь хоёр танхимтай. Танхимуудын дунд маргаан гарвал Төлөөлөгчдийн танхим давуу эрхтэй.<br><br>➢ **Зөвлөхүүдийн танхим**<br><br>Нийт 242 гишүүнийг холимог системээр сонгоно. 142 гишүүнийг 62-10 мандат бүхий 47 тойргоос , үлдсэн 100 гишүүнийг үндэсний хэмжээнд нэг тойрог болгон тус тус сонгодог байна. Бүрэн эрхийн хугацаа 6 жил. 3 жил тутамд гишүүдийн хагас нь шинээр сонгогддог.<br><br>➢ **Төлөөлөгчдийн танхим**<br><br>4 жилийн хугацаатай сонгогдсон 480 гишүүдтэй. Төлөөлөгчдийн танхимыг хугацаанаас нь өмнө татан буулгах эрх зүйн зохицуулалт бий. Тус танхимын нийт гишүүдийн 300 нь сонгуулийн тойргоос нэг суудлын төлөө өрсөлддөг бол бусад 180 гишүүн нь намын жагсаалтын системээр 11 мужуудаас сонгогдоно.<br><br>**Орон нутгийн засаг захиргаа**<br><br>• Захирагч буюу Мэрүүдийг сонгодог<br>• Өөрсдийн чуулгантай. | **Эзэн хаан**<br><br>Угсаа залгамжлагч, төрийн тэргүүн бөгөөд гүйцэтгэх засаглалыг удирдахгүй. Түүний хязгаарлагдмал эрх мэдэл Зөвлөлийн болон Сайд нарын танхимын зөвшөөрлөөр хэрэгжинэ. Тэрээр Ерөнхий сайд, Ерөнхий шүүгч, Сайд нарын танхимын гишүүдийг томилж, Үндсэн хуульд өөрчлөлт, засвар оруулахыг зарлах, Төлөөлөгчдийн танхимыг тараах, Үндэсний зөвлөлийг зарлан хуралдуулах эрхтэй.<br><br>**Ерөнхий сайд**<br><br>Тэргүүнийг ихэвчлэн Төлөөлөгчдийн танхимд олонх болсон нам, эвслийн гишүүдээс Үндэсний зөвлөлийн нууц санал хураалтаар сонгоно. Тэрээр өөрийн танхимын гишүүдийг сонгож, Эзэн хаан 4 жилийн хугацаатай томилдог.<br><br>➢ **Сайд нарын танхим**<br><br>Ерөнхий сайд даргалж, Үндсэн хуулийн дагуу 14 гишүүнийг томилох ба тэдний гурвыг нь тусгай гишүүдээр томилж болно. Ерөнхий сайд хүсвэл гишүүдийн талыг нь Зөвлөлөөс томилно. | **Дээд шүүх**<br><br>Шүүх засаглалын дээд байгууллага. Ерөнхий шүүгчийг Эзэн хаан Танхимын санал болгосноор томилдог. Бусад 14 шүүгчийг Танхимаас сонгоно. Дээд шүүхийн шүүгчид Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хэрэгжилт, гүйцэтгэх засаглалын дүрэм, журам, тогтоолуудад шүүх засаглалын зүгээс хяналт тавих эрхтэй. Доод шатны шүүхийг баталгаажуулах, гарсан шийдвэрийг Үндсэн хуулинд нийцүүлэн эцсийн шийдвэрийг гаргана.<br><br>➢ **Танхимын дээд шүүх**<br>Бүрэлдэхүүнд нь 8 шүүгч орох ба тэднийг Дээд шүүхийн дэвшүүлсэн саналын дагуу Сайд нарын танхим томилно. Тэд анхан шатны шүүхийн биелэлтийг хариуцна.<br><br>➢ **Гэр бүлийн шүүх**<br>50 дүүрэг ба гэр бүлийн шүүхийн шүүгчдийг Дээд шүүхийн саналын дагуу Сайд нарын танхим томилно. Тэд иргэний ба эрүүгийн хэргийн шийдвэр, тухайлбал хөнгөн ба хүнд шийтгэл, торгууль, бусад нэхэмжлэл, заргыг хамтдаа барагдуулах үүрэгтэй.<br><br>➢ **Дүгнэлтийн шүүх**<br>438 шүүхтэй бөгөөд шүүгчдийг нь Дээд шүүхийн саналаар Сайд нарын танхим томилно. |

[108]Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 302 дахь тал.

## 4. ГЕРМАН

Албан ёсны нэр: Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
Хүн ам: 82 сая
Нийслэл: Берлин
Нутаг дэвсгэр: 357,021 км$^2$
Тусгаар тогтносон он: 1871
Үндсэн хууль баталсан он: 1949
Засаг захиргааны нэгж: 16 холбооны муж
Харьяа газар нутаг: Байхгүй
Эрх зүйн бүл: Ром-Германы[109]

### ТӨРИЙН ТОГТОЛЦОО

| ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ | ШҮҮХ ЗАСАГЛАЛ |
|---|---|---|
| **Холбооны парламент**<br><br>Хоёр танхимтай.<br><br>➢ **Бундесрат**<br><br>Парламентын дээд танхим бөгөөд 16 муж улсуудын Засгийн газруудаас сонгогдсон 69 төлөөлөгчидтэй, муж улс бүр 3-6 төлөөлөгчдийг томилно.<br><br>➢ **Бундестаг**<br><br>Парламентын доод танхим бөгөөд 4 жилийн хугацаатай сонгогдсон 662 гишүүнтэй. Бундестаг Германы Канцлерыг 4 жилийн хугацаатай сонгон томилдог.<br><br>**Орон нутгийн засаг захиргаа**<br><br>16 муж улсын засаг захиргаа нь тус бүрдээ сонгогдсон хууль тогтоох байгууллагатай. | **Канцлер**<br><br>Засгийн газрын тэргүүнийг Ерөнхийлөгчийн санал болгосноор Бундестагаас сонгож, Ерөнхийлөгч томилно. Канцлер нь Танхимынхаа сайд нарыг санал болгон, дотоодын улс төрийн бодлогыг хэрэгжүүлдэг. Ерөнхийлөгчид санал зөвлөмж өгдөг.<br><br>**Ерөнхийлөгч**<br><br>Холбооны Ерөнхийлөгч нь Холбооны хурлаас 5 жилийн хугацаатай сонгогдоно. Холбооны хурал нь Бундестагийн гишүүд, түүнтэй тэнцүү тооны муж улсын төлөөлөгчдөөс бүрдсэн онцгой байгууллага бөгөөд гагцхүү Холбооны Ерөнхийлөгчийг сонгох эрхтэй. Ерөнхийлөгч нь билэг тэмдгийн шинжтэй ба тэрээр олон улсын гэрээ батлах ба гадаадад эх орноо төлөөлдөг.<br><br>➢ **Танхим**<br><br>Танхим нь Канцлер болон холбооны сайдуудаас бүрдэнэ. Танхимын гишүүдийг Канцлерийн санал болгосноор Ерөнхийлөгч томилно. | **Холбооны Үндсэн хуулийн шүүх**<br><br>Холбооны шүүх болон бусад гишүүдээс бүрдэнэ. Шүүгчдийг Бундестаг болон Бундесратаас тэнцүү тоогоор сонгоно. Холбооны Үндсэн хуулийн шүүх нь Холбооны Үндсэн хуультай холбоотой бүх маргааныг шийдэх эрхтэй. Муж улсууд нь өөрсдийн Үндсэн хуулийн шүүхтэй бөгөөд энэ нь өөрийн Үндсэн хуульд хамараах, түүнийг зөрчиж эсэх маргааныг шийдвэрлэдэг.<br><br>➢ **Холбооны шүүх**<br><br>➢ **Муж улсуудын шүүх** |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[109]Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 240 дэх тал.

## 5. ФРАНЦ

| | |
|---|---|
| Албан ёсны нэр: | Бүгд Найрамдах Франц Улс |
| Хүн ам: | 547,030 сая |
| Нийслэл: | Парис |
| Нутаг дэвсгэр: | 547,030 км$^2$ |
| Тусгаар тогтносон он: | 486 |
| Үндсэн хууль баталсан он: | 1958 |
| Засаг захиргааны нэгж: | 22 муж |
| Харьяа газар нутаг: | 4 харьяа бүс, далайн чанад дахь 4 газар нутаг, тусгай статустай 2 газар нутаг |
| Эрх зүйн бүл: | Ром-Германы[110] |

## ТӨРИЙН ТОГТОЛЦОО

| ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ | ШҮҮХ ЗАСАГЛАЛ |
|---|---|---|
| **Парламент**<br><br>Хоёр танхимтай.<br><br>➢ **Сенат**<br><br>Дээд танхим нь шууд бус сонгогчдын коллегиос сонгогдсон 348 гишүүнтэй.<br><br>Сенатуудын 1/3 нь 3 жил тутамд шинээр сонгогдоно.<br><br>➢ **Үндэсний ассамблей**<br><br>Доод танхимын 577 гишүүн 5 жилийн хугацаатайгаар бүх нийтийн сонгуулиар сонгогдоно.<br><br>**Орон нутгийн засаг захиргаа**<br><br>• 22 муж<br>• засаг захиргааны 96 нэгжүүд нь яам тамгын газрын хэлтсүүд<br>• нутаг дэвсгэр болон хамтын нөхөрлөлийн үйл ажиллагааг хянана | **Ерөнхийлөгч**<br><br>7 жилийн хугацаатай сонгогдоно. 30 гаруй нэгж, харьяа нутаг дэвсгэрээс 500 гаруй дэмжигчийн гарын үсэгтэй санал цуглуулан албан ёсоор нэр дэвших эрхийг авна. Тэрээр олон улсын хэлэлцээр батлах, Ерөнхий сайдыг томилох, Үндэсний ассамблейг тараах бүрэн эрхтэй ба Сайд нарын зөвлөлийг тэргүүлэх, Шүүхийн дээд зөвлөлийг удирдах, Францын төрийн дээд албан тушаалтан.<br><br>**Ерөнхий сайд**<br><br>Засгийн газрын тэргүүн нь парламентад олонх болсон нам эвслээс нэр дэвшин сонгогдох ба Ерөнхийлөгч тодорхой бус хугацаагаар томилно. Ерөнхий сайд нь Засгийн газрыг удирдах ба түүний үүрэг хариуцлагыг тусган танхимын гишүүдийн зүгээс Ерөнхийлөгчид санал дэвшүүлнэ.<br><br>➢ **Сайд нарын танхим**<br><br>Танхимыг Ерөнхийлөгч даргалаж, Ерөнхий сайд тэргүүлнэ. 15 гүйцэтгэх агентлагуудаас бүрдэнэ. | **Дээд шүүх**<br><br>Шүүхийн дээд байгууллага ба шүүгчдийг Ерөнхийлөгч томилно. Дээд шүүх нь иргэний, эрүүгийн, нийгмийн, арилжааны, эдийн засгийн, санхүүгийн хуулийн хэргийг шүүх үндсэн 6 танхимд хуваагдана. Анхан шатны шүүхийн шийдвэр, дүгнэлтийг хянах, ямар нэгэн хуулийн хүрээнд хамаарах хэргүүдийг шүүн шийдвэрлэнэ.<br><br>➢ **Үндсэн хуулийн зөвлөл**<br><br>9 гишүүнтэй, Ерөнхийлөгчийг нь ээлжлэн сонгоно: Сенатын ерөнхийлөгч, Үндэсний ассамблейн ерөнхийлөгч тус тус 3 жилийн хугацаатай тэргүүлнэ.<br><br>Зөвлөл нь Ерөнхийлөгчийн, Парламентын сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх, дүнг нийтэд зарлах, Парламентаар хэлэлцэгдэж байгаа хуулийн төсөл, эсхүл шинээр батлагдсан хуулийг хянан үзэж Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах, хэрэв Үндсэн хуультай зөрчилдсөн тохиолдолд нийтлүүлэхийг хойшлуулах эрхтэй. |

[110]Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 240 дэх тал.

## 6. ИХ БРИТАНИ

| | |
|---|---|
| Албан ёсны нэр: | Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс |
| Хүн ам: | 59.5 сая |
| Нийслэл: | Лондон |
| Нутаг дэвсгэр: | 244.820 км$^2$ |
| Тусгаар тогтносон он: | 1707 |
| Үндсэн хууль баталсан он: | Тэмдэглэгдээгүй |
| Засаг захиргааны нэгж: | Англи-47 хот, Умард Ирланд-24 тойрог, Шотланд-32 зөвлөлийн муж, Уэльс-11 гүнгийн харьяат хот |
| Харьяа газар нутаг: | 15 газар нутаг |
| Эрх зүйн бүл: | Англи-Саксоны[111] |

### ТӨРИЙН ТОГТОЛЦОО

| ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ | ШҮҮХ ЗАСАГЛАЛ |
|---|---|---|
| **Парламент**<br><br>Хоёр танхимтай.<br><br>➢ **Лордын танхим**<br><br>670 гаруй гишүүнтэй, тэдний 92 нь угсаа залгамжлагч язгууртнууд, 26 нь хамба лам нар, 550 гаруй нь язгууртнууд байна. Засгийн газарт асуулт тавих, шүүмжлэн хэлэлцэх эрхтэй ба мөнгөний асуудлаас бусад хууль тогтоомжийг санаачлах, хууль тогтоомжийг 1 жил хүртэл хугацаагаар хойшлуулах эрхтэй.<br><br>➢ **Нийтийн танхим**<br><br>Бүх нийтийн сонгуулиар сонгогдсон 659 гишүүдийн 529 нь Англи, 72 нь Шотланд, 40 нь Уэльс, 18 нь Умард Ирландаас тус тус сонгогдоно. Бүрэн эрхийн хугацаа 5 жил. Танхим нь дангаараа хууль санаачлах, татвар, төсвийн зардлын тухай хуулийн төслийг танилцуулна.<br><br>**Мужуудийн парламент**<br><br>• Шотландын парламент-129 гишүүнтэй<br>• Умард Ирландын ассамблей-108 гишүүнтэй<br>• Уэльсийн Үндэсний ассамблей-60 гишүүнтэй | **Эзэн хаан**<br><br>Төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Английн сүмийн тэргүүн, угсаа залгамжилсан, бэлгэ тэмдгийн шинжтэй. Эзэн хаан олон улсын гэрээнд гарын үсэг зурах, парламент, шүүх байгууллагын зарим албан тушаалтныг томилох, Ерөнхий сайдтай 7 хоног тутам уулзах, парламентыг тараах эрхтэй.<br><br>**Ерөнхий сайд**<br><br>Парламентад олонхын суудалтай намын тэргүүн сонгогдох ба тэрээр Засгийн газрын тэргүүлж, гишүүдийг томилох, төрийн албаны үйл ажиллагааг удирдах үүрэгтэй.<br><br>**Сайд нарын танхим**<br><br>20 сайд, Засгийн газрын харьяа агентлагуудын дарга нараас бүрдэнэ. Ерөнхий сайд өөрийн танхимын гишүүдийн тоог яг нарийн тодорхойлж томилох ба тэд Парламентын гишүүд байх ёстой.<br><br>➢ **Засгийн газ**ар<br><br>Эх баригч намаас сонгогдсон 100 гаруй гишүүн буюу танхимын гишүүд, сайд нар, тэдний нарийн бичгийн дарга нар, шадарлагч, шадар туслахууд болон цөөн тооны язгууртануудаас бүрдэнэ. | **Үндсэн хуулийн асуудал хариуцсан газар**<br><br>Шүүх засаглалын дээд байгууллага. Английн эрх зүйн тогтолцоог шинэчлэх, Дээд шүүх байгуулах болон Шотланд, Уэльс, Умард Ирландын Үндэсний шүүх байгуулах ажлыг гүйцэтгэх зорилгоор саяхан байгуулагджээ.<br><br>➢ **Давж заалдах шүүх**<br><br>Эзэн хааны шүүхээс ирсэн эрүүгийн хэрэг, Дээд шүүх, мужийн шүүх, тусгай шүүхээс ирсэн гэмт хэргүүдийг хянан шийдвэрлэнэ.<br><br>➢ **Дээд шүүх**<br><br>Гэрээ хэлэлцээр, худалдаа, иргэний, зохиогчийн эрхийн хэргүүдийг шүүн таслана.<br><br>**Муж, дүүргийн шүүх**<br><br>Эзэн хааны шүүх, Мужийн шүүх, Зөвлөлийн шүүхийн шүүгчид удирдана. Шүүгчид нь газар, татвар, тэтгэвэр тэтгэмж, нийгмийн аюулгүй байдал, цагаачлалын асуудлаар гаргасан шийдвэрийг сонсох, шүүн хэлэлцэнэ. Шүүхийн томилгооны хорооноос шүүгчдийг томилох ба Шотланд, Умард Ирланд, Уэльсийн шүүхүүд нь бие даасан байна. |

[111] Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 227 дахь тал.

## 7. БРАЗИЛ

| | |
|---|---|
| Албан ёсны нэр: | Холбооны Бүгд Найрамдах Бразил Улс |
| Хүн ам: | 172,6 сая |
| Нийслэл: | Бразилиа |
| Нутаг дэвсгэр: | 8,456,503 км$^2$ |
| Тусгаар тогтносон он: | 1822 |
| Үндсэн хууль баталсан он: | 1988 |
| Засаг захиргааны нэгж: | 26 муж улс, 1 холбооны дүүрэг |
| Харьяа газар нутаг: | Байхгүй |
| Эрх зүйн бүл: | Ром-Германы[112] |

## ТӨРИЙН ТОГТОЛЦОО

| ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ | ШҮҮХ ЗАСАГЛАЛ |
|---|---|---|
| **Үндэсний Конгресс**<br><br>Хоёр танхимтай.<br><br>➢ **Төлөөлөгчдийн танхим**<br><br>513 суудалтай, гишүүд нь бүх нийтийн сонгуулиар муж, холбооны дүүрэг бүрээс 4 жилийн хугацаатай сонгогдоно. Муж улс бүрээс 8-60 хүртэлх төлөөлөгчдийг сонгоно.<br><br>➢ **Холбооны сенат**<br><br>81 суудалтай, муж улс, холбооны дүүрэг бүрээс 3 гишүүнийг бүх нийтийн сонгуулиар сонгоно. Гишүүд нь 8 жилийн хугацаатай сонгогдоно. Нийт гишүүдийн 1/3 нь 4 жил тутамд шинээр сонгогдоно.<br><br>**Орон нутгийн засаг захиргаа**<br><br>Муж улсууд тус бүр Чуулгантай. Захирагч нар муж улсуудыг удирдана. Түүнчлэн өөртөө засах хотын зөвлөлтэй. | **Ерөнхийлөгч**<br><br>4 жилийн хугацаатай бүх нийтийн сонгуулиар сонгогдох ба 1 удаа улируулан сонгох эрхтэй. Ерөнхийлөгч нь 35-аас дээш насны Бразил үндэстэн байна. Тэрээр төр, засгийн тэргүүн бөгөөд Холбооны сенатын зөвшөөрөлтэйгээр Төв Банкны захирал, Ерөнхий өмгөөлөгч, Дээд шүүхийн шүүгчид, элчин сайдууд зэрэг нийт 48.000 албан хаагчид, тушаалтнуудыг томилох эрх мэдэлтэй. Тэрээр зарлиг тогтоол гаргах, хууль санаачлах, хуулийг дэлгэрүүлэх эрхийг мөн эдэлнэ.<br><br>➢ **Дэд Ерөнхийлөгч**<br><br>Ерөнхийлөгчийн нэгэн адилаар бүх нийтийн сонгуулиар 4 жилийн хугацаатай сонгогдоно. Нэг удаа улиран сонгогдож болно. Тэрээр гүйцэтгэх засаглал, захиргааг удирдахад Ерөнхийлөгчид туслалцаа үзүүлнэ.<br><br>➢ **Сайд нарын Танхим**<br><br>Гишүүдийн тоо янз бүр байна. Ерөнхийлөгч танхимыг томилох, татан буулгах эрхтэй. | **Холбооны улсын дээд шүүх**<br><br>Шүүхийн дээд байгууллагын удирдлага нь хууль эрх зүй, Үндсэн хуулийн зохих сургалт дүүргэсэн, дадлага туршлагатай 11 шүүгчдээс бүрдэнэ. Шүүгчдийг Холбооны сенат нэр дэвшүүлж, Ерөнхийлөгч бүх насаар нь томилно.<br><br>➢ **Шударга ёсны дээд шүүх**<br><br>Засгийн газрын эсрэг үүсгэсэн шүүхийн тогтоол, гэмт хэргийн үндэслэлтэй хуулийн шийдвэрийг шүүн шийдвэрлэх байгууллага. Нийт 35 шүүгчдээс бүрдэнэ. Гишүүдийг Холбооны сенатаас батламжилсанаар Ерөнхийлөгч томилно.<br><br>➢ **Муж улсын шүүх**<br><br>Муж улс бүрийн нийслэлүүд болон Холбооны дүүрэг шүүхтэй байна. Орон нутгийн шүүхийн үйл ажиллагаанд хяналт тавина. Шүүх бүр хамгийн багадаа 7 шүүгчтэй байдаг. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[112] Дэлхийн улс орнуудын парламент. УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргасан. УБ., 2010 он. 265 дахь тал.

## 8. ИТАЛИ

| | |
|---|---|
| Албан ёсны нэр: | Бүгд Найрамдах Итали Улс |
| Хүн ам: | 57,5 сая |
| Нийслэл: | Ром |
| Нутаг дэвсгэр: | 301,230 км$^2$ |
| Тусгаар тогтносон он: | 1861.03.17 |
| Үндсэн хууль баталсан он: | 1948.01.01 |
| Засаг захиргааны нэгж: | 20 муж |
| Харьяа газар нутаг: | Байхгүй |
| Эрх зүйн бүл: | Ром-Германы[113] |

### ТӨРИЙН ТОГТОЛЦОО

| ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ | ШҮҮХ ЗАСАГЛАЛ |
|---|---|---|
| **Парламент**<br><br>Хоёр танхимтай ба танхимууд нь ижил тэнцүү эрхтэй. Аливаа хууль батлагдахдаа хоёр танхимаар хэлэлцэгдсэн байна.<br><br>➢ **Сенат**<br><br>Нийт 324 гишүүдтэй. Гишүүдийг пропорциональ системээр 5 жилийн хугацаатай сонгоно.<br><br>➢ **Төлөөлөгчдийн танхим**<br><br>Нийт 630 гишүүдтэй. Гишүүдийг пропорциональ системээр 5 жилийн хугацаатай сонгоно.<br><br>**Орон нутгийн засаг захиргаа**<br><br>Засаг захиргааны 5 автономит дүүрэг, 20 муж, 105 тойрогт сонгогдсон Зөвлөлүүд ажиллана. | **Ерөнхийлөгч**<br><br>Парламентаам 7 жилийн хугацаатайгаар сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч ба Парламентад хуулийн төслийг дахин хэлэлцүүлэхээр буцаах, Парламентын хоёр танхимыг тараах эрхтэй.<br><br>**Ерөнхий сайд**<br><br>Ерөнхийлөгч нэр дэвшүүлж, Парламент батална. Тэрээр Засгийн газрын тэргүүн ба Засгийн газрын хэрэгжүүлж буй бодлого, сайд нарын үйл ажиллагаанд хяналт тавих, зохицуулалт хийх эрхтэй.<br><br>➢ **Сайд нарын зөвлөл**<br><br>Сайд нарыг Ерөнхий сайдын зөвлөснөөр Ерөнхийлөгч нэрийг нь дэвшүүлж, Парламент батална. | **Дээд шүүх**<br><br>Италийн шүүх засаглалын хяналт тавих дээд байгууллага. Дээд шүүх нь доод, анхан шатны шүүхээс гаргасан дүрэм журамд дахин хяналт, тодотгол хийж иргэний ба эрүүгийн хэргийг шийдвэрлэх эрх мэдэлтэй. Бусад жирийн хэргүүдийн хувьд 10 хэсэгт буюу 6 эрүүгийн, 3 иргэний, 1 ажил эрхлэгчдийн маргааныг шүүн таслах шүүхэд хуваагдана.<br><br>➢ **Үндсэн хуулийн шүүх**<br><br>15 гишүүнийг 9 жилийн хугацаатайгаар сонгож, тэдний 1/3 хувийг нь Ерөнхийлөгч, 1/3 хувийг Парламент, 1/3 хувийг нь шүүх томилно. Үндсэн хуулийн шүүх нь ямар нэгэн хууль үндсэн хуультай зөрчилдөж байгааг батласан бол Ерөнхийлөгчийн дэмжлэгтэйгээр алдааг засаж, шийдвэрлэнэ.<br><br>➢ **Анхан шатны шүүх**<br><br>Иргэний, эрүүгийн хэргийн шүүгчдийг мэргэжлийн сонгон шалгаруулалтаар өрсөлдүүлэн авдаг ба хамгийн өндөр оноо авсан нь даргалах журамтай. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[113]Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 240 дэх тал.

## 9. ОРОС

| | |
|---|---|
| Албан ёсны нэр: | Оросын Холбооны Улс |
| Хүн ам: | 144,7 сая |
| Нийслэл: | Москва |
| Нутаг дэвсгэр: | 17,075,184 км$^2$ |
| Тусгаар тогтносон он: | 1991 |
| Үндсэн хууль баталсан он: | 1993 |
| Засаг захиргааны нэгж: | 21 бүгд найрамдах улс, 68 бусад засаг захиргааны нэгж |
| Харьяа газар нутаг: | Байхгүй |
| Эрх зүйн бүл: | Ром-Германы[114] |

## ТӨРИЙН ТОГТОЛЦОО

| ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ | ШҮҮХ ЗАСАГЛАЛ |
|---|---|---|
| **Холбооны хурал**<br><br>Хоёр танхимтай. Холбооны зөвлөл нь Төрийн Думын баталсан хуулийн төслийг хэрэгсэхгүй болгох эрхтэй. Дум тухайн хуулийн төслийг 2 дахь удаагаа хэлэлцэж дийлэнх олонхоор баталсан бол түүнд нэмэлт, өөрчлөлт оруулна.<br><br>➢ **Холбооны зөвлөл**<br><br>Дээд танхимд ОХУ-ын субъект нэг бүрээс 2 төлөөлөгч, субъектүүдын төрийн захиргаа, гүйцэтгэх байгууллагаас тус бүр 1 төлөөлөгчийг 4 жилийн хугацаатай сонгоно. Ерөнхийлөгчийн сонгуулийг зарлах, түүнийг огцруулах, хилийн өөрчлөлтийг батлах, Думаас гаргасан хуульд хориг тавих, батлах эрхтэй.<br><br>➢ **Төрийн Дум**<br><br>Доод танхимын 450 гишүүнийг 4 жилээр сонгоно. Тэдний хагас нь сонгуулийн тойргуудаас, хагас нь намын жагсаалтаар сонгогдоно. Засгийн газарт хяналт тавих, Төв банкны дарга, сайд нарыг томилох, үндэсний төсөв, хууль батлана.<br><br>**Орон нутгийн засаг захиргаа**<br><br>21 бүгд найрамдах улс, 68 муж, дүүргийг сонгогдсон мужийн Зөвлөл, Ерөнхийлөгч болон Захирагч нар удирдана. | **Ерөнхийлөгч**<br><br>Бүх нийтийн сонгуулиар 6 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн, Үндэсний аюулгүйн зөвлөлийн дарга, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч ба улс орны үндсэн бодлогыг хэрэгжүүлэх, шүүх засаглалын эцсийн шийдвэр гаргаж, шүүгчийн үүрэг гүйцэтгэх, элчин сайдыг томилох, төрийн аюулгүй байдлыг хангах, сонгуулийг зарлах, парламентыг тараах эрхтэй.<br><br>➢ **Ерөнхийлөгчийн алба**<br>Аюулгүй байдлын зөвлөл, Батлан хамгаалах зөвлөл, Засгийн газрын хэрэг эрхлэх газар зэрэг хамаарах ба тэдгээр нь Ерөнхийлөгчийг Засгийн газрын бодлогын хэрэгжилтийг удирдах, зарлиг, тогтоолыг төсөвлөх зэрэгт туслалцаа үзүүлнэ.<br><br>**Ерөнхий сайд**<br><br>Ерөнхийлөгч Ерөнхий сайдыг нэр дэвшүүлж, Төрийн Дум батална. Тэрээр Засгийн газрын тэргүүн ба Ерөнхийлөгчийн удирдлагад ажиллах ба 8 орлогчтой. Сайд нарын танхимыг бүрдүүлж, Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу Засгийн газрын өдөр тумын үйл ажиллагааг удирдана.<br><br>➢ **Сайд нарын зөвлөл**<br><br>Яам, агентлаг, удирдах газрууд, Ерөнхий сайд, түүний орлогчдоос бүрдэнэ. | **Үндсэн хуулийн шүүх**<br><br>19 гишүүнээс бүрдэх ба тэдний Ерөнхийлөгч санал болгосноор Холбооны зөвлөл бүх насаар нь томилно. Баталсан хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, чиглэл, орон нутгийн үндсэн хууль, журам, хууль эрхийн актууд нь үндсэн хуультай тохирох эсэхийг хянах, мөн холбооны болон орон нутгийн эрх баригчдын хооронд үүссэн маргааныг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй.<br><br>➢ **Дээд шүүх**<br><br>Иргэний, эрүүгийн хэргийг шүүн таслах хуулийн дээд байгууллага бөгөөд 20 шүүгчийг Ерөнхийлөгч санал болгосноор Холбооны зөвлөл насаар нь томилно.<br><br>➢ **Хөндлөнгийн шүүх**<br><br>Эдийн засгийн маргаан, тухайлбал, гэрээний маргаан болон доод шатны шүүхийн шийдвэрийг шүүх үүрэгтэй ба 70 гишүүнээс бүрдэнэ. Хэргийг тангарагтнууд бус шүүгчид шийдвэрлэнэ. |

[114]Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 274 дэх тал.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## 10. ЭНЭТХЭГ

| | |
|---|---|
| Албан ёсны нэр: | Бүгд Найрамдах Энэтхэг Улс |
| Хүн ам: | 1,03 тэрбум |
| Нийслэл: | Дели |
| Нутаг дэвсгэр: | 3,287,585 $км^2$ |
| Тусгаар тогтносон он: | 1947 |
| Үндсэн хууль баталсан он: | 1950 |
| Засаг захиргааны нэгж: | 28 муж улс, 7 холбоот муж |
| Харьяа газар нутаг: | Байхгүй |
| Эрх зүйн бүл: | Англи-Саксоны[115] |

### ТӨРИЙН ТОГТОЛЦОО

| ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ | ШҮҮХ ЗАСАГЛАЛ |
|---|---|---|
| **Парламент**<br><br>Хоёр танхимтай. Ардын танхим нь илүү эрх мэдэлтэй, санхүүгийн хууль тогтоомжийг батална. Харин хуулийн төслийг хоёр танхимд хэлэлцдэг.<br><br>➢ **Төрийн буюу Дээд танхим**<br><br>245 гишүүдтэй ба тэдний 233 нь орон нутгийн ассамблей буюу мужийн хууль тогтоох байгууллагууд шууд бус сонгуулиар сонгодог. Бусад 12 нь Ерөнхийлөгчийн санал болгосон хүндэт иргэдээс сонгоно. Гишүүд нь 6 жилийн хугацаатай сонгогдох ба 2 жил тутам тэдний 1/3 хувь нь солигддог.<br><br>➢ **Ардын буюу Доод танхим**<br><br>545 гишүүдтэй, тэдний 543 нь бүх нийтийн санал хуралтаар сонгодох ба үлдсэн 2 гишүүнийг Англи-Энэтхэгийн нийгэмлэгээс Ерөнхийлөгч томилно. Гишүүд 5 жилийн хугацаатай томилогдоно.<br><br>**Орон нутгийн засаг захиргаа**<br><br>• 28 муж улс, 7 нутаг дэвсгэрийн нэгжүүдэд хуваагдана.<br>• Мужийн захирагч сайд нь мужийн хууль тогтоох байгууллагад ажлаа хариуцна.<br>• Мужийн захирагчдыг Ерөнхийлөгч томилно. | **Ерөнхийлөгч**<br><br>Орон нутгийн хууль тогтоох байгууллагууд, Парламентын хоёр танхимын гишүүдээр батламжуулсны эцэст 5 жилийн хугацаатай сонгогддог. Тэрээр төрийн тэргүүн, үндэсний эв нэгдлийн билэг тэмдэг байна.<br><br>➢ **Дэд Ерөнхийлөгч**<br><br>5 жилийн хугацаатай сонгогдох ба бүрэн эрхийх нь хугацаа Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаанаас шууд хамаардаг. Тэрээр Дээд танхимын дарга болно.<br><br>**Ерөнхий сайд**<br><br>Хууль тогтоох байгууллагын сонгуулийн дараа Доод танхимыг бүрдүүлж буй олонхын нам бүлгийн даргыг Ерөнхийлөгч Засгийн газрын тэргүүнээр сонгодог. Ерөнхий сайд нь Сайд нарын зөвлөлийн шийдвэрийг Ерөнхийлөгчид дамжуулах үүрэгтэй.<br><br>➢ **Сайд нарын зөвлөл**<br><br>Ерөнхий сайдын санал болгосны дагуу Ардын танхимын гишүүдийн дэмжлэгтэйгээр Ерөнхийлөгч томилдог ба төрийн сайдууд болон дэд сайдуудыг парламент баталдаг. | **Дээд шүүх**<br><br>Иргэний, эрүүгийн гэмт хэрэг, Үндсэн хуультай холбогдох хэргийг шүүн таслах дээд байгууллага. Ерөнхий шүүгчийн хамт нийт 26 шүүгчдээс бүрдэх ба Ерөнхий сайдын санал болгосны дагуу Ерөнхийлөгч тэднийг бүх насаар нь томилдог. Шүүх засаглал нь хоёроос дээш мужийн засаг захиргааны хооронд гарсан хэргүүдийг шийдвэрлэх зорилгоор мужуудын дээд шүүхийн хоорондох иргэний болон эрүүгийн гэмт хэргийг шилжүүлэх эсвэл дараагийн шатны шүүх ажиллагааг гүйцэтгэнэ. Нийт 18 шүүхийн шүүгчид нь нэгээс илүү мужийг хариуцан ажиллах бөгөөд ерөнхий шүүгчийг Энэтхэгийн Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, мужийн захирагчийн зөвшөөрөл, зөвлөмжийн дагуу тус улсын Ерөнхийлөгч томилдог. Олон тооны танхимын шүүгчид нь нэг шүүхээс нөгөөрүү шилжиж байдаг бөгөөд шүүгчид 62 насандаа тэтгэвэртээ гардаг.<br><br>➢ **Дүүргийн шүүх**<br><br>Шүүгчдийг мужийн Дээд шүүхийн зөвлөмжөөр тухайн мужийн захирагч томилдог. Дүүрэг бүрд иргэний хэргийг шүүн таслах шүүгчид байдаг. |

[115]Дэлхийн улс орнуудын парламент. УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргасан. УБ., 2010 он. 235 дахь тал.

## 11. КАНАД

| | |
|---|---|
| Албан ёсны нэр: | Канад |
| Хүн ам: | 31.6 сая |
| Нийслэл: | Оттава |
| Нутаг дэвсгэр: | 9,984,670 км$^2$ |
| Тусгаар тогтносон он: | 1867 |
| Үндсэн хууль баталсан он: | 1867 |
| Засаг захиргааны нэгж: | 10 муж, 3 харьяат муж |
| Харьяа газар нутаг: | Байхгүй |
| Эрх зүйн бүл: | Англи-Саксоны[116] |

### ТӨРИЙН ТОГТОЛЦОО

| ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ | ШҮҮХ ЗАСАГЛАЛ |
|---|---|---|
| **Парламент**<br><br>Хоёр танхимтай. Хуулийн төсөл нь хоёр танхимаар хэлэлцэнэ. Сенат нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хэрэгсэхгүй болгох, хуулийн төслийг Нийтийн танхимд дахин хэлэлцүүлэхээр буцаах эрхтэй.<br><br>➢ **Сенат**<br><br>105 сенатыг 75 нас хүртэл нь Амбан захирагч томилно. Сенат нь Засгийн газрын үйл ажиллагаа, бодлогод анхаарах үүрэгтэй.<br><br>➢ **Нийтийн танхим**<br><br>Бүх нийтийн сонгуулиар 5 жилийн хугацаатай сонгогдсон 301 гишүүдтэй. Хэрэв Засгийн газар ялалт байгуулж чадаагүй, эсвэл огцорвол Ерөнхий сайд Амбан захирагчаас Засгийн газрыг тараах хүсэлтэ гаргана. Хууль тогтоох засаглалын гол эрхийг эдлэх ба Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй.<br><br>**Орон нутгийн засаг захиргаа**<br><br>10 бие даасан муж, 3 харьяат мужуудад хуваагдах ба бие даасан муж бүрт хууль тогтоох чуулгантай. Хатан хааныг цэргийн захирагчид төлөөлөн удирдана. | **Эзэн хаан**<br><br>Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын хаан/ хатан хаан байх ба Хамтын нөхөрлөлийн орнуудын эрхэм дээдэс, төрийн тэргүүн, эв нэгдлийн билэг тэмдэг байна.<br><br>➢ **Амбан захирагчийг**<br><br>Эзэн хаан таваас доошгүй жил томилно. Тэрээр Эзэн хааныг төлөөлөн ажиллах үүрэгтэй. Ерөнхий сайдыг томилох, Парламентыг зарлан хуралдуулах, тараах эрхтэй.<br><br>**Ерөнхий сайд**<br><br>Засгийн газрын тэргүүн ба Нийтийн танхимд олонхын суудал авсан намын тэргүүн байна. Нууцын зөвлөл<br><br>Эзэн хааны зөвлөлдөх зөвлөл ба гишүүдийг нь Ерөнхий сайдын зөвлөснөөр Амбан захирагч томилно.<br><br>➢ **Сайд нарын танхим**<br><br>Ерөнхий сайд муж бүрээс 1 сайдыг гишүүнээр нь томилно. Сайдууд нь Нийтийн танхим, Нууцын зөвлөлийн гишүүд байна. | **Дээд шүүх**<br><br>Иргэний ба эрүүгийн, Үндсэн хуулийн бусад хэргүүдийг шүүн таслах шүүх засаглалын хамгийн дээд байгууллага ба шүүгчдийг Ерөнхий сайд дэвшүүлж, Амбан захирагч бүх насаар нь томилно. Дээд шүүхийн ерөнхий шүүгч 75 нас хүртлээ албан тушаал хаших эрхтэй.<br><br>➢ Холбооны шүүхэд орчин үеийн холбооны шүүх засаглалын бүхий л асуудал хамрагддаг ба албан хаагчид нь ихэвчлэн Канадын иргэд, үндэстэн байна. Хууль эрх зүйн шүүх нь бүх төрлийн эрүүгийн хэргийг шүүн таслах эрхтэй.<br><br>➢ **Мужийн шүүх**<br><br>Муж бүр өөрийн өвөрмөц онцлогт тохирсон шүүхийн тогтолцоотой. Мужийн эрх мэдэл бүхий дээд шүүх, давж заалдах шүүхтэй ба шүүгчдийг холбооны шүүхээс томилно.<br><br>➢ **Татварын шүүх**<br><br>Канадын холбооны шүүхийн дэд хэсэг бөгөөд үндэсний болоод холбооны татварын хууль цааз, дүрэм журмыг ноцтой зөрчсөн, холбогдох хэргүүдийг шүүн таслах, хянах үүрэгтэй. |

[116]Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 227 дахь тал.

UILMN СУДАЛГААНЫ САН

## 12. АВСТРАЛИ

| | |
|---|---|
| Албан ёсны нэр: | Австралийн Хамтын Нөхөрлөлийн Улс |
| Хүн ам: | 19,3 сая |
| Нийслэл: | Канберра |
| Нутаг дэвсгэр: | 7,617,930 $км^2$ |
| Тусгаар тогтносон он: | 1901.01.01 |
| Үндсэн хууль баталсан он: | 1900.07.09 |
| Засаг захиргааны нэгж: | 6 муж улс, 2 харьяат газар |
| Харьяа газар нутаг: | Аштор Картиерийн арал, Христас арал, Кокосын арал, Шүрэн дайлан арал, Хейрд арал, МакДоналдын арал, Норфолкын арал |
| Эрх зүйн бүл: | Англи-Саксоны[117] |

## ТӨРИЙН ТОГТОЛЦОО

| ХУУЛЬ ТОГТООХ ЗАСАГЛАЛ | ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ | ШҮҮХ ЗАСАГЛАЛ |
|---|---|---|
| **Конгресс**<br><br>2 танхимтай.<br><br>➢ **Сенат**<br><br>Нийт 76 сенатортой ба мужийн тойргуудаас 6 жилийн хугацаатай сонгогдоно. Тэдний хагас нь 3 жил тутамд шинээр сонгогдоно.<br><br>➢ Төлөөлөгчдийн танхим<br><br>Сенатын гишүүдийг 2 дахин нэмсэнтэй тэнцэх тооны гишүүдтэй. Танхим нь 150 суудалтай ба муж, харьяа нутаг дэвсгэрийн хуваарилалтаас тус бүр 5 гишүүн сонгогдоно. Танхимын гишүүд нь 3 жилийн хугацаатай бүх ард түмний сонгуулиар сонгогдоно.<br><br>**Орон нутгийн засаг захиргааны**<br><br>• 6 муж улс, 2 харьяат газар<br>• муж улсуудын парламент нь хоёр танхимтай | **Эзэн хаан**<br><br>Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын хаан/хатан хаан байх ба Хамтын нөхөрлөлийн орнуудын эрхэм дээдэс, төрийн тэргүүн, эв нэгдлийн билэг тэмдэг.<br><br>➢ **Амбан захирагч**<br><br>Ерөнхий сайдтай зөвшөлцөн Эзэн хаан томилно. Тэрээр Парламентыг зарлан хуралдуулах, тараах эрхтэй. Парламентаар зөвшөөрөгдсөн байна. Тэрээр өөрийн хүсэлтээр огцрох, эсвэл Хааны зарлигаар буух хүртлээ тус албыг хашина.<br><br>**Ерөнхий сайд**<br><br>Төлөөлөгчдийн танхимд олонх болсон нам эвслийн тэргүүн байх ба Сайд нарын танхимыг даргална.<br><br>➢ **Холбооны гүйцэтгэх зөвлөлд**<br><br>Бүх сайд нар орох ба Амбан захирагч нь зөвлөх үүрэгтэй. Сайд нарын танхимын Гишүүд 16 сайдыг тус улсын Парламентын гишүүдээс Ерөнхий сайдын зөвлөснөөр Амбан захирагч томилно. | **Дээд шүүх**<br><br>Тус улсын шүүх засаглалын эрх бүхий дээд байгууллага, иргэн, эрүүгийн гэмт хэргийг шүүн таслахын зэрэгцээ муж улсуудын хоорондын маргаантай асуудлууд, олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн зарчим, журам болон Үндсэн хуулийн холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилтэнд хяналт тавина. Шүүхийн гишүүд болох 7 шүүгчдийг Амбан захирагч 70 нас хүртэл нь томилдог.<br><br>➢ **Холбооны шүүх**<br><br>Иргэн, эрүүгийн хэргийн хууль тогтоомж, үндэстэн хоорондын маргаан, дампуурал, хамтын ажиллагаатай холбогдсон элдэв маргаан зөрчилд холбогдох хэргүүдийг шүүн тасалж хэлэлцэнэ. 45 Шүүгчдийг Амбан захирагч 70 нас хүртэл нь томилдог.<br><br>➢ **Гэр бүлийн шүүх**<br><br>Гэр бүлийн зөрчил, цуцлалт, хүүхэд асран хүмүүжүүлэх тухай хуульд хамраах хэргүүдийг шийдвэрлэнэ. Шүүгчдийн Амбан захирагч томилно. |

[117]Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 227 дахь тал.

## 13. ИСПАНИ

Албан ёсны нэр: Испанийн Вант Улс
Хүн ам: 39.9 сая
Нийслэл: Мадрид
Нутаг дэвсгэр: 504,782 км$^2$
Тусгаар тогтносон он: 1492
Үндсэн хууль баталсан он: 1978
Засаг захиргааны нэгж: 19 бие даасан муж улс
Харьяа газар нутаг: Исла Карифан, Пеньон-де-Алусемас, Пеньон де Велез, де ла Гомера
Эрх зүйн бүл: Ром-Германы[118]

## ТӨРИЙН ТОГТОЛЦОО

| ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ | ШҮҮХ ЗАСАГЛАЛ |
|---|---|---|
| **Парламент**<br><br>Хоёр танхимтай.<br><br>➢ Сенат<br><br>Мужуудаас сонгогдсон 208 гишүүнтэй, тэдний 51 нь автономит мужийн парламентаас шууд сонгогддог. Бүрэн эрхийн хугацаа 4 жил. Сенатын гишүүд хуулийн төсөл санаачлах эрхгүй ч хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй.<br><br>➢ **Төлөөлөгчийн танхим**<br><br>Пропорциональ системээр бүх нийтийн сонгуулиар сонгогдсон 350 гишүүнтэй. Бүрэн эрхийн хугацаа 4 жил. Танхим нь хууль тогтоомж санаачлах эрхтэй.<br><br>**Мужийн засаг захиргаа**<br><br>• Бие даасан 19 муж улстай.<br>• Муж улс бүр Ерөнхийлөгчөө сонгодог ба нэг танхимтай Парламенттай.<br>• Муж улс бүр Дээд шүүхтэй. | **Эзэн хаан**<br><br>Тэрээр угсаа залгамжлагч ба төрийн тэргүүн, эв нэгдлийн билэгдэл, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Тэрээр Төлөөлөгчдийн танхимын зөвлөснөөр Засгийн газрын ерөнхийлөгч буюу тэргүүнийг, Засгийн газрын ерөнхийлөгчийн зөвлөснөөр дэд Ерөнхийлөгчийг томилно. Дэд ерөнхийлөгч нь Засгийн газрын тэргүүний орлогч юм. Мөн хууль тогтоох засаглалыг дэмжих, тараах эрхтэй.<br><br>➢ **Төрийн зөвлөл**<br><br>Төрийн өндөр албан тушаалтнууд, зэвсэгт хүчин, төрийн албаны тэргүүлэгч ажилтнуудыг багтаасан зөвлөлдөх дээд байгууллага юм. Ерөнхийлөгчийг нь Сайд нарын зөвлөлөөс томилно.<br><br>**Засгийн газрын Ерөнхийлөгч**<br><br>Засгийн газрын тэргүүн нь Парламентад олонхын суудалтай намын тэргүүн байна. Эзэн хаан түүнийг Төлөөлөгчдийн танхимд санал болгосноор сонгох ба хоёр дэд Ерөнхийлөгчийг дэвшүүлэн томилдог байна.<br><br>➢ **Сайд нарын зөвлөл**<br><br>Ерөнхий сайд, түүний дэд сайдууд тэргүүлэх бөгөөд Засгийн газрын бодлогыг тодорхойлно. | **Дээд шүүх**<br><br>Шүүх засаглалын дээд байгууллага ба иргэн, эрүү, захиргаа, нийгмийн болон цэргийн танхимуудад хуваагдана. Нийт 95 шүүгчдийг Дээд шүүхийн Ерөнхийлөгч удирдана. Тэдний бүрэн эрхийг Шүүхийн зөвлөлийн 20 гишүүн (зөвлөлийн гишүүдийн 8-ыг нь парламент, 12-ыг нь шүүгчдээс томилдог)-ийг нэр дэвшүүлж, Хаан томилно.<br><br>➢ **Үндсэн хуулийн шүүх**<br><br>Мужийн асуудалтай холбоотой хуулийн төслийг Зөвлөлөөр батлуулна. Зөвлөл санхүүтэй холбоотой хуулийн төсөлд хяналт тавьж батална. Шүүхийн 12 шүүгчдийг Засгийн газар, Шүүхийн зөвлөл, Парламентаас 9 жилийн хугацаатайгаар томилно.<br><br>➢ **Анхан шатны шүүх**<br><br>Муж улс бүр Дээд шүүх, мужийн шүүх, анхан шатны шүүх, хотын шүүхтэй. Нэгдсэн болон бие даан үйл ажиллагаа явуулдаг шүүхүүд нь хууль бусаар мөнгө угаалт, хар тамхи, мансууруулах бодис худалдаалах, алан хядлагатай холбоотой хэргүүдийг шүүн таслах, хянан шийдвэрлэх эрхтэй. |

[118]Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 240 дэх тал.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## 14. ӨМНӨД СОЛОНГОС

| | |
|---|---|
| Албан ёсны нэр: | Бүгд Найрамдах Солонгос Улс |
| Хүн ам: | 47,1 сая |
| Нийслэл: | Дели |
| Нутаг дэвсгэр: | 98,480 км$^2$ |
| Тусгаар тогтносон он: | 1948 |
| Үндсэн хууль баталсан он: | 1948 |
| Засаг захиргааны нэгж: | 9 муж, 7 хот |
| Харьяа газар нутаг: | Байхгүй |
| Эрх зүйн бүл: | Ром-Германы эрх зүйн бүлд хамаарах боловч хууль тогтоомжид нь Америкийн эрх зүйгээс нэлээд зүйлийг авсан.[119] |

## ТӨРИЙН ТОГТОЛЦОО

| ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ | ШҮҮХ ЗАСАГЛАЛ |
|---|---|---|
| Парламент<br><br>Нэг танхимтай.<br><br>**Үндэсний Ассамблей**<br><br>273 гишүүдтэй. Тэдний 227 нь бүх нийтийн сонгуулиар, 46 нь сонгуулийн үр дүнгээс хамаарч улс төрийн намуудын нэрсийн жагсаалтаар сонгогдоно. Бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.<br><br>**Орон нутгийн засаг захиргаа**<br><br>9 мужийг захирагчид удирдана. | **Ерөнхийлөгч**<br><br>Бүх ард түмний сонгуулиар 5 жилийн хугацаатайгаар нэг удаа сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн, хууль тогтоох байгууллагын тэргүүлэгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн албыг хашина.<br><br>➢ **Ерөнхий сайд**<br><br>Ерөнхийлөгч томилох ба Засгийн газрыг тэргүүлнэ.<br><br>➢ **Төрийн зөвлөл**<br><br>Ерөнхий сайд санал болгосноор Ерөнхийлөгчийн томилсон 20 гишүүдээс бүрдэнэ. Тэд засгийн газрын үйл ажиллагааг хянана. | **Үндсэн хуулийн шүүх**<br><br>Нийт 9 шүүгчтэй, тэдний гурвыг нь Ерөнхийлөгч, гурвыг нь Үндэсний ассемблей, бусад гурвыг нь Шүүхийн дарга тус тус томилно.<br><br>➢ **Дээд шүүх**<br><br>Хууль тогтоох дээд байгууллага бөгөөд гишүүдийг нь 6 жилийн хугацаатай Үндэсний ассамблейн зөвшөөрснөөр Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг дахин томилж болно.<br><br>➢ **Ерөнхий ба Доод шатны шүүх**<br><br>Шүүгч, ерөнхий шүүгч нар Дээд шүүхийн бага хурлаар батлагдан 10 жилийн хугацаатай томилогдоно. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[119]Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 411 дэх тал.

## 15. МЕКСИК

| | |
|---|---|
| Албан ёсны нэр: | Мексикийн Нэгдсэн Улс |
| Хүн ам: | 100,4 сая |
| Нийслэл: | Мексик |
| Нутаг дэвсгэр: | 1,972,550 км$^2$ |
| Тусгаар тогтносон он: | 1836 |
| Үндсэн хууль баталсан он: | 1917 |
| Засаг захиргааны нэгж: | 31 муж улс, 1 холбооны дүүрэг |
| Харьяа газар нутаг: | Байхгүй |
| Эрх зүйн бүл: | Ром-Германы[120] |

### ТӨРИЙН ТОГТОЛЦОО

| ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА | ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ | ШҮҮХ ЗАСАГЛАЛ |
|---|---|---|
- Эзэн хаанаас гүйцэтгэх засаглалыг томилдог – 23 орон;
- Амбан захирагч томилдог – 11 орон;
- Сонгуулиар гүйцэтгэх засаглалыг томилдог – 6 орон;
- Бусад /шашин, цэргийн, ерөнхийлөгч Засгийн газрын тэргүүн байх гэх мэт/ - 3 орон тус тус байна.

| *№* | *Улсын нэр* | *Гүйцэтгэх засаглал* |
|---|---|---|
| | | **АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛ** |
| | | ❖ **ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛ** |
| 1. | **Австрали** | • **Эзэн хаан** нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын хаан/хатан хаан байх ба Хамтын нөхөрлөлийн орнуудын эрхэм дээдэс, төрийн тэргүүн, эв нэгдлийн билэг тэмдэг байна.<br>• **Амбан захирагчийг** Ерөнхий сайдтай зөвшөлцөн Эзэн хаан томилно. Тэрээр Парламентыг зарлан хуралдуулах, тараах эрхтэй. Хууль тогтоох засаглалаас зөвшөөрөгдсөн байна. Тэрээр өөрийн хүсэлтээр огцрох, эсвэл Хааны зарлигаар буух хүртлээ тус албыг хашина.<br>• **Ерөнхий сайд** нь Төлөөлөгчдийн танхимд олонх болсон нам эвслийн тэргүүн байх ба Сайд нарын танхимыг даргална.<br>• **Холбооны гүйцэтгэх зөвлөлд** бүх сайд багтана. Амбан захирагч нь тус зөвлөлд зөвлөх үүрэгтэй.<br>• **Сайд нарын танхимын** гишүүд болох 16 сайдыг Парламентын гишүүдээс Ерөнхий сайдын зөвлөсний дагуу Амбан захирагч томилно. |
| 2. | **Австри** | • **Ерөнхийлөгч** нь бүх нийтийн санал хураалтаар 6 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байх ба Засгийн газрын тэргүүнийг томилох, хуулийн төсөл, олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд гарын үсэг зурах, парламентыг зарлан хуралдуулах, тараах эрхтэй.<br>• **Канцелер** бол Парламентад олонхын суудал авсан нам, эвслийн тэргүүн байна. Тэрээр Засгийн газрын тэргүүн ба төрийн үйлчилгээний албанд хяналт тавих үүрэгтэй.<br>• **Сайд нарын Танхимын** гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Ерөнхийлөгч томилно. Зөвлөл нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих ба Танхимыг Канцелер удирдана. |
| 3. | **Андорра** | • **Хун тайжийн зөвлөл** - Франц, Испаний Ерөнхийлөгч болон Ургеллийн хамбатан нар тус Зөвлөлийг тэргүүлэх ба төрийн тэргүүний үүргийг гүйцэтгэнэ.<br>• **Ерөнхийлөгч** нь Парламентын гишүүн байх ба Парламентаас сонгогдож, Хун тайжийн зөвлөл томилно. Ерөнхий сайд нь Засгийн газрын тэргүүн байх ба Хун тайжийн зөвлөлийг тэргүүлж, хууль тогтоомжид хориг тавина. |

[136]Төр улсуудын засгийн газар (Дэлхийн улс төрийн тогтолцооны гарын авлага). Монсудар хэвлэлийн газар. 2011.



UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | • **Гүйцэтгэх зөвлөлийн** гишүүдийг Парламентаас сонгох ба Гүйцэтгэх зөвлөл нь засгийн газрын үйл ажиллагааг хянах үүрэгтэй. |
| 4. | **Антигуа ба Барбуда** | • **Эзэн хаан** нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын хаан/хатан хаан байх ба төрийн тэргүүн, билэгдлийн шинжтэй.<br>• **Амбан захирагч** - Сонгуулийн дараа Ерөнхий сайдын зөвлөснөөр Британийн Эзэн хаан томилно. Тэрээр Эзэн хааныг төлөөлж ажиллана.<br>• **Ерөнхий сайд** - Парламентад олонхи болсон нам, эвслийн тэргүүн байх ба Амбан захирагч томилно. Тэрээр Засгийн газрыг тэргүүлж, Сайд нарын Зөвлөлд хяналт тавина.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Амбан захирагч томилно. Засгийн газрын үйл ажиллагааг хянах, Парламентад тайлагнана. |
| 5. | **Багамын арлууд** | • **Эзэн хаан** нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын хаан/хатан хаан байх ба төрийн тэргүүн, билэгдлийн шинжтэй.<br>• **Амбан захирагч** - Сонгуулийн дараа сонгогдож, Британийн Эзэн хааныг төлөөлж ажиллана.<br>• **Ерөнхий сайд** - Парламентад олонх болсон нам, эвслийн тэргүүнийг Амбан захирагч томилно. Тэрээр Засгийн газрын тэргүүн.<br>• **Сайд нарын танхимын** 9 гишүүнийг Парламентаас сонгон Ерөнхий сайдын зөвлөсний дагуу Амбан захирагч томилно. Танхимын гишүүд нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, хуулийн төсөл боловсруулна. |
| 6. | **Бангладеш** | • **Ерөнхийлөгчийг** Парламентаас 5 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр төрийн тэргүүн, Үндэсний зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Тэрээр парламентыг зарлан хуралдуулах, тараах, шагнал гардуулах, өршөөл үзүүлэх, Ерөнхий прокурорыг томилох эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** нь парламентад олонх болсон нам эвслийн удирдагчдаас сонгогдох ба Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын танхимын** гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Ерөнхийлөгч томилно. Ерөнхий сайд даргалж, Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, Парламентад тайлагнах үүрэгтэй. |
| 7. | **Барбадос** | • **Эзэн хаан** нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын хаан/хатан хаан байх ба төрийн тэргүүн, билэгдлийн шинжтэй.<br>• **Амбан захирагч** - Сонгуулийн дараа сонгогдож, Британийн Эзэн хааныг төлөөлж ажиллана.<br>• **Ерөнхий сайд** - Парламентад олонх болсон нам, эвслийн тэргүүнийг Амбан захирагч томилно. Ерөнхий сайд нь Засгийн газрын тэргүүн бөгөөд өөрийн Сайд нарын танхимыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын танхимын** гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Амбан захирагч томилно. |
| 8. | **Белиз** | • **Эзэн хаан** нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын хаан/хатан хаан байх ба төрийн тэргүүн, билэгдлийн шинжтэй.<br>• **Амбан захирагч** - Сонгуулийн дараа сонгогдож, Британийн Эзэн хааныг төлөөлж ажиллана.<br>• **Ерөнхий сайд** - Парламентад олонх болсон нам, эвслийн тэргүүнийг Амбан захирагч томилно. Ерөнхий сайд нь Засгийн газрын тэргүүнээр ажиллана.<br>• **Сайд нарын танхимын** гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Амбан захирагч томилно. |
| 9. | **Бельги** | • **Эзэн хаан** нь төрийн тэргүүн ба Ерөнхий сайдыг томилох, Парламентыг тараах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Эзэн хаан Төлөөлөгчдийн танхимаас томилно. Ерөнхий сайд нь засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын танхимын** гишүүд болон Ерөнхий сайдыг Төлөөлөгчдийн танхимын гишүүдээс томилно. Хэрэв танхимын сайд дахин Парламентаас сонгогдсон бол дараагийн сонгууль хүртэл дахин сонгогдохгүй. |
| 10. | **Вануату** | • **Ерөнхийлөгч** - Мужийн зөвлөл болон Парламентын сонгуулийн коллегиар батлагдаж 4 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн бөгөөд Ерөнхий сайдын зөвлөснөөр парламентыг тараах эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** - Парламентад олонх болосн нам, эвслийн тэргүүнийг Парламент томилно. Тэрээр засгийн газрын тэргүүн.<br>• **Сайд нарын зөвлөлийн** гишүүн 13-аас дээшгүй байх ба тэднийг Ерөнхий сайд томилно. |
| 11. | **Герман** | • **Канцлер** – Засгийн газрын тэргүүнийг Ерөнхийлөгчийн санал болгосноор Бундестагаас сонгож, Ерөнхийлөгч томилно. Канцлер нь Танхимынхаа сайд нарыг санал болгон, дотоодын улс төрийн бодлогыг хэрэгжүүлдэг. |

| | | |
|---|---|---|
| | | Ерөнхийлөгчид санал зөвлөмж өгнө.<br>• **Ерөнхийлөгч** нь Холбооны хураас 5 жилийн хугацаатай сонгогдоно. Холбооны хурал нь Бундестагийн гишүүд, түүнтэй тэнцүү тооны муж улсын төлөөлөгчдөөс бүрдсэн онцгой байгууллага бөгөөд гагцхүү Холбооны Ерөнхийлөгчийг сонгох эрхтэй. Ерөнхийлөгч нь билэг тэмдгийн шинжтэй ба тэрээр олон улсын гэрээ батлах ба гадаадад эх орноо төлөөлдөг.<br>• **Танхим** нь Канцлер болон холбооны сайдуудаас бүрдэнэ. Танхимын гишүүдийг Канцлерийн санал болгосноор Ерөнхийлөгч томилно. |
| 12. | **Гренада** | • **Эзэн хаан** нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын хаан/хатан хаан байх ба төрийн тэргүүн, билэгдлийн шинжтэй.<br>• **Амбан захирагчийг** Эзэн хаан томилох ба тэрээр Эзэн хааныг төлөөлж ажиллана.<br>• **Ерөнхий сайдаар** Парламентад олонх болсон нам, эвслийн тэргүүнийг Амбан захирагч томилно. Ерөнхий сайд нь Засгийн газрыг тэргүүн ба сонгуулийг зарлан явуулах эрхтэй.<br>• **Сайд нарын танхимын** гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Амбан захирагч томилно. Танхим нь засгийн газрын үйл ажиллагааг хянана. |
| 13. | **Дани** | • **Эзэн хаан** нь угсаа залгамжлагч, төрийн тэргүүн, үндэсний эв нэгдлийн билэгдэл.<br>• **Ерөнхий сайд** нь сонгуулийн дараа парламентад олонх болсон нам эвслийн тэргүүн байх ба түүнийг Хаан томилно. Тэрээр засгийн газрын тэргүүн бөгөөд парламентыг тараах, шинэ сонгуулийг зарлах бүрэн эрхтэй.<br>• **Сайд нарын танхимын** 20 гишүүдийг Ерөнхий сайд зөвлөсний дагуу Хаан томилж, Парламент батлана. |
| 14. | **Доминик** | • **Ерөнхийлөгчид** Парламентад олонх болсон, мөн сөрөг хүчний намаас нэр дэвшиж болно. Түүнийг Парламентаас 5 жилийн хугацаатай сононо томилно. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байна.<br>• **Ерөнхийлөгч сайд** нь Үндэсний танхимд олонх болсон нам, эвслийн тэргүүн байх ба түүнийг Ерөнхийлөгч томилно. Тэрээр засгийн газрыг тэргүүлж, өөрийн танхимыг удирдах ба сонгуулийг зарлах эрхтэй.<br>• **Сайд нарын танхим** - Гишүүд нь эх барьж байгаа намын Үндэсний чуулганы танхимаас сонгож, Ерөнхий сайдын зөвлөснөр Ерөнхийлөгч томилно. |
| 15. | **Израиль** | • **Ерөнхийлөгч** нь Парламентаас 5 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн бөгөөд хууль батлах, шүүгч болон дипломатуудыг томилох, төрийн дээд одон медаль, шагнал гардуулах, өршөөл үзүүлэх эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** нь Парламентад олонх болсон намын тэргүүн байх ба түүнийг Ерөнхийлөгч томилно. Тэрээр Засгийн газрын тэргүүлэх, танхимын улс төрийн бодлогын хөтөлбөрийг тогтоох, Парламентыг тараах эрхтэй.<br>• **Сайд нарын танхимын** гишүүдийг Ерөнхий сайд томилж Парламент батлана. Танхимын гишүүд нь засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах ба парламентад хууль тогтоомж хэлэлцүүлүүлэхээр оруулах эрхтэй. |
| 16. | **Ирланд** | • **Ерөнхийлөгч** - Бүх нийтийн санал хураалтаар 7 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн бөгөөд хууль батлахын зэрэгцээ Ерөнхий сайдын зөвлөснөөр Парламентыг тараах эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** - Парламентад олонх болсон нам, эвслийн тэргүүнийг Ерөнхий сайдад Төлөөлөгчдийн танхимаас нэр дэвшүүлж, Ерөнхийлөгч томилно. Тэрээр засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын танхимын** 15 гишүүнийг Ерөнхий сайд нэр дэвшүүлж, Төлөөлөгчдийн танхим батална. Гишүүд нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 17. | **Исланд** | • **Ерөнхийлөгч** - Бүх нийтийн шууд санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн бөгөөд Ерөнхий сайдын зөвлөснөөр Парламентыг тараах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** сонгуулийн дараа Ерөнхийлөгч томилно. Ерөнхий сайд нь Засгийн газрын тэргүүн.<br>• **Сайд нарын Танхимын** 12 гишүүнийг Ерөнхий сайд томилж, Парламент батална. Танхимын гишүүд нь засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, хуулийн төсөл боловсруулна. |
| 18. | **Испани** | • **Эзэн хаан** нь угсаа залгамжлагч ба төрийн тэргүүн, эв нэгдлийн билэгдэл, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Тэрээр Төлөөлөгчдийн танхимын зөвлөснөөр Засгийн газрын ерөнхийлөгч буюу тэргүүнийг, Засгийн газрын ерөнхийлөгчийн зөвлөснөөр дэд Ерөнхийлөгчийг томилно. Дэд ерөнхийлөгч нь Засгийн газрын тэргүүний орлогч юм. Мөн хууль тогтоох засаглалыг дэмжих, тараах эрхтэй. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | • **Төрийн зөвлөл** - Төрийн өндөр албан тушаалтнууд, зэвсэгт хүчин, төрийн албаны тэргүүлэгч ажилтнуудыг багтаасан зөвлөлдөх дээд байгууллага юм. Ерөнхийлөгчийг нь Сайд нарын зөвлөлөөс томилно.<br>• **Засгийн газрын Ерөнхийлөгч** буюу Засгийн газрын тэргүүн нь Парламентад олонхын суудалтай намын тэргүүн байна. Эзэн хаан түүнийг Төлөөлөгчдийн танхимд санал болгосноор сонгох ба хоёр дэд Ерөнхийлөгчийг дэвшүүлэн томилдог байна.<br>• **Сайд нарын зөвлөл -** Ерөнхий сайд, түүний дэд сайдууд тэргүүлэх бөгөөд Засгийн газрын бодлогыг тодорхойлно. |
| 19. | **Итали** | • **Ерөнхийлөгч** нь Парламентаас 7 жилийн хугацаатайгаар сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч ба Парламентад хуулийн төслийг дахин хэлэлцүүлэхээр буцаах, Парламентын хоёр танхимыг тараах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч нэр дэвшүүлж, Парламент батална. Тэрээр Засгийн газрын тэргүүн ба Засгийн газрын хэрэгжүүлж буй бодлого, сайд нарын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, зохицуулалт хийнэ.<br>• **Сайд нарын зөвлөлийн** гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Ерөнхийлөгч нэрийг нь дэвшүүлж, Парламент батална. |
| 20. | **Их Британи** | • **Эзэн хаан -** Төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Английн сүмийн тэргүүн, угсаа залгамжилсан, бэлгэ тэмдгийн шинжтэй. Эзэн хаан олон улсын гэрээнд гарын үсэг зурах, төрийн тэргүүнийг хүлээн авч уулзах, парламент, шүүх байгууллагын зарим албан тушаалтныг томилох, Ерөнхий сайдтай 7 хоног тутам уулзах, парламентыг тараах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдаар** Парламентад олонхын суудалтай намын тэргүүн сонгогдох ба тэрээр Засгийн газрын тэргүүн байж Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, гишүүдийг томилох, төрийн албаны үйл ажиллагааг удирдах үүрэгтэй.<br>• **Сайд нарын танхим** нь 20 сайд, Засгийн газрын харьяа агентлагуудын дарга нараас бүрдэнэ. Ерөнхий сайд өөрийн танхимын гишүүдийн тоог яг нарийн тодорхойлж томилох ба тэд Парламентын гишүүд байх ёстой.<br>• **Засгийн газар** нь эх баригч намаас сонгогдсон 100 гаруй гишүүн буюу танхимын гишүүд, сайд нар, тэдний нарийн бичгийн дарга нар, шадарлагч, шадар туслахууд болон цөөн тооны язгууртануудаас бүрдэнэ. |
| 21. | **Канад** | • **Эзэн хаан** нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын хаан/хатан хаан байх ба Хамтын нөхөрлөлийн орнуудын эрхэм дээдэс, төрийн тэргүүн, эв нэгдлийн билэг тэмдэг байна.<br>• **Амбан захирагчийг** Эзэн хаан таваас доошгүй жил томилно. Тэрээр Эзэн хааныг төлөөлөн ажиллах үүрэгтэй ба Ерөнхий сайдыг томилох, Парламентыг зарлан хуралдуулах, тараах эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** нь Засгийн газрын тэргүүн ба гол төлөв парламентын Нийтийн танхимд олонх болсон намын тэргүүн байна.<br>• **Нууцын зөвлөл** нь Эзэн хааны зөвлөлдөх зөвлөл ба гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Амбан захирагч томилно.<br>• **Сайд нарын танхим** - Ерөнхий сайд муж бүрээс 1 сайдыг гишүүнээр нь томилно. Сайдууд нь Нийтийн танхим, Нууцын зөвлөлийн гишүүд байна. |
| 22. | **Литва** | • **Ерөнхийлөгч** нь бүх нийтийн шууд санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгогдох ба тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь парламентыг тараах, баталсан хуулийг Парламентад буцаах, дахин хэлэлцүүлэгт шилжүүлэх эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилж, Парламент батална. Тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын танхимын** гишүүдийг Ерөнхий сайд зөвлөснөөр Ерөнхийлөгч томилно. |
| 23. | **Лихтенштейн** | • **Эзэн хаан** нь угсаа залгамжлагч, төрийн тэргүүн бөгөөд Парламентыг зарлан хуралдуулах, тараах, зарлиг, тогтоол гаргах, хууль тогтоомжид хориг тавих, одон медаль, шагнал гардуулах эрхтэй.<br>• **Засгийн газрын тэргүүн** нь Парламентат олонх болсон нам, эвслийн тэргүүн байх ба Эзэн хаан томилно.<br>• **Засгийн газрын дэд тэргүүн** нь Парламент дахь цөөнхийн тэргүүн байх ба Эзэн хаан томилно.<br>• **Сайд нарын танхим** - 6 гишүүнийг Парламентаас сонгож, Эзэн хаан томилно. Засгийн газрын үйл ажиллагааг хянана |
| 24. | **Люксембург** | • **Их ван** – Угсаа залгамжилсан Их ван нь төрийн тэргүүн ба Төлөөлөгчдийн танхимыг тараах эрхтэй. Засгийн газартай хамт төрийн эрхийг барина. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | • **Ерөнхий сайд** нь Парламентад олонх болсон нам, эвслийн тэргүүнийг Ерөнхий сайдад нэр дэвшүүлж, Их ван томилно. Ерөнхий сайд нь засгийн газрын тэргүүн бөгөөд Төлөөлөгчдийн танхимд тайлагнана.<br>• **Шадар сайдыг** Их ван томилно.<br>• **Сайд нарын зөвлөлийн** гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Их ван томилно.<br>• **Төрийн Зөвлөлийн** 21 гишүүнийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Их ван бүх насаар нь томилно. Зөвлөл нь хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхимд танилцуулахаас өмнө хянан хэлэлцэж, саналаа илэрхийлнэ. |
| 25. | **Маврикий** | • **Ерөнхийлөгч** нь Үндэсний Ассамблейгээс 5 жилийн хугацаатай сонгогдох ба тэрээр төрийн тэргүүн байна.<br>• **Дэд Ерөнхийлөгч** - Үндэсний Ассамблейгээс 5 жилийн хугацаатай сонгогдоно.<br>• **Ерөнхий сайд** - Парламентад олонх болсон нам, эвслийн тэргүүнийг Ерөнхий сайдад нэр дэвшүүлж, Ерөнхийлөгч томилно. Тэрээр Засгийн газрын тэргүүн, Үндэсний Ассамблейд ажлаа тайлагнана.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** 20 гаруй гишүүнийг Ерөнхий сайдын зөвлөсний дагуу Ерөнхийлөгч томилно. |
| 26. | **Малайз** | • **Эзэн хаан** нь угсаа залгамжлагч 9 Султан, тэдний гэр бүлээс 5 жил тутам сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн, шашны удирдагч ба Ерөнхий сайдын зөвлөснөөр Парламентыг тараах эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** нь Засгийн газрын тэргүүн ба Парламентын доод танхимд олон суудал авсан намын удирдагч байна.<br>• **Сайд нарын танхимын** гишүүдийг Парламентын гишүүдээс Ерөнхий сайдын зөвлөснөөр Эзэн хаан томилно. Танхим нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, Парламентад тайлагнах үүрэгтэй. |
| 27. | **Мальт** | • **Ерөнхийлөгч** нь Парламентаас 5 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүний хувьд хууль төсөл батлах, Парламентыг тараах, одон медаль, шагнал гардуулах эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** - Парламентад олонх болсон нам, эвслийн тэргүүнийг Ерөнхийлөгч нь 5 жилийн хугацаатай томилно. Тэрээр Сайд нарын танхимыг удирдана.<br>• **Сайд нарын Танхимын** гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Парламентаас сонгож, Ерөнхийлөгч томилно. Танхимын гишүүд нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, Парламентад тайлагнана. |
| 28. | **Маршаллын арлууд** | • **Ерөнхийлөгчийг** Парламентаас 4 жилийн хугацаатай томилно. Хэрэв Парламентын гишүүн нь Ерөнхийлөгч болбол тэрээр тэрхүү албан үүргээ орхих ёстой. Тэрээр төрийн тэргүүн ба хуулинд хориг тавихгүй, харин Парламентыг тараах эрхтэй.<br>• **Сайд нарын танхимын** 6-10 гишүүнийг Парламентаас сонгон Ерөнхийлөгч томилно. Танхим нь Засгийн газрын үйл ажиллагааг хянана. |
| 29. | **Молдав** | • **Ерөнхийлөгч** - бүх нийтийн санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч бөгөөд олон улстай гэрээ хэлэлцээр хийх, парламентын хэлэлцүүлэгт оролцоно.<br>• **Ерөнхий сайдыг** Парламентын зөвшөөрснөөр Ерөнхийлөгч томилно. Тэрээр засгийн газрын тэргүүн бөгөөд Сайд нарын танхимыг удирдана.<br>• **Сайд нарын танхимын** 21 гишүүнийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Ерөнхийлөгч нэр дэвшүүлж Парламент батална. |
| 30. | **Нидерланд** | • **Эзэн хаан** нь угсаа залгамжлагч, төрийн тэргүүн ба сонгуулийн дараа Парламентын 2-р танхимын удирдалагыг батламжилж, түүний байгуулалтыг тогтоож, Засгийн газрын бодлогыг тодорхойлно.<br>• **Ерөнхий сайдаар** Парламентад олонх болсон нам, эвслийн тэргүүнийг Эзэн хаан томилно. Тэрээр Засгийн газрын тэргүүн, Сайд нарын зөвлөлийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг удирдана.<br>• **Сайд нарын Зөвлөлийг** Эзэн хаан томилно. Зөвлөлийн гишүүнээр Парламентын гишүүн бус хүнийг сонгоно. |
| 31. | **Норвеги** | • **Эзэн хаан** – Угсаа залгамжлагч эзэн хаан нь төрийн тэргүүн, хуурай замын болон усан цэргийн ерөнхий командлагч, Норвегийн сүм, хийдүүдийн тэргүүн байна. Парламентын онцгой чуулганыг зарлан хуралдуулах, нээх, хуульд хориг тавих эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** – Парламентад олонх болсон нам, эвслийн тэргүүнийг Ерөнхий сайдад нэр дэвшүүлж, Парламентын зөвшөөрсний дагуу Эзэн хаан томилно. Тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ. |

DIP.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | • **Төрийн зөвлөлийн** гишүүдийг Парламентын зөвшөөрсний дагуу Эзэн хаан томилно. |
| 32. | **Өмнөд Африк** | • **Ерөнхийлөгч** нь төрийн болон Засгийн газрын тэргүүн, Үндэсний чуулган дахь эрх баригч намын дарга ба 5 жилийн хугацаатай сонгогдоно. Танхимын гишүүдийг тэргүүлж, тэднийг томилох болон хуулийн төслийг хэлэлцүүлэх, баталах, гарын үсэг зурах эрхтэй. Түүнчлэн төрийн тэргүүн нь өөрийн хүсэлтээр, итгэл хүлээгээгүй тохиолдолд албан тушаалаасаа огцорч болно.<br>• **Дэд Ерөнхийлөгчийг** Ерөнхийлөгч томилох ба тэрээр гүйцэтгэх засгалалын үйл ажиллагаанд туслах үүрэгтэй. |
| 33. | **Папуа-Шинэ Гвиней** | • **Эзэн хаан** нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын хаан/хатан хаан байх ба тэрээр төрийн тэргүүн, билэгдлийн шинжтэй.<br>• **Амбан захирагч** - Британийн Эзэн хааны төлөөлөгчийг Үндэсний гүйцэтгэх Зөвлөл томилно.<br>• **Ерөнхий сайд** - Парламентад олонх болсон нам, эвслийн тэргүүнийг Ерөнхий сайдад нэр дэвшүүлж, Амбан захирагч томилно. Тэрээр Засгийн газрын тэргүүн бөгөөд Амбан захирагчийн зөвшөөрлөөр парламентыг тараах, шинэ сонгуулийг зарлах эрхтэй.<br>• **Үндэсний гүйцэтгэх зөвлөл** - Ерөнхий сайдаас гадна парламентад олонх болсон нам, эвслийн 27 гишүүнээс бүрдэнэ. Гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Амбан захирагч томилно. |
| 34. | **Польш** | • **Ерөнхийлөгч** нь бүх нийтийн санал хураалтаар 5 жилээр хугацаатайгаар сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч бөгөөд гадаад харилцааны бодлогыг тодорхойлох, парламентыг тараах эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** нь Доод танхимд олон суудал авсан нам эвслийн тэргүүн байх ба түүний Ерөнхийлөгч томилж, Доод танхим батлана. Тэрээр улс орны дотоод хэргийг удирдан чиглүүлэх ба Сайд нарын зөвлөлийг удирдана.<br>• **Дэд ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилж, Парламентыг Доод танхим батлана.<br>• **Сайд нарын зөвлөлийн** гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Ерөнхийлөгч томилж, Доод танхим батлана. |
| 35. | **Португали** | • **Ерөнхийлөгч** нь ард нийтийн санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Төрийн зөвлөлийн албаны тэргүүн, элчин сайд нарыг томилох, дайн зарлах, одон медаль, шагнал урамшуулал олгох эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** сонгуулийн дараа Үндэсний чуулгантай зөвшилцөж Ерөнхийлөгч томилно. Ерөнхий сайд нь Засгийн газрын тэргүүн.<br>• **Сайд нарын Зөвлөл** нь 15-18 сайд нараас бүрдэнэ. Ерөнхий сайдын зөвлөснөөр Ерөнхийлөгчийн томилно. |
| 36. | **Самоа** | • **Төрийн тэргүүн** нь бүх насаараа сонгогдон ажиллах ба Парламентаас залгамжлагчийг сонгоно.<br>• **Ерөнхий сайдыг** Парламентаас олонхын санал авсан хүнийг сонгох ба Төрийн тэргүүн нь 5 жилийн хугацаатай томилно. Тэрээр засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын танхимын** 12 гишүүнийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Парламентын гишүүдээс Төрийн тэргүүн томилж, Парламент батална. Танхимын гишүүд нь Засгийн газрын үйл ажиллагааг хянана. |
| 37. | **Сан-Марино** | • **Капитан-регент** - Дээд ерөнхий зөвлөлөөс жилд 2 капитан-регентийг томилох бөгөөд Капитан-регент нь төрийн тэргүүний албыг тус бүрдээ хагас жилээр гүйцэтгэдэг. Капитан-регент нь Дээд ерөнхий зөвлөл, Төрийн конгресс, 12-ын зөвлөлийг тэргүүлнэ.<br>• **Төрийн конгресс** нь Парламентаас сонгогдсон 10 нарийн бичгийн даргаас бүрдэх ба 5 жилийн хугацаатай төрийн сайдын үүргийг гүйцэтгэнэ. Төрийн конгресс нь хууль эрх зүй, бодлогын хэрэгжилт, зорилтуудыг шийдвэрлэх, зохион байгуулах үүрэгтэй. Гадаад болон улс төрийн хэрэг хариуцсан Төрийн нарийн бичгийн дарга нь засгийн газрын тэргүүн байна. |
| 38. | **Сент-Винсент ба Гренадин** | • **Эзэн хаан** нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын хаан/хатан хаан байх ба тэрээр төрийн тэргүүн, билэгдлийн шинжтэй.<br>• **Амбан захирагчийг** сонгуулийн дараа Эзэн хаан томилно. Тэрээр Британийн Эзэн хааныг төлөөлөн ажиллана.<br>• **Ерөнхий сайд** - Парламентад олонх болсон нам, эвслийн тэргүүнээр Амбан захирагч томилно. Ерөнхий сайд нь Засгийн газрыг тэргүүн, Сайд нарын танхимын үйл ажиллагаанд хяналт тавих, сонгууль зарлах эрхтэй.<br>• **Шадар сайд** - Ерөнхий сайдын зөвлөснөөр Амбан захирагч томилно. |

UILMN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | • **Сайд нарын танхимын** гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Амбан захирагч томилно. Танхим нь засгийн газрын үйл ажиллагааг хянана. |
| 39. | **Сент-Китс ба Невис** | • **Эзэн хаан** нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын хаан/хатан хаан байх ба тэрээр төрийн тэргүүн, билэгдлийн шинжтэй.<br>• **Амбан захирагчийг** сонгуулийн дараа Эзэн хаан томилно. Тэрээр Британийн Эзэн хааныг томилно.<br>• **Ерөнхий сайд** нь Парламетад олонх болсон нам, эвслийн тэргүүн байх ба Амбан захирагч томилно. Тэрээр Засгийн газрыг тэргүүлж, бүх нийтийн сонгуулийг зарлах эрхтэй.<br>• **Шадар сайдыг** Амбан захирагч томилно.<br>• **Сайд нарын танхимын** гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Амбан захирагч томилно. Засгийн газрын үйл ажиллагааг хянана. |
| 40. | **Сент-Люси** | • **Эзэн хаан** нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын хаан/хатан хаан байх ба тэрээр төрийн тэргүүн, билэгдлийн шинжтэй.<br>• **Амбан захирагч** - Британийн Эзэн хааны төлөөлөгчийг Үндэсний гүйцэтгэх Зөвлөл томилно. Тэрээр Танхимын итгэл хүлээлгэх эсэх тухай санал хураалтын дараа, эсвэл Ерөнхий сайдын хүсэлтээр Парламентыг тараах эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** - Парламентад олонх болсон нам, эвслийн тэргүүнээр сонгуулийн дараа Амбан захирагч томилно. Ерөнхий сайд засгийн газрын тэргүүн бөгөөд өөрийн тэргүүлж буй танхимыг толгойлно. |
| 41. | **Сингапур** | • **Ерөнхийлөгч** – Бүх ард түмний санал асуулгаар 6 жилийн хугацаатайгаар сонгогдоно.<br>• **Ерөнхий сайдад** Парламентад олонхын суудал авсан нам, эвслийн тэргүүнийг нэр дэвшүүлж, Ерөнхийлөгч томилно.<br>• **Сайд нарын танхим** нь Парламентын гишүүдээс бүрдэх ба Ерөнхий сайдын зөвлөсний дагуу Ерөнхийлөгч томилно. |
| 42. | **Словак** | • **Ерөнхийлөгч** нь бүх нийтийн санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгогдоно. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байх ба хуулийн төсөлд хориг тавих, парламентыг тараах, төрийн дээд одон медаль, шагнал гардуулах эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** нь парламентад олонхын суудал авсан нам эвслийн тэргүүн байх бөгөөд Ерөнхийлөгч томилно.<br>• **Сайд нарын танхимын** гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Ерөнхийлөгч томилно. Танхимын гишүүд нь засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 43. | **Словян** | • **Ерөнхийлөгч** - бүх нийтийн шууд санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.<br>• **Ерөнхий сайд** - Ерөнхийлөгч нь Парламентад олонх болсон нам, эвслийн тэргүүнийг Ерөнхий сайдад нэр дэвшүүлж, Парламент нь батлана. Тэрээр Засгийн газрын тэргүүн, танхимынхаа хамт төрийн бодлогыг боловсруулна.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** гишүүдийг Ерөнхий сайд нэр дэвшүүлж, Парламент батална. |
| 44. | **Соломоны арлууд** | • **Эзэн хаан** нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын хаан/хатан хаан байх ба төрийн тэргүүн, билэгдлийн шинжтэй.<br>• **Амбан захирагч** нь 5 жилийн хугацаатай Үндэсний Ассамблейгаас томилогдох ба Британийн Эзэн хааныг төлөөлнө.<br>• **Ерөнхий сайд** Парламентад олонх болсон нам, эвслийн тэргүүнийг Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх ба Үндэсний парламентаас 5 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын танхимын** 20 гишүүдийг Ерөнхий сайд нь Парламентын гишүүдээс сонгон томилно. |
| 45. | **Суринам** | • **Ерөнхийлөгчийг** Үндэсний чуулганы гишүүдийн 3/4 хувийн саналаар 5 жилийн хугацаатай сонгох ба хэрэв парламент зөвшөөрөхгүй бол Ард түмний чуулганаар сонгоно. Тэрээр төрийн тэргүүн байна.<br>• **Дэд Ерөнхийлөгч** нь Үндэсний Ассамблейн олонхын саналаар 5 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр Сайд нарын Зөвлөлийг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** гишүүдийг Ерөнхийлөгч томилж, Үндэсний Ассамблейд ажлаа тайлагнана.<br>• **Төрийн зөвлөлийн** 15 гишүүнийг Парламентад суудалтай улс төрийн намуудаас ижил тэнцүү хэмжээтэй томилно. Зөвлөлийг Ерөнхийлөгч тэргүүлэх ба зөвлөгөө үүрэгтэй. |
| 46. | **Тайланд** | • **Хаан** нь угсаа залгамжлах эрхтэй ба улсын тэргүүн, үндэсний эв нэгдлийн билэгдэл байна. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | • **Ерөнхий сайд** нь Парламетад олонхын суудал авсан нам, эвслийн удирдагч байх ба Хаан томилно. Тэрээр Засгийн газрыг тэргүүлж, Сайд нарын Зөвлөлийг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын Зөвлөл** нь Засгийн газрын тэргүүн болон 5 шадар сайдыг оролцуулаад нийт 25 гишүүнтэй. Зөвлөлийн гишүүд нь Засгийн газрын бодлогыг тодорхойлох, нөөцийн тараалт хувиарлалтад хяналт тавих, тодруулах үүрэгтэй. |
| 47. | **Тринадад ба Тобаго** | • **Ерөнхийлөгч** - Парламентын чуулганаас 5 жилийн хугацаатай сонгогдоно. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн ба Ерөнхий сайдын саналаар сонгуулийг хугацаанаас нь өмнө зарлах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдаар** Төлөөлөгчдийн танхимд олонх болсон нам, эвслийн тэргүүнийг Ерөнхийлөгч томилно. Тэрээр Засгийн газрын тэргүүн, Сайд нарын Танхимыг удирдах болно.<br>• **Сайд нарын Танхимын гишүүдийг** Парламентаас сонгон нэр дэвшүүлж, Ерөнхий сайд томилно. Танхимын гишүүд нь засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, Парламентад тайлагнах үүрэгтэй. |
| 48. | **Турк** | • **Ерөнхийлөгч** нь Парламентаас 7 жилийн хугацаатайгаар сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн ба Парламентыг тараах, олон улсын гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурах, шагнал гардуулах эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** нь Парламентад олон суудал авсан нам эвсэлийн тэргүүн байх ба Ерөнхийлөгч томилно. Тэрээр Засгийн газрын тэргүүн.<br>• **Сайд нарын зөвлөл** нь Ерөнхий сайд тэргүүтэй 20-24 гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий сайд нь гишүүдийг санал болгож, Ерөнхийлөгч нь томилно.. |
| 49. | **Унгар** | • **Ерөнхийлөгч** нь 5 жилийн хугацаатайгаар Парламентаас сонгогдоно. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Тэрээр бүх ард түмний санал асуулга санаачлах, хуулийн төслийг парламентаар дахин хэлэлцүүлэхээр буцаах эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** нь Парламентад олонхи болсон намын гишүүн байх ба Парламентаас баталж, Ерөнхийлөгч томилно. Тэрээр засгийн газрын тэргүүний хувьд улс орныхоо дотоод бодлогыг удирдан чиглүүлэх, Сайд нарын танхимыг тараах эрхтэй.<br>• **Сайд нарын танхимын** гишүүдийг Ерөнхий сайд томилж, Парламент батална. |
| 50. | **Финланд** | • **Ерөнхийлөгч** - Бүх нийтийн санал хураалтаар 6 жилийн хугацаатай сонгогдоно. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч бөгөөд хууль санаачлах, хууль тогтоомжид хориг тавих, парламентыг тараах, онцгой чуулган зарлах эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** - Парламентад олонх болсон нам, эвслийн даргыг Ерөнхий сайдад нэр дэвшүүлж, Ерөнхийлөгч томилно. Ерөнхий сайд нь Засгийн газрын тэргүүн, Сайд нарын танхимыг удирдана.<br>• **Сайд нарын танхимын** 15 гишүүнийг Ерөнхийлөгч томилно. Танхим нь хуулийн төсөл санаачлах, төрийн албанд хяналт тавьж ажиллана. |
| 51. | **Хорват** | • **Ерөнхийлөгч** - бүх нийтийн санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч, онц байдлын үед улс орныг тэргүүлнэ.<br>• **Ерөнхий сайд** - Ерөнхийлөгч нэр дэвшүүлж, Парламент батална. Тэрээр Засгийн газрыг тэргүүлэх, улсын төсвийг төсөвлөх, хууль тогтоомжийг гүйцэтгэх, дотоод, гадаад бодлогыг хөтлөн явуулах үүрэгтэй.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Ерөнхийлөгч томилж, Парламент батлана. Зөвлөлийг Ерөнхий сайд тэргүүлнэ. |
| 52. | **Чех** | • **Ерөнхийлөгчийг** Парламентын 2 танхимын хамтарсан хуралдаанаар хэлэлцэж 5 жилийн хугацаатай сонгоно. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн. Тэрээр Төлөөлөгчдийн танхимыг тараах, сонгууль зарлах, хууль санаачлах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилно. Тэрээр засгийн газрын тэргүүн, улс орны гадаад, дотоод улс төрийн бодлогын зорилгыг хэрэгжүүлнэ.<br>• **Сайд нарын Зөвлөлийг** Ерөнхий сайдын зөвлөсний дагуу Ерөнхийлөгч томилно. Зөвлөл нь засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана. |
| 53. | **Швед** | • **Эзэн хаан** нь угсаа залгамжлагч, төрийн тэргүүн байна.<br>• **Ерөнхий сайд** нь Парламентаас сонгогдох ба Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын танхимын** 21 сайдыг Парламентаас сонгоно. Танхимын гишүүд нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 54. | **Швейцарь** | • **Холбооны зөвлөлийн** 7 гишүүнийг парламентаас 4 жилийн хугацаатай |

UILMN СУДАЛ ДАНЫСАН

| | | |
|---|---|---|
| | | сонгоно. Тэдний 2 нь Христийн ардчиллын нам, 2 нь Социал демократ нам, 2 нь Чөлөөт ардчиллын нам, 1 нь Швейцарийн ардын намаас тус тус сонгогдоно. Холбооны зөвлөлийн гишүүд нь засгийн үйл ажиллагаанд хяналт тавина.<br>• **Ерөнхийлөгчийг** жил бүр Холбооны зөвлөлийн гишүүдээс сонгож, Парламентаас баталдаг. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн ба Холбооны зөвлөлийн үйл ажиллагаанд зохион байгуулах эрхтэй.<br>• **Дэд ерөнхийлөгчийг** жил бүр Холбооны зөвлөлийн гишүүдээс сонгож Парламентаас батална. Тэрээр Ерөнхийлөгчийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ түүнийг эзгүй үед Ерөнхийлөгчийн үүргийг гүйцэтгэнэ. |
| 55. | **Шинэ Зеланд** | • **Амбан захирагч** - Сонгуулийн үйл ажиллагаа дууссаны дараа Их Британы Эзэн хаан томилно. Амбан захирагч нь засгийн газрыг тэргүүлэх, хуулийн төслийг зөвшөөрөх, парламентыг тараах эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** - Парламентад олонх болсон нам эвслийн тэргүүнийг Ерөнхий сайдад нэр дэвшүүлж, Амбан захирагч томилно. Тэрээр засгийн газрыг тэргүүлэх ба Парламентын сонгуулийг зогсоох эрхтэй.<br>• **Сайд нарын танхим** - Парламентын 15-20 гишүүдээс бүрдэх ба Ерөнхий сайдын зөвлөснөөр Амбан захирагч томилно. |
| 56. | **Энэтхэг** | • **Ерөнхийлөгч** – Орон нутгийн хууль тогтоох байгууллагууд, Парламентын хоёр танхимын гишүүдээр батламжуулсны эцэст 5 жилийн хугацаатай сонгогддог. Тэрээр төрийн тэргүүн, үндэсний эв нэгдлийн билэг тэмдэг байна.<br>• **Дэд Ерөнхийлөгч** – 5 жилийн хугацаатай сонгогдох ба бүрэн эрхийх нь хугацаа Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаанаас шууд хамаардаг. Тэрээр Дээд танхимын дарга болно.<br>• **Ерөнхий сайд** – Хууль тогтоох байгууллагын сонгуулийн дараа Доод танхимыг бүрдүүлж буй олонхын нам бүлгийн даргыг Ерөнхийлөгч Засгийн газрын тэргүүнээр сонгодог. Ерөнхий сайд нь Сайд нарын зөвлөлийн шийдвэрийг Ерөнхийлөгчид дамжуулах үүрэгтэй.<br>• **Сайд нарын зөвлөл** – Ерөнхий сайдын санал болгосны дагуу Ардын танхимын гишүүдийн дэмжлэгтэйгээр Ерөнхийлөгч томилдог ба төрийн сайдууд болон дэд сайдуудыг парламент баталдаг. |
| 57. | **Эстони** | • **Ерөнхийлөгч** - Парламентаас 5 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр төрийн тэргүүн бөгөөд дипломат албад албан тушаалтнуудыг томилох, хуулийн төслийг Парламентаар дахин хэлэлцүүлэхээр буцаах эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** - Ерөнхийлөгч нэрийг нь дэвшүүлж, Парламентаар батална. Ерөнхий сайд нь Засгийн газрыг тэргүүлэх ба төрийн бодлогыг хэрэгжүүлэх, Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** гишүүдийг Ерөнхий сайд санал болгож, Парламент батална. Зөвлөлийг Ерөнхий сайд удирдах бөгөөд Парламентад үйл ажиллагаагаа тайлагнах үүрэгтэй. |
| 58. | **Ямайк** | • **Эзэн хаан** нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын хаан/хатан хаан байх ба төрийн тэргүүн, билэгдлийн шинжтэй.<br>• **Амбан захирагч** - Эзэн хааныг төлөөлөх ба сонгуулийн дараа Ерөнхий сайдтай зөвшилцсөний дараа Эзэн хаан томилно.<br>• **Ерөнхий сайд** - Парламентад олонх болсон нам эвслийн тэргүүнийг Ерөнхий сайдад нэр дэвшүүлж, Амбан захирагч томилно. Ерөнхий сайд нь Засгийн газрын тэргүүн, Төлөөлөгчдийн танхимд ажлаа тайлагнах үүрэгтэй.<br>• **Сайд нарын танхимын** гишүүдийг Парламентын гишүүдээс сонгож Ерөнхий сайд томилно. Танхимын гишүүд нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 59. | **Япон** | • **Эзэн хаан** нь угсаа залгамжлагч, төрийн тэргүүн бөгөөд гүйцэтгэх засаглалыг удирдахгүй. Түүний хязгаарлагдмал эрх мэдэл Зөвлөлийн болон Сайд нарын танхимын зөвшөөрлөөр хэрэгжинэ. Тэрбээр Ерөнхий сайд, Ерөнхий шүүгч, Сайд нарын танхимын гишүүдийг томилж, Үндсэн хуульд өөрчлөлт, засвар оруулахыг зарлах, Төлөөлөгчдийн танхимыг тараах, Үндэсний зөвлөлийг зарлан хуралдуулах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** ихэвчлэн Төлөөлөгчдийн танхимд олонх болсон нам, эвслийн гишүүдээс Үндэсний зөвлөлийн нууц санал хураалтаар сонгоно. Тэрээр өөрийн танхимын гишүүдийг сонгож, Эзэн хаан 4 жилийн хугацаатай томилдог.<br>• **Сайд нарын танхимыг** Ерөнхий сайд даргалж, Үндсэн хуулийн дагуу 14 гишүүнийг томилох ба тэдний гурвыг нь тусгай гишүүдээр томилж болно. Ерөнхий сайд хүсвэл гишүүдийн талыг нь Зөвлөлөөс томилно. |
| | | ❖ **ОЛОН НАМЫН ЗАСАГЛАЛ** |
| 60. | **Азербайжан** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн шууд санал хураалтаар 5 жилийн хугацаатай |

| | | |
|---|---|---|
| | | сонгоно. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилж, Парламент батлана Тэрээр Засгийн газрын тэргүүн, Сайд нарын Зөвлөлийг даргална.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** 8 гишүүнийг Ерөнхийлөгч томилж, Парламент батална. |
| 61. | **Албани** | • **Ерөнхийлөгч** - Ард Түмний Чуулганы гишүүдийн 3/5 хувийн нууц санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр төрийн тэргүүн бөгөөд хуулийн төслийг Парламентад буцаах, төрийн дээд одон медаль, шагнал гардуулах, цол олгох, бүх ард түмний санал асуулга болон сонгуулийн товийг зарлах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ард Түмний Чуулганд олонх болсон намын тэргүүн байх ба Ерөнхийлөгч томилж, Парламент батламжилна. Тэрээр засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** гишүүдийг Ерөнхий сайд нэр дэвшүүлж, Ерөнхийлөгч томилно. Зөвлөлийг Ерөнхий сайд даргалах ба засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 62. | **Алжир** | • **Ерөнхийлөгч** нь бүх нийтийн санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч бөгөөд хууль санаачлах, Парламентыг тараах, сонгуулийн товийг урьдчилан зарлах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилох ба тэрээр засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** гишүүдийг Ерөнхий сайд томилно. Сайд нарын Зөвлөл нь Засгийн газрын хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 63. | **Армян** | • **Ерөнхийлөгч** нь бүх нийтийн санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн бөгөөд Үндэсний чуулганыг тараах, зарлиг тогтоол гаргах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилох ба Үндэсний чуулганы гишүүн байх албагүй. Тэрээр Засгийн газрыг тэргүүлж, Сайд нарын Зөвлөлийг даргална.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** гишүүнээр Үндэсний чуулганы гишүүнийг сонгохгүй ба гишүүдийг Ерөнхий сайд томилно. Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 64. | **Болгар** | • **Ерөнхийлөгч** нь 5 жилийн хугацаатай сонгогдох ба нэг удаа улиран сонгогдох эрхтэй. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь хуулийн төслийг Үндэсний чуулганд буцаах, олон улсын гэрээ хэлэлцээрүүдийг батлах, хэлэлцэх, гарын үсэг зурах, дипломат албаны түшмэлүүдийг томилох, төрийн дээд одон медаль, шагнал гардуулах эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** нь Үндэсний чуулганд олонх болсон нам, эвслийн тэргүүн байх ба түүнийг Ерөнхийлөгч томилно. Тэрээр Засгийн газрыг тэргүүн, Сайд нарын Зөвлөлийг даргална.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** гишүүдийг Ерөнхий сайд томилж, Парламент батална. Сайд нарын Зөвлөл нь Засгийн газрын үйл ажиллагаа, улсын төсөвт хяналт тавина. |
| 65. | **Босни Герцоговин** | • **Ерөнхийлөгч** - Серб, Хорват, Бошнык тус бүр Ерөнхийлөгчтэй байх ба тэдгээр гурав нь өөрсдийн үндэстнүүдийн санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгогдоно. Энэ гурван ерөнхийлөгч нь 8 сарын хугацаатайгаар Босни Герцеговиныг ээлжлэн захирна. Ерөнхийлөгч нь гадаад хэргийг явуулах, элчин сайд нарыг томилох, Парламентын шийдвэрийг хянах эрхтэй.<br>• **Сайд нарын Танхимын** гишүүдийг Парламент батлана. Танхимын даргыг Ерөнхийлөгч нэр дэвшүүлж, Парламент батлана. |
| 66. | **Буркино Фасо** | • **Ерөнхийлөгч** нь бүх нийтийн санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн бөгөөд хууль санаачлах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилж, Парламент батлах ба тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** 36 гишүүд нь нам бус болон сөрөг хүчний намын гишүүд байх ба Ерөнхий сайдын зөвлөснөөр Ерөнхийлөгч томилно. |
| 67. | **Габон** | • **Ерөнхийлөгчийг** нийтийн шууд санал хураалтаар 7 жилийн хугацаатай бүх сонгоно. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь онц байдлыг зарлах, Парламентыг тараах, шинээр бүх нийтийн санал асуулга зарлах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилно. Тэрээр Засгийн газрын тэргүүлнэ.<br>• **Сайд нарын танхимын** 39 гишүүдийг Үндэсний чуулганаас сонгож, Ерөнхий сайдын зөвлөснөөр Ерөнхийлөгч томилно. Танхим нь засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 68. | **Гаити** | • **Ерөнхийлөгч** - бүх нийтийн санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгох ба |

UGHMN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | нэг удаа улируулж болно. Тэрээр төрийн тэргүүн бөгөөд хууль дэлгэрүүлэх, шүүхийн шийдвэрийг баталгаажуулах, элчин сайд нарыг томилох, төрийн дээд одон медаль, шагнал гардуулах эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** - Үндэсний чуулганд олонх болсон намын даргыг сонгуулийн дараа Ерөнхийлөгч томилж, Парламент батлана. Ерөнхий сайд нь Засгийн газрыг тэргүүлэх ба танхимынхаа гишүүд, бусад албан тушаалтнуудыг томилох, огцруулах эрхтэй.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** гишүүдийг Ерөхийлөгчийн зөвлөснөөр Ерөнхий сайд томилно. Зөвлөлийг Ерөнхийлөгч даргална. Зөвлөл нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 69. | **Гамби** | • **Ерөнхийлөгч** - бүх нийтийн шууд санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь Үндэсний чуулганы хуралдааныг зарлах, тараах, шинэ сонгуулийг зарлах эрхтэй.<br>• **Дэд ерөнхийлөгчийг** Ерөнхийлөгч томилно.<br>• **Сайд нарын танхимын** гишүүд нь Үндэсний чуулганы гишүүд байх бөгөөд тэднийг Ерөнхийлөгч томилно. |
| 70. | **Гвиней** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн шууд санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь тогтоол гаргах, хууль санаачлах, төрийн албан хаагчдыг томилох, Үндэсний Ардын чуулганыг тараах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилох ба тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** 25 гишүүнийг Ерөнхийлөгч томилно. Зөвлөлийг Ерөнхийлөгч удирдах бөгөөд Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 71. | **Зааны Ясан Эрэг** | • **Ерөнхийлөгч** - бүх нийтийн санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч хууль санаачлах, бүх нийтийн санал асуулга зарлах, төрийн болон цэргийн өндөр албан тушаалтныг томилох, олон улсын гэрээ хэлэлцээрүүдийг батлах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилох ба тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын танхимын** гишүүдийг Ерөнхийлөгч томилно. Ерөнхийлөгч Танхимыг даргална. |
| 72. | **Зүүн Тимор** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн шууд санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр төрийн тэргүүн байна.<br>• **Ерөнхий сайд** нь Парламентад олонх болсон нам эвслийн тэргүүн байх ба түүнийг Ерөнхийлөгч томилно. Ерөнхий сайд нь Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Төрийн зөвлөлийн** 9 сайд, 8 нарийн бичгийн даргыг Зүүн Тимор дахь НҮБ-ийн шилжилтийн удирдлага, Парламент хоорондын зөвшилцлийн дагуу сонгоно. |
| 73. | **Йемен** | • **Ерөнхийлөгч** - бүх нийтийн санал хураалтаар 7 жилийн хугацаатай сонгогдох ба нэг удаа улируулан сонгож болно. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь хууль дэлгэрүүлэх, бүх нийтийн санал асуулгыг зарлах, төрийн болон цэргийн албан тушаалтнуудыг томилох, улс төрийн орогнол олгох эрхтэй.<br>• **Дэд Ерөнхийлөгчийг** Ерөнхийлөгч томилно.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилох ба тэрээр засгийн газрын тэргүүлж, Сайд нарын Зөвлөлийг даргална.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Ерөнхийлөгч томилно. Сайд нарын Зөвлөл нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, улсын төсвийг гаргах, хэлэлцэх үүрэгтэй. |
| 74. | **Индонези** | • **Ерөнхийлөгч** - бүх нийтийн санал хуралтаар 5 жилийн хугацаатай сонгогдоно. Ерөнхийлөгч бол төр, засгийн газрын тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Тэрээр дүрэм журам тогтоох, дайн зарлах, олон улсын гэрээ хэлэлцээрүүдийг батлах эрхтэй.<br>• **Дэд ерөнхийлөгч** - Бүх нийтийн санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгогдоно.<br>• **Сайд нарын Танхим** - Ерөнхийлөгч танхимын гишүүдийг томилох ба танхим нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 75. | **Кабо Верде** | • **Ерөнхийлөгч** нь бүх нийтийн шууд санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгогдоно. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн банйа.<br>• **Ерөнхий сайдыг** Парламентаас нэр дэвшүүлж Ерөнхийлөгч томилно. Тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** гишүүдийг Ерөнхий сайд томилно. |
| 76. | **Ливан** | • **Ерөнхийлөгч** нь бүх нийтийн санал хураалтаар 6 жилийн хугацаатай |

| | | |
|---|---|---|
| | | сонгогдох ба улиран сонгогдохгүй. Үндэсний чуулганы гишүүдийн 2/3 хувиар олонхын санал авсан тохиолдолд сонгогдоно. Уламжлалын дагуу Маринатын христийн шашинтанг томилно. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байх ба хууль дэлгэрүүлэх, хуулийн төсөлд хориг тавих, дүрэм, журамд хяналт тавих, олон улсын гэрээ хэлэлцээрүүдийг батлах, Үндэсний чуулганыг тараах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Үндэсний чуулганаас зөвласний дагуу Ерөнхийлөгч томилно. Уламжлал ёсоор Сунни Лал шашныхан байна.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Ерөнхийлөгч томилно. Зөвлөлийг Ерөнхий сайд тэргүүлнэ. |
| 77. | **Мавритан** | • **Ерөнхийлөгч** - Бүх нийтийн санал хураалтаар 6 жилийн хугацаатайгаар томилно. Ерөнхийлөгч нь Лалын шашинтан байх ба тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилох бөгөөд тэрээр Засгийн газрыг тэргүүлж, түүний бодлогыг тодорхойлж чиглүүлэнэ.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөсний дагуу Ерөнхийлөгч томилно. Зөвлөлийг Ерөнхийлөгч тэргүүлнэ.<br>• **Лалын Зөвлөлийн** гишүүд нь Ерөнхийлөгчийн томилсон лалын 5 тэргүүн байх ба тэд Ерөнхийлөгчид зөвөлгөө өгнө. |
| 78. | **Македон** | • **Ерөнхийлөгч** - бүх нийтийн шууд санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь хуулийн төсөлд хориг тавих, батлах, төрийн дээд одон шагнал, цол гардуулна.<br>• **Ерөнхий сайд** нь Парламентад олонх болсон нам эвслийн тэргүүн байна. Ерөнхийлөгч нэрийг нь дэвшүүлж, Парламентаар батална. Ерөнхий сайд нь Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын танхимын** гишүүдийг Чуулганаар сонгоно. Танхим нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, улсын төсөвт санал оруулна. |
| 79. | **Мали** | • **Ерөнхийлөгч** нь бүх нийтийн санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь хуульд хориг тавих, Үндэсний чуулганыг тараах, бүх нийтийн санал хураалтыг зарлах, төрийн дээд одон медаль гардуулах, өршөөл үзүүлэх, үндэсний онцгой байдлыг зарлах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилох бөгөөд тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** 22 гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Ерөнхийлөгч томилно. |
| 80. | **Мозамбик** | • **Ерөнхийлөгч** - бүх нийтийн санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төр, засгийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байх ба Парламентыг тараах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилох бөгөөд тэрээр Сайд нарын Зөвлөлийг тэргүүлэх, улсын төсөв гаргах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг Парламентад танилцуулна.<br>• **Сайд нарын Зөвлөлийг** Ерөнхийлөгч томилно. |
| 81. | **Монгол Улс** | • **Ерөнхийлөгч** нь Улсын Их Хуралд суудал бүхий намаас нэр дэвшүүлж бүх нийтийн санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгогдох ба нэг удаа улируулан сонгогдох эрхтэй. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь олон улсын гэрээ байгуулах, Засгийн газарт чиглэл өгөх, төрийн дээд одон медалиар шагнах, хуульд хориг тавих, хуулиар тогтоосон журмын дагуу Парламентыг тараах эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** - Парламентад олонх болсон намын даргыг Ерөнхийлөгчтэй зөвшилцөж Улсын Их Хурал 4 жилийн хугацаагаар томилно. Тэрээр Засгийн газрын тэргүүн байна.<br>• **Сайд нарын Танхимын** гишүүдийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлж, Улсын Их Хурал батлана. |
| 82. | **Нигер** | • **Ерөнхийлөгч** нь бүх нийтийн санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн байна.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилох бөгөөд тэрээр Ерөнхийлөгчийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.<br>• **Сайд нарын Танхимын** 23 гишүүнийг Ерөнхийлөгч томилно. Танхимыг Ерөнхийлөгч даргалах ба Танхим нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 83. | **Нигерия** | • **Ерөнхийлөгч** - бүх нийтийн санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгогдоно. Ерөнхийлөгч бол төр, засгийн газрын тэргүүн, зэвсэгт хүчний |

| | | |
|---|---|---|
| | | ерөнхий командлагч байна.<br>• **Холбооны гүйцэтгэх зөвлөлийн** гишүүдийг Ерөнхийлөгч томилох бөгөөд Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй. |
| 84. | **Румын** | • **Ерөнхийлөгч** - бүх нийтийн санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь хуулийн төслийг Парламентад буцаах, Парламентыг тараах, бүх нийтийн санал хураалтыг зарлах, зарлиг тогтоолд Ерөнхий сайдын хамтаар гарын үсэг зурах, батламжлах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч нэр дэвшүүлж, Парламентын хоёр танхимаар батлуулна. Тэрээр Засгийн газрын тэргүүн, Сайд нарын Зөвлөлийг даргална.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** гишүүдийг Ерөнхий сайд томилно. Танхим нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, Парламентад үйл ажиллагаагаа тайлагнах үүрэгтэй. |
| 85. | **Сао-Томе ба Принсип** | • **Ерөнхийлөгч** - Бүх нийтийн санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгогдох ба нэг удаа улиран сонгогдох эрхтэй. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилж, Парламент батална. Тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** 14 гишүүнийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Ерөнхийлөгч томилно. Зөвлөлийг Ерөнхий сайд тэргүүлнэ. Зөвлөл нь Засгийн газрын үйл ажиллагааг хянах, Ерөнхийлөгч болон Парламентад үйл ажиллагаагаа тайлагнана. |
| 86. | **Сейшелийн арлууд** | • **Ерөнхийлөгч** нь Бүх нийтийн санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгогдоэо. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь төрийн дээд одон медаль, шагнал гардуулах, Засгийн газрыг байгуулах, татан буулгах, элчин сайдуудыг томилох, олон улсын гэрээ хэлэлцээрүүдийг батлах, Парламентыг тараах эрхтэй.<br>• **Сайд нарын зөвлөлийг** Ерөнхийлөгч томилж, тэргүүлнэ. Сайд нарын Зөвлөл нь Засгийн газрын үйл ажиллагааг хянана. |
| 87. | **Серб** | • **Ерөнхийлөгч** - Үндэсний Чуулганаас 4 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн бөгөөд Сайд нарын Зөвлөлийг удирдана.<br>• **Сайд нарын Зөвлөл** нь 4 жилийн хугацаатай сонгогдсон 5 гишүүнтэй. |
| 88. | **Сьерра-Леоне** | • **Ерөнхийлөгч** - бүх нийтийн санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төр, засгийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь Төлөөлөгчдийн танхимыг тараах, шинэ сонгуулийн товыг зарлах эрхтэй.<br>• **Дэд ерөнхийлөгч** нь Ерөнхийлөгч томилох ба Төлөөлөгчдийн танхимын гишүүн байна.<br>• **Төрийн сайд нарын танхимын** 17 гишүүнийг Ерөнхийлөгч томилж, Төлөөлөгчдийн танхим баталах ба тэд Төлөөлөгчдийн танхимын гишүүд байна. Танхим нь засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 89. | **Тайвань** | • **Ерөнхийлөгч** нь бүх нийтийн шууд санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байх ба Парламентыг тараах, сонгуулийн товыг зарлах, Гүйцэтгэх танхимыг тараах эрхтэй.<br>• **Дэд ерөнхийлөгчийг** Ерөнхийлөгчийг сонгохтой адил зармаар сонгох ба тэрээр Ерөнхийлөгчид туслах үүрэгтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилно. Тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Гүйцэтгэх Танхимыг** Ерөнхийлөгч томилж, Ерөнхий сайд удирдана. Танхим нь засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих бөгөөд онц байдал зарлах бүрэн эрхийг Ерөнхийлөгчид олгоно. |
| 90. | **Төв Африкийн БНУ** | • **Ерөнхийлөгч** - бүх нийтийн санал хураалтаар 6 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр төрийн тэргүүн бөгөөд Үндэсний Чуулганыг зарлан хуралдуулах, цэргийн албан тушаалтнуудыг томилох эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилох бөгөөд тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** гишүүдийг Ерөнхийлөгч томилж, даргална. Зөвлөл нь засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих болон хууль санаачлана. |
| 91. | **Фижи** | • **Ерөнхийлөгч** нь Тэргүүлэгчдийн их зөвлөлөөс 4 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдын зөвлөснөөр Парламентыг тараах эрхтэй.<br>• **Дэд ерөнхийлөгч** нь Тэргүүлэгчдийн их зөвлөлөөс 5 жилийн хугацаатай сонгогдоно.<br>• **Ерөнхий сайд** нь Төлөөлөгчдийн танхимын гишүүн байх ба түүнийг |

LIB.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | Ерөнхийлөгч томилж, Парламент батална. Тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын Танхим** нь 15-аас дээшгүй парламентын гишүүдээс бүрдэх бөгөөд гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Ерөнхийлөгч томилно. Танхим нь Засгийн газрын үйл ажиллагааг хянана.<br>• **Тэргүүлэгчдийн их зөвлөл** нь 46 гишүүнээс бүрдэнэ. Зөвлөл нь фижигийн уламжлалд зөвөлгөө өгнө. |
| 92. | **Франц** | • **Ерөнхийлөгч** - Төрийн тэргүүн нь 7 жилийн хугацаатай сонгогдох ба Франц улсын иргэн, сүүлийн 23 жилийн туршид Францын хууль эрх зүй, цэргийн албаны болзолуудыг хангасан байх ёстой. 30 гаруй нэгж, харьяа нутаг дэвсгэрээс 500 гаруй дэмжигчийн гарын үсэгтэй санал цуглуулан албан ёсоор нэр дэвших эрхийг олж авна. Тэрбээр олон улсын хэлэлцээр батлах, Ерөнхий сайдыг томилох, Үндэсний ассамблейг тараах бүрэн эрхтэй ба Сайд нарын зөвлөлийг тэргүүлэх, Шүүхийн дээд зөвлөлийг удирдах, Францын төрийн дээд албан тушаалтан.<br>• **Ерөнхий сайд** - Засгийн газрын тэргүүн нь парламентад олонх болсон нам эвслээс нэр дэвшин сонгогдох ба Ерөнхийлөгч тодорхой бус хугацаагаар томилно. Ерөнхий сайд нь Засгийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах бөгөөд Засгийн газрын асуулгад хариулт өгнө. Түүнчлэн танхимын тэргүүний хувьд түүний үүрэг хариуцлагыг тусган танхимын гишүүдийн зүгээс Ерөнхийлөгчид санал дэвшүүлнэ.<br>• **Сайд нарын танхимыг** Ерөнхийлөгч даргалаж, Ерөнхий сайд тэргүүлнэ. Сайд нарын зөвлөл нь 15 гүйцэтгэх агентлагуудаас бүрдэнэ. |
| 93. | **Этиоп** | • **Ерөнхийлөгч** - Бүх Ард Түмний Төлөөлөгчдийн танхимаас 6 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн байна.<br>• **Ерөнхий сайдыг** сонгуулийн дараа эрх барьж буй намаас томилох ба тэрээр Касгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** гишүүдийг нь Ерөнхий сайд нэр дэвшүүлж, Танхим батламжилна. |
| | | **ЕРӨНХИЙЛӨГЧИЙН АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛ** |
| 94. | **АНУ** | • **Ерөнхийлөгч** – Муж улс болгоноос шууд сонгогдсон сонгогчдоос бүрдсэн Сонгогчдын коллегийн саналаар 4 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төр, засгийн тэргүүн бөгөөд зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.<br>• **Дэд ерөнхийлөгч** – Ерөнхийлөгчийн адил жишгээр 4 жилийн хугацаатай сонгогдох ба тэрээр гүйцэтгэх засаглалын бодлогыг хэрэгжүүлэхэд Ерөнхийлөгчид тусална.<br>• **Сайд нарын Танхимын** 15 гишүүнийг Ерөнхийлөгч томилж, Сенат батална.<br>• **Гүйцэтгэх агентлагууд** нь гүйцэтгэх засаглалын хамгийн чухал салбар бөгөөд Конгрессоос эрх, үүргийг тодорхойлдог. |
| 95. | **Аргентин** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн шууд санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр төр, засгийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч хууль санаачлах, хуульд хориг тавих, хууль дэлгэрүүлэх, зарлиг тогтоол гаргах, өршөөл үзүүлэх эрхтэй.<br>• **Дэд ерөнхийлөгчийг** бүх нийтийн шууд санал хураалтаар 4 жилийн хугацаатайгаар сонгох ба Ерөнхийлөгчийн сонгуультай хамт зохион байгуулна.<br>• **Сайд нарын Танхимын** гишүүдийг Ерөнхийлөгч томилно. Танхимыг Ерөнхийлөгч даргална. Танхим нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 96. | **Бразил** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн сонгуулиар 4 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр төр, засгийн тэргүүн бөгөөд Холбооны сенатын зөвшөөрөлтэйгээр Төв Банкны захирал, Ерөнхий өмгөөлөгч, Дээд шүүхийн шүүгчид, элчин сайдууд зэрэг нийт 48.000 албан тушаалтнуудыг томилно. Ерөнхийлөгч нь зарлиг гаргах, хууль санаачлах, хуулийг дэлгэрүүлнэ.<br>• **Дэд ерөнхийлөгчийг** Ерөнхийлөгчийн нэгэн адилаар бүх нийтийн сонгуулиар 4 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр Ерөнхийлөгчид туслалцаа үзүүлнэ.<br>• **Сайд нарын Танхимын** гишүүдийн тоо янз бүр байна. Ерөнхийлөгч танхимыг томилох, татан буулгах эрхтэй. |
| 97. | **Венесуэл** | • **Ерөнхийлөгч** - бүх нийтийн санал хураалтаар 6 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр төрийн тэргүүн бөгөөд хууль санаачлах, хуулийн төслийн Парламентад буцаах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилно.<br>• **Сайд нарын танхимын** гишүүдийг Парламент зөвшөөрч, Ерөнхийлөгч томилно. Танхим нь засгийн үйл ажиллагааг хянана. |
| 98. | **Гана** | • **Ерөнхийлөгч** - бүх нийтийн шууд санал хураалтаар 4 жилийн хугацаатай |

| | | |
|---|---|---|
| | | сонгоно. Тэрээр төр, засгийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Засгийн газрын албан тушаалтнуудыг томилох, төрийн дээд одон медаль, цол хэргэм гардуулах, хуулийн төсөлд хориг тавих эрхтэй.<br>• **Дэд ерөнхийлөгч** - Бүх нийтийн шууд санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгоно.<br>• **Сайд нарын Зөвлөлд** Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Дэд ерөнхийлөгчөөс гадна 10-19 сайдууд багтана. Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлнэ. Ерөнхийлөгч танхимыг удирдана. |
| 99. | **Гватемала** | • **Ерөнхийлөгч** нь бүх нийтийн шууд санал хураалтаар 4 жилийн хугацаатайгаар нэг удаа сонгогдоно. Тэрээр төр, засгийн тэргүүн байна.<br>• **Дэд ерөнхийлөгч** нь бүх нийтийн шууд санал хураалтаар 4 жилийн хугацаатайгаар нэг удаа сонгогдоно. Тэрээр 4 жилийн завсарласны дараа Ерөнхийлөгчид нэр дэвшиж болно. Дэд ерөнхийлөгч нь Парламентыг даргална.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** гишүүдийг Ерөнхийлөгч томилно. Зөвлөл нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 100. | **Египет** | • **Ерөнхийлөгчийг** 2/3-ийн саналаар нэр дэвшүүлж, бүх нийтийн санал хураалтаар 6 жилийн хугацаатай сонгогдоно.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилох ба тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Танхим** нь Ерөнхийлөгчийн томилсон сайд нараас бүрдэнэ. |
| 101. | **Казакстан** | • **Ерөнхийлөгч** - бүх нийтийн шууд санал хураалтаар 7 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр төрийн тэргүүн, зэвсгэт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь хуулийн төсөлд хориг тавих, зарлиг гаргах, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг санаачлах, парламентыг тараах, бүх нийтийн санал хураалтыг зарлах, олон улсын гэрээ хэлэлцээрийг батлах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилно. Тэрээр Засгийн газрыг тэргүүлж, Танхимыг удирдана.<br>• **Сайд нарын Танхим** нь 4 шадар сайд, бусад 14 сайдуудаас бүрдэх бөгөөд тэдний Ерөнхийлөгч томилно. Танхим нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 102. | **Камерун** | • **Ерөнхийлөгч** нь бүх нийтийн шууд санал хураалтаар 7 жилийн хугацаатай сонгогдох ба нэг удаа улиран сонгогдох эрхтэй. Тэрээр төр, засгийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч бөгөөд хууль санаачлах, Засгийн газрын өндөр албан тушаалтныг томилох, улсын төсвийг хянах, төрийн өмчийн компаниудын ашгийг захиран зарцуулах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилох ба тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын зөвлөлийн** гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Ерөнхийлөгч томилно. Зөвлөлийг Ерөнхийлөгч тэргүүлнэ. Засгийн газрын үйл ажиллагааг хянана |
| 103. | **Кени** | • **Ерөнхийлөгч** нь бүх нийтийн шууд санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгогдох ба тэрээр Парламентын гишүүн байна. Тэрээр төр, засгийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь парламентыг тараах эрхтэй.<br>• **Дэд ерөнхийлөгчийг** Ерөнхийлөгч нь Парламентын гишүүдээс сонгон томилно. Хэрэв Ерөнхийлөгчийн албан тушаал 90-ээс дээш хоног эзгүй байвал Дэд ерөнхийлөгчийг тэр албан тушаалд томилно.<br>• **Сайд нарын Танхимын** гишүүдийг Ерөнхийлөгч томилно. Гишүүд нь Парламентын гишүүдээс бүрдэнэ. Танхим нь Засгийн газрын үйл ажиллагааг хянах, Парламентад тайлагнах үүрэгтэй. |
| 104. | **Колумб** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн шууд санал хураалтаар 4 жилийн хугацаатай нэг удаа сонгогдоно. Тэрээр төр, засгийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь хуулийн төсөлд хориг тавих, зарлиг гаргах, Засгийн газрын албан тушаалтнуудыг томилох, огцруулах, олон улсын гэрээ хэлэлцээрийг батлана.<br>• **Дэд ерөнхийлөгчийг** Ерөнхийлөгчийн адил 4 жилийн хугацаатай сонгоно.<br>• **Сайд нарын Танхимын** гишүүдийг Ерөнхийлөгч томилох ба Танхим нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 105. | **Мадагаскар** | • **Ерөнхийлөгч** нь бүх нийтийн шууд санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн бөгөөд хууль дэлгэрүүлэх, парламентыг тараах, Сайд нарын зөвлөлийг удирдах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилж, Парламент батална. Тэрээр Засгийн газрыг тэргүүлж, хууль санаачлах бөгөөд Засгийн газрын болон цэргийн албан тушаалтнуудыг томилно. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | • **Сайд нарын Зөвлөлийг** Ерөнхийлөгч томилно. Зөвлөл нь Засгийн газрыг хянаж, Ерөнхийлөгчид тайлагнана. |
| 106. | **Малави** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн шууд санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгоно. Ерөнхийлөгч нь төр, засгийн тэргүүн бөгөөд хууль батлах, буцаах, Парламентыг тараах, шинэ сонгуулийн товыг зарлах эрхтэй.<br>• **Дэд ерөнхийлөгчийг** Ерөнхийлөгчийн адил 5 жилийн хугацаатай сонгоно. Ерөнхийлөгч нь сөрөг хүчний намаас хоёр дахь Дэд ерөнхийлөгчийг томилох эрхтэй.<br>• **Сайд нарын Танхимын** 46 гишүүдийг Парламентын гишүүдээс Ерөнхийлөгч томилно. Танхим нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 107. | **Мексик** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн сонгуулиар 6 жилийн хугацаатай сонгоно. Дахин сонгогдохгүй. Тэрээр төрийн тэргүүн бөгөөд Засгийн газраа толгойлно, зэвсэгт хүчний ерөнхий командлагч ба Конгресст хууль тогтоомж танилцуулах, хуулийн төсөлд хориг тавих, зарлиг тогтоол гаргах эрхтэй.<br>• **Сайд нарын танхимыг** Ерөнхийлөгч томилж, Сенат батална. Танхим нь засгийн газар, түүний бодлогод хяналт тавина.<br>• **Гүйцэтгэх агентлагийн** Ерөнхий захирагчийг Конгрессын зөвшөөрлөөр Ерөнхийлөгч томилно. |
| 108. | **ОХУ** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн шууд сонгуулиар 6 жилийн хугацаатай сонгогдох ба 1 удаа улируулан сонгоно. Тэрбээр төрийн тэргүүн, Үндэсний аюулгүйн зөвлөлийн дарга, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч бөгөөд улс орны ерөнхий бодлогыг хэрэгжүүлэх, гүйцэтгэх, шүүх засаглалын хооронд эцсийн шийдвэр гаргаж, шүүгчийн үүрэг гүйцэтгэх, элчин сайд нарыг томилох, төрийн аюулгүй байдлыг хангах, сайд нарыг огцруулах, сонгуулийг зарлах, парламентыг тараах эрхтэй.<br>• **Ерөнхийлөгчийн алба** Аюулгүй байдлын зөвлөл, Батлан хамгаалах зөвлөл, Засгийн газрын хэрэг эрхлэх газар зэрэг хамаарах ба тэдгээр нь Ерөнхийлөгчийг Засгийн газрын бодлогын хэрэгжилтийг удирдах, зарлиг, тогтоолыг төсөвлөх зэрэгт туслалцаа үзүүлнэ.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхий сайдыг нэр дэвшүүлж, Төрийн Дум батална. Тэрээр Засгийн газрын тэргүүн ба Ерөнхийлөгчийн захиргаанд ажиллана. Ерөнхий сайд 8 орлогчтой. Сайд нарын танхимыг бүрдүүлж, Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу гүйцэтгэх засаглалын өдөр тумын үйл ажиллагааг хянана.<br>• **Сайд нарын зөвлөл** нь яам, агентлаг, удирдах газрууд, Ерөнхий сайд, түүний орлогчдоос бүрдэнэ. |
| 109. | **Өмнөд Солонгос** | • **Ерөнхийлөгч** нь бүх ард түмний сонгуулиар 5 жилийн хугацаатайгаар нэг удаа сонгогдоно. Тэрбээр төрийн тэргүүн, хууль тогтоох байгууллагын тэргүүлэгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн албыг хашина.<br>• **Ерөнхий сайд** - Ерөнхийлөгч томилох ба Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Төрийн зөвлөл** нь Ерөнхий сайд санал болгосноор Ерөнхийлөгчийн томилсон 20 гишүүдээс бүрдэнэ. Тэд засгийн газрын үйл ажиллагааг хянана. |
| 110. | **Перу** | • **Ерөнхийлөгч** - бүх нийтийн шууд санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр төр, засгийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь зарлиг гаргах, хуульд хориг тавих эрхтэй.<br>• **Дэд Ерөнхийлөгч нарыг** бүх нийтийн шууд санал хураалтаар сонгоно. Хэрвээ Ерөнхийлөгч таалал төгсвөл Нэгдүгээр Дэд ерөнхийлөгч ажлыг хүлээн авна.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилох ба тэрээр Сайд нарын Зөвлөлийг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** гишүүдийг Ерөнхийлөгч томилно. Зөвлөл нь Ерөнхийлөгчийн зарлигийг баталж, хуулийн төсөл боловсруулна. |
| 111. | **Танзани** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн шууд санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр төр, засгийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь хууль батлах, хориг тавих эрхтэй.<br>• **Дэд ерөнхийлөгч нарыг** Ерөнхийлөгч томилно. Нэгдүгээр Дэд ерөнхийлөгч нь Занзибараас, Хоёрдугаар Дэд ерөнхийлөгч нь эх газраас тус тус сонгоно. Хоёрдугаар Дэд ерөнхийлөгч нь Ерөнхий сайдын албыг хашиж, Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын Танхимын** гишүүд нь Парламентын гишүүдээс бүрдэнэ. Тэднийг Ерөнхийлөгч томилох ба тэд Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 112. | **Узбекистан** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн шууд санал хураалтаар 7 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр төр, засгийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь хууль санаачлах, батлах, Засгийн газрын бодлогыг тодорхойлох, үндэсний болон мужийн албан тушаалтнуудыг томилно. |

LIIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | • **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилно. Тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын Зөвлөлийг** Ерөнхийлөгч томилно. Зөвлөлийг Ерөнхий сайд тэргүүлэх бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааг хянана. |
| 113. | **Украйн** | • **Ерөнхийлөгч** - Бүх нийтийн шууд санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төр, засгийн тэргүүн бөгөөд гадаадад үндэстнээ танилцуулах, Сайд нарын танхимын ажиллагааг зогсоох, үндэсний онц байдлыг зарлах, Дээд зөвлөлийг тараах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч нэр дэвшүүлж, Дээд зөвлөл батлана.<br>• **Сайд нарын танхим** нь Ерөнхий сайд, 2 шадар сайд, бусад 15 сайдуудаас бүрдэнэ. Сайд нарын танхимыг Ерөнхийлөгч томилж, Дээд зөвлөл баталнa. Танхим Засгийн газрын үйл ажиллагааг хянана. |
| 114. | **Филиппин** | • **Ерөнхийлөгч** нь бүх нийтийн сонгуулиар 6 жилийн хугацаатайгаар нэг удаа сонгогдоно. Төр, засгийн тэргүүний албыг хашина.<br>• **Дэд Ерөнхийлөгч** нь бүх нийтийн сонгуулиар 6 жилийн хугацаатайгаар нэг удаа сонгогдоно.<br>• **Танхимын** гишүүдийг Парламент зөвшөөрч, Ерөнхийлөгч томилох ба Засгийн газарт хяналт тавина. |
| 115. | **Чили** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн шууд санал хураалтаар 6 жилийн хугацаатай нэг удаа сонгоно. Тэрээр төр, засгийн тэргүүний хувьд парламентыг зарлан хуралдуулах, хуулийн төсөлд хориг тавих, хууль санаачлах, тогтол гаргах, бүх ард түмний санал хураалтыг зарлах эрхтэй.<br>• **Сайд нарын танхимын** 21 гишүүнийг Ерөнхийлөгч томилно. Танхим нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 116. | **Шри Ланк** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн шууд санал хураалтаар 6 жилийн хугацаатайгаар сонгоно. Тэрээр төр, засгийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч бөгөөд Парламентыг зарлан хуралдуулах, тараах, бүх ард түмний санал хураалтыг зарлах, өршөөл үзүүлэх, үндэсний онц байдал зарлах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдаар** Парламентад олонх болсон нам эвслийн тэргүүнийг Ерөнхийлөгч томилно.<br>• **Сайд нарын танхимын** гишүүд нь Чуулганы гишүүдээс бүрдэх ба Ерөнхийлөгч томилж, Чуулганаар батлуулна. Танхим нь Засгийн газрын үйл ажиллагааг хянана. |
| 117. | **Эквадор** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн шууд санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгох ба улиран сонгохгүй. Тэрээр төр, засгийн тэргүүн байна.<br>• **Дэд ерөнхийлөгчийг** Ерөнхийлөгчийн адил бүх нийтийн шууд санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгох ба улиран сонгохгүй.<br>• **Сайд нарын танхимын** гишүүдийг Ерөнхийлөгч томилно. Танхим нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| | | **ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАСАГЛАЛ** |
| 118. | **Ангол** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийт шууд санал хураалтаар 6 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр төр, засгийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байх ба Парламентын зөвшөөрөлтэйгээр дайн зарлах, төрийн дээд одон медаль гардуулах, парламентын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулах, бүх нийтийн сонгууль зарлах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилно.<br>• **Сайд нарын Зөвлөл** нь Ерөнхийлөгчийн томилсон 29 гишүүдээс бүрдэнэ. Зөвлөл нь Засгийн газрын үйл ажиллагааг хянах бөгөөд Зөвлөлийг Ерөнхийлөгч тэргүүлнэ. |
| 119. | **Беларус** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн шууд санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгоно. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Үндэсний Аюулгүйн Зөвлөлийн дарга байх бөгөөд хууль санаачлах, батлах, хуулийн төсөлт хориг тавих, Парламентыг тараах бүрэн эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилно. Тэрээр засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын Зөвлөлийн** 26 гишүүнийг Ерөнхийлөгч томилно. Зөвлөл нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 120. | **Жибути** | • **Ерөнхийлөгч** нь бүх нийтийн шууд санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгогдано.Тэрээр төрийн тэргүүн, зэвсгэт хүчний ерөнхий командлагч байна.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилох бөгөөд тэрээр Засгийн газрыг тэргүүлж, Депутатуудын зөвлөлийг удирдана.<br>• **Депутатуудын зөвлөл** нь 15 гишүүнтэй бөгөөд тэднийг Ерөнхийлөгч томилно. Зөвлөл Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, Ерөнхийлөгчид тайлагнах үүрэгтэй. |
| 121. | **Зимбабве** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн шууд санал хураалтаар 6 жилийн хугацаатай |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | сонгоно. Тэрээр төр, засгийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь олон улсын гэрээ хэлэлцээр батлах, элчин сайдуудыг томилох, дайн зарлах, хуулийн төсөл зөвшөөрөх, Парламентыг тараах эрхтэй.<br>• **Дэд ерөнхийлөгч нарыг** Ерөнхийлөгч томилно. Тэд Ерөнхийлөгчийн гүйцэтгэх засаглалыг удирдах үүрэгт тусална.<br>• **Сайд нарын танхимын** гишүүдийг Ерөнхийлөгч томилно. Танхим нь Засгийн газрын үйл ажиллагааг хянах бөгөөд Парламентад тайлагнана. |
| 122. | **Коморын Ардууд** | • **Ерөнхийлөгч** нь бүх нийтийн шууд санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгогдоно. Ерөнхийлөгч нь төр, засгийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.<br>• **Ерөнхий сайдаар** Парламентад олонх болсон нам эвсэлийн гишүүнээс Ерөнхийлөгч томилно.<br>• **Засгийн газрын Зөвлөл** - арлуудын захирагчид болон гишүүдээс бүрдэх бөгөөд тэднийг Ерөнхийлөгч томилно. Зөвлөл Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй. |
| 123. | **Тажикистан** | • **Ерөнхийлөгч** - Бүх нийтийн шууд санал хураалтаар үнэмлэхүй олонхын саналаар 7 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр төрийн тэргүүн бөгөөд Парламентын спикерийн хувьд Парламентын тогтоолыг хүчингүй болгох, үндэсний онц байдлыг зарлах эрхэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилж, Парламент батална. Тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын Зөвлөл** нь 14 тэргүүн сайд, 19 зөвлөхүүдээс бүрдэх бөгөөд тэднийг Ерөнхийлөгч томилно. Сайд нарын Зөвлөл Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих ба Ерөнхий сайд Зөвлөлийг тэргүүлнэ. |
| 124. | **Того** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн шууд санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр төр, засгийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Ерөнхийлөгч нь хуулийн төсөл санаачлах, Парламентыг тараах, Засгийн газрын албан тушаалтнуудыг томилох, улсын болон орон нутгийн төсвийг хянах эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** нь Пардаментад олонх болсон нам, эвслийн гишүүн байх ба түүнийг Ерөнхийлөгч томилно. Тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын зөвлөлийг** Ерөнхий сайдын зөвлөснөөр Ерөнхийлөгч томилно. Зөвлөл нь Засгийн газрын үйл ажиллагааг хянана. |
| 125. | **Туркменистан** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн шууд санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгодог байсан. 1999 оноос Ерөнхийлөгчийг Бүх ард түмний Зөвлөлөөс бүх насаар нь сонгохоор болж бүрэн эрхийх нь хугацааг сунгасан байна. Ерөнхийлөгч нь төр, засгийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Тэрээр хууль гаргах, улсын ерөнхий шүүгч, прокуроруудыг томилох, огцруулах, 18 сарын дотор итгэл хүлээлгэх эсэх талаар санал хураалт хоёр удаа явуулах, Парламентыг тараах эрхтэй.<br>• **Сайд нарын танхимыг** Ерөнхийлөгч томилж, Парламент батална. Танхим нь Засгийн газрын үйл ажиллагааг хянах бөгөөд Ерөнхийлөгч тэргүүлнэ. |
| 126. | **Экваторын Гвиней** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн шууд санал хураалтаар 7 жилийн хугацаатай сонгоно. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байх бөгөөд хууль санаачлах, Парламентыг тараах, олон улсын гэрээ хэлэлцээр батлах, гарын үсэг зурах, Парламентын сонгуулийн товыг зарлах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилно. Тэрээр Засгийн газрыг тэргүүлж, дотоодын хэргийг шийдвэрлэж зохицуулах үүрэгтэй.<br>• **Сайд нарын танхимын** гишүүдийг Ерөнхийлөгч томилно. Танхим нь Засгийн газрын үйл ажиллагааг хянана. |
| | | ❖ **НАМГҮЙ АРДЧИЛАЛ** |
| 127. | **Кирибати** | • **Ерөнхийлөгчийг** Парламент нь өөрсдийн гишүүдээс нэр дэвшүүлж, бүх нийтийн шууд санал хураалтаар 4 жилийн хугацаатайгаар сонгоно. Тэрээр дахин 2 удаа улиран сонгогдож болно. Ерөнхийлөгч нь төр, засгийн тэргүүн бөгөөд Ерөнхий шүүгчийг томилно.<br>• **Дэд ерөнхийлөгчийг** Ерөнхийлөгч томилно.<br>• **Сайд нарын Танхимд** Дэд ерөнхийлөгч, Ерөнхий шүүгч, Парламентын 10 гишүүн багтана. Сайд нарын Танхим Засгийн газрын үйл ажиллагааг хянана. |
| 128. | **Микронез** | • **Ерөнхийлөгчийг** 4 мус улсын парламентаас 4 жилийн хугацаатай сонгоно. Парламентын гишүүн нь Ерөнхийлөгчөөр сонгогдвол тэрээр гишүүний үүрэгт ажлаас татгалзах ёстой. Тэрээр төр, засгийн тэргүүн байна.<br>• **Дэд ерөнхийлөгчийг** Ерөнхийлөгчийн адил 4 муж улсын парламентаас 4 жилийн хугацаатай сонгогдоно. Хэрэв Парламентын гишүүн нь Дэд ерөнхийлөгчөөр сонгогдвол тэрээр мөн гишүүний үүрэгт ажлаасаа татгалзана. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | Түүнчлэн Ерөнхийлөгч нэр дэвшиж гарсан муж улсаас бусад 3 муж улсаас Дэд ерөнхийлөгчид нэр дэвшшшлнэ.<br>• **Сайд нарын танхимын** гишүүдийг Ерөнхийлөгч томилно. |
| 129. | **Наури** | • **Ерөнхийлөгч** нь төр, засгийн тэргүүн байх бөгөөд Парламент нь өөрийн гишүүдээс сонгож томилно.<br>• **Сайд нарын танхим** нь 4-5 сайдтай бөгөөд тэднийг Ерөнхийлөгч томилж, Парламент шийдвэрлэнэ. |
| 130. | **Палау** | • **Ерөнхийлөгч** - бүх нийтийн шууд санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр төр, засгийн тэргүүн байна.<br>• **Дэд ерөнхийлөгч** - бүх нийтийн шууд санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгоно. Сонгуулийг Ерөнхийлөгчийн сонгуулиас тусад нь явуулна.<br>• **Сайд нарын танхим** нь 8 гишүүнтэй.<br>• **Тэргүүлэгчдийн зөвлөлийн** гишүүд нь 16 муж улсаас сонгогдох ба Ерөнхийлөгчид хууль эрх зүй, уламжлалт ёс заншилтай холбоотой асуудлаар зөвлөх үүрэгтэй. |
| 131. | **Тувалу** | • **Амбан захирагч** - Ерөнхий сайд, Парламентын зөвлөснөөр Их Британий Эзэн хаан томилно. Тэрээр төрийн тэргүүн байх бөгөөд Парламентыг тараах эрхтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Парламент нь гишүүдийнхээ дундаас сонгоно. Тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Шадар сайдыг** мөн Парламент нь гишүүдийнхээ дундаас сонгоно.<br>• **Сайд нарын Танхимд** Ерөнхий сайд, 4 яамдын сайд багтах бөгөөд тэднийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Амбан захирагч томилно. Танхим нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 132. | **Уганда** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн шууд санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгоно. Ерөнхийлөгч нь төр, засгийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Тэрээр хууль санаачлах, Элчин төлөөлөгчдийг томилох, олон улсын гэрээ хэлэлцээр батлах, үндэсний онц байдал болон дайн зарлах бүрэн эрхтэй.<br>• **Дэд ерөнхийлөгчийг** Ерөнхийлөгч томилж, Парламент батламжилна. Тэрээр Танхимын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилно.<br>• **Сайд нарын Танхимын** гишүүд нь парламентын гишүүд байх ба Парламент батламжилж, Ерөнхийлөгч томилно. Танхим нь үндэсний бодлогыг хэрэгжүүлэх, Засгийн газрын үйл ажиллагааг хянах үүрэгтэй бөгөөд Ерөнхийлөгч тэргүүлнэ. |
| | | **НАМ ТӨВТЭЙ ЗАСАГЛАЛ** |
| 133. | **БНХАУ** | • **БНХАУ-ын дарга** буюу төрийн тэргүүнийг ХКН-аас нэр дэвшүүлж, БХАТИХ-аар батлан 5 жилийн хугацаатай томилдог бөгөөд нэг л удаа улируулан сонгодог. Тэрээр ХКН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, ХКН-ын Цэргийн зөвлөлийн даргын үүргийг гүйцэтгэх ба өршөөлийн зарлиг гаргах, дайн зарлах болон Ерөнхий сайдыг томилох эрхтэй.<br>• **Орлогч дарга**<br>• **Ерөнхий сайд** нь Төрийн зөвлөл буюу Засгийн газрын тэргүүн бөгөөд БХАТИХ-аас томилогдоно.<br>• **Төрийн зөвлөл** нь БХАТИХ-аас сонгон томилсон Ерөнхий сайд, Орлогч дарга, Төрийн зөвлөхүүд, яамдын сайд нар, зөвлөлийн тэргүүн нар, Ерөнхий аудитор, Ерөнхий нарийн бичгийн дарга зэрэг хариуцлагатай албан тушаалтнуудаас бүрдэнэ. |
| 134. | **Вьетнам** | • **Ерөнхийлөгчийг** Үндэсний Ассамблей нь өөрсдийн гишүүдийн дундаас 5 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр төрийн тэргүүн ба зэвсэгт хүчний ерөнхий командлагч.<br>• **Ерөнхий сайдыг** Үндэсний Ассамблейнн гишүүдээс Ерөнхийлөгч томилох ба тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Улс төрийн товчоо (УТТ)** - Коммунист намаас сонгогдсон 15 гишүүдээс бүрдэнэ. УТТ нь Засгийн газрын бодлогыг чиглүүлэх, түүний хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй.<br>• **Сайд нарын танхим** - 36 гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Ерөнхийлөгч томилж, Үндэсний Ассамблей батлана. Танхим нь Засгийн газрын үйл ажиллагааг хянана. |
| 135. | **Куба** | • **Ерөнхийлөгчийг** Парламентаас сонгох ба тэрээр төр, засгийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Коммунист намын Нарийн бичгийн дарга байна.<br>• **Дэд ерөнхийлөгчийг** Парламентаас сонгох ба тэрээр Батлан хамгаалахын |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | сайд, Сайд нарын зөвлөлийн дэд даргын албыг давхар хашина.<br>• **Сайд нарын Зөвлөл** - Гишүүдийг нь Төрийн зөвлөлөөс нэр дэвшүүлж, Парламент батална. Сайд нарын Зөвлөлийг Ерөнхийлөгч тэргүүлж, Засгийн газрын үйл ажиллагааг хянах, улсын төсөвт хяналт тавих, гадаад харилцаа, худалдааг удирдан зохион байгуулах, хууль батлах, дотоодын аюулгүй байдлыг сахин хамгаална. |
| 136. | **Лаос** | • **Улс төрийн товчоо (УТТ)** - Төв Хорооноос сонгогдсон 9 гишүүнээс бүрдэнэ. УТТ Засгийн газрын болон намын бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг хянах үүрэгтэй.<br>• **Ерөнхийлөгч** - Парламентын 3/2 хувийн саналаар сонгоно. Тэрээр төрийн тэргүүн, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байх ба шүүх, цэргийн албан тушаалтнуудыг томилно.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч 5 жилийн хугацаатай томилж, Парламентаар батлах ба тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын Зөвлөл** - Гишүүдийг Ерөнхийлөгч томилж, Үндэсний Ассамблей батлана. Засгийн газрын үйл ажиллагааг хянах, хууль санаачлах, улсын төсөв гаргана. |
| 137. | **Ливи** | • **Ерөнхийлөгч** нь Парламентаас шууд сонгогдох ба тэрээр төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Тэрээр зарлиг, уриалга, тунхаг гаргана.<br>• **Ерөнхий нарийн бичгийн даргыг** Парламентаас сонгох ба Засгийн газрын тэргүүний албыг хашина.<br>• **Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газарт** Ерөнхий нарийн бичгийн дарга, түүний албан хаагчид, зөвлөхүүд багтах баПарламентын үйл ажиллагаа, Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина.<br>• **Ардын Ерөнхий Хороо** - 3 жилийн хугацаатай Ерөнхий нарийн бчигийн дарга нарын газраас сонгогдсон 20 нарийн бичгийн дарга нараас бүрдэнэ. |
| 138. | **Сири** | • **Ерөнхийлөгч** - бүх нийтийн шууд санал хураалтаар 7 жилийн хугацаатай сонгоно. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч ба Ислам шашнитан, Үндэсний Батхи Намын Ерөнхий нарийн бичгийн дарга байна. Тэрээр Ардын Зөвлөлийн зөвшөөрөлтэйгээр хууль батлах, иргэний болон цэргийн дээд албан тушаалтнуудыг томилох, дайн зарлах, Ардын Зөвлөлийг тараах эрхтэй.<br>• **3 Дэд Ерөнхийлөгчийг** Ерөнхийлөгч томилно.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилох ба тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын зөвлөлийн** гишүүдийг Ерөнхийлөгч томилох ба Зөвлөл нь Засгийн газрын үйл ажиллагааг хянах үүрэгтэй. |
| 139. | **Хойд Солонгос** | • **Ерөнхий нарийн бичгийн дарга** нь төрийн тэргүүн, зэвсэгт хүчний өрөнхий командлагч, Батлан хамгаалах хорооны дарга, Солонгосын Ажилчдын намын Ерөнхий нарийн бичгийн дарга байна. Тэрээр гүйцэтгэх засаглалыг тэргүүлнэ.<br>• **Ардын Их Хурлын Тэргүүлэгчид (АИХТ)-ийн дарга буюу Ерөнхийлөгч** нь Төрийн захиргааны зөвлөл, Дээд танхимын болон АИХТ-ын даргын хувьд АИХТ-ын хуралдаангүй үед Бүх ардын чуулганыг тэргүүлэх, үйл ажиллагааг чиглүүлэх үүрэгтэй ба 2 дэд ерөнхийлөгч, 2 өргөмжит дэд ерөнхийлөгчтэй.<br>• **Ерөнхий сайд** нь Засгийн газрын тэргүүн ба Ардын Их Хурлаас сонгогдоно. Тэрээр Төрийн захиргааны зөвлөл, Танхимын болон Ардын Төв хорооны дарга байх ба 3 шадар сайдтай. |
| | | **ХААНТ ЗАСАГ** |
| 140. | **Арабын НЭУ** | • **Холбооны дээд зөвлөл** нь Төрийн эрх барих дээд байгууллага бөгөөд 7 Эмирээс бүрдэнэ. Хууль батлах, өөрсдийн гишүүдээс Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг сонгодог. Жилд 4 удаа хуралддаг.<br>• **Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг** Холбооны дээд зөвлөлөөс 5 жилийн хугацаатай сонгоно. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, Холбооны дээд зөвлөлийг даргалах ба зэвсэгт хүчнийг удирдана.<br>• **Ерөнхий сайд нь** Засгийн газрын тэргүүнийг Ерөнхийлөгч томилно.<br>• **Сайд нарын танхимын** гишүүдийг Ерөнхий сайд томилно. |
| 141. | **Бруней** | • **Султан** нь угсаа залгамжлан төрийн эрх барих эрхтэй ба төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч, шашны удирдагч, Ерөнхий сайд байна. Хуультай адил үйлчлэх зарлиг гаргах эрхтэй.<br>• **Нууцын Зөвлөлийн** гишүүдийг Султан томилно. Үндсэн хууль болон төрийн цол, хэргэмийн талаарх асуудал, маргааныг шийдвэрлэхэд зөвлөгөө өгөх үүрэгтэй.<br>• **Эрх шилжүүлэх зөвлөлийн** гишүүдийг Султан томилно. Хаан ширээнд суух дараагийн хүнийг тодорхойлох үүрэгтэй. |

UIL.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | • **Шашны зөвлөлийн** гишүүдийг Султан томилох ба Исламын эрх зүй, шариатын эрх зүйн асуудлаар Султанд зөвлөгөө өгөх эрхтэй. |
| 142. | **Бутан** | • **Эзэн хаан** - Угсаа залгамжлагч, төр, засгийн тэргүүн ба хуулийн төслийг дахин хэлэлцүүлэхээр Парламентад буцаах эрхтэй. Харин хориг тавих эрхгүй. • **Эзэн хааны Зөвлөхүүдийн зөвлөл** нь Үндэсний Ассамблейн гишүүдээс бүрдэнэ. Хаант засаг ба парламент хоорондын харилцааг хослуулан ажиллана. • **Сайд нарын Зөвлөл** - Эзэн хааны санал болгож, Парламентын зөвшөөрсөн 15 гишүүдийг 5 жилийн хугацаатай томилно. Эзэн хааны удирдсан Засгийн газрын хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 143. | **Йордан** | • **Ерөнхий сайдыг** Эзэн хаан томилох ба Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. • **Танхимыг** Ерөнхий сайд томилж, Эзэн хаан батална. Улс орны ерөнхий бодлогын асуудлаар Төлөөлөгчдийн танхимд хариуцлага хүлээлгэх, Парламентыг огцруулах эрхтэй. |
| 144. | **Камбож** | • **Эзэн хааныг** Хаан ширээ залгамжлуулах Зөвлөл сонгоно. Эзэн хаан бол төрийн тэргүүн, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч. Эзэн хаан элчин сайдууд, Засгийн газрын албан тушаалтнуудыг томилох, үндэсний онц байдал зарлах, өршөөл үзүүлэх эрхтэй. • **Ерөнхий сайд** - Олонхын бүлгийн дарга байх бөгөөд Үндэсний Ассамблейн дарга нэрийг нь дэвшүүлж Эзэн хааны томилно. Тэрээр Засгийн газрын тэргүүн, Сайд нарын Зөвлөлийг тэргүүлэгч байна. • **Сайд нарын Зөвлөл** - Эзэн хааны томилсон 24 гишүүн нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 145. | **Катар** | • **Эмир** нь угсаа залгамжилан төрийн эрхийг барина. Гүйцэтгэх эрх мэдлийг дангаар хэрэгжүүлэгч, зэвсэгт хүчний ерөнхий командлагч, зарлиг гаргах, төрийн албан хаагчид болон цэргийн тушаалтнуудыг томилох, огцруулах эрхтэй. Эмир нь хууль тогтоох байгууллагаа тараах бүрэн эрхтэй. • **Ерөнхий сайдыг** Эмир томилох бөгөөд ихэвчлэн Эзэн хааны гэр бүлийн аль нэг гишүүнийг томилно. Засгийн газрын тэргүүн тэрбээр засгийн газрын хэрэгжүүлж буй хөтөлбөр, түүний санхүүжилтийн асуудлыг хянаж ажилладаг. • **Сайд нарын зөвлөлийн** гишүүдийг Эмир томилно. Хуулийн төсөл боловсруулах, засгийн газрын үйл ажиллагааг хянах үүрэгтэй. |
| 146. | **Кувейт** | • **Эмир** – Угсаа залгамжлан хаан ширээнд суудаг. Төрийн тэргүүн, зэвсэгт хүчний командлагч тэрээр хууль санаачлах, тогтоол гаргах, иргэний, цэргийн болон дипломат алба тушаалтнуудыг томилох, огцруулах ба ял хөнгөлөх, уучлал үзүүлэх эрхтэй. • **Ерөнхий сайд** – Уламжлалын дагуу хунтайж Ерөнхий сайд болдог. Ерөнхий сайдыг Эмир томилно. Тэрбээр Засгийн газрыг тэргүүлнэ. • **Сайд нарын зөвлөл** нь 16 гишүүнтэй. Эмир баталж, Ерөнхий сайд томилно. |
| 147. | **Лесото** | • **Эзэн хаан** нь угсаа залгамжилсан бөгөөд өөрийн угсаа залгамжлагчаа нэр заан томилох эрхтэй. Эзэн хаан бол төрийн тэргүүн, хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын эрх мэдлийг билэглийн чанартай удирдана. • **Ерөнхий сайд** нь Үндэсний Ассамблейн дарга, олонхын бүлгийн тэргүүн тул шууд томилогдох ба Засгийн газрыг тэргүүлж, Танхимыг удирдана. • **Сайд нарын Танхим** - Ерөнхий сайд, шадар сайдуудыг оролцуулаад нийт 17 гишүүнээс бүрдэнэ. |
| 148. | **Монако** | • **Эзэн хаан** нь угсаа залгамжилсан бөгөөд төрийн тэргүүн, хуулийн төсөл төлөвлөх, хориг тавих, олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд гарын үсэг зурах бүрэн эрхтэй. • **Төрийн сайд** - Францын Засгийн газраас нэр дэвшүүлж, Эзэн хаан томилно. Тэрээр Засгийн газрын тэргүүн, танхимыг удирдах, гадаад хэрэг, цагдаагийн байгууллагыг удирдах, Эзэн хаанд тайлагнах үүрэгтэй. • **Засгийн газрын Зөвлөл** - Төрийн сайд, Санхүү, эдийн засаг, дотоод хэрэг, олон нийтийн ажил эрхлэлт болон нийгмийн хэргийг хариуцсан 3 гишүүнээс бүрдэнэ. Гишүүдийг Эзэн хаан томилно. • **Хаан ширээ залгамжлуулах Зөвлөл** - Парламентын зөвшөөрснөөр Эзэн хаан томилох 7 гишүүнийг 3 жилийн хугацаатай томилно. Үндсэн хуультай холбогдох асуудлаар Эзэн хаантай зөвлөлдөнө. |
| 149. | **Марокко** | • **Эзэн хаан** - угсаа залгамжилсан бөгөөд тэрээр төр, шашны тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Парламентыг хуралдуулах, тараах эрхтэй. • **Ерөнхий сайдыг** сонгуулийн дараа эзэн хаан томилно. Засгийн газрын тэргүүн бөгөөд Засгийн газрын захиргааны хөтөлбөрийг танилцуулна. • **Сайд нарын танхимын** гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Эзэн хаан |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | томилно. Хуралдааныг Эзэн хаан даргална. |
| 150. | **Непал** | • **Эзэн хаан** - Угсаа залгамжлагч, төрийн тэргүүн бөгөөд Парламентыг зарлан хуралдуулах, тараах, сонгуулийн тавыг зарлах, өршөөл үзүүлэх эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** - Парламентад олонхыг бүрдүүлсэн нам эвслийн удирдагч нэр дэвшиж, Эзэн хаан томилно. Засгийн газрын тэргүүн, Сайд нарын зөвлөлийн тэргүүлнэ.<br>• **Сайд нарын Зөвлөлийг** Ерөнхий сайдын зөвлөсний дагуу Эзэн хаан томилно. Зөвлөл нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 151. | **Оман** | • **Султан** нь угсаа залгамжилсан бөгөөд тэрээр төр, засгийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Ерөнхий сайд, Гадаад хэргийн болон Сангийн сайдын албыг давхар хашина.<br>• **Сайд нарын Зөвлөл** - Султаны томилсон 26 гишүүдээс бүрдэх бөгөөд Зөвлөлийг Султан удирдаж, Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавина. |
| 152. | **Саудын Араб** | • **Эзэн хаан** - Угсаа залгамжилсан Эзэн хаан нь төрийн тэргүүн, шашны тэргүүн, Шариатын эрх зүй, Саудын уламжлалыг хадгалах үүрэгтэй. Шүүхийн өршөөл үзүүлэх эрхийг Эзэн хаан хэрэгжүүлдэг.<br>• **Сайд нарын зөвлөл** нь Дээд угсааны гэр бүлийн гишүүдээс бүрдэх 29 гишүүнтэй, 4 жилийн хугацаатайгаар Эзэн хаан томилно. Тэд Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, бодлого боловсруулах үүрэгтэй.<br>• **Дээд зөвлөл** - Удирдагч хун тайж нараас бүрдэх энэхүү зөвлөл нь төрийн хэргийг залгамжлах, тэтгэмж олгох зэрэг асуудлыг нууцаар хэлэлцдэг. |
| 153. | **Свазиланд** | • **Эзэн хаан** - Угсаа залгамжилсан, төр, засгийн тэргүүн бөгөөд Парламентаас баталсан хуулийг хуульчлан батлахаас өмнө хууль тогтоох засаглалын тэргүүний хувьд батлаж зөвшөөрөх, өндөр албан тугаалтнуудыг томилох эрхтэй.<br>• **Ерөнхий сайд** - Эзэн хаан томилох ба тэрээр Засгийн газрын тэргүүлж, Танхимыг удирдан ажиллана.<br>• **Сайд нарын Зөвлөлийн танхим** - Ерөнхий сайд, шадар сайд зэрэг 16 гишүүнээс бүрдэнэ. Танхимын гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Эзэн хаан томилно. |
| 154. | **Тонга** | • **Эзэн хаан** - Угсаа залгамжилсан бөгөөд төрийн тэргүүн байна.<br>• **Ерөнхий сайдыг** Эзэн хаан бүх насаар нь томилдог.<br>• **Танхим** - Эзэн хааны томилсон 12 сайдуудаас бүрдэнэ.<br>• **Хувийн зөвлөл** нь Эзэн хаан, Сайд нарын танхимын гишүүд, Вава-у, Ха-апайн захирагчид нараас бүрдэнэ. Ассамблейгаар батлагдсан хууль тогтомж, зарлиг, захирамжийг хянан шалгаж, эцсийн шийдвэрийг гаргана. Гэмт хэргийн шүүхийн эцсийн тогтоолыг гаргана. |
| | | **ШАШИН, ТӨР ХОСОЛОН ЗАХИРАХ ЗАСАГЛАЛ** |
| 155. | **Ватикан** | • **Ромын Пап** - Гүйцэтгэн захирах эрхийг бүх насаараа Ромын католик сүмийн Гэгээн Католик шашны их ламын Коллежоос сонгогдсон тэргүүн хамба лам буюу Пап эдэлнэ.<br>• **Төрийн нарийн бичгийн дарга** - Католик шашны их ламтаныг Пап томилдог. Төрийн нарийн бичгийн дарга нарын газрыг тэргүүлж Папт үргэлж танилцуулах үүрэгтэй.<br>• **Төрийн нарийн бичгийн дарга нарын газар** нь Ромын Төрийн ордны хамгийн чухал алба ба Ерөнхий болон Гадаад улсуудтай харилцах харилцааны гэсэн хэлтэсээс бүрдэнэ.<br>• **Папын зөвлөл:** Тус зөвлөл нь маш өргөн хүрээтэй арга хэмжээг авч явуулдаг бөгөөд тэдгээр нь залуучуудын хөдөлгөөн, гэр бүлийн асуудал, буяны үйл ажиллагаа, шашны номлол сургаалийг сурталчлах, олон нийтэд түгээх үйл ажиллагааг эрхэлдэг.<br>• **Цугларалт** Шашны номлол, сүсэг бишрэлийн үзэл баримтлал, хамба ламын уулзалт зэргийг багтаадаг.<br>• **Папын эрх мэдэл:** Католик шажны их ламтаны эрх мэдэл Ватиканы эдийн засгийн менежментийн талаар Папт зөвлөгөө туслалж үзүүлдэг. |
| 156. | **Иран** | • **Ерөнхийлөгч** - Мажорити системээр 4 жилийн хугацаатай сонгогдоно. Хоёр дахь өндөр албан тушаалтан бөгөөд гүйцэтгэх засаглалыг тэргүүлэн сайд нарыг томилох, огцруулахаас гадна Кабинетыг удирдаж, хууль тогтоох байгууллагаас өмнөх бодлогыг явуулдаг. Зөвлөлийн тэргүүн бөгөөд Дээд удирдагчийн үүрэг хариуцлагыг эдэлнэ.<br>• **Дэд Ерөнхийлөгчид** - Гүйцэтгэх засаглал нь нийт 8 дэд Ерөнхийлөгчтэй.<br>• **Танхим** нь 22 сайдаас бүрдэнэ.<br>• **Сонгуулийн системийг** Үндэсний Гвардийн Зөвлөл хариуцах тул тэдний зөвшөөрлөөр нэр дэвшигчдийг зарлах, тэдний сонгуулийн хэмжүүрийг |

| | | |
|---|---|---|
| | | тогтоох, зөвшөөрүүлэх, өрсөлдөх стандартыг батладаг. Үндсэн хуулинд олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрдөг боловч одоо хүртэл албан ёсоор байгуулагдсан нам байхгүй бөгөөд шинээр 2 нам бүртгүүлээд байгаа аж. |
| | | **ЦЭРГИЙН ДЭГЛЭМТЭЙ ЗАСАГЛАЛ** |
| 157. | **Бирм** | • **Ерөнхий сайд** бол Төрийн Хөгжил, Энх тайвны Зөвлөлийг хянадаг цэргийн удирдагч байна. Тэрээр төр, засгийн тэргүүн бөгөөд Зэвсэгт хүчний ерөнхий командлагч юм. Хуулийн зарлиг, тогтоол гаргах эрхтэй.<br>• **Танхимыг** энгийн 8 иргэн, цэргийн 27 албан хаагч нийт 35 гишүүндээс бүрдэнэ. Гишүүдийг Төрийн Хөгжил, Энх тайвны Зөвлөл томилно. |
| 158. | **Конго** | • **Ерөнхийлөгч** - Бүх нийтийн шууд санал хураалтаар 7 жилийн хугацаатай сонгогдоно. Төр засгийн тэргүүн бөгөөд Зэвсэгт хүчний ерөнхий командлагч өөрийн эрх мэдлийн хүрээнд зарлиг тогтоол гаргана.<br>• **Үндэсний Гүйцэтгэх Зөвлөл** нь Ерөнхийлөгчийн томилсон 25 гишүүдээс бүрдэж Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, Ерөнхийлөгч даргалах үүрэгтэй. |
| 159. | **Пакистан** | • **Ерөнхийлөгч** - Бол төрийн тэргүүн бөгөөд Үндэсний Ассамблей, Сенатын танхим, мужийн ассамблейгаас бүрдсэн сонгуулийн коллегиас шууд бус санал хураалтаар сонгодог. 2001 онд одоогийн Ерөнхийлөгч өөрийгөө тус улсын тэргүүнээр зарласан. Тус улсын тэргүүн нь дахин сонгогдох эрхтэйгээр 5 жилийн хугацаатай томилогддог.<br>• **Ерөнхий сайд** нь Засгийн газрын тэргүүн бөгөөд өөрийн томилсон Сайд нарын танхимыг даргална. Танхимын гишүүдийг Үндэсний Ассамблейгээс 4 жилийн хугацаатай томилно. Ихэвчлэн томоохон намын тэргүүн нар байдаг. Тэрээр Ерөнхийлөгч, Шүүх засаглалын эрх мэдэлтэний хяналтанд байна.<br>• **Сонгуулийн систем** - Сонгуулийн ерөнхий комисс нь биеэ даасан, бүрэн эрх бүхийүндсэн хуулийн өмнө хариуцлаг хүлээсэн байгууллага бөгөөд Үндэсний болон Мужийн Ассамблейдад хэсэгчилсэн ба чөлөөт сонгуулийг явуулах үүрэгтэй. Сонгуулийн Ерөнхий комиссын ажилтан нь сонгуулийн талаарх мэдээлэл ба орон нутгийн засаг захиргааны сонгуулийн талаар зөвхөн Сенатын танхим, Ерөнхийлөгчид танилцуулах эрхтэй |
| 160. | **Судан** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгоно. Төр засгийн тэргүүн бөгөөд Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч парламентыг тараах, зарлан хуралдуулах, Үндсэн хуулинд хориг тавих, зарлиг тогтоол гаргах эрхтэй.<br>• **2 Дэд Ерөнхийлөгчийг** Ерөнхийлөгч томилно.<br>• **Сайд нарын Зөвлөлийг** Ерөнхийлөгч томилно. |
| | | **ШИЛЖИЛТИЙН ЗАСАГЛАЛ** |
| 161. | **Афганистан** | • **Шилжилтийн үеийн Эрх барих байгууллага** нь томилогдсон 30 гишүүдтэй. 2001 оны 12-р сард НҮБ-ын ивээл дор Афганчууд Талибаны дэглэмийг нуран унгаасны дараа шинэ Засгийн газрыг байгуулсан.<br>• **Ерөнхийлөгч** нь төр засгийн тэргүүн бөгөөд шилжилтийн үеийн эрх барих байгууллагаас томилсон.<br>• **Дөрвөн Дэд ерөнхийлөгчийг** Шилжилтийн үеийн эрх барих байгууллагаас томилно.<br>• Сайд нарын танхим нь Шилжилтийн үеийн эрх барих байгууллагын 30 гишүүдээс бүрдэх ба Засгийн газрын үйл ажиллагааг хянах, Ерөнхийлөгчид зөвлөнө. |
| 162. | **Бахрейн** | • **Амир** бол Хэмжээлшгүй эрхт, угсаа залгамжилсан төрийн тэргүүн бөгөөд Зэвсэгт хүчний ерөнхий командлагч.<br>• **Ерөнхий сайдыг** Амир томилсноор Засгийн газрыг тэргүүлнэ.<br>• **Сайд нарын танхимыг** Амир томилно. |
| 163. | **Бурунди** | • **Шилжилтийн үеийн Ерөнхийлөгч** нь 18 сарын хугацаатай алба хашина.<br>• **Дэд Ерөнхийлөгч** - Ерөнхийлөгчийн нэгэн адил 18 сарын хугацаатай ажиллана.<br>• **Сайд нарын зөвлөлийн** 26 гишүүдийг үндэсний угсаатны бүлэглэлүүдээс ижил хэмжээний төлөөллөөр Ерөнхийлөгч томилно |
| 164. | **Ирак** | • АНУ Түр засгийн газар буюу Мужийн Эрх барих дэдэ байгууллага Эвсэлийг тус оны 5 дугаар сард байгуулсан. Иракийн Засгийн Зөвлөл нь 25 гишүүдийг томилж 7 дугаар сард Иракийн үндсэн хуулийн төслийг бүтээх хороог байгуулж, сайд нарын нэрийг дэвшүүлсэн банйа. Тус зөвлөл нь улс орныхоо өнөөгийн нийгмийн байдлын талаар өөрсдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, удаан ч гэсэн өргөн хүрээтэй үйл явцыг бий болгох талаар танилцуулсан. Түүнчлэн АНУ-ын үзэж байгаагаар тэдний өөр хоорондоо сөргөлдөх нь гол бус харин улсаа шинээр эмхлэн байгуулах, өөрсдийн дуу |

UIH MN
СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | хоолой, зөн билэгээ тунхаглан зарлах нь юу юунаас илүү зүйл юм гэжээ. |
| 165. | **Либери** | • **Ерөнхийлөгчийг** - 6 жилийн хугацаатай бүх нийтийн шууд санал хураалтаар сонгоно. Ерөнхийлөгч нь төр, засгийн тэргүүн бөгөөд Зэвсэгт хүчний ерөнхий командлагчын хувьд хуулийн төсөлд хориг тавих, батлах бүрэн эрхтэй.<br>• **Сайд нарын Танхимын** 16 гишүүдийг Ерөнхийлөгч томилж Сенатын танхимаар батлуулна. Сайд нарын танхим засгийн газрын үйл ажиллагааг хянана. |
| 166. | **Мальдив** | • **Ерөнхийлөгчийг** парламентын нууц санал хураалтаар нэр дэвшүүлж 5 жилийн хугацаатайгаар үндэсний олон нийтийн санал хураалтаар сонгоно. Ерөнхийлөгч төр, засгийн тэргүүн бөгөөд Зэвсэгт хүчний ерөнхий командлагчын хувьд үндэсний эрдэнэсийн болон мөнгөн санд хяналт тавих, төрийн дээд одон медаль гардуудлах, цол хэргэм хүртээх, хуулийн төсөлд хориг тавих, батлах, Дээд шүүхийн удидлагад хяналт тавина.<br>• **Сайд нарын танхимын** 24 гишүүдийг Ерөнхийлөгч томилно. Сайд нарын танхим нь засгийн газрын үйл ажиллагааг хянаж, Парламентатд тайлагнана. |
| 167. | **Руанда** | • **Ерөнхийлөгчийг** бүх нийтийн шууд санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгоно. Тэрээр төрийн тэргүүн бөгөөд Сайд нарын зөвлөлийг тэргүүлнэ.<br>• **Ерөнхий сайдыг** Ерөнхийлөгч томилох бөгөөд Засгийн газрыг удирдана.<br>• **Сайд нарын Зөвлөл** нь үндэсний хэргийг хариуцах бөгөөд Үндэсний нэгдсэн Засгийн газрын намын лидеруудын зөвлөсний дагуу Ерөнхийлөгч томилно. |
| 168. | **Сомали** | • **Ерөнхийлөгч** нь төрийн тэргүүн бөгөөд 3 жилийн хугацаатайгаар Шилжилтийн үеийн Үндэсний Ассамблейгаас томилно.<br>• **Ерөнхий сайд** нь Засгийн газрыг тэргүүлэх ба Шилжилтийн үеийн Үндэсний Ассамблейгаас томилно.<br>• **Сайд нарын танхим** нь Шилжилтийн үеийн Үндэсний Ассамблей, Ерөнхийлөгчөөс томилсон 31 гишүүдээс бүрдэнэ. |
| 169. | **Эритри** | • **Ерөнхийлөгчийг** нь төр, засгийн тэргүүн, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч бөгөөд Үндэсний Ассамблей сонгоно. Тэрээр Төрийн Зөвлөл, Парламентыг тэргүүлж, яам, удирдах эрх барих байгууллагууд, комисс болон бусад албан байгууллагуудын удирдлагыг томилно.<br>• **Төрийн Зөвлөлийн** 17 гишүүдийг Ерөнхийлөгч томилох ба Засгийн газрын бодлого, хууль тогтоомжтийг хэрэгжүүлэх, Үндэсний Ассамблейд тайлагнана. |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ЗАСГИЙН ГАЗРЫГ БҮРДҮҮЛЭХ АСУУДЛААРХ ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

*Г.Алтан-Оч (Ph.D), Ч.Онончимэг, Д.Халиун, Г.Чулуун*

Захиалагчийн хүсэлтийн дагуу парламентад бүлэгтэй нам, эвслүүдийн оролцоог хангах замаар Засгийн газрыг бүрдүүлдэг эсэх асуудлаар Украин, ХБНГУ, Нидерланд, БНСУ, Канад зэрэг орны эрх зүйн зохицуулалт, туршлагыг судалсан болно.

## 1. ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮН

Засгийн газрын бүрэлдэхүүнд ерөнхий сайдаар толгойлуулан яамдын болон зарим төрийн төв байгууллагын дээд удирдлагууд орно. Мөн засгийн газрыг ерөнхийлөгч юмуу эзэн хаан толгойлдог улсууд ч нилээн олон бий. Франц, Бельги зэрэг нилээд оронд хуралдааныг нь ерөнхийлөгч тэргүүлдэг, сайд нарын зөвлөл болон ерөнхий сайдаар толгойлуулсан кабинетийн зөвлөл гэж зааглагддаг. (Францийн үндсэн хуулийн 9 ба 21 дүгээр заалт). Их Британи, Энэтхэг зэрэг олон оронд засгийн газар нь олон албан тушаалтан орсон өргөн бүрэлдэхүүнтэй байх боловч байнгын үйл ажиллагаагаа ерөнхий сайд болон голлох нөлөө бүхий сайд нараас бүрдсэн кабинетийн бүрэлдэхүүнтэйгээр явуулдаг.

Улс төр, намын талаасаа бол засгийн газар намын болон нам бус байж болох бөгөөд улс төрийн намуудын засгийн газар нь нэг намын болон олон намын буюу эвслийн засгийн газар хэлбэртэй байна. Нэг намын засгийн газрыг ерөнхийлөгчийн бүгд найрамдах улсуудад ерөнхийлөгч өөрийн намаас бүрдүүлэн байгуулдаг практик өргөн байдаг байна. Мэдээж, хаант улсууд, парламентын бүгд найрамдах улсууд болон хагас ерөнхийлөгчийн бүгд найрамдах улсад (semi-presidential republic) парламентад (парламентын доод танхимд) нэг нам олонх болсон бол нэг намын засгийн газар байгуулна.

Мөн парламентын засаглалтай улсад нэг нам парламентад олонх болж чадаагүй боловч засгийн газарт орохыг хүсээгүй бусад намуудын дэмжлэгийг авч нэг намын засгийн газар байгуулж болдог. Энэ бол парламент дахь цөөнхийн засгийн газар. Харин парламентад олонхыг бүрдүүлсэн нэг намын, эсхүл хэд хэдэн намын эвслийн засгийн газрыг парламент дахь олонхын засгийн газар гэнэ.

Парламентад нэг нам олонхыг бүрдүүлж чадаагүй, эсхүл олонхын дэмжлэгийг авч чадахгүй тохиолдолд бусад нам, төлөөллүүдтэй эвсэл байгуулж, парламентаар дэмжүүлэн засгийн газраа байгуулна. Ийм жишиг ХБНГУ, Итали зэрэг парламентын бүгд найрамдах улсууд, Бельги, Дани, Нидерланд, Япон зэрэг парламентат хаант улсуудад түгээмэл.

Олон намын системтэй улсуудын хувьд тодорхой тохиолдолд улс төрийн намын оролцоогүй засгийн газар байгуулах явдал байдаг. Парламент дахь нам, намын фракцууд эвслийн засгийн газар байгуулах тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд ийнхүү нам бус засгийн газар байгуулдаг. Мэргэжлийн удирдлагын ажилтнууд, технократуудаас бүрдэх ийм засгийн газар гол төлөв эвслийн засгийн газар байгуулах тохиролцоонд хүртэл юмуу парламентын шинэ сонгууль явуултал ажилладаг.

Парламентын бүгд найрамдах улсууд, парламентат хаант засаглалтай орнуудад засгийн газрыг бүрдүүлэхэд парламент голлох рольтой байх боловч парламентын гаднах бүтцүүд, жишээлбэл, төрийн тэргүүн тодорхой оролцоотой байх тохиолдол бий.

Парламентын засаглалтай улсуудад засгийн газрыг байгуулах хамгийн ерөнхий түгээмэл хэлбэр нь: төрийн тэргүүн (хаан, ерөнхийлөгч) парламентад олонхыг бүрдүүлсэн улс төрийн нам юмуу намуудын эвслийн лидерт ерөнхий сайдад нэр дэвшигчийн хувиар засгийн газрын бүрэлдэхүүнд нэр дэвшигчдийг бүрдүүлэхийг даалгана. Үүний дараа ерөнхий сайдад нэр дэвшигч нь засгийн газрын бүрэлдэхүүнд нэр дэвшигчдийн жагсаалтыг байгуулагдах засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хамт парламентад өргөн барина.

Парламент итгэл үзүүлсэн тохиолдолд төрийн тэргүүн холбогдох эрх зүйн акт гаргаж засгийн газрыг байгуулах ажлыг эцэслэнэ. Гэхдээ улс орон бүрт өөр өөрийн онцлог бий. Тухайлбал, парламентын засаглалтай Итали, Энэтхэг, Канад, Грек зэрэг улсуудад ерөнхий сайдыг төрийн тэргүүн нь томилдог бол, ХБНГУ, Испани, Япон зэрэг улсуудад парламент нь ерөнхий сайдыг сонгож, дараа нь төрийн тэргүүн өөрийн эрх зүйн актаар томилгоог хүчин төгөлдөр болгоно.

Их Британи, Энэтхэг, Грек, Австрали, Шинэ Зеланд, Шри-Ланка зэрэг улсуудад сайд нар нь парламентын гишүүн байх ёстой бол Австри, Нидерланд, Норвеги, Украйн зэрэг улсад сайд нар нь парламентын гишүүн байж болохгүй, Испани, Финланд, Дани зэрэг улсад сайд нар нь парламентын гишүүн байж ч болно, гишүүн биш ч байж болно. ХБНГУ, Болгар зэрэг зарим оронд парламент ерөнхий сайдыг томилоод дараа ерөнхий сайд нь өөрөө сайд нараа томилж, чөлөөлнө.

## 2. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

### 2.1 Канад улс

Канад улс Үндсэн хуульт хаант засаглалтай улс юм. Үндсэн хуульд зааснаар улсын төрийн тэргүүн нь Их Британи хатан хаан II Элизабет, харин Ерөнхий сайд Засгийн газраа тэргүүлдэг, холбооны, ардчилсан улс юм. Албан ёсоор Их Британийн Хатан хаан Канад Улсын тэргүүн ба Амбан захирагч нь Хатан хааны бие төлөөлөгч юм. Амбан Захирагчийг аль нэг улс төрийн намаас бус гол төлөв дипломат буюу цэргийн албан хаагчдаас сонгон Ерөнхий сайдын саналын дагуу Хатан хаан Канадын англи, францчуудаас ээлжлэн томилдог байна. Амбан захирагчийг томилолтын хугацаа хуулиар 5 жил байдаг. Тэрээр Канадын төрийн тэргүүн бөгөөд Засгийн газартай байр сууриа зохицуулан ажилладаг. Одоогийн Амбан Захирагч Дэвид Жонстон Канадын 28 дахь Амбан захирагч бөгөөд үүрэгт ажилдаа 2008 оны 10 дугаар сарын 14-ноос орсон.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

***Амбан захирагчийн эрх, үүрэг***

1. Канад Улсад Их Британийн Хатан хааныг төлөөлнө. Парламентыг зарлан хуралдуулах, тараах эрхтэй. Гэхдээ шийдвэрийг Ерөнхий сайд гаргаж, Амбан захирагч хэрэгжүүлнэ. Аль нэг нам сонгуульд дийлэнх олонхын санал аваагүй буюу Ерөнхий сайд нас барсан тохиолдолд Ерөнхий сайдыг томилох асуудлыг Амбан захирагч бие даан шийдвэрлэнэ.
2. Канадын тусгаар тогтнолын илэрхийлэл байна. Тэрээр гадаад орнуудад төрийн тэргүүний хувиар айлчилна, гадаадын төрийн тэргүүн нарыг хүлээн авна. Элчин сайд, бүрэн эрхт төлөөлөгч нарын Итгэмжлэх жуух бичгийг хүлээж авна. Канадын зэвсэгт хүчний дээд командлагч байна.
3. Төрийн дээд шагналыг олгоно.
4. Канад Улсын үндэсний нэгдмэл байдлын илэрхийлэл байна.

**Ерөнхий сайд нь ихэвчлэн Нийтийн Танхимын гишүүн байдаг**

Холбооны Засгийн газрыг сонгуульд ялсан улс төрийн нам эмхлэн байгуулна. 2006 оны 1 дүгээр сарын 23-нд болсон парламентын сонгуулиар Консерватив нам хамгийн олон суудал авч цөөнхийн засгийн газраа байгуулсан. Ерөнхий сайд Стефен Харпер 2006 оны 2 дугаар сард томилогдож кабинетын гишүүдийн хамт тангарах өргөсөн.

Засгийн газар нийт 27 яамтай. Парламентын нарийн бичгийн дарга нар нь гол төлөв засгийн газрын гишүүн байдаг. Тэднийг парламентын гишүүд дотроос Ерөнхий сайд томилдог. Засгийн газрыг Ерөнхий сайд толгойлно. Амбан захирагч Ерөнхий сайдыг томилох буюу сонгуульд ялсан намын тэргүүнийг засгийн газраа эмхлэн байгуулахыг санал болгоно. Ерөнхий сайд нь ихэвчлэн Нийтийн Танхимын гишүүн байдаг.

Парламентын гишүүн биш хүн Ерөнхий сайдаар томилогдож болно. Гэхдээ богино хугацаанд Парламентын гишүүн болох ёстой аж. Ерөнхий сайд сонгуулиар суудлаа алдсан ч нам нь парламентад олонх байгаа тохиолдолд албан тушаалдаа сайд хэвээр байх боломжтой ба харин парламентын гишүүнээр дахин сонгогдох шаардлагатай. Ерөнхий сайдын сонгон авсан кабинетын гишүүдийг Парламент хэлэлцэж батална.

## 2.2 Нидерланд улс

**Шинэ Засгийн газар байгуулах журам**

Нидерланд улс Үндсэн хуульт хаант засаглалтай улс юм. 1998 оноос найман Засгийн газар шинээр байгуулагдсан. Үндсэн хуульд засгийн газар байгуулах үйл ажиллагааны талаар дурдаагүй байдаг ба гагцхүү хуучин засгийн газрыг огцруулах, шинэ засгийн газрыг Улсын тэргүүн (Эзэн хаан/Хатан хаан)-ий зарлигаар томилно гэж заасан байна.[137] Үндсэн хууль болон холбогдох хууль, журмуудаар шинэ Засгийн газар байгуулах үйл ажиллагааг зохицуулаагүй асуудлуудыг заншлын эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулдаг.

2012 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Парламентын доод танхим болох Төлөөлөгчдийн танхим нь Засгийн газар байгуулах үйл ажиллагааг зохицуулсан Дэгийн тухай журамд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд тус нэмэлт, өөрчлөлтөөр шинэ Засгийн газрыг байгуулах ажлыг зохион байгуулах, эхлүүлэх эрхийг Төлөөлөгчдийн танхимд олгосон байна. Өмнө нь Засгийн газрыг байгуулах үйл ажиллагаанд Улсын тэргүүн голлох үүргийг гүйцэтгэдэг байсан ба зөвлөхүүдтэйгээ зөвлөлдсөний үндсэн дээр Төлөөлөгчдийн танхимаас дэмжлэг авах боломж бүхий Засгийн газрын байгуулах талаар судалж танилцуулах үүрэг бүхий *informateur*[138] -г томилж, тус ажиллагааг тодорхой үр дүнд хүрсний дараагаар *formateur*[139]-г томилох замаар явагдаж байжээ. Журамд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу Дэгийн тухай журмын 139а хэсэгт Төлөөлөгчдийн танхимын ээлжит сонгуулийн санал хураалт явуулсан өдрөөс хойш 7-с дээшгүй хоногийн дотор ээлжит чуулганаар сонгуулийн үр дүнг хэлэлцэх ба тус хэлэлцүүлгээр нэг буюу түүнээс дээш *informateur,* эсхүл *formateur*-г томилж, тэдгээрийн хийж гүйцэтгэх үүрэг даалгаврыг боловсруулж, мэдээлэл бэлтгэхийг үүрэг болгохоор заасан байна. Танхим нь шаардлагагүй гэж үзвэл мэдээлэх үе шатыг алгасаж, засгийн газрыг байгуулах үйл ажиллагааг нэн даруй эхлүүлж болно. Тэгсэн тохиолдолд тус хэлэлцүүлгээр засгийн газрыг байгуулах үүрэг даалгаврын төслийг боловсруулах мөн нэг буюу түүнээс дээш *formateur* -г томилж ажиллуулна.

[137]Үндсэн хуулийн 43, 48 дугаар зүйл.

[138]Informateur - нь ихэнхдээ урьд өмнө нь сайд, эсхүл намын даргын алба хашиж байсан туршлагатай улс төрч байх бөгөөд шинээр байгуулагдах Засгийн газарт орохгүй юм. Informateur болон formateur-н чиг үүргийг хуулиар тодорхой заагаагүй бөгөөд 1950-ид оноос Бельги, Нидерландад дэлгэрч, улс төрийн уламжлал болсон байна.

[139]Formateur - эвслийн засгийн газар байгуулах боломжтой эсэх асуудал хариуцсан улс төрч. /Нидерланд, Люксенбург, Израиль, Итали болон Чех/ Ихэвчлэн байгуулах гэж буй эвслийн хамгийн их суудал авсан намын гишүүн байх ба эвсэл байгуулагдах тохиолдолд шинэ Засгийн газрын тэргүүн болдог.

***Informateur*-н чиг үүрэг**

Сонгуулийн үр дүн *Informateur*-т өгөх үүрэг даалгаврыг тодорхойлох бөгөөд хоёр нам олонхын саналыг хувааж авч, хоорондоо зөвшилцөлд хүрсэн тохиолдолд түүнийг үүрэг нь харьцангуй бага байна.

*Informateur*-ын гол үүрэг нь шинэ Засгийн газрын хэрхэн байгуулж болох талаар судлах явдал юм. Тэрээр Засгийн газрыг байгуулахад аль намууд эвсэл байгуулахад бэлэн болон боломжтой талаар, учирч болзошгүй саад, бэрхшээлийн тухай судлах юм. Голландын парламентын түүхэнд хэзээ ч нэг нам 50 хувиас дээш санал авч байгаагүй бөгөөд эвслийн Засгийн газар байгуулахын тулд намуудад хамтран ажиллах зайлшгүй шаардлага гарсаар ирсэн ба эвслийн Засгийн газарт ороогүй намууд нь сөрөг хүчнийг бүрдүүлнэ.

*Informateur* нь Эвслийн гэрээний төслийг боловсруулах ажлын зохион байгуулах бөгөөд зарим тохиолдолд тус ажлыг өөр *Informateur*-т үүрэг болгож болно. *Informateur* нь эвслийн бүлгийн намуудтай шинээр байгуулагдах Засгийн газрын нийтлэг зорилго, зорилт болон бодлогын асуудлуудаар хэлэлцэн тохиролцох ажлыг зохион байгуулах бөгөөд тохиролцоонд хүрсэн нөхцөлд эвслийн бүлгийн намууд шинэ Засгийн газрын цаашдын үйл ажиллагаа, баримтлах бодлогыг тодорхойлсон Эвслийн гэрээг байгуулна.

***Formateur* -н чиг үүрэг**

Эвслийн гэрээнд бодлогын гол асуудлууд тусгагдсаны дараа Төлөөлөгчдийн танхим нь Засгийн газрын *formateur*-г томилон ажиллуулах бөгөөд ихэнх тохиолдолд тэрээр Ерөнхий сайдаар томилогдон ажиллаж магадлал хамгийн өндөр байна. Ихэнхдээ олонхын суудлыг эзэлсэн нам Ерөнхий сайдыг нэр дэвшүүлэх бөгөөд Ерөнхий сайд нь Засгийн газрын байгуулах яриа хэлцэл, сайд нарын албан тушаалыг хуваарилах зэрэг ажлыг хийнэ. *Formateur* нь Эвслийн бүлгүүдийн өмнөөс сайд болон төрийн нарийн бичгийн даргын[140] албан тушаалд тохирох хүмүүсийг сонгоно.

Ийнхүү багаа бүрдүүлсний дараа Засгийн газрын урьдчилсан хуралдааныг хуралдуулаж, тус хуралдаанаар сайд нар нь Эвслийн гэрээнд хэлэлцэн тохиролцсон нийтлэг зорилго, зорилт, бодлогын хүрээнд хамтран ажиллахаа мэдэгдэх ёстой. Улсын тэргүүн нь сайд болон төрийн нарийн бичгийн дарга нарыг томилон батламжлана. Үүний дараагаар Засгийн газар нь Төлөөлөгчдийн танхимд Засгийн газрын мөрийн хөтөлбөрөө өргөн барина.

Хугацааны хувьд Засгийн газрыг аль болох түргэн бүрдүүлэх шаардлагатай ч бодит байдал дээр тус ажиллагаа нь удаашрах бөгөөд 1946 оноос Засгийн газрын бүрдүүлэх процесс дунджаар 89,5 хоног байсан байна. Хамгийн хурдан байгуулагдсан Засгийн газар нь 1948 оны Дрес I-ийн кабинет 10 хоногийн дотор байгуулагдаж байсан бол хамгийн удаан нь ван Агт I-ийн кабинет 208 хоногийн дотор байгуулагдсан байна. Өнөөгийн Ерөнхий сайд Рютте II -ийн кабинет 52 хоногийн дотор байгуулагджээ.

Засгийн газрын гишүүд буюу яамдын сайд нарыг эвсэл байгуулсан нам тус бүрийн хэмжээнд дүйцүүлэн бүрдүүлдэг ба олонхын суудал авсан нам нь Ерөнхий сайд болон сайд нарын дийлэнхийг бүрдүүлнэ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[140]Төрийн нарийн бичгийн даргын буюу State Secretary - Сайд нараас гадна secretaries of state гэж байх бөгөөд тэдгээр нь дэд сайдын үүргийг гүйцэтгэнэ. Сайдтай харьцуулахад тооны хувьд харилцан адилгүй байх бөгөөд ихэнх тохиолдолд яамдуудад байхгүй эсвэл нэгээс дээшгүй төрийн нарийн бичгийн даргатай байна. Боловсролын яам нь хоёроос гурван төрийн нарийн бичигтэй байна. Төрийн нарийн бичгийн дарга нар гадаадад томилолтоор ажиллахдаа Сайдаар зарлагдах эрхтэй байдаг.

**Рютте-Ашшерийн кабинет**

Нидерландын өнөөгийн Ерөнхий сайд Рютте-Ашшерийн кабинет нь 2012 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр байгуулагдсан байна. Тус кабинет нь 13 сайд, 7 төрийн нарийн бичгийн даргатай үйл ажиллагаа явуулж байна. Эрх чөлөө ба ардчиллын төлөөх ардын нам (VVD) болон Хөдөлмөрийн нам (PvdA)-уудын эвслийн Засгийн газар бөгөөд VVD намаас 7 сайд болон 3 төрийн нарийн бичгийн дарга, PvdA намаас 6 сайд болон 4 төрийн нарийн бичгийн даргыг тус тус томилсон байна.

Цөөнгүй тохиолдолд эвсэл дахь жижиг намууд өөрсдийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор тусгай “хөтөлбөрийн сайд”-тай байх шаардлагыг тавь даг ба “нэмэлт” сайд нар нь үйл ажиллагаа явуулж буй нэг болон түүнээс дээш яамдаас төсөв болон хүний нөөцөө бүрдүүлдэг байна. Дээрх асуудлыг Засгийн газрыг бүрдүүлэх явцдаа нарийвчлан тохиролцдог байна.

**2.3 ХБНГУ-ын эрхзүйн зохицуулалт**

ХБНГУ-ын Засгийн газрын тэргүүн (Ерөнхий сайд)-ийг Бундэсканцлэр[141] (“Холбооны Канцлэр”) гэдэг. Бундэсканцлэр нь үнэндээ Германы хамгийн улстөрийн эрх мэдэлтэй хүн бөгөөд албан ёсны протоколын эрэмбээр Бундэспрэзидент (Холбооны Ерөнхийлөгч буюу улсын тэргүүн), Бундэстагспрэзидент (Холбооны Хурлын Ерөнхийлөгч буюу Парламентын дарга)-ийн дараагаар 3 дугаарт жагсдаг. Бундэсканцлэрийг Бундэспрэзидентийн санал болгосноор Бундэстагт хэлэлцүүлэггүйгээр (урьдчилсан хэлэлцүүлэг явуулахгүй) сонгодог. Түүнийг Бундэстагийн бүрэн эрхийн хугацаанаас өмнө зөвхөн конструктив[142] (бүтээгч буюу орных нь хүнийг зэрэг нэр дэвшүүлээд) аргаар итгэл үл үзүүлэх санал хураалтаар[143] огцруулж болно.

Конструктив итгэл үл үзүүлэх санал хураалт нь юуны өмнө засгийн газрын хямралаас зайлсхийх, нөгөөтэйгүүр, зөвхөн өнөөг хүртэлх засгийн газрын чиг шугам, бодлого алдаатай байсан гэдгээс илүүтэй итгэл үл үзүүлэх тэрхүү цаг дор шинээр байгуулах засгийн газрын бүтцэд итгэл үзүүлэх асуудлыг нэгэн зэрэг тавьж байгаагаараа асар ач холбогдолтой юм. Үүнийг хуульчилж өгсөнөөр деструктив итгэл үл үзүүлэх санал хураалтын боломжийг хаасан байна.

Бундэсканцлэрийг нууц санал хураалтаар сонгодог байна. Энэхүү зохицуулалтыг үндсэн хуулинд оруулаагүй боловч Парламентын дэгийн тухай хуулинд тусгасан байдаг.

Герман улсад ардчилсан хуульчлан тогтоох[144] ёсны зарчмыг баримтлан парламент нь бусад төрийн байгууллын тэргүүнийг сонгох буюу томилдог. Харин доод шатных нь албан тушаалтныг төрийн өөр байгууллаас томилдог. Жишээ нь, Холбооны төрийн нарийн бичгийн даргыг Бундэспрэзидент томилдог бол сайдыг нь Бундэсканцлэр томилдог байна.

ХБНГУ-ын Парламентыг “Германы Бундэстаг”[145] (“Холбооны Хурал”) гэж нэрлэдэг. Хуулинд зааснаар, Бундэстаг нь 598 гишүүнээс бүрдэнэ. Гэвч илүүдэл (Ьberhang) мандат[146], мөн тэнцвэржүүлэх мандатын улмаас ихэвчлэн үүнээс олон байдаг. Одоогийн 18 дахь удаагийн Германы Бундэстагт 4 илүүдэл, 29 тэнцвэржүүлэх мандат хуваарилсанаар нийт 631 гишүүнтэй үйл ажиллагаа явуулж буй. Үүнээс CDU/CSU-нэгдэл 311, SPD 193, Зүүнийхэн 64, Ногоонтнууд 63 суудал тус тус авсан байна.

[141]Бундэсканцлэр (Википед) – Bundeskanzler. http://de.wikipedia.org/
[142]Үүний эсрэг нь деструктив (сөнөөгч буюу орны хүнийг нэр дэвшүүлэхгүй).
[143]Итгэл үл үзүүлэх санал хураалт (Википед) – Misstrauensvotum. http://de.wikipedia.org/
[144]Legitimation
[145]Германы Бундэстаг (Википед) – Deutsche Bundestag. http://de.wikipedia.org/
[146]Илүүдэл суудал (Википед) – Ьberhangmandat. http://de.wikipedia.org/

Бундэстагийн шийдвэрийг[147] энгийн, эсвэл төгс, эсвэл гуравны хоёрын дийлэнх олонхын саналаар гаргадаг. Төгс олонхын шийдвэр гаргахад Бундэстагийн бүх гишүүдийн тэн хагасаас адаглаж нэг санал илүү авах шаардлагатай. Холбооны Ерөнхийлөгч[148] , түүний орлогчид, Бундэсканцлэр, Зэвсэгт хүчний төлөөлөгчийг[149] сонгох, Канцлэраас оруулсан итгэл үзүүлэх (Парламентыг тараах тухай) асуудал, Холбооны Зөвлөлийн[150] хоригийг буцаах, мөн конструктив итгэл үл үзүүлэх санал хураалтаар шийдвэр гаргахад төгс олонхын санал хэрэгтэй.

Бундэстагийн шинэ бүрэлдэхүүнийг харвал, аль ч улстөрийн хүчин энгийн олонх болоогүй, хамгийн олон суудал авч (харьцангуй олонх болж) ялалт байгуулсан нь "нэгдэл" мөн. Парламентын 50%+1 нь 316, гуравны хоёр дээр нэмэх нэг нь 411 гишүүн юм. Эндээс харахад, нэгдэл нь дангаар ерөнхий сайдыг томилох чадамжгүй бөгөөд олонх болоход 5 суудал дутжээ. Иймээс дийлэнх олонхыг бүрдүүлэх зорилгоор 193 суудал бүхий социал демократ намтай эвсэж, засгийн газраа байгуулахад хүрчээ. 2014.02.17-нд байгуулагдсан одоогийн Холбооны Засгийн газар[151] нь CDU/CSU-нэгдэл 10 (Бундэсканцлэрийг оруулаад), SPD 6 сайдын тус тус бүрэлдэхүүнтэй танхимаас бүрдэж байна.

**Олонхын тухай ойлголт**

- Харьцангуй олонх[152] - бусадтай харьцуулахад илүү санал авсан буюу хувь хэсэг.

- Энгийн олонх[153] - бусад бүгдийг нийлүүлсэнээс илүү санал авсан буюу хувь хэсэг.

- Төгс олонх[154] - түдгэлзсэн буюу үл оролцсоныг хамруулан бусад бүгдийг нийлүүлсэнээс илүү санал авсан буюу хувь хэсэг.

- Дийлэнх олонх[155] - тодорхой зааснаас илүү санал авсан буюу хувь хэсэг.

Энгийн үгээр хэлбэл, хамгийн олон санал авсаныг харьцангуй (релатив) олонх; тоологдсон бүх саналын (санал хураалтанд оролцсон гишүүдийн) 50%+1 санал авсаныг энгийн (ердийн) олонх; тоологдвол зохих бүх саналын (нийт гишүүдийн) 50%+1 санал авсаныг төгс (абсолют) олонх; "гуравны хоёр" (66.67%), "дөрөвний гурав" (75%) г.м. тодорхой заасан санал авсаныг дийлэнх (өргөн) олонх гэнэ.

Теорем буюу мөрдлөг: Төгс олонх болгон мөн энгийн олонх болно; энгийн олонх болгон мөн харьцангуй олонх болно.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[147]Төгс олонхи - Absolute Mehrheit. http://www.bundestag.de/service/glossar/A/abs_mehrheit/245310
[148]Bundesprдsident
[149]Wehrbeauftragter
[150]Bundesrat
[151] Холбооны Засгийн газар (Википед) - Bundesregierung (Deutschland). http://de.wikipedia.org/
•"Бүгд Найрамдах Солонгос Улсын улс төрийн тогтолцоо", Д.Сайнбилэг, 2010 он.http://www.lexadin.nl/wlg/
•Нидерланд Улсын Засгийн газар, http://www.government.nl/issues/forming-a-new-government
• Төлөөлөгчдийн танхим, http://www.houseofrepresentatives.nl
[152]Relative Mehrheit
[153]Einfache Mehrheit
[154]Absolute Mehrheit
[155]Qualifizierte Mehrheit

## 2.4 Украйны улстөрийн хүчнүүд сонгуулийн дараа [парламентад] эвсэх асуудалд

- ***Нэгэн жишээ***

Сонгуулиар улстөрийн аль нэг нам олонх болж чадаагүй үед “парламентын олонх”-ийг бүрдүүлэх шаардлага үүснэ. Улстөрийн нам хүчнүүд энэ шаардлагын дагуу “сонгуулийн дараах эвсэл”-ийг парламентын дотор байгуулдаг. Ингэхгүйгээр, Засгийн газрыг шинээр эмхлэх, улмаар түүнийг тогтвортой ажиллуулах боломж зохих ёсоор бүрддэггүй, парламент дахь “хүчний харьцангуй тэнцвэр” –ийн байдал энэ боломжийг олгохгүй байх явдал түгээмэл тохионо. Дэлхийн улс орнууд “хүчний ийм харьцангуй тэнцвэрт байдал” нэгэнт үүссэн тохиолдолд, түүнээс “сонгуулийн дараах эвсэл (каолици) байгуулах” замаар гардаг.

Украйны Дээд Рада-ийн ээлжит бус сонгууль саяхан болж өмнө дурдсантай төсөөт үр дүн гарав. Дээд Рада анхдугаар чуулганаа 2014.11.27–нд нээхээр төлөвлөж байна. Сонгуулийн дараах эвслийг хэрхэн байгуулж байгааг Украйны жишээн дээр тодруулж авч үзье.




- Эхний дүрслэлд, намын нэрээр (5 хувийн босготой) явуулсан санал хураалтын дүнг үзүүлжээ.




- Дараагийн жагсаалтад, Дээд Рада –ийн 421 суудал парламентын сонгуулийн дүнд яаж хуваагдсаныг харуулна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Монгол Улс парламентын засаглалтай тиймээс, Украйны жишээ энд төдийлэн тохирохгүй гэх "үндэслэл" эргэлзээтэйг эхлээд зориуд тэмдэглэх нь зөв болов уу. Аливаа улс орныг парламентын ... ерөнхийлөгчийн, хагас-ерөнхийлөгчийн, эсвэл хагас-парламентын засаглалтай гэж ярих ялгах нь угаасаа барьц багатай, нарийн зааглалгүй тойм ойлголт байдаг. Үүнийг Үндсэн хуулийн эрх зүйн үүднээс тайлбарласан нь элбэг ч, тэдгээр нь энэ удаад манай сэдвийн хүрээнд хамаарахгүй.

Украйны парламентын ээлжит бус сонгуулиар 5 хувийн босго давсан улстөрийн хүчнүүдэд хоорондоо эвслийн гэрээ байгуулах боломж нээгдсэн. Тэд энэ боломжийн дагуу Эвслийн гэрээ байгуулах төсөл дээр, сонгуулийн урьдчилсан дүнг баримжаалан хэдийнэ ажиллаж зарим тодорхой үр дүнд хүрчээ.
Талуудын байгуулж буй Эвслийн гэрээ нь 66 хууд. бүхий улстөрийн том хэмжээний чухал баримт бичиг юм. Гэрээний агуулга үндсэн 3 хэсэгтэй. Тэдгээр нь:

1. Зарчим;
2. Дэг;
3. Улс нийгэмд авч хэрэгжүүлэх реформууд (ойрын ба дунд хугацааны);

Уг баримтад дурдсанаар,

- Эвслийн гэрээ нь удахгүй байгуулагдах Эвслийн засгийн газрын Мөрийн хөтөлбөрийн үндэс болж өгнө.
- Эвслийн гишүүнчлэлийн асуудлыг гэрээгээр тодотгож, Эвслийг Ардын фронт, Ерөнхийлөгчийн блок ... зэрэг 3 гол нам хүчин хамтарч байгуулж байгаа ба парламентад суудалтай бусад жижиг улстөрийн намуудыг урьж байгаа гэдгээ тэмдэглэжээ.
- Мөн, байгуулагдаж байгаа парламентын энэхүү эвсэлд ямар улстөрийн хүчнийг оруулахгүй болохыг тодорхой нэрлэж заасан байна. "Сөрөг хүчний нэгдэл" гэх сонгуулийн дүнгээр 4-т жагссан блокийг "2014.01.16 –нд ард түмнийг айлган сүрдүүлэх, нийгэмд диктатур тогтоох" гэсэн хуулийг дэмжсэн (санал өгсөн) гэдгээр нь эвслийн гадна үлдээв.
- Эвслийн Хурал, Эвслийн зөвлөлийн талаар нарийн тусгасан. Эдгээр нь эвслийн удирдах байгууллага юм. Эвслийг бүрдүүлэгч үндсэн 3 тал тус бүр 3 ба 3-н хүнийг Эвслийн зөвлөлд оруулах бөгөөд талуудыг төлөөлсөн 3 хүний нэг нь фракцын тэргүүн байх ёстой.
- Эвслийн Зөвлөлийн фракц бүр "фракцаа төлөөлсөн шийдвэр гаргах [зөвхөн] 1 саналтай" байна. Эвслийн зөвлөл шийдвэрээ дийлэнх олонхын санал нэгдэж гаргана. (Энэ нь, олон суудал бүхий улстөрийн тодорхой хүчний саналын жин эвсэл дээрээ бусдаасаа заавал илүү үнэ цэнэтэй байх албагүйг харуулж байна)
- Эвслийн засгийн газар байгуулах тал дээр "Ерөнхий сайд нь яамны сайдуудыг парламентын эвсэл дээр зөвшилцөх замаар Згийн газрын кабинетаа байгуулна" гэж туссан. Мөн "сайдууд нь дэд сайдуудаа өөрөө мэдэж тавих" санаа оржээ.
- Эвслийн гэрээний төслийг эхний ээлжинд тус тусдаа фракц дээрээ боловсруулсан, улмаар нийлүүлж нэгтгэжээ. Зарим талын санал болгосон гэрээнд "тэргүүн ээлжинд ондоо багтаан батлах болзол бүхий 36 хуулийн нэр"-ийн жагсаалтыг хавсаргасан байв.
- Төслийн боловсруулалтын шатанд "парламентын депутатын халдашгүй байдлыг нийтэд нь цуцлах" асуудал ч хөндөгдөж байлаа.

Парламентын үнэмлэхүй олонхыг бүрүүлэх зорилгоор улстөрийн хүчнүүд сонгуулийн дараа энэ мэтээр энд тэндгүй эвсдэг. Эдийн засгийн хямрал нүүрлэсэн, эсхүл дайн дажин дэгдсэн үед мөн ингэж эвсэх явдал гардаг. Эвслийн засгийн газрын тухай ойлголт олон

UIH MN СУДАЛГААНЫ САН

тодотголтой. Парламентад суудалтай улстөрийн хүчнүүдийн оролцоог бүрэн хангасан өргөн эвслийг “Үндэсний эв нэгдлийн”, улстөрийн зонхилох хүчнүүдийн явцуу хүрээнд байгуулсан эвслийг “их эвсэл” гэх нь бий.

**2.5 Бүгд Найрамдах Солонгос улс**

БНСУ-ын хувьд Үндэсний Ассемблейн нэр дэвшигчдийг

- *Тойргийн сонгуулиар* /Тойргийн сонгуульд нэр дэвшигчдээс дараах нөхцөл үндэслэн Үндэсний Ассемблейн гишүүнээр сонгоно.
    - Олонхын санал авсан нэр дэвшигч. Хэрэв 2 ба түүнээс дээш нэр дэвшигчийн авсан саналын тоо тэнцвэл насны эрэмбээр шийдвэрлэнэ.
    - Санал хураах цаг дуустал ганц нэр дэвшигч байх тохиолдолд тухайн нэр дэвшигчийг сонгогдсонд тооцно.
- *Хувь тэнцүүлэн хуваарлих зарчмаар*
    - Хүчинтэй саналын хуудас 100-ны 3 хувиас дээш байх, эсхүл тойргийн сонгуулиас 5 дээш санал авсан улс төрийн намд пропорциональ төлөөллтийн сонгуульд оролцож авсан саналын хувь дагуу суудал хуваарилна. Хувийг тогтоохдоо тойргийн сонгуульд авсан саналын тоог намуудын авсан нийт саналын тоотой харьцуулан тогтооно.
    - Хувиа тогтоолгосон намуудын хувьд Үндэсний Ассемблейгаас суудал хуваарилуулж авна. Авах суудлын тоог тогтоохдоо сонгуульд авсан саналынх нь нийт хувийг Үндэсний Ассемблейн нийт пропорциональ суудлын тоонд хуваана. Пропорциональ хуваарилалтаар үлдсэн суудлыг тогтсон тооноос бага суудал авсан намуудын саналын тооны эрэмбээр нэг нэгээр хуваарилна гэсэн хоёр арга замаар сонгох бөгөөд сонгогчийн зүгээс тухайн нэр дэвшиж буй нэр дэвшигчид бус нэр дэвшиж буй намд саналаа өгдөг.

Үндэсний Ассемблейн нийт гишүүдийн тоо 299 байгаа бөгөөд тэдээрийн 243 нь тойргийн сонгуулиар 56 нь пропорциональ буюу хувь тэнцүүлэх аргаар сонгогдсон гишүүд байдаг.

***Засгийн газрыг бүрдүүлэх эрх зүйн зохицуулалт:***

БНСУ-ын Үндсэн хуулийн 66.4-т “Гүйцэтгэх эрх мэдэл нь Ерөнхийлөгчөөр удирдуулсан Засгийн газарт байна” гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл, Гүйцэтгэх засаглалын удирдан зохион байгуулах хамгийн дээд эрх мэдэл нь ерөнхийлөгчид байдаг.

Мөн Үндсэн хуулийн 86-р зүйлд “Ерөнхий сайдыг Үндэсний Ассемблейн дэмжлэгтэйгээр Ерөнхийлөгч томилно. Ерөнхий сайд нь Ерөнхийлөгчид шадарлан, ерөнхийлөгчийн тушаасан дагуу Засгийн газрын бүх яам тамгын газрыг ерөнхийлөн захирна” гэж заасан байдаг. Ерөнхий сайдын дор тусгай албан үүрэг гүйцэтгэх 3 шадар сайд ажиллана.

Ерөнхий сайд Төрийн хэргийн зөвлөлийн гишүүн, яамдын сайд нарыг томилох, огцруулах эрхтэй. Өөрөөр хэлбэл Төрийн хэргийн зөвлөлийн гишүүн, яамдын сайд нарыг томилох хүсэлт гаргаж, Төрийн хэргийн зөвлөлийн гишүүнийг огцруулах тухай саналаа ерөнхийлөгчид өргөн барьж болно.

Гүйцэтгэх засаглалын яамдын сайд нарын хувьд Төрийн хэргийн зөвлөлийн гишүүн байх бөгөөд Ерөнхий сайдын хүсэлтийн дагуу Ерөнхийлөгч томилно. Тиймээс Төрийн хэргийн зөвлөлийн гишүүн биш бол сайдаар томилогдох аргагүй. Харин сайдыг албан тушаалаас нь огцруулах асуудлыг ерөнхийлөгч шийдвэрлэнэ. Сайд нь төрийн хэрэгт Ерөнхийлөгчийг шадарлан Засгийн газрын хуралдаанд /Засгийн газрын хуралдаан нь Ерөнхийлөгч, Ерөнхий сайд болон сайд нар 15-30 хүний бүрэлдэхүүнтэй байна. Үндсэн хуулийн 88 зүйлийн 2-т/ гишүүний эрхтэйгээр оролцоно.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ


- Бундэсканцлэр (Википед) – Bundeskanzler. http://de.wikipedia.org/
- Итгэл үл үзүүлэх санал хураалт - Misstrauensvotum. http://de.wikipedia.org/Германы Бундэстаг (Википед) - Deutsche Bundestag. http://de.wikipedia.org/
- Илүүдэл суудал (Википед) – Ьberhangmandat. http://de.wikipedia.org/
- Төгс олонх - Absolute Mehrheit. http://www.bundestag.de/
- Холбооны Засгийн газар (Википед) - Bundesregierung (Deutschland). http://de.wikipedia.org/“Бүгд Найрамдах Солонгос Улсын улс төрийн тогтолцоо”. Д.Сайнбилэг, 2010 он. http://www.lexadin.nl/wlg/
- Нидерланд Улсын Засгийн газар. http://www.government.nl/issues/forming-a-new-government
- Төлөөлөгчдийн танхим. http://www.houseofrepresentatives.nl


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОЙМ МЭДЭЭЛЭЛ [КАЗАХСТАН УЛСЫН ТУРШЛАГА]

*Г.Чулуун*

Хууль санаачлагчдаас Хяналтын тухай хуулийн төслийг УИХ –д өргөн барьж, улмаар УИХ-ын даргын захирамжаар 2014 оны V сард Ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгээс хуулийн төслийг боловсронгуй болгохоор иргэд байгууллагуудын саналыг авах, бодлого зарчмын олон асуудлыг оролцооны үндсэн дээр оновчтой шийдэх чиглэлээр ажиллаж байна. 2014.9.28 –нд Нийслэлийн иргэний танхимд уг хуулийн төслийн нээлттэй хэлэлцүүлэг явуулсан.

Гадаадын улс орнуудад ч аливаа хуулийн төслийг агуулга санаа, зарчим, үзэл баримлалын талаас нь салбарын байгууллага мэргэжилтнүүдийн болон хараат бус эксперт, шинжээч сонирхогч иргэдийн идэвх оролцоотойгоор хэлэлцэх нь түгээмэл. Доорх мэдээлэлд, Төрийн хяналт шалгалтын тухай Казахстан Улсын [шинэ] хуулийн хэрэгжилтийн сэдвээр болсон Дугуй ширээний ярилцлагын тоймоос болон тухайн хууль тогтоомжид холбогдох зарим зүйлсийг нэмж өгүүлнэ.

* * *

1. Хяналт шалгалтын талаар баримтлах бодлогын зохицуулалт Казахстанд Эдийн засгийн хөгжил, худалдааны яамандаа илүү хамааралтай ажил асуудал байдаг. Эл байдал ОХУ –д ч мөн адил юм. Мөн, зарим улсад, хаана, чухам ямар талбарт явуулах хяналт шалгалтын тухай ярьж байгаагаа тухайн хуулийн гарчигт нь тодотгож зааж өгсөн байв. Жишээ нь, Хяналтын тухай Украйн Улсын хууль “Аж ахуйн [бизнесийн] үйл ажиллагааны талбарт тавих улсын хяналт шалгалтын үндсэн зарчмын тухай” гэсэн дэлгэрэнгүй нэртэй.

2. Хувийн хэвшлийг дэмжих хөгжүүлэх чиглэлийн хууль тогтоомжид (2006) оруулсан нэмэлт өөрчлөлт (2009) -өөр, Казахстанд, төрийн байгууллага албан тушаалтнаас иргэн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтын нийтлэгээр баримлах дэг зарчмыг тодруулж тогтоосон. Хуулийн өөрчлөлтөөр тэнд олон улсын жишгийг дагаж эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэх нэвтрүүлэхээр болж, мөн түүнчлэн (бизнес эрхлэгч) талыг шалгалтын үед өөрийгөө хамгаалах эрх зүйн нэмэлт боломжуудаар хангаж өгсөн. Холбогдох хууль тогтоомжийн үндсэн дээр, Казахстанд, жишээлбэл бага бизнесийн байгууллага анх үүсэн бүртгүүлснээсээ хойш хэсэг хугацаанд (3 жилийн дотор) шалгалтанд өртөхгүй байх эрхтэй; гэх мэт. Хуулийн нэмэлт шинэ өөрчлөлтүүд үйлчилж хэрэгжсэний дүнд мэргэжлийн хяналтын байгууллагуудаас явуулсан төлөвлөгөөт шалгалтын тоо Казахстанд 2011 онд өмнөх жилийнхээсээ 26 хувиар буурсан байв.

   Казахстаны Ерөнхий прокурорын газрын мэдээнд, мэргэжлийн хяналтын байгууллагуудын төлөвлөгөөт хяналтын хүрээнд 2012 оны эхний хагас жилд хийгдэхээр байсан нийт шалгалтын 20 хувь (26000) нь ёс бус, хууль зөрчсөн шинжтэй байсныг дурджээ. Энэ нь нэгэнт батлагдсан хууль дүрэм бодит амьдрал дээр тэр болгон яв цав бууж хэрэгждэггүйг харуулах нэг жишээ бөгөөд аливаа дэг дүрмийн агуулгын ба түүнийг хэрэгжүүлэгч албаны хүмүүсийн үзэл санааны хоорондын нийцэмжийг асуудлыг хөндсөн, нийгэм дэх хүний нөөцийн менежментийн чиглэлд хамаарах тусдаа өөр сэдэв юм.

СУДАЛГААНЫ САН

Казахстанд, прокурорын газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдийн жагсаалтад "бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах" асуудал багтдаг ба мэргэжлийн хяналтын газрын дурдсан 26000 төлөвлөгдсөн хяналт-шалгалтыг Казахстаны Ерөнхий прокурорын газар хэрэгжихээс нь өмнө нь зогсоожээ. Энд анхаарал татахуйц аспект ажиглагдав. Казахстаны прокурорын хяналтын хүрээнд гүйцэтгэх засаглалын хэрэгжүүлэх үйл ажиллагаа ямар нэг хэмжээгээр өртөж болдог нь харагдаж байна.

Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулиар прокурорын байгууллагын эрхлэх үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлсон. Тэнд зааснаар,

2.1. Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий шүүх эрх мэдлийн (оролцогч) байгууллага" бөгөөд захиргааны зөрчлийн [зөвхөн] "хэрэг бүртгэх ажиллагаа" –нд хяналт (11.1. – 11.2.8) тавьдаг.

3. Казахстан Улсын Засгийн газрын тогтоолоор "Бизнесийн үйл ажиллагааг 2020 он хүртэл төрөөс дэмжин зохицуулах Концепц" (№380) бодлогын баримт бичгийг 2014.4.18 –нд батласан. Энэ Концепцийн агуулгын хүрээнд төрийн хяналтыг хэрэгжүүлэх арга зармын асуудлууд туссан. Концепцид болон холбогдох хэлэлцүүлэгт, төрийн зүгээс тавигдах хяналт шалгалтад шийдвэл зохих бодлогын асуудал олон байгааг дурдахдаа доорх асуудуудыг тухайлан буруушаажээ. Үүнд,
   - зөрчил дутагдлыг гарахаас нь өмнө сэргийлэхийн оронд гаргасан хойно нь шийтгэх арга хандлага давамгайлан оршиж байна;
   - хяналт шалгалтын үед төрөөс тавигдаж байгаа шаардлагууд тооны хувьд хэтэрхий их, зарим нь бүр үл гүйцэлдэх (биелүүлэх боломжгүй) шинжтэй;
   - шалгалтууд давтагдсан давхардсан, шаардлагууд хуучирсан хоцрогдсон, үндэслэл муутай байх нь түгээмэл болсон;
   - хяналт шалгалтыг цагт нь оножолж хийх тал дээр бодлогогүй, зарчимгүй;
   - учирч болох эрсдлийг зөв үнэлж чаддаггүй, ахин дахин (байнга) шалгадаг (тодорхой баримтлах шинжлэх ухаанч арга зүйгүй);
   - хяналт шалгалтын хэрэгжүүлэгч төрийн байгууллагууд хангалттай олон төрлийн эрхтэй байдаг ч хянаж шалгаад байгаа тухайн тодорхой салбарт хуримтлагдаж үүссэн, байж болшгүй нийтлэг зөрчил завхарлын төлөө эцсийн дүндээ хэн ч хариуцлага хүлээдэггүй; гэх мэт.

4. Казахстан Улсын Ерөнхийлөгчийн зарлиг (№858, 2009.8.24) -аар батлагдсан Казахстан Улсын эрх зүйн шинэтгэл (2010-2020) –ийн бодлогыг баримт бичигт, бизнес эрхлэгчдийн хувийн сонирхлыг нийтийн сонирхолтой холбон уялдуулах зөв зохистой зохицуулалтын асуудлын чухлыг тухайлан хөндөж, энэ чиглэлд тусгай Кодекс хэрэгтэйг байгааг болон Казахстанд хуулиар хориглоогүй л бол хэн ч ямар ч чиглэлээр бизнесийн үйл ажиллагаа өрнүүлэх, эхлэх эрхийн баталгаатайг онцлон тэмдэглэжээ.

5. Эдийн засгийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэлийн талаар гаргасан Казахстаны засгийн газар ба Улсын үндэсний банкны хамтарсан Мэдэгдэл (Заявление, 2014) –д, «нийтийн, хэрэглэгчийн болон бизнесийн эрх ашгийн тэнцвэрийн балансыг хангах» -ыг дурдаад, ингэхийн тулд гүйцэтгэх засаглалын байгууллагууд илүүдсэн зарим эрх мэдлээсээ татгалзах чөлөөлөгдөхийн чухлыг онцлон тэмдэглэсэн байв. Энэ Мэдэгдлийг Казахстан Улсын засгийн газрын 2014 оны 242 дугаар тогтоолоор сайшаасан болно.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

6. Казахстанд хяналт шалгалтын эрх бүхий төрийн байгууллагуудын “бизнест тавигдах шаардлага тогтоох” эрхийг 2011 оноос хязгаарлаж, энэ эрхийг илүү өндөр төвшинд (Засгийн газрын тогтоолоор, Ерөнхийлөгчийн зарлигаар) шийдэж байхаар зохицуулсан.

7. Казахстаны Мод боловсруулагч тавилга угсрагч үйлдвэрүүдийн Нэгдсэн ассоциацаас Улсын хяналт шалгалтын тухай хуулийн агуулга хэрэгжилттэй холбогдуулж гаргасан санал дотор,
   a) Хяналт ба шалгалт нь тусдаа 2 өөр ойлголт; гэдгийг дурдсан байв. Үйлдвэрлэлийн процесс дахь (төрийн зүгээс тавих контроль) шалгалт нь дотоод ба гадаад гэж ялгагддаг бол төрийн хяналтыг нь дээд ба эрх бүхий байгууллагын гэж ангилж болохоор юм.
   b) Шалгалт нь зөрчил дутагдлын эсрэг шуурхай реакцийн шинжтэй байдаг хяналт нь захиргааны хэрэг үүсгэлгүйгээр эрх зүйн хязгаарлалтыг хэрэгжүүлэх сахиулах арга хэмжээ байдаг.
   c) Хувийн хэвшилд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаа бараг 100 орчим чиглэлээр төрийн хяналт шалгалтад өртдөг. Жишээ нь, гааль, татвар, цахилгаан эрчим хүч, байгаль орчин хамгаалал, иргэний хамгаалалт, онцгой байдал, галын аюулгүй байдал, санхүү нягтлан бүртгэл, зар сурталчилгаа .. гээд хяналт шалгалт явагддаг төрөлжсөн чиглэлүүдийн жагсаалт их урт. Бүхнийг хамарсан бүгдийг хянасан энэ хэт хяналтын тогтолцооны гарын аяыг дааж гарах нь жижиг дунд үйлвэрлэгч нарт амар зорилт биш юм. Тэднийг, хөл дээрээ баттай зогссон, олон төрлийн нөөц чадамж бүхий том үйлдвэрлэгч нартай адилтгаж үзэж болохгүй;
   d) Казахстанд, хяналт шалгалтын эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаа бараг нэг төрлийн бизнес болтлоо “хөгжлөө” гэх зэргээр олон санаа дурдагджээ.

8. Өмчлөгч, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах ТББ –ын төлөөллийн тэмдэглэсэн санал санаан дотор,
   a) Төрийн хяналт шалгалтын өнөөгийн тогтолцоо механизмыг боловсронгуй болгох боломцоогүй, учир нь, тэр аль хэдийнээ “боловсорч нэгэнт гүйцжээ”. Казахстаны нийгэмд бүхнийг хамарсан хяналтын систем үйлчилж байна. Хэрэв, энэ талаар улс гүрнийг байр эзлүүлэн жагсаадаг бол Казахстан улс их дээгүүр давхихаар, бүр ОХУ –ыг ч ардаа орхихоор болжээ.
   b) Хэрэглэгч үйлдвэрлэгч хоёрын дунд хэтэрхий олон хянах ба шалгах эрх бүхий байгууллагууд оршиж байна, тэглээ гээд байдал сайн байна уу гэтэл бас үгүй юм. Хэрэглэгч гомдлоо гаргаад, гомдлыг нь шүүх барагдуулаад, шаардлагатай тохиолдолд зохих шийтгэлийг нь буруутай этгээдэд хүлээлгээд хариуцлага тооцоод явах өөр арга хандлага оршин байх боломжтой. Гарц хайх цаг болсон.
   c) Дурдсан байдлыг эерэгээр өөрчлөхийн тулд радидикал шинжтэй арга хэмжээ шаардлагатай. Хяналт шалгалтын эрх мэдлийг шүүхийн тогтолцооны талбарт шилжүүлж өгсөн ч болохгүй гэх газаргүй. Казахстаны Үндсэн хуулийн 75 дугаар зүйлд, шударга үнэнийг зөвхөн шүүх тогтооно [“правосудие” ухагдахуун өргөн утгатай] гэсэн. Гэтэл, казахстанд үүнийг зөвхөн шүүх биш, хяналт шалгалтын эрхтэй төрийн системийн 114 байгууллага энд тэндгүй зэрэг зэрэг “тогтоож” байна. Хянах шалгах эрх бүхий экспертийг зөвхөн шүүх томилдог баймаар байна. Гүржийн туршлагаар, казахстанчууд хянадаг шалгадаг байгууллагынхаа тоог эрс цөөлөх цаг хэдийнэ болжээ.
   d) Хяналт шалгалтын талаар өнөөгийн мөрдөж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох гэж эрмэлзэх зорих шаардлагагүй, үзэл санааны өөрчлөлт хэрэгтэй, хяналт шалгалтын байгууллагууд өөрснөө бас хараат байдалд оршдог, хэрэв тэд шалгуулагч талаа бага торговол авилга авчихаж гэж хардагдах магадлалтай; гэх зэргээр ярьж олон талаас нь харж ярьж шүүмжилж хэлэлцжээ.

9. Хянан шалгах чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааг нэгдсэн нэг шкалаар хэмжих боломж хомс байдгаас түүнд бүхэлд нь дүн шинжилгээ хийх асуудал ярвигтай байдаг. Харин нэг тухайлсан салбарын хүрээнд дүн шинжилгээний аргазүйн асуудлыг хөндөж авч үзсэн өгүүлэл статъя ховор биш. Төрийн ОХУ –д, Казахстанд төрийн хяналт шалгалтын байгууллагуудын үйл ажиллагааны үр өгөөжийг үнэлэх дүгнэх критерт холбогуулж боловсруулсан олон баримт бичиг бий. Жишээ нь, Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын хянан шалгах үйл ажиллгааны үр өгөөжийг нэмэгдүүлэх Концепц (2014 - 2018) гэх мэт. ОХУ –д хяналтын тухай хуулийн төсөл эдүгээ мөн хэлэлцүүлгийн шатандаа явж байна.

* * *

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АШИГЛАСАН МАТЕРИАЛ


- Казахстаны Хяналт шалгалтын тухай хууль (29.12.2014 –ний өдрийн нэмэлт өөрчлөлтийг тусгасан), http://online.zakon.kz/Document/?doc_id=30914758;
- Концепция к проекту Закона Республики Казахстан «Об общественном контроле в Республике Казахстан», http://online.zakon.kz/Document/?doc_id=31404214; болон эдгээрт холбогдох зарим материал;

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УИХ-ын Тамгын газар ©
“СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ – XX БОТЬ”

УИХ-ын Тамгын газрын хэвлэх цех
Хэвлэлтэнд шилжүүлсэн: 2015.03.26
Хэвлэлийн хуудас: 23, Хэвлэсэн тоо: 350
Цаасны хэмжээ: B5

УБ., 2015